

Хүүхдийн Хэсэг 2

Зөвийг Сонго А
Нас 4–7


Хүүхдийн Хэсэг 2

Зөвийг Сонго А

Дөрвөөс долоон насны хүүхдүүдэд заахад зориулав

© 1995 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 12/93
Орчуулгын зөвшөөрөл: 12/93
Primary 2: Choose the Right A-гийн орчуулга
Mongolian



Агуулга

Хичээлийн Дугаар ба Нэр	Хуудас
Багшид зориулсан тусламж	vii
1 Зөвийг Сонгохоос Аз Жаргал Ирдэг	1
2 Би Зөвийг Сонгож Чадна	6
3 Би Бурханы Хүүхэд	12
4 Би Есүс Христийг Дагахыг Сонгосон	18
5 Би Зөв Сонголтуудыг Хийж Чадна	23
6 Бидэнд Онцгой Гэр Бүл Бий	28
7 Есүс Христийн Төрөлт Дэлхийд Баяр Хөөр Авчирсан	33
8 Тэнгэрлэг Эцэг Намайг Харж Ханддаг	38
9 Есүс Христ Надтай Адил Хүүхэд Байсан	42
10 Би Залбирлаар Тэнгэрлэг Эцэгтэй Ярьж Чадна	48
11 Би Есүс Христийн Тухай Бусдад Ярьж Чадна	55
12 Би Баптисмд Бэлтгэж Чадна	60
13 Ариун Сүнсний Бэлэг Надад Тусалж Чадна	66
14 Зөвийг Сонгох Зоригтой Бай	73
15 Ирж, Намайг Дага	81
16 Есүс Христэд Эдгээх Хүч Байдаг	87
17 Санваар Надад Тусалдаг	93
18 Залбирлууд Хамгийн Сайнаар Хариулагддаг	98
19 Есүс Христ Надад Хайртай	104
20 Есүс Христийн Заадаг Зүйлүүд Бол Агуу Эрдэнэс Мөн	110
21 Би Хүндэтгэлтэй Байж Чадна	117
22 Амар Амгаланг Бий Болгогчид Адислагддаг	124
23 Есүс Христ Бол Сайн Хоньчин	129
24 Би Талархлаа Харуулж Чадна	134
25 “Баярлалаа” Гэж Хэлэхээ Санагтун	139
26 Зөвийг Сонгох нь Надад Баяртай Мэдрэмж Төрүүлдэг	144
27 Би Хуваалцсанаараа Бусдыг Баяртай Байхад нь Тусалж Чадна	149
28 Би Эелдэг Байж Чадна	153
29 Би Сайн Үлгэр Жишээ Байж Чадна	159

30	Би Дуулгавартай Байж Чадна	166
31	Би Хуулийг Дуулгавартай Сахих Болно	173
32	Бие Биенээ Хайрла	179
33	Би Аравны Нэгээ Төлж Чадна	187
34	Ямагт Үнэнийг Ярь	193
35	Надад Авьяас Бий	199
36	Би Зөвийг Сонгосон Үедээ Ухаалаг Байдаг	206
37	Би Хүндэтгэлийн Өдрийг Ариунаар Сахиж Чадна	212
38	Би Ариун Ёслолын Үеэр Есүс Христийг Дурсан Санах Болно	220
39	Би Бусдад Үйлчилснээр Есүс Христийг Дагаж Чадна	227
40	Би Бусдыг Уучилж Чадна	232
41	Есүс Христ Бол Бидний Аврагч	238
42	Есүс Христийн Сүм Дэлхий Дээр Байдаг	244
43	Есүс Христ Дахин Ирнэ	251
44	Би Амьтдад Хайраа Илэрхийлж Чадна	257
45	Бид Есүс Христийн Амилалтыг (Улаан Өндөгний Баяр) Тэмдэглэдэг	264
46	Есүс Христ Бол Хамгийн Агуу Бэлэг (Зул Сарын Баяр)	270
	Дуунуудын үгс	276

Багшид Зориулсан Тусламж

Зорилго

Есүс Христийн үлгэр жишээг дагаснаар хүүхдүүд зөвийг сонгож, баптисм, хүртэн, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд болно гэдгийг хүүхдүүдэд заахад тусламж болгон энэхүү гарын авлагыг бичжээ.

Хүүхдийн

Хэсгийн Багш

Нарт Өгөх Захиас

Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд зааж, үүний дагуу амьдарч сурахад нь туслах нандин дуудлагыг Тэнгэр дэх бидний Эцэг та нарт өгчээ. Та хүүхдүүдэд үйлчилж, тэднийг нэг бүрчлэн “Христэд ирэхийг” урьснаар тэдний амьдралыг адислах болно. Тэнгэрлэг Эцэгийн адислалуудыг ойлгож эхлэн түүний сайн мэдээний тухай гэрчлэлүүдийг хүлээн авахад нь та тэдэнд тусалж чадна. Түүнчлэн та өөрөө өсч хөгжин хүүхдүүдээс сурах болно. Хүүхдийн Хэсэгт үйлчлэх нь танд агуу их баяр баяслыг авчирч чадна. Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдэд үйлчилснээр, та бас Тэнгэрлэг Эцэгт үйлчилж байгаа болно (Мозая 2:17-г үз).

Та сайн мэдээний зарчмуудаар амьдарч, судруудыг судлан, санваарын удирдагчдын зөвлөгөөг дагаж, түүнчлэн залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгт ойр байснаар заадаг хүүхдүүдийнхээ талаар Ариун Сүнснээс бурханлиг нөлөөлөл хүлээн авах болно. Хүүхдүүдтэй ойр ойрхон гэрчлэлээ хуваалцаж, энэхүү чухал дуудлагад Ариун Сүнсийг танаар дамжин нөлөөлөхөөр болго. Ингэсэн үед, Хүүхдийн Хэсэгт хийх зүйл тань биднийг Тэнгэрлэг Эцэгийн хувьд хүлээн зөвшөөрөхүйц байхын тулд Сүнс таныг чиглүүлэх болно.

Ангийн

Мэдээлэл

ЗС нь Зөвийг Сонго гэсэн утгатай. Энэ гарын авлагын урд байгаа ЗС бамбай, мөн ЗС бөгж (31362) нь нилээд хэдэн хичээлд ашиглагддаг. Түүнээс гадна хичээл 1 нь мөн нилээд хэдэн хичээлд ашиглагдах ЗС төлөвлөгөө гаргах заавруудыг агуулдаг. ЗС бөгж нь эзэмшигчдээ зөвийг сонгохыг хувьчлан сануулагч болж үйлчилдэг. Хэрэв танай бүсэд ЗС бөгж байдаг бол хэсэг, эсвэл салбарт тань хүүхэд бүрт бөгж худалдаж авах санхүүгийн бололцоо бий эсэх талаар бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэйгээ зөвлөлд.

Хичээлийн Цаг

Залбирал

Хичээлийн үе болгоныг залбирлаар эхэлж мөн дуусга. Залбирал хийх тогтмол боломжийг хүүхэд бүрт олго. Залбирлын тухай заавар зөвлөгөө өгч, мөн залбиралд оруулах санаануудын талаар хүүхдүүдээс асууж, залбирлыг хичээлийн утга учир бүхий хэсэг болго. Өөрийнхөө саналуудыг ангийн хэрэгцээ болон тухайн хичээлийн захиаст төвлөрүүл.

Хичээлүүдийг заах нь

Хичээл бүрийг хүүхдүүдийг ойлгож, тэдэнд таалагддаг болгож, мөн та өөрөө Сүнсний удирдамжтай байхын тулд хичээл бүрийг анхааралтай бөгөөд залбиралтайгаар бэлтгэ.

Хичээл 45 болон 46-гаас (Улаан Өндөгний Баяр болон Христийн Мэндэлсний Баяр) бусад хичээлүүдийг дэс дараагаар нь заа. Хэрэв ангийн чинь хүүхдүүдээс хэн нэг нь тухайн жилд баптисм хүртвэл, ангийнхаа эхний хүүхдийг баптисм хүртэхээс өмнө та баптисм болон гишүүний баталгааны тухай хичээл 12, 13-ыг зааж болно.

Хичээлийн материалуудаас ангидаа тохирохыг нь сонгож ав. Хичээл бүрийн төгсгөлд жагсаасан баяжуулах үйл ажиллагаануудыг өөрийнхөө тохирно гэж үзсэн хичээлдээ ашиглах хэрэгтэй. Хичээлийн бүх материал буюу баяжуулах үйл ажиллагаанууд нь танай ангийн хүүхдүүд, эсвэл танай бүсийн хувьд тохиромжгүй байж болно. Зарим үйл ажиллагаанууд нь дөрвөн настай хүүхдүүдийн хувьд хэтэрхий хүнд байж болно; бусад үйл ажиллагаанууд нь долоон настай хүүхдүүдэд таалагдахын хувьд дэндүү энгийн байж болно.

Ангийнхан чинь хариу үйлдэл сайн үзүүлэх үйл ажиллагаануудыг сонгож ав. Хэрэв танай ангид бага насны хүүхдүүд байдаг бол тэдний анхаарлыг төвлөрүүлж байхын тулд хичээлийн үеэр дуунууд болон хуруугаар тоглох тоглоомуудыг ашиглаж болно. Хэрэв энэ нь хүүхдүүдэд таалагдаж байгаа бол дуу буюу хурууны тоглоомыг давтан тоглуулж болно. Бага насны хүүхдүүдэд цаасан дээр бичсэн үгсийн оронд та өөрийн зурсан буюу сэтгүүлээс хайчилж авсан зургуудыг ашиглах замаар тухайн үед заагдаж байгаа ерөнхий дүр зургийг зураглан харуулж болно.

Хүүхдүүдэд хичээлийг бүү уншиж өг. Хэрэв та хичээлийг өөрийнхөө үгээр заавал хүүхдүүд илүү сайн хариулах болно. Ангийн гишүүдийг сайн мэдээний захиасыг Сүнстэйгээр илүү дуртай сонсож, хариулуулахын тулд хувийн, товч гэрчлэлээ хэлж бай.

Teaching—No Greater Call (33043) гарын авлага нь хичээлүүдийг заахад тань тусалж болно.

Анги дахь Хөгжим

Хөгжим нь ангид Их Эзэний Сүнснийг авчирч чадна. Ангиараа дуулах нь хичээлийг тань улам сонирхолтой болгож, хүүхдүүдэд хичээлийн ерөнхий санааг илүү сайн тогтоон санахад нь тусалж чадна.

Энэ гарын авлагад нэгээс олон удаа хэрэглэгддэг дуунуудын үгс нь гарын авлагын ар талд хэвлэгдсэн болно. Гарын авлагад ганцхан удаа ашиглагдсан дуунуудын үгс нь тухайн хичээлүүдэд багтсан байгаа. Эдгээр дуунуудын хөгжмийг *Children's Songbook* (35395)–аас олж болно.

Ангид дуулах явдлыг урам хайрласан зүйл болгохын тулд та ур чадвартай хөгжимчин байх шаардлагагүй юм. Хүүхдүүд таны сайн дуулдаг үгийг мэдэхгүй; тэд зөвхөн дуулах нь та нарт таалагддагийг л мэдэх болно. Хичээлийнхээ бэлтгэлийн нэг хэсэг болгон гэртээ дуу сурч, дуулах дадлага хий. Хэрэв танд тусгайлан тусламж хэрэгтэй бол, Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагч буюу хөгжимчнөөс тусламж хүс. (Нэмэлт тусламж болгон “*Music in the Classroom,*” *The How Book for Teaching Children* [31109], х. 40–42-ыг үз.)

Ялангуяа танай ангид бага насны хүүхдүүд байдаг бол та дуунуудад тохирох үйл хөдлөлүүдийг ашиглаж болно. Түүнчлэн та дууны үгсийг дуулалгүйгээр хэлж өгч болно.

Итгэлийн Тунхаг

Итгэлийн Тунхаг бол Хүүхдийн Хэсгийн сургалтын хөтөлбөрийн чухал хэсэг юм. Итгэлийн тунхагийг хичээлд хэрэглэгдэж байгаа үед хүүхдүүдийг чадах хэмжээгээрээ итгэлийн тунхагаас цээжлэхэд нь урамшуулан дэмж.

Судрууд

Судруудаа долоо хоног бүр ангид авчирч, хүүхдүүдэд өөрсдийгөө тэдгээрээс унших болон заахыг харах боломж олго. Хэрэв хүүхдүүдэд өөрсдийнх

Заахад туслах зүйлүүд

нь судар байдаг бол тэднийг тэдгээрийгээ долоо хоног бүр ангидаа авчрахыг нь урамшуулан дэмж. Ахлах насны хүүхдүүдэд хичээл дээр ашиглагдаж байгаа хэсгүүдийг олж уншихад нь тусал. Судруудын үнэ цэнийн талаарх гэрчлэлээ ойр ойрхон хуваалцаж бай.

Зураг. Хичээл дээр ашиглагддаг ихэнх зургууд нь дугаарлагдсан бөгөөд гарын авлагатай хамт ирдэг уутанд байгаа болно. Эдгээр зургууд нь гарын авлагатай хамт байх ёстой. Хичээл тус бүрт шаардлагатай зургууд нь хичээлийн “Бэлтгэл” гэсэн хэсэгт жагсаагдсан. Түүнчлэн “Бэлтгэл” гэсэн хэсэгт танай цуглааны байрны номын санд байдаг илүү том хэмжээтэй зургууд (адил сэдэвтэй зарим зургууд номын сангийн зургуудаас өөр байж болно) болон Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга дахь зургуудын дугаарыг оруулсан болно.

Үзүүлэн бүхий хайчилбарууд. Хичээлүүдэд ашиглагддаг үзүүлэн бүхий хайчилбарууд нь гарын авлагатай хамт байдаг бөгөөд гарын авлагатай хамт хадгалагдах ёстой. Дүрснүүдийг хайчлаад тохирох хичээлүүдэд ашигла. Та хичээлүүдэд санал болгосон үг бичсэн хэрчим цаас, схем, тарааж өгөх материал зэрэг бусад заахад туслах энгийн зүйлсийг хийж ашиглах хэрэгтэй. Эдгээр туслах зүйлүүдийг бусад хичээлүүд буюу дараагийн жилүүдэд ашиглахаар хадгал.

Хөгжим. “Анги дахь Хөгжим,” х. viii-ыг үз.

Хоол хүнсний зүйл. Хичээл дээр хоол хүнсний зүйл хэрэглэхийг санал болгосон ямар ч үед хүүхдүүдээс хэнд нь ч хоол хүнсний ямар нэг харшил болон биеийн бусад сөрөг хариу үйлдэл илэрдэг эсэхийг эцэг эхчүүдээс нь асууж магадлана уу. Мацгийн Ням гарагт хоол хүнсний зүйл бүү авчир.

Хуваалцах Цагийн Танилцуулгууд

Үе үе танай ангиас Хүүхдийн Хэсгийн хуваалцах цагийн үеэр сайн мэдээний энгийн танилцуулга хийхийг хүсэх болно. Ийм танилцуулгуудыг хичээлүүдээс хялбаршуулан авах ёстой. Та хичээлд бэлтгэх болон заахдаа хуваалцах цагт тохирох санаануудыг эрж хай. Түүнчлэн та тухайн үеийн хүүхдийн ариун ёслолын цуглааны танилцуулгаас аль нэг зарчмыг хуваалцахыг сонгож болно.

Хуваалцах цагийн үеэр өөрийнхөө удирдлага дор хүүхдүүдээр сайн мэдээний зарчмыг заалгах нь тэдэнд уг зарчмыг сурч, хуваалцахад нь туслах ашигтай арга мөн.

Хуваалцах цагийн танилцуулга нь энгийн хялбар бөгөөд их давтлага шаардахгүй байгаа эсэхийг шалга. Та хичээлийн нэг хэсгийг уг танилцуулгыг бэлтгэхэд ашиглаж болно. Ангийн үр нөлөөтэй, энгийн танилцуулгуудад дараах зөвлөмжүүдийг ашиглаж болно:

1. Хичээлийн аль нэг түүх, эсвэл нөхцөл байдлаас жүжигчлэн тоглоход нь хүүхдүүдэд тусал.
2. Зураг, зурвас цаасан дээр бичсэн үгс, хайчилбар дүрсүүдийг ашиглан хичээлийн аль нэг түүхийг хүүхдүүдээр яриул.
3. Болох гэж байгаа баптисмынх нь талаарх бодол санааг нь хүүхдүүдээр тайлбарлуул. Хэрэв хүүхдүүдийн хэн нэгэн нь найман нас хүрч, баптисм хүртсэн бол баптисмынх нь талаарх бодол санаагаа хуваалцахыг тэднээс хүс.

4. Итгэлийн тунхагийг давтаж, тайлбарлахад нь хүүхдүүдэд тусал. Түүнчлэн та *Children's Songbook*, х. 122–33-аас итгэлийн тунхагийн тухай дуунуудын нэгийг тэднээр дуулуулахыг хүсч болно.

Нэмэлт тусламж авахын тулд *Primary Sharing Time Resource Manual* (33231)-ийг үз.

**Хүүхдүүдийн
Гэр Бүлүүдтэй
Хуваалцах нь**

Хүүхдүүдийг Хүүхдийн Хэсэгт сурсан зүйлээ гэр бүлтэйгээ хуваалцахад нь урамшуулан дэмж. Хичээлийг баяжуулахын тулд эцэг эхчүүдийг үе үе ирж, хичээлд оролцохыг урь. Хүүхдийн Хэсгийг хүүхдүүдийнх нь хувьд илүү утга учиртай болгоход туслах эцэг эхийн аливаа санаануудыг уриалгаханаар хүлээж ав.

**Баптисмд
Бэлтгэх нь**

Танай ангид долоон настай хүүхдүүд байдаг бол тэдний зарим нь тухайн жилд баптисм хүртэх байж таарна. Хүүхдийн Хэсгийн багшийн хувьд та тэдгээр хүүхдүүдийн гэр бүл болон ангийн гишүүдийг баптисмд бэлтгэхэд нь дэмжин тусалж чадна. Үүнийг хийхэд тань туслах дараах зөвлөмжүүдийг анхаар:

1. Хэрэв боломжтой бол өөрийнхөө ангийн анхны хүүхдийг баптисм хүртэхээс нь өмнө баптисм болон гишүүний баталгааны тухай хичээлүүдийг (хичээл 12, 13) заа.
2. Хүүхэд бүрийн баптисмын өмнөх Ням гарагт энэ ёслолын ач холбогдлын талаар ярилцахын тулд хичээлийн цагаас хэдэн минут гарга.
3. Боломжтой бол, хүүхэд бүрийн баптисмд Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн нэг гишүүн болон оролцож чадах ангийн гишүүдийн хамт оролц.
4. Хүүхдүүдэд хуваалцах цагт зориулж баптисмын тухай ангид хийх танилцуулгуудыг бэлтгэхэд нь тусал.

**Хүүхдүүдийг
Ойлгох нь**

Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд заах таны дуудлага бол таны бишоп, эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлөөр дамжуулан танд өгөгдсөн нандин итгэмжлэл юм. Санваарын эдгээр удирдагчид Тэнгэрлэг Эцэгийн бурханлиг нөлөөллөөр таныг дуудсан билээ. Та ангийнхаа хүүхдүүдэд бүх амьдралынхаа туршид Аврагчийг дагахад нь маш их нөлөө үзүүлж чадна.

Ангийнхаа хүүхдүүдэд ямагт нааштай хандаж, тэднийг хайрлах хайрыг илэрхийлж бай. Хүүхэд бүрийн авъяас, сонирхол, чадварыг таньж мэд. Унших болон бичих шаардлагатай хичээлийн үйл ажиллагаануудыг хүүхдүүдийн чадварт тохируулан хэрэглэ.

Тэднийг сонсох хийгээд хүүхэд болгонд аль болохоор ганцаарчлан анхаарал тавих байдлаар бүх хүүхдүүдэд өөрийнхөө үнэ цэнийг нааштайгаар үнэлэх явдлыг төлөвшүүлэхэд тусла.

Эдгээр хичээлүүдийг нэг адил насны буюу дөрвөөс долоон нас хүртэлх холимог насны хүүхдүүдийн бүлгийн аль алинд нь зориулж бичсэн болно. Гэвч, та өөрийнхөө ангийн хүүхдүүдийн насанд тохируулан хичээлүүдийг

хялбаршуулах хэрэгтэй байж болно. Хичээлийг яаж зохион байгуулахаас хамаарахгүйгээр хүүхдүүдийн насны ерөнхий онцлогуудыг ойлгох нь илүү үр дүнтэй заахад тань туслах болно. Энэ нь хүүхдүүд хичээл хийх үедээ яагаад тийм зан төрхтэй байдаг хийгээд тэдэнд хамгийн сайнаар заах арга замаар хэрхэн заахыг мэдэхэд тань туслах болно. Түүнчлэн хүүхдүүдийг ойлгох нь ангид сэтгэл санааны эерэг уур амьсгал бий болгоход тань тусална. Та хичээлд бэлтгэхдээ дараах нөхцөлүүдийг нэгтгэн дүгнэ. Гэвч, хүүхэд бүр өөрийнхөө хувь хэмжээгээр өсч хөгждөгийг санагтун. Эдгээр нь зөвхөн ерөнхий удирдамжууд юм.

Дөрвөн настай хүүхдүүд

Дөрвөн нас бол танин мэдэх нас юм. *Яагаад, яаж* гэсэн хоёр үг бол дөрвөн настай хүүхдүүдийн хамгийн олон хэрэглэдэг үг юм. Дөрвөн настай хүүхдүүд нэн идэвхитэй байдаг. Дараах нь дөрвөн настай хүүхдүүдийн ерөнхий онцлогууд юм:

1. Тэд гурван настай хүүхдүүдийг бодвол илүү амархнаар, мөн илүү итгэлтэйгээр гүйж, харайж, авирч чадна. Тэд бөмбөг шидэх буюу өшиглөж, тэгш өнцөгтүүдээр байшин угсарч чадна.
2. “Би үүнийг өмнө нь хийсэн; одоо би ямар нэгэн өөр юм хийж чадна” гэхчлэнгээр тэд хэлэх дуртай байдаг.
3. Тэд бусад хүүхдүүдтэй тоглох дуртай байдаг хэдий ч, олон хүүхэдтэй бүлэгтэй нийлэхэд бэлэн биш байдаг.
4. Тэд бусад хүүхдүүдтэй тоглохыг хүсдэг бөгөөд ингэх шаардлагатай байдаг ч гэсэн тэд ихэвчлэн тус тусдаа тоглодог. Тэд бүлэгтэй хамтран хөгжмийн аянд тоглох буюу бүжиглэж ч болох боловч бусад хүүхдүүдийн яаж тоглож байгаа буюу бүжиглэж байгааг төдийлөн анхаардаггүй.
5. Тэд олон асуулт асуухаас гадна өөр хүүхэд буюу насанд хүрсэн хүнтэй яриа өрнүүлж чадна.
6. Тэдэнд тохиолдсон зүйл ихэвчлэн гэрт тохиолддог учраас тэд гол төлөв гэр орон, гэр бүлийнхээ тухай ярьдаг. Энэ насны хүүхдүүд гэр бүлийнхээ талаар багшдаа ярих дуртай байдаг. Тэд бусад хүүхдүүдийн түүхүүдийг сонсохоосоо илүү өөрсдийнхөө түүхүүдийг ярих нь олонтаа байдаг. Гэр бүл дээр төвлөрсөн хичээлүүд болон үйл ажиллагаануудад тэд дуртай байдаг.
7. Тэд гагцхүү тухайн цаг үедээ л амьдардаг. Өчигдөр болон маргааш нь бага ач холбогдолтой байдаг. Гэвч тэд болох гэж байгаа үйл явдлуудад их сэтгэл хөдлөлтэйгөөр ханддаг, учир нь тэд цаг хугацааны утга учрыг ухан ойлгож чаддаггүй, тэд ирээдүйн зарим үйл явдлын талаар “Энэ чинь маргааш уу?” хэмээн асууж болно.
8. Тэд түүхүүд болон холбож хэлсэн үгсийг сонсох дуртай байдаг. Тэд өөрсдийн дуртай түүхүүдийг өчүүхэн ч өөрчлөлтгүйгээр дахин дахин сонсохыг хүсдэг. Түүхийг сонссоны дараа, тэд үйл явдлыг жүжигчлэн тоглох дуртай байдаг.
9. Тэд бага зэргийн туслалцаатайгаар залбирч сурч чаддаг.

Таван настай хүүхдүүд

Таван настай хүүхдүүд өөртөө илүү итгэлтэй, ерөнхийдөө бие даасан байдалтай байдаг. Тэд ихэвчлэн гэр орондоо өөрсдөөс нь хийхийг хүсэн хүлээдэг зүйлийг хийж сурсан байдаг. Тэд бусад хүүхдүүдтэй тоглохдоо сайн ч гэсэн, дээс тоглох, зураг зурах зэрэг олон арга замаар өөрөө өөрсдийгөө бас зугаацуулж чаддаг. Дараах нь таван настай хүүхдүүдийн зан чанарын нийтлэг хэлбэрүүд юм:

1. Тэдний их булчингийн зохицуулалт үргэлжлэн сайжирсаар байдаг. Одоо тэд дээс тоглож, нугарч, өрөөсөн хөл дээрээ догонцон үсэрч чадна. Тэд чарга буюу тэргэнцэрийг амархан чирж, түрж чадна.
2. Тэдний бага булчингийн зохицуулалт нь зураг эвлүүлж наах, хайчлах, зургуудыг шугамнуудын дагуу биш ч гэсэн будах боломжийг тэдэнд олгодог байна. Мөн тэдний олонх нь гутлынхаа үдээсийг үдэж чаддаг.
3. Дөрвөн настай хүүхдүүдийг бодвол тэд илүү итгэлтэй бөгөөд биеэ даасан байдаг. Тэд голдуу гэр орныхоо ажилд туслах дуртай байдаг, мөн тэд эцэг эхтэйгээ хамт ажиллаж чадаж байгаадаа баяртай байдаг.
4. “Энэ чинь юунд хэрэгтэй юм бэ?”, эсвэл “Энэ чинь яаж ажилладаг юм бэ?” гэж тэд асуухдаа үнэн сэтгэлээсээ байдаг. Тэд бодолтой, үнэн хариуг өөрсдийн ойлгож чадах хэлээр, нарийвчлалтайгаар хүлээж авахыг хүсдэг, мөн ингэх ч ёстой.
5. Тэд багш нараа хайрладаг бөгөөд тэдний дэргэд суух нь онцгой боломж гэж үздэг байна. Багш нар нь тэднээр туслалцуулан зураг дээш нь барих, эсвэл өөр ямар нэгэн юм хийхийг хүсэхэд тэд баяртай байдаг.
6. Тэд бага бүлгээр хийх төслүүд болон гэр орон, гэр бүлийн тухай жүжигчилсэн тоглолтуудад дуртай байдаг.
7. Тэд түүхүүд сонсох буюу ярих дуртай байдаг, мөн тэд нэг түүхийг ярихыг дахин дахин гуйдаг. Давтлага бол тэдний сурах гол арга мөн. Тэд голдуу түүхийг номын хуудас эргүүлж байхдаа бараг үг үгээр нь ярьж чаддаг.
8. Тэд ихэвчлэн нөхөрсөг, өөдрөг, энхрий, тусархуу байдаг, гэвч аргаа олохгүй үедээ их ааш муутай болдог.
9. Тэд том болж, нас нэмэгдсэнээ харуулах шинэ боломжуудтай болох дуртай байдаг.
10. Тэд арваас арван хоёр минутад анхаарлаа төвлөрүүлэх чадвартай байдгаас нэг үйл ажиллагаанаас нөгөөд түргэн шилждэг. Хурууны тоглоомууд тэдний хувьд аль хэдийн жаахан хүүхдийнх болсон гэж тэд боддог болж эхэлдэг бөгөөд илүү том хүүхдийн үйл ажиллагаа буюу өөр дасгалууд хийхийг хүсдэг.
11. Тэд голдуу өөр хүүхдийн тоглож байгаа ямар нэгэн зүйлээр тоглохыг шаардах болно. Ийм асуудлыг анхааралтайгаар шийдвэрлэхийг хичээ; хүүхдүүдэд ээлжлэхийг заа.
12. Тэд цөөн хүүхэдтэй бүлгийг олон хүүхэдтэй бүлгээс илүүд үздэг. Тэд арван хүүхэдтэй бүлгээс илүү нэг сайн найзтайгаа тоглохыг дээр гэж үздэг.
13. Тэд төсөөлөл, бодит байдлын хоорондох ялгааг хараахан мэдээгүй байдаг. Тиймээс, хүүхэд өөрийнх нь цаг алтаар хийгдсэн, аав нь аль ч бусад аавуудаас илүү том буюу эсвэл түүний барьсан загас үлэмж том байсан гэж хэлж болно. Энэ бол хүүхдийн амьдрал дахь хэвийн үе мөн; юу бодитой, хүүхдүүдэд юу бодитой бишийг ялган таньж сурахад цаг хугацаа шаардагддаг. Хүүхдүүдийг хөгжиж байхад энэ үе өнгөрдөг.
14. Тэд бол өрнүүн хүсэл эрмэлзэлтэй суралцагчид мөн. Тэнгэрлэг Эцэг тэдэнд нэн бодитой учраас тэд түүнийг ихэд сонирхож, түүний тухай олон асуулт асуудаг. Залбирах нь тэдэнд таалагддаг бөгөөд тэд туслалцаагүйг залбирах чадвартай ч байж болно.

Зургаан настай
хүүхдүүд

Зургаан настай хүүхдүүд биеэ сайн хянах чадвартай болсон байх бөгөөд шинэ ур чадварт суралцах хийгээд аль хэдийн олж авсан ур чадваруудаа төгөлдөржүүлэхэд их эрч хүч гаргаж чаддаг. Жишээ нь, тэд дээсээр тоглож, бөмбөг залж, шүгэлдэж, гаран дээрээ эргэж, дугуй унаж чадаж болох юм. Зургаан настай хүүхдүүдэд өөрсдийн бага булчинг ашиглахад бэрхшээлтэй хэвээр байж болох боловч тэд цагаан толгойн үсгүүд, өөрсдийн нэр, тэрчлэн өөр хэдэн үгсийг дармалдан бичиж сурч чадна. Дараах нь зургаан настай хүүхдүүдийн ерөнхий онцлогууд юм:

1. Тэдний анхаарлаа төвлөрүүлэх хугацаа нэмэгдэнэ. Хэдийгээр тэд ихэд тайван бус ч гэсэн, сонирхлоосоо хамааран арван тав буюу хорин минутын үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж чадна.
2. Модонд авирах, тоглоомын талбай дахь төхөөрөмжүүд дээр дасгал хийх, эсвэл гүйлтийн тэмцээн зэрэг бүх биеийн хөдөлгөөн хийх нь тэдэнд таалагддаг.
3. Тэд тоглоомууд болон нөхөрсөг тэмцээнүүдэд дуртай байдаг.
4. Багшийн санал тэдэнд их чухал ач холбогдолтой байдаг. Тэд багшийн дэргэд суухыг мөн зураг өргөж харуулах буюу эсвэл материалуудыг номын санд буцаан аваачиж өгөх зэргээр хичээлд туслахыг хүсдэг.
5. Тэд мөн түүхүүд сонсох, тэдгээрийг жүжигчлэн тоглох, мөн дуурайх дуртай хэвээр байдаг. Олонх нь ахлах насны маягаар хувцаслах дуртай байдаг.
6. Тэд нэн өгөөмөр, энхрий ялдам хийгээд эв нийцтэй байдаг хэдий ч өөрсдийн өвөрмөц арга замыг олоогүй үедээ их муухай ааштай бөгөөд маргаанч байж болно.
7. Тэд дээсэн дээгүүр үсрэх, харайх, дэвхрэх зэрэгт илүү чадваржсан байдаг. Тэд эдгээр чадваруудаа тоглоомонд ашиглахдаа дуртай байдаг.
8. Тэд сайн ба муу зан чанарт ихэд анхаардаг болсон байдаг.
9. Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэх тэдний итгэл өсөн нэмэгддэг. Зургаан настай хүүхдүүдийн ихэнх нь хэрэв өмнө нь гэр орондоо болон бусад хичээлүүд дээр залбирч байсан туршлагатай бол ганцаараа залбирч чадна.

Долоон настай
хүүхдүүд

Хүүхдүүд долоотойдоо эцэг эхдээ ойр дотно хэвээр байж, тэдний хайр, анхаарал хийгээд энэрэл халамжийг үнэлсэн хэвээр байдаг хэдий ч гэр орноос гадуурх олон хүмүүс болон нөхцөл байдлуудтай илүү их холбоотой болж эхэлдэг байна. Тэдэнд хувийн таашаал сонирхол бий болж, зарим зүйлд өөрсдөө бие даан шийдвэр гаргах боломжтой байхыг хүсдэг. Тэд өөрсдийнхөө эргэн тойрон дахь амьдралд үнэхээр хүсэл эрмэлзэлтэй болж, мөн үүнийгээ үлэмж хэмжээгээр сонирхож эхэлдэг. Тэд олон үйл ажиллагааг олж мэдэн өөрсдөд нь баяр баясгалан авчирдаг үйл ажиллагаануудыг давтан хийх дуртай байдаг. Дараах нь долоон настай хүүхдүүдийн ерөнхий онцлогууд юм:

1. Тэдний том булчингууд сайн хянагддаг, мөн тэд илүү гуалиг тэгш, хурдан, шаламгай болдог.
2. Тэдний бага булчингийн хяналт хөгждөг. Тэд илүү хялбархан бөгөөд нямбай дармалдан бичиж чадна.
3. Ихэнх хүүхдүүд нь хөдөлгөөнтэй, идэвхтэй тоглоомонд дуртай болж, нэг тоглоомоо дахин, дахин тоглодог.

4. Тэд голдуу тайван биш мөн хөдөлгөөнтэй болдог. Тэд эрч хүчээр дүүрэн боловч амархан ядардаг. Амралтын цаг чухал.
5. Тэд юм цуглуулж, тэдгээрийн талаар ярих дуртай байдаг. Тэд өөрсдөө буюу хэсэг бүлгээрээ хийсэн юмсынхаа талаар ярилцах бас дуртай байдаг.
6. Нэг зүйл дээр анхаарал төвлөрөх хугацаа нь нэмэгддэг, энэ насны хүүхдүүд хэрэв сонирхолтой байвал төслийг дуусгаж чадна, гэсэн хэдий ч, энэ нь хориос хорин таван минут л шаарддаг. Тэдэнд ихэнх хичээлүүдийн үйл ажиллагааг өөрчлөх хэрэгтэй байдаг.
7. Тэд эсрэг хүйсийн хүүхдүүдтэй бага хэмжээгээр харилцан ажиллаж эхэлдэг.
8. Тэд түрэмгий биш, өөрсдийн арга замд төдийлөн шийдэмгий биш байдаг.
9. Тэд бодолдоо илүү бие даасан, илүү учир зүйн үндэслэлтэй болдог.
10. Тэд зөв, буруугийн талаар илүү сайн мэдэх болж, тэдний бодлоор зөвийг хийдэггүй хүмүүсийн тухайд их шүүмжлэлтэй ханддаг.
11. Тэд баптисм хийлгэхийг тэсэн ядан хүлээж байдаг.
12. Тэд ганцаар залбирч чадна, тэрчлэн голдуу залбирлууддаа шууд хариу хүлээдэг.
13. Тэд мацгийн Ням гарагт доод тал нь нэг хоолоор мацаг барьж, аравны нэг төлж чаддагтаа бахархалтай байж болно.

**Тахир Дутуу
Хүүхдүүдийг
Оролцуулах
Тусгай
Удирдамжууд**

Аврагч бидэнд тахир дутуу хүмүүст сэтгэл санааны дэмжлэг, энэрлийг үзүүлэхэд үлгэр дуурайл үзүүлсэн билээ. Тэрээр амилалтынхаа дараа Нифайчууд дээр очихдоо:

“Та нарын дунд өвчтэй нь байна уу? Тэднийг нааш авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, эсвээс уяман өвчтэй, эсвээс татанги эсвээс дүлий эсвээс ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн нэгэн байна уу? Тэднийг нааш нь авчрагтун мөн би тэднийг эдгээх болно, учир нь та нарыг өрөвдөх сэтгэл надад буй” хэмээн хэлжээ (3 Нифай 17:7).

Та Хүүхдийн Хэсгийн багшийн хувьд өрөвч сэтгэлийг харуулах онцгой байр сууринд байдаг билээ. Та мэргэжлийн туслалцаа үзүүлэх талаар сургагдаагүй байж болох хэдий ч, тахир дутуу хүүхдүүдийг ойлгож, тэднийг тэтгэн дэмжиж чадна. Санаа тавих, ойлгох, үйл ажиллагаануудыг сурахад нь ангийн гишүүн бүрийг оролцуулах хүсэл хэрэгтэй.

Тахир дутуу хүүхдүүд, тэдний ойлголтын түвшин ямар байхаас хамааралгүй Сүнсээр хөндөгдөж чадна. Зарим хүүхдүүд Хүүхдийн Хэсгийн нийт цагт оролцох боломжгүй байж болох хэдий ч, тэд Сүнсийг бүр багахан ч гэсэн мэдрэх боломжтой байх хэрэгтэй. Хэрэв аль нэг хүүхдэд Хүүхдийн Хэсгийн үед нийт бүлгээс тусдаа байх цаг шаардлагатай байвал тэр хүүхдийн хэрэгцээнд мэдрэмжтэйгээр хандах нэг хамтрагч байх шаардлагатай байж болно.

Ангийн зарим гишүүдэд тахир дутуу, оюун ухааны хомсдолтой, хэл ярианы гажигтай, хараа буюу сонсголгүй, зан төлвийн болоод нийгмийн асуудалтай, оюуны эмгэгтэй, хөдөлгөөний бэрхшээлтэй, эсвэл эрүүл мэндийн хувьд хууч өвчтэй хүүхдүүд хүндрэлтэй байж болно. Зарим хүүхдүүдэд таньж мэдэхгүй хэл болон соёлын хүндрэл бэрхшээлтэй тулгарч болно. Хувийн нөхцөл байдлуудаас хамаарахгүйгээр хүүхэд бүр бусдаар хайрлуулж, хүлээн зөвшөөрөгдөж, сайн мэдээг сурч, Сүнснийг мэдэрч, амжилттай оролцож, түүнчлэн бусдад үйлчлэх нэгэн адил хэрэгцээтэй байдаг.

Эдгээр удирдамжууд нь тахир дутуу хүүхдүүдэд заахад тань тусалж чадна:

- Тахир дутуугийнх нь талаар огт анхаарахгүйгээр, зөвхөн хүүхдийг танин мэд. Ердийн байдгаараа, нөхөрсөг, эелдэг ялдамхан бай.
- Тухайн хүүхдийн өвөрмөц хүч хийгээд бэрхшээлийн тухай мэд.
- Ангийн гишүүдэд ангийн гишүүн бүрийг хүндэтгэх үүрэг хариуцлагыг нь зааж, сануулахад бүхий л хүчин чармайлтаа гарга. Ангийн тахир дутуу гишүүнд туслах нь нийт ангийнханы хувьд Христийнхтэй адил суралцах туршлага болж чадна.
- Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүд, түүнчлэн тохиромжтой үед хүүхэдтэй өөртэй нь зөвшилцөх байдлаар хүүхдэд заах хамгийн шилдэг аргуудыг ол.
- Тахир дутуу хүүхдүүдийг уншуулах, залбирал хийлгэх буюу өөр байдлаар оролцуулахаар дуудахаас өмнө ангийн үйл ажиллагаанд оролцох талаарх тэдний санаа бодлыг асууж бай. Хүүхэд бүрийн чадвар, авьяасыг онцлон анхаарч, хүүхэд ая таатай, амжилттай оролцож болох арга замуудыг эрж хай.
- Тахир дутуу хүүхдүүдийн хувийн хэрэгцээнд тохируулан хичээлийн материалууд болон эргэн тойрон дахь зүйлүүдийг хялбар эвтэйхэн болго.

**Хүүхэдтэй Зүй
Бус Харьцах
Асуудлуудыг
Зохицуулах нь**

Багшийн хувьд та ангийнхаа хүүхдүүдээс сэтгэл санааны болон бие махбодын зүй бус харьцаанаас болж тавгүйдтэг хүүхдүүдийг мэддэг болж болно. Хэрэв та ангийнхаа аль нэг хүүхдийн талаар санаа зовниж байгаа бол бишоптойгоо зөвлөнө үү. Хичээлд бэлтгэж заахдаа Их Эзэний удирдамж, чиглүүллийн төлөө залбир. Ангийнхаа хүүхэд бүрт өөрийгөө Тэнгэрлэг Эцэгийн үнэ цэнэтэй хүүхэд бөгөөд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд бүгдэд нь хайртай, биднийг аз жаргалтай, аюулгүй байхыг хүсдэг гэдгийг мэдрэхэд нь тусал.

Зөвийг Сонгохоос Аз Жаргал Ирдэг

Хичээл

1

Зорилго

Хүүхэд бүрт зөвийг сонгохоос аз жаргал ирдгийг ойлгоход нь туслах

Бэлтгэл

1. Матай 5:6, 3 Нифай 12:6-г залбиралтайгаар судал. Түүнчлэн Сургаал ба Гэрээ 58:27 болон *Евангелийн Үндсүүд* (31110), бүлэг 4-ийг үз.
 2. ЗС уриа хий. Есүс Хүүхэдтэй хамт зураг 2-1-ийг том цаасан дээр буюу самбарын үзүүлэн дээр тогтоо. ЗС үсгүүдийг зургийн дээд талд, тэрчлэн *Би зөвийг сонгоно* гэсэн үгсийг зургийн доод талд дармалдан бич. Уриаг дараагийн хичээлүүдэд ашиглахаар хадгал.
 3. Хүүхэд бүрийн тухай ангийнхантай хуваалцахаар зарим нарийн тодорхой зүйлийг мэдэхийн тулд хүүхэд бүрийн эцэг эхтэй ярилц.
 4. “Зөв замыг сонго” (*Children’s Songbook*, х. 160) дууг дуулах буюу үгийг нь хэлэхээр бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
 5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи буюу Мормоны ном.
 - б. Шохой, самбар хийгээд арилгагч.
 - в. ЗС бөгж байхгүй хүүхэд бүрт үүнийг өгөх (х.vii дахь “Багшид зориулсан тусламжуудын ”Ангид хийх мэдээллийг“ үз).
 - г. Хүүхэд бүрт ЗС бамбайн нэг хувь, эсвэл үүний хуулбар зураг (гарын авлагын урд талд байгаа).
 - д. Өнгийн харандаа, хайчнууд.
 - е. Хүүхэд бүрт урт нэхмэлийн утас.
 6. Өөрийн ашиглахыг хүссэн баяжуулах үйл ажиллагаануудад зориулан шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

Хичээл Заах

Зөвлөмж

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон ангийнхаа хүүхдүүдэд хайраа илэрхийлэн, нээлтийн залбирал хий.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ Хоёр Бидэнд Хайртай

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Өөрийнхөө тухай, мөн Хүүхдийн хэсгийн энэ жилийн ангийн талаарх сэтгэгдэл болон хүслийн тухай хүүхдүүдэд товчхон ярь. Хүүхэд бүрийг ангийн бусад гишүүдэд танилцуулах, ингэхдээ уг хүүхдийн талаар ямар нэг юм хэл.

ЗС уриа

Өөрийнхөө хийсэн ЗС уриаг үзүүл. Хүүхдийн хэсгийн ангид энэ жил бидний Аврагч, Есүс Христийн тухай сурч мэдэх болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэдний мэдэж авах хамгийн чухал зүйлүүдийн нэг нь Есүс тэднийг бүгдээрэнг нь хичнээн их хайрладаг тухай юм. Есүс ангийн чинь хүүхэд бүрийг хайрладгийг гэрчил. Энэ жишээнд байгаагийн адил хүүхэд бүрийг нэрээр нь дурдан: “Есүс Стефанид хайртай” гэхчлэн хэл. Тэнгэрлэг Эцэг ч бас тэднийг бүгдээрэнг нь хайрладаг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ Хоёр Биднийг Аз Жаргалтай Байхыг Хүсдэг

Багшийн
танилцуулга

Хүүхдэд Есүс Христ, Тэнгэрлэг Эцэг хоёр биднийг бүгдээрэнг нь маш их хайрладаг учраас тэд биднийг аз жаргалтай байхыг хүсдэг гэж хэл. Та үнэхээр аз жаргалтай байгаагаа мэдэрсэн зарим тохиолдлуудаасаа хүүхдүүдтэй хуваалц. (Ийм жишээнүүд нь баптисм хүртэх, бусадтай хуваалцах, найз нартайгаа ямар нэгэн хөгжилтэй зүйл хийх, зорилгодоо хүрэхээр ажиллах, гэр бүлийнхэнтэйгээ хамт цагийг сайхан өнгөрүүлэх, Есүсийн тухай унших буюу сурах, ариун сүмд гэрлэх болон номлолд үйлчлэх зэргийг оруулсан байж болно.)

Хүүхдийн
оролцоо

Хүүхдүүдээр өөрсдийнх нь баяртай байдаг үеүдийнх нь тухай яриул. Хэрэв хүүхдүүдийг жаахан өдөөх хэрэгтэй бол дараахтай адил асуултуудыг асуу:

- Та нар ах, эгч, дүү нартайгаа тоглохдоо баяртай байдаг уу?
- Та нар ээж, эсвэл аавдаа туслахдаа баяртай байдаг уу?
- Та нар дуртай үйл ажиллагаагаа хийхдээ баяртай байдаг уу?
- Та нар Сүмд ирэхдээ баяртай байдаг уу?

Зөвийг Сонгох нь Аз Жаргал Авчирдаг

Түүх ба
ярилцлага

Дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Жэймс яг манай ангийн гишүүн байх насанд хүрсэн жаал хүү байлаа. Нэг өдөр тэрээр өөрийнхөө тэжээдэг амьтныг ангидаа авчирч болох эсэхийг Хүүхдийн Хэсгийн багшаасаа асуужээ. Багш нь “Зөвийг сонго, Жэймс ээ, Зөвийг сонго” гэж хариулжээ.

- Жэймс юу хийхийг сонгосон гэж та нар бодож байна вэ?

Жэймс найзыгаа сүм рүү авчирч болох эсэхийг Хүүхдийн Хэсгийн багшаасаа асуухад багш нь, “Зөвийг сонго, Жэймс ээ, Үргэлж зөвийг сонго” гэж хэлжээ.

- Түүнийг ямар сонголт хийсэн гэж та нар бодож байна вэ?

“Зөвийг сонго, Жэймс ээ. Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр биднийг үргэлж зөвийг сонгохыг хүсдэг” гэсэн эдгээр ижил үгсийг эцэг эх нь олон удаа хэлэхийг Жэймс сонссон байлаа.

- Зөвийг сонгох гэдэг нь юу гэсэн үг вэ?

Нэг өдөр Жэймс сургуулиасаа гэртээ ирээд ээж нь нэг жигнэмгийг түүнд, бас нэгийг ахад нь тавьсан байхыг олж харжээ. Жэймс жигнэмэгт дуртай байсан бөгөөд тэрээр өөрийнхөө жигнэмгийг хурдхан шиг идчихлээ. Тэгээд тэр ахынхаа жигнэмгийг харлаа. Ах нь гэртээ байсангүй, тэгээд ч “Зөвийг сонго, Жэймс ээ, Үргэлж зөвийг сонго” гэж хэлэх хүн ойр хавьд нь байсангүй.

- Та нар яах байсан бэ?
- Хэрэв Жэймс зөвийг сонгосон бол тэр яах байсан бэ?

Жэймс ахынхаа жигнэмгийг идчихэв. Жэймсийн ах гэртээ ирээд түүнд жигнэмэг байхгүй байгааг харжээ. Тэрээр ээж нь түүнд жигнэмэг тавихаа мартсан юм байхдаа гэж бодсон бөгөөд тэр маш гунигтай байлаа. Ахынхаа жигнэмгийг идсэн нь Жэймст эвгүй санагджээ.

- Жэймс зөвийг сонгосон уу?
- Жэймс хийсэн сонголтондоо баяртай байсан уу?
- Одоо Жеймс яах ёстой вэ?

Хүүхдүүдэд Жэймсийн буруу сонголтоо залруулж болох арга замуудын талаар бодоход нь тусал. Бид үргэлж зөвийг сонгохыг хичээх ёстой боловч хэрэв бид бурууг сонговол буруу сонголтуудаа залруулахыг хичээх ёстой гэдгийг онцлон хэл. Бид буруу сонголт хийсэн үедээ баяр баясгалангүй байх болно, харин бид зөв сонголтууд хийсэн үедээ баяртай байх болно.

Судар

Бид зөвийг сонгосон үедээ баяртай байх болно хэмээн Есүс бидэнд хэлсэн гэдгийг хүүхдүүдэд хэл. Матай 5:6 буюу 3 Нифай 12:6-г (*зөв шударгыг дуустал*) чангаар унш. “Зөв шударгын тул өлсөж мөн цангах” гэдэг нь зөвийг сонгох гэсэн утгатайг тайлбарла. Бид зөвийг сонгосон үедээ адислагдах болно.

ЗС нь Зөвийг Сонгох Гэдгийг Төлөөлдөг

Самбар дээр хийх үйл ажиллагаа

- Ээж чинь чиний бүтэн нэрийг бичихгүйгээр чинийх болох ямар нэгэн зүйлийг хэрхэн тэмдэглэж болох вэ? (Тэрээр нэрний чинь эхний үсгүүдийг хэрэглэж болно.)

Бидний нэрний эхний үсгүүд бол бидний овог нэрийн эхний үсгүүд юм гэдгийг тайлбарла.

Өөрийнхөө нэрийн эхний үсгүүд ямар үсгүүд болохыг хүүхдүүдэд хэлж өг. Тэдгээрийг самбар дээр бичиж, тохирох үед нь эхний үсэг бүр лүү зааж нэрээ давтан хэл.

- Таны нэрийн эхний үсгүүд нь ямар үсгүүд вэ?

Хүүхдүүдийн нэрийн эхний үсгүүдийг самбар дээр бичээд тэдгээр нь тэдний нэрийг хэрхэн төлөөлдгийг харуул. Эхлээд нэрийн эхний үсгүүдийг дармалдаж, дараа нь нэрүүдийн үлдсэн хэсгийг нэмж бич. (Хэрэв танай анги олон хүүхэдтэй бол жишээ болгож цөөхөн хүүхдийн нэрийн эхний үсгүүдийг ашигла.)

ЗС-ыг доор үзүүлснээр самбарт босоогоор нь бич. Хэрэв хүүхдүүд үсгүүдийг уншиж чаддаг бол тэдний гарыг өргүүл.

З С

Нэрийн эхний үсгүүдийг ангийнхантай хамт чангаар унш. Эдгээр үгийн эхний үсгүүд нь хоёр чухал үгийг төлөөлж байгааг хүүхдүүдэд хэл. Үгнүүдийг самбарт гүйцээж бич:

Зөвийг
Сонго

Үгсийг хүүхдүүдтэй хамт уншаад тэднээр эхний үсгүүдийг нь давтан хэлүүл. Тэгээд үсгүүд нь юуг төлөөлдгийг хамтдаа хэл.

Хүүхдүүд “ЗС” гэж хэлэхдээ “зөвийг сонго” гэдгийг бодож байх ёстой гэдгийг онцлон хэл. Эдгээр эхний үсгүүд нь тэдэнд Есүс Христийг дагах болон тэднийг баяртай болгодог зүйлүүдийг хийхийг санахад нь тусална гэдгийг хүүхдүүдэд хэл.

Бид Зөвийг Сонгохыг Санаж Чадна

ЗС уриа

ЗС уриан дээрх Есүс Христийн зургийг үз. Хүүхдүүдэд тэднийг энэ жил Хүүхдийн Хэсэгт Есүс дэлхий дээр амьдарч байхдаа хийж, мөн зааж байсан олон зүйлүүдийн тухай сурах болно гэдгийг хэл. Есүс үргэлж зөвийг сонгодог байсан бөгөөд тэрээр биднийг аз жаргалтай байж, бусдыг аз жаргалтай байхад нь туслахын тулд зөвийг сонгохыг хүсдэг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг босгож, ЗС уриан дээрх “Би зөвийг сонгоно” гэсэн өгүүлбэрийг хамтад нь хэлүүл.

Дуу

Хүүхдүүдэд “Зөв замыг сонго” дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд нь тусал. Хүүхдүүдийг дууг дуулж, эсвэл зарим үгсийг нь өөрсдөө хэлж чаддаг болтол нь дууг хэд хэдэн удаа давт.

ЗС бөгж

ЗС бөгж байхгүй хүүхдүүдэд бөгжнүүдийг тарааж өг (хэрэв ЗС бөгж олж авах боломжгүй бол ЗС бамбайн үйл ажиллагаанд алгасан орж, бамбайн дээр үсгүүдийн тухай ярилц). Бүх хүүхдүүдээр өөрсдийнх нь бөгжийг харуул.

- Энэ бөгжин дээрх эхний үсгүүд юуг төлөөлдөг вэ? (Зөвийг сонго.)

Хүүхдүүдэд өөрсдийнх нь ЗС бөгжнүүд нь тэдэнд Есүс тэднээс зөвийг сонгохыг хүсдэгийг санахад тусалж чадна гэдгийг хэл.

ЗС бамбайн үйл ажиллагаа

Хүүхэд бүрт будгийн харандаанууд болон ЗС бамбайн нэг хувийг будуулахаар тарааж өг. Хүүхэд бүрт бамбайг хайчлан авч, мөн нэхмэлийн утас гүйлгэн оруулахын тулд орой дээр нь жижиг нүх гаргахад нь тусал. Хүүхэд бамбайг хүзүүнээсээ зүүж болохын тулд утасны үзүүрийг зангидна уу.

Дүгнэлт

Ярилцлагыг нэгтгэн дүгнэ

- ЗС нь ямар утгатай вэ?
- Зөвийг сонгох гэдэг нь ямар утгатай вэ?
- Хэн бид бүгдийг хайрладаг мөн биднийг аз жаргалтай байхыг хүсдэг вэ? (Тэнгэрлэг Эцэг; Есүс Христ.)
- Биднийг аз жаргалтай байлгахын тулд Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр биднийг юу хийхийг хүсдэг вэ?

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр биднийг хайрладаг бөгөөд биднийг аз жаргалтай байхыг хүсдэг тухай гэрчлэлээ хэл. Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг дагаж, зөвийг сонгосноор бид амар амгалан хийгээд аз жаргалыг олж болохыг хүүхдүүдэд хэл.

Хүүхдийн хэсэгт ирснээр зөвийг сонгосных нь төлөө хүүхдүүдийг магтаж, долоо хоног бүр ирэхийг нь урамшуулан дэмж.

Хүүхдүүдийг дараагийн долоо хоногт ЗС уриан дээрх үгсийг тогтооход нь урамшуулан дэмж (“Би зөвийг сонгоно”).

Нэг хүүхдийг хаалтын залбирал хийлгэхээр урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдэд тэд Хүүхдийн Хэсэгт энэ жил зөвийг сонгох талаар олон зүйлийг сурч мэдэх болно гэдгийг тайлбарла.

Дэлхийн Өмнөх Амьдрал, зураг 2-4; Загасчдыг Дуудсан нь, зураг 2-24; Бошиглогч Иосеф Смит, зураг 2-39-ийг үзүүл. Хүүхдүүдэд тэд зөвийг сонгосон зарим чухал хүмүүсийн талаар сурах болно гэдгийг хэл. Зураг бүрийн товч тоймыг урьдчилан өг.

- Зураг 2-4. Дэлхийд ирэхийг сонгосноороо бид зөвийг сонгосон (хичээл 4-ийг үз).
- Зураг 2-24. Түүнийг дагахын тулд загасчлахаа орхисноор Есүсийн Төлөөлөгчид зөвийг сонгосон (Хичээл 15-ыг үз).
- Зураг 2-39. Үнэн сүмийг олохын тулд залбирснаараа Иосеф Смит зөвийг сонгосон (Хичээл 20-ийг үз).

2. Хүүхдүүдийг бие биенээ илүү сайн мэддэг болоход нь туслахын тулд хүүхэд бүрийн нэрийг жижигхэн цаасан дээр бичиж, цааснуудыг хайрцагт хий. Хүүхэд бүрээр хайрцагнаас нэг нэр сонгуулж, ангийн үлдсэн хүүхдүүдийг үүний хэн болохыг нь таах хүртэл нэр нь сугалагдсан хүүхдийг таах түлхүүрүүдийг өг. Таах түлхүүрүүд нь “Энэ хүүхэд маш их инээмсэглэдэг,” “Энэ хүүхэд цэнхэр хувцас өмсөж байна,” эсвэл “Энэ хүүхэд хар үстэй” гэх мэт өгүүлбэрүүд байж болно.

3. Хүүхдүүдийн хийж болох зарим үйлдлийг тодорхойл. Хэрэв үйл ажиллагаа нь зөв сонголтыг төлөөлж байгаа бол босохыг, хэрэв үйл ажиллагаа нь буруу сонголтыг төлөөлж байгаа бол суухыг хүүхдүүдээс хүс. Дараах жишээнүүдийг ашигла, эсвэл өөрөө зарим жишээнүүд зохио:

- Сүмд цагтаа очиход бэлэн байхын тулд та нар эрт босч бай.
- Өглөөний цайнд идэхийг хүсч байгаа зүйл чинь байхгүй байвал чангаар гомдолло.
- Жаахан эмэгтэй дүүдээ олдохгүй байгаа гутлыг нь олоход тусал.
- Танай Хүүхдийн Хэсэгт ирсэн шинэ хүүхэдтэй “сайн байна уу” гэж мэндэл.
- Цуглааны байранд орж ирэхдээ хөлөөрөө чанга дэвсэл.
- Ариун ёслолын үед Есүс Христийн тухай бод.
- Хүүхдийн Хэсгийнхээ хичээлийг чимээгүй сонс.

Зорилго “Есүс надаас юу хийхийг хүсэх байсан бол?” гэж асууснаар зөвийг сонгож чадна гэдгийг нь ойлгоход хүүхэд бүрт туслах.

- Бэлтгэл**
1. 2 Нифай 31:10-ыг залбиралтайгаар судал.
 2. Хичээл дэх түүхийг дүрслэн үзүүлэхийн тулд дотроо өндөгнүүдтэй шувууны үүр хий. Түмпэнг сүрэл, өвс буюу нэхмэлийн утсаар дүүргэ. Сайтар чанасан гурван өндгийг үүрэнд хий. Хэрэв өндөг олдохгүй бол өндөг хэлбэртэй гурван цаас хайчилж үүрэнд хий.
 3. Таван хэсэг цаасыг нэгээс тав хүртэл дугаарлаж, жижиг уут, эсвэл өөр саванд хий.
 4. “Би Есүстэй Адилхан Болохыг Хичээнэ” (*Children’s Songbook*, х. 78) дуу дуулах, эсвэл үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг нь гарын авлагын ар талд байгаа.
 5. Шаардлагатай материалууд:
 - а. Мормоны Ном.
 - б. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 6. Өөрийн ашиглахыг хүссэн баяжуулах үйл ажиллагаанд зориулан шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Та хүүхдүүдээс тэднийг ЗС урианаас үгсийг цээжлэх боломжтой байсан эсэхийг нь асуухыг хүсч болно (“Би зөвийг сонгоно”).

Есүс Христ Биднийг Зөвийг Сонгохыг Хүсдэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

“Удирдагчийг дага” тоглоомыг хүүхдүүдээр тоглуул. Хүүхдүүд эгнээгээр зогсоно. Эгнээн дэх эхний хүүхэд гүйж, үсэрч, дээс тоглох, эсвэл өрөөний нөгөө тал хүртэл ямар нэгэн өөр үйл ажиллагаа хийнэ. Бусад хүүхдүүд эхний хүүхдийн хийснийг дуурайн хийнэ. Тэгээд эхний хүүхэд эгнээний сүүлд очиход хоёр дахь хүүхэд удирдагч болно. Хүүхэд бүр удирдагч болох хүртэл үйлдлийг давтан хийнэ.

Судрын
ярилцлага

2 Нифай 31:10-ын эхний хэсгийг *Та нар намайг дагагтун* гэснийг дуустал чангаар унш. Эдгээр үгсийг Есүс Христ хэлснийг тайлбарла. Есүс биднээс өөрийгөө дагахыг хүсдэг билээ.

- Бид Есүсийг хэрхэн дагаж чадах вэ?

2 Нифай 31:10-ын үлдсэн хэсгийг чангаар унш. Бид зарлигуудыг дуулгавартай дагаж түүний хийх байсан зүйлүүдийг хийхдээ Есүс Христийг дагадаг гэдгийг тайлбарла.

ЗС уриа

ЗС уриаг үзүүл. Хүүхдүүдэд Есүсийн заасан зүйлүүд бидэнд юуг зөв болохыг хэлж өгдөг учраас тэднийг Есүсийн тухай илүү ихийг сурахын хэрээр илүү сайн сонголтуудыг хийх боломжтой болно гэдгийг хэл.

Бидэнд сонголт хийхэд хэцүү байх үед юу зөв болохыг мэдэхэд минь тусалж болох асуултыг бид өөрсдөөсөө асууж болно гэдгийг тайлбарла. Асуулт нь, “Юу хийхийг Есүс надаас хүсэх байсан бол?”

Түүх ба
ярилцлага

Дүрслэн үзүүлэхээр хийсэн шувууныхаа үүрийг ашиглан дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Варрен гэдэг нэртэй нэг хөвгүүн шувууд хоргодон амьдардаг нэгэн газрын ойролцоо амьдардаг байжээ. Шувуудын хоргодон амьдардаг газар бол шувуудыг хамгаалдаг газар юм. Варрены эцгийн ажил бол шувуудыг хамгаалахад туслах явдал байв. Варрен гэрийнхээ ойролцоох өндөр сахлаг өвсөн дотор шувууны үүр байхыг олж харжээ. Тэгээд тэр эх шувууг нь байхгүй үеэр үүрэн дэх өндөгнүүдийг харах дуртай байлаа. Нэг өдөр Варреныг өндөгнүүдийг харж байтал чанга дуу чимээ гарах нь сонсогджээ. Тэр дээшээ хартал сургуулийнх нь хоёр эрэгтэй хүүхэд чавхаар шувуу харвасан байв.

Нөгөөх хоёр хүүхэд Варреныг хараад үүрэн доторхыг үзэхээр ирлээ. Хоёр хүүхдийн нэг нь өндөгнүүдийг няцлахыг хүсчээ. Варрен хөвгүүдийг өндөгнүүдийг няцлахгүй байхыг ятгаж, хоргодох газартаа байгаа шувуудыг алах нь хуулийн эсрэг хэрэг болно гэж хэлжээ. Нөгөөх хүүхдүүд чавхаар шувууг харвасныг хэнд ч хэлэхгүй байх нь дээр гэдгийг Варренд хэлжээ. Тэд хууль зөрчсөний төлөө шийтгүүлэхийг хүсээгүй ажээ. Варрен гэр лүүгээ удаан алхаж явах зуураа яах ёстой вэ гэдгээ бодож байлаа. Хэрэв тэрээр нөгөөх хоёр хүүхдийн тухай аавдаа хэлвэл тэд түүгээр доог тохуу хийж, эсвэл түүнийг өвтгөх болно.

ЗС уриан дээрх Есүсийн зураг руу заа.

- Варрен өөртөө зөвийг сонгоход туслахын тулд өөрөөсөө ямар асуулт асуух хэрэгтэй вэ? (“Есүс намайг юу хийхийг хүсэх байсан бол?”)
- Чи яах байсан бэ?

Варрен нөгөөх хүүхдүүдийн тухай аавдаа хэлэхээр шийджээ. Аав нь хүүхдүүд болон эцэг эхтэй нь ярих хэрэгтэй гэж хэлжээ. Варрен аавдаа нөгөөх хүүхдүүдтэй сургууль дээр тааралдахаас санаа зовж байна гэж хэлэхэд аав нь нөгөөх хүүхдүүдийг өөрийнхөө сайн найз болгох арга замыг хайхыг түүнд санал болгосон байна.

Чавхаар шувуу харваж, өндөгнүүдийг хагалахыг хүсч байсан хүүхдүүдтэй найз болохыг Варрен хүссэнгүй. Аав нь ийм санал гаргасанд тэрээр урам хугарсан байв. Варрен тэр шөнөжингөө аавынхаа хэлснийг бодов. Варрен өөр шийдвэр гаргахаар болжээ.

- Варрен ямар шийдвэр гаргах ёстой байсан бэ?

ЗС уриан дээрх Есүсийн зураг руу дахин заа.

- Варрен өөрөөсөө ямар асуулт асуух ёстой байсан бэ? (“Есүс намайг юу хийхийг хүсэх байсан бол?”)
- Варрен юу хийх ёстой байсан бэ?

Варрен нөгөөх хүүхдүүдтэй дахин уулзахад өөрсдийнх нь тухай аавдаа хэлсний учир түүнд ууртай байлаа. Тэд түүнийг зодохоор заналхийлсэн аж.

Варрен айсан хэдий ч, Есүс түүнээс хийхийг хүсэх байсан тэр зүйлийг тэрээр хийхээр шийдсэн ажээ. Варрен аавынхаа хамт Бямба гарагт явган аяллаар явах гэж байгаагаа нөгөө хүүхдүүдэд хэлж, хамт явах уу гэж тэднээс хүсчээ. Нөгөөх хүүхдүүд гайхаж, хэсэг хугацаанд юу ч хэлсэнгүй. Варрен тэдэнд ийм нөхөрсөг байх юм гэж тэд огт санасангүй ажээ. Эцэст нь тэд явахыг зөвшөөрөв. Варреныг хөвгүүдэд баяртай гэж хэлэх үед түүнд амар амгалан мэдрэмж төржээ. Нөгөөх хөвгүүдийг найз нараа болгосон нь хийх ёстой зөв зүйл байсан гэдгийг тэр мэдэж байв. (Claudia Remington, "The Nest,"-ээс хялбаршуулан авав *Friend*, 1980 оны Тавдугаар сар, х. 2–5.)

- Варренд яагаад амар амгалан мэдрэмж төрсөн бэ?
- Та нар зөвийг сонгож, Есүсийн та нараас хийхийг хүсдэг тэр зүйлийг хийсний улмаас хэзээ та нар амар амгалан мэдрэмжтэй болсон бэ?

Хүүхдүүдийг зөвийг сонгосны улмаас тэдэнд тохиолдсон аливаа тохиолдлынхоо талаар ярихыг нь урь.

Есүс Христийн Биднийг Хийхийг Хүсдэг Тэр Зүйлийг Бид Хийж Чадна

Ярилцах үйл
ажиллагаа

“Есүс намайг юу хийхийг хүсэх байсан бол?” гэсэн асуултыг хүүхдүүдээр давтан хэлүүл. Тэд энэ асуултад хариулах дадлага хийх болно гэдгийг тэдэнд хэл. Дугаарласан цааснууд бүхий хүүдий буюу савыг үзүүл. Цаасыг хүүхдүүдээр ээлжлэн сонгуул. Хүүхэд бүрийн сонгосон тоотой тохирох нөхцөлийг уншиж, асуултуудад хүүхдүүдээр хариулуул. (Хэрэв танай анги олон хүүхэдтэй бол илүү олон нөхцөл нэмж болно.)

1. Чи тэгш өнцөгтүүдээр байшин барьж байлаа. Жаахан эмэгтэй дүү чинь чиний хийсэн зүйлийг нураачихжээ.
 - Чи өөрөөсөө ямар асуулт асуух ёстой вэ?
 - Есүс чамаас юу хийхийг хүсэх байсан бэ?
2. Найз чинь танай гэрт тоглохоор иржээ. Ах чинь чамтай бас найзтай чинь тоглохыг хүссэн боловч чи найзтайгаа хоёулахнаа тогломоор байлаа.
 - Чи өөрөөсөө ямар асуулт асуух ёстой вэ?
 - Есүс чамаас юу хийхийг хүсэх байсан бэ? (Ахыгаа тоглохыг урих нь цорын ганцхан хариулт биш гэдгийг заагаад, өөр шийд олоход нь хүүхдүүдэд тусал.)
3. Чи зэргэлдээх хаалганы хүүхдүүдтэй бөмбөг тоглохыг хүсдэг байжээ. Тэд чамд доромжилсон үгс хэлж гэртээ харь гэжээ. Тэднийг ч бас доромжилмоор чамд санагдав.
 - Чи өөрөөсөө ямар асуулт асуух ёстой вэ?
 - Есүс чамаас юу хийхийг хүсэх байсан бэ?
4. Ээж чинь чамайг тоглохоор гадагшаа гарахаасаа өмнө ороо хураа гэж хүсчээ. Найз нар чинь чамайг гарах хаалганы дэргэд хүлээж байлаа.
 - Чи өөрөөсөө ямар асуулт асуух ёстой вэ?
 - Есүс чамаас юу хийхийг хүсэх байсан бэ?
5. Гэрийнхээ гадуурх хашааг цэвэрлэхэд аавд чинь туслалцаа хэрэгтэй байв. Чи дотогшоо орж уншиж байгаа номоо дуусгамаар байдаг.
 - Чи өөрөөсөө ямар асуулт асуух ёстой вэ?
 - Есүс чамаас юу хийхийг хүсэх байсан бэ?

Есүсийн заадаг зүйлүүд нөхцөл байдал бүрт яг юу хийхийг бидэнд хэлж өгдөггүй гэдгийг тайлбарла. Ухаалаг шийдвэр гаргаж сурахыг Есүс биднээс хүсдэг. Хэрхэн хайр нинжин сэтгэлийг бодох хийгээд харуулахад суралцахыг Тэрбээр биднээс хүсдэг.

Дүгнэлт

Дуу	Хүүхдүүдтэй хамт “Би Есүстэй Адилхан Болохыг Хичээнэ” дууг дуулах буюу эсвэл үгийг нь хэл.
Гэрчлэл	<p>Зөвийг сонгосноороо бид Есүс Христтэй адилхан байж чадна гэдгийг хүүхдүүдэд сануул. Есүс тэднийг хайрладаг бөгөөд тэднийг аз жаргалтай, амар амгалан байлгахын тулд зөвийг сонгохыг тэднээс хүсдэгийг гэрчил.</p> <p>Энэ долоо хоногт тэднийг шийдвэр гаргах үед нь, “Есүс чамаас юу хийхийг хүсэх байсан бэ?” асуултыг өөрсөдөөсөө асуухад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.</p> <p>Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Есүс тэднээс юу хийхийг хүсдэгийг өөрсөдөөсөө асуухыг санахын төлөө залбирахыг тэр хүүхдээс хүс.</p>

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдэд будгийн харандаа, цаас өгч, Есүс тэднээс хийхийг нь хүсдэг зүйлүүд, тухайлбал сүмд ирэх, эцэг эхдээ туслах, ганцаардсан хүүхдийг тайтгаруулах, эсвэл ах эгч дүү нартайгаа тоглох мэт зүйлүүдийн зургийг тэднээр зуруул. Хүүхэд бүрийн цаасан дээр *Есүс надаас юу хийхийг хүсэх байсан бэ?* гэж бич.
2. “Зөвийг Хийхдээ Зоригтой Бай” (*Children’s Songbook*, х. 158) буюу “Нифайгийн Зориг” (*Children’s Songbook*, х. 120) дууг дуулах буюу эсвэл үгийг нь хэл. “Зөвийг Хийхдээ Зоригтой Бай” дууны үг гарын авлагын ар талд байгаа. Дуулсны дараа та Варрены тухай өгүүллийг хүүхдүүдэд сануул. Варрен зарим хэцүү сонголтийг хийх хэрэгтэй байсан.

- Зарим үед яагаад зөвийг сонгоход хэцүү байдаг вэ?

Зарим үед энэ нь хэцүү байдаг ч хэрэв бид зөвийг сонгохыг үргэлж хичээвэл амар амгалан, баяртай мэдрэмжтэй болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Нифайн Зориг

Хотын хаалган дотор ёс бус Лэбэн рүү очиж
Ялтсуудыг авчир хэмээн Нифайд Их Эзэн зарлиглажээ.

Лэмэн, Лэмүэл хоёул ингэхээс айжээ.

Эр зоригтон нь Нифай байв; ийн тэрээр хариулжээ:

“Явах болно би; Их Эзэний зарлигийг биелүүлнэ би.

Их Эзэн замыг бэлддэгийг би мэднэ; дуулгавартай дагахыг
надаас тэр хүсдэг.

Явах болно би; Их Эзэний зарлигийг биелүүлнэ би.

Их Эзэн замыг бэлддэгийг би мэднэ; дуулгавартай дагахыг надаас
тэр хүсдэг.”

(© 1986 by Wilford N. Hansen Jr. and Lisa Tensmeyer Hansen. Used by permission.)

3. Хичээлийн төгсгөлд хүүхэд бүрт тараах материалын нэг хувийг өгөхөөр хувил. Тарааж өгөх материалын доод талаас нарийн зурвасыг хайчилж ав (тоонуудыг орхи). Хүүхэд бүрт дуу болон цаасан дээр бичсэн дууны үгийг өг. Цаасан дээрх дууны үг болон тарааж өгсөн дууг уншиж, дууны үг аяндаа яаж тохирч байгааг хүүхдүүдээр олуул. Хүүхдүүдэд багахан цавуу, тууз өгч, дууны үг бичсэн цаасыг дууны үгсийн тохирох газарт нь наалгуул. Хүүхдүүдийн нэрийг тарааж өгсөн материал дээр бичиж өг, эсвэл тэднээр бичүүл.

Хүүхдүүдийг цаасыг нааж дуусахад тэдэнд “Зөв Замыг Сонго” дууг нэг, эсвэл хоёр удаа дуулахад нь тусал. Сайн ажил хийснийх нь төлөө тэднийг магт.

Зөв Замыг Сонго

Үүгээр амьдарч, аз жаргалтай байх (1) зам бий; _____ (1)

Энэ нь (2) өдөр бүр бий. _____ (2)

Заадаг зүйлүүдийг нь (3) сурч байна би; _____ (3)

Эдгээр нь надад тусалж замыг үзүүлэх болно.

_____ (4) (4) зам мөн аз жаргалтай бай.

Би үргэлж (5) _____ (5)

(1)

ЗӨВ

(2)

ЗӨВИЙГ СОНГОХ НЬ

(3)

Есүс

(4)

ЗӨВИЙГ СОНГО

(5)


ЗӨВИЙГ СОНГО.

Зорилго

Тэнгэрлэг Эцэг бидний хүн бүгдэд хайртай, учир нь бид түүний хүүхдүүд юм гэдгийг мэдэхэд нь хүүхэд болгонд туслах.

Бэлтгэл

1. Дуулал 82:6-г залбиралтайгаар судал. Мөн Еврей 12:9; Мосе 1:39; түүнчлэн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 2-ыг үз.
2. Найраг баян хуурын хэлбэрээр хэсэг цаасыг нугалах замаар цаасан хэлхээ хүүхэлдэй хий (доорх зургийг хар). Цаасны нугалсан ирмэг дээр хүний хагас дүрс зур. Дүрсийг тойруулан хайчил, харин биеийн хэсэг рүү орсон нугалсан ирмэгийг буюу гарыг тойруулан бүү хайчил. Хүүхэлдэйнүүд хэлхэгдсэн гарнуудаараа дэлгэгдэх болно. Та хүүхэлдэйнүүдийг ангид, хүүхдүүдэд харуулан хайчилж болно, эсвэл хүүхэд бүрт цаасаар жижигхэн хүүхэлдэй хийж болно.



3. Үг бичсэн цаасан туузыг бэлтгэ:

Сүнс

Бие махбод

Гэр бүл

4. “Тэнгэрлэг Эцэг Минь Надад Хайртай” (*Children’s Songbook*, х. 228) болон “Би Бурханы Хүүхэд” (*Children’s Songbook*, х. 2) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. “Би Бурханы Хүүхэд” дууны үг гарын авлагын ар талд байгаа болно.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Жижиг толь.
 - в. Таван хурууны бээлий (хэрэв бээлий олдохгүй бол, та бээлийний зураг буюу зурсан зураг ашиглаж болно).
 - г. Зураг 2-2, Нялх Хүүхэдтэй Гэр Бүл (62307) буюу эсвэл сая төрсөн нялх хүүхдийн гэрэл зураг.
6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Тэднийг “Есүс надаас юу хийхийг хүсэх байсан бэ?” гэсэн асуултыг асуух үед тэдэнд тохиолдсон туршлагыг нь тэднээр тайлагнуулж болно.

Би Хэн Бэ?

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Доорх асуултыг асуу:

- Би хэн бэ?

Хүүхдүүдийг хариулсны дараа, бүтэн нэрийг нь давтан хэлүүл.

Хүүхэд бүр рүү зааж, “Чи хэн бэ?” гэж асуу. Хүүхэд бүрээр нэрийг нь хэлүүлж, хариулуул. Бид бүгдээрээ онцгой хүмүүс гэдгийг тайлбарла.

Ярилцлага

Нялх Хүүхэдтэй Гэр Бүл, Зураг 2-2-ыг үзүүлж, гэр бүлийнх нь гишүүдийг хүүхдүүдээр заалга, эсвэл саяхан төрсөн нялх хүүхдийн зургийг үзүүл.

- Энэ нялх хүүхэд хэдэн сартай гэж та нар бодож байна?
- Энэ нялх хүүхэд дэлхий дээр төрөхөөсөө өмнө хаана амьдарч байсан бэ?

Бид энэ дэлхий дээр ирэхээсээ өмнө бүгдээрээ тэнгэрт Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдарч байсныг тайлбарла. Бид бол түүний хүүхдүүд. Чухам иймээс бид түүнийг Тэнгэрлэг Эцэг гэж нэрлэдэг. Түүнчлэн бид өөрсдийн тэнгэрлэг эх хийгээд Тэнгэрлэг Эцэгийн үлдсэн бүх хүүхдүүдийн хамт амьдарч байсан билээ. Дэлхий дээр төрсөн хүн болгон Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд юм. Бид Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байснаа санадаггүй боловч судруудаас уншснаар түүний хүүхдүүд гэдгээ мэддэг.

Судар

Дуулал 82:6-ийн сүүлчийн хэсгийг, *та нар бүгдээрээ* гэснээс эхлэн чангаар унш. *Хамгийн Дээд* гэдэг нь Тэнгэрлэг Эцэг гэсэн утгатайг тайлбарла.

Тэнгэрлэг Эцэгийн бүх итгэлтэй сүнсэн хүүхдүүд дэлхий дээр ирэхийг хүсдэгийг тайлбарла. Түүний сүнсэн хүүхдүүдээс олонх нь аль хэдийн төрсөн боловч мөн цаана нь олон хүүхэд дэлхий дээр ирэхийг хүлээсээр байгаа билээ.

Бидэнд Сүнс Байдаг

Ярилцлага

“Сүнс” гэж бичсэн цаасан туузыг үзүүл.

Бид дэлхийд ирэхээс өмнө тэнгэрт амьдарч байхдаа бие махбодтой байгаагүйг хүүхдүүдэд тайлбарла. Бид сүнснүүд байжээ.

- Сүнс гэж юу вэ?

Бидний сүнс бол биднийг амьд байлгадаг бидний нэг хэсэг гэдгийг тайлбарла.

- Та нарын сүнс ямаршуухан байдаг гэж та нар боддог вэ?

Жижиг толь дамжуулан өгөөд хүүхэд бүрийг үүн рүү харуул. Тэдний сүнс ямар харагддаг тухайд толь ямар нэгэн санаа өгч байгаа эсэхийг хүүхдүүдээс асуу.

Бидний сүнс бие махбодтой маань адилхан харагддагийг тайлбарла. Жишээ нь, сүнснүүд нүд, чих, гар, хөлтэй байдаг.

Үзүүлэнт хичээл Ширээн дээр бээлий тавь. Бээлий яг л гар шиг хэлбэртэй хэдий ч бээлий амьд биш учир гар шиг хөдөлж чадахгүй гэдгийг тайлбарла. Гарыг бээлийнд углахад бээлий хөдөлж чадна. Гараа бээлийнд хийгээд хуруунуудаа хөдөлгө. Ингэхэд бээлий бие махбодтой адилхан харин гар сүнстэй адилхан байгааг тайлбарла. Бидний бие махбод дотроо сүнсгүй бол хөдөлж чадахгүй. Гар бээлийн дотор байхдаа харагддаггүйтэй адил сүнс бидний биен дотор харагддаггүй. (Boyd K. Packer, *Teach Ye Diligently* [Salt Lake City: Deseret Book Co., 1975], х. 231–33-ыг үз.)

Бид Бие Махбодтой

Ярилцлага “Бие махбод” гэсэн үгтэй цаасан туузыг үзүүл.

Биднийг дэлхийд ирэхэд бидний хүн нэг бүрт бие өгөгджээ. Нүд, чих, гар, хөл зэрэг биеийнх нь зарим эрхтэнгүүдийг хүүхдүүдээр нэрлүүл.

- Та нарын бие махбод юу хийж чадах вэ?

Үйл ажиллагаа Харайх, үсрэх, хөдлөх, ярих, мөлхөх буюу бүжиглэх зэрэг бие махбодын хийж чадах олон зүйлээс зарим зүйлийг хүүхдүүдээр нэрлүүлэх буюу хийлгүүлж үзүүл.

Цаасан хүүхэлдэйн тухай ярилцлага Цаасан хүүхэлдэйн гинжэн хэлхээг хүүхдүүдэд үзүүл.

- Бид эдгээр цаасан хүүхэлдэйнүүдтэй юугаараа адилхан бэ? (Бид бас гар, хөл, толгойтой.)
- Бид тэдгээрээс юугаараа ялгаатай вэ? (Хүүхэлдэйнүүдийг цаасаар хийсэн, харин бид мах, ясаар хийгдсэн биетэй билээ. Хүүхэлдэйнүүд амьгүй; бид амьтай. Тэд бүгд адилхан харагддаг, харин бид нэг нэгнээсээ өөр өөр харагддаг.)
- Хэрэв бид бүгдээрээ хоорондоо адилхан харагддаг байсан бол юу болох вэ?

Тоглоом Таныг хүүхдүүдийг дүрсэлсэн өгүүлбэр хэлэхэд тэднийг босохыг хүс. Хэрэв өгүүлбэр нь тэднийг дүрслээгүй бол тэднийг суухыг хүс. Ангийнхаа хүүхдүүдийн адил төстэй болон ялгааг харуулах өгүүлбэрүүдийг ашигла, жишээ нь—

- Бүх охид бос.
- Бор нүдтэй хүн бүр бос.
- Хамартай бүхэн бос.
- Хэрэв чи шар үстэй бол бос.

Бид бүгдэд адил нийтлэг зүйл олон бий боловч яг адил хоёр хүн байдаггүй гэдгийг анхааруул. Тэнгэрлэг Эцэг биднийг бусдын бие махбодтой адил төстэй боловч бусад аль ч бие махбодтой яг адил биш тийм бие махбодтой болгохоор төлөвлөсөн. Бидний хэн нь ч гэсэн бусад хүн бүрээс өөр юм.

Биднийг Хайрладаг Гэр Бүл Бидэнд Бий

Багшийн танилцуулга “Гэр бүл” гэсэн үгтэй цаасан туузыг үзүүл.

Тэнгэрлэг Эцэг бид бүгдийг бие махбодыг хүлээж авахуулахын тулд дэлхий рүү илгээсэн тийм их хайраар биднийг хайрладгийг хүүхдүүдэд хэл. Тэрээр биднийг бидний төлөө анхаарал халамж тавьж, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тухай бидэнд заах гэр бүлүүд рүү илгээсэн юм.

Түүх

Дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Нэг хөвгүүн түүний аав хоёр өглөө эрт холын явган аялалд гарчээ. Тэд тэр өдрийг хамтдаа загасчилж өнгөрөөхийг хүссэн учраас тэр хоёр хэрэгслүүдээ баглаж аваад жижигхэн сайхан нуурыг чиглэн алхжээ. Тэд явганаар удаан алхаад, тэгээд хөвгүүн ядарч эхлэн улам, улам бүр удаан явах болжээ.

Нуур харагдах үед нуурын гоё цэнхэр усыг харахын тулд аав нь урагш яаравчилжээ. Хүү нь гүйцээд ирнэ гэж тэр бодсон аж.

Аав нь нуурт хүрч ирээд хүүгээ түүнийг гүйцээгүйг мэдэв. Хүү нь харагдахгүй байв. Аав нь загасны уургаа доош тавиад хүүгээ хаа сайгүй эрж хайж эхэллээ. Тэр бүх чадлаараа хашгирсан хэдий ч хүү нь хариулсангүй. Аав нь айж эхэлжээ. Хүү нь төөрчихлөө гэж үү? Тэр бэртчихээгүй байгаа?

Аав нь өвдөг сөгдөн залбирав. Хүүгээ олоход нь туслахыг тэрээр Тэнгэрлэг Эцэгээс хүсчээ. Тэгээд тэрээр босч зам даган буцаж алхав. Удалгүй тэр хүүгээ олжээ. Аав нь хүүгээ чанга тэвэрч, түүнд ямар их хайртайгаа хэлжээ. (Owen C. Bennion, "Turning the Heart of a Father,"-гаас хялбаршуулан авав, *Ensign*, 1971 оны Тавдугаар сар, х. 28–30.)

Ярилцлага

- Аав нь түүнд хайртай гэдгийг хүү нь яаж мэдсэн бэ? (Аав нь түүнийг загасчлахдаа авч явсан, түүнийг төөрөхөд эрж хайсан, түүний төлөө залбирсан, түүнийг олоод хичнээн их баярласнаараа харуулсан.)
- Гэрийнхэн чинь чамд хайртай гэдгийг та нар яаж мэддэг вэ?

Хүүхдүүдийг хариулсны дараа бидний эцэг эхчүүд болон гэр бүлийнхэний биднийг хайрладаг харуулдаг олон арга зам байдгийг тайлбарла.

Биднийг Хайрладаг Тэнгэрлэг Эцэг Бидэнд Бий

Ярилцлага

- Өөрт чинь Тэнгэрлэг Эцэг хайртайг та нар яаж мэддэг вэ?

Дуу

Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг бөгөөд биднийг аз жаргалтай байхыг хүсдэгийг хүүхдүүдэд хэл. Амьдрах сайхан дэлхийг Тэрээр бидэнд өгсөн юм. "Тэнгэрлэг Эцэг Минь Надад Хайртай" дууг дуул, эсвэл үгийг нь хэлэхдээ үйлдлүүдийг харуулахад нь хүүхдүүдэд тусал:

Шувуу (*гараараа далавч адил дэвнэ*) жиргэхийг сонсохоороо би (*гараараа чихээ хөмөрнө*),

Эсвэл цэнхэр тэнгэрийг харахаараа (*гараа дээш өргөн дугуйрсан хөдөлгөөн хийнэ*)

Борооны дуслыг нүүрэн дээрээ дусахыг мэдрэхээрээ (*хуруугаараа борооны дусал адил хөдөлгөөн хийнэ*),

Эсвэл салхи хажуугаар сүнгэнэхээр (*хоёр гараараа урагш хойш даллана*)

Хилэн сарнайд хүрэхээрээ би (*цэцэг үнэрлэж байгаа дүр үзүүлнэ*).

Эсвэл голт борын моддын дэргэдүүр алхахдаа (*байран дээрээ алхална*)

Миний төлөө Тэнгэрлэг Эцэгийн бүтээсэн (*өөрийгөө чанга тэвэрнэ*)

Үзэсгэлэнт энэ дэлхийд амьдардагтаа баярлана би (*гараа дэлгэн харуулна*).

Харж болохын тулд тэр надад нүд өгсөн (*нүдээ заана*)

Эрвээхийн далавчтай адил (*Эрхий долоовор хуруугаа нийлүүлж бусад хуруунуудаараа далавч адил дэвнэ*).

Сонсож болохын тулд тэр надад чих өгсөн (*чихээ заана*)

Юмсын ид шидэт чимээг сонсохын тулд (*гараараа чихээ хөмөрнө*).

Тэр надад оюун санаа болон амьдрал (толгойныхоо хажуу талыг заана), зүрх сэтгэлийг минь өгсөн (зүрхэн тушаагаа заана);

Түүнд би хүндэтгэлтэйгээр талархана (гараа тохойгоор нь нугална)

Нэг хэсэг нь би болох бүх бүтээлтийн учир (гараа дэлгэнэ).

Тийм ээ, Тэнгэрлэг Эцэг надад хайртайг мэднэ би (гараа зүрхэн тушаагаа байрлуулна).

Ярилцлага

- Тэнгэрлэг Эцэг чамд хайртайг ямар зүйлүүд та нарт сануулдаг вэ?
- Та нар бол Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бөгөөд тэрээр та нарт хайртайг мэдэх нь та нарт ямар сэтгэгдэл төрүүлдэг вэ?

Дүгнэлт

Дуу

“Би Бурханы хүүхэд” дууны эхний бадгийг хүүхдүүдээр дуулуул. Бурхан бол Тэнгэрлэг Эцэгийн өөр нэг нэр гэдгийг хүүхдүүдэд сануул.

Уг дууны үг бидний хүн нэг бүр нь Тэнгэрлэг Эцэгийн хайртай хүүхэд бөгөөд тэрээр биднийг дэлхийд ирж биетэй болгохоор төлөвлөсөн юм гэдгийг бидэнд өгүүлдэгийг анхааруул. Тэрээр бас биднийг хайрлаж, бидэнд заах гэр бүлийг бидний төлөө төлөвлөсөн бөгөөд ингэснээр бид түүнтэй дахин хамт амьдрахаар буцаж очиж чадна.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг бидэнд бие махбод, мөн дээр нь амьдрах гоё сайхан дэлхий, тэрчлэн биднийг хайрлах гэр бүлийг өгсөн учраас тэр бидэнд хайртай гэдгийг гэрчил.

Дэлхийд ирэх боломжтой болсныхоо төлөө өнөө орой өөрсдийнхөө залбиралд Тэнгэрлэг Эцэгт талархахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Нэг хүүхдийг хаалтын залбирал хийлгэхээр урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Цаасан хүүхэлдэйнүүдийг салган хайчилж, хүүхэд бүрт нэгийг өг. Хүүхэлдэйнүүдийг хүүхдүүдээр будуулж чимэглүүл. Хүүхдүүдийг дуусахад тэднээр хүүхэлдэйнүүдийг нь ангийн үлдсэн хүүхдүүдэд үзүүлүүл. Цаасан хүүхэлдэй бүр хэрхэн өөр, гоё болсныг тэмдэглэн хэл. Бид мөн адил төстэй хэдий ч, нэг хүн нөгөөтэйгөө яг адилхан байдаггүй.
2. Хүүхдүүдийг тойрог болгон суулга. Даавуун бөмбөг буюу өөр ямар нэг зөөлөн зүйлийг хүүхэд рүү хаяж өгөөд, хичээлийн тухай нэг асуулт асуу. Хүүхэд асуултанд хариулаад даавуун бөмбөгийг тан уруу буцааж шидэхийг түүнээс хүс. Хүүхэд бүр ээлжээр доод тал нь нэг асуултад хариулах хүртэл давт. Дараах асуултуудыг ашиглах буюу эсвэл өөрөө асуултууд зохио:
 - Дэлхийд ирэхээс өмнө бид бүгд хаана амьдарч байсан бэ? (Тэнгэрт.)
 - Бид хэнтэй хамт амьдарч байсан бэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон хүн болгонтой хамт.)
 - Одоо бид хаана амьдарч байна вэ? (Дэлхий дээр.)
 - Бидний сүнс юутай адилхан харагддаг вэ? (Бидний бие махбодтой адилхан харагддаг.)

3. Хүүхдүүдэд цаас харандаа, бал, эсвэл будгийн харандаа өгч Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд хайртайг өөрсдөд нь сануулдаг зүйлүүдийн зургуудыг тэднээр зуруул.
4. Хүүхдүүдийг босгож, “Багш хэлж байна” гэдэг тоглоом тоглуул. Таныг заавар өгөхөөсөө өмнө “Багш хэлж байна” гэж таныг хэлсэн тохиолдолд л тэд өөрийн тань хэлсэн зүйлийг хийх ёстойг тайлбарла. Гараа тохойгоор нь нугалах, мөрөндөө хүрэх, эргэх зэрэг үйлдлүүдийг зарим үед “Багш хэлж байна” гэж хэлэхээс өмнө заримдаа зүгээр үйлдэл хийхийг хүүхдүүдээс хүс. Хэрэв таныг “Багш хэлж байна” гэж хэлээгүй байхад хүүхдүүд үйлдэл хийсэн бол тэд тоглоом дуустал суух ёстой. Өөрийнхөө хүссэн тоогоор тоглоомыг давт.

Тэдний бие махбод эдгээр бүх үйлдлүүдийг хийх боломжийг тэдэнд олгодгийг хүүхдүүдэд сануул.

Би Есүс Христийг Дагахыг Сонгосон

Зорилго

Дэлхийн өмнөх амьдралд бид Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй хамт амьдарч байсан бөгөөд тэднийг дагахаар сонгосныг ойлгоход нь хүүхэд болгонд туслах.

Бэлтгэл

1. Иов 38:7, Мосе 4:1–4, Абрахам 3:24–28, тэрчлэн Итгэлийн Тунхаг 1:1-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 3-ыг үз.
2. “Би Бурханы Хүүхэд” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.58) дууны эхний бадгийг аял, эсвэл дуул. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи, Агуу Үнэт Сувд.
 - б. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - в. Зураг 2-3, Есүс бол Христ (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 240; 62572); зураг 2-4, Дэлхийн Өмнөх Амьдрал.
4. Ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагааныхаа шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Бурханы Хүүхдүүд

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Та нэг дуу аялах гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Анхааралтай сонсож, тэгээд таныг аялж дуусахад уг дууны нэрийг хэлэхийг хүүхдүүдээс хүс. “Би Бурханы Хүүхэд” дууг аял.

- Би ямар дуу аялсан бэ?
- Энэ дуу та нарыг хэн гэж нэрлэж байна вэ?

Дууны эхний бадгийг хүүхдүүдээр дуулуул.

Ярилцлагыг
нэгтгэн дүгнэ

Өмнөх хичээлд бид дэлхийд ирэхээсээ өмнө хаана амьдарч байсан тухай ярьсан гэдгийг хүүхдүүдэд сануул.

- Бид дэлхийд ирэхээсээ өмнө хаана амьдарч байсан бэ?
- Тэнгэрт бид хэнтэй хамт амьдарч байсан бэ?
- Бид бүгдийг юу ах, эгч дүүс болгодог вэ? (Бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд.)

Тэнгэрт Бид Чухал Сонголт Хийсэн

Багшийн
танилцуулга

Биднийг тэнгэрт Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байхад, биднийг төрөхөөс өмнө тохиолдсон сэтгэл нэн хөдөлгөм нэг зүйлийн тухай тэд сурах гэж байгааг хүүхдүүдэд хэл.

Дэлхийн Өмнөх Амьдрал, зураг 2-4-ыг үзүүл. Энэ бол тэнгэр үүнтэй төстэй гэсэн зураачийн санаа гэдгийг тайлбарла. Бид бүгд тэнгэрт Тэнгэрлэг Эцэгтэй хамт алхаж, түүнтэй ярьдаг байсан сүнснүүд байсныг тайлбарла. Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрах нь юутай адил байж болох тухай бодохыг хүүхдүүдээс хүс. Түүнийг харж, түүнтэй хамт байх нь хичнээн гайхамшигтай зүйл болохыг ойлгоход нь тэдэнд тусал.

Биднийг тэнгэрт байхад Тэнгэрлэг Эцэг нэгэн агуу хуралдаанд оролцуулахаар биднийг дуудсан юм гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд тэнд байжээ. Тэнгэрлэг Эцэг бидэнтэй ярихыг хүссэн ажээ.

Бид бие махбодтой болж, зөвийг сонгоход суралцахын тулд хэсэг хугацаагаар түүний дэргэдээс холдох хэрэгтэй болсныг Тэнгэрлэг Эцэг бидэнд хэлснийг тайлбарла. Биднийг эдгээр зүйлүүдийг хийж болох газрыг өгнө гэдгийг Тэнгэрлэг Эцэг бидэнд ярьжээ.

- Биднийг хаашаа явахыг Тэнгэрлэг Эцэг хүссэн бэ? (Дэлхий рүү.)

Бид дэлхийд ирэхдээ түүнтэй хамт амьдарч байснаа санахгүй байх болно гэдгийг Тэнгэрлэг Эцэг бидэнд ярьсан ажээ. Мөн дэлхий дээр байх бидний хугацаа дууссаны дараа тэнгэрт буцан очиж, дахин түүнтэй хамт амьдрахад бидэнд туслах нэг хүн бидэнд хэрэгтэй байх болно гэж Тэр бас хэлжээ. Бидэнд туслах нэг хүнийг илгээхээр Тэр амласан билээ.

Ярилцлага

- Тэнгэрт буцан очиж, түүнтэй дахин хамт амьдрахад чинь туслахын тулд Тэнгэрлэг Эцэг хэн нэгнийг илгээхүйцээр та нарыг хангалттай хайрладаг байсныг мэдэх нь та нарт ямар санагддаг вэ?

Бидэнд туслахаар хэн нэгнийг тэрээр илгээх болно гэж Тэнгэр Эцэгийг хэлэхэд бид бүгд баярлан хашгирсныг тайлбарла (Иов 38:7-г үз).

Есүс Бол Христ, зураг 2-3-ыг үзүүл.

- Энэ хэн бэ?

Есүс Христ бидэнтэй хамт тэнгэрт амьдарч байсныг тайлбарла. Тэр бол бидний Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн ууган нь билээ.

Итгэлийн Тунхаг

Сүмийн хувьд бидний юунд итгэдгийг өгүүлдэг Итгэлийн Тунхаг гэж нэрлэгддэг тунхаглал бидэнд байдаг гэдгийг хүүхдүүдэд хэл. “Мөнхийн Эцэг Бурхан, Түүний Хүү Есүс Христэд бид итгэдэг” гэсэн итгэлийн нэгдүгээр тунхагийн эхний хэсгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.

Мөнхийн Эцэг Бурхан гэдэг нь Тэнгэрлэг Эцэгийн өөр нэг нэр болохыг хүүхдүүдэд хэлж өг.

Судрын түүх ба
ярилцлага

Бидэнд заалгахаар хэнийг илгээх ёстой вэ гэдгийг Тэнгэрлэг Эцэг асуусныг хүүхдүүдэд хэлж өг. Агуу Үнэт Сувдын Абрахам 3:27-г нээж, “Би энд байна, намайг илгээгтүн” гэж Есүсийн хариулсныг чангаар унш. Бидэнд туслахын тулд Тэнгэрлэг Эцэг түүнээс юу ч хийхийг хүслээ гэсэн тэр үүнийг хийх болно гэж Есүс хэлжээ. Мосе 4:2-ын сүүлчийн хэсгийг (*Эцэгээс эхлэн*) чангаар унш. Есүс бас бүх алдар сууг Тэнгэрлэг Эцэгт өгөх болно гэж хэлжээ. *Алдар суугийн* утгыг товч тайлбарла.

- Есүс Тэнгэрлэг Эцэгт хайртай байсныг та нар хэрхэн хэлж чадах вэ? (Тэнгэрлэг Эцэгийн түүнээс хийхийг хүссэн зүйлийг Тэр хийх хүсэлтэй байв.)
- Есүс өөр хэнд хайртай байсан бэ? (Бидэнд.)

Есүсийн хийх хүсэлтэй байсан зүйлийг нэгтгэн дүгнэх байдлаар Тэнгэрлэг Эцэгийг болон биднийг хайрладаг Есүсийн хайрын тухай онцгойлон хэл.

Есүс Христ . . . хүсэлтэй байв.

- Бидэнд туслахаар дэлхийд ирэх.
- Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэх.
- Амьдрах, аз жаргалтай байх зөв замыг бидэнд заах.
- Бидэнд Тэнгэрлэг Эцэгтэй дахин хамт амьдарч чадахын тулд хийх ёстой зүйлийг бидэнд үзүүлэх.
- Бидний төлөө амьдралаа өгөх.

Люцифер нэртэй өөр нэг сүнсэн хүү бидэнд туслахын тулд дэлхий рүү илгээгдэх хүсэлтэй байсныг анхааруулан хэл. Тэрээр дэлхийд ирж, бид бүгдийг зөвийг хийхэд албадах болно гэж Тэнгэрлэг Эцэгт хэлжээ. Тэр биднийг зөвхөн өөрсдийнхөө төлөө сонголт хийхийг зөвшөөрөхгүй байсан. Люцифер Тэнгэрлэг Эцэгээс бүх хүндэтгэл хийгээд алдар сууг өөртөө өгөхийг хүссэн аж.

Абрахам 3:27-гоос “Эхнийхийг нь би илгээх болно” гэсэн Тэнгэрлэг Эцэгийн шийдвэрийг чангаар унш.

- Тэнгэрлэг Эцэг өөртөө туслуулахаар хэнийг сонгосон бэ?

Люцифер сонгогдоогүйдээ маш их ууртай байсныг тайлбарла. Тэр Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг хүлээн авсангүй. Үүний оронд, Люцифер тэнгэрт их дайн өдөөжээ. Энэ бол буу, бөмбөг хэрэглэсэн дайн байгаагүй, харин үг яриа болон хүмүүсийг өөрийг нь дагуулах тухай дайн байжээ. Люцифер бидний сүнсэн ах эгч дүүсийн заримд нь түүний хилэнцэт санаанууд сайн хэмээн ятгаж дөнгөсөн бөгөөд тэд Есүсийн оронд түүнийг дагахаар сонгосон ажээ.

Люцифер мөн Сатан буюу чөтгөр гэж нэрлэгддэгийг хүүхдүүдэд хэлж өг.

Ярилцлага

- Та нар хэнийг дагахыг сонгосон бэ? Есүсийг үү, эсвэл Сатаныг уу?

Хэрэв тэд Есүсийг дагахаар сонгосон бол босохыг хүүхдүүдээс хүс. Тэд бүгдээрээ Есүсийг дагахыг сонгосон учир бүгдээрээ босох ёстойг тайлбарла.

Бид дэлхий дээр байгаа учраас Есүсийг дагаснаа мэддэгийг тайлбарла. Сатаныг дагасан сүнснүүдэд дэлхий дээр төрж, мөн бие махбодыг хүлээн авахыг зөвшөөрөөгүй билээ.

Есүсийг дагахаар сонгосноороо та ямар их аз жаргалтай байдгаа хүүхдүүдэд хэлж өг. Тэд Сатаныг биш, харин Есүсийг дагахаар сонгосон учраас та тэднээр бахархдагаа хүүхдүүдэд хэл. Зөвийг сонгосных нь төлөө хүүхдүүдийг магт.

Бид Есүс Христийг Дагахаа Үргэлжлүүлэхийг Хүсдэг

Багшийн
танилцуулга

Хүүхдүүдэд тэднийг Есүсийг дагахад албадаагүй гэдгийг онцгойлон анхааруул. Тэд сонголт хийсэн билээ. Тэд Сатаныг дагаж болох байсан. Гэвч тэд зөв замыг сонгожээ.

Дэлхий дээр энэ амьдралд тэдэнд мөн адил сонголт байдгийг хүүхдүүдэд хэлж өг. Сатан урьдын адил биднийг өөрийнхөө араас дагуулахыг хичээж байдаг. Есүсийг дагахыг Тэнгэрлэг Эцэг биднээс хүсдэг, яагаад гэвэл энэ нь биднийг аз жаргалтай болгож, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой хамт дахин амьдрах боломжийг бидэнд олгох болно. Гэвч биднийг Есүсийг дагахад албадаагүй. Есүсийн биднийг хийхийг хүсдэг сайн зүйлүүдийг эсвэл Сатаны биднийг хийхийг хүсдэг муу зүйлүүдийг хийх үү гэдгээ бид сонгож чадна.

ЗС уриа

ЗС уриаг үзүүл. Уриан дээр хэн байгааг хүүхдүүдээс асуу. Уриан дээрх үгсийг зааж байхдаа тэдгээрийг унш. Тэгээд хүүхдүүдээр өөртэйгөө хамт “Би зөвийг сонгох болно” гэсэн үгсийг хэлүүл.

Ярилцлага

Есүсийг дагахын тулд тэдний юу хийх ёстой талаарх дараах асуултуудад (эсвэл өөрийнхөө зохиосон зарим асуултуудад) хүүхдүүдээр хариулуул:

- Хэрэв чи Есүсийг дагахыг сонгоод хэн нэгнийг санаандгүйгээр гомдоосон тохиолдолд чи яах ёстой вэ?
- Хэрэв чи Есүсийг дагахыг сонговол энэ ангид биеэ хэрхэн авч явах вэ? (Чимээгүй суух, анхааралтай сонсох, зохих ёсоор оролцох, бусад хүүхдүүдэд саад болохгүй байх зэрэг үйлдлүүдийг хүүхдүүдээр хийлгүүлж үзүүл)
- Хэрэв чи Есүсийг дагахыг сонгоход хэн нэгэн хүн чамд бэлэг өгч, эсвэл чиний төлөө ямар нэгэн зүйл хийсэн тохиолдолд чи юу хийх буюу хэлэх вэ?
- Хэрэв чи Есүсийг дагахаар сонгосон бол, чамд найрсаг бус байгаа хэн нэгэнд хэрхэн хандах вэ?

ЗС уриаг дахин үзэж, түүн дээрх үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл.

Дүгнэлт

Гэрчлэл

Бид дэлхийд ирэхээс өмнө бидний хүн бүр сонголт хийсэн гэдэг гэрчлэлийг хэл. Бид Есүс Христийг дагахыг сонгосон, хэрэв Есүсийн бидэнд хийхийг заасан зүйлүүдийг хийвэл бид түүнтэй болон Тэнгэрлэг Эцэгтэй хамт дахин амьдрах болно.

Хүүхдүүд Хүүхдийн Хэсэгт долоо хоног бүр Есүсийн биднээс хийхийг хүсдэг зүйлүүдийн тухай мэдэж авах болно гэдгийг тайлбарла.

Хүүхдүүдийг бидний Аврагч болгохоор Есүсийг дэлхийд илгээснийх нь төлөө Тэнгэрлэг Эцэгт өөрсдийн залбиралд талархал илэрхийлэхэд нь урамшуулан дэмж. Нэгэн цагт түүнтэй болон Есүстэй хамт дахин амьдрахын тулд зөв сонголтууд хийхэд өөрсдөд нь туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг тэдэнд санал болго.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдээр өөрсдийнх нь ЗС бөгжүүдийг нь харуул. Хэрэв хүүхдүүд ЗС бөгжөө зүүгээгүй бол та хүүхэд бүрийн хуруунд бөгжийг дуурайлган нарийн тууз уяж болно. Бөгжнүүд нь тэд Есүсийг дагахаар сонголт хийснийг нь тэдэнд сануулж байх болно гэдгийг, мөн тэд үргэлжлүүлэн зөв сонголтууд хийх ёстой гэдгийг тэдэнд сануулах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

2. “Би Тэнгэрт Амьдарч Байсан” (*Children’s Songbook*, х. 4) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэл:

Эрт үед би тэнгэрт амьдарч байсан; энэ үнэн;

Энд таньдаг хүмүүстэйгээ амьдарч, бас хайрладаг байсан.

Та ч бас тийм байсан.

Дэлхийн тухай, хүмүүний мөнхийн авралын тухай

Дээр Тэнгэрлэг Эцэг сайхан төлөвлөгөө танилцуулсан юм

Та дуулсныхаа дараа уг дуу юуны тухай өгүүлж байгаа тухай дараах асуултуудыг асуу (хүүхдүүдэд хариулахад нь туслахын тулд шаардлагатай бол дууны мөрүүдийг давт):

- Та нарыг хаана амьдарч байсан гэж энэ дуунд өгүүлж байна вэ? Та нар хэзээ тэнд амьдарч байсан бэ?
- Тэнд та нар хэнтэй хамт амьдарч байсан бэ?
- Биднийг тэнгэрт түүнтэй хамт байхад Тэнгэрлэг Эцэг юу хийсэн бэ?
- Төлөвлөгөө юуны тухай байсан бэ?

Дууны хоёрдугаар бадгийг дуулж мөн адил төстэй асуултуудыг асуу:

Дээр тэнгэрт бид бүгдийг эргэж ирэхийн тулд

Амиа өргөхөөр хайрладаг нэгэн түүнд хэрэгтэйг Эцэг өгүүлэв.

Бурханлиг хүндэтгэл хүссэн өөр нэгэн тэнд бас байв

“Аваа, намайг илгээ, алдар суу таных байх болно” гэж Есүс хэлэв,

(© 1987 by Janeen Jacobs Brady. Зөвшөөрлөөр ашиглана.)

3. Тэнгэрийг ямар байна гэж боддог тухай хүүхдүүдээр зураг зуруул.

4. “Тэр Өөрийн Хүүг Илгээсэн” (*Children’s Songbook*, х. 34) эсвэл “Би Бурханы Төлөвлөгөөг Дагана” (*Children’s Songbook*, х. 164) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. “Тэр өөрийн Хүүг Илгээсэн” дууны үг гарын авлагын ар талд байгаа.

Би Бурханы Төлөвлөгөөг Дагана.

Миний амьдрал бэлэг мөн; миний амьдралд төлөвлөгөө бий.

Миний амьдралд зорилго бий; тэнгэрт энэ нь эхэлсэн.

Дэлхий дэх сайхан гэртээ ирэх нь миний сонголт байв

Намайг чиглүүлэх Бурханы гэрлийг төрснөөсөө хойш эрэлхийлнэм.

Өөрийнхөө төлөөх Бурханы төлөвлөгөөг дагана би.

Түүний үгийг бас түүний хайрыг чанга тэвэрч

Би ажиллах болно, мөн би залбирах болно;

Би үргэлж түүний замаар алхах болно.

Тэгээд би дэлхий дээр аз жаргалтай байх болно

Тийнхүү дээрх гэртээ ч бас адил байх болно.

Би Зөв Сонголтуудыг Хийж Чадна

Хичээл
5

Зорилго

Тэнгэрлэг Эцэг бидэнд сонгох эрх чөлөөг өгсөн учраас бид зөвийг сонгож чадна гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 21:14–16, Сургаал ба Гэрээ 37:4-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 4-ийг үз.
2. “Зөв Замыг Сонго” (*Children’s Songbook*, х. 160) дууг дуулах буюу үгийг хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
3. Хэрэв та дараагийн долоо хоногт үзэх хичээл 6-гийн баяжуулах үйл ажиллагаа 1-ийг ашиглахыг хүсвэл (хуудас 28-ыг үз) хүүхэд бүрт гэр лүүгээ эх, эцэгтээ авч очих дараахтай адил зурвас бэлтгэ:

Дараагийн удаа бид ангид энэ тухай ярилцах учир [хүүхдийн нэр] түүний нэр хэрхэн сонгогдсоныг хэлж өгнө үү. Баярлалаа.

Хэрэв та дараагийн долоо хоногийн хичээл 6-гийн баяжуулах үйл ажиллагаа 2-ыг ашиглахыг хүсвэл, хүүхдүүдтэйгээ хамт гэр бүлээрээ авахуулсан гэрэл зураг хүүхэддээ өгч явуулахыг хүүхэд бүрийн эцэг эхээс хүссэн зурвас бэлтгэ (хэрэв та хоёр үйл ажиллагааг хоёуланг нь ашиглах бол энэ зурвас дээрхийн адил байж болно).

4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи болон Сургаал ба Гэрээний нэг хувь.
 - б. ЗС уриаг (хичээл 1-ийг үз).
 - в. Өөр өнгөтэй чихэр буюу чулуу мэт жижиг зүйлстэй нэг аяга. Хүүхэд бүр хэд хэдэн өнгөнөөс сонголт хийхээр бодож хангалттай олон өнгө ав.
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэгэн юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Өөрсдийнхөө Төлөө Сонгохыг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ Хоёр Биднээс Хүсдэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Жижиг зүйлстэй аягыг үзүүлж хүүхэд бүрээр нэг зүйлийг сонгуул. Хүүхдүүдийг дөнгөж сая нэг сонголт хийснийг тэдэнд хэл. Бид өдөр бүр олон сонголт хийх шаардлагатай болдог.

- Өнөөдөр та нар ямар сонголтууд хийсэн бэ? (Хариултууд нь ямар хувцас өмсөх, өглөөний хоолондоо юу идэх, эсвэл чөлөөт цагаараа юу хийхийг сонгосон зэрэг хариултууд байж болно.)

Сонголтууд хийх нь дэлхий дээрх амьдралын маш чухал хэсэг гэдгийг хүүхдүүдэд хэл. Зарим сонголтууд амархан, зарим нь хэцүү байдаг. Бидний сонгох эрх тэнгэрт биднийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нартай хамт байхад бидэнд өгөгдсөн юм.

Багшийн
танилцуулга

Биднийг дэлхийд ирэхээс өмнө Тэнгэрлэг Эцэг биднийг нэг хуралдаанд дуудсаныг хүүхдүүдэд сануул. Хүүхдүүдийг тэр хуралдаан дээр болсон зүйлийг өмнөх хичээлээс санаж байгаа эсэхийг олж мэд. Хэрэв тэд санахгүй байвал, дараах санаануудыг гарган түргэн бататга.

Энэ хуралдаан дээр Тэнгэрлэг Эцэг түүнтэй адилхан болоход бидэнд туслах төлөвлөгөөг танилцуулжээ. Бид тэр төлөвлөгөөг дагахыг сонгосон юм, тиймээс бид дэлхийд ирж, бие махбодыг хүлээн авсан билээ. Хэрэв бид дэлхий дээр байх үедээ зарлигуудыг сахихыг сонговол Тэнгэрлэг Эцэгтэй хамт дахин амьдрах боломжтой байх болно. Есүс Христ бидэнд Тэнгэрлэг Эцэгтэй хамт дахин амьдрахын тулд юу хийх ёстойг үзүүлэхийн тулд дэлхийд хүрч ирэхийг санал болгосон байна. Люцифер дэлхийд ирж, зарлигуудыг сахиулахын тулд хүн бүрийг албадахыг хүсч байлаа. Тэрээр хүмүүст ямар ч сонголтууд өгөхийг хүсэхгүй байв. Харин Есүс Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахыг хүсч байв. Тэр хүмүүсийг яаж амьдрахаа сонгох боломжтой байхыг хүссэн.

Бид зөв сонголтууд хийхийг сурч чадах учраас бидний хувьд өөрсдийнхөө төлөө сонгох нь нэн сайн байх болно гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэдэж байсан гэдгийг тайлбарла. Өөрсдийнхөө төлөө сонгох боломжтой байхыг сонголт гэдэг. *Сонголт* гэдэг үгийг хүүхдүүдээр хоёр удаа чангаар хэлүүл.

Люцифер (бас Сатан хэмээн нэрлэгддэг) болон түүнийг дагалдагчид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний эсрэг одоо ч тэмцээр байгаа болно. Есүсийг дагаж, зөвийг хийхийн оронд тэднийг дагахыг сонгож өөрсдийн сонголтыг ашиглахыг тэд биднээс хүсдэг.

ЗС уриа

ЗС уриаг үзүүл.

- Бидэнд зөвийг сонгоход туслахын тулд Есүс юу хийхийг хүссэн бэ? (Бид ухаалгаар сонгох боломжтой болох учраас тэр юу зөв бэ гэдгийг бидэнд заахын тулд дэлхийд ирэхийг хүссэн.)

ЗС уриан дээрх үгсийг заа. Эдгээр үгсийг чангаар хэлж, дараа нь өөртэйгөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл.

Хүүхдүүд Зөвийг Хийхийг Сонгож Чадна

Судрын түүх

Матай 21:14–16 дахь түүхийг өөрийн үгээр ярь. Ахлах тахилчдын зарим нь Есүс Христ бол Аврагч, тэдэнд туслахын тулд Тэнгэрлэг Эцэгийн илгээсэн нэгэн мөн гэдэгт итгэхгүй байсныг тайлбарла. Тэд түүнийг хөнөөхийн тулд Есүсийг ямар нэгэн буруу юм хийх нь үү гэж түүнийг анхааралтай ажиглан анаж байсан юм.

Есүсийг ариун сүм дотор хараагүй болон хазгар доголлон хүмүүсийг эдгээхэд ахлах тахилчид ууртай байсныг тайлбарла. Хүүхдүүд Есүсийг магтаж эхлэхэд, тахилчид бүр ч илүү уурлаж, хүүхдүүдийг болиулахыг Есүсээс хүсчээ. Гэвч үүний оронд, бяцхан хүүхдүүд түүнийг магтах болно гэдгийг тэд судруудад уншаагүй юм уу гэж тахилчдаас тэр асуужээ.

Яг энэ түүхэн дэх хүүхдүүд шиг, ангийн тань хүүхдүүд Есүсийг дагаж, магтахыг сонгож болно гэдгийг анхааруул.

Судар	Сургаал ба Гэрээг нээж Сургаал ба Гэрээний 37:4-ийн: “Хүн бүр өөрийнхөө төлөө сонгог” гэсэн хэсгийг чангаар унш. Энэ сударт хүн бүр гэсэн нь бүх хүмүүс гэсэн утгатайг тайлбарла. Бид бүгд хийдэг зүйлээ сонгож чадна. Хүүхдүүдийг босгож энэ өгүүлбэрийг давтан хэлүүл.
ЗС уриа	ЗС уриаг зааж, уриан дээрх үгсийг хүүхдүүдээр дахин давтаж хэлүүл.

Бид Зөвийг Сонгож Чадна

Түүх	<p>Есүсийн хийдэг байсан зүйлийг хийхээр сонгосон нэг хүүхдийн тухай түүхийг хүүхдүүдэд ярьж өг. Та дараах түүхийг ашиглаж болно:</p> <p>Бриттани Ням гарагийн өглөө сэрэхдээ ааш муутай байв. Тэр урьд шөнө нь хэтэрхий орой унтсан бөгөөд өглөө их эрт босох шаардлагатай байжээ. Тэр угаалгын өрөөнд орох ээлжээ хүлээх хэрэгтэй байв. Дараа нь тэр өрөөсөн гутлаа олсонгүй. Тэгтэл тэр хөлийнхөө хурууг сандалд цохичихов. Тэр бүхэл гэр бүлийг хождуулах нь гэж бодсон учраас том ах нь түүнд ууртай байв.</p> <p>Хүүхдийн Хэсэгт Бриттани дуулсангүй. Тэр инээмсэглэсэнгүй. Тэр ч байтугай тэр сонссонгүй. Тэрээр Хүүхдийн Хэсэгт байгаагүй ч болоосой гэж боджээ. Тэр арын эгнээнд сууж, хөмсөг зангидан халаасандаа байсан юмсаар тоглож байлаа.</p> <ul style="list-style-type: none"> • Бриттани ямар сонголт хийсэн бэ? <p>Бриттанийн багш хичээлээ бэлтгэхийн тулд шаргуу ажилласан бөгөөд Бриттаниг сонсохгүй байгааг нь мэджээ. Хичээлийн дараа Бриттанийн багш Бриттанитай ганцаарчлан ярилцаж, юу болсныг асуужээ. Бриттани уйлж эхлэв. Тэр баяртай байхыг хүсч, мөн тэр багшийгаа ч бас баяртай байгаасай гэж хүсч байлаа.</p> <p>Түүнийг нэг туршилт хийгээд үзэх эсэхийг Бриттанийн багш асуув. Туршилт гэдэг нь хөгжилтэй юм шиг Бриттанид санагджээ. Зөвийг сонгох болон Есүсийн биднийг хийхийг хүсдэг зүйлийг хийх нь биднийг баяртай болгож чадна гэж багш нь тайлбарлажээ. Хүүхдийн Хэсэгт дараагийн Ням гарагт Есүсийн түүгээр хийлгэхийг хүсдэг тэр зүйлийг хийгээд үзэхийг Бриттани зөвшөөрчээ.</p> <p>Дараагийнх нь Бямба гарагт Бриттанийн багш нөгөөх туршилтын тухай түүнд сануулсан аж. “Маргааш би Есүсийн надаас хийхийг хүсдэг зүйлийг хийх болно” гэж Бриттани өөртөө хэлэв.</p> <p>Ням гарагийн өглөө Бриттани сэрээд туршилтыг хийж үзэхээр сэтгэл догдолсон байлаа. Тэр сүм рүү явахаар тэр дорхноо бэлэн болж, бас эгчдээ бэлэн болоход нь тусалжээ. Бриттани Хүүхдийн Хэсэгт ирэхдээ инээмсэглэж байв. Тэр нээлтийн дууг дуулж, нээлтийн залбиралд хүндэтгэлтэйгээр сууж байв. Бриттанийн хажууд сууж байсан эрэгтэй хүүхэд түүнд байнга шивнэж байлаа, тэгээд удалгүй Бриттани хариу шивнэж, сонсохгүй байв. Хичээлд орохын яг өмнөхөн Бриттани өөдөө харж ханан дээрх Есүсийн зургийг харжээ. Есүсийн түүгээр хийлгэхийг хүсдэг зүйлийг тэрээр хийхийг хүссэнээ санав. Бриттани ангид чимээгүйхэн орж урд талын эгнээнд суув. Тэр хичээлийг анхааралтай сонсож, багш нь түүнээс асуусан асуултуудад хариулж байв. Бриттани баяртай байлаа. Тэр зөвийг сонгосондоо баяртай байлаа. Зөвийг сонгох болон Есүсийн түүгээр хийлгэхийг хүсдэг зүйлийг хийх нь түүнийг баяртай болгосныг Бриттани мэджээ.</p>
------	---

- Ярилцлага
- Яагаад Бриттани баяртай байсан бэ?
 - Зөвийг сонгосны улмаас та нар хэзээ баяртай байсан бэ?

Дүгнэлт

Үйл ажиллагаа

Хүүхэд бүрийн эрхий хурууг гозойлгон зааж нударга зангидуул. Хүүхдүүдийн хийж болох зарим сонголтуудыг та дүрслэх гэж байгаагаа тэдэнд хэл. Хэрэв дүрслэгдсэн сонголт нь Есүсийн тэднээр хийлгэхийг хүсдэг ямар нэгэн зүйл байвал тэд эрхий хуруугаа гозойлгон харуулах ёстой. Хэрэв дүрслэл нь Сатаны тэднээр хийлгэхийг хүсдэг ямар нэгэн зүйл байвал тэд эрхий хуруугаа доош нь харуулан заах ёстой. Дараах жишээнүүдийг ашиглах буюу эсвэл зарим жишээнүүдийг өөрөө зохио:

- Чи Хүүхдийн Хэсэгт ирэхээр сонголт хийв.
- Удирдагч хүн бүхнийг дуулахыг хүсэхэд чи Хүүхдийн Хэсэгт дуулахаар сонгожээ.
- Чи залбирлын үед нүдээ нээлттэй байлгахаар шийджээ.
- Чи найзыгаа сүмд дагуулж ирэхээр сонгожээ.
- Чи ариун ёслолын үед найзтайгаа шивнэн ярихыг сонгосон байв.
- Чи ангидаа чимээгүй явж орохоор сонгосон байв.
- Нэг хүүхдийг бүдэрч унахад чи чанга инээхийг сонгожээ.
- Чи дуу чимээ гаргаж, бусад хүүхдүүдийг үймүүлэхийг сонгожээ.
- Чи багшдаа үйл ажиллагаанд нь туслахыг сонгожээ.
- Асуултад буруу хариулсан хэн нэгнийг чи шоолохыг сонгожээ.
- Багшийг түүх ярьж байхад чи анхааралтай сонсохыг сонгожээ.

Дуу

“Зөв Замыг Сонго” дууг дуулах буюу хүүхдүүдийг үгийг нь хэлэхэд удирд.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг бидэнд сонголтыг өгсөний төлөө та ямар их талархалтай байдгаа хүүхдүүдэд хэл. Зөв сонголтууд хийх хүүхдүүдийн чадварт итгэлтэй байдгаа илэрхийл.

Хүүхэд бүрийг долоо хоногийн үеэр хийсэн нэг зөв сонголтынхоо тухай дараагийн долоо хоногийн хичээл дээр ярихад бэлэн байхыг хүс.

Тарааж өгөх материал

Хэрэв та дараагийн долоо хоногийн хичээлийн талаар хүүхдүүдэд зориулсан зурвас бэлтгэсэн бол үүнийгээ хүүхэд бүрт өг. Хүүхдүүдэд зурвасуудыг тайлбарлаж, эдгээр зурвасуудыг эцэг эхчүүддээ өг гэж тэдэнд хэл.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Бүх хүүхдүүдийг босго. Нэг хүүхдийг удирдагч болгохоор сонгож, нэг зоос буюу товчийг түүнд өг. Зоосыг аль нэг гарт нь нуулган атгуулж, удирдагчийг ангийнхний өмнө зогсоо. Зоос аль гарт нь байгааг ангийн бусад хүүхдүүдээр таалга. Хүн бүхнийг таасны дараа удирдагч зоос аль

гарт байсныг харуулна. Зөв таасан хүүхдүүд удирдагч руу нэг алхамаар ахина. Бусад нь байсан газартаа үлдэнэ. Хүүхдийг удирдагчид хүртэл тоглоомыг үргэлжлүүлнэ.

- Та нар таах бүртээ яагаад бүгдээрээ зөв таасангүй вэ? (Таахад чинь туслах ямар ч мэдээлэл та нарт байгаагүй.)
- Таах нь сонголт хийх сайн арга зам мөн үү?

Бид шийдвэрүүдээ гаргах үедээ тааж болохгүй гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Есүс бидэнд юу хийх ёстойг маань заасан билээ. Хэрэв бид Тэнгэрлэг Эцэг болон Есүсийн биднээс хийхийг хүсдэг зүйлийг хийвэл, бид үргэлж зөв сонголтууд хийх болно.

2. Хүүхдүүдэд цаас будгийн харандаа өгч, Есүс Христийн тэднээр Хүүхдийн Хэсэгт хийлгэхийг хүсэх зүйлүүдийг тэднийг өөрсдөө хийж байгаагаар зуруул. Жишээнүүд нь чимээгүй суух, дуулах, багшид туслах, эсвэл чимээгүй явах байж болно.

3. Доорх үйлдлүүдийг ашиглан, “Сонс, сонс” (*Children’s Songbook*, х. 107) дууг дуулах буюу заасан хөдөлгөөнийг хийн үгийг нь хэлэхэд хүүхдүүдэд тусал:

Намуухан чимээгүй дуу хоолойг сонс (*гараа чихэн дээрээ тавь*)!

Сонс! Сонс! (*хуруугаа уруулдаа хүргэ*)!

Чи сонголт хийх үедээ (*гараа сунган, алгаа дээш нь харуул*).

Тэр чамайг үргэлж удирдах болно (*гараа цээжиндээ зөрүүл*).

Дууны үгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд дууг хэдэн удаа давт.

Зорилго

Хүүхдүүдийг гэр бүлд өсөхийг нь Тэнгэрлэг Эцэг төлөвлөснийг ойлгоход хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Лук 1:26–38, Матай 1:18–25-ыг залбиралтайгаар судал.
2. Дараах үсгүүдийг цаасаар хайчил. Үсэг бүрийг гурав буюу дөрвөн ямхын өндөртэйгөөр хий:

ГЭР БҮЛ

3. “Аз Жаргалтай Гэр Бүл” (*Children’s Songbook*, х. 198) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд орсон болно.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Гэр бүлийн тань зураг (сонголтоор).
 - в. Цаас, харандаа, эсвэл будгийн харандаанууд.
 - г. Зураг 2-5, Зар Түгээгч; зураг 2-6, Есүс Христийн Төрөлт (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 201; 62495).
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Анхааруулга: Ангийн гишүүдийн гэр бүлийн байдалд анхаарал болгоомжтой ханд. Гэр бүлийн хувьд хамгийн чухал зүйл нь гэр бүл дэх хүмүүсийн тоо биш, харин гэр бүлийн гишүүд бие биенээ хайрлаж, халамжлах явдал мөн гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэгэн юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Та хүүхэд бүрийг өнгөрсөн долоо хоногийн хугацаанд зөвийг сонгосон үеийнх нь тухай ярихыг урьж болно.

Гэр Бүлүүд Бол Тэнгэрлэг Эцэгийн Төлөвлөгөөний Нэг Хэсэг Мөн

- Та нар дэлхийд ирэхээсээ өмнө хаана амьдарч байсан бэ?
- Бидний хүн нэг бүр Тэнгэрлэг Эцэгийг дагахаар сонгож, дэлхийд ирснийг хүүхдүүдтэй хамт давт. Биднийг дэлхийд ирэхэд Тэнгэрлэг Эцэг бидэнд туслах болон биднийг хайрлах хүмүүсээр биднийг адисласныг хүүхдүүдэд хэл.

Эдгээр хүмүүсийн хэн болохыг ойлгоход нь тэдэнд туслах түлхүүрүүдийг та тэдэнд өгөх болно гэдгээ хүүхдүүдэд хэл. Тэгээд *гэр бүл* гэсэн үгийн үсэг тус бүрийг нэг хүүхдээр өргүүл. Эдгээр үсгүүд нийлээд ямар үг болж байгааг хүүхдүүдээр нэрлүүл. Тэгээд энэ үсгээр эхэлсэн түлхүүрийг өг. Зарим боломжтой түлхүүрүүд нь дараагийн хуудсанд өгөгдсөн болно.

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

1. **Г**эрийн нэг хэсэг бол Аав.
2. **Э**гч, авга ах, нагац эгч нар үүний нэг хэсэг.
3. **Р**омд өгүүлснээр Ээж бол үүний нэг хэсэг.
4. **Б**и үүний нэг хэсэг.
5. **Ү**үний нэг хэсэг бол хайр.
6. **Л**ав л чи үүний нэг хэсэг.

Та бүх түлхүүрүүдийг өгөөд *гэр бүл* гэдэг үгийг хүүхдүүдийн хамт давтан хэл.

Ярилцлага

- Бидэнд яагаад гэр бүл хэрэгтэй байдаг вэ?

Биднийг нялх хүүхэд байх үед бидний төлөө анхаарал халамж тавих хүмүүс бидэнд хэрэгтэй байсныг тайлбарла. Бидний хүн нэг бүрийн хувьд биднийг хайрлаж, биднийг халамжлах гэр бүлийн хамт амьдрахыг Тэнгэрлэг Эцэг төлөвлөсөн билээ. Биднийг өсөх үед гэр бүлүүд маань бас бидэнд зааж, ухаалаг сонголтууд хийхэд бидэнд тусалдаг билээ.

Есүс Христийг Нэгэн Гэр Бүлд Төрөхийг Тэнгэрлэг Эцэг Төлөвлөжээ

Судрын түүх ба ярилцлага

Есүс Христийг нэгэн гэр бүлд төрөхийг Тэнгэрлэг Эцэг төлөвлөснийг тайлбарла. Дэлхий дээр Есүсийг хайрлаж, халамжлах тэр эрэгтэй, эмэгтэй хоёр хүн Тэнгэрлэг Эцэгийг хайрлаж, зарлигуудыг нь сахидаг байжээ.

Зар Түгээгч, зураг 2-5-ыг үзүүлж, тэнгэр элч Габриел Маритай ирж уулзсан тухай Лук 1:26–38 дахь түүхийг ярь.

- Энэ зураг дээрх эмэгтэй хүн хэн бэ? (Лук 1:27-г үз.)
- Энэ зураг дээрх эрэгтэй хүн хэн бэ? (Лук 1:26-г үз.)

Мари тэнгэр элчтэй уулзаад гайхаж, санаа нь бага зэрэг зовсон хэдий ч, Тэнгэрлэг Эцэгийн түүгээр хийлгэхийг хүссэн юуг ч болов тэрээр хийх хүсэлтэй байсан гэдгийг тайлбарла (Лук 1:29, 38-ыг үз).

- Тэнгэр элч Марид юу хэлсэн бэ? (Лук 1:31–32-ыг үз.)
- Жаал хүүгийн эцэг хэн байсан бэ? (Тэнгэрлэг Эцэг.)

Есүс Христийн Төрөлт, зураг 2-6-г үзүүл.

- Энэ зураг дээрх эрэгтэй хүн хэн бэ?

Иосеф бол Есүсийг хайрлаж, халамжлан Есүсийн эхтэй гэрлэхээр Тэнгэрлэг Эцэгээр сонгогдсон зөв шударга хүн байсныг хүүхдүүдэд хэл. Есүсийг төрөхөөс өмнө нэгэн тэнгэр элч бас Иосеф дээр айлчлан ирснийг тайлбарла. Матай 1:18–25 дахь түүхийг товчхон ярь. Матай 1:21-т тэнгэр элч Иосефт юу гэж хэлснийг чангаар унш.

- Хүүг хэн гэж нэрлэхийг тэнгэр элч Мари, Иосеф хоёрт хэлсэн бэ?

Есүс гэдэг нэр аврагч гэсэн утгатайг тайлбарла. Есүс Христ бид бүгдийг бидний нүглүүдээс аварч, Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очин түүнтэй хамт үүрд амьдрахад бидэнд тусалсан билээ. Есүсийг төрөхөөс өмнө дэлхий дээр амьдарч байсан бошиглогчид Аврагчийн нэрийг Есүс Христ байх болно гэдгийг зөгнөн хэлж байжээ. *Христ* гэдэг үг нь Тэнгэрлэг Эцэгээр сонгогдсон гэсэн утгатай “тослогдсон нэгэн” гэсэн утгатай үг юм.

- Есүст яагаад гэр бүл хэрэгтэй байсан бэ?

Гэр Бүлүүд Маань Бидэнд Хайртай

Багшийн
танилцуулга

Бүх гэр бүлүүд хоорондоо ялгаатайг тайлбарла. Зарим гэр бүлд эцэг эх хоёр байдаг, зарим гэр бүлүүдэд эцэг, эхийн аль нэгэн нь байдаг. Зарим гэр бүл олон хүүхэдтэй байхад зарим гэр бүл ганцхан буюу эсвэл цөөхөн хүүхэдтэй байдаг. Зарим гэр бүлүүдэд хүүхдүүд, эцэг эх, эмээ, өвөө, авга, нагац ах нар, мөн авга, нагац эгч нар бүгдээрээ хамт амьдардаг. Зарим хүүхдүүд, өөрсөдтэйгөө холбоогүй насанд хүрэгчидтэй хамт амьдардаг хэдий ч, тэд эдгээр хүүхдүүдийг мөн л хайрлаж, халамжилдаг. Гэр бүлүүд хамтдаа өөр, өөр зүйлүүдийг хийдэг бөгөөд хайраа мөн өөр өөр байдлаар харуулдаг. Гэр бүлүүдийн хувьд хамгийн чухал зүйл бол гэр бүлийн гишүүд бие биенээ хайрлаж, халамжлах явдал мөн. Хүн бүр гэр бүлийнхээ нэг хэсэг байх хэрэгтэй.

Ярилцлага

- Чамайг жаахан хүүхэд байхад гэр бүл чинь чиний төлөө юу хийдэг байсан бэ?
- Одоо гэр бүл чинь чиний төлөө юу хийдэг вэ?
- Гэр бүлийнхээ бусад гишүүдийн төлөө чи юу хийдэг вэ?

Хүүхдийн
оролцоо

Хэрэв та гэр бүлийнхээ зургийг авчирсан бол үүнийгээ үзүүл. Өөрийнхөө гэр бүлийн гишүүдийг зааж, яагаад хүн нэг бүр нь таны хувьд чухал болохыг хэлж өг. Гэр бүлийнх нь тухай хүүхдүүдээр яриул. Гэр бүлийнхэн нь тэднийг хайрладгийг мэдсэн учраас тэд баяртай байсан үеийнх нь тухай ярихыг хүүхдүүдээс хүс.

Гэр Бүл Маань Бидэнд Тусалдаг

Ярилцлага

Гэр бүлийн гишүүд бие биенээ хайрлаж, бие биендээ тусалдаг тухай та хэдэн жишээ өгөхдөө анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Таныг жишээ өгсний дараа жишээн дэх хүмүүс бие биенээ хайрлах хайрыг хэрхэн харуулсныг ярихыг хүүхдүүдээс хүс. Дараах жишээнүүдийг ашиглах буюу эсвэл өөрөө зарим жишээг зохио:

- Көркийн жаахан эрэгтэй дүү шөнө айдаг байж, тиймээс аюулгүй байдлыг мэдрэхийн тулд залбирал хэлэхэд нь Көрк түүнд тусалжээ. Дараа нь Көрк унтахад нь Эрикт туслахын тулд нэг дуу дуулж өгөв.
- Кейтлийн ээж шөнө гэртээ хоносонгүй. Кейтлин зүрхэн хэлбэртэй цаас хайчилж, тэр ээждээ хичнээн их хайртайг түүнд хэлсэн зурвас бичжээ. Тэр зурвасыг ээж нь гэртээ ирээд олох учраас ээжийнхээ дэрэн дээр тавьжээ.
- Яны эмээ түүнийг зөв бичгийн дүрмийн хичээлээ хийхэд нь Янд туслах цагийг долоо хоног бүр гаргадаг байв. Эмээгийнх нь тусалцаа болон магтаал түүний жагсаалт дахь бүх үгсийг сурахад нь түүнийг урамшуулан дэмждэг байв.
- Тони баптисм хүртэхээсээ өмнө Мормоны Номыг унших зорилго тавьжээ. Орой болгон эгч нь түүнтэй хамт сууж уншихыг нь сонсдог байв. Тэр Тонид хэцүү үгсийг ойлгоход нь тусалдаг байлаа. Тони эгчийнхээ тусалцаатайгаар зорилгодоо хүрэх боломжтой болжээ.
- Ангийнх нь зарим хүүхэд эрэгтэй дүүг нь шоолохыг Хейди сонсчээ. Дүү нь бараг уйлах шахав, тиймээс Хейди түүнийг хол аваачиж, түүнтэй тогложээ. Тэд бусад хүүхдүүдийг шоолох ёсгүйг Хейди дараа нь ангийнхандаа хэлжээ.

Үзүүлэнт хичээл	Хуруугаа тэнийлгэн гараа өргө. Гэр бүлийн гишүүдийг гарын эрхий хуруу болон бусад хуруунуудтай адил хамтдаа ажиллаж болно гэдгийг тайлбарла. Эрхий хуруугаа ашиглалгүйгээр судрууд юм уу, эсвэл өөр ямар нэг юмыг нэг гараараа дээш нь өргөх гэж оролдохыг хүүхдүүдээс хүс. Эрхий хуруунаас бусад хуруунуудаар юмыг дээш нь өргөх гэж оролдохоос, эрхий хуруу болон бусад хуруунуудыг хамтад нь ашиглах нь хавьгүй амархныг тайлбарла. Гэр бүлийн гишүүн бүр чухлыг хүүхдүүдэд сануул. Гэр бүлийн гишүүд бүгдээрээ хамтран ажиллах үед их зүйлийг биелүүлж чадна.
Урлан бүтээх үйл ажиллагаа	Хүүхдүүдэд цаас, будгийн харандаанууд, эсвэл балын харандаанууд өгч, гэр бүлийнх нь зургуудыг зуруул: Зураг бүр дээр <i>Миний Гэр Бүл Надад Хайртай</i> гэж бичүүл.

Дүгнэлт

Дуу	“Аз Жаргалтай Гэр Бүл” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.
Гэрчлэл	Бидний хүн нэг бүр гэр бүлээр хайрлуулж, халамжлуулахыг Тэнгэрлэг Эцэг хүсдэг тухай гэрчлэлийг хэл. Гэр бүл болгон ялгаатай, мөн гэр бүл болгон чухлыг хүүхдүүдэд сануул. Тэд гэр бүлээ аз жаргалтай байхад нь туслахын тулд их зүйл хийж чадна гэдгийг гэрчил. Зурсан зургуудаа гэрийнхэндээ үзүүлж, тэд гэрийнхэндээ хичнээн их хайртайгаа хэлэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж. Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Гэр бүлийнхээ төлөө Тэнгэрлэг Эцэгт талархахыг тэр хүүхдээс хүс.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хэрэв энэ нь танай соёл заншлын хувьд утга учиртай бол хүүхэд бүрээр өөрийнх нь нэр хэрхэн сонгогдсоныг ярихад бэлтгүүлж ирүүл. Үүнийг хичээл 5-ын төгсгөлд хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зурвас явуулж, хүүхдийнх нь нэр хэрхэн сонгогдсоныг тэдэнд хэлж өгөхийг хүссэн зурвасыг тэдэнд явуулан хийж болно (хуудас 23-ыг үз). Биднийг төрөхөд бидний гэр бүлүүд бидэнд зориулж нэр сонгосныг хичээл дээр тайлбарла. Нэр нь хэрхэн сонгогдсоныг хүүхэд бүрээр бусад хүүхдүүдэд яриул. (Хэрэв боломжтой бол, нэр нь хэрхэн сонгогдсон тухай хүүхдээ ярихаар бэлтгүүлж ирүүлэхийг эцэг эхчүүдэд нь сануулахын тулд долоо хоногийн үеэр та тэдэнтэй холбоо барьж болно.)
2. Хүүхэд бүр гэр бүлийнхээ зургийг гэрээсээ авчрахаар зохион байгуул (тэдний анхаарлыг сарниулахгүйн тулд зургуудыг хичээлийн эхэнд хурааж ав). Хүүхдүүдийг нэг нэгээр нь гэр бүлийнхээ зургуудыг үзүүлж, гэрийнхэндээ хайртай байдаг нэг, эсвэл хоёр шалтгааны тухай яриул. (Хэрэв та бас баяжуулах үйл ажиллагаа 1-ийг ашиглахаар төлөвлөсөн бол, хичээл 5-ын төгсгөлд гэр бүлүүдэд явуулсан зурвас дээр гэр бүлийн зураг хүссэн хүсэлтээ нэмж болно.)

3. Гэр бүлийн гишүүдийн нэрсийг ашиглан “Энд Бид Хамтдаа” (*Children’s Songbook*, х. 261) дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл:

Энд бид хамтдаа, хамтдаа, хамтдаа байна;

Өө, энд бид гэр бүлдээ хамтдаа байна.

Аав, ээж, эгч, ах, дүү байна;

Өө, энэ гэрэлт нарлаг өдөр энд бид хамтдаа байна.

Бүх гишүүд нэрлэгдэх тул *эмээ, өвөө, авга, нагац* гэхчлэн үгсийг ашиглан нэмэлт бадгуудыг дуул.

Өөрсдийг нь хайрлаж, халамжлах гэр бүлүүдэд тэднийг амьдруулахаар тэдний төлөө Тэнгэрлэг Эцэг төлөвлөснийг хүүхдүүдэд сануул.

4. Хүүхэд бүрээр гарыг нь хэсэг цаасан дээр тавьж, хуруунуудыг нь тойруулан зуруул. Хүүхдүүдээр хуруунууд дээр гэр бүлийнх нь гишүүдийг төлөөлүүлэн хүний нүүр зуруулах буюу хайрыг нь үзүүлэхийн тулд дунд хэсэгт нь зүрх зуруул. Нэг гэр бүлийн гишүүд бол гарын хуруунуудтай адил юм: хүн бүр чухал гэдгийг хүүхдүүдэд сануул.
5. Гэр бүлийн гишүүд бие биедээ хэрхэн тусалж чадахыг харуулсан нөхцөлүүдийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул. Хичээлийн нөхцөлүүдийг ашиглах буюу зарим нөхцөлийг өөрөө зохио.
6. Таныг үгсийг хэлж байх хооронд дараах шүлгийн дагуу үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Миний Гэр Бүл

Шувууд модонд үүрээ засдаг шиг (*гараараа далавч адил дэвнэ*)

Надад өөрийн гэр бүл минь бий (*өөр рүүгээ заана*)

Тэд намайг хооллодог (*хоол идэж байгаа дүр үзүүлнэ*)

Тоглохыг бас надад заадаг (*үсэртнэ*)

Тиймээс би өдөржингөө аюулгүй, баяртай байж чадна (*инээмсэглэнэ*)

7. Хүүхдүүдийг гар гараасаа хөтлөн тойргоор явж байхад дараах үгсийг хэл

Гэр бүл чинь чамд их хайртай шүү;

Гэр бүл чинь чамд их хайртай шүү;

Ай хөө, гэр бүл минь!

Гэр бүл чинь чамд их хайртай шүү.

Дараагийн бадгийг та дуулахдаа тойргийн голд зогсох нэг хүүхдийг сонго:

Энэ гэр бүлд аав бий,

Энэ гэр бүлд аав бий;

Ай хөө гэр бүл минь!

Энэ гэр бүлд аав бий.

Аавыг ээжээр сольж, тойргийн гол дахь эхний хүүхдийг өөр хүүхдээр сольж энэ бадгийг давт. Гэр бүлийн бусад гишүүдийн нэрсийг ашиглан хүүхэд бүрийг тойргийн голд зогсох хүртэл үргэлжлүүл. Бүх хүүхдүүдийг хамтдаа зогсож байхад эхний бадгийг дахин нэг удаа дуул.

Есүс Христийн Төрөлт Дэлхийд Баяр Хөөр Авчирсан

Хичээл
7

Зорилго Есүс Христийн төрөлт дэлхийд баяр хөөр авчирсныг хүүхэд бүрийг мэдрэхэд нь туслах.

Бэлтгэл

1. Лук 2:1–20-ийг залбиралтайгаар судал.
2. Арван хоёр сартай хуанли авчрах буюу эсвэл төрсөн өдрийн үйл ажиллагаанд зориулсан цагийн хуваарь гарга. Цагийн хуваарь гаргахын тулд урт туузан цаасыг арван хоёр тэнцүү хэсэгт хувааж, хэсэг бүрт сарын нэрсийг дарааллаар бич.
3. Хүүхдийн Хэсгийн нарийн бичгийн дарга, хэсгийн бичиг хэргийн ажилтан, эсвэл хүүхдүүдийн эцэг эхчүүдээс асууж, ангийнхаа хүүхэд бүрийн төрсөн өдрийг мэдэж ав.
4. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийнхөө зөвшөөрлөөр, нэг ээж буюу ээж болох гэж байгаа хүнийг урьж, тэрээр хүүхдийнхээ төрөлтөд хэрхэн бэлтгэсэн буюу бэлтгэж байгааг нь хүүхдүүдэд товчхон яриул. Тэрээр хэрхэн сэтгэл догдолж байсан буюу байгааг нь яриандаа оруулахыг түүнээс хүс.
5. “Алс Тэртээ Хол Иудейн Нутаг Хээр Талд” дууны (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.52) эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
6. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хүүхэд бүрт жижиг цаас, харандаа.
 - в. Скоч буюу өөр наалддаг зүйл.
 - г. Зураг 2-6, Есүс Христийн Төрөлт (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 201; 62495).
7. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Анхааруулга: Та хүүхдүүдийн төрсөн өдрийн тухай ярилцахдаа ангийнхаа өргөмөл буюу бусдын асрамжид байдаг хүүхдүүдийн тухайд нэн анхаарал болгоомжтой бай. Тэдний төрсөн нь ч бас баяртай үйл явдал мөн гэдгийг тэд ойлгоход анхаар.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Төрсөн Өдрүүд Онцгой Юм

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Та нэг онцгой өдрийн тухай бодож байгаагаа хүүхдүүдэд хэл. Та тэдэнд түлхүүр өгөх болно гэдгээ, мөн түлхүүрийг сонсохыг тэднээс хүсч, ямар өдрийн талаар та бодож байгааг тэд мэдсэн үед гараа өргөх ёстойг тайлбарла. “Төрсөн Өдрийн Мэнд Хүргэе” дууг аялах буюу өөр ямар нэг тодорхой түлхүүр өг.

- Би ямар онцгой өдрийн тухай бодож байна вэ?
- Та нар төрсөн өдрийнхөө тухайд юунд нь хамгийн дуртай вэ?

Хуанлийн буюу
үйл ажиллагааны
цагийн хуваарь

Цаас харандаа тарааж өг. Хүүхэд бүрээр цаасан дээр нэрийг нь бичүүл (Шаардлагатай бол хүүхдүүдэд тусал).

Хуанли буюу цагийн хуваарийг үзүүл. Саруудын нэрийг таныг унших үед тэдгээрийг тантай хамт хэлэхийг хүүхдүүдээс хүс. Сар бүрийн нэрийг нэг нэгээр дахин унш, тэгээд тухайн сард төрсөн өдөр нь болдог хүүхдүүдийг хуанли буюу цагийн хуваарь дээр нэрээ наахыг хүс.

- Чамайг төрөхөд гэрийхэнд чинь ямар санагдаж байсан гэж чи боддог вэ?

Зочин үг хэлэгч

Ээж буюу ээж болох гэж байгаа хүнийг танилцуулж хүүхдийнхээ төрөлтөд бэлтгэсэн буюу бэлтгэж байгаа талаарх сэтгэгдлийг нь илэрхийлүүл.

Ярилцлага

Тэдний төрөлтөд бэлтгэх үедээ эрүүл мэндийнх нь төлөө залбирах, нэр сонгох, хүүхдийн хувцас болон бусад зүйлс олж авах, хаана унтуулж байхыг нь төлөвлөх зэрэг тэдний гэрийнхний хийсэн байж болох зүйлүүдийн талаар хүүхдүүдтэй ярилц. Тэдний төрөлт баяртай, сэтгэл хөдөлгөм үйл явдал байсан гэж бодоход нь хүүхдүүдэд тусал. Хэрэв та өөрөө хүүхэдтэй бол, гэр бүлд чинь хүүхэд төрөх үед юу хийсэн болон ямар сэтгэгдэл төрж байсан тухайгаа ярьж болно.

Төрөх болон бие махбодыг хүлээж авах нь бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг гэдгийг хүүхдүүдэд сануул.

Есүс Христийн Төрсөн Өдөр Гайхамшигтай Сайхан Өдөр Байв

Багшийн
танилцуулга

Хүмүүсийн олон жил хүлээсэн нэг хүүхдийн төрөлтийн тухай тэд одоо мэдэх болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Эрт дээр үед нэгэн өдөр аврагч төрөх болно хэмээн бошиглогчид хэлдэг байв. Тэнгэрлэг Эцэгт буцан очиж түүнтэй хамт дахин амьдрахыг Тэрээр хүмүүст боломжтой болгох байлаа. Энэ хүүхдийн төрөлтийг хүмүүс хүлээсээр, хүлээсээр л байлаа.

- Энэ хүүхэд хэн байсан бэ? (Есүс Христ)

Есүсийг яг хэзээ төрөхийг хэн ч мэдэхгүй байсныг анхааруул. Зарим эцэг эхчүүд Есүс амьдралын зөв замыг үзүүлэх болно, тэгээд дараа нь Тэнгэрлэг Эцэгт буцан очиж түүнтэй хамт амьдрахыг хүн бүрийн хувьд боломжтой болгоно гэдгийг мэддэг байсан учраас энэхүү агуу үйл явдлыг хүсэн хүлээхийг хүүхдүүддээ заадаг байжээ. Бидний Аврагч болох Есүсгүйгээр хэн ч Тэнгэрлэг Эцэгтэй хамт дахин амьдрах боломжгүй юм.

Жүжигчилсэн
тоглолтод
бэлтгэх нь

Хүүхдүүдийг Есүс Христийг төрөхөөс өмнө амьдарч байсан мэт дүр үзүүлэхийг тэднээс хүс. Тэд бол Бетлехем хотын ойролцоо амьдардаг хүүхдүүд гэдгийг тэдэнд хэл. Эцэг эхчүүд нь Аврагчийн төрөлтийг хүсэн хүлээхийг тэдэнд заадаг ажээ. Өнөө орой тэд хонио хариулахад нь аав нартаа тусалж гадаа бэлчээрт байна.

- Аав нартайгаа хамт хонио хариулахаар явахдаа та нар юу авч явах вэ? (Хариулт нь өмсөх дулаан хувцас, идэх юм байж болно.)

Хүүхдүүдийн нүдийг аниулж, дараах үйл явдлыг төсөөлүүл:

Орой болж, хоньчид хонио маргааш өглөөг хүртэл тайван унтах хашаанд нь оруулж байна. Цэлмэг шөнө болж, одод гарч эхлэв. Удалгүй тэнгэр хурц оддоор дүүрэв. Юм бүхэн амар тайван, нам гүм байна. (Ангид шөнийг дүрслэхийн тулд та гэрлүүдийг унтрааж болно.)

Судрын түүх ба жүжигчилсэн тоглолт	<p>Лук 2:8–18 дахь тэнгэр элч хоньчид дээр хүрч ирсэн тухай түүхийг ярьж өг. Та уг түүхийг ярихдаа Библиэс цөөн шүлгийг чангаар унш.</p> <p>Тэнгэр элчийг хараад хоньчид айсан боловч, харин тэнгэр элч тэдэнд, “Бүү айгтун: учир нь болгоогтун, би бүх ард түмнийг үлэмж баярлуулах [сайн мэдээг] авчирлаа” гэж хэлжээ (Лук 2:10).</p> <p>Тэнгэр элчийг хараад айж байгааг, дараа нь тэр тэнгэр элчийн хэлснийг сонсоод баярлаж байгааг хүүхдүүдээр үггүй жүжигчлэн харуулуул.</p> <p>Тэнгэр элч Есүсийн төрөлтийн тухай хоньчдод ярьж (Лук 2:11-ийг), нялх Есүсийг хаанаас олж харж болохыг тэдэнд хэлжээ (Лук 2:12-ыг үз). Тэгээд хоньчид гэнэт олон тэнгэр элчийг “Бурханыг магтан, дээд өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь хүмүүст байх болтугай” гэхийг сонсчээ (Лук 2:13–14).</p>
Дуу	<p>“Алс Тэртээ Хол Иудейн Нутаг Хээр Талд” дууг дуулах буюу үгийг нь хэл. Хэрэв хүүхдүүд үгийг нь мэддэг бол өөртэйгөө нэгдэхэд тэднийг урь.</p> <p>Алс тэртээ хол Иудейн нутаг хээр талд, Эртний хоньчид баярын дууг сонсжээ: Бурханыг магтъя, Бурханыг магтъя, Дээдийн дээд Бурханыг магтъя; Ертөнц, хүмүүс амар байг; Ертөнц, хүмүүс амар байг!</p>
Судрын түүх ба жүжигчилсэн тоглолтын үргэлжлэл	<p>Тэнгэр элчүүдийг тэнгэрт буцахад, хоньчид нялх Есүсийг олохын тулд явахаар шийджээ (Лук 2:15-ыг үз). Хүүхдүүд аав нарынхаа хамт нялх Есүсийг үзэхээр Бетлехем руу явахаар болж байгааг тэднээр жүжигчлэн тоглуул (та анги доторх өөр хэсэг рүү явж болно).</p> <p>Есүс Христийн Төрөлт, зураг 2-6-г үзүүл.</p> <ul style="list-style-type: none"> • Энэ зураг дээрх хүмүүс хэн бэ? <p>Хоньчид нялх хүүхдийг тэнгэр элчийн яг тэдэнд хэлснээр олж харсныг тайлбарла. Тэр тэжээлийн тэвшинд даавуугаар өлгийдүүлэн хэвтэж байв (та даавуугаар өлгийдүүлэх гэдэг нь хүүхдийг хэсэг даавуугаар ороосон байлаа гэсэн утгатай гэж тайлбарлахыг хүсч болох юм). Есүсийг харж, түүний тухай сонсох боломж олгосон олон зүйлийн талаар хоньчид баяр талархалтай байлаа, тэгээд тэд харсан, сонссон зүйлийнхээ талаар бусад хүмүүст ярьжээ (Лук 2:17–18-ыг үз).</p>
	Дүгнэлт
Хүүхдийн оролцоо	<p>Хүүхэд бүрийг босохыг урьж, тэр шөнө хоньчид хонио манаж байхад тохиолдсон нэг зүйлийн талаар яриул. Өдий удаан хүлээсэн Аврагчийн төрөлтийн дараа олон хүмүүс нэн их баяртай байсныг онцлон хэл.</p>
Гэрчлэл	<p>Есүс Христийг дэлхийд ирсэнд та ямар их баяртай байдгаа хүүхдүүдэд хэл. Есүс бол дэлхийн Аврагч мөн гэдэг гэрчлэлээ хуваалцаж, Есүсийн заадаг зүйлүүдийг дагах нь нэгэн цагт Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар эргэж очиход бидэнд туслах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.</p> <p>Гэртээ харьж, Есүс Христийн төрөлтийн тухай мэдсэн зүйлийнхээ талаар эцэг эхчүүддээ ярихад нь хүүхдүүдийг урамшуул.</p> <p>Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Есүс Христийн төрөлтийн төлөө талархал илэрхийлэхийг тэр хүүхдэд санал болго.</p>

**Баяжуулах Үйл
Ажиллагаанууд**

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохи-
рохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт
буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг
“Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Аврагчийн төрөлтийн эргэн тойрон дахь үйл явдлуудыг жүжигчлэн
тоглоход нь хүүхдүүдэд тусал. Хүзүүний ороолтууд, тоглоомон хүүхэлдэй
зэрэг зарим энгийн төлөөлөх зүйлүүдийг та авчирч болно.
2. “Нэгэнтээ Би Нялх Байлаа” дууны (үгийг нь “Once There Was a Snowman”
дууны аяар дуулж болно, *Children’s Songbook*, х. 249) үгийг хэлж, үйл
хөдлөлийг нь хийхэд хүүхдүүдэд тусал. Эхний бадгийн хувьд биеэ
атийлгаж намхан болгох, харин хоёр дахь бадгийн хувьд биеэ сунгах
үйлдлүүдийг ашигла.



Нэгэнтээ би нялх, нялх, нялх байлаа

Нэгэнтээ би нялх, балчирхан, балчирхан балчирхан байлаа

Одоо би том, том, том болон өсч байна

Одоо би том, өндөр, өндөр, өндөр болон өсч байна.

3. “Малын Тэвшинд” (*Children’s Songbook*, х. 42), “Маригийн Бүүвэйн Дуу”
(*Children’s Songbook*, х. 44), эсвэл “Чимээгүй Байгаарай, Миний Хүү”
(*Children’s Songbook*, х. 48) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. Эдгээр
дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.
4. Нялх Есүс болон тэжээлийн тэвшний зураг чимэглэлүүдийн (хичээлийн
төгсгөлд байгаа) хуулбар буюу хуулгыг хүүхэд бүрт хий. Хүүхэд бүрээр
тэжээлийн тэвхийг будуулж дээр нь жаахан өвс, хуурай өвс буюу
нэхмэлийн утас наалгаж, нялх хүүхдийн ор болгуул. Тэгээд нялх Есүсийн
зургийг хүүхэд бүрээр будуул. Нялх Есүсийн зургуудыг хайчилж,
тэдгээрийг тэжээлийн тэвшинд наахад нь хүүхдүүдэд тусал.



Тэнгэрлэг Эцэг Намайг Харж Ханддаг

Зорилго

Тэнгэрлэг Эцэг хэрэгтэй цаг үед бидэнд тусалж биднийг адислах болно гэдэгт итгэх хүүхэд бүрийн итгэлийг бэхжүүлэх

Бэлтгэл

1. Матай 2:1–15, 19–20-ийг залбиралтайгаар судал.
 2. Хүүхэд бүр өөрийнхөө нүүрний зургийг дээр нь зурахад хүрэхээр том дугуй цаасыг хүүхэд бүрт зориулан бэлд. Дугуй бүрийн орой дээр нүх гаргаж *Тэнгэрлэг Эцэг Намайг Харж Ханддаг* гэж дугуйн ирмэг дээгүүр бич.
 3. Тэнгэрлэг Эцэг таныг ослоос, таныг асуудал шийдэх хэрэгтэй болох үед, эсвэл танд тайтгарал хэрэгтэй болсон үед таныг харж, хандаж, хамгаалж байсныг мэдэрсэн тохиолдлоосоо хуваалцахад бэлтгэ. Эсвэл Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр хэсгийнхээ буюу салбарынхаа нэг гишүүнийг ангидаа ирж, ийм туршлагаасаа хуваалцахыг урь.
 4. “Хайрт Эцэг минь Талархъя Тандаа Би” дууг (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.61) дуул, эсвэл үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
 5. Шаадлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Цэцэг, гоё чулуу эсвэл талархал илэрхийлсэн товч зурвас зэрэг хүүхэд бүрт өгөх жижигхэн бэлэг.
 - в. Будгийн буюу балын харандаанууд.
 - г. Хүүхэд бүрт урт нэхмэлийн утас.
 - д. Зураг 2-7, Мэргэн Хүмүүс (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 203; 62120); зураг 2-8, Египет Уруу Зугатсан нь (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 204; 62119); зураг 2-9, Давид О.МакКэй Хөвгүүн Байхдаа.
 6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Тэнгэрлэг Эцэг Бидний Төлөө Олон Зүйлийг Хийдэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Нүдээ анихыг хүүхдүүдээс хүс. Жижиг бэлгийг хүүхэд бүрийн өвөр дээр тавиад, нүдээ нээхийг хүүхдүүдээс хүс. Тэрхүү аятайхан гэнэтийн бэлгийн талаар маш товчхон ярих хугацаа хүүхдүүдэд олго.

- Энэ бэлгийг та нарын өвөр дээр хэн тавьсан гэж та нар бодож байна вэ?
- Би яагаад та нарт бэлэг өгсөн гэж та нар бодож байна вэ?
- Гоё сайхан зүйлүүдийг та нарт өөр хэн өгдөг вэ? (Эцэг эхчүүд, гэр бүл, найз нар, Тэнгэрлэг Эцэг)

- Та нарт зориулж Тэнгэрлэг Эцэг юу хийсэн бэ? (Хариултууд нь та нарыг дэлхийд ирэхийг төлөвлөсөн, бидэнд гэр бүлийг өгсөн болон бидний аврагч болгохоор Есүс Христийг дэлхийд илгээсэн зэрэг байж болно.)

Дуу

“Хайрт Эцэг минь Талархъя Тандаа Би” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Бидэнд зориулж Тэнгэрлэг Эцэгийн хийдэг нэг зүйл бол бидэнд бэрхшээлтэй асуудал тулгарахад хамгаалж, тайтгаруулдаг явдал мөн. Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэлтэй байвал тэрээр бидэнд асуудлуудаа хэрхэн шийдвэрлэх талаар сайн шийдвэр гаргахад туслах ба биднийг урамшуулан дэмжих болно.

Тэнгэрлэг Эцэг Нялх Есүсийг Хамгаалсан Юм

Судрын түүх

Мэргэн Хүмүүс, зураг 2-7-г үзүүл. Матай 2:1–12-т байдаг нялх Христийг хайж байсан Мэргэн хүмүүсийн тухай түүхийг ярьж өг.

Херод Хаан Мэргэн Хүмүүст хэлэхдээ, тэрээр Христ хүүхдийг шүтэн бишрэх буюу эсвэл түүнд хайраа үзүүлэхийг хүсч байна гэснийг тайлбарла (Христ хүүхэд гэдэг нь нялх Есүсийн өөр нэг нэр гэдгийг та тайлбарлаж болно). Гэвч Херод Хаан Есүсийг хорлохыг үнэхээр хүсч байсан ажээ. Матай 2:12-ыг чангаар уншиж, Херод Хаан руу буцаж очихгүй байхыг Мэргэн Хүмүүст хэлснээр Тэнгэрлэг Эцэг Есүсийг хамгаалсныг тайлбарла.

Судрын түүх

Египет Уруу Зугатсан нь, зураг 2-8-ыг үзүүл. Матай 2:13–15 дахь түүхийг ярьж өг. Шүлэг 13-ыг чангаар уншиж, устгах гэсэн нь алах гэсэн утгатайг тайлбарла.

- Тэнгэр элч яагаад Иосефт үзэгдсэн бэ? (Матай 2:13-ыг үз)
- Тэнгэр элч Египет руу явахыг Иосефт яагаад хэлсэн бэ? (Херод Хаан Есүсийг олж чадахгүй байхын тулд)
- Херод Хаан яагаад нялх Есүсийг алахыг хүсч байсан бэ? (Есүс том болоод түүний хаан суудлыг авах вий гэж тэр айж байжээ.)

Есүс, Мари хоёрыг Египет руу авч явахыг Иосефт анхааруулснаар Тэнгэрлэг Эцэг Есүсийг харж хандаж, хамгаалсныг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг Есүсийг үргэлж харж хандаж байв.

Матай 2:19–20-ийг чангаар унш.

- Тэнгэр элч Иосефт яагаад дахин үзэгдсэн бэ? (Матай 2:20-ийг үз.)
- Иосеф, Мари, нялх Есүсийн хувьд Израилд эргэж ирэх нь яагаад аюулгүй байсан бэ? (Херод хаан нас барсан. Матай 2:19–20-ийг үз.)

Тэнгэрлэг Эцэг Биднийг Харж Ханддаг

Ярилцлага

Бидний хүн нэг бүр Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд гэдгийг хүүхдүүдэд сануул. Яг Есүсийг харж хандаж байсны адилаар Тэрээр биднийг харж ханддаг. Бид түүний зарлигуудыг дуулгавартай дагаж, түүнээс тусламжийг хүсэхэд Тэнгэрлэг Эцэг бидэнд туслах болно. (Тэнгэрлэг Эцэг үргэлж бидэнд тусалдаг, гэвч зарим үед тэрээр яг бидний хүсэн хүлээж байсны адилаар тусалдаггүйг та тэмдэглэн хэлж болно.)

- Та нар Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг яаж хүсч болох вэ? (Залбирч.)
- Та нарыг өвчтэй байхад, та нарыг ганцаардахад, та нарыг айхад Тэнгэрлэг Эцэг та нарт хэрхэн тусалж болох вэ?

Түүх	<p>Давид О.МакКэй Хөвгүүн Байхдаа, зураг 2-9-ийг үзүүл. Давид О.МакКэй (тэр аавынхаа өвөр дээр сууж байна), энэ жаал хүү өсч том болсон хойноо Сүмийн ес дэх Ерөнхийлөгч болсныг хүүхдүүдэд хэл. Түүнийг бяцхан хөвгүүн байхад түүнд тохиолдсон туршлагын талаарх дараах түүхийг ярьж өг:</p> <p>“Нэг шөнө аавыгаа эзгүйд Давид . . . гэрийнх нь орчинд дуу чимээ гарахыг сонсч, хулгайч байх гэж боджээ. Ээж нь [дуу чимээг] сонсвол, тэр бас айх болно гэдгийг мэдэж байв, ингээд ээж нь сонсоогүй байх гэж тэр найджээ. Тэр бүр сэрчихсэн хэвтэж байгаад, . . . эцэг эхчүүд нь түүнд заадаг байсан нэг зүйлийг—залбирал хийхээр шийджээ. Тэр орныхоо дэргэд үргэлж өвдөг сөгдөн залбирлаа хэлдэг байж, тиймээс тэр одоо орноосоо босч, доош өвдөг сөгдөн залбиръя гэж боджээ. Тэр ихэд айсан байсан учраас орноос босно гэдэг нь хүндхэн сорилт байв; энэ нь түүний бүх хүч чадал сэтгэлийн тэнхээг шавхав. Гэвч тэр үүнийг хийсэн ажээ!</p> <p>“Тэр орныхоо дэргэд доош өвдөг сөгдөн, чин сэтгэлээсээ, мөн үнэнхүү итгэлтэйгээр залбирчээ. Тэгтэл, яг нэг хүн нөгөөдөө хэлэх шиг, ‘Битгий ай, Юу ч чамд хор хүргэхгүй’ гэж түүнд хандан хэлэх дуу хоолойг тэр сонсов. Тэгээд Давид орондоо буцаж ороод бөх гэгч нь унтжээ” (Marie F. Felt, “David: A Boy of Promise,” <i>Instructor</i>, 1969 оны Есдүгээр сар, х. 330).</p>
Түүх	<p>Сүм дэх Төлөөлөгч болсон ахлагч Хю Б.Брауны тухай дараах түүхийг ярьж өг:</p> <p>“Би бага байхдаа шөнө муухай зүүд зүүдэлвэл, би сэрээд, ‘Ээж ээ, та байна уу?’ гэж дууддаг байлаа. Ээжийн өрөө, миний өрөөний хажууд байсан болохоор тэр сонсоод ‘Тийм ээ, Миний хүү, би энд байна’ гэж түргэн хариулдаг сан.</p> <p>“Олон жилийн дараа намайг Англид номлолоор явахад, намайг дуудахад ээж минь хариулахаар тэнд байж байхгүй, харин бидний Тэнгэрлэг Эцэг үргэлж тэнд байх болно гэдгийг ээж минь надад сануулж билээ.</p> <p>“Номлолд байхдаа болон амьдралынхаа туршид би олон удаа: ‘Аав аа, та байна уу?’ гэж дуудсан. Би үргэлж хариу хүлээн авдаг байсан” (in Joleen Meredith, “Friend to Friend,” <i>Friend</i>, 1975 оны Наймдугаар сар, х. 7).</p> <p>Тэнгэрлэг Эцэг бидэнд хандан чангаар ярихгүй ч гэсэн тэр биднийг үргэлж харж ханддагийг тайлбарла. Зарим үед тэр бидэнд амар амгалангийн мэдрэмж төрүүлснээр эсвэл бидний оюун ухаанд санаануудыг өгч бидэнд тусалдаг.</p>
Багшийн танилцуулга буюу үг хэлэгч зочин	Тэнгэрлэг Эцэг таныг харж, хандаж байсан тухай өөртөө мэдрэгдсэн туршлагыг хуваалцах буюу, эсвэл хэсгийн болон салбарын аль нэг гишүүнийг туршлагыг нь хуваалцуулахаар урь.
Урлан бүтээх үйл ажиллагаа	Хүүхэд бүрт будгийн, эсвэл балын харандаанууд, мөн дугуй цаас өг. Дугуй цаасан дээр хүүхэд бүрээр өөрийнх нь нүүрийг зуруул. Хүүхдүүд дугуйг хүзүүндээ зүүж болох тул тэднээр дугуй бүрийн дээд тал дахь нүхээр утас сүвлүүл. Дугуйнууд дээрх үгсийг чанга унших буюу хүүхдүүдээр уншуул.
	Дүгнэлт
Гэрчлэл	<p>Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг дэлхий дээр байхад түүнийг хайрлаж, харж ханддаг байсны адил Тэнгэрлэг Эцэг бас биднийг хүн нэг бүрийг хайрлаж, харж ханддаг тухай гэрчлэлээ хэл.</p> <p>Нэг хүүхдийг зааж, “Тэнгэрлэг Эцэг . . . -ийг (нэрийг нь хэлнэ) үргэлж харж хандаж байдаг” гэж хэл. Хүүхэд бүр дээр үүнийг давт.</p> <p>Тэнгэрлэг Эцэгт итгэж, өнөө оройнхоо залбиралд өөрсдийг нь хамгаалах халамжлалыг гуйхад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.</p>

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Хайр, тусламжийнх нь төлөө Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлэхийг тэр хүүхдээс хүс.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдийн Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг хүсч болох нөхцөлүүдийг тодорхойлон бичсэн цааснууд бэлтгэ. Цааснуудыг саванд хийж, хүүхдүүдийг эдгээрээс нэг, нэгийг ээлжээр сонгуулж, тэнд дүрсэлсэн нөхцөлд тэд юу хийхийг нь хэлүүл. Та дараах нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл өөрөө зарим нөхцөлүүдийг зохиож болно:
 - а. Танай гэр бүл аялалд явах гэж байна. Аяллын үеэрх гэр бүлийнхээ аюулгүй байдлын төлөө эцэг эхийн чинь санаа зовж байна.
 - б. Эмэгтэй дүү чинь өвдөж, эмнэлэгт байна. Чи түүний төлөө санаа зовниж байгаа.
 - в. Гэрийнхэнтэйгээ хамт явган аяллаар явж байгаад чи төөрчихжээ.
 - г. Чи хөлөө хугалж, тэгээд өвдөлт болон эвгүй боолтноосоо залхсан байв. Чи маш их цухалдаж байна.
 - д. Энэ бол чиний шинэ хэсэг буюу салбар дахь Хүүхдийн Хэсэгт ирэх анхны өдөр байлаа, тэгээд чи айж байлаа.
2. Сандалнуудыг өрөөнд энд тэнд замбараагүй тавьж, тэдгээр нь амьдралд бидэнд тулгардаг бэрхшээлтэй асуудлуудыг төлөөлж байгааг хүүхдүүдэд хэл. Нэг хүүхдийн нүдийг боож, түүнийг амаар чиглэл өгч өрөөн дотуур явахад нь удирд. Хэдийгээр бид Тэнгэрлэг Эцэгийг харж чадахгүй ч гэсэн, түүний зарлигуудыг дагах нь бидний амьдралын туршид бидэнд туслах болно гэдгийг тайлбарла. Хэрэв өнөөх хүүхэд сандал мөргөвөл бид бүгд бэрхшээлтэй асуудалтай тулгардаг бөгөөд асуудлуудаа шийдвэрлэхэд туслахыг болон тайтгарлыг Тэнгэрлэг Эцэгээс гуйж болно. Нүдээ боолгож, өрөөн дундуур удирдуулан явахыг хүссэн хүүхэд бүрийг ээлж, ээлжээр нь явуул.
3. “Бурхан Бүхнийг Харж Ханддаг” (*Children’s Songbook*, х. 229) дууны хоёр бадаг, “Эцэг Минь Амьдыг Би Мэднэ” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.59) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. “Эцэг Минь Амьдыг Би Мэднэ” дууны үг гарын авлагын ар талд байгаа болно.

Бурхан Бүхнийг Харж Ханддаг

Дээр гялалзагч бүх оддыг
Дээд тэнгэрт Бурхан тоолсон.
Дэлхийнүүд агуу, болжмор жижигхэн;
Бурхан бүхнийг харж хандаж байдаг.

Ажиллаж, тоглож байгаа хүүхэд бүрийг
Тэр өдөржин, шөнөжин санадаг.
Юу хийхийг чинь тэр чамд заана;
Бурхан бүхнийг харж хандаж байдаг.

(Анхных нь нэр: “Loving Care.” *Tuning Up* of THE WORLD OF MUSIC цувралаас авав, © 1936 by Silver Burdett & Ginn. Зөвшөөрлөөр ашиглана.)

Есүс Христ Надтай Адил Хүүхэд Байсан

Зорилго

Есүсийн хүүхэд ахуй үеийн тухай мэдлэгээ нэмэгдүүлснээр Есүс Христтэй адилхан болох хүүхдүүдийн хүслийг бататгах.

Бэлтгэл

1. Матай 2:19–23, Лук 2:40–52-ыг залбиралтайгаар судал. *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 11-ийг мөн үз.
2. Библийн Сургууль, зураг 2-12-т харуулсны дагуу, түүнчлэн энэ хичээлд дүрсэлсний дагуу хуйлмал бичиг хийхийн тулд цаас, савх ашигла. Хуйлмал цаасан дээр Лук 2:52-ын үгсийг бич.
3. “Нэгэн цагт Есүс Бяцхан Хүүхэд Байсан” (*Children’s Songbook*, х. 55) дууг дуулах буюу хоёр бадгийнх нь үгийг хэлэхэд бэлтгэ. Хэрэв боломжтой бол, энэ хичээлийг орох долоо хоног болон үүнийг заахын өмнөх долоо хоногт дуулах цагаар энэ дууг дуулах дадлага хийхэд нь хүүхдүүдэд туслахыг Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагчаас хүс.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Угж, өлгий, хүүхдийн шажигнадаг тоглоом зэрэг нялх хүүхдийн юмс.
 - в. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - г. Зураг 2-10, Гэр Бүлийн Библийн Амьдрал; зураг 2-11, Есүс Христийн Хүүхэд Ахуй Нас (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 206; 62124); зураг 2-12, Библийн Сургууль; зураг 2-13, Жаал Хүү Есүс Ариун Сүмд (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 205; 62500).
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Нэгэн Цагт Есүс Хүүхэд Байсан

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Нялх хүүхдийн эд юмсыг хүүхдүүдэд тарааж өгөөд тэдгээрийг харуулж, бариулж үзүүл. Эдгээр юмс юунд ашиглагддагийг тайлбарла. Нэгэн цагт Есүс Христ хүүхэд байсныг анхааруулан хэл.

- Эдгээртэй адил зүйлүүдийг Есүс ашигладаг байсан гэж та нар бодож байна уу?

Есүсийг нялх байхад нялх хүүхдүүдийн ашигладаг байсан зарим зүйлүүд маш энгийн байсныг хэлж өг. Тэдгээр зүйлүүдийн зарим нь одоогийнхоос их өөр байсан ажээ. Энэ хичээлээр Есүсийг хүүхэд байх үеийн амьдралын тухай хүүхдүүд мэдэх болно гэдгийг тайлбарла.

Есүс Гэртэй Байсан

Зураг дээр
ярилцах нь

Гэр Бүлийн Библийн Амьдрал, зураг 2-10-ыг үзүүл. Энэ бол Назарын хүмүүсийн амьдарч байсан гэр орны нэг төрөл гэдгийг хүүхдүүдэд хэл. Назар бол Есүсийн өссөн хотхон бөгөөд (Матай 2:23-ыг үз), Есүс үүн шиг гэр оронд амьдарч байсан байх. Зургийг хүүхдүүдээр сайн харуулж, үүний тухай яриулан асуулт тавиул. Хэрэв хүүхдүүдэд асуулт байхгүй бол та дараахтай төстэй асуултууд асууж болно:

- Гэр бүл нь хаана унтдаг байсан гэж та нар бодож байна? (Эмэгтэй хүний гадагш нь гаргаж байгаа шалны дэвсгэр, эмэгтэйн ар талд байгаа ханын шүүгээ өөр нэг эвхсэн гудсыг заа. Байшингийн дээвэр нь хавтгай, байшин бүрийн гаднах шатны довжоо дээвэр лүү гарсан байдгийг тайлбарла. Хүүхдүүд заримдаа дээвэр дээр унтдаг байсан байж магадгүй.)
- Энэ байшинд нялх хүүхэд хаана унтдаг байсан бэ? (Хүүхдийн ор луу заа. Иосеф мужаан байсан бөгөөд нялх Есүст зориулж ийм хүүхдийн ор хийсэн байж болох юм гэдгийг тайлбарла.)
- Том шилэн савнуудыг юунд ашигладаг байсан гэж та нар бодож байна? (Заримд нь ус хийдэг байжээ. Айлуудад татуургын ус байдаггүй байсан учраас гэр бүлийн хэрэглэдэг бүх усыг тосгон дахь худгаас зөөдөг байв. Худаг гэдэг бол дотроо цэвэр устай газар доорх гүнзгий нүх юм.)
- Шалан дээр сууж байгаа эмэгтэй юу хийж байна вэ? (Талх хийхийн тулд тариа тээрэмдэж байна)
- Цахилгаан байгаагүй болохоор тэд гэр орноо яаж гэрэлдүүлдэг байсан бэ? (Тэд тосон дэн хэрэглэдэг байлаа. Тариа тээрэмдэж байгаа эмэгтэйн ар дахь мухар сандал дээрх дэнг заа. Шилэн савнуудын заримд нь дэнгийн тос хадгалдаг байсан байж болох юм.)

Зураг дээр
ярилцах нь

Есүс Христийн Хүүхэд Ахуй Үе, зураг 2-11-ийг үзүүл.

- Энэ зураг дээрх хүмүүс хэн бэ? (Есүс, Иосеф хоёр)
- Тэд юу хийж байна вэ?

Есүс Иосефт ажилд нь тусалдаг байсан нь дамжиггүй, мөн Иосеф Есүсийг өөр шигээ мужаан болгохын тулд заадаг байсан байж болно (Марк 6:3-ыг үз).

- Энэ гэрт Есүс өөр юу сурсан гэж та нар бодож байна?

Библид бидний уншдаг түүхүүдтэй адил түүхүүдийг Есүст гэрт нь ярьж өгдөг байсныг онцгойлон хэл. Бас залбирахыг, мөн бидний эцэг эхчүүд бидэнд заадаг шиг зөвийг хийхийг сонгохыг түүнд заадаг байжээ. Мари, Иосеф хоёр яг бидний нэгэн адил Тэнгэрлэг Эцэгт итгэдэг байв.

Есүс Хөвгүүн Байхдаа Олон Зүйлийг Хийдэг Байжээ

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр гарыг нь урагш сунгуул. Тэдний иддэг байж болох янз бүрийн хоолны нэрсийг хэл. Тухайн хоолыг Есүс иддэг байсан гэж бодож байгаа бол гарынхаа алгыг дээш нь харуул, хэрэв тэд тухайн хоол хүнсийг тэр иддэггүй байсан гэж бодож байгаа бол гарынхаа алгыг доош нь харуул гэж хүүхдүүдэд хэл. Талх, загас, хурганы мах, зөгийн бал, усан үзэм, инжрийн жимс, дал модны жимс, сүү гэхчлэн Есүсийн иддэг байсан байж болох аливаа хоол хүнсийг хэлэхэд анхаар.

Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Та нарын бага нас Есүсийн бага наснаас ямар ялгаатай гэж та нар боддог вэ? • Та нарын бага нас Есүсийн бага наснаас юугаараа адил төстэй гэж та нар боддог вэ?
	<p>Есүсийн хөвгүүн байхдаа хийдэг байсан байж болох ямар зүйлүүдийг хүүхдүүд хийдэг тухай тэднээр яриул. Жишээ нь, тэд зараалаар юманд яваад ирэх, эцэг эхдээ туслах, сургуульд явах, бага насны хүүхэд асрах, дуу дуулах, тоглоом тоглох, уралдах эсвэл морь унах зэргийг хийдэг байж болно. Эдгээр болон адил төстэй зүйлүүдийг Есүс хийдэг байсан байж магадгүй гэдгийг санал болго (жишээ нь, Есүс морь унаж огт үзээгүй байх, харин тэр илжиг унаж байсан нь гарцаагүй).</p>
Зураг дээр ярилцах нь	<p>Есүс Судруудыг Судалдаг Байжээ</p> <p>Библийн Сургууль, зураг 2-12-ыг үзүүл. Назарын бага насны хөвгүүд синагог буюу сүм дээр сургуульд явдаг байсныг тайлбарла. Сургуулийн багш нь тосгоны синагогийн тэргүүн байдаг байжээ. Түүнийг рабби гэдэг байв. Хүүхдүүдээр хамтад нь <i>рабби</i> гэж хэлүүл.</p> <p>Есүс гэртээ заалгахын хажуугаар үүн шиг сургуульд явдаг байсан байж болохыг тайлбарла.</p> <ul style="list-style-type: none"> • Энэ сургууль танай сургуулиас ямар ялгаатай вэ? (Хариултууд нь хөвгүүдийн хувцасладаг байдал, хаана суудаг болон бичдэг самбар зэргийг оруулсан байж болно.) <p>Тэр үед бяцхан охид сургуульд явдаггүй байсныг тайлбарла. Тэдэнд ээжүүд нь гэртээ заадаг байжээ.</p>
Хуйлмал бичиг үзүүлэх нь	<p>Сургуульд ямар ч ном байдаггүй байсныг анхааруулан хэл. Есүсийн үед хөвгүүд хуйлмал бичгээс уншиж сурдаг байжээ. <i>Хуйлмал бичиг</i> гэдэг үгийг хүүхдүүдээр давтан хэлүүл.</p> <p>Өөрийн хийсэн хуйлмал бичгийг хүүхдүүдэд үзүүл. Хуйлмал бичиг бол дээр нь юм бичсэн, хоёр үзүүрийг нь савханд бэхэлсэн урт туузан цаас юм. Нэг үзүүрийг нь хуйлаагүй, нөгөөг нь хуйлсан байхад хуудас цаасны хэмжээтэй хэсэг нь харагддаг байна. Тэгээд хичээлийн сүүл хэсэг хүртэл хуйлмал бичгийг хойш нь тавь.</p>
Багшийн танилцуулга	<p>Сургуульд хөвгүүдийн судалдаг байсан хуйлмал бичгүүд нь Есүс Христийг төрөхөөс өмнө амьдарч байсан бошиглогчдын заадаг зүйлүүдийг агуулдаг байсныг тайлбарла. Библийн нэг хэсэг нь Хуучин Гэрээ гэдгийг үзүүл. Библийн энэ хэсэг нь эдгээр хуйлмал бичгүүдийн зарим хэсэг дээрх бичээсүүд болон түүхүүдийг агуулдагийг хүүхдүүдэд хэл.</p> <p>Зураг дээрх раббийн барьж байгаа хуйлмал бичиг болон түүний хажуудах хайрцган доторх хуйлмал бичгүүдийг нэг хүүхдээр заалга. Эдгээр хуйлмал бичгүүдээс хөвгүүд уншиж, бичиж сурдаг байсныг тайлбарла. Үүнийг бид Библиэс бичиж, уншиж сурдагтай харьцуулж болох юм.</p>
Судрын түүх	<p>Есүс Хөвгүүн Ариун Сүмд Байгаа нь, зураг 2-13-ыг үзүүлж, Лук 2:41–50 дахь түүхийг ярьж өг.</p> <p>Мари, Иосеф хоёр аяллынхаа эхний өдрийн төгсгөлд Есүсийг хаанаас ч хайгаад олоогүйдээ сэтгэл нь ихэд зовж, айсныг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэд Иерусалим уруу яаралтай эргэж ирэн эцэст нь түүнийг олох хүртэл гурван өдөр хайжээ.</p>

- Мари, Иосеф хоёр Есүсийг хаанаас олсон бэ?
- Ариун сүм дотор Есүс юу хийж байсан бэ? (Лук 2:46-г үз.)

Судруудыг агуу хичээл зүтгэлээр судалдаг байсан хүмүүстэй Есүс ярилцаж байсныг тайлбарла. Есүс ийм их юм мэдэж байсанд тэр хүмүүс гайхжээ. Лук 2:47-г чанга унш. *Гайхлыг төрүүлэх* гэдэг нь гайхах гэсэн утгатайг тайлбарла.

Бид Есүс Христтэй Улам Адилхан Болж Чадна

Ярилцлага

Есүс Мари, Иосеф хоёртой хамт Назарт эргэж ирэн тэнд өссөнийг тайлбарла. Өөрийн хийсэн хуйлмал бичгийг дээш нь өргөж, үүнээс Лук 2:52-ыг унш. *Өссөөр байсан* гэдэг нь том болсоор байсан гэсэн утгатайг тайлбарла.

- Есүс мэргэн ухаанд өсч байлаа гэж энэ сударт өгүүлсэн нь юу гэсэн үг вэ?

Хүүхдүүд зөвийг сонгож сурч байгаа учраас тэдний хүн нэг бүр ч бас мэргэн ухаанд өсч байгаа гэдгийг тэдэнд тайлбарла. Тэд хэдхэн сарын өмнө байснаасаа одоо хэрхэн илүү ухаалаг болсон тухай хэдэн жишээ гарга.

- Есүс “Бурханы таалалд нийцэж” өссөн гэж өгүүлсэн уг шүлгийн сүүлчийн хэсэг ямар утгатай вэ? (Тэнгэрлэг Эцэг түүгээр хийлгэхийг хүссэн зүйлийг Есүс үргэлж хийж байсан учраас Тэнгэрлэг Эцэг баяртай байлаа.)
- Та нар яаж Тэнгэрлэг Эцэгийн таалалд өсч чадах вэ?

Бид Есүс Христтэй улам адилхан болсон үед Тэнгэрлэг Эцэг баярладгийг тайлбарла. Есүс үргэлж зөвийг сонгодог байв.

- Бусдын шоолдог хүүхдэд Есүс хэрхэн хандах байсан гэж та нар бодож байна?

“Бусдын шоолдог хүүхдэд би хэрхэн ханддаг вэ?” гэсэн асуултыг хүүхдүүдээр өөрсдөөс нь асуулга.

- Залуу Есүсийг тоглож байхад ээж нь эсвэл Иосеф ямар нэг юм хийхийг түүнээс хүсэхэд тэр яасан гэж та нар боддог вэ?

“Хэрэв намайг тоглож байхад ээж юм уу аав ямар нэг юм хийхийг надаас хүсвэл би яах вэ?” гэсэн асуултыг хүүхдүүдээр өөрсдөөс нь асуулга.

Есүс яагаад бусад хүмүүсийн “тааллыг олсныг” тайлбарла (Лук 2:52-ыг үз). Тэд түүний эргэн тойронд байх дуртай байв.

- Есүсийг хөвгүүн байх үед нь түүнийг өөрийнхөө найз байхад чи дуртай байх байсан уу?

ЗС уриа

ЗС уриаг үзүүлж, түүн дээрх: “Би зөвийг сонгох болно” гэсэн үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Хүүхдүүд зөвийг сонгосон үедээ Есүс Христтэй улам адилхан болдгийг тэдэнд сануул.

Дүгнэлт

Дуу

“Нэгэн Цагт Есүс Бяцхан Хүүхэд Байсан” дууны хоёр бадгийг хүүхдүүдтэй хамт дуул, эсвэл үгийг нь хэл. Хүүхдүүдийн мэдэхгүй аливаа үгсийг тайлбарла. Жишээ нь, *ундууцах* гэдэг нь уцаарлах гэсэн утгатай. Юмс түүнийг хээр болоогүй бол Есүс уцаарладаггүй байлаа.

Нэгэн цагт Есүс бяцхан хүүхэд байв
Нээрээ над шиг л бяцхан хүүхэд байв;
Мөн цэвэр, номхон, дөлгөөн байв тэр,
Бяцхан хүүхэд ямар байх ёстой тийм л байв.

Тэгэхээр, бяцхан хүүхдүүд ээ,
Чи, би тэгээд бүгд
Түүнтэй адил байхыг хичээцгээе,
Хичээ, хичээ, хичээ.

Бяцхан хүүхдүүд шиг тэр тоглодог байв
Баяр хөөртэй өсвөр насныхны тоглоомоор;
Тоглоом буруудлаа ч, хэзээ ч тэр уцаарладаггүй байв
Тэгээд тэр үргэлж үнэнийг ярьдаг байв.
Тэгэхээр, бяцхан хүүхдүүд ээ,
Чи, би тэгээд бүгд
Түүнтэй адил байхыг хичээцгээе,
Хичээ, хичээ, хичээ.

Гэрчлэл

Зөвийг сонгох болон Есүс Христтэй адилхан болох нь биднийг аз жаргалтай болгох болно гэдгийг гэрчил. Есүс Христийн амьдрал биднийг хэрхэн амьдарвал зохихын үлгэр жишээ болж байдагт та ямар их талархалтай байдгаа хүүхдүүдэд ярь.

Есүсийн бага нас зарим талаар тэдний бага настай их адилхан байсан нь дамжиггүй гэдгийг хүүхдүүдэд хэл. Есүсийн нэгэн адилаар үргэлж зөвийг сонгоход нь тэднийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхэд бүрийн өндрийг уяа буюу нэхмэлийн утсаар хэмж. Хүүхэд бүрийн өндөрт тохируулан уяа буюу утсыг тайрч, үүнийг хүүхдэд хадгалуул. Тэдний бие өсч томрохын хэрээр тэд Бурханы таалалд нийцэх бас хэрэгтэйг хүүхдүүдэд сануул. Тэд Есүс Христийн нэгэн адил сайн сонголтууд хийснээр үүнийг хийж чадна.
2. Лук 2:52-ыг хэдэн удаа өөртэйгөө хамт давтан хэлэхэд нь хүүхдүүдэд тусал. Тэнгэрлэг Эцэгийн таалалд нийцэж өсөх боломжийг тэдэнд олгож болох онцгой сонголтуудын тухай ярилц.
3. Инжрийн жимс, усан үзэм, дал модны жимс, бяслаг, талх, самар буюу чидун жимснүүд зэрэг Есүс Христийн иддэг байсан байж болох хүнсний зүйлүүдийг авчирч, хүүхдүүдэд амсуул. Өөрийнхөө авчрах хүнсний зүйлүүдэд хүүхдүүдийг харшилгүй эсэхийг нь хүүхдүүдийн эцэг эхчүүдээс урьдчилан лавла. (Хэрэв та энэ хичээлийг мацгийн Ням гарагт зааж байгаа бол хүнсний зүйл бүү авчир.)
4. Нялх хүүхдүүдийн хийж чадах зүйлүүдийн тухай ярилцаж, тэдгээрийг хүүхдүүдийн одоо хийж чадах зүйлүүдтэй харьцуул. Дараах асуултуудыг асуу:

- Нялх хүүхэд явж чадах уу? Чи явж чадах уу?
- Нялх хүүхэд ярьж чадах уу? Чи ярьж чадах уу?

Хүүхдүүд өсөхийн хэрээр, зөвийг сонгосноор Аврагчтай илүү адилхан болох тэдний чадвар өсдөгийг тайлбарла.

5. Хүүхэд бүрт хэсэг давстай зуурсан гурил өгч (жорыг доор үз), жижигхэн аяга, ваар буюу Есүс Христийн хөвгүүн байхдаа ашиглаж байсан байж болох бусад зүйлүүдийг хүүхдүүдээр хийлгэ.

Давстай зуурсан гурил

Шаардлагатай материалууд:

2 аяга гурил

1 аяга давс

1 халбага тос

Ус

Хүнсний будаг (сонголтоор)

Заавар: Давс, гурилыг холь. Шавар шиг найрлагатай зуурмаг гаргаж авахын тулд тос, хангалттай ус нэмж хий. Зуурмагийг наалдамхай биш, овоолж болохоор болтол нь жаахан, жаахнаар ус нэмж хий. Хөнгөвтөр нух. Хэрэв та зуурмагийг өнгөтэй болгоё гэвэл, давс, гуриланд ус нэмэхээс өмнө усанд хүнсний будгийг нэмж хий. Сийрэг агаартай саванд зуурмагийг хадгал.

Би Залбирлаар Тэнгэрлэг Эцэгтэй Ярьж Чадна

Зорилго

Хүндэтгэлтэйгээр залбирах байдлаар тэд Тэнгэрлэг Эцэгт илүү ойр дотно өсч чадна гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах.

Бэлтгэл

1. Матай 6:9, 3 Нифай 18:19–20-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 8-ыг үз.

2. Цаасан туузан дээр бичсэн үгсийг бэлтгэ:

Чи

Та

3. Дараахтай адил асуултуудыг тус, тусдаа цаасан дээр бич. Ангийнхаа хүүхэд бүрт доод тал нь нэг асуулт тавь (хэрэв танай анги цөөхөн хүүхэдтэй бол та хүүхэд бүрт доод тал нь хоёр асуулт тавьж болно).

а. Хэрэв танай гэр бүлд хэн нэгэн чинь хэсэг хугацаагаар гэрээсээ явах болвол та нар залбирлууддаа Тэнгэрлэг Эцэгээс юу хүсч болох вэ?

б. Хэрэв бидэнд зөвийг сонгох тухай хичээл заагдсан бол бид ангийн залбиралдаа Тэнгэрлэг Эцэгээс юу хүсч болох вэ?

в. Хэрэв эелдэг найрсаг байх тухай хичээл бидэнд заагдсан бол бид анги дахь залбиралдаа Тэнгэрлэг Эцэгээс юу хүсч болох вэ?

г. Хэрэв найз чинь өвдөж, тэгээд гадаа гарч тоглож чадахгүй байгаа бол та нар залбирлууддаа Тэнгэрлэг Эцэгээс юу хүсч болох вэ?

д. Бид өглөө, орой бүрийнхээ залбирлууддаа юу хүсч болох вэ?

е. Бид Хүүхдийн хэсгийн хичээл дээр залбирахдаа хүүхдүүдийн төлөө юу хүсч болох вэ?

4. “Залбирлын Дуу” (*Children’s Songbook*, х. 22) дуулахад буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.

5. Шаардлагатай материалууд:

а. Библи, Мормоны Ном.

б. Зураг 2-14, Ангийн Залбирал (62200); зураг 2-15, Бригам Янг; зураг 2-16, Хибер Ж.Грант Хүүхэд Байхдаа.

6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урихын өмнө Ангийн Залбирал, зураг 2-14-ыг үзүүлж, “Залбирлын Дуу” дууг хүндэтгэлтэйгээр дуулах буюу үгийг нь хэл.

Бид өнөөдөр залбиралд тэргүүнээ бөхийлгөв,
Бид гараа цээжиндээ авав,
Тэгээд залбирахдаа нүдээ анив бид
Тэнгэрлэг Эцэгтэй ярив бид.

- Ангид хэн нэгнийг залбирал хэлж байхад үлдсэн бид яах ёстой вэ?

“Залбирлын Дуу” дууг дахин дуул. Энэ дууны үгсийн хүүхдүүдэд хий гэж хэлсэн зүйлүүдийг хийх байдлаар тэднийг залбиралд бэлэн болго.

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Бид Залбирахын Өмнө Бэлэн Болдог

Ярилцлага

- Энэ дуу биднийг залбиралд бэлэн болохын тулд юу хий гэж хэлсэн бэ?
- Бид залбирахдаа яагаад толгойгоо бөхийлгөдөг вэ?

Бид залбирахдаа толгойгоо бөхийлгөдөг нь бид Тэнгэрлэг Эцэгийг хайрладаг, хүндлэн дээдэлж, мөн хүндэтгэдэг гэдгийг түүнд харуулдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэнгэрлэг Эцэг бол ямар ч хаан, ерөнхийлөгч буюу дэлхий дээрх ямар ч хүнээс илүү агуу, илүү хүчтэй бөгөөд тэрээр бидний төлөө олон зүйлийг хийсэн билээ. Бид түүнийг хайрладаг, бас түүнийг хүндэтгэдгээ харуулах ёстой.

- Бид залбирахдаа яагаад гараа цээжиндээ авдаг вэ?

Залбирлын үед гараа хөдөлгөх нь хүмүүсийн анхаарлыг залбирлыг сонсохоос сарниулж болно гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

- Бид залбирахдаа яагаад нүдээ аньдаг вэ?

Хүүхдүүдийг хариултын тухай бодож байх үед та тэдний нүдийг аниулж болно.

Хүүхдүүд нүдээ аньсан үед өөрсдийнх нь эргэн тойрон дахь зүйлүүд анхаарлыг чинь сарниулах нь бага байдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэд Тэнгэрлэг Эцэгийн тухай, мөн түүнд өөрсдийн хэлж байгаа зүйлүүдийн талаар бодож болно.

Бид Залбирч Байхдаа Тэнгэрлэг Эцэгтэй Ойр Байгаагаа Мэдэрч Чадна

Багшийн танилцуулга

Толгойгоо бөхийлгөж, гараа цээжиндээ авч, нүдээ аньснаар бид анхаарлаа эргэн тойрондоо байгаа юмст биш, харин залбиралдаа анхааруулж чадна гэдгийг тайлбарла. Бид тайван мэдрэмжтэй байж, Тэнгэрлэг Эцэгт ойр байгаагаа мэдэрч чадна. Бид түүнтэй ярихад бэлэн байна.

Түүх

Бригам Янг, зураг 2-15, Хибер Ж.Грант Хүүхэд Байхдаа, зураг 2-16-г үзүүлж, залбирлын үед Тэнгэрлэг Эцэгтэй ойр байснаа мэдэрсэн жаал хүүгийн тухай дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Олон жилийн өмнө Бригам Янг бошиглогч бөгөөд Сүмийн Ерөнхийлөгч байлаа. Хибер Ж.Грант гэдэг нэртэй, зургаа орчим настай нэг хөвгүүн Ерөнхийлөгч Янгийн бага хөвгүүдийн нэгэнтэй хамт тоглодог байв. Гэр бүлийг хамтад нь залбиралд дуудах цаг болоход Хибер Ерөнхийлөгч Янгийн гэрт тоглож байх нь олонтаа тохиолддог байжээ. Хибер тэдний гэр бүлтэй хамт өвдөг сөгдөн, гараа цээжиндээ авч, толгойгоо бөхийлгөн, нүдээ аньж, Ерөнхийлөгч Янгийн залбирахыг сонсдог байв. Тэнгэрлэг Эцэгтэй Ерөнхийлөгч Янгийн ярьдаг арга хэлбэрийн улмаас Тэнгэрлэг Эцэг тэр үед өрөөнд байгаа юм шиг Хиберт санагддаг байжээ. Тэр ч байтугай заримдаа Хибер Тэнгэрлэг Эцэг тэнд байгаа эсэхийг харахын тулд нүдээ

нээж хардаг байсан аж. Мэдээж хэрэг, тэр зөвхөн Ерөнхийлөгч Янг болон гэр бүлийг нь л хардаг байв. Гэвч Тэнгэрлэг Эцэг Ерөнхийлөгч Янгтай хамт түүнийг сонсон, түүний хүссэн тусламж болоод удирдамжийг түүнд өгч байгаа гэдэгт бат итгэсэн хэвээр байлаа.

Хибер том болсон хойноо Төлөөлөгч, дараа нь Сүмийн Ерөнхийлөгч болсон юм. (Heber J. Grant, *Gospel Standards*, эмхтгэл. G. Homer Durham [Salt Lake City: *Improvement Era*, 1941], х. 223–24-ийг үз.)

Хибер Ж.Грантын нэгэн адил, залбирлын үед та Тэнгэрлэг Эцэгтэй ойр байгаагаа мэдэрч байсан өөрийнхөө туршлагыг хуваалцаж болно.

Биднийг залбирч байхад Тэнгэрлэг Эцэг биднийг үргэлж сонсож байдаг гэдгийг хүүхдүүдэд сануул. Бид залбирч байхдаа толгойгоо бөхийлгөж, гараа цээжиндээ авч, нүдээ аних нь Тэнгэрлэг Эцэгийг бидэнд ойр байгааг мэдрэхэд бидэнд тусалж чадна.

Бид Залбирч Байхдаа Хүндэтгэлтэйгээр Ярьдаг

Судрын
ярилцлага

Бид залбирлуудаа түүнтэй ярих арга хэлбэрээр Тэнгэрлэг Эцэгийг хайрлах хайр, хүндэтгэлийг бас харуулдгийг тайлбарла.

- Та нар хэн нэгэнтэй ярихыг хүссэн үедээ түүний анхаарлыг татахын тулд хэлэх анхны үг чинь юу вэ? (Тэр хүний нэр.)
- Та нарын Тэнгэрлэг Эцэгтэй ярихыг хүссэн үедээ хэлэх анхны зүйл чинь юу вэ?

Залбиралд бидний хэлэх анхны зүйл бол Тэнгэрлэг Эцэгийн нэр гэдгийг тайлбарла. Есүс дэлхий дээр байхдаа үүнийг хийхийг бидэнд заадаг байсныг хүүхдүүдэд ярь. Матай 6:9-ийг чанга уншиж, “Тэнгэрт байдаг бидний Эцэг” гэхийг “Тэнгэр дэх Бидний Эцэг” буюу “Тэнгэрлэг Эцэг” гэж бид ихэвчлэн товчилж хэлдгийг тайлбарла.

Залбирлуудаа хэрхэн төгсгөхийг Есүс бас бидэнд хэлж өгснийг хүүхдүүдэд хэл. 3 Нифай 18:19-ийг чанга унш.

- Залбирлуудаа яаж төгсгө гэж Есүс бидэнд хэлсэн бэ? (Түүний нэрээр. Бид залбирлуудаа *Есүс Христийн нэрээр, амен* гэж төгсгөдөг)
- Биднийг ангийн буюу гэр бүлийн залбирал хийж байхад залбирал хийж байгаа хүн “амен” гэж хэлэхэд бид яах ёстой вэ?

Хэсэг бүлгийн залбирлын төгсгөлд бид “амен” гэж хэлдэг нь залбиралд уг хүний хэлсэнтэй бид санал нэг байна гэсэн утгатай юм. Залбирал хэлсэн хүнтэй бид хамт залбирсан гэсэн үг юм.

Цаасан туузан
дээр бичсэн
үгсийг ярилцах нь

Бид Тэнгэрлэг Эцэгт хандан ярих үедээ, “Бид чамд талархаж байна” гэх буюу “бид чамаас гуйж байна” гэхчлэн чи гэж хэлдэггүйг тэд анзаарсан эсэхийг хүүхдүүдээс асуу.

“Чи” гэсэн үг бичсэн туузан цаасыг үзүүл.

- *Чи* гэдэг үгийн оронд бид ямар үг хэрэглэдэг вэ? (*Та*)

“Чи” гэдэг үгийг “Та” гэдэг үгээр тагла. “Бид Танд талархаж байна,” “Бид Танаас гуйж байна” гэсэн өгүүлбэрүүдийг хүүхдүүдээр хүндэтгэлтэйгээр давтан хэлүүл

- Бид яагаад *чи* гэхийн оронд *та* гэж хэлдэг вэ? (Энэ бол бид Тэнгэрлэг Эцэгийг дээдлэн хүндэлж, бас хүндэтгэдгийг харуулах өөр нэг арга зам мөн.)

Бид Өөрсдийнхөө Адислалуудын Төлөө Тэнгэрлэг Эцэгт Талархахаар Залбирдаг

Тоглоом

Бид яагаад залбирдаг тухайд нэн чухал хоёр шалтгаан байдгийг хүүхдүүдэд хэл. Залбирлын эхний чухал шалтгааныг олж мэдэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд, тэднийг хоёр багт хуваа. Баг бүрээс ээлжлэн, тэдний төлөө Тэнгэрлэг Эцэгийн хийсэн ямар нэг юмыг хүүхдүүдээр нэрлүүл. Тэд өмнө нь нэрлээгүй зүйлийг ээлж бүртээ хэлэх ёстой. Хэрэв баг тэр даруйд хариулж чадахгүй бол ээлж нөгөө багт шилжинэ. Тоглоомыг тодорхой хэдэн минутад, эсвэл багуудын аль аль нь өмнө нь нэрлэгдээгүй ямар нэг зүйлийг бодож олж чадахгүй болох хүртэл үргэлжлүүл.

Хэрэв хүүхдүүд дараах боломжтой хариултуудыг өгөөгүй бол одоо тэдгээрийг хэл:

- Тэнгэрлэг Эцэг бидний амьдралыг бидэнд өгсөн.
- Тэрээр бидэнд гэр бүлүүдийг маань өгсөн.
- Тэрээр бидэнд дэлхийг өгсөн.
- Тэрээр бидэнд туслахын тулд Есүс Христийг дэлхийд илгээсэн.
- Тэрээр бидний залбирлуудад хамгийн шилдэг арга замаар хариулахыг амласан билээ.

Ярилцлага

Дараах асуултуудыг хүүхдүүдтэй хамт ярилц:

- Хэн нэгэн нь чамд бэлэг өгөх, эсвэл чамайг хайрлаж, эелдэг найрсаг байвал чи юу гэж хэлэх ёстой вэ?
- Өөр бусад хэнээс ч илүү их бэлгийг хэн бидэнд өгсөн бэ? (Тэнгэрлэг Эцэг.)
- Залбирлын эхний шалтгаан юу вэ? (Бидэнд өгдөг олон адислалуудынх нь төлөө Тэнгэрлэг Эцэгтээ талархах.)

Бид өөрсдийн эцэг эх, гэр бүлийн гишүүд эсвэл найз нартаа бидний төлөө хийсэн зүйлүүдэд нь талархдаг шиг, мөн бидний төлөө түүний хийсэн зүйлүүдэд Тэнгэрлэг Эцэгт талархах ёстойг онцлон хэл. Биднийг түүнд талархахад Тэнгэрлэг Эцэг баяртай байдаг.

Тэнгэрлэг Эцэгээс Тусламж Гуйхын Тулд Бид Залбирдаг

Түүх

Бидний залбирлын хоёр дахь шалтгааныг олж мэдэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд Стефений тухай дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Стефен эцэг эхийнхээ хамт саяхан нэг шинэ хотхонд шилжиж иржээ. Сургуульдаа ирсэн анхны өдөр ангидаа нэг ч хүүхдийг танихгүй байв. Стефенд аймаар санагдаж байжээ. Түүнд гэр лүүгээ яваад өгмөөр санагдсан аж. Түүний уйлж байгааг хэн ч харахыг тэр хүсээгүй учраас тэр толгойгоороо ширээн дээр дэрлэн доош харсан байлаа.

Стефен толгойгоороо ширээн дээр дэрлэн доош харсныг удалгүй багш нь ажиглажээ. Багш нь түүнийг өвдсөн юм болов уу гэж бодоод, түүнтэй ярилцахаар дэргэд нь очсон аж. Стефен сургууль дээр уйлснаасаа ичиж, уйлахаа болих гэж оролдов. Гэвч тэрээр гэмшиж байсан учраас больж чадсангүй.

Өөр хэн ч сонсохооргүй намуухнаар, “Тэнгэрлэг Эцэг минь ээ, уйлахаа болиход минь Та надад туслаач” хэмээн тэр залбирчээ.

Стефен удалгүй уйлахаа болив. Одоо түүний сэтгэл уужирч сайхан боллоо гэж тэр багшдаа хэлжээ, тэр өдөр түүний хувьд баяртай өдөр байлаа.

Ярилцлага

- Сэтгэл санаа нь сайхан болоход Стефенд юу тусалсан бэ?
- Та нарын залбирлууд та нарт хэрхэн тусалж байсан бэ?

Үйл ажиллагаа

Бидний залбирдаг хоёр дахь шалтгаан бол Тэнгэрлэг Эцэгээс тусламж хүсэх явдал гэдгийг тайлбарла. Хүүхдүүд өөрсдийнхөө залбиралд тусламж хүсч болох зарим тодорхой арга замыг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд асуулт бичсэн цаасуудыг ширээн дээр буюу шалан дээр дэлгэн тавь. Асуулт бүрийг уншиж, сонгож авсан хүүхдээр хариулт өгүүл.

Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг хүлээн авахын тулд бид зөвийг сонгохыг ихэд чармайх ёстойг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Хэрэв бид тусламж хүсч залбиран Тэнгэрлэг Эцэгийн бидний хувьд хамгийн сайн болохыг мэддэг тэр зүйлийг хүсвэл тэрээр бидний залбирсан тэр зүйлийг бидэнд өгөх болно (3 Нифай 18:20-ийг үз).

Дүгнэлт

Ярилцлага

- Өнөөдөр бид хаалтын залбиралдаа Тэнгэрлэг Эцэгт юуны төлөө талархал илэрхийлж болох вэ? (Хариултууд нь Хүүхдийн Хэсэгт ирж, залбирлын тухай илүү олон зүйл мэдэж авах боломж байж болно.)
- Бид залбиралдаа Тэнгэрлэг Эцэгээс юу хүсч болох вэ?

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэгтэй өдөр бүр ярих нь хичнээн чухал болох тухай гэрчлэлээ хэл. Бид өглөө, орой түүнчлэн бидэнд онцгой тусламж хэрэгтэй болсон буюу эсвэл Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлэх онцгой мэдрэмж төрсөн ямар ч үед бид залбирч болно гэдгийг хүүхдүүдэд сануул.

Энэ долоо хоногт өдөр болгон өглөө, оройд залбирахаа санахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Залбирлын өмнө, “Залбирлын Дуу” дууг аяархан дуулж, уг дууны өгүүлдэг зүйлүүдийг хийлгэх байдлаар хүүхдүүдийг залбиралд бэлэн болго. Ганцхан хүн залбирч үг хэлж байлаа ч гэсэн өрөөнд байгаа хүн болгоныг Тэнгэрлэг Эцэг сонсож байгаа гэдгийг тэдэнд сануул. Залбирлын төгсгөлд бүх хүүхэд “амен” гэж хэлэх ёстойг сануул.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хичээлийн төгсгөлд байгаа “Би Хүндэтгэлтэйгээр Залбирах Болно” гэсэн гарчигтай тарааж өгөх материалын хувь, эсвэл хуулбарыг хүүхэд бүрт өг. Хүүхдүүдэд будгийн харандаа өгч, зургуудыг тэднээр будуул. Зургуудыг гэр бүлийн гишүүддээ үзүүлж, залбирлын тухай өнөөдөр юу сурснаа тэдэнд ярихад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.
2. “Бид Толгойгоо Бөхийлгөдөг” (*Children’s Songbook*, х. 25) дууны эхний бадгийг үйлдлүүдийг хийнгээ дуулах буюу эсвэл үгийг нь хэлэхэд хүүхдүүдэд тусал:

Бид толгойгоо бөхийлгөн (*толгойгоо бөхийлгөнө*), нүдээ аньж (*нүдээ анина*)
 Бяцхан залбирал хэлдэг (*гараа цээжиндээ авна*).
 Бид бүгдийн хуваалцдаг адислалын төлөө (*гараа дэлгэнэ*)
 Бид Эцэгтээ ялдамхнаар талархдаг.

3. Залбирах үедээ тэдний хэлэх ёстой зүйлүүдийг хүүхдүүдэд сануулахын тулд “Би Итгэлтэйгээр Залбирдаг” (*Children’s Songbook*, х. 14) дууны хоёрдугаар бадгийг дуулах буюу үгийг нь хэл.

“Хайрт Тэнгэрлэг Эцэг минь” гэж эхэлдэг би;
 Илгээдэг адислалуудад нь талархдаг би;
 Тэгээд хэрэгтэй байгаа зүйлээ даруухнаар хүсдэг би,
 Есүс Христийн нэрээр, Амен.

(© 1987 by Janice Carr Perry. Зөвшөөрлөөр ашиглав.)

4. Хүүхдүүдэд цаас, будгийн харандаа буюу балын харандаа өгч, өөрсдийнх нь залбирч байгаа зургийг тэднээр зуруул. Тэд гэр бүлийн залбирал, өглөө, оройн хувийн залбирал, хоолны үеэр хийх залбирал, эсвэл өөр газар, өөр үед тэд залбирч байгаа зургуудыг зурж болно.

Би Хүндэтгэлтэйгээр
Залбирах Болно



Би Есүс Христийн Тухай Бусдад Ярьж Чадна

Хичээл
11

Зорилго Хүүхдүүдийг бусдад Есүс Христийн тухай мэдэхэд нь туслахад тэдэнд сүнслэгээр нөлөөлөх.

Бэлтгэл

1. Алма 17–19, 23-ыг залбиралтайгаар судал.
2. “Тэд Намайг Номлолд Дуудна Гэж Би Найдна” (*Children’s Songbook*, х. 169) дууг дуулах буюу үгийг хэлэхэд бэлтгэ
3. Шаардлагатай материалууд:
 - а. Мормоны Ном.
 - б. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - в. Зураг 2-17, Мозаягийн Дөрвөн Хөвгүүн Залбиралд Өвдөг Сөгдсөн Байгаа нь, зураг 2-18, Хаан Лэмонайд Аммон Зааж Байгаа нь.
4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Нэгтгэн дүгнэлт Залбиралд хэрэглэсэн хэл яриа, эсвэл хүүхдүүдийн хүндэтгэлтэй хандаж байгаа байдалд тайлбар өг. Залбирлын ач холбогдлыг онцлон хэлэхийн тулд өмнөх хичээлийг түргэн нэгтгэн дүгнэ.

Номлогч Нар Бусдад Есүс Христийн Тухай Ярьдаг

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа “Тэд Намайг Номлолд Дуудна Гэж Би Найдна” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Намайг нэг, хоёр тохой өсөхөд
Номлолд тэд намайг дуудна гэж найдна.
Заах, номлох, номлогч нарын адил ажиллахад
Тэгэхэд би бэлэн байна гэдэгт найдна.

Үнэнийг мэдэхийг хүсдэг хүмүүстэй
Сайн мэдээг хуваалцаж чадна гэдэгтээ би итгэнэ.
Номлогч болохыг хүснэ би
Насны залууд Их Эзэнд үйлчилж тусална би.

- Та нар аль нэгэн номлогчийг таньдаг уу?

Номлолд үйлчилж байгаа гэр бүлийнхээ гишүүд, эсвэл өөрийнхөө бүс дэх номлогч нар гэхчлэн таньдаг номлогч нарынх нь тухай хүүхдүүдээр яриул.

- Номлогч нар юу хийдэг вэ?

Тэд залуу байх үедээ номлогч нар болох арга замуудын тухай энэ хичээлд мэдэх болно гэдгийг тайлбарла.

Судрын түүх Мормоны Номыг хүүхдүүдэд үзүүлж, Алма 17:6–12-т байдаг Мозаягийн хөвгүүдийн тухай түүхийг ярь. Хаан Мозаягийн хөвгүүдийн аль нэг нь дараачийн хаан болж болох байсан хэдий ч ингэхийн оронд тэд номлогч нар болохыг хүссэн ажээ. Тэд тэр үед нэн ёс бус байсан Лэмэнчүүдэд номлохыг хүсчээ. Мозаягийн хөвгүүд хүн бүрийг сайн мэдээг сонсох боломжтой байхыг хүсчээ. Лэмэнчүүд нэн их ёс бус байсан учраас тэдэнд заахаар очих нь Мозаягийн хөвгүүдэд аюултай байлаа.

- Лэмэнчүүдэд номлохоор явахаасаа өмнө Мозаягийн хөвгүүд өөрсдийгөө хэрхэн бэлтгэсэн гэж та нар бодож байна?

Мозаягийн Дөрвөн Хөвгүүн Залбиралд Өвдөг Сөгдсөн Байгаа нь, зураг 2-17-г үзүүл.

Мозаягийн хөвгүүд залбирч, сайн номлогч нар байхад нь тэдэнд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс хүссэнийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг тэднийг харж хандаж байх учраас тэд олон хүмүүст заах болно гэж тэдэнд хэлжээ (Алма 17:10–11-ийг үз). Алма 17:12-ыг чанга унш. Залбирсан нь Лэмэнчүүд рүү очиж заах зоригийг Мозаягийн хөвгүүдэд өгөхөд тусалсныг онцлон хэл.

Судрын түүх Мозаягийн хөвгүүд бүгдээрээ өөр, өөр бүсүүдэд заахаар явсныг тайлбарла. Хаан Лэмонайд Зааж Байгаа нь, зураг 2-18-ыг үзүүлж, Алма 17:17–25 дахь түүхийг ярь. Мозаягийн хөвгүүдийн нэг Аммон, Лэмэнчүүдийн Хаан Лэмонайн зарц байхаар сайн дураараа санал гаргажээ. Аммон хааны хонь хариулах ажил үүрэгтэй болсон. Аммон, Хаан Лэмонайн хамгийн сайн зарц байв. Хаан Лэмонай болон түүний хүмүүс сайн мэдээний тухай мэдэхийг хүсэхээр болтол Аммон тийм сайн үлгэр жишээ үзүүлжээ.

Аммон болон түүний ах нарын ажлын улмаас мянга мянган Лэмэнчүүд Сүмд нэгдсэн гэдгийг тайлбарла (Алма 23:5-ыг үз).

Ярилцлага

- Яагаад Аммон болон түүний ах нар Лэмэнчүүдэд сайн мэдээг заахаар амь насаараа дэнчин тавьсан бэ? (Сайн мэдээ тэдэнд аз жаргал авчирсан учраас тэд үүнийг бусад хүмүүстэй хуваалцахыг хүсчээ.)
- Лэмэнчүүдэд сайн мэдээг заахад тус болсон ямар зүйлийг Аммон хийсэн бэ? (Тэрээр тусламжийн төлөө залбирчээ; тэр шаргуу ажиллаж байв, тэр сайн үлгэр дуурайл болж байв.)

Бид Номлогч Болж Чадна

Есүс Христийн тухай бусдад ярих нь бидний номлогч болж чадах нэг арга зам гэдгийг тайлбарла. Хүн бүр Есүс Христ болон түүний сүмийн тухай мэдэх нь чухал юм.

Түүх Есүс Христ болон түүний сүмийн тухай бусад хүмүүсийг мэдэхэд нь тусалсан нэг хүүхдийн тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:

Зарим үед гадасны чуулганд хэлж байгаа үгийг сонсох нь Тадад хэцүү байв, учир нь хэлж байгаа үгний ихэнх нь насанд хүрэгчдэд зориулсан юм шиг санагддаг байв. Гэвч гадасны ерөнхийлөгч, “Хүүхдүүд ээ, та нар ч бас номлогч байж чадна” гэж хэлэхийг Тад сонсоод, тэр анхааралтай сонсож, номлогч болох арга замуудын талаар бодож, Есүсийн тухай бусдад ярьж эхэлжээ.

Маргааш өглөө нь өглөөний хоолны үеэр, зэргэлдээ хаалганы хөрш хатагтай Мөрфиг урьж, Сүмийн тухай мэдүүлье гэж Тад эцэг эхтэйгээ ярьжээ. Энэ бол зөв санаа гэж Тадын эцэг эх үзсэн болохоор Тад хатагтай

Мөрфийн гэрт очиж, Есүс Христ болон түүний сүмийн талаар мэдэхийг тэр хүсэж байгаа эсэхийг түүнээс асуужээ. Хатагтай Мөрфи болно гэж хэлэв, ингээд удалгүй тэрээр номлогч нараас суралцаж эхэлжээ.

- Есүс болон түүний сүмийн талаар мэдэхийг хүссэн эсэхийг Тэд хатагтай Мөрфигээс асуугаагүй бол юу болох байсан бэ?

Тадын аав ээж хоёр Тадын үлгэр жишээг дагаж эхлэв. Тэд найз нар болон уулзсан бусад хүмүүст Сүмийн тухай ярьдаг болжээ. Зарим хүмүүс Сүмийн тухай сонсохыг хүсдэггүй байсан боловч зарим нь сонсож, мөн зарим хүмүүс баптисм хүртсэн ажээ. Хатагтай Мөрфи баптисм хүртэхдээ Аврагчийн тухай илүү ихийг мэдэхэд тусалсных нь төлөө Тадад талархал илэрхийлсэн байна.

Ярилцлага

Тадыг жишээ болгон ашиглаж, хүүхдүүд номлогч болж, Есүс Христ болон түүний сүмийн тухай бусдад ярьж чадна гэдгийг анхааруулан хэл.

- Есүсийн тухай та нар хэнд ярьж болох вэ?

Найз нар, хөршүүд, түүнчлэн Сүмийн гишүүн бус төрөл төрөгсөд, эсвэл сүмд явдаггүй хүмүүс гэхчлэн Есүс Христийн тухай ярьж болох хүмүүсийн талаар бодоход нь хүүхдүүдэд тусал.

Сайн үлгэр жишээ үзүүлж, бусад хүмүүст эелдэг мөн тэднийг бодож байснаар, түүнчлэн сайн мэдээний дагуу амьдарснаар бидний хүн нэг бүр номлогч байж чадна гэдгийг тайлбарла. Аммоны сайн номлогч байсан арга замуудын нэг нь сайн үлгэр жишээ үзүүлэх явдал байсныг хүүхдүүдэд сануул.

Түүх

Номлогч байсан дараах хүүхдүүдийн тухай түүхийг өөрийн үгээр ярьж өг:

Нэг өдөр хоёр номлогч нэг айлын хаалга тогшжээ. Хатагтай Жеймс гэдэг эмэгтэй хаалга онгойлгожээ. Тэд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс явна гэж номлогч нар түүнд хэлэв. Хатагтай Жеймс номлогч нарыг урьж оруулаад тэрээр Сүмийн тухай илүү ихийг мэдмээр байна гэж тэдэнд хэлжээ. Энэ нь номлогч нарыг ихэд баяртай болгосон ажээ.

Сүмд харьяалагддаг нэг гэр бүлийн зэргэлдээх хаалганд амьдардаг байснаа хатагтай Жеймс номлогч нарт ярьжээ. Тэр гэр бүлийн хүүхдүүд үргэлж туйлын эелдэг ялдамхан байсныг тэр хэлсэн аж. Тэд хүн бүртэй шударгаар тоглож, бусад хүмүүсийн өмч хөрөнгөнд хүндэтгэлтэйгээр ханддаг байжээ. Энэ хүүхдүүдийг ийм эелдэг ялдамхан хөршүүд байхыг заасан сүмийн тухай илүү ихийг мэдэхийг хүссэн гэж хатагтай Жеймс ярьсан гэнэ.

- Хатагтай Жеймсийн зэргэлдээ амьдардаг байсан хүүхдүүд яаж номлогч нар байсан бэ?
- Хөршүүд болон найз нартаа та нар хэрхэн сайн үлгэр жишээ үзүүлж болох вэ?

Жүжигчлэн тоглох үйл ажиллагаа

Хүүхдүүд эелдэг найрсаг, хэрсүү бодолтой байснаар номлогчид байж болох хэд хэдэн нөхцөлийг жүжигчлэн тоглох болно гэдгийг тэдэнд тайлбарла.

Хүүхдүүдээр нөхцөлийг сонгуулж, тэгээд тухайн нөхцөлд хийх зүйлийг жүжигчлэн тоглох хүүхдүүдийг сонгож ав. Хүүхэд бүрт доод тал нь нэг нөхцөлд оролцох боломж олго. Дараах жишээнүүдийг ашиглах, эсвэл өөрөө жишээнүүдийг зохио:

Нөхцөл 1 (гурван хүүхэд хэрэгтэй)

Та нарын хоёр нь гудамж уруудан явж байна. Та нар маш том модонд авирч эхэлж байгаа бяцхан хүүхдийг харжээ. Энэ нь тэр хүүхдийн хувьд аюултайг та нар мэдэж байв.

- Та нар яах вэ?

Нөхцөл 2 (хоёр хүүхэд хэрэгтэй)

Нэг хөрш чинь гар дүүрэн хүнсний зүйл авч явааг чи харжээ. Хүнсний зүйлтэй уутнуудын нэг нь урагдаж, жүрж газраар дүүрэн таран унажээ.

- Та нар яах вэ?

Нөхцөл 3 (гурав буюу түүнээс олон хүүхэд хэрэгтэй)

Та нар найз нартайгаа тоглож байна. Саяхан ойролцоо газар нүүж ирсэн нэг хүүхэд та нартай нэгдэхийг хүсчээ.

- Та нар яах вэ?

Нөхцөл 4 (дөрөв буюу түүнээс олон хүүхэд хэрэгтэй)

Танай хөрш хаалганд нэг шинэ айл нүүж иржээ. Тэд Сүмийн гишүүд биш. Хүүхдүүд нь дараагийн долоо хоногт Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагаанд очих дуртай байж болох юм гэж чи боджээ.

- Чи яах вэ?

Жүжигчлэн тоглох үйл ажиллагааны дараа сайн номлогч нар байсных нь төлөө хүүхдүүдэд талархал илэрхийл.

Дүгнэлт

ЗС уриа

ЗС уриаг заа, эсвэл тэдний ЗС бөгжүүдийг хүүхдүүдээр харуул. Тэд номлогч нар болсноор зөвийг сонгож, Есүс Христийг дагадгийг хүүхдүүдэд хэл. Уриан дээрх үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл (эсвэл тэдний бөгжин дээрх эхний үсгүүд юуг төлөөлж байгааг хэлүүл).

Гэрчлэл

Сайн номлогч нар байхыг хүссэнийх нь төлөө хүүхдүүдийг магт. Хүн бүрт Есүс Христ болон түүний сүмийн тухай заахын ач холбогдлын тухай гэрчлэлээ хэл. Есүс болон түүний сүмийн тухай мэдэх нь биднийг аз жаргалтай болгодог.

Ирэх долоо хоногт хүүхэд бүрийг номлогч байх нэг арга замын талаар бодоход нь тэдэнд тусал. Эдгээр санаанууд хэт нарийн буюу их нуршуу байх шаардлагагүй. Нөхөрсөг байж, бусдад тусалснаар, мөн түүнчлэн Сүмийн тухай мэдэхэд хүмүүсийг урьснаар тэд номлогч нар байж чадна гэдгийг хүүхдүүдэд сануул.

Номлогч байх арга замуудын талаар гэрийнхэнтэйгээ ярилцахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдийн Хэсгийнхээ ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр өөрийн бүсэд үйлчилж байгаа буюу саяхан эргэж ирсэн номлогч нарыг хичээлийн сүүлчийн хэдэн минутад оролцуулж, номлогч болохын тулд хүүхдүүд одоо юу хийж болох тухай хүүхдүүдэд ярихыг урь.
2. Номлогч нар танд тусалсан үеийн тухай, эсвэл Есүс Христ болон түүний сүмийн тухай мэдэхэд нь өөр хэн нэгэнд та тусалж чадсан тухайгаа хүүхдүүдэд ярь. Энэ туршлага танд ямар сэтгэгдэл төрүүлснийг тэдэнд ярь.
3. Хүүхдүүдээр өөрсдийг нь номлогч болсон мэтээр зуруул. Зураг бүрийг дараах байдлаар хаягла:

(Хүүхдийн нэр)
Номлогч
Есүс Христийн Хожмын
Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

4. “Би Одоо Номлогч Болохыг Хүснэ” (*Children’s Songbook*, х. 168), “Миний Хийдэг Зүйлс” (*Children’s Songbook*, х. 170), эсвэл “Түүний Үнэнийг Бид Дэлхийд Авчирна” (*Children’s Songbook*, х. 172) дуунуудын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэл.

Би Одоо Номлогч Болохыг Хүснэ

Би одоо номлогч болохыг хүснэ.

Өсөх хүртлээ хүлээхийг эс хүснэ би.

Бага байхдаа сайн мэдээг хуваалцахыг хүснэ би,

Учир нь надад өөрийн гэрчлэл бий.

Миний Хийдэг Зүйлүүд

Бурханы үгийг зааж, номлон

Хол явахад хэтэрхий бага байна би,

Энгийн байдлаар, өөрийн хийдэг зүйлүүдээр

Энэ үнэнийг харуулж чадна би.

Түүний Үнэнийг Дэлхийд Бид Авчирна

Их Эзэнийг хайрладаг сайн эцэг эхчүүдэд

Эртний Нифайн адил бид төрсөн юм.

Их Эзэний зарлигласнаар бид хийх ёстой гэж

Бидэнд зааж, тэгээд бид ойлгосон юм,

Дахилт:

Бид Хиламаны армитай адил юм.

Бидэнд бага насанд минь заасан юм.

Түүний үнэнийг дэлхийд авчрахын тулд

Бид Их Эзэний номлогчид байх болно.

(© 1983 by Janice Carr Perry. Зөвшөөрлөөр ашиглана.)

Зорилго

Баптисм хүртэх хүүхэд бүрийн хүслийг нэмэгдүүлж, баптисмд хэрхэн бэлтгэх тухай ойлголтыг хүүхдүүдэд өгөх.

Бэлтгэл

1. Матай 3:13–17, Сургаал ба Гэрээ 20:72–74-ийг залбиралтайгаар судал. Мөн Иохан 1:25–34 болон *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 20-ийг үз.
2. Хэрэв боломжтой бол Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдагчаар “Баптисм” (*Children’s Songbook*, х. 100) дууг хүүхдүүдээр нээлт, хаалтын үйл ажиллагааны үед дуулуул.
3. Иохан Баптист Есүст Баптисм Хүртээж Байгаа нь, зураг 2-19-ийг халхлах хэмжээний зузаан цаас бэлтгэ. Энэ цаасыг ангийнхаа хүүхдийн тоогоор жижиг хэсгүүд болгон хайчил. Жижиг хэсгүүдийг зураг дээр үүнийг харагдуулахгүйгээр дээр нь тавь.
4. Зузаан цаасаар зургаан том хөлийн хэв хий.
5. Хичээлийн төгсгөлд зургуудын хувийг буюу тойруулж зурсан зургийн хувийг хүүхэд бүрт өгөхөөр бэлтгэ.
6. Хэн танд баптисм хүртээсэн, хаана та баптисм хүртсэн гэхчлэн өөрийнхөө баптисмын талаар, зарим тодорхой мэдээлэл бэлтгэж, баптисм хүртэхэд төрсөн сэтгэгдлийнхээ тухай товч ярь. Хэрэв та хүүхэд байхдаа баптисм хүртсэн бол та тэр үеийнхээ зургийг авчирч болно.
7. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Скоч буюу өөр наалдагч зүйл.
 - в. Зураг 2-19, Иохан Баптист Есүст Баптисм Хүртээж Байгаа нь (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 208; 62133); зураг 2-20, Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн (62018).
8. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Ахлах насны хүүхдүүдийн багш нарт зориулсан анхааруулга: Баяжуулах үйл ажиллагаа 5, 6, 7-г удахгүй баптисм хүртэх гэж байгаа ахлах насны хүүхдүүдэд тусгайлан зориулсан болно.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христ Баптисм Хүртжээ

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Иохан Баптист Есүст Баптисм Хүртээж Байгаа нь, зураг 2-19-ийг ил гарга. Цаасан доорх зураг нь хоёр чухал хүнийх гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэр хүмүүсийн хэн болохыг хүүхдүүдээр таалгахыг хүс, гэвч зургийг бүгдийг нь

ил гаргах хүртэл ямар нэг зүйлийг чангаар хэлэхгүй байхыг тэднээс хүс. Хүүхэд бүрийг ээлж ээлжээрээ зургийг далдалсан хэсэг цаасуудыг нэг нэгээр нь авахыг хүс.

Зургийг далдалсан бүх цаасыг авсны дараа, асуу:

- Зураг дээрх хүмүүс хэн бэ?
- Тэд юу хийж байна вэ?

Судрын түүх

Матай 3:13–17 дахь Есүс Христийн баптисмын тухай түүхийг ярь. Есүс баптисм хүртэе гэж хүсэхэд Иохан Баптист гайхсныг тайлбарла. Есүс хэзээ ч нүгэл үйлдээгүйг Иохан мэдэж байсан болохоор Есүсийг баптисм хүртэх шаардлагатай гэж тэр бодохгүй байжээ. Гэвч баптисм хүртэх нь Тэнгэрлэг Эцэгээс ирсэн зарлиг гэдгийг Есүс Иоханд хэлж, тэгээд тэр Тэнгэрлэг Эцэгийн бүх зарлигийг дуулгавартай дагахыг хүсчээ.

Зураг дээрх голыг зааж, Иордан гол дээр Иохан Есүст баптисм хүртээснийг тайлбарла. Иохан усанд умбуулалтаар Есүст баптисм хүртээжээ. *Умбуулалт* гэдэг нь усанд бүрэн дүрэх гэсэн утгатай.

Матай 3:17-г чанга уншиж, эдгээр нь Тэнгэрлэг Эцэгийн үгс гэдгийг тайлбарла. Биднийг баптисм хүртэхэд Тэнгэрлэг Эцэг бас сэтгэл хангалуун байдгийг хүүхдүүдэд хэл.

Тоглоом

“Сүүлчийн Үгс” тоглоомыг хүүхдүүдтэй хамт тогло. Доогуур нь зурсан үгсийг орхин доорх нотолгоонуудыг унш. Зохих үгсийг бөглөхийг нэг хүүхдээс хүс. Хэрэв хүүхэд хариуг санахгүй бол зөв хариу өгөгдөх хүртэл, дараагийнх нь хүүхэд рүү оч (асуултад хариулж чадаагүй хүүхдийг бүү ичээ). Шаардлагатай үед хүүхдүүдэд туслан хүүхэд бүрийг асуултад зөв хариулах хүртэл тоглоомыг үргэлжлүүл. Шаардлагатай бол асуултуудыг хоёр удаа тавь.

1. Есүс Христэд Иохан Баптист баптисм хүртээсэн.
2. Есүс Иордан голд баптисм хүртсэн.
3. Тэнгэрлэг Эцэгийн зарлигийг (заасан зүйлийг) дуулгавартай дагахын тулд Есүс баптисм хүртсэн.
4. Есүс баптисм хүртэхдээ усанд бүрэн дүрэгдсэн.
5. Есүсийг баптисм хүртсэний дараа Иохан тэр хоёр Тэнгэрлэг Эцэгийн дуу хоолойг сонссон.
6. Бид найман настай байхдаа Есүсийн үлгэр жишээг дагаж, баптисм хүртэж болно.

Баптисм Хүртсэнээр Бид Есүс Христийн Үлгэр Жишээг Дагаж Чадна

Багшийн
танилцуулга

Хүүхдүүд найман нас хүрсэн үедээ баптисм хүртэж болно гэдгийг тэдэнд хэл. Тэд найман нас хүрэх болон баптисм хүртэхэд яг одоо бэлтгэж, бэлэн болж байх хэрэгтэй.

Бид баптисм хүртэхдээ Тэнгэрлэг Эцэгтэй гэрээнүүд (амлалтууд) хийдгийг тайлбарла. Бид түүний зарлигуудыг дуулгавартай дагах, бусдыг уучлах, мөн Есүс Христийг дагахаар амладаг. Хариуд нь тэр биднийг Сүмд хүлээн авч, биднийг удирдаж, бидэнд туслахаар амладаг.

Өөрийнхөө баптисмын тухай ангийнхандаа ярьж өг. Та хаана баптисм хүртсэн (баптисмын сан буюу гол гэх мэт), хэн баптисм хүртээсэн, мөн таны баптисмыг харахаар хэн тэнд байсан зэргийг та дурдаж болно.

Хэрэв та хүүхэд байхдаа баптисм хүртсэн бол, тэр үеийнхээ зургийг хүүхдүүдэд үзүүл. Сүмийн гишүүн болох хүсэл хийгээд сэтгэл догдолсон зэрэг, баптисмынхаа үед төрсөн сэтгэгдлийг тэдэнтэй хуваалц.

Есүс Христ болон та үүнийг хийсний адилаар нэг өдөр тэд ч бас баптисм хүртэж болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Түүх

Баптисм хүртэж байгаа нэг хүүхдийн тухай түүхийг ярьж өг. Та дараах түүхийг ашиглаж болно:

Марког долоон настай байхад гэр бүл нь Сүмд нэгджээ. Маркогос бусад гэр бүлийнх нь бүх хүн баптисм хүртэв. Түүний нас нь болоогүй байлаа. Марко гэр бүлтэйгээ хамт баптисм хүртэж чадаагүйдээ маш урам муутай байсан боловч тэр удахгүй баптисм хүртэх насанд хүрнэ, тэгэхлээр тэр үүнд бэлтгэхийн тулд хүлээх тэр цагийг ашиглах ёстой гэж ээж нь түүнд хэлжээ.

- Марко баптисм хүртэхэд хэрхэн бэлтгэж болох вэ?

Дараагийн жил нь Марко зөвийг сонгох болон түүгээр Есүсийн хийлгэхийг хүсдэг зүйлүүдийг хийхийг маш их хичээдэг байв. Тэгсээр эцэст нь Марко найман нас хүрэв. Тэрээр цав, цагаан хувцас өмсөж, аав нь түүнд баптисм хүртээв. Маркогийн аав түүнийг уснаас гаргаж ирэхэд Марко Есүсийн нэгэн адил усанд умбуулалтаар баптисм хүртсэндээ нэн баяртай байлаа. Есүсийн сүмийн гишүүн болсондоо тэр баяртай байв.

Одоо Бид Баптисмд Бэлтгэж Чадна

Хөлийн хэвийн үйл ажиллагаа

Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн, зураг 2-20-ийг үзүүл, хэрэв боломжтой бол, зургийг ангийн хаалган дээр байрлуул.

- Энэ хүүхэд Есүсийн үлгэр жишээг хэрхэн дагаж байна вэ?

Яг одооноос хүүхдүүд баптисмд бэлтгэж болно гэдгийг тэдэнд сануул. Цаасан хөлийн хэвнүүд болон хичээлийн төгсгөл дэх зургаан зургийн нэг хувийг үзүүл. Зургууд нь тэднийг баптисмд хөтлөх алхмуудыг төлөөлж байгааг хүүхдүүдэд хэл. Доорх мэтийн асуултуудыг асууж, дүрсэлсэн алхам бүрийг ярилц. Алхам бүрийн талаар хэлэлцсэний дараа баптисмын зураг руу очих зам бий болгон, нэг хүүхдээр хөлийн хэвийг шалан дээр тавиул.

1. Есүс Христ болон Тэнгэрлэг Эцэгт итгэж, тэдний тухай суралц.

- Бид яагаад Есүс Христ болон Тэнгэрлэг Эцэгийн тухай сурах ёстой вэ?
- Бид тэдний тухай хаана сурч болох вэ?

2. Тэнгэрлэг Эцэгт хандан залбир.

- Залбирах нь баптисмд бэлэн болоход бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

3. Уучилдаг, бусдыг хайрладаг бай.

- Биднийг уучлахад юу болдог вэ?
- Бусдыг хайрлах хайраа бид яаж харуулж болох вэ?

4. Өдөр бүр зөвийг сонго.

- Бидэнд зөвийг сонгох ямар арга замууд байдаг вэ?

5. Судрын түүхүүдийг унш, эсвэл сонс.

- Судруудыг судлах нь та нарт хэрхэн тусалсан бэ?

6. Найман нас хүрсэн байх.

- Баптисмд бэлтгэхийн тулд найман нас хүрэхээсээ өмнө та нар юу хийж болох вэ?

Бүх хөлийн хэвүүдийг шалан дээр тавьсны дараа хүүхдүүдийг нэг нэгээр нь хөлийн хэвнүүд дээр гишгэн баптисмын зураг руу хүртэл өрөөн дундуур явуул. Хөлийн хэв бүр дээр гишгэхдээ тэд баптисмд хэрхэн бэлтгэдгийг тайлбарлахад нь хүүхдүүдэд тусал.

Дүгнэлт

Тарааж өгөх материал

Хүүхэд бүрт дээрх зургаа зургаан зургийг гэрт нь өгч явуул. Цааснууд дээр нь хүүхдүүдийн нэрийг бичих буюу, эсвэл тэднээр өөрсдөөр нь бичүүл.

Гэрчлэл

Баптисмын ач холбогдлын тухай гэрчлэлээ хүүхдүүдэд хэл. Биднийг баптисм хүртэхэд Тэнгэрлэг Эцэг сэтгэл хангалуун байдгийг хүүхдүүдэд сануул.

Баптисмын тухай сурсан зүйлээ гэрийнхэндээ заахдаа хуудсан зургуудыг ашиглахыг хүүхдүүдэд санал болго. Зургуудын дүрсэлсэн зургаан алхмыг дагаснаар баптисм хүртэхэд бэлтгэхэд хүүхэд бүрийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Хүүхдүүдийг ангиас явахад бэлэн болох үед тэднээр өрөөнөөс гарах замдаа хөлийн хэвүүд дээгүүр дахин алхуул.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.






1. Хүүхэд бүрт зориулан хэсэг цаасан дээр хөлийн хэв зур. Хөлийн хэв бүр дээр *Би Есүс Христийг дагах болно* гэж бич. Хөлийн хэвүүдийг хүүхдүүдээр будуулах буюу чимэглүүл.
2. Хэрэв та нарын цуглаан хийдэг газар баптисмын сан байдаг бол хүүхдүүдийг тийш нь аваачиж үзүүл.
3. “Би Төрсөн Өдрүүддээ Дуртай” (*Children’s Songbook*, х. 104) дууны эхний хоёр бадгийг дуулах буюу үгийг нь хэл. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
4. “Баптисм” (*Children’s Songbook*, х. 100) эсвэл “Есүс Христийг Баптисм Хүртэхэд” (*Children’s Songbook*, х. 102) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. “Баптисм” дууны үг гарын авлагын ар талд байгаа.

Есүс Христийг Баптисм Хүртэхэд

Иордан Гол дээр тэнд
Есүс Христийг баптисм хүртэхэд,
Бурхан Тэргүүтний гурван гишүүн
Бултаараа тэнд хайранд байлаа.
Есүс Христийг баптисм хүртэхэд
Бурхан тэнгэрээс ярив;
Ариун Сүнс хүрч ирэн
Алгуурхнаар тагтаа болж буув.

Баптисм одоо хүртсэн учраас
Би түүний үлгэр жишээг дагана—
Ариун санваарын хүчээр
Умбуулалтаар баптисм хүртэж байна.
Тэнгэрлэг Эцэгийн хаант улсын
Тэгээд би гишүүн нь болно
Цаг бүрт намайг удирдах
Ариун Сүнстэй болно оо би.

5. Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн, зураг 2-20-ийг Иохан Баптист Есүст
Баптисм Хүртээж Байгаа нь, зураг 2-19-ийн хажууд үзүүлэн болгож тавь.
Баптисм хүртэх тухай хүүхдүүд юу мэддэгийг нь тэдэнтэй хамт нэгтгэн
дүгнэ. Баптисм бол хүсэн хүлээх учиртай онцгой тохиол гэдгийг ойлгоход
нь хүүхдүүдэд тусал. Энэ бол тэдний нэгэн цагт хийх учиртай хамгийн
чухал зүйлүүдийн нэг мөн. Дараах санаануудыг ярилц:
- а. Бид баптисм хүртээд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн гишүүд болдог. (Бага насны хүүхдүүд өөрсдийгөө сүмийн
гишүүд биш гэж боддог бол наймаас доош насны хүүхдүүд гишүүд
хэмээн тооцогдож болно. Харин тэд найман нас хүрсэн үедээ Сүмийн
албан ёсны гишүүд болохын тулд баптисм хүртэх ёстой.)
 - б. Баптисм хүртэхийн тулд бид доод тал нь найман нас хүрсэн байх ёстой.
 - в. Бидний баптисмын тухай ярилцахаар бишоп буюу салбарын
ерөнхийлөгч бидэнтэй уулздаг.
 - г. Бид баптисм хүртэхдээ цагаан хувцас өмсдөг (зураг 2-20-ийг үз).
 - д. Бид умбуулалтаар, усанд бүрэн дүрэгдэж баптисм хүртдэг (тэд усан
дор ердөө нэг юм уу хоёр хором л болдог, ус нэг их гүн биш, тэгээд ч
тэдэнд баптисм хүртээж байгаа хүн найдвартай барьж байдаг гэдгийг
хүүхдүүд ойлгосон байхад анхаар.)
 - е. Бидэнд баптисм хүртээж байгаа хүн санваартан буюу Мелкизедек
Санваар атгадаг байх ёстой.
 - ё. Есүс баптисм хүртсэн тэр байдлаар бид баптисм хүртдэг. Тэр бидэнд
үлгэр жишээ үзүүлсэн билээ.
6. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр баптисм хүртэхэд нь
тэдэнд юу тохиолддог талаар хүүхдүүдэд яриулахын тулд нэг санваартныг
урь. Хүүхэд болон баптисм гүйцэтгэж байгаа хүн яаж зогсох, тэд гараа яаж
барихыг түүгээр тайлбарлуул. Баптисм гүйцэтгэж байгаа хүн хүүхдийг ус
руу зөөлөн хийж, түүнийг хурдан дахин буцааж гаргадгийг түүгээр
тайлбарлуул. Ийм байдлаар тэд Есүс баптисм хүртсэнтэй адилаар
баптисм хүртдэгийг хүүхдүүдэд сануул.
- Бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр баптисм хэрхэн
гүйцэтгэгддэгийг санваартан ангид үзүүлж болно. (Санваартан үүнийг
үзүүлэхдээ баптисмын залбирлыг хэлэх ёсгүй.)
7. Баптисмын залбирал бол тухай бүр яг адил байдлаар хэлдэг цөөхөн
залбирлын нэг гэдгийг тайлбарла. Энэ залбирлын үгсийг Есүс Христ
судруудад илчилсэн байдаг. Сургаал ба Гэрээ 20:73 дахь залбирлыг
чанга унш (*Итгэмжилснээр* гэдэг үгнээс эхлэн).




Ариун Сүнсний Бэлэг Надад Тусалж Чадна

Зорилго

Хүүхдүүд баптисм хүртсэнийхээ дараа өөрсдөд нь туслах Ариун Сүнсний бэлэг хүлээн авах болно гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 49:13–14, 130:22, мөн Итгэлийн Тунхаг 1:1, 4-ийг залбиралтайгаар судал. Моронай 10:5; Сургаал ба Гэрээ 9:8–9; 85:6; түүнчлэн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 21-ийг үз.
2. Дараах “асуултын цэцгүүдийг” зузаан цаасаар хий.



Цэцгүүдийг дөрвөөс зургаан ямх урттай савх модонд бэхэлж, ваар, эсвэл шилэн саванд хий.

3. “Эцэг Минь Амьдыг Би Мэднэ” (Сүмийн дуулал ба хүүхдийн дуунууд, х. 59) дууг дуулах буюу үгийг нь хэл. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Сургаал ба Гэрээний нэг хувь.
 - б. Зураг 2-19, Иохан Баптист Есүст Баптисм Хүртээж Байгаа нь, (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 208; 62133).
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Ариун Сүнсний Бэлгийг Хүлээн Авч Чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Иохан Баптист Есүст Баптисм Хүртээж Байгаа нь, зураг 2-19-ийг үзүүл. Хүүхэд бүрээр нэг асуултын цэцэг сонгуулж, сүүлчийн долоо хоногийн хичээлийг нэгтгэн дүгнэ. Цэцгэн дээрх үгээр эхэлсэн Есүс Христийн баптисмын тухай тус бүр нэг асуулт асуу. Хэрэв цэцэг сонгосон хүүхэд асуултад хариулж чадахгүй бол ангийн үлдсэн хэсгээр туслуул (хариултыг нь мэдэхгүй хүүхдийг ичээхгүйн тулд анхааралтай бай).

Боломжтой асуултууд:

- *Хэн* Есүст баптисм хүртээсэн бэ? (Иохан Баптист.)
- *Хаана* Есүс баптисм хүртсэн бэ? (Иордан голд.)
- Умбуулалт гэж юу вэ? (Усанд бүрэн шумбуулах.)
- *Яагаад* Есүс баптисм хүртсэн бэ? (Тэнгэрлэг Эцэгийн зарлигийг сахих болон бидэнд үлгэр жишээ үзүүлэхийн тулд.)
- *Хэзээ* бид баптисм хүртэж болох вэ? (Бид найман нас хүрэхээрээ.)

Багшийн
танилцуулга

Хүүхдүүдээр зураг 2-19 дээр байгаа хоёр хүнийг хэн болохыг нь хэлүүл.

- Есүсийг баптисм хүртсэний дараа Есүс Христ, Иохан Баптист хоёр хэний дууг сонссон бэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүсийн баптисмыг харж байсан бөгөөд Есүсийг баптисм хүртэхэд сэтгэл хангалуун байжээ гэдгийг хүүхдүүдэд сануул. Есүсийн баптисм дээр өөр нэг онцгой хүн байсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Энэ хүн Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрт тусалдаг. Түүнийг Ариун Сүнс гэдэг.

Итгэлийн Тунхаг

Хүүхдүүдийг босгож, Итгэлийн нэгдүгээр тунхагийг өөртэйгөө хамт давтан хэлүүл.

Судар

Ариун Сүнс бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой адил юм, учир нь тэрээр биднийг хайрладаг, мөн бидэнд туслахыг хүсдгийг тайлбарла. Гэвч Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрын нэгэн адил Ариун Сүнс мах, ясан биегүй юм. Сургаал ба Гэрээ 130:22-ыг *Сүнсэн хүн* гэснийг хүртэл дуустал унш. Бид Ариун Сүнснийг харж чадахгүй боловч, зөв зүйлийг хийхэд тэр бидэнд тусалж чадна. Биднийг зөвийг сонгох үед тэрээр бидний дотор дулаан, баяртай мэдрэмжийг төрүүлдэг.

Судар

Хүүхдүүдийг баптисм хүртсэний дараа Мелкизедек Санваар атгадаг эрэгтэйчүүд тэдэнд хоёр агуу адислал өгөх болно гэдгийг тэдэнд хэл. Сургаал ба Гэрээ 49:14-ийг чанга уншиж, энэ судар тэр хоёр адислалын нэг нь юу болохыг бидэнд өгүүлдэг гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. *Үүнийг хийдэг хэн боловч* гэсэн нь баптисм хүртдэг хэн ч гэсэн утгатайг тайлбарла.

Итгэлийн Тунхаг

Итгэлийн дөрөвдүгээр тунхагийн нэг хэсгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал: “Ариун Сүнсний бэлгийн төлөө . . . гар тавихад бид итгэдэг.” Ариун Сүнсний бэлэг бол баптисмын дараа бидний хүлээн авч болдог агуу адислалуудын нэг гэдгийг хүүхдүүдэд хэлж өг.

Багшийн
танилцуулга

Бид Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахад ямар зүйлүүд үнэн бөгөөд зөв болохыг мэдэхэд Ариун Сүнс бидэнд туслах болно гэдгийг тайлбарла. Ариун Сүнс бүр биднийг баптисм хүртэж, гишүүнээр батлагдахаас өмнө ч бидэнд тусалж болох хэдий ч бид энэ бэлгийг хүлээн авсны дараа Ариун Сүнс бидний байнгын хамтрагч болж болдог. Энэ нь бид зөвийг хийхийг хичээж байхад түүний төлөө бидэнтэй хамт үргэлж байдаг гэсэн утгатай юм.

Бид Сүмийн Гишүүд болон Батлагдаж Болно

Багшийн
танилцуулга

Баптисмын дараа бидний хүлээж авдаг өөр нэг адислал бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлагдах явдал мөн гэдгийг тайлбарла. Үүнийг гишүүний баталгаа гэдэг. *Гишүүний баталгаа* гэж хүүхдүүдээр хэдэн удаа давтан хэлүүл.

Зургийн түүх

Хичээлийн төгсгөл дэх “Робертагийн Гишүүний Баталгаа” түүхийг ярьж өг. Таныг уг түүхийг ярьж байх хооронд хүүхдүүд зургуудыг харж байхын тулд тэднийг өөрийгөө тойруулан зогсоо.

Ярилцлага

Та уг түүхийг ярьсны дараа дараах асуултуудыг асуу:

- Робертад юу өгсөн бэ? (Ариун Сүнсний бэлэг)
- Түүнд Ариун Сүнс өгөх залбирлыг хэн хэлсэн бэ? (Аав нь)
- Робертагийн аав ямар эрх мэдэлтэй байсан бэ? (Мелкизедек Санваар)
- Робертад мэдрэгдсэн халуун дулаан мэдрэмж нь юу байсан гэж та нар бодож байна вэ? (Ариун Сүнсний нөлөө)

Түүхийг хүүхдүүдээр дахин яриул. Зураг тус бүрийн тухай яриулахаар өөр хүүхдийг урь.

Юуг Үнэн Болохыг Мэдэхэд Ариун Сүнс Бидэнд Туслах Болно

Багшийн
танилцуулга

Сүмийг үнэн гэдгийг мэдэхэд Ариун Сүнс бидэнд туслах болно гэдгийг тайлбарла. Заримдаа бид нэн их баяр талархалтай байж, энэхүү мэдрэмжийнхээ тухай бусдад ярихыг хүсдэг. Энэ нь мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр биднийг гэрчлэлээ хэлэх үед олонтаа тохиолддог.

- Мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр та нар гэрчлэлээ хэлж үзсэн үү?

Хэрэв хүүхдүүдээс хэн нэг нь гэрчлэлээ хэлж байсан бол тэр үед ямар сэтгэгдэл төрснийг нь хүүхдүүдээр яриул.

Зарим хүмүүс Ариун Сүнсээр дүүрсэн үедээ тэд бүр бага зэрэг уйлдгийг тайлбарла. Энэ бол гунигийн нулимс биш; баярын нулимс. Зарим үед гэрчлэлийн цуглааны үед, эсвэл тэднийг залбирах, судар унших, эсвэл сүмд үг хэлэхийг сонсож байх үеэр тэдэнд халуун дулаан, амар амгалан мэдрэмж төрж болохыг хүүхдүүдэд ярь. Энэхүү амар амгалангийн мэдрэмж бол эдгээр зүйлүүд нь үнэн бөгөөд зөв гэдгийг тэдэнд мэдэгдэж байгаа Ариун Сүнсний шивнээ юм.

Дуу

“Эцэг Минь Амьдыг Би Мэднэ” (Сүмийн Дуулал болон Хүүхдийн Дуу, х. 59) дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу эсвэл үгийг нь хэл.

Энэ дуун дахь “Сүнс” гэдэг үг нь Ариун Сүнс гэсэн утгатай юм гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэгийн бодитой мөн түүний бидэнд хайртайг мэдэхэд Ариун Сүнс бидэнд тусалдаг.

Ариун Сүнс Биднийг Удирдаж, Бидэнд Анхааруулж Чадна

Түүх ба
ярилцлага

Сара Жейн Женн Канноны тухай түүхийг өөрийн үгээр ярь. Ариун Сүнс юуны тухай түүнд шивнэснийг сонсохыг хүүхдүүдээс хүс.

Сара Жейн бол дээр үед шинэ гэр оронтой болохын тулд Америкийн аглаг буйдаар дамжин явганаар аялсан нэгэн анхдагч охин байжээ. Тэр Ютад ирсний дараа авга эгчийнхээ хамт барьж дуусаагүй байшинд амьдарч байв. Ханануудын орой дээр брезент даавуу дэлгэн татаж дээвэр болгон, өнцөг бүр дээр нь том чулуу тавьсан байжээ.

Нэг өдөр Сара гэртээ юм оёж байтал, “Наанаасаа хурдхан холд” гэж хэлэх дууг сонсжээ. Ойр хавьд нь өөр хүн байсангүй, гэвч Сара Жейн өрөөний нөгөө тал руу очив. Түүнийг дөнгөж тэнд холдонгуут чулуунуудын нэг нь дээвэр дээрээс доош унав. Хэрэв Сара Жейн тэндээс холдоогүй бол, чулуу түүнийг цохиж мэдэх байв. (“Move Away Quickly,” in *Remarkable Stories from the Lives of Latter-day Saint Women*, эмхтгэл. Leon R. Hartshorn, 2 боть. [Salt Lake City: Deseret Book Co., 1973–75], 2:34-ийг үз.)

- Сара Жейнд хэн хэлсэн бэ?
- Ариун Сүнс Сара Жейнд юу гэж хэлсэн бэ?
- Сара Жейн юу хийсэн бэ?
- Хэрэв Сара Жейн сонсоогүй бол юу болох байсан бэ?

Ариун Сүнс бидний сонсож болох дуугаар үргэлж ярьдаггүйг хүүхдүүдэд сануул. Олон удаа тэр бидний хийх ёстой зүйлүүдийн талаар мэдрэмжүүдийг бидэнд төрүүлдэг.

Дүгнэлт

Нэгтгэн дүгнэх
үйл ажиллагаа

Ариун Сүнсний тухай юу мэддэгээ ярихыг хүүхдүүдээс хүс. Та нэгтгэн дүгнэлт хийхийн тулд асуулт цэцгүүдийг дахин ашиглаж болно. Та доорх асуултуудыг ашиглаж болно:

- Та нар баптисм хүртсэний дараа *ямар* үнэ цэнэтэй бэлэг хүлээн авч болох вэ? (Ариун Сүнсний бэлэг.)
- Ариун Сүнс гэж хэн бэ? (Есүс, Тэнгэрлэг Эцэг хоёрт тусалдаг бие; биднийг тайтгаруулж, бидэнд тусалж чаддаг сүнс.)
- Ариун Сүнсний бэлгийг бидэнд хэзээ өгдөг вэ? (Биднийг баптисм хүртсэний дараа; Сүмийн гишүүдээр батлагдсан үед.)
- Ариун Сүнсний өдөөлтүүдийг бид хаана мэдэрч болох вэ? (Өөрсдийн зүрх сэтгэл хийгээд оюун ухаанд. Түүнчлэн, “гэрт,” “сүм дээр,” эсвэл “бидний зөвийг сонгодог тэр газар гэх мэт хаана ч гэсэн байж болно.)
- *Яагаад* Тэнгэрлэг Эцэг Ариун Сүнсийг бидэнтэй хамт байлгахаар илгээсэн бэ? (Бидэнд тусалж, биднийг тайтгаруулахын тулд; биднийг удирдаж, бас анхааруулахын тулд; бидэнд юу нь үнэнийг хэлэхийн тулд; хайр, амар амгалангийн мэдрэмжүүдийг бидэнд төрүүлэхийн тулд.)

Гэрчлэл

Ариун Сүнсний тухай өөрийн мэдрэмжүүд хийгээд тэрээр бидэнд хэрхэн тусалж, биднийг хэрхэн удирддаг тухай гэрчлэлээ хүүхдүүдтэй хуваалц. Ариун Сүнс танд гэрчлэл хэлсэн буюу танд тусалсан үеийн тухай хувийн гэрчлэлийнхээ тухай та ярьж болно.

Тэд Ариун Сүнсийг өөрсөдтэйгөө хамт үргэлж байлгаж болохын тулд зөвийг сонгоход нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Та бэлгэнд хүлээж авсан боловч, эвдэрсэн, элэгдэж хуучирсан буюу хэрэглэж дууссан учраас ямар ч хэрэггүй болсон, хагархай таваг, хуучин хувцас хунарын зүйл, эсвэл хоолны хоосон сав авчир.

Хэрэгцээгүй болсон бэлгийг хүүхдүүдэд үзүүл. Бэлгийг хэн танд өгсөн, мөн хэзээ, яагаад тэд үүнийг танд өгсөн тухай сонирхолтой мэдээллийг тэдэнд ярь. Хэдийгээр энэ бэлэг нэгэн цагт таны хувьд ач холбогдолтой байсан хэдий ч эвдэрсэн, элэгдэж хуучирсан буюу эсвэл ашиглаж дууссан учир хэрэгцээгүй болсныг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Та баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан үед та өөр төрлийн бэлэг хүлээн авсныг тайлбарла. Энэ бол элэгдэж хуучрах буюу хэрэглэгдэж дуусдаггүй, нэн үнэ цэнэтэй бэлэг юм. Энэхүү үнэлж баршгүй бэлэг ашиглах тусам улам илүү үнэ цэнэтэй болдог.

- Энэ ямар бэлэг вэ?

Энэ бэлэг бол Ариун Сүнсний бэлэг гэдгийг хүүхдүүдийг таасан үед (эсвэл та тэдэнд хэлж өгсөн үед), тэд амьдралынхаа бүхий л үеийн туршид олон бэлэг хүлээн авах боловч Ариун Сүнсний бэлэг бол тэд дэлхий дээр байх үедээ хүлээн авах хамгийн үнэ цэнэтэй бэлэг юм гэдгийг тэдэнд хэл.

2. “Намуухан, Чимээгүй Дуу Хоолой” (*Children’s Songbook*, х. 106) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Намайг удирдахын тулд, үзэж болох муугаас намайг аврахын тулд
Намуухан чимээгүй дуу хоолойгоор Сүнс надад ярьдаг.
Хэрэв би зөвийг хийхийг хичээвэл тэр намайг шөнөөр удирдах болно,
Намайг чиглүүлж, намайг хамгаалан, бодгальд минь гэрлийг өгнө.

Дууны сүүлчийн хэсгийг дуулах буюу үгийг нь хэлэх үед доор өгүүлсэн үйлдлүүдийг хий.

Сонс, сонс (*гараа чихээ хөмрөн харуулна*).

Ариун Сүнс шивнэнэ (*Заагуур хуруугаар уруулаа заана*).

Сонс, сонс (*гараа чихээ хөмрөн харуулна*).

Намуухан чимээгүй дуу хоолойг (*Зүрхнийхээ тушаа гараа тавь*).

3. Хүүхдүүд намуухан, чимээгүй дуу хоолойгоор удирдагдаж болохыг нь харуулахын тулд дараах чимээгүй тоглоомоор тогло:

Энэ тоглоомыг тоглохоор ямар нэг жижигхэн зүйлийг хүүхдүүдэд үзүүлээд нуу. Таныг уг зүйлийг нуух хооронд нэг хүүхдийг ангиас түр зуур гарга. Хүүхдийг эргэж ирэхэд, уг зүйлийг олохын тулд тэр анхааралтай сонсох ёстойг тайлбарла. Хүүхэд нуусан зүйл рүү чиглэх буюу харахад харандаагаар зөөлхөн тогших, алгаа аяархан таших буюу дуу аялах зэрэг ярихгүйгээр өгөх дохиог ашиглана. Хүүхдийг зөв чиглэлд харахад зөөлхөн тогш. Нуусан зүйл рүү хүүхдийг бүр ойртоход, түүнийг олох хүртэл улам хурдан тогш (эсвэл улам чанга дуу аял). Нуусан зүйлийг эрж олох боломжийг хүүхдүүдийн хүссэний дагуу өөр хүүхдэд олгон үйл ажиллагааг давт.

Ариун сүнсний намуухан, анир чимээгүй дуу хоолойг сонссоноор тэд амьдралдаа удирдагдаж болно гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Ариун Сүнс үргэлж чанга ярьдаггүйг тэдэнд сануул. Зарим үед бид ямар нэгэн зөв юм хийхэд халуун дулаан мэдрэмжийг, эсвэл биднийг ямар нэгэн буруу юм хийхэд (эсвэл хийхийг хүсэхэд) тэрээр бидэнд муу санаа бодол буюу мэдрэмжийг төрүүлдэг. Ариун Сүнс юу хийхийг бидэнд хэлэхийг мэдэхийн тулд бид маш анхааралтай байх ёстой.

4. Хүүхдүүдээр хоёр гарыг нь цаасан дээр тавиулан өөр, өөр өнгийн будгийн харандаагаар зуруул. Ариун Сүнсний бэлэг хүлээн авах гар тавилтыг төлөөлүүлэн гарыг зурган дээр нь тавиул. Зураг бүр дээр хүүхдийн нэрийг бичүүл.

5. “Ариун Сүнс” (*Children’s Songbook*, х. 105), эсвэл “Би Төрсөн Өдрүүддээ Дуртай” (*Children’s Songbook*, х. 104) дууны гуравдугаар бадгийг дуулах буюу эсвэл үгийг нь хэл. Эдгээр дууны үг гарын авлагын ар талд байгаа.

Робертагийн Гишүүний Баталгаа




Энэ бол Робертагийн хувьд онцгой өдөр юм. Тэр дөнгөж саяхан баптисм хүртээд байна. Одоо тэр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлагдах бөгөөд түүнд Ариун Сүнсний бэлэг өгөх болно. (Робертаг баптисм хүртэж, ааваараа гишүүнээр батлагдахад Мелкизедек Санваар атгагч зохистой хэн ч гэсэн эдгээр ёслолуудыг гүйцэтгэж болно гэдгийг та хүүхдүүдэд тайлбарлаж болно.)




Робертагийн аав түүнийг уснаас гарахад тусалсны дараа ээж нь хуурай хувцастай түүнийг угтжээ. Түүний нойтон үсийг удалгүй цэмцийтэл самнахад тэр баяртайгаар инээмсэглэж байв!



Роберта бэлэн болж, түүнийг хүлээж байсан гэр бүл, найз нөхөддөө эргэж ирэв. Тэр аавынхаа хамт өрөөний нүүрэн талын сандал руу очлоо.



Робертагийн сонгосон хүмүүсийг гарч ирж, тойрогт зогсоно уу гэж бишоп [салбарын ерөнхийлөгч] хүслээ. Роберта аав, өвөө, авга ахаа, тэрчлэн гэрийн багш нараа сонгосон ажээ. Эдгээр бүх эрэгтэйчүүд Мелкизедек Санваарыг атгадаг.



Роберта толгойгоо бөхийлгөж нүдээ анив. Тэдгээр эрэгтэйчүүд түүний толгой дээр гараа тавьж, аав нь түүний нэрийг хэлж, Сүмийн гишүүнээр батлан, түүнд Ариун Сүнсний бэлэг өгөв.



Гишүүний баталгаа дууссаны дараа Роберта тойрогт зогсож байсан хүмүүстэй гар барьж, тэд түүнд баяр хүргэв. Роберта дотроо гайхамшигтай халуун дулаан мэдрэмжтэй байсан бөгөөд тийнхүү тэрээр зөвийг сонгосноо мэдэв.

Зөвийг Сонгох Зоригтой Бай

Хичээл


14

Зорилго

Сатан түүнийг уруу татахыг оролдсон үед Есүс Христийн хийсний адилаар хүүхдүүд зөвийг сонгож чадна гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах.

Бэлтгэл

1. Матай 4:1–11-ийг залбиралтайгаар судал.
2. Цаасаар буюу адил төстэй материалаар, үзүүлсний дагуу энгийн титэм хий:



3. “Зөвийг Сонго” тоглоомын самбарыг зурах буюу хатуу картон цаасаар (хичээлийн төгсгөлд харуулснаар) хувилан хий.
 4. Тоглоомын асуултуудыг тусгай цаасан дээр (хуудас 71–72) бичиж, тэдгээрийг жижиг хүүдий буюу өөр саванд хий.
 5. “Зөвийг Хийх Зоригтой Бай” (*Children’s Songbook*, х. 158) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
 6. Сонголтоор: Ахлагч Пинегарын захидлыг хувилж, дугтуйнд хий.
 7. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хэдэн чулуу.
 - в. “Зөвийг Сонго” тоглоомыг тэмдэглэхэд заагч болгон ашиглах өөр, өөр өнгө, хэлбэр бүхий хоёр товч буюу өөр жижиг зүйлүүд.
 - г. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - д. Зураг 2-21, Ахлагч Рекс Д.Пинегар; зураг 2-22, Эрт Дээр Үед Ашиглагдаж Байсан Ариун Сүм (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 118; 62300).
 8. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Өөрсдийнхөө Төлөө Сонголтууд Хийж Чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

“Зөвийг Сонго” тоглоомын хөлгийг үзүүлж, тоглоомын асуултуудад хариулж чадахын тулд хичээлийг анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс.

Ярилцлага

- Хэн нэгэн хүн та нарыг ямар нэгэн зүйл хийхэд зоригжуулж байсан уу?
Хэн нэгэн хүн хүүхдүүдийг ямар нэгэн зүйл хийхэд зоригжуулж байсан тохиолдлынх нь талаар хүүхдүүдээр яриул.

Захидал

Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтэн Ахлагч Рекс Д.Пинегарын хүүхдүүдэд зориулсан захидал өөрт чинь байгааг хүүхдүүдэд хэл. Түүнийг долоон настай байхад түүнд тохиолдсон нэгэн зоригжуулалтын тухай туршлагаа

тэрээр өгүүлснийг тайлбарла. Ахлагч Рекс Д.Пинегар, зураг 2-21-ийг үзүүлж, захидлыг унших буюу үүний тухай ярь. (Хэрэв та захидлын хуулбарыг хийсэн бол үүнийгээ дугтуйнд хийж, гарын авлагаас уншихын оронд захидлаас унш.)

“Эрхэм хүндэт найз нар минь ээ,

“ ‘Чи чаддаг юм бол тэг л дээ!’ гэдэг үгийг хөвгүүд, охид чамайг зоригтой, хүчтэй, самбаатайг чинь бусдад нотлох гэсэн найз нараасаа олонтаа сонсдог. Эцэг эх чинь, эсвэл багш нар чинь битгий хий гэдэг ямар нэг зүйлийг—чиний буруу гэдгийг нь мэддэг ямар нэгэн зүйлийг хийхийг тэд чамаас хүсч болно. Буруу болохыг нь бид мэддэг ямар нэгэн зүйлийг хийхэд бид хүч чадлаа бус, харин сул талаа харуулдгийг би мэдсэн. Хүн зөвийг хийх зоригтой байгаа үед л гагцхүү жинхэнэ эр зориг, хүч чадлаа харуулдаг.

“Намайг долоо орчим настай байхад би надад их таалагддаг нэг найзтай байлаа. Бид хоёр голдуу сургуулиас гэр лүүгээ хамт явдаг байв. . . . Бид хоёр зоригтой байх тухай мөн олон зүйл хийх чадвартай байх тухай ярилцдаг байлаа.

“Заримдаа бид хоёр зоригтойгоо, эсвэл биднээс ахмад хөвгүүд, охидын хийж байхыг нь харсан зүйлүүдийг бид ч хийж чадна гэдгийг нотлохын тулд суваг дээгүүр харайх юм уу, эсвэл модонд авирахад бие биенээ басдаг байв.

“Нэг өдөр бид хоёр манай гэр лүү хүрч ирэн замын хажууд зогсон сургуулийн хамгийн хурдан гүйгч хэн байсан тухай ярилцаж байлаа. . . . Би найзаасаа илүү хурдан гүйж чадна гэж намайг улайран зүтгэхэд тэр над руу эргэж хараад, “Хэрэв чи тийм л хурдан гүйдэг юм бол, тэр машиныг энд ирэхээс өмнө замаар хөндлөн гүйгээд гараадах л даа!” гэх нь тэр.

“Би зам руу хараад, машин тун богинохон зайд байгааг харав. Би үг ч хэлсэнгүй хурдан гүйдэг, бас зоригтойгоо харуулахын тулд зам руу хар эрчээрээ харайв. Хормын дараа машины тоормос чахран дуугарав! Машинь шаврын хаалт намайг цохиж, тэгээд би ухаангүй амьтан газар мөргөн унав.

“Намайг нүдээ нээж харахад, бие маань шархиран өвдөж, бардам зан минь дарагдаж, ээжийн минь санаа нь зовсон нүүр царай намайг хурдан ч биш, зоригтой ч биш болохыг надад ухааруулж билээ. Би зөвхөн тэнэг амьтан байлаа. Би өөртөө болон өрөөл бусдад уйтгар гуниг авчирсан байлаа. . . .

“Миний авсан сургамж . . . бүхий л амьдралын маань туршид үнэ цэнэтэй байлаа. Хүн хэдийд ч хүлээн зөвшөөрч болох ганцхүү тэр зориг бол ЗӨВИЙГ ҮЙЛДЭХ ЗОРИГ мөн гэдгийг би мэдэж авсан билээ.

“Хэрэв чи ямар нэгэн зөв бус зүйл, Тэнгэрлэг Эцэг буюу эцэг эх чинь чамайг хийхийг хүсдэггүй ямар нэг зүйлийг хийх зоригтой байгаа бол чи уйтгар гунигтай, урам хугарсан мэдрэмжтэй хоцрох болно. Чи зөвийг хийхээр зориглосон үедээ өөрийнхөө тухайд сайн сайхан мэдрэмжтэй байх болно.

“Нэг найз нөгөөдөө хэлдэгийн адил эцэг эхдээ болон Их Эзэний заадаг зүйлүүдэд дуулгавартай байхад та нарыг урамшуулан дэмжиж байна. . . . Зөвийг хийхэд зоригтой байснаараа та нар Есүс Христийн найз байж, Түүний агуу адислалуудыг хүртэх болно.

“Та нар үргэлж ЗӨВИЙГ ХИЙХ ЗОРИГТОЙ байх болтугай.

“Хайраа илэрхийлсэн та нарын найз, Рекс Д.Пинегар” (“Friend to Friend,” *Friend*, 1974оны Аравдугаар сар, х. 10–11).

Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Залуу Рекс Пинегар ямар сонголт хийсэн бэ? (Тэр машины өмнүүр гүйхийг сонгосон.) • Тэр зөвийг сонгосон уу? • Тэр юу хийх ёстой байсан бэ? • Энэ ослоос тэр ямар сургамж авсан гэж та нар бодож байна? • Хэн нэгэн хүн чамайг ямар нэг юм хийхэд басамжлахад чи үүнийг хийх ёстой юу?
	<p>Ахлагч Пинегар “зөвийг хийх зоригтой бай” гэж тэдэнд хэлснийг хүүхдүүдэд сануул.</p> <ul style="list-style-type: none"> • Зөвийг хийхэд зориглох гэдэг нь юу гэсэн үг вэ? <p>Зөвийг сонгох нь үргэлж, ялангуяа хэн нэгэн нь та нарыг буруу юм хийхэд түлхэхэд үргэлж амархан байдаггүйг тайлбарла. Найз нар маань биднийг хүчтэй, зоригтой гэж бодоосой гэж бид бүгд хүсдэг бөгөөд тэд биднийг хочлохыг бид хүсдэггүй. Зөвийг хийхэд зориглох гэдэг бол зөвийг хийхэд хэцүү байгаа үед үүнийг хийх гэсэн үг гэдгийг тайлбарла.</p>
Дуу	<p>Хүүхдүүдийг босгож, “Зөвийг Хийх Зоригтой Бай” дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлүүл. Хэрэв хүүхдүүд дууг мэдэхгүй бол хүүхдүүдийг үгийг нь сурахад туслахын тулд дууг тэдэнд хэдэн удаа дуулж өгөх буюу үгийг нь хэлж өг. Дараагийн удаа хэн нэг нь тэднийг тэнэг юм хийхэд өдөн түлхвэл тэд энэ дууны үгийг санаж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Энэ дууны үг зөвийг хийхийг тэдэнд сануулж, бас зөвийг хийх зоригтой байхад нь тэдэнд туслах болно.</p>
ЗС бөгж	<p>Хэрэв хүүхдүүд бөгжөө зүүсэн бол бөгжөө харахыг хүүхдүүдээс хүс. Тэдний бөгжнүүд бас тэдэнд зөвийг сонгохоо санахад нь туслах болно гэдгийг анхааруулан хэл.</p>
Багшийн танилцуулга	<p>Буруу юм хийлгэхээр өдөн түлхэхийг уруу таталт гэдгийг хүүхдүүдэд хэлж өг. <i>Уруу таталт</i> гэдэг үгийг хүүхдүүдээр хэдэн удаа давтан хэлүүл. Хүмүүсээр буруу сонголтууд хийлгэхийн тулд Сатан тэднийг уруу татахыг хичээдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр хүн бүрийг зөв сонголтууд хийгээсэй гэж хүсдэг, учир нь аз жаргалтай байх цорын ганц зам бол үргэлж зөвийг сонгохыг хичээх явдал мөн гэдгийг тэд мэддэг билээ. Биднийг аз жаргалтай байхыг Сатан хүсдэггүй, мөн буруу сонголтууд биднийг аз жаргалгүй болгох болно гэдгийг тэр мэддэг.</p>
	<p>Сатан Есүс Христийг Буруу Сонголтууд Хийхийг Хүсдэг Байв</p> <p>Матай 4:1–11-т байдаг цөлд Есүс Христийн уруу татагдаж байсан тухай түүхийг ярь. Есүс баптисм хүртсэнийхээ дараа Тэнгэрлэг Эцэгт улам ойр байгаагаа мэдрэхийн тулд мацаг барьж, залбирахаар ганцаараа байхыг хүсчээ. Тэр дөчин өдөр, дөчин шөнө мацаг барив. Энэ бол тэр дөч хоногийн турш юу ч идээгүй гэсэн үг юм.</p> <ul style="list-style-type: none"> • Удаан хугацаагаар юу ч идэхгүй байхад та нарт ямар мэдрэмж төрдөг вэ? • Дөч хоног мацаг барьсны дараа Есүст ямар санагдаж байсан гэж та нар бодож байна вэ? <p>Есүс маш их өлссөн, бас юу ч идээгүйгээс түүний бие сул байсан учир энэ нь түүнийг уруу татахад тохиромжтой цаг мөн гэж Сатан бодож байсныг</p>

тайлбарла. Сатан түүний хүчийг буруу байдлаар ашиглахын тулд Есүсийг уруу татахыг хүсч байжээ.

Чулуунууд, цаасан титэм, Эрт Үед Ашиглагдаж Байсан Ариун Сүм, зураг 2-22-ыг гарга. Есүст Сатаны санал болгосон уруу таталтуудтай эдгээр зүйлүүд ямар холбоотой болохыг ойлгохын тулд анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс.

Чулуунуудыг өргөж үзүүл. Матай 4:3-ыг чанга унш. Сатан эхлээд чулуунуудыг Аврагчаар талх болгон хувиргуулахыг оролдов. Хэдийгээр тэр өлссөн байсан ч үүнийг хийхэд өөрийн хүчийг ашиглах нь зөв биш гэдгийг Есүс мэдэж байв. Үүний оронд Есүс хоолыг зөв зүйлийг хийхтэй адил чухал биш гэж тэрээр Сатанд хэлжээ (Матай 4:4-ийг үз).

Эрт Үед Ашиглагддаг Байсан Ариун Сүм, зураг 2-22-ыг өргөж харуул. Дараа нь ариун сүмийн орой дээрээс үсэрснээр Аврагч өөрийгөө Бурханы Хүү мөн болохыг нотлуулах гэж Сатан оролдсон гэдгийг тайлбарла. Хэрэв тэр үсэрч, тэнгэр элчүүд түүнийг гэмтэхээс аврах юм бол тэр Бурханы Хүү болохыг нотлох болно гэж Сатан Есүст хэлжээ (Матай 4:6-г үз). Сатан түүнийг өдөөн түлхэж түүгээр хийлгэх гэсэн зүйлийг хийхээс Есүс татгалзжээ. Тэнэг зүйлүүдийг хийж, Тэнгэрлэг Эцэгийн түүнийг хамгаалахыг хүсэн хүлээх нь зөв биш гэдгийг тэр мэдэж байжээ (Матай 4:7-г үз).

Титмийг өргөж харуул. Сатан дахиад нэг уруу татах гэж оролдсоныг тайлбарла. Хэрэв тэр сөхөрч, Сатаныг шүтэн биширвэл дэлхийн хаант улсуудын бүх баялгийг тэрээр авч чадна гэж Сатан Есүст хэлжээ (Матай 4:8–9-ийг үз). Есүс зөвхөн Тэнгэрлэг Эцэгийг л шүтэн бишрэх ёстой гэдгээ мэдэж байв. Тэр зайл гэж Сатанд зарлиглав.

Судар

“Эндээс зайл, Сатан аа” гэж Есүсийн хэлсэн үгийг Матай 4:10-аас чанга унш. Хүүхдүүдийг босгож, эдгээр үгсийг давтан хэлүүл.

Есүс зөв зүйлд дуртай байсан учраас үргэлж зөвийг сонгодог байсан бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн бүх зарлигуудыг дуулгавартай дагахаар амласан байлаа.

Есүсийн Нэгэн Адил Бид Зөвийг Сонгож Чадна

ЗС уриа

ЗС уриаг үзүүлж, түүн дээрх үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Үргэлж зөвийг сонгохыг хичээснээрээ бид Есүстэй илүү адилхан болдгийг тайлбарла. Хэрэв бид зөвийг сонгохыг хичээвэл Тэнгэрлэг Эцэг бидэнд туслах болно.

Нэгтгэн дүгнэх тоглоом

Хүүхдүүдэд “Зөвийг Сонго” тоглоомыг тоглоход тусал. Есүс хэрхэн үргэлж зөвийг сонгодог байсныг санах болон бас хүүхдүүд хэрхэн зөвийг сонгоход энэ тоглоом тэдэнд туслах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Ангийг хоёр багт хувааж, баг тус бүрт нэг товч буюу өөр жижиг зүйлийг ялгагч болгон өг. Баг тус бүрээр өөрийн ялгагчийг тоглоомын хөлгийн “Яв” гэсэн нүдэн дээр тавиул. Баг тус бүрийн хүүхдүүдээр өөрийн бэлтгэсэн цааснуудаас асуултуудыг ээлж, ээлжээр сонгуул (Асуултуудыг нэгээс дээш удаа хэрэглэж болно). Асуулт бүрийг уншиж, багийн гишүүдээр хамтад нь асуултад хариулуул. Хэрэв тэд зөв хариулбал, тэд өөрийн ялгагчийг асуултын ард харуулсан тоогоор ахиулан тавина. Хэрэв тэд асуултанд буруу хариулсан бол тэдний ялгагч байсан нүдэндээ хэвээр үлдэнэ.

Хэрэв баг “ЗС” нүдэн дээр буувал тэд уг нүдний дээдэх шатаар дээш авирна. Хэрэв тэд “БС” (буруу сонголт) нүдэн дээр буувал тэд уг нүдний доорх нүд рүү ухарна.

Тоглоомын асуултууд

1. Залуу Рекс Пинегар яагаад машины өмнүүр гүйсэн бэ? (*Хоёр нүдээр урагш нүү.*)
2. Ахлагч Пинегар зориг гаргасандаа баяртай байсан уу, эсвэл гунигтай байсан уу? (*Нэг нүдээр урагш нүү.*)
3. Есүс Христ цөлд хичнээн өдөр мацаг барьж залбирсан бэ? (*Хоёр нүдээр урагш нүү.*)
4. Есүсийг хэн уруу татахыг оролдсон бэ? (*Гурван нүдээр урагш нүү.*)
5. Мацаг барина гэсэн нь юу гэсэн үг вэ? (*Таван нүдээр урагш нүү.*)
6. Сатан хэдэн өөр арга замаар Есүсийг уруу татахыг оролдсон бэ? (*Хоёр нүдээр урагш нүү.*)
7. Сатан Есүсийг чулуунуудаар юу хийхийг хүссэн бэ? (*Дөрвөн нүдээр урагш нүү.*)
8. Сатан Есүсийг ариун сүмийн орой дээрээс юу хийхийг хүссэн бэ? (*Гурван нүдээр урагш нүү.*)
9. Хэрэв тэр өвдөг сөгдөж, түүнийг шүтэн биширвэл яана гэж Сатан Есүст амласан бэ? (*Таван нүдээр урагш нүү.*)
10. Сатаны түүгээр хийлгэхийг хүссэн зүйлийг Есүс хийсэн үү? (*Гурван нүд урагш нүү.*)
11. Хэн нэгэн биднээр ямар нэг буруу буюу тэнэг зүйл хийлгэхээр өдөн түлхэхэд бид юу хийхийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр биднээс хүсдэг вэ? (*Таван нүдээр урагш нүү.*)
12. Бид сонголт хийх хэрэгтэй болсон үед юу хийх ёстой вэ? (*Зургаан нүдээр урагш нүү.*)
13. Уруу таталт гэж юу вэ? (*Зургаан нүдээр урагш нүү.*)
14. Хэрэв бид буруу сонголтууд хийвэл бид баяртай байх уу, эсвэл баяр хөөргүй байх уу? (*Нэг нүдээр урагш нүү.*)
15. Хэн нэгэн хүн ямар нэгэн юм хийлгэхээр чамайг өдөөн түлхвэл чи үүнийг хийдэг үү? (*Хоёр нүдээр урагш нүү.*)

Асуултуудын хариу

1. Тэр үүнийг хий гэсэн найзынхаа түлхээсийг хүлээн авчээ.
2. Гунигтай.
3. Дөч хоног.
4. Сатан.
5. Юу ч идэх буюу уухгүй байх.
6. Гурав.
7. Чулуунуудыг талх болгох.
8. Тэр бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү мөн гэдгийг нотлохын тулд үсрэх.
9. Дэлхийн бүх хаант улсууд болон тэдний хүчийг.
10. Үгүй.

11. Зөвийг сонгох.
12. Зөвийг сонгох.
13. Ямар нэгэн буруу юм хийх түлхээс.
14. Баяр хөөргүй.
15. Үгүй.

Дүгнэлт

Багшийн
танилцуулга

Есүс Христ хэдийгээр уруу татагдаж байсан ч гэсэн тэр үргэлж зөвийг сонгодог байв. Хүүхдүүд сонголт хийх болсон үедээ “Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр юу хийхийг надаас хүсэх байсан бол?” хэмээн өөрсдөөсөө асууж байхыг тэдэнд сануул. Тэд бас “Зөвийг Хийх Зоригтой Бай” (эсвэл “Зөвийг Сонго”) дууг дуулж, ЗС бөгжнүүдээ харж болно. Эдгээр зүйлүүд зөвийг сонгохыг тэдэнд сануулах болно.

ЗС уриа

ЗС уриан дээрх үгсийг хүүхдүүдээр дахин хэлүүл.

Гэрчлэл

Зөвийг сонгох нь тэднийг баяртай болгодгийг хүүхдүүдэд гэрчил. Хэн нэгэн хүн өөрийг чинь тэнэг сонголт хийхэд өдөөн түлхэж байсан үеийн тухай та ярьж болно. Өөрийн хийсэн сонголтыг болон энэ талаар хожим нь танд ямар сэтгэгдэл төрж байсныг тайлбарла.

Хэн нэгэн хүн тэднийг ямар нэгэн тэнэг юм хийлгэхээр өдөөн түлхэх үед зөвийг сонгоход нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Доор заасан үйлдлүүдийг хийлгэн дараах үгсийг хүүхдүүдээр хэлүүлэх буюу “Хэрэв Та Нар Аз Жаргалтай Байвал” (*Children's Songbook*, х. 266) дууны аяар дуулуул:

Зөвийг сонгодгоо харуулахын тулд үнэнийг ярина би (*уруулаа зөөлөн товших [буюу алга ташиж] дороо эргэнэ*)

Зөвийг сонгодгоо харуулахын тулд үнэнийг ярина би (*уруулаа зөөлөн товшиж дороо эргэнэ*)


Аврагчийн замыг би мэднэ, миний юу хэлэхийг энэ нь харуулдаг;

Зөвийг сонгодгоо харуулахын тулд үнэнийг ярина би (*уруулаа зөөлөн товшиж дороо эргэнэ*)

“Үнэнийг ярина би” гэдгийг “Найрсаг байна би,” эсвэл “Залбирлуудаа хэлнэ би” гэсэн үгсээр сольж, та дууг хэд хэдэн удаа дуулах буюу үгийг нь хэлж болно.

2. Тэд сонголт хийх ёстой нөхцөлүүдэд зөвийг хийхийг хэрхэн зориглохыг жүжигчлэн үзүүлэхэд хүүхдүүдэд тусал. Доорх нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл өөрөө зарим нөхцөлийг зохио:

Зөвийг Сонго




Зорилго

Есүс Христийг дагах хүүхэд бүрийн хүслийг хүчтэй болгох.

Бэлтгэл

1. Матай 4:18–22, Лук 5:1–11, Иохан 14:15, 15:17-г залбиралтайгаар судал.
2. Цаасаар гурван хос хөлийн том хэв хайчил. Хөлийн хэвүүд дээр дараах үгсийг бич:
 - а. Ир / Намайг дага
 - б. Сахь / Миний Зарлигуудыг
 - в. Хайрла / Нэг Нэгнээ



3. “Ир, Намайг Дага” (*Hymns*, ду.116) дууллын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - в. Хүүхэд бүрт хоёр цаас, нэг харандаа.
 - г. Зураг 2-23, Аавынхаа Мөрөөр Явж Байгаа Хүүхэд; зураг 2-24, Загасчдыг Дуудсан нь, (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 209; 62496)
 5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христ Өөрийгөө Дагахыг Биднээс Хүсдэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

“Удирдагчийг Дага” тоглоомоор хүүхдүүдийг тоглуул. Өрөөний нэг талд хүүхдүүдийг нэг эгнээ болгон жагсааж зогсоо. Эгнээний нэг дэх хүүхэд харайх, дэвхрэх, үсрэх зэрэг өөр өөр үйлдлийг өрөөний нөгөө тал хүртэл хийнэ. Бусад хүүхдүүд эхний хүүхдийн хийж байгаа үйлдлийг давтан дагана. Тэгээд эхний хүүхэд эгнээний адагт очиж, хоёр дахь хүүхэд удирдагч болно. Хүүхэд бүр удирдагч болтол тоглоомыг үргэлжлүүл.

Өнөөдрийн хичээл дээр тэд Есүсийг дагахыг сурах болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Түүх

Аавынхаа Мөрөөр Явж Байгаа Хүүхэд, зураг 2-23-ыг үзүүлж, дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь (хэрэв ангийн чинь хүүхдүүд цас гэж юу байдгийг мэддэггүй бол өөрийн цаг уур, орчинд тохируулан энэ түүхийг хялбаршуулж болно):

Сэм аавдаа түлээний мод бэлтгэхэд нь туслахаар явжээ. Өвөл цаг байж, цасны зузаан гүнзгий байв. Сэм аавтайгаа хоёулаа тэвэр дүүрэн мод авч, гэр лүүгээ буцаад явж эхлэв. Хүнд ачаатайгаар гүнзгий цасан дундуур явах нь Сэмийн хувьд хэцүү байв. Цасан дээрх миний мөрөөр яв гэж аав нь Сэмд хэлжээ. Аавынхаа мөрөөр явах нь Сэмд хавигүй хялбар байлаа.

- Яагаад Сэм аавынхаа мөрийг дагасан бэ?
- Цасан дундуур аавынхаа мөрөөр явах нь Сэмийн хувьд яагаад амархан байсан гэж та нар бодож байна?

Судрын түүх

Загасчдыг Дуудсан нь, зураг 2-24-ийг үзүүл. Матай 4:18–22, Лук 5:1–11 дэх түүхүүдийг ярьж өг. Есүс Христ дэлхий дээр байхдаа хүмүүсийг өөрийн шавь нар буюу туслагчид байхаар дуудсаныг тайлбарла.

Та түүхийг уншихдаа Матай 4:19-ийг тохиромжтой үед нь чанга унш. Есүс “Би та нарыг хүмүүсийн загасчид болгоё” гэсэн нь хүмүүст заахад эдгээр хүмүүсийг туслагчдаа болгохыг Есүс хүсч байсан гэсэн утгатай юм.

- Эдгээр загасчид яагаад Есүсийг дагасан бэ?
- Есүс өөрийгөө дагаж, түүний шавь болохыг та нараас хүссэн бол та нар яах вэ?

Ярилцлага

Есүс Христийн шавь нараа дуудсан түүхийг Сэм, түүний аав хоёрын тухай түүхтэй харьцуул. Сэмийн аав өөрийгөө дагахыг Сэмээс хүссэн шиг Есүс өөрийгөө дагахыг бид бүгдээс хүсдэг. Хэрэв Сэм аавынхаа мөрийг дагаж явах юм бол Сэмийн хувьд хавигүй амар байхыг Сэмийн аав мэдэж байлаа. Хэрэв бид түүнийг дагах юм бол бидний амьдрал илүү хөнгөн мөн бид илүү аз жаргалтай байх болно гэдгийг Аврагч мэддэг.

- Есүсийг дагах гэдэг нь юу гэсэн үг вэ?
- Бид Есүсийг дагасан үед амьдрал бидний хувьд яагаад хөнгөн байдаг вэ?

Дуу

“Ир, Намайг Дага” дууллын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхдээ хүүхдүүдийн мэдэхгүй аливаа үгсийг тайлбарла (*даган алхах* гэх мэт).

“Ирж, намайг дага” гэж аврагч хэлэв.

Тэгээд бүгдээрээ түүний мөрөөр дагацгаая,
Учир нь Бурханы хайртай төрсөн Хүүтэй
Бид тэгээд нэг байж чадна.

Түүнтэй адил байхыг хичээ, мөн түүний зарлигуудыг дуулгавартай дагаснаар бид Есүсийг дагаж чадна гэдгийг тайлбарла. Бид түүний арга замыг мэдэж, биднээр түүний хийлгэхийг хүсдэг зүйлийг хийхдээ бид түүний мөрөөр дагаж байдаг.

Хөлийн хэвээр хийх үйл ажиллагаа

“Ирж,” “Намайг дага” гэж дээр нь бичсэн хөлийн хоёр хэвийг үзүүл. Хүүхдүүдтэй хамт үгсийг унш. Холбоо үгсийг хүүхдүүдээр хэдэн удаа давт-ан хэлүүл.

ЗС уриаг ангийнханы өмнө үзүүл. Нэг хүүхдээр хөлийн хэвүүдийг өрөөний нөгөө талд тавиул. (Хичээл цааш үргэлжлэх үед хөлийн хэвүүдийг шалан дээр тавьж, тэдгээр нь ЗС уриа дээрх Аврагчийн зураг руу хүүхэд алхаж хүрч болох зам болох ёстой.)

Зарлигуудыг Сахихыг Есүс Биднээс Хүсдэг

Судрын
ярилцлага

Есүс Христийг дагана гэдэг нь биднээр хийлгэхийг түүний хүсдэг зүйлүүдийг хийх хүсэлтэй байна гэсэн үг гэдгийг тайлбарла. Есүсийн биднээр хийлгэхийг хүссэн зүйлүүдийн нэгнийх нь тухай өөрийг чинь уншиж байх хооронд сонсохыг хүүхдүүдээс хүс.

Иохан 14:15-ыг чанга унш. Эдгээр нь Есүсийн үг гэдгийг тайлбарла. Өөртэйгөө хамт судрыг хүүхдүүдээр давтан хэлүүл.

- Биднийг юу хийх ёстой гэж Есүс хэлсэн бэ?
- Есүсийн зарлигуудыг сахина гэсэн нь юу гэсэн үг вэ?

Хөлийн хэвээр
хийх үйл
ажиллагаа

“Миний Зарлигууд,” “Сахь” гэсэн үгс бичсэн хөлийн хэвүүдийг үзүүлж, холбоо үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Эдгээр хөлийн хэвүүдийг эхний хос хөлийн хэвнээс холгүй, нэг хүүхдээр тавиул. (Хүүхэд хөлийн нэг хэвээс нөгөө рүү нь алхахаар тэдгээрийг тохирох зайд ойрхон байрлуулах хэрэгтэй.)

Ярилцлага

Тэдний Есүсийг дагаж болох зарим нөхцөлүүдийг хүүхдүүдэд зориулан тодорхойл. Нөхцөл бүрт хүүхдүүд юу хийж болохыг тэднээр ээлж, ээлжээр нь тайлбарлуул. Доорх жишээнүүдийг ашиглах буюу ангийнхаа хувьд тохирох зарим жишээг өөрөө зохио.

1. Чи сургууль дээрээ тоглож байгаад дотроо мөнгөтэй түрийвч олжээ.
 - Чи Есүсийг хэрхэн дагах вэ?
2. Чи унтахад бэлэн болсон, мөн их ядарснаас тэр даруйд унтмаар санагдаж байлаа.
 - Чи унтахаар орондоо орохоос өмнө Есүсийг хэрхэн дагах вэ?
3. Жаахан эмэгтэй дүү чинь гудамж руу гүйгээд явчихгүйн тулд чамайг түүнийг харж байгаарай гэж ээж чинь чамаас хүсчээ. Хэдэн найз чинь хүрч ирээд хамтдаа тоглохоор явцгаая гэж чамайг урьжээ.
 - Чи Есүсийг хэрхэн дагах вэ?
4. Нэг шинэ хүүхэд танай сургуульд сурч эхэлжээ, зарим хүүхдүүд түүнийг шоолдог байв.
 - Чи Есүсийг хэрхэн дагах вэ?
5. Зарим найз нар чинь тэдэнтэй хамт садан төрлүүд дээрээ очно уу гэж чамайг урьжээ, гэвч тэд чиний сүмд явдаг хугацаанд багтан эргэж ирэхгүй.
 - Чи Есүсийг хэрхэн дагах вэ?

Есүсийг дагахаар тэд сонгож болох бусад нөхцөлүүдийг тодорхойлоход хүүхдүүдийг урь. Биднээр хийлгэхээр түүний хүсдэг зүйлүүдийг бид хийснээрээ бид зөвийг сонгодгийг анхааруулан хэл.

Бие Биенээ Хайрлахыг Есүс Биднээс Хүсдэг

Судар

Есүсийн мөрөөр дагаж болох өөр арга замыг илрүүлж олоход нь хүүхдүүдэд тусалж, Иохан 15:17-г чанга унш. Эдгээр нь Есүсийн үг гэдгийг тайлбарла. Судрыг өөртэйгөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл.

- Хэнийг хайрлахыг Есүс биднээс хүсдэг вэ?

Хөлийн хэвээр
хийх үйл
ажиллагаа

Түүх

“Нэг Нэгнээ,” “Хайрла” гэж бичсэн хөлийн хэвүүдийг үзүүл. Эдгээр үгсийг хүүхдүүдтэй хамт уншиж, холбоо үгсийг тэднээр давтан хэлүүл. Хөлийн хэвүүдийг өмнөхийн нэгэн адилаар тавихыг нэг хүүхдийг хүс.

Хибер гэдэг нэртэй нэг бага насны хөвгүүн Есүс Христийг хэрхэн дагадаг байсан тухай дараах түүхийг ярих буюу уншиж өг:

Хибер хүйтэнд чичирч, нимгэн хүрэм нь түүнийг халхалсан төдий байлаа. Удахгүй түүний төрсөн өдөр болох байв, ингээд түүний хүсдэг бүх юм нь дулаан хүрэм байлаа. Гэвч тэр ээжийгээ хүрэм авч өгөөч хүсвэл ээж нь гунигтай байх болно гэдгийг мэдэж байв, учир нь түүнд хүрэм авч өгөх мөнгө байхгүй байлаа. Хиберийг бага байхад аав нь нас барсан ажээ, тиймээс Хиберийн ээж өөрсөддөө хэрэгтэй мөнгийг олохын тулд шаргуу ажилладаг байв. Тэр голдуу бусад хүмүүст хувцас хийж, шөнө дунд болтол юм оёдог байв.

Хиберийн төрсөн өдрөөр ээж нь түүнд төрсөн өдрийн баяр хүргэж, өөрийнхөө оёсон гоё хүрмийг түүнд гардуулж өгчээ. Хибер энэ хүрмийг өмсч гадаа гарч, мөн нь үүнийг хэр дулаан болохыг үзэхийг тэсч ядан хүлээж байв.

Хэдэн долоо хоногийн дараа Хибер зараалаар явж байхдаа зөвхөн ноосон цамц өмссөн нэг хөвгүүнийг харжээ. Тэр хүүхэд хичнээн их даарч байгааг нь Хибер мэдэж байв. Хибер бараг бодолгүйгээр хүрмээ тайлж, тэр хөвгүүнд өгөв.

Хиберийн ээж түүнийг хуучин хүрмээ өмсөхийг нь хараад шинэ хүрмээ яасныг нь түүнээс асуужээ.

“Энэ хүрэм надаас илүү их хэрэгтэй байгаа нэг хүүхдийг хараад би хүрмээ түүнд өгчихлөө” гэж Хибер тайлбарлав.

“Чи түүнд хуучныгаа өгч болохгүй байсан юм уу?” гэж ээж нь асуув.

Түүнийг ойлгох болов уу гэж найдан, Хибер ээж рүүгээ харвал ээжийнх нүд нулимсаар дүүрэхийг харав. Ээж нь хүүгээ чанга тэвэрч, “Мэдээж хэрэг, чи чадахгүй шүү дээ, Хибер” гэж хэлжээ. (Lucile C. Reading, “The Coat,” *Children’s Friend*, 1966 оны Арваннэгдүгээр сар, х. 5-ыг үз.)

- Хибер Есүс Христийг хэрхэн дагасан бэ?

Энэ түүхэн дэх хөвгүүн бол том болсон хойноо Сүмийн долоо дахь Ерөнхийлөгч болсон Хибер Ж.Грант байсныг хүүхдүүдэд хэл.

Ярилцлага

Бусдад хайраа харуулж болох арга замуудын талаар хүүхдүүдээр бодуул. Тэднийг санаануудыг бодоход туслахын тулд та дараах асуултууд шиг асуултуудыг ашиглаж болно:

- Хэрэв нэг хүн унаж, бэртэхийг та нар харвал хайраа харуулахын тулд яах вэ?
- Хэрэв сургууль дээр хэн нэг нь үдийн хоолгүй байвал хайраа харуулахын тулд та нар яах вэ?

Бусдыг хайрлах гэдэг нь санаа сэтгэл болон үгнээс илүү зүйл гэдгийг тайлбарла. Бид хийдэг зүйлээрээ хайраа үзүүлдэг. Хүүхдүүдийг өнгөрсөн долоо хоногийн турш бусад хүмүүст хайраа хэрхэн үзүүлсэн тухайгаа ярихыг урь.

Бид Зөвийг Сонгож, Есүс Христийг Дагах Болно

Хөлийн хэвээр
хийх үйл
ажиллагаа

Хөлийн хэвнээс хөлийн хэвэнд алхаж, ЗС уриан дээрх Есүсийн зурагны дэргэд хүрч зогсох боломжийг хүүхэд бүрт олго. Энэ долоо хоногт Есүсийг дагахын тулд хийх нэг зүйлийг хүүхэд бүрээр хэлүүл.

Бид зөвийг сонгохдоо Есүс Христийг дагадгийг хүүхдүүдэд сануул. ЗС уриа руу зааж, “Би зөвийг сонгох болно” гэсэн өгүүлбэрийг хүүхдүүдээр давтан хэлүүл.

Дүгнэлт

Үйл ажиллагаа

Хүүхэд бүрт хоёр цаас, нэг харандаа өг. Тэдний гутлыг тойруулж зуруулан, хүүхдүүдээр хос хөлийн хэв хийлгэ. Цаасны дээд талд *Би Есүс Христийг дагах болно* гэж бичих буюу хүүхдүүдээр бичүүл. Есүсийг дагах шийдвэр төгс байдлыг нь сануулж байхын тулд хөлийнх нь хэвүүдийг хүүхдүүдийн гэрт нь өгч явуул.

Гэрчлэл

Есүс Христийг дагах нь өөрийг тань хэрхэн аз жаргалтай болгосныг хүүхдүүдэд ярь. Хэрэв бид түүнийг дагавал, Есүс биднийг Тэнгэрлэг Эцэгтэй буцаад хамт дахин амьдрах замд биднийг удирдах болно гэдгийг гэрчил.

Есүсийн алхааг үргэлж дагахыг хичээхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж. Өөрсдийнхөө хөлийн цаасан хэвнүүдийн талаар эцэг эхтэйгээ ярилцахыг хүүхдүүдэд санал болго.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Есүс Христийг дагаж, зөвийг сонгоход нь хүүхдүүдэд туслаач гэж Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг тэр хүүхдэд санал болго.


Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Та үйлдлүүд (алга таших, толгой дохих буюу алхах зэрэг) хийх гэж байгаагаа хүүхдүүдэд тайлбарла. Өөрийн үйлдлийг давтан хийхийг тэднээс хүс. Нэг удаа үүнийг хийгээд, дараа нь өөр үйлдэл нэмж, энэ хоёр үйлдлийг хоёуланг нь хүүхдүүдээр давтуул. Тухай бүр шинэ үйлдлүүд нэм. Хичнээн хүүхэд зөв дэс дарааллаар санаж, давтан хийхийг үз.

Үүнийг Аврагчийг дагахтай адилтга. Бид түүний үлгэр жишээг ганцхан зүйлд биш харин өөрсдийн хийдэг юм бүхэнд дагахыг хичээх ёстой.

2. Ангийн гишүүн бүрт зориулан цаасан хэлхээ бүхий хүүхэлдэйнүүд бэлтгэ. (Ахлах насны хүүхдүүд өөрсдийнхөө хэлхээ хүүхэлдэйнүүдийг хийх сонирхолтой байж болно.) Хэсэг цаасыг баян хуур хөгжим шиг эвх. Эвхсэн цаасан дээр хүүхэлдэйг зурж (доорх зургийг хар), хүүхэлдэйг хайчил. Хүүхэд бүрт гинжин хүүхэлдэй хийж, үүний доод талд *Бие Биенээ Хайрла* гэж бич. Бие биенээ хайрлах нь Есүсийн биднээс хийхийг хүссэн хамгийн чухал зүйлүүдийн нэг мөн гэдгийг тайлбарла.



3. “Би Есүстэй Адил Байхыг Хичээнэ” (*Children’s Songbook*, х. 78), дууны эхний бадаг, “Бие Биенээ Хайрла” (*Children’s Songbook*, х. 136), эсвэл “Зарлигуудыг Сахь” (*Children’s Songbook*, х. 146) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. “Би Есүстэй Адил Байхыг Хичээнэ”, “Бие Биенээ Хайрла” дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа. “Зарлигуудыг Сахь” дууны үг дараагийн хуудсанд байгаа болно.

Зарлигуудыг Сахь

Зарлигуудыг сахь;
 Зарлигуудыг сахь!
 Үүнд аюулгүй байдал буй;
 Үүнд амар амгалан буй.
 Тэр адислалуудыг илгээнэ;
 Тэр адислалуудыг илгээнэ.
 Бошиглогчийн үгс:
 Зарлигуудыг сахь.
 Үүнд аюулгүй байдал, амар амгалан буй.

Есүс Христэд Эдгээх Хүч Байдаг

Хичээл
16

Зорилго

Есүс Христэд эдгээх хүч байдаг, мөн санваартны адислалууд өвчтөнийг эдгээж чадна гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 9:18–19, 23–26; Марк 5:22–24, 35–43; Лук 8:41–42, 49–56; Иаков 5:14–15; болон Сургаал ба Гэрээ 42:48-ыг залбиралтайгаар судал.
2. Хичээлийн төгсгөлд байгаа зургуудыг хувилах буюу тойруулан зурж, салгаж ав. Эдгээр зургууд “Би Юу Вэ?” гэдэг үйл ажиллагаанд хэрэглэгдэх болно.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи, Сургаал ба Гэрээ.
 - б. Хүмүүс өвчлөх буюу бэртэхэд тэднийг эдгээхэд анхан шатны тусламж болгон хэрэглэдэг эмчилгээний тос, боолт болон ханиадны бэлдмэл зэрэг юмсыг агуулдаг хайрцаг буюу хүүдий.
 - в. Жижигхэн шилтэй ариулан адисласан тос.
 - г. Зураг 2-25, Иайрын Охиныг Есүс Эдгээсэн нь, (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 215; 62231); зураг 2-26, Есүс Өвчтөнүүдийг Эдгээж Байгаа нь, зураг 2-27 Өвчтөнүүдийг Адислаж Байгаа нь, (62342).
4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Заримдаа Өвчилдөг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Эмнэлгийн анхны тусламжийн хайрцаг буюу хүүдийг үзүүлж, үүн дотор бид өвчлөх буюу бэртэх үед биднийг эдгэрэхэд туслах зарим зүйлүүд байдаг гэдгийг тайлбарла. Юм бүр нь чухам юу болохыг хүүхдүүдийг тааж хэлэх түлхүүрүүдийг тэдэнд өг (жишээ нь, “Энэ зүйл нянгуудыг өвчтэй газар буюу шархнаас гарган цэвэрлэхэд тусалдаг”).

Хүүхдүүд бүх зүйлийг таахад тэдэнд үүнийг үзүүлж, энэ зүйл хүмүүсийг эдгэрэхэд хэрхэн ашиглагддаг талаар товч ярь. Эцэг эхийнхээ туслалцаагүйгээр эдгээр зүйлүүдийг хэрэглэхгүй байхыг хүүхдүүдэд сануул.

Багшийн
танилцуулга

Бараг хүн болгон өвдөх буюу бэртдэгийг тайлбарла. Зарим үед бэртэх буюу өвдөх нь ердөө хэсэгхэн хугацаанд үргэлжилдэг бөгөөд бидний эцэг эхчүүд бидний төлөө анхаарал халамж тавихад хялбархан болдог боловч, зарим үед бидний өвчлөл хүнд байдаг учраас туслалцаа авахаар биднийг эмч рүү авч явах хэрэгтэй болдог.

Биднийг өвчлөхөд бидэнд тусалж чадах өөр нэг арга байдгийг тайлбарла. Есүс Христ дэлхий дээр амьдарч байхдаа олон хүмүүсийг адисалж тэднийг эрүүл болгосон юм. Тэднийг эдгээхэд тэрээр санваарын хүчийг ашигладаг байв.

Есүс Христ Өвчтөнийг Эдгээв

Судрын түүх

Иайрын Охиныг Есүс Эдгээсэн нь, зураг 2-25-ыг үзүүлж, Лук 8:41–42, 49–56 дахь Иайрын охиныг Есүс босгосон тухай түүхийг ярь (мөн Матай 9:18–19, 23–26, Марк 5:22–24, 35–43-ыг үз).

Иайр агуу итгэлтэй байсныг тайлбарла. Хэрэв Есүс ирж, өвчтэй охиныг нь адислах юм бол тэр эдгэрэх болно гэдэгт итгэж байжээ. Есүсийг Иайрын гэрт ирэхэд олон хүмүүс түүнийг тойрон бүчиж, түүний тусламжийг хүсчээ. Есүсийг өөр нэг өвчтэй эмэгтэйд тусалж байх зуур нэг эрэгтэй хүн Иайрын тухай захиастай хүрч иржээ.

Лук 8:49–50-ийг чанга унш.

- Элч Иайрт юу гэж хэлсэн бэ? (Лук 8:49-ийг үз.)
- Есүс Иайрт юу гэж хэлсэн бэ? (Лук 8:50-ийг үз.)

Есүс Иайрын гэр ирээд битгий уйл гэж хүмүүст хэлэв, учир нь охин үхээгүй байжээ. Гэвч хүмүүс Есүсийг шоолон инээлдэж, түүгээр доог дохуу хийж байв, учир нь тэд охиныг үхсэн гэж бодож байжээ (Лук 8:52–53-ыг үз).

Есүс өөрийн шавь Петр, Иаков, Иохан, Иайр, Иайрын эхнэрээс бусад бүх хүмүүсийг тэндээс холдуулжээ. Тэгээд Есүс охиныг гараараа барьж, бос гэж түүнд хэлэв. Охин орноосоо босч, бүр зүгээр болжээ.

- Есүс яагаад Петр, Иаков, Иохан болон охины эцэг эхээс бусад хүн бүрийг гэрээс гаргасан гэж та нар бодож байна? (Учир нь бусад хүмүүс түүнийг шоолж, тэрээр охиныг эдгээж чадна гэдэгт итгэхгүй байв. Тэдэнд итгэл байсангүй.)
- Иайрын охиныг Есүс яагаад эдгээх хүчтэй байсан бэ? (Түүнд санваар байв; охины эцэг эхчүүд итгэлтэй байлаа.)

Багшийн танилцуулга

Өвчтөнийг Есүс Эдгээсэн нь, зураг 2-26-г үзүүлж, хүүхдүүдийг өвчилсөн үед нь Есүс тэднийг адислахаар ирлээ гэж төсөөлөн бодвол тэдэнд ямар сэтгэгдэл төрөхийг нь тэднээс асуу. Есүс өөрийг нь дэлхий дээр амьдарч байхад дэлхийд амьдарч байсан хүүхдүүдэд маш их хайртай байсанчлан тэднийг нэг бүрчлэн хайрладаг байсныг онцгойлон хэл. Хэдийгээр одоо тэрээр дэлхий дээр байхгүй байгаа ч гэсэн санваар болон түүний нэрээр үйлдэх хүчийг тэрээр зөв шударга хүмүүст өгсөн билээ. Тэд биднийг эдгээхийн тулд яг л Есүс энд байгаа юм шигээр бидэнд адислалуудыг өгч чадна.

Санваарыг Атгадаг Хүмүүс Биднийг Адисалж Чадна

Ярилцлага

Өвчтөнийг Адислаж Байгаа нь, зураг 2–27-г үзүүл.

- Энэ зураг дээр юу болж байна вэ?

Мелкизедек Санваарыг атгадаг хүмүүс өвчилсөн хэн нэгэнд адислал өгөх үед бид үүнийг өвчтөнүүдийг адислах гэж нэрлэдгийг тайлбарла. Адислах гэдэг үгийг хүүхдүүдээр хэдэн удаа давтан хэлүүл.

Ариусган адисласан тостой шилийг хүүхдүүдэд үзүүл. Санваарыг атгагч эрэгтэйчүүдээр энэ тос тусгайлан адислагдсаныг тайлбарла. Хэн нэгэн нь

өвчилж, тэгээд эдгэрч сайжрахад нь түүнд тусламж хэрэгтэй байгаа үед Мелкизедек Санваар атгагч хоёр эрэгтэй хүн өвчтэй хүнд адислал өгөхөөр энэ тосыг ашигладаг (Иаков 5:14–15-ыг үз).

- Чи адислал авч үзсэн үү?

Тэдний авсан буюу гэр бүлүүдээ авахыг нь харсан санваарын аливаа адислалуудын талаар хүүхдүүдээр яриул. Таныг өөрийг чинь буюу эсвэл гэр бүлийн чинь гишүүнийг санваарыг атгагчид адисласан тохиолдлын талаар та хүүхдүүдэд ярьж болно.

Түүх

Санваарын адислалаар дамжуулан эдгэрсэн хүний тухай түүхийг ярь. Хүүхдүүдийн болон өөрийн чинь таних, тухайлбал, хэсгийн буюу салбарын гишүүний тухай үнэн түүх хамгийн үр дүнтэй байх болно. Хэрэв та ийм түүх мэдэхгүй бол дараах түүхийг ашиглаж болно:

Жессикаг сургуулиас гэртээ ирэхэд аав нь хаалган дээр угтаж, тэр өглөө түүний шинэ бяцхан эрэгтэй дүү төрсөн гэж хэлжээ. Тэр бяцхан хүү гарах ёстой хугацаанаасаа нилээд өмнө төрсөн бөгөөд их жижигхэн, сул дорой байлаа. Энэ хүүхэд хэдхэн цагаас илүү амьдарч чадахгүй байж мэднэ гэж эмч хэлжээ.

Аавынх нь санаа их зовсныг Жессика харж байв. Тэр бяцхан хүүг амьд байгаасай гэж хүсч байсан болохоор Жессика гунигтай байлаа.

Жессикагийн аав өөрийнхөө гэрийн багш нарын нэгэнд нь утасдаж, түүнийг ирж, бяцхан хүүд адислал өгөхөд нь туслахыг хүсчээ. Гэрийн багшийг ирэхэд, тэд бүгдээрээ Жессикагийн ээж, шинээр төрсөн дүү нь байсан унтлагын өрөө лүү оров. Жессикагийн аав, гэрийн багш хоёр шинэ төрсөн бяцхан хүүгийн жаахан толгой дээр гараа зөөлхөн тавьж, Жессикагийн аав түүнд дэлхий дээр амьдрах үүргээ биелүүлэхэд нь түүнийг адислажээ. Халуун дулаан тайтгарал хийгээд амар амгалангаар Жессика дүүрчээ. Санваарын хүчийн учир түүний бяцхан дүү өсч торнин, хүчтэй болно гэдгийг тэр мэдэж байв. (“Moments to Remember,”-ээс хялбаршуулан авав, *Children’s Friend*, 1963 оны Хоёрдугаар сар, х. 41.)

Багшийн танилцуулга

Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр эдгээгдэхийг хүсдэг хүн бүрийг хайрладаг боловч зарим үед хүмүүс адислагдсан байлаа ч гэсэн эдгэдэггүй. Зарим хүмүүс эдгэрдэггүй, учир нь тэд өвчтэйгөө буюу эсвэл тахир дутуу байдалтайгаа амьдарч сурснаар илүү хүчирхэг хүмүүс байж чадна гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэддэг. Бусад зарим хүмүүс эмчлэгддэггүй, учир нь нас барах болон Тэнгэрлэг Эцэгт буцаж очих зөв цаг нь тэдний хувьд ирсэн байдаг (С ба Г 42:48-ыг үз). Залбирал бүрт тохирох хамгийн сайн хариуг Тэнгэрлэг Эцэг мэддэг гэдэгт бид итгэлтэй байх ёстой.

Үйл ажиллагаа

Хэд хэдэн хүүхдийг ангийн өмнө гаргаж, “Би Юу Вэ?” үйл ажиллагааны зургуудыг бариулан зогсоо. Зургууд юуг төлөөлж байгааг хүүхдүүдээр хэлүүл.

Өвчтөнийг адислахад ордог юмс болон хүмүүсийн тухай зарим тодорхойлолтуудыг та уншиж өгөх гэж байгаагаа тайлбарла. Аль зураг ямар тодорхойлолтод тохирч байгааг хүүхдүүдээр олуул.

1. Өвчтэй хүнд адислал өгөхөд намайг хэрэглэдэг. Санваар атгагч нь өвчтэй хүний толгой дээр надаас хэдэн дуслыг түрхдэг. Би юу вэ? (Ариулан адисалсан тос.)
2. Хэрхэн амьдрахыг нь хүмүүст би үзүүлдэг. Надад итгэх итгэл өвчнийг даван туулахад нь хүмүүст тусалдаг. Би хэн бэ? (Есүс Христ.)

3. Надад онцгой адислал хэрэгтэй байна. Би халуунтай байна. Бие маань сайжрахад туслахын тулд надад адислал өгөхийг би ааваасаа гуйсан. Би хэн бэ? (Өвчтэй хүүхэд.)
4. Санваар гэж нэрлэгддэг тусгай хүч надад өгөгдсөн. Хүмүүст адислал өгөхийн тулд би энэ хүчийг ашиглаж болно. Би хэн бэ? (Мелкизедек Санваар атгадаг хүн.)
5. Өвчтэй хүн адислал хүсэхэд Мелкизедек Санваар атгадаг эрэгтэйчүүд дуудагддаг. Ихэвчлэн тодорхой тооны эрэгтэйчүүд оролцдог. Би бол тэр тоо нь. Би юу вэ? (2-ын тоо.)
6. Санваарыг атгадаг хүмүүс өвчтөнүүдийг адислах үед намайг өвчтэй хүний толгой дээр тавьдаг. Би юу вэ? (Гар.)

Дүгнэлт

Нэгтгэн дүгнэх
ярилцлага

Эмнэлгийн анхны тусламжийн цүнх буюу савыг дахин үзүүл.

- Эдгээр зүйлүүдийг бид юунд ашигладаг вэ?
- Биднийг өвчлөх юм уу бэртэхэд өөр юу биднийг эдгэрэхэд бидэнд тусалж болох вэ?

Гэрчлэл

Есүс Христ болон түүний эдгээх хүчний агуу чанарын тухай гэрчлэлээ хэл. Биднийг өвчлөх үед биднийг адисалж болох учраас Мелкизедек Санваар атгагч зөв шударга хүмүүсийг Есүс өгсөнд та хичнээн их талархалтай байдгаа хүүхдүүдэд хэл.

Сурсан зүйлээ гэр бүлүүдтэйгээ хэрхэн хуваалцаж болох талаар бодож үзэхийг хүүхдүүдээс асуу. Аврагч Иайрын охиныг хэрхэн эдгээсэн тухай түүхийг гэрийнхэндээ ярихад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Самбар дээр *Эдгээх бэлэгт бид итгэдэг* гэж бичээд Иосеф Смит энэхүү агуу үнэнийг итгэлийн долдугаар тунхагийн нэг хэсэг болгон бидэнд өгснийг тайлбарла. Хүүхдүүдийг босгож, энэ өгүүлбэрийг давтан хэлүүл. Нэг удаад нэг юм уу хоёр үгийг арилгаж, үүнийг цээжлэхэд нь тэдэнд тусал. Эцэст нь энэ өгүүлбэрийг цээжилж, бүрэн арилгах хүртэл хүүхдүүдээр үргэлжлүүлэн давтан хэлүүл.
2. Дор харуулсан үйлдлүүдийг хийж, “Итгэл” (*Children’s Songbook*, х. 96) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэл. Эдгэрэхэд итгэл чухал ач холбогдолтойг хүүхдүүдэд сануул.




Итгэл бол шинэ өдөр бүрийг гэрэлтүүлэх (гараа мөр лүүгээ алгуурхан буулгана),

нар мандахыг мэдэх явдал билээ (толгой дээрээ гараараа тойрог үүсгэнэ).

Итгэл бол намайг залбирах бүрт залбирлуудыг минь (*залбирч байгаа юм шиг гараа цээжиндээ авна*)

Их Эзэн сонсоно гэдгийг мэдэх явдал юм (гараа чихний ард хөмөрнө).
 Итгэл бол бяцхан үртэй адил юм (*Зүүн гараа аяга мэт дээш харуулж,
 баруун гараараа үр тарьж байгааг дүрсэлнэ*):
 Тарьсан бол ургана (*аяга хэлбэртэй болгосон зүүн гараас баруун
 гараараа ургаж байгааг дүрсэлнэ*)
 Итгэл бол зүрх сэтгэлийн минь өсөлт юм (*гараа зүрхэн тушаа тавина*).
 Хэзээ зөвийг үйлдэхээ (*заагуур хуруугаараа дээш заана*).
 Би мэднэ (*баруун заагуур хуруугаар толгойдоо хүрнэ*).

3. 3 Нифай 17:5–9 дэх Есүс Христийн Нифайчуудыг эдгээсэн тухай түүхийг ярь. Хэрэв боломжтой бол уг түүхийг дүрслэн үзүүлэхийн тулд Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга дахь зураг 317-г (эсвэл цуглааны байрны номын сан дахь 62541) ашигла. Хүүхдүүдээр өөрсдийнх нь нүд, чих, хөл зэрэг Есүсийн эдгээсэн зарим эрхтнүүд дээр нь хүргүүл. Есүс тэднийг эдгээхэд Нифайчуудад хичнээн гайхамшигтай сайхан мэдрэмжтэй байсан тухай хүүхдүүдтэй ярилц. Шүлэг 8-ын сүүлчийн хэсгийг (*учир нь би харж байна* гэснээс) чанга уншиж, Есүс Христэд итгэлтэй байхын чухлыг хүүхдүүдэд сануул.
4. Хичээлийн төгсгөл дэх зургуудын хувь буюу хуулбарыг хүүхэд бүрээр хийлгэ. Хүүхдүүдэд будгийн харандаанууд өгч, зургуудыг будуул. Санваарын адислалуудаар дамжуулан өвчтэй хүмүүс хэрхэн эдгэрч болохыг гэрийнхэнтэйгээ ярилцахад зургуудыг ашиглахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.



2



Зорилго Санваар бидэнд хэрхэн тусалж болохыг ойлгоход хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Марк 4:35–41-ийг залбиралтайгаар судал. Тэрчлэн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 13-ыг бас үз.
2. “Эзэн, Шуурга Догширч Байна” (*Hymns*, ду.105) найрал дуу болон дууллын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Мөн тэрчлэн зарим хэцүү үгсийн утгыг хүүхдүүдэд тайлбарлахад бэлтгэ.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Гар чийдэн буюу эсвэл жижиг дэнлүү. Үүнийг авчрах боломжгүй бол анги дахь гэрлийн чийдэнг ашиглаж болно.
 - в. Зураг 2-20, Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн; зураг 2-27, Өвчтөнүүдийг Адисалж Байгаа нь, (62342); зураг 2-28, Шуургыг Намдаасан нь, (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 214: 62139); зураг 2-29 Ариун Ёслолыг Түгээсэн нь, (62021); зураг 2-30, Гишүүнээр Батлагдаж Байгаа Охин (62020); зураг 2-31 Нялх Хүүхэд Адисалж Байгаа нь; зураг 2-32, Шинэхэн Гэрлэсэн Хос Ариун Сүмийн Өмнө; зураг 2-33 Охиноо Адисалж Байгаа Аав.
4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Анхааруулга: Эцэггүй буюу эцэг нь санваарыг атгадаггүй ангийнхаа хүүхдүүдийн санаа бодолд мэдрэмтгий ханд.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Санваар Бол Хамгийн Агуу Хүч

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хүч гэдэг үгийн утгыг дүрслэхэд туслахын тулд гар чийдэн, жижиг дэнлүү буюу анги дахь гэрлийн чийдэнг ашигла. Ярилцлагыг эхлэхдээ гэрлийг унтраасан бай. Хэдийгээр бүх хэсгүүд нь зохих ёсоороо байгаа ч гэсэн гар чийдэн буюу чийдэн гэрэл өгөхгүй байгааг анхааруулан хэл.

- Гэрэл асахын өмнө яах ёстой вэ?

Гэрлийг залгахад юу болдгийг хүүхэд бүрээр үзүүл. Гар чийдэн буюу чийдэн нь гэрэл өгөхийн өмнө цахилгааны хүчдэлд холбогдох ёстойг тайлбарла.

Судрын түүх

Энэ хичээл бол өөр нэг хүч, цахилгааны эрчим хүчнээс илүү агуу хүчний тухай болохыг хүүхдүүдэд хэл. Дараах түүхийг сонсож, ямар хүч энд ашиглагдсан тухай бодохыг хүүхдүүдээс хүс. Марк 4:35–41 дэх түүхийг ярь.

- Хэрэв та нар хүчтэй шуурганы үеэр завин дээр байсан бол та нарт ямар санагдах байсан бэ?

Шуурганаас айсан учир шавь нар нь Есүс Христийг сэрээснийг тайлбарла. Марк 4:38-ын сүүлчийн хэсэгт шавь нарын Есүсээс асуусан зүйлийг (Эзэн гэдгээс эхлэн) чанга унш. Шуурга завийг живүүлж, бүгдээрээ үхэх болно гэж шавь нар нь айсан байлаа.

Шуургыг Намдаасан нь, зураг 2-28-ыг үзүүлж, Есүсийн юу хийснийг ойлгохын тулд Марк 4:39-ийг чанга унш. “Чимээгүй, намд” гэсэн Есүсийн үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл.

Шуурга тийм хурдан намдсанд шавь нар нь гайхсаныг тайлбарла. Марк 4:41-ээс: “Салхи болон далай хүртэл түүнд захирагдаж байдаг Тэр ер нь хэн юм бэ?” гэж тэд бие биенээсээ асуусныг чангаар унш. Салхи болон давалгаануудыг хянах хүч түүнд байсанд Есүсийн шавь нар гайхжээ.

Дуу

“Эзэн, Шуурга Догширч Байна” дууны эхний бадаг болон дахилтыг дуулах буюу үгийг нь хэл. Эхлэхээсээ өмнө энэ дуу бол дөнгөж сая тэдний сонссон түүхийн тухай дуу мөн гэдгийг хүүхдүүдэд хэл. Дахилтан дахь Есүсийн үгсийг (“Чимээгүй, намд”) сонсохыг тэднээс хүс. (Энэ дууны үг бага насны хүүхдүүдэд ойлгоход нь хүнд байж болох хэдий ч, дууны утгыг ойлгоход нь Сүнс тэдэнд тусалж чадна. Зарим илүү хүнд үгсийг та хүүхдүүдэд тайлбарлаж болно.)

Та дуулах буюу дууны үгийг хэлж байхдаа үггүй жүжгийн янз бүрийн үйлдлийг хийхэд нь хүүхдүүдэд тусалж болно. Хэрэв тэд завинд байгаа мэт урагш хойш дайвалзан хөдлөх, гараараа давалгаатай адил хөдөлгөөн хийх, шавь нарын нүүрэн дээрх айдсыг харуулах зэрэг хөдөлгөөн буюу үйлдлийг харуулж болно.

Эзэн минь, шуурга ширүүсч байна!
 Давалгаа өндөрт хуйларч байна!
 Тэнгэр бараантан сүүдэртэж байна.
 Оромж, тусламж ойр алга.
 Бидний үхэх нь танд хамаагүй гэж үү?
 Бөх гэгч нойрсож та яаж чадна вэ
 Хилэгнэлийн гүн булш
 Хором бүр догшрон заналхийлж байхад?

Дахилт:

Салхи хийгээд давалгаа таны хүслийг дагах болно:
 Чимээгүй, намд.
 Далайд шидэгдэх шуургын хилэгнэл ч
 Чөтгөр ч, хүмүүн ч ер юу ч байсан,
 Далай, тэнгэр, газрын Эзэн минь
 Дээр нь хэвтэж байгаа завийг ус залгиж чадах нь үгүй.
 Тэд таны хүслийг аятай сайхнаар дагана:
 Чимээгүй, намд; чимээгүй, намд.
 Тэд таны хүслийг аятай сайхнаар дагана:
 Чимээгүй, чимээгүй, намд.

- Шуургыг зогсоох боломжийг түүнд олгосон ямар агуу хүч Есүс Христэд байсан бэ? (Тэнгэрлэг Эцэгийн нэрээр үйлдэх хүч болох санваарын хүч.)

Санваар гэдэг үгийг хүүхдүүдээр чанга хэлүүл.

Бид Санваараар Адислагдаж Чадна

Багшийн
танилцуулга

Сүмд олон эрэгтэйчүүдэд яг ийм хүч байдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр санваарыг Сүмийн зохистой эрэгтэйчүүдэд өгсөн юм. Эдгээр эрэгтэйчүүд Тэнгэрлэг Эцэгээр чиглүүлэгдсэн үед тэд санваарыг бидэнд туслах болон биднийг адислахад ашиглаж чадна.

- Санваар атгадаг хэнийг та нар мэдэх вэ?

Зураг дээрх
ярилцлага

Санваарын ёслолуудын тухай зургуудыг нэг нэгээр нь үзүүл. Зургуудыг хүүхдүүдээр өргүүлж заалган, тус бүр дээр нь болж байгаа зүйлийг ярихад нь хүүхдүүдэд тусал. Эдгээр бүх зүйлүүд санваарыг атгадаг эрэгтэйчүүдээр хийгддэгийг онцлон хэл. Эдгээр ёслолуудын талаар хүүхдүүдэд тохиолдсон аливаа туршлагынх нь талаар тэднээр яриул.

Өвчтөнийг Адислаж Байгаа нь, зураг 2-27-г үзүүл. Өвчтөнийг адислах талаар хичээл 16-д хүүхдүүдийн сурсан зүйлүүдийн тухай тэдэнд сануул. Санваарыг атгадаг хүмүүс өвчтэй хүмүүст бие нь сайжрахад туслахын тулд адислалууд өгч чадна гэдгийг санахад нь хүүхдүүдэд тусал.

- Та нар өвчтэй байсны улмаас адислагдаж үзсэн үү?

Ариун Ёслол Түгээж Байгаа нь, зураг 2-29-ийг үзүүл. Аароны Санваар дахь санваартнууд буюу Мелкизедек Санваар атгадаг эрэгтэйчүүд ариун ёслолыг адисладаг бөгөөд Аароны Санваар дахь диконууд ариун ёслол түгээдгийг тайлбарла. Ариун ёслолд тусалдаг өөрсдийн гэр бүлийн ахмад гишүүд буюу найз нарынх нь тухай хүүхдүүдээр яриул.

Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн, зураг 2-20-ийг үзүүл. Есүс Христ ингэсний нэгэн адил бид бүгд санваар атгадаг нэг эрэгтэй хүнээр баптисм хүртсэнийг хүүхдүүдэд сануул. Иохан Баптист санваарыг атгадаг байсан, тиймээс тэр Есүст баптисм хүртээх боломжтой байлаа.

- Та нараас хэн нэгэн чинь баптисмд байж үзсэн үү? (Хэрэв хүүхдүүдээс хэн нэг нь баптисм хүртсэн бол та баптисмынх нь талаар тэднээр яриулахыг хүсч болох юм.)

Гишүүнээр Батлагдаж Байгаа Охин, зураг 2-30-ийг үзүүл. Тэднийг баптисм хүртсэний дараа тэдний хүн нэг бүрийг Мелкизедек Санваар атгадаг эрэгтэйчүүд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлах болно. Энэ үед тэдэнд санваарын хүчээр дамжуулан Ариун Сүнсний бэлэг өгөгддөг.

Хүүхдийг Адисалж Байгаа нь, зураг 2-31-ийг үзүүл. Сүмд нялх хүүхдүүдэд нэр өгөх үед тэд санваарын адислалууд хүлээн авч болно гэдгийг хүүхдүүдэд сануул. Энэ байдлаар саяхан адислагдсан тэдний мэдэх нэг хүүхдийн тухай хүүхдүүдээр яриул. (Хүүхдүүдийн зарим нь нялх байхдаа ийм байдлаар адислагдаагүйдээ санаа нь зовж байгаа бол санваарын адислалуудыг хүлээн авах өөр бусад олон боломж тэдэнд байх болно гэдэгт тэднийг итгүүл.)

Шинэхэн Гэрлэсэн Хос Ариун Сүмийн Өмнө, зураг 2-32-ыг үзүүл. Хүүхдүүд том болсон хойноо ариун сүмд гэрлэхээр явах боломжтой байх болно гэдгийг тайлбарла. Холболт хийх санваарын хүчийг атгадаг эрэгтэйчүүд зөв шударга хосуудыг ариун сүмд гэрлүүлдэг. Ариун сүмийн гэрлэлт гэр бүлийг үүрд мөнхөд хамтад нь байлгах боломжийг олгодог.

Түүх

Тэдэнд ямар нэг асуудал тулгарахад тэд санваарын адислал хүлээн авч болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Охиноо Адислаж Байгаа Аав, зураг 2-33-ыг үзүүлж, асуудал тулгарах үед санваарын хүчээр адислагдсан охины тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:

Сюзан сургуульд явах анхныхаа өдөрт бэлтгэж байлаа. Тэр сургуулиа эхлэхэд сэтгэл догдолсон байсан боловч эцэст нь тэрхүү анхны өдөр ирэхэд тэр айсан ажээ.

Сюзан өглөөжингөө чимээгүй байлаа. Ээж нь түүний дуртай өглөөний хоолыг хийсэн боловч Сюзан үүнийг хараад инээмсэглэсэнгүй. Тэр идэхийг хичээсэн боловч, чадсангүй.

Сюзан өвчтэй байна гэж ээждээ хэлэв. Тэр халуураагүй байгаа гэж ээж нь толгойг нь барьж үзэв. Тэр бас хоолойг нь харсан боловч улаан биш байв. Хаана нь өвдөж байгаа Сюзаны ээж асуулаа. Сюзан зүгээр л дотроо хөгжилтэй байна гэж хэлжээ.

Тэр өдөр сургуулийн анхны өдөр учраас түүнийг дотроо хөгжилтэй байгаа байх гэж Сюзаны аав хэлжээ. Тэр бүхэл өдөржингөө гэрээсээ хол байна гэж бодсоноос бас юу хүлээж байгааг мэдэхгүй байснаас бага зэрэг айсан байжээ. Сюзаны аав шинэ ажлаа эхлэхэд мөн адилхан мэдрэмжтэй байснаа тайлбарлажээ.

Сюзаны аав түүнийг сургуульд явахаас нь өмнө түүнд адислал өгье гэжээ.

Адислал Сюзанд байсан айдас, хөгжилтэй мэдрэмжийг зайлуулж туслах ажээ. Сюзаны аав гараа түүний толгой дээр тавьж, түүнд тусгай адислал өгөв.

Тэр үдээс хойш Сюзан гэртээ ирэхдээ баяртай байлаа. Сургууль түүнд таалагдлаа, бас багш нь их сайхан юм гэж тэр ээждээ ярьсан аж. Аав нь Сюзаныг сургууль дээрээ сайхан байхад тусалж түүнд тусгай адислал өгсөнд баяртай байлаа.

Ийм төрлийн адислалыг эцгийн адислал гэж нэрлэх нь олонтаа байдгийг тайлбарла. Хэрэв бидний аавууд бидэнд адислал өгөх боломжгүй бол бид өөрсөддөө адислал хэрэгтэй болсон үед гэрийн багш нар, гэр бүлийн бусад гишүүд, эсвэл бишоп буюу салбарын ерөнхийлөгч зэрэг Мелкизедек Санваар атгадаг бусад эрэгтэйчүүдээс адислал өгөхийг хүсч болно.

Дүгнэлт

Зураг дээр нэгтгэн дүгнэх нь

- Санваарын адислал бидэнд хэзээ хэрэгтэй байж болох буюу хэзээ бид үүнийг хүсч болох вэ?

Зураг тус бүрийг үзүүлж, дүрсэлж байгаа ёслолыг хүүхдүүдэд хэлж өг. Ёслол буюу адислал бүрийн нэрийг хүүхдүүдээр хамтад нь чангаар хэлүүл. Энэ бол санваарын хүчний бидний төлөө хийж чадах зүйлүүдээс хэдхэн нь гэдгийг хэл.

Гэрчлэл

Амьдралд маань бидэнд туслах Есүст байсан тэрхүү хүч—санваарын хүч бидэнд байгаад талархал илэрхийлсэн гэрчлэлээ хэл.

Хүүхдүүдэд адислал хэрэгтэй болсон үед аав нараасаа (эсвэл Мелкизедек Санваар атгагч өөр хэн нэгнээс) санваарын адислал хүсэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Санваарын адислалуудын төлөө талархал илэрхийлэхийг уг хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт

буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр хүүхдэд нэр өгөх болон хүүхдийн адислалын тухай яриулахаар ангийн нэг хүүхдийн эцэг эхийг урь. Тэд нялх хүүхдийг хэрхэн гоё сайхан хувцасласан болон гэрийн багш нар, гэр бүлийн гишүүд болон ойр дотны бусад найз нараа ёслолыг үзүүлэх буюу оролцуулах ямар байсныг ярихыг хүс. Мөн хүүхдэд нэр өгөх болон адислал өгөхөд санваарын хүчийг ашиглах боломжтой байсан нь ямар санагдаж байсан тухай ярихыг тэр ааваас хүс.
2. Марк 4:35–41 дэх түүхийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул.
3. Хүүхдүүдэд цаас, будгийн болон балын харандаанууд өг, тэгээд ариун ёслол түгээх мэтийн санваарын аль нэг ёслолын зургийг хүүхэд бүрээр зуруул. Хүүхэд бүрийн зургийг дүрсэлсэн ёслолын нэрээр нэрлэ.
4. Санваарын ёслолуудын тухай дараах дуунуудаас нэгийг нь буюу түүнээс илүүг дуулах буюу үгийг нь хэлүүл: “Санваар Сэргээгдсэн нь” (*Children’s Songbook*, х. 89), “Би Ариун Ёслол Хүртэхийн Өмнө” (*Children’s Songbook*, х. 73), “Би Ариун Сүмийг Харах Дуртай” (*Children’s Songbook*, х. 95), “Баптисм” (*Children’s Songbook*, х. 100), “Ариун Сүнс” (*Children’s Songbook*, х. 105). “Баптисм,” “Ариун Сүнс” дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.

Санваар Сэргээгдсэн нь

Санваар сэргээгдэв,
Үнэн хүмүүнд мэдэгдэв,
Тэгснээр Бурхан дэлхийд ярив
Түүний хүч дахин энд ирэв.

Би Ариун Ёслол Хүртэхийн Өмнө

Би ариун ёслол хүртэхийн өмнө нам гүм суудаг.
Есүс дэлхийд ирж миний төлөө нас барсныг би мэднэ.

Есүсийн мэддэг байсан хөвгүүд охидын тухай би боддог,
Эрт үед дэлхий дээр алхаж байсан түүний өдрүүдийг.

Би ус талхыг хүртэж Галилд Есүсийн
Хайрладаг байсан тэр хүүхэд шиг байхыг ихэд хичээдэг.

Би Ариун Сүмийг Харах Дуртай

Би Ариун Сүмийг харах дуртай
Би нэгэн өдөр тийшээ очно
Ариун Сүнсийг мэдрэхээр,
Сонсож бас залбирахаар.
Учир нь ариун сүм Бурханы өргөө юм,
Хайр, үзэсгэлэнгийн газар юм.
Багаасаа би өөрийгөө бэлтгэнэ;
Энэ бол миний ариун үүрэг.

Би ариун сүмийг харах дуртай.
Би нэг өдөр дотор нь орно.
Би Эцэгтэйгээ гэрээнд орно
Би дагахыг амлана.
Учир нь ариун сүм ариун газар юм
Тэнд бид хамтдаа лацдан холбуулдаг

Зорилго

Тэнгэрлэг Эцэг бидний залбирлуудыг үргэлж сонсож тэдгээрт шилдэг арга замаар хариулдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Лук 1:5–17-г залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 8-ыг үз.
2. “Би Хурдан Дагана” (*Children’s Songbook*, х. 197) дууны бүх гурван бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
3. Тэнгэрлэг Эцэг залбирлын чинь хариуд өөрт чинь тусалсан хувийн туршлагаа хуваалцахад бэлтгэ.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Зураг 2-34, Иохан Баптистад Нэр Өгсөн нь.
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Тусламжийн Төлөө Залбирч Болно

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Хүүхдүүдийн хамт “Би Хурдан Дагана” дууны бүх гурван бадгийг дуулах буюу үгийг нь хэл.

- Бид яагаад эцэг эхээ болон Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагах ёстой вэ? (Бидэнд хамгийн сайн болох зүйлийг хийхэд тэд бидэнд тусалж чадах учраас.)

Түүх

Дараах түүхийг ярь:

Мередит нэг шөнө муухай зүүд зүүдэлжээ. Тэр төөрч тэгээд айсан байлаа гэж зүүдэлжээ. Тэр сэрээд уйлсан байна.

- Хэрэв чи Мередит байсан бол яах вэ?

Мередит аавыгаа дуудахад, аав нь орж ирээд түүнийг тэвэрчээ. Мередит аятайхан болж, тэгээд буцаад унтжээ.

- Яагаад Мередит аавыгаа дуудсан бэ? (Түүнд тусламж хэрэгтэй байсан бөгөөд аав нь түүнд тусална гэдгийг тэр мэдэж байв.)
- Чамд тусламж хэрэгтэй болоход чи хэнийг дууддаг вэ? (Хариултууд нь Тэнгэрлэг Эцэг, эцэг эх, гэр бүлийн бусад гишүүд, найз нар байж болно.)
- Бид Тэнгэрлэг Эцэгийг хэрхэн дуудаж, түүний тусламжийг яаж хүсдэг вэ? (Залбирах.)

	<p>Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн болж өссөн Жон А.Видцогийн тухай дараах түүхийг хүүхдүүдэд ярь:</p> <p>Түүнийг бага байхад Жоны аав нас барж, Жоны ээж хүүхдүүдээ тэтгэхийн тулд шаргуу ажиллажээ. Жон ээждээ туслахын тулд ажил олж хийхийг хүсдэг байлаа. Хичээлийнхээ дараа хийх ажил олох нь хэцүү байсан боловч, эцэст нь нэг ажил олов. Нэг өдөр ажлынх нь дарга нь Жонийг хэдэн долоо хоногийн туршид сайн ажил хийлээ гэж хэлээд, цалинд нь таван алтан долларын зоос өгчээ.</p> <p>“Таван доллар! Энэ чинь мөнгө шүү дээ! Би баяртай байлаа! Би мөнгөнийхөө хагасыг ээждээ өгье; би шинэ ном худалдаж аваад, үлдсэнийг нь хадгалж болно. Би өмднийхөө халаасанд гэрэлтсэн шинэ алтан зоосоо хийгээд азтай учралынхаа талаар ээждээ ярихаар ухасхийн харайлаа.</p> <p>“Гэр лүүгээ явах замдаа би халаасандаа гараа хийж . . . мөнгөө тэмтэрч үзэв. Мөнгө маань байдаггүй! Би бүхэл халаасаа дахиад л нэгжиж үзэв. Алтан зоос тэнд байдаггүй! Үүний оронд зоос доош унасан цоорхойг би халаасан дотроо оллоо. Тун тоогүй юм болжээ! Надад тун их гунигтай санагдаж тэгээд би сувгийн эрэг дээр суугаад уйлж гарлаа.</p> <p>“Жон алтан зоосоо хайж замаараа буцав. Түүний ирсэн явган зам банзан зам байсан бөгөөд тэр банз бүрийн завсрыг сайтар шагайн харж явлаа. Гэвч тэр мөнгөө олсонгүй. Эцэст нь тэрээр мөнгө бүр хаягдаж дээ гэж бодов.</p>
<p>Үйл ажиллагаа (сонголтоор)</p>	<p>Хаягдсан зоосыг эрж байгаа Жон мэтээр анги дотуур хэдэн агшинд хүүхдүүдийг явуул. Тэгээд тэднийг суудалд нь буцаан суулга.</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэв та нар Жон байсан бол дараа нь яах байсан бэ?
<p>Түүхийн үргэлжлэл</p>	<p>Жон ярьсан нь: “Тэгээд би алтан зоос хаана байгааг Их Эзэн мэдэж байгааг саналаа, хэрэв тэр надад туслах юм бол, намайг үүнийг олоосой гэж хүсэх юм бол, мөнгө бүр хаягдахгүй байх сан гэдгийг саналаа.</p> <p>“Тэгээд би нэг том модны ард өвдөг сөгдөн, өөртөө тохиолдсон золгүй явдлын тухай Их Эзэнд хэлж, хэрэв тэрээр алтан зоосыг олоход надад туслахыг миний төлөө хийх хамгийн сайн зүйл гэж бодож байна уу гэдгийг түүнээс асуулаа. Намайг босоход надад их сайхан санагдаж байлаа. Их Эзэн залбирлыг минь сонссон гэдэгт би бат итгэж байлаа.</p> <p>“[Харанхуй болж байлаа]. Газар дээрх ямар ч юм, ялангуяа жижигхэн алтан зоос сайн харагдахааргүй байв. Гэвч би энэ удаад аажуухан явав, учир нь Их Эзэн надад туслах болно гэдгийг би мэдэж байлаа. Замын хоёр дахь хэсгийн хагасыг хүртэл тэнд өвсөн дотор хаясан таван долларын алтан зоос маань хэвтэж байлаа. . . . Баярласандаа болоод би бараг л хашгирчих шахав. Ээж маань хичнээн их баяртай байх бол, худалдаж авахаар төлөвлөсөн ном минь надад хичнээн их таалагдах бол. Би хашааг налж зогсоод, ‘Мөнгөө олоход минь тусалсанд Их Эзэн Танд баярлалаа’ гэж хэлэв.</p> <p>“Их Эзэн залбирлуудыг сонсдог гэдгийг би тэр үеэс хойш мэддэг болсон. Тэгээд тэр өдрөөс хойш, халаасандаа цоорхойтой байхаас болгоомжилдог болсон” (Жон А.Видцо “The Lost Gold Piece,” <i>Children’s Friend</i>, 1947 оны Есдүгээр сар, х. 369).</p>
<p>Ярилцлага</p>	<ul style="list-style-type: none"> • Зоосныхоо талаар Жон хичнээн удаа залбирсан бэ? • Эхлээд Жон юуны төлөө залбирсан бэ? (Мөнгөө олоход нь түүнд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхын тулд.)

- Жоны залбирлын хариу юу байсан бэ?
- Яагаад Жон хоёр дахь удаагаа залбирсан бэ? (Өөртөө тусалсанд нь Тэнгэрлэг Эцэгт талархахаар.)
- Та нарыг залбирахад Тэнгэрлэг Эцэг та нарт хэрхэн тусалсан бэ?

Багшийн
танилцуулга

Яг бидний дэлхийн эцэг эхчүүдийн нэгэн адил, Тэнгэрлэг Эцэг биднийг хайрлаж, бидэнд туслахыг хүсдэгийг хүүхдүүдэд онцгойлон хэл. Биднийг тусламж хүсэхэд Тэнгэрлэг Эцэг биднийг сонсох болно. Тэнгэрлэг Эцэг залбирлын чинь хариуд өөрт чинь тусалсан үеийн тухай хүүхдүүдэд ярь.

Залбирлууд Өөр Өөр Байдлаар Хариулагддаг

Судрын түүх

Библийг өргөж үзүүлээд, дараагийн түүхийг Библиэс үзэх болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

Иохан Баптистад Нэр Өгсөн нь, зураг 2-34-ийг үзүүлж, Лук 1:5–17 дахь түүхийг ярьж өг.

Захариа, Элизабет хоёр зөв шударга хүмүүс байсныг, мөн тэд хүүхэдтэй болохын тулд олон жил залбирсныг тайлбарла. Одоо тэд хоёул өтөлжээ, гэтэл тэд хүүхэдгүй хэвээр байлаа.

Захариа ариун сүмд тэнгэр элчийг анх хараад гайхаж, бас ялигүй айсныг тайлбарла. Лук 1:13–14-гоос тэнгэр элчийн Захариад хэлсэн зүйлийг чанга унш. Тэнгэр элчийн амласан зүйл биелэгдэж, Захариа, Элизабет хоёр хүүхэдтэй болсныг тайлбарла.

Тэнгэрлэг Эцэг Захариа, Элизабет хоёрын бүх залбирлуудыг сонсож байсныг онцлон хэл. Гэвч энэ үеийг хүртэл тэдэнд хүүхэд төрөх цаг нь болоогүй байжээ. Тэр хүүхэд, Иохан, Иохан Баптист хэмээгдэх агуу бошиглогч болж өсөх болно гэдгийг тэнгэр элч Захариад хэлжээ. Есүс Христэд итгэж, түүнийг дагахад нь олон хүмүүсийг бэлтгэхийн тулд Иохан энэ үед төржээ.

Багшийн
танилцуулга

Бид зарим үед Элизабет, Захариа хоёр шиг, эдүгээ биш, харин хожим нь бидний хувьд сайн болох ямар нэг зүйлийн төлөө залбирдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг бидний бүх залбирлуудыг сонсож, мөн бидний хувьд хамгийн сайн арга зам хийгээд цаг хугацаанд залбирлуудад маань хариулдаг.

Жон Видцо хаясан зоосныхоо талаар залбирч байхдаа, зоос хаана байгааг Тэнгэрлэг Эцэг мэдэж байсныг, түүнчлэн “хэрэв энэ нь миний хувьд хамгийн сайн зүйл гэж тэрээр бодож байсан бол” зоосыг олоход надад туслах болно гэдгийг тэр санаж байсныг хүүхдүүдэд сануул. Зоосыг олох нь түүний хувьд хамгийн сайн зүйл байсан учир Жон түүнийг тэр даруй олсон билээ.

Зарим үед бид өөрсөддөө сайн биш ямар нэг зүйлийг эцэг эхээсээ гуйх нь байдаг, тиймээс тэдэнд “үгүй” гэж хэлэх шаардлагатай болдог. Үүнтэй нэгэн адил, бидний хувьд зөв биш гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэддэг ямар нэг зүйлийн төлөө бид залбирч магадгүй, ингэвэл тэрээр “үгүй” гэж хэлнэ.

Түүх

Дараах болсон явдлыг өөрийн үгээр ярь:

Майкл ханиад хүрч гэртээ байх үед нь цас—өвлийн анхны их цас оржээ. Майкл гадаа цасан дээр тоглоё гэж ээжээсээ гуйсан боловч ээж нь “болохгүй” гэжээ. Ханиад нь улам дордоно гэж тэр айсан ажээ.

Майкл цасан дээр тоглохыг үнэхээр хүсч байлаа, тэгээд ээжийнх нь шийдвэрийг Тэнгэрлэг Эцэгээр өөрчлүүлэхийн төлөө тэр залбирав. Найз Алекс

нь ирж, цасан дээр тоглох уу гэж түүнээс асуухад Майкл хоолоо идэх хэрэгтэй байгаа, харин ээж нь түүнийг цасан дээр тоглохыг зөвшөөрөхийн тулд тэр залбирсан болохоор тэр хоолны дараа тоглох боломжтой байх болно гэж хэлжээ.

Үдийн хоолны дараа Майкл гадаа тоглож болох уу гэж ээжээсээ дахин асуужээ. Түүнийг гадаа тоглохыг зөвшөөрөөч гэж тэр залбирснаа ээждээ хэлэв. Майклын ээж гунигтай харагдаж байлаа. Өнөөдөр түүний өвчнийг үгдрээж мэдэхээр байхад Тэнгэрлэг Эцэг түүнийг гадаа тоглохыг хүснэ гэж бодож байна уу гэж ээж нь Майклаас асуужээ.

- Тэнгэрлэг Эцэг Майклын залбирлыг сонссон гэж та нар бодож байна уу?
- Тэнгэрлэг Эцэг залбиралд хэрхэн хариулсан бэ?

Алексыг эргэж ирэхэд, Майкл өөрийгөө гадаа гарч болохгүй гэж хэлжээ. Тэнгэрлэг Эцэг Майклын залбиралд хариулаагүй юм байна гэж Алекс хэлэв. Тэнгэрлэг Эцэг түүний залбиралд хариулсан, гэвч “үгүй” гэсэн хариу байсныг Майкл тайлбарлав.

Дүгнэлт

Гэрчлэл

Биднийг хүн бүрийнх нь хувьд юу хамгийн сайн болохыг Тэнгэрлэг Эцэг мэддэг бөгөөд тэрээр бидний залбирлуудад хамгийн сайнаар хариулдаг тухай гэрчлэлээ хүүхдүүдэд хэл. Тэрээр зарим үед “тийм,” зарим үед “үгүй” гэж хэлдэг, зарим үед тэрээр залбирсан зүйлээ хүлээж авахын өмнө хэсэг зуур хүлээхийг биднээс хүсдэг.

Нэгтгэн дүгнэлт

- Жон Видцогийн залбиралд Тэнгэрлэг Эцэг хэрхэн хариулсан бэ?
- Элизабет, Захариа нарын залбиралд Тэнгэрлэг Эцэг хэрхэн хариулсан бэ?
- Майклын залбиралд Тэнгэрлэг Эцэг хэрхэн хариулсан бэ?

Бүр хариу нь “үгүй,” буюу “одоо биш” байлаа ч гэсэн залбирлууддаа Тэнгэрлэг Эцэгээс хариу авахад нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Тэд эцэг эх болж тоглохдоо хүүхдүүдэд нь юу хамгийн чухал болохыг шийдэх болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийнхээ тавьсан хүсэлт бүрт “тийм ээ,” “үгүй”, “одоо биш” гэж хариулахыг хүүхдүүдээс хүс. Доорх нөхцөлүүдийг буюу өөрсдийнхөө зарим нөхцөлүүдийг ашиглан хүүхдүүдийн асууж болох зарим зүйлүүдийг дүрсэл.
 - а. Хоолны цаг бараг болох гэж байна. Танай хүүхэд халууцаж бас өлссөнөөс мөхөөлдөс идэхийг хүсч байна.
 - Та юу хэлэх вэ?
 - Та яагаад ингэж хэлэх вэ?

- б. Хүйтэн, бороотой өдөр байлаа. Танай хүүхэд гадаа гарч тоглохын тулд усанд сэлэх хувцастай гадагш гарахыг хүсчээ.
- Чи юу гэж хэлэх вэ?
 - Яагаад чи ингэж хэлэх вэ?
- в. Хүүхдүүд чинь бүх ажлаа дуусгажээ. Дөнгөж үд өнгөрч байв. Тэд тоглохоор гадагш гарч болох уу гэж асуужээ.
- Чи юу гэж хэлэх вэ?
 - Яагаад чи ингэж хэлэх вэ?
- г. Танай хүүхэд тоглоом авах гэж мөнгө цуглуулж байгаад хүрэлцэхүйц мөнгө цуглуулжээ, Тэр тоглоом худалдаж авахын тулд тэр даруй явахыг хүсчээ, Та (эцэг эх) бас хэдхэн минутын дараа дэлгүүр лүү явах гэж байна.
- Чи юу гэж хэлэх вэ?
 - Яагаад чи ингэж хэлэх вэ?
- д. Танай хүүхэд моринд дуртай, тэгээд өөрийн гэсэн морьтой болохыг хүсчээ. Тэр дөнгөж таван настай.
- Чи юу гэж хэлэх вэ?
 - Яагаад чи ингэж хэлэх вэ?
- е. Хүүхдүүд чинь тоглоом, номнууддаа хайхрамжгүй ханддаг байлаа, Тэд тоглоом, номнууддаа хайр гамтай хандахын оронд, шинийг худалдаж авахыг хүсдэг аж, Тэд өөрсдийнхөө дуртай номнуудын нэгийг дэлгүүрт хараад түүнийг авч болох уу гэж асуужээ.
- Чи юу гэж хэлэх вэ?
 - Яагаад чи ингэж хэлэх вэ?
- Эцэг эхчүүд хүүхдүүддээ хамгийн сайн зүйлийг хийхийг хүсдэгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг бас өөрийн хүүхдүүдээс хамгийн сайн зүйл хийхийг хүсдэг. Тэнгэрлэг Эцэг бидний залбирлуудад үргэлж хариулдаг бөгөөд бидний хувьд хамгийн сайн болох тэрхүү арга замаар бидний залбирлуудад хариулдаг билээ. Яг л бидний дэлхийн эцэг эхчүүд заримдаа, “тийм ээ” гэж, заримдаа “үгүй” гэж, бас заримдаа “одоо биш” гэж хариулдаг шиг бидний Тэнгэрлэг Эцэг заримдаа бидний залбирлуудад, “тийм ээ”, заримдаа “үгүй”, бас заримдаа “одоо биш” гэж хариулдаг.
2. *Beginning Course Videocassette*, боть 1, хэсэг 16, “The Lost Gold Piece” (53178, 3:08) танай бүсэд байдаг бол, Жон А.Видцогийн тухай түүхийг ярихын оронд эдгээрийг үзүүл.
 3. Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийнхөө зөвшөөрлөөр хүүхдүүдэд зориулан “Хүүхдийн Залбирал” (*Children’s Songbook*, p. 12) дууг дуулуулахаар цөөн тооны зочдыг урь.
 4. “Надад Хэлээч, Их Эзэн Минь” (*Children’s Songbook*, х. 176) эсвэл “Тэнгэрлэг Эцэг Минь Надад Хэрэгтэй” (*Children’s Songbook*, х. 12) дууллуудыг дуулах буюу үгийг нь хэлүүл.

Надад Хэлээч, Их Эзэн Минь

Өнөөдөр надаар юу хэлүүлж, хийлгүүлэхийг
Өөрийнхөө аргаар надад хэлээч, Их Эзэн минь, би залбиръя.
Өө, Их Эзэн минь, таны хүслийг мэдэж, хайрлахыг надад заагаач
Өөрийн тань хайрлангуй үгийг ойлгоход минь туслаач.

Таны хайрлах гараар би удирдуулж,
Таны дууг сонсож, адисласан зарлигийг тань дагана.
Мөч бүр таны ойр байгааг мэдэхэд
Хүч өгөгдөж, айдас бүр арилна.


Тэнгэрлэг Эцэг Минь Надад Хэрэгтэй
Өдөр бүр надад туслахад
Тэнгэрлэг Эцэг минь надад хэрэгтэй.
Тэр намайг аз жаргалтай байж,
Шударгаар сонгохыг хүсдэг.
Тэр намайг аз жаргалтай байж,
Шударгаар сонгохыг хүсдэг.

Зорилго

Есүс Христ бүх хүүхдүүдийг хайрладаг, бас адислагчийг мэдрэхэд нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 25:34–40, Марк 10:13–16, 3 Нифай 17-г залбиралтайгаар судал.
2. Хэрэв боломжтой бол нэгтгэн дүгнэх хичээлд зориулж дараах материалуудыг бэлтгэ:
 - а. Хоолны тавагны дайтай дугуй цаас хайчилж бэлтгэ. Дугуйн гуравны нэгийг улаанаар, гуравны нэгийг шар, гуравны нэгийг цэнхрээр буд.



- б. Өнгөтэй арванхоёр хатуу цаасан жижиг хуудас хий, үүнд: дөрвөн улаан, дөрвөн шар, дөрвөн цэнхэр (илүү олон хүүхэдтэй ангид илүү олон хуудас бэлтгэж болно).
 - в. Хуудас тус бүр дээр дараахтай адил нэгтгэн дүгнэх асуулт бич:

Есүс Христ хэнд хайртай вэ?

Есүс Христ та нарт хайртайг та нар яаж мэддэг вэ?

“Хүүхдүүдийг над уруу ирэхийг нь зөвшөөр” гэж Есүс хэлсэн нь ямар учиртай вэ?

Эцэг эхчүүд хүүхдүүдээ Есүстэй уулзуулахаар авчрахад Есүсийн шавь нар (туслагчид) юу хийхийг хичээсэн бэ?

Америк дахь өвчтөнүүд болон бэртсэн хүмүүсийг хайрладаг байснаа Есүс хэрхэн харуулсан бэ?

Америкд тэрээр хүүхдүүдийг адисалсны дараа Есүс яасан бэ?

Хүүхдүүдийг нь Есүс адисалсны дараа хэн тэдэнтэй хамт зогсож байхыг Америк дахь эцэг эхчүүд харсан бэ?

Есүс яагаад тэр хүүхдүүдийг адисалсан бэ?

Есүс Христийг хайрлах хайраа бид хэрхэн харуулж болох вэ?
 - г. Хуудсуудыг гадна талд нь асуултын тэмдэг тавьсан хайрцаг буюу хүүдийд хий.
 - д. Өнгөтэй дугуй дээр хаях товч буюу зоос авчир.
3. “Тэр Сайхан Түүхийг Уншихаараа Би” (*Children’s Songbook*, х. 60) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа болно.

4. Шаардлагатай материалууд :
 - а. Библи, Мормоны Ном.
 - б. Зураг 2-35, Христ ба Хүүхдүүд (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 216; 62467); зураг 2-36, Есүс Нифайчуудын Хүүхдүүдийг Адисалж Байгаа нь.
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христ Бяцхан Хүүхдүүдийг Хайрлаж, Адисалсан нь

Нэгтгэн дүгнэх хичээлд зориулсан хуудсуудыг агуулсан хайрцаг буюу хүүдийг үзүүл. Хичээлийн төгсгөлд тэд тоглоом тоглох болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Тоглоомын асуултууд болон хариултуудыг мэдэж авахын тулд тэд хичээлийг анхааралтай сонсох хэрэгтэй.

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

“Тэр Сайхан Түүхийг Уншихаараа Би” дууны хоёр бадгийг хоёуланг нь хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл (Хэрэв хүүхдүүд энэ дууг мэдэхгүй бол, үүнийг тэдэнд заах буюу дуулж өг.) Дууны үгийг ярилцаж, Есүс Христ тэднийг гараараа тэврэх буюу толгой дээр нь гараа тавих нь хичнээн сайхан байхыг хүүхдүүдээр төсөөлүүлэн бодуул.

Судрын түүх

Христ ба Хүүхдүүд, зураг 2-35-ыг үзүүлж, бас Библийг харуул. Өөрийн чинь ярих гэж байгаа түүх Марк 10:13–16-д байдгийг хэл.

Есүсийг зааж байх үед хүүхдүүд түүний яриаг тасалдуулж, үймүүлж болно хэмээн шавь нар нь айж байсныг тайлбарла. Гэвч Аврагч хүүхдүүдийг өөр лүүгээ ойртож ирэхийг хүсчээ. Марк 10:14-т Есүс юу гэж хэлснийг чанга унш (*Хүүхдүүдэд зөвшөөр* гэдгээс эхлэн). Энэ сударт *зөвшөөр* гэсэн үг нь боломж олго гэсэн утгатайг тайлбарла. *Ирэхийг зөвшөөр* гэдэг үгийг *ирүүл* гэдэг үгээр сольж унш.

- Хүүхдүүд түүн рүү хүрч ирэхэд Есүс яасан бэ?

Марк 10:16-г унш. Есүс юу хийснийг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд, хичээл 17-д тэд санваарын тухай ямар зүйлүүдийг мэдэж авсныг нь тэдэнд сануул. Бидний эцгүүд болон санваар атгагч бусад хүмүүсээс бидэнд өгдөг адислалууд Есүсээс бидэнд өгч болох байсан тэдгээр адислалуудтай адил болохыг тайлбарла.

- Есүс яагаад хүүхдүүдийг өөр лүүгээ ирэхийг хүссэн бэ? (Учир нь гэвэл тэр хүүхдүүдийг хайрлаж, тэднийг адислахыг хүсдэг байсан.)

Хэдийгээр тэр насанд хүрэгчдэд зааж завгүй байсан хэдий ч, тэднийг хайрлах агуу хайрын учир бяцхан хүүхдүүдийг өргөж, тэднийг адислах цаг гаргасан ажээ.

Гэрчлэл

Есүс хүүхдүүдийг хайрладаг тухай гэрчлэлээ хуваалц. Та “Тэр Сайхан Түүхийг Уншихаараа Би” дууг хүүхдүүдтэй хамт дахин дуулж болно.

Судрын түүх

Нифайчуудын Хүүхдүүдийг Есүс Адисалж Байгаа нь, зураг 2-36-г үзүүл. Хүүхдүүдээр зургийг харуулж, зураг дээр харсан зүйлээ тэднээр яриул. Мормоны Номыг үзүүл. Есүс Христ Америк дахь энэ хүмүүст Ариун Нутаг

дахь хүмүүсийн нэгэн адил зааж байсныг, түүнчлэн Мормоны Номонд дүрслэгдсэн Америкт очсон түүний айлчлалыг тайлбарла. 3 Нифай 17 дахь түүхийг ярь.

Есүс Христ Америк дахь хүмүүст зааж дуусгахад тэд түүнийг явахыг хүсээгүйг тайлбарла. Есүс тэр хүмүүсийг нэн их хайрладаг байв, тиймээс тэрээр өвчтэй буюу гэмтэж бэртсэн бүх хүмүүсийг адисалж, эдгээсэн ажээ (3 Нифай 17:7–10-ыг үз).

Дараа нь Есүс бүх хүүхдүүдийг өөр лүүгээ авчрахыг хүсчээ. Тэр тэднийг өөрийгөө тойруулан, гайхамшигтай сайхан залбирал хэлжээ (3 Нифай 17:11–15-ыг үз).

Энэ залбирлын үгс нь тэмдэглэж авахын аргагүй их хийгээд гайхамшигтайг Мормоны Ном өгүүлдгийг хүүхдүүдэд хэл (3 Нифай 17:15-ыг үз).

Дараа нь Есүс хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, тэднийг адисалж, тэдний төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсныг тайлбарла. Тэнгэр элчүүд хүүхдүүдтэй нь хамт байсныг эцэг эхчүүд нь харжээ (3 Нифай 17:21–24-ийг үз). Тэнд байсан бүх хүмүүс хүүхдүүдийг хайрлах Есүсийн агуу хайрыг тэгэхэд мэдэрчээ.

Ярилцлага

- Есүс тэднийг адисалж, тэдний төлөө залбирахад хүүхдүүдэд ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Есүсийн тухай бодож үзэхэд та нарт ямар санагддаг вэ?

Есүс Христ Бидэнд Хайртай

Ярилцлага

Эдүгээ Есүс Христ өөрийн биеэр энд байхгүй ч гэсэн, тэрээр дэлхийд байсан үедээ хүүхдүүдийг хайрладаг байсан шигээ биднийг бас тэгж хайрладгийг тайлбарла.

- Есүс бидэнд хайртайг бид яаж мэддэг вэ? (Асуултууд нь дараах зүйлүүдийг багтаасан байж болно: Тэр бидэнд зориулж дэлхийг бүтээсэн юм; амьдралдаа бидний сахих ёстой зарлигуудыг тэр өгсөн; тэр бидний төлөө амьдралаа өгсөн; тэр Сүмийг удирдан чиглүүлж, өөрийн бошиглогчдоор дамжуулан бидэнтэй ярьдаг; тэр бидэнд сайн үлгэр жишээ үзүүлсэн.)

Хүүхдүүдийн оролцоо

Тэнгэрлэг Эцэгийн чиглүүллийн дор Есүс Христ дэлхийг болон үүн дээрх бүх ургамал, амьтныг бүтээснийг хүүхдүүдэд сануул.

Өөрийн дуртай амьтан буюу ургамлыг нэрлэхийг хүүхэд бүрээс хүс. Есүсийн бүтээсэн эдгээр зүйлүүдийг харсан үедээ хүүхдүүд Есүс өөрсдөд нь хайртайг санах учиртайг хүүхдүүдэд сануул.

Зураг дээрх ярилцлага

Христ ба Хүүхдүүд, зураг 2-35, мөн Нифайчуудын Хүүхдүүдийг Есүс Адисалж Байгаа нь, зураг 2-36-г дахин үзүүл.

- Есүс өөрсдийг нь хайрладагт эдгээр хүүхдүүд баяртай байсан гэж та нар бодож байна уу?
- Есүс та нарыг хайрладагт та нар баяртай байдаг уу?

Бид Түүнд Хайртайгаа Есүс Христэд Харуулж Чадна

Багшийн танилцуулга

Есүс Христ дэлхий дээр байхгүй ч гэсэн, биднийг хайрладаг түүний хайрын төлөө бид талархалтай байдаг гэдгийг түүнчлэн бид түүнд хайртай гэдгээ түүнд харуулж чадна гэдгийг тайлбарла. Бид түүний зарлигуудыг сахих нь Есүсийг хайрладгаа түүнд харуулах нэг арга зам гэдгийг тайлбарла.

Судар	Бид түүнийг хайрладгаа Есүст харуулах өөр нэг арга замын талаар хүүхдүүдэд хэлхийн тулд Матай 25:40-ийг чанга унш. (Хаан гэдэг бол Есүс Христийн өөр нэг нэр гэдгийг тайлбарла.) Хэрэв бид бусад хүмүүст найрсаг байх юм бол энэ нь түүнд найрсаг байхтай адил юм гэж Аврагч энэ сударт өгүүлдгийг тайлбарла. Бид бусдад найрсаг хандсанаараа Есүст хайртайгаа түүнд харуулдаг.
Нэгтгэн дүгнэх тоглоом	<p>Өнөөдрийн хичээлээр сурсан зүйлээ санахад нь хүүхдүүдэд туслахын тулд дараах тоглоомыг тогло. (Хэрэв тоглоомын бүх материалыг бэлтгэх боломжгүй бол, тоглоомыг тохирох байдлаар хялбаршуулах буюу бэлтгэл хэсэгт жагсаасан асуултуудыг уншиж, хүүхдүүдээр асуултуудад ээлжээр хариулуул.)</p> <p>Хуудсуудыг хайрцагнаас буюу хүүдийнээс гаргаж шалан дээр буюу ширээн дээр өнгө өнгөөр нь хэсэглэн хувааж тавь. Өнгөөр ялгаж будсан дугуйг хуудаснуудын ойролцоо тавь.</p> <p>Товч буюу зоосыг дугуй дээр нэг хүүхдээр орхиулж, дугуйн хэсэгт товчны буусан өнгөтэй адил хуудсыг сонгоно. Хуудсан дээрх асуултыг чанга уншиж, уг асуултыг тэр хүүхдээр хариулуул. Хүүхэд бүрээр ээлжээр үүнийг хийлгэ.</p> <p>Хэрэв хуудас тохирсон хүүхэд асуултад хариулж чадахгүй бол, та өөрөө буюу ангийн бусад гишүүд шаардлагатай сануулах дохиог өгч болно. Хэрэв цаг байвал аливаа сануулах дохиогүйгээр тоглоомыг дахин тогло. Есүсийн тухай болон өөрсдийг нь хайрлах түүний хайрын тухай өдий их зүйл мэдэж байгаагийнх нь төлөө хүүхдүүдийг магт.</p>
Гэрчлэл	<p>Дүгнэлт</p> <p>Тэдний хүн бүрийг Есүс Христ хайрладаг бөгөөд тэднийг үргэлж хайрлах болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Есүс хүүхдүүдтэй хамт байхад дуртай, мөн тэдэнд тусалж, тэднийг адислахыг хүсдэг. Ангийн чинь хүүхэд бүрийг Есүс хайрлаж, үнэлдэг тухай гэрчлэлээ хэл.</p> <p>Тэрээр хүүхдүүдийг хайрладаг учраас тэдэнд зориулж Есүсийн хийсэн бүх зүйлүүдийн талаар долоо хоногийн турш бодож үзэхэд нь хүүхдүүдийг урамшуул. Бодож олсон зүйлүүдийнхээ жагсаалт гаргах буюу зургууд зурж Хүүхдийн Хэсэгт дараагийн хоногт тэдгээрийг та хүүхдүүдээр авчруулахыг хүсч болно.</p> <p>Хүүхдүүд зарлигуудыг сахиснаар мөн бусдад найрсаг байснаар Есүст хайртайгаа харуулж чадна гэдгийг тэдэнд сануул.</p> <p>Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Есүс Христийн төлөө мөн түүний хайрын төлөө талархал илэрхийлэхийг тэр хүүхдэд санал болго.</p> <p>Хичээл дуусч хүүхдүүд ангиас гарч явах үед “Есүс чамд хайртай, би бас чамд хайртай” гэж шивнэн хэлүүл.</p>

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хатуу цаасан дээр хадсан жижигхэн толь хичээл дээр авчир. Хүүхдүүдийг толинд бүү харуул. Цаасны ар талыг өргөж харуулаад Есүс тэднийг нэн их хайрладаг хүмүүсийн нууц зураг өөрт чинь байгааг ангийнханд хэл.

Хүүхдүүдийг нэг нэгээр нь ирүүлж “зургийг” үзүүл. Хүн бүгд зургийг ээлжээр үзэж дуустал нууц байлгахыг хүүхдүүдээс хүс. Есүс тэднийг нэг бүрчлэн хайрладгийг хүүхдүүдэд сануул.

2. “Есүс Бяцхан Хүүхдүүдэд Хайртай” (*Children’s Songbook*, х. 59) буюу “Би Аврагчийн Хайрыг Мэдэрдэг” (*Children’s Songbook*, х. 74) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.
3. Дараах шүлгийн үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Есүс Бүх Хүүхдүүдэд Хайртай

Есүс бүх хүүхдүүдэд хайртай (гараа алдлан өргөнө)

Бяцхан хүүхдүүд балчир хэвээрээ байна (хүүхдийн өндрийг гараараа өвдөгт хүргэн харуулна)


Өлгийдөө байгаа нялхад ч тэр (гараараа өлгий дүрслэн харуулна)

Өндөр болж, том болсон тэдэнд ч бас (Гараа толгойноос дээш өргөж харуулна)

(*Finger Fun for Little Folk* by Thea Cannon-аас авав. © 1949 by the Standard Publishing Company, Cincinnati, Ohio. Зөвшөөрлөөр ашиглана.)

Хүссэнээрээ хэдэн ч удаа давтаж болно.

4. Христ хүүхдүүдтэй хамт байгаа зургийн хувийг (хичээлийн төгсгөлд байгаа) хүүхэд бүрийн тоогоор бэлтгэ. Зураг дээрх хүүхдүүдийн нүүрэн дээр хүүхдүүдээр зуруулж, зургуудыг нь өнгө ялган будуул. Хэрэв та хүүхэд бүрт зориулан хувь бэлтгэж чадахгүй бол, нэг том хувь бэлтгээд хүүхэд бүрээр зураг дээрх хүүхдүүдийн нэгийг нь өнгө ялган будуул.
Хэрэв тэд Есүс Христ дэлхий дээр амьдарч байсан тэр үед байсан бол, тэр тэднийг гараараа тэвэрч, мөн л тэднийг адислах байсныг хүүхдүүдэд хэл. Хэдийгээр Есүс одоо дэлхий дээр байхгүй ч гэсэн, дэлхий дээрх хүмүүсийг тэр хайрласан хэвээр байгааг тэдэнд сануул.



Есүс Христийн Заадаг Зүйлүүд Бол Агуу Эрдэнэс Мөн

Зорилго

Есүс Христийн заадаг зүйлүүдийн тухай илүү ихийг мэдэх хүүхдүүдийн хүслийг хүчтэй болгох.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 19:23–24, Иосеф Смит—Түүх 1:14–20-ийг залбиралтайгаар судал. Мөн Матай 3:13–16; 4:1–11; 6:9; Марк 10:13–16; 3 Нифай 18:19; болон *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 10-ыг үз.
 2. *Есүс Христийн заадаг зүйлүүд бол агуу эрдэнэс мөн* гэсэн үгсийг цаасан дээр бич. Цаасыг эвхэж, жижиг хайрцаг буюу саванд хий. Савыг амархан олдохоор газарт ангидаа нуу. (Хэрэв танай ангийн хүүхдүүд уншиж чаддаггүй бол Есүсийн зураг юм уу эсвэл Библи, Мормоны Номыг нуу.)
 3. Шаардлагатай материалууд:
 - а. Судрууд.
 - б. Өөрт чинь үнэ цэнэтэй ямар нэг хувийн зүйл.
 - в. Тоглоомын даавуун бөмбөг буюу өөр зөөлөн зүйл.
 - г. Зураг 2-37, Уулан Дээрх Номлол (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 212; 62166); зураг 2-29, Анхны Үзэгдэл (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 403; 62470); зураг 2-39, Иосеф Смит (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 401; 62002); Амьд Бошиглогчийн Зураг (Сүмийн сэтгүүл буюу цуглааны байрны номын сангаас авах).
 4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Есүс тэднийг хайрладаг учраас тэдний төлөө түүний хийсэн зүйлүүдийн жагсаалт хийх буюу зураг зуруулахыг өнгөрсөн долоо хоногт хүүхдүүдээс хүссэн бол, та эдгээр жагсаалтууд буюу зургуудын тухай хэдэн минут ярилцаж болно.

Бидэнд Олон Эрдэнэс Бий

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Өөрийнхөө авчирсан хувийн үнэ цэнэтэй зүйлээ хүүхдүүдэд үзүүл. Үүнийг хэрхэн ашигладаг, хаанаас олж авсан буюу эсвэл үүнийг та хэр зэрэг удаан эзэмшиж байгаа гэхчлэн уг зүйлийн талаар зарим тодорхой зүйлийг ярь. Энэ зүйл яагаад танд чухал болох тухай түүнчлэн энэ зүйл алдагдах, хулгайлагдах буюу эвдэрвэл хичнээн гунигтай байхыг онцлон заа. Энэ зүйл бол таны хувьд үнэт зүйлсийн нэг мөн гэдгийг тайлбарла.

- Эрдэнэс гэж юу вэ? (Их үнэ цэнэтэй ямар нэг зүйл.)

Түүх

Үнэт зүйлс эзэмшдэг байсан нэг хүүхдийн тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:

Рутын сургуулийн найз нарынх нь нэг сургуульдаа өдөр бүр хүзүүний зүүлт зүүж ирдэг байжээ. Энэ бол түүний хэзээ ч хараагүй хамгийн гоё зүүлт гэж Рут боддог байжээ. Мөн үүн шиг зүүлт нэгийг олж авах сан гэж тэр хүсдэг байжээ.

Рутын төрсөн өдрийн өглөө ээж нь түүнд нэг бэлэг гардуулав. Энэ нь гоё цаасанд туузаар ороосон жижигхэн хайрцаг байв. Хайрцган дотор гоё алтан зүүлт байхыг Рут харлаа. Энэ нь зүрхэн хэлбэртэй, голдоо гялалзсан ягаан чулуун шигтгээтэй байлаа. Рут нүдэндээ итгэж ядан байв.

Ярилцлага

- Зүүлт Рутэд ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Та нарт ямар үнэт зүйлс байдаг вэ? (Гэрийн тэжээмэл амьтан, дуртай тоглоом буюу ном, эсвэл хувцас гэх мэт зарим санааг та тэдэнд хэлж өгч болно.)

Есүс Христийн Үгс Бол Агуу Эрдэнэс Мөн

Үнэт зүйлс олох үйл ажиллагаа

Бидний хүн нэг бүрт байж болох үнэт зүйлээс (хүүхдүүд өөрсдийн үнэт зүйлс хэмээн нэрлэсэн зарим зүйлийг тэднээр нэрлүүл) илүү агуу үнэт зүйл байдгийг тайлбарла. Энэ үнэт зүйл бол бидний эзэмшдэг ямар ч зүйлээс илүү үнэ цэнэтэй юм. Энэ үнэт зүйлийг мөнгөөр худалдаж авч болдоггүй, энэ нь эвдрэх буюу хулгайлагддаггүй. Энэ үнэт зүйлийг олж авахын тулд олон хүмүүс өөрсдийн эзэмшдэг бүхнээ орхиход бэлэн байдаг тийм их үнэ цэнэтэй юм. Тэр ч байтугай зарим хүмүүс үүний төлөө амь насаа өгөхөд бэлэн байдаг.

Энэ агуу үнэт зүйл юу болохыг мэдэхийн тулд тэд үнэт зүйлийг олох гэж байгааг хүүхдүүдэд хэл. Энэхүү үнэт зүйлийг та ангид нууснаа тайлбарла. Энэхүү үнэт зүйлийг чимээгүй эрэхийг хүүхдүүдээс хүс.

Хүүхдүүд хайрцаг буюу савыг олоход үүнийг нэг хүүхдээр нээлгэж, захиасыг чангаар уншуул. Тэгээд захиасны үгсийг өөртэйгөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл. (Хэрэв та Есүсийн зураг буюу судрын ном нуусан бол, энэ зүйл Есүс Христийн сургаалуудыг төлөөлж байгааг тайлбарла. Есүс Христийн сургаалууд бидний хувьд агуу үнэт зүйл мөн гэдгийг хүүхдүүдэд хэл.)

- Яагаад Есүс Христийн сургаалууд бидний хувьд агуу үнэт зүйл байдаг вэ?

Есүс Христийн сургаалууд бидний хувьд агуу үнэт зүйлс байдаг, учир нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дагаснаар хэрхэн аз жаргалтай байхыг эдгээр сургаалууд бидэнд харуулдаг онцгой анхаарал хандуул.

Судар

Сургаал ба Гэрээ 19:23-ын (үгсийг дуустал) эхний хэсгийг чанга унш. Есүс Христ үүнийг хэлснийг тайлбарла. Өөрийнхөө мөн сургаалуудынхаа тухай биднийг мэдээсэй гэж тэрээр хүсдэг.

Бид Есүс Христийн Сургаалуудыг Судруудаас Сурч Болно

Багшийн танилцуулга

Уулан Дээрх Номлол, зураг 2-37-г үзүүл. Зураг дээр юу болж байгааг хүүхдүүдээр дүрслүүл.

Аврагч дэлхий дээр байхдаа хотоос хотод очиж, хүмүүс аз жаргалтай байж, нэгэн цагт Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар эргэж очиж чадахуйц тийм байдлаар тэд хэрхэн амьдрах ёстойг хүмүүст заадаг байсныг тайлбарла. Олон хүмүүс түүний сургаалуудыг сонсож, түүнийг хаа ч явсан дагаж явдаг байжээ. Зарим үед хэдэн мянган хүмүүс сонсож, суралцахын тулд түүнийг тойрон цуглардаг байв.

- Есүсийг сонсох үед хүмүүст хэрхэн санагддаг байсан гэж та нар бодож байна?

Есүс ядардаг байснаас зарим үед түүнд амралт хэрэгтэй болох үед шавь нар нь (туслагчид) хүмүүсийг явуулахыг хичээдэг байсныг тайлбарла. Түүний сургаалуудыг сонсохоос хүмүүсийг бүү холдуул гэж Есүс үргэлж хэлдэг байжээ. Үүрд мөнхөд үргэлжлэх баяр хөөр, аз жаргалыг эдлэхийн тулд бүх хүмүүс сонсож, суралцахыг тэр хүсдэг байв.

Судруудыг үзүүл. Судруудаас бид Есүсийн сургаалуудаас олныг сурч болно гэдгийг тайлбарла. Шинэ Гэрээний оршил хуудсыг үзүүл. Есүс дэлхий дээр байх үед түүний зааж байсан зүйлүүдийн зарим нь Шинэ Гэрээнд бичигдсэнийг тайлбарла.

Тоглоом

Есүс дэлхий дээр байх үедээ олон зүйлийг үлгэр жишээгээр заадаг байсныг тайлбарла. Есүсийн хийж байсан буюу зааж байсан зарим зүйлүүдийг санахад нь хүүхдүүдэд туслах “Би бодож байна . . .” тоглоомыг тогло.

Энэ тоглоомыг тоглохын тулд Есүс Христийн амьдралын тухай дараах тодорхойлолтууд болон үйл явдлуудыг уншиж, дагалдах асуултуудыг нэг нэгээр нь асуу. Асуултын хариуг мэдсэн үед нь хүүхдүүдийн гарыг өргүүл. Даавуун бөмбөг буюу өөр зөөлөн зүйлийг гар өргөсөн хүүхэд рүү шидэж, хариулах асуултыг нь тавь. Хүүхэд бүрийг наад тал нь нэг асуултад хариулах боломж олго.

1. Есүс Иордан гол дээр Иохан Баптистын хамт зогсож байсан үеийн тухай би бодож байна (Матай 3:13–15).

- Иордан гол дээр Есүст юу тохиолдсон бэ?
- Есүс яаж баптисм хүртсэн бэ? (Усанд умбуулалтаар.)
- Бид яаж баптисм хүртэхээр заагддаг вэ? (Усанд умбуулалтаар.)

2. Иохан Баптист Есүст баптисм хүртээж байх үед тэнд байсан тусгай нэгэний тухай би бодож байна. Хүн болгон түүнийг харж чадахгүй, гэвч тэрээр тэнд байсныг Есүс, Иохан хоёр мэдэж байв (Матай 3:16-г үз).

- Би хэний тухай бодож байна вэ? (Ариун Сүнс.)
- Ариун Сүнсний бэлэг хүлээн авахын тулд юу хийхийг бидэнд заадаг вэ? (Баптисм хүртэж, гишүүнээр батлагдах.)

3. Есүс хоолгүйгээр дөчин өдөр, дөчин шөнө болсон үеийн тухай би бодож байна (Матай 4:1–11-ийг үз).

- Хэн Есүсийг уруу татах гэж оролдсон бэ?
- Есүс яасан бэ? (Тэр зөвийг сонгож, зайлахыг Сатанд зарлигласан.)
- Уруу татагдсан үедээ юу хийхийг бидэнд заадаг вэ? (Зөвийг сонгохыг.)

4. Есүсийн шавь нар хүүхдүүдийг холдуулах гэж оролдсон үеийн тухай би бодож байна (Марк 10:13–16-г үз).

- Есүс шавь нартаа юу гэж хэлсэн бэ? (Тэр хүүхдүүдэд хайртай учраас тэднийг тэнд үлдэхийг хүсч байсан.)
- Есүс хэнд хайртай вэ? (Бид бүгдэд.)
- Есүс яагаад бидэнд заадаг вэ? (Тэр бидэнд хайртай, мөн биднийг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг учраас.)

5. Есүс хэрхэн залбирахыг хүмүүст заадаг байсан үеийн тухай би бодож байна (Матай 6:9 болон 3 Нифай 18:19-ийг үз).

- Бид хэрхэн залбирахыг Есүс хэнд заасан бэ?
- Бид залбирлуудаа хэрхэн төгсгөх ёстой гэж Есүс заасан бэ?
- Бид хэзээ залбирах ёстой вэ? (Бүх хариултыг хүлээн ав, бид Тэнгэрлэг Эцэгт ойр байхыг мэдэрч, түүнд талархах эсвэл түүний тусламжийг хүссэн үедээ хэзээ ч залбирч болно гэдгийг хүүхдүүдэд сануул.)

Бид Есүс Христийн Сургаалуудыг Амьд Бошиглогчоос Сурч Болно

Багшийн
танилцуулга

Бид Есүс Христийн сургаалуудаас олныг нь судруудыг унших замаар сурч болох хэдий ч, судрууд Есүсийн сургаалуудыг бүгдийг нь агуулдаггүйг тайлбарла. Есүс дэлхийг орхисон цагаас хойш заахаа зогсоогоогүй юм. Одоо тэрээр бошиглогчдоор дамжуулан заадаг. Есүс өөрийн бошиглогчтой ярьж, бид юу мэдэх хэрэгтэйг түүнд хэлж өгдөг. Тэгээд бошиглогч Есүсийн сургаалуудыг бидэнд өгдөг.

Судрын түүх

Анхны Үзэгдэл, зураг 2-38-ыг үзүүлж, Иосеф Смит—Түүх 1:14–20-д байдаг түүхийг ярихад хүүхдүүдээр өөртөө туслуул.

Иосеф Смит бошиглогч байж, үнэнийг заахын тулд Тэнгэрлэг Эцэгээр бэлтгэгдсэн юм гэдэгт онцгой анхаарал хандуул. Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр Иосеф Смит дээр хүрч ирэн, тэр үед дэлхий дээр байсан сүмүүдээс аль нь ч зөв биш байсныг түүнд хэлжээ. Хожим нь Иосеф үнэн сүмийг дэлхийд эргүүлэн авчрахад Иосефт тусалсан билээ.

- Өнөө үед Есүс Христийн үнэн сүмийн нэр юу вэ? (Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм)

Энэ нэрийг хүүхдүүдээр хэдэн удаа хамтад нь давтан хэлүүл.

Зурган дээрх
ярилцлага

Бошиглогч Иосеф Смит, зураг 2-39-ийг үзүүл. Иосеф Смит Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны бошиглогч болсныг тайлбарла. Есүс тэднээр юу хийлгэхийг хүсдэг байсныг мэдэхэд нь Сүмийн эхэн үеийн гишүүдэд тэрээр тусалсан юм.

Бошиглогч Иосеф Смитийн зурагны дараа амьд бошиглогчийн зургийг үзүүл.

- Энэ хэн бэ?

Есүс Христ Иосеф Смиттэй барьдаг байсны нэгэн адил амьд бошиглогчтой ярьдгийг тайлбарла. Бид бошиглогчдын үгсийг сонсож байгаа нь Есүсийн сургаалуудыг сонсож байгаа юм.

Гэрчлэл

Бошиглогчтой байна гэдэг нь хичнээн гайхамшигтай сайхан болохыг хүүхдүүдэд хэлж өг. Эдүгээгийн бошиглогч бол Аврагчийн сургаалуудыг бидэнд заадаг үнэн бошиглогч мөн гэдгийг гэрчил.

Есүс Христийн Сургаалууд Бидэнд Чухал Ач Холбогдолтой

Түүх

Сүмийн гишүүн байна гэдэг нь түүнчлэн Аврагчийн сургаалууд бидэнд байгаа нь хичнээн гайхамшигтай сайхан зүйл болохыг бид заримдаа мартаж болохыг хүүхдүүдэд хэл. Есүсийн сургаалууд бол агуу үнэт зүйл гэдгийг бид санах хэрэгтэй.

Есүс Христийн сургаалуудыг мэдэхийн, тэрчлэн түүний сүмийн гишүүн байхын ач холбогдлыг харуулсан өөрийн таньдаг хэн нэгэний тухай түүхийг ярь. Хэрэв та тийм түүх мэдэхгүй бол, дараах түүхийг ашигла:

Алет номлогч нартай ярилцаж, тэд Есүс Христийн сургаалуудыг заадгийг мэджээ. Тэр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болохыг хүсч байсан боловч, аав нь түүнийг баптисм хүртэхийг хүссэнгүй. Есүсийн сургаалуудыг сурах хийгээд Есүсийн сүмийн гишүүн болох нь Алетын хувьд ямар утга учиртай болохыг аав нь ойлгоогүй ажээ. Аав нь хүлээхийг түүнээс хүсчээ. Алет хүлээсэн хэдий ч, Сүмийн гишүүн болох нь түүний хувьд хичнээн чухал болохыг аав нь нэг өдөр ойлгох болно гэж бодон тэр сүмд явахаа үргэлжлүүлж, залбирсаар байжээ

Христийн Мэндэлсний Баярын үеэр Алетын аав Христийн Мэндэлсний Баяраар юу хүсэх вэ гэж түүнээс асуув. Түүний хүсэх цорын ганц зүйл бол баптисм хүртэхийг нь зөвшөөрөөч гэж тэр аавдаа хэлжээ. Хэрэв баптисм нь Алетын хувьд тийм чухал ач холбогдолтой юм бол тэрээр зөвшөөрч болох юм гэж шийджээ. Алет Христийн Мэндэлсний Баярын босгон дээр баптисм хүртэв. Энэ бол түүний хүлээж авсан цорын ганц бэлэг байсан хэдий ч, түүнд нэн их баяр хөөрийг авчирсан агуу үнэт зүйл байлаа.

- Алет ямар бэлэг хүссэн бэ?
- Энэ бэлэг яагаад ийм их ач холбогдолтой байсан бэ?

Дүгнэлт

Ярилцлага

Есүс Христийн сургаалуудын төлөө бид хичнээн их талархалтай байж болохыг хүүхдүүдтэй хамт ярилц. Бид талархалтай байж болох нь—

- Аврагчийн нэгэн адил бид баптисм хүртэж болно.
- Бид баптисм хүртсэнийхээ дараа Ариун Сүнсний бэлэг хүлээн авч болно.
- Бидэнд тусламж хэрэгтэй болсон үед бид залбирч болно.
- Зөвийг хэрхэн сонгохыг бид сурч болно.
- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд хайртайг бид мэддэг.
- Бидэнд заах судрууд хийгээд амьд бошиглогчид бидэнд байдаг.

Гэрчлэл

Энэ бол Есүс Христийн үнэн сүм болох тухай гэрчлэлээ хэлж, та гишүүн байгаадаа түүнчлэн Есүсийн сургаалуудыг сурах боломжтой байгаадаа хичнээн баяр талархалтай байдгаа хүүхдүүдэд хэл.

Хүүхэд бүрийг босгож, Есүсийн сургаалуудын төлөө талархлаа илэрхийлэхийг урь. (Аль ч хүүхдээс ингэхийг шаардаж болохгүй.) Шаардлагатай үед хүүхдүүдэд тусал.

Аврагчийн төлөө түүнчлэн түүний сургаалуудын төлөө талархлаа илэрхийлэх нь гэрчлэлээ хэлэх нэг арга зам гэдгийг онцлон тэмдэглэ. Хүүхдүүд сая гэрчлэлээ хуваалцсаныг нь тэдэнд хэл.

Гэртээ гэрчлэлээ хуваалцахыг нь хүүхдүүдэд урамшуулан дэмж. Сүнс тэднийг өдөөсөн үед тэд бас мацгийн болон гэрчлэлийн цуглаан дээр гэрчлэлээ хэлж, мөн Есүсийн сургаалуудын талаар мөн Есүс Христийн сүмийн талаар юу мэддэгээ хуваалцаж болно гэдгийг санал болго.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хичээлийн төгсгөл дэх зургуудын хуудасны хуулбарыг хүүхэд бүрт бэлтгэ. Зарим хүмүүс зурагтай хуудсаны голд байгаа шиг тийм үнэт зүйлсийн хайрцагт өөрсдийн дуртай зүйлсээ хадгалдгийг тайлбарла.

- Үнэт зүйлсийн хайрцагт та нар юугаа хадгалах вэ?



Есүс Христийн сургаалууд мэт бидэнд байдаг хамгийн үнэтэй зүйлүүдийг бид хайрцагт хадгалж чадахгүйг хүүхдүүдэд сануул. Дөрвөн зургаар төлөөлүүлсэн (баптисм, залбирал, ариун ёслол, хайр) Есүсийн сургаалуудын тухай ярилц.

Сургаалуудын зурагнаас үнэт зүйлсийн хайрцаг луу чиглэсэн шугамнуудыг хүүхдүүдээр татуулж, дараа нь зургуудыг тэднээр будуул.

2. Биднийг хий хэмээн Есүсийн заадаг зүйлүүдийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул. Ямар заадаг зүйлийг жүжигчлэн тоглосныг бусад хүүхдүүдээр таалга. Жишээнүүд нь залбирал, хүндэтгэлтэй байх, аравны нэгээ төлөх, эцэг эхдээ туслах, эсвэл ах эгч дүү нартаа эелдэг найрсаг байх явдал байж болно.

3. “Би Есүстэй Адил Болохыг Хичээнэ” (*Children’s Songbook*, х. 78), “Есүс Бяцхан Хүүхдүүдэд Хайртай” (*Children’s Songbook*, х. 59), эсвэл “Есүс Намайг Нарны Цацраг Байхыг Хүсдэг” (*Children’s Songbook*, х. 60) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.

Есүс Христийн Сургаалууд Агуу Эрдэнэс Мөн



Зорилго Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт хүндэтгэлээ харуулахад нь хүүхэд бүрийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Лук 2:1–16, 3 Нифай 17:11–12, 21–24-ийг залбиралтайгаар судал.
2. Хичээлийн төгсгөл дэх загвараас ам, нүд, чих, гар, хөлийн тавхай, шилбийг хайчлан бэлтгэ. Хайчилбаруудыг цүнх буюу өөр саванд хий.
3. Дараах үгсийг бичсэн туузан цаас бэлтгэ:

Хүндэтгэл

4. “Хүндэтгэлтэйгээр, Чимээгүйхэн” (*Children’s Songbook*, х. 26), “Би Хүндэтгэлтэй Байхыг Хичээнэ” (*Children’s Songbook*, х. 28) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи, Мормоны Ном.
 - б. Зураг 2-36, Нифайчуудын Хүүхдүүдийг Есүс Адисалж Байгаа нь; зураг 2-41, Хүндэтгэлтэй Хүүхэд; зураг 2-40, Есүс Төрсөн нь (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 200; 62116).
6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Нээлтийн залбирлын өмнө “Хүндэтгэлтэйгээр, Чимээгүйхэн” дууг дуулах буюу үгийг нь хэл.

Бид таныг хүндэтгэлтэйгээр, чимээгүйхэн, хайрлан боддог; Хүндэтгэлтэйгээр, чимээгүйхэн, аярнаар ая дуугаа дуулдаг. Хүндэтгэлтэйгээр, чимээгүйхэн, даруухнаар бид одоо залбирч байна, Өнөөдөр бидний зүрх сэтгэлд Таны Ариун Сүнс оршиг.

Хүндэтгэлтэй Хүүхэд, зураг 2-40-ийг үзүүл. Зураг дээрх хүүхэд Тэнгэрлэг Эцэгтэй залбиралд ярилцахаар бэлтгэж байгааг хүүхдүүдэд хэл.

- Бид залбиралд хэрхэн бэлэн болдог вэ? (Бид гараа зөрүүлж, нүдээ анин, толгойгоо бөхийлгөдөг.)
- Бид яагаад гараа зөрүүлж, нүдээ анин, толгойгоо бөхийлгөн залбиралд бэлэн болдог вэ?

Бид эдгээр зүйлүүдийг хийснээр залбирч байх үедээ Тэнгэрлэг Эцэг бидэнд ойр байгааг мэдрэх нь бидний хувьд хялбар байдаг. Яг л бидний дэлхийн эцэг эхчүүд биднийг анхааралтай сонсдогийг мэдэх нь чухал байдаг шиг,

биднийг залбирч байх үед Тэнгэрлэг Эцэг ойрхон байгааг мэдрэх нь чухал юм гэдгийг тайлбарла.

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Нээлтийн залбирлын дараа та залбиралд түүнтэй ярилцах онцгой боломжийнхоо төлөө хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгт талархлаа товч илэрхийл.

Хүндэтгэл Бол Хайрын хийгээд Дээдлэн Хүндлэх Мэдрэмж Юм

Цаасан туузан дээрх үгэн дээр ярилцах нь

Хүндэтгэлтэй хүүхдийн зурагны хажууд “Хүндэтгэл” гэж бичсэн туузан цаасыг үзүүл. Туузан цаасан дээрх үгийг уншиж, үүнийг хүүхдүүдээр давтан хэлүүл.

- Хүндэтгэл гэж юу вэ?

Хүндэтгэл гэдэг бол зөвхөн чимээгүй нам гүм байхаас илүү зүйл гэдэгт онцлон анхаар. Хүндэтгэл бол Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг хайрлах хайр хийгээд хүндлэлийн тусгай мэдрэмж юм.

Залбирахад нь буюу Есүсийн тухай түүхүүдийг уншиж өгөхөд нь эцэг эхчүүд нь тэдэнд туслах үед, эсвэл Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн үзэсгэлэн төгөлдөр бүтээлүүдийг үзэх буюу сонсоход тэдэнд төрдөг мэдрэмжүүдийн талаар бодож үзэхийг хүүхдүүдээс хүс. Тэнгэрлэг Эцэгийн сүнс ойрхон байгааг мэдэхэд эдгээр мэдрэмжүүд бидэнд тусалдаг.

Зураг дээрх ярилцлага

Нифайчуудын Хүүхдүүдийг Есүс Адисалж Байгаа нь, зураг 2-36-г үзүүл. Зургийн тухай хүүхдүүдээр яриул (3 Нифай 17:11–12, 21–24-ийг үз).

- Есүсийн талаар Нифайчуудын хүүхдүүдэд ямар санагдсан гэж та нар бодож байна?

Есүс Төрсөн нь, зураг 2-41-ийг үзүүлж, Есүсийн төрсөн тухай түүхийг ярихыг хүүхдүүдээс хүс (Лук 2:1–16-г үз). Зураг дээрх хүмүүсийг тэднээр анхаархалтай харуул.

- Хүмүүс нялх Есүсийг хараад тэдэнд юу гэж бодогдсон гэж та нар бодож байна?
- Хэрэв та нар нялх Есүсийг харсан бол та нарт ямар санагдах байсан гэж та нар бодож байна?

Бид Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрыг хайраар бодож байвал бид хүндэтгэлтэй байгаа нь тэр гэдгийг тайлбарла.

Бид Үйл Хэргээрээ Хүндэтгэлийг Харуулдаг

Ярилцлага

- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг хүндэтгэх хүндэтгэлийн (хайр болон хүндлэл) мэдрэмжээ бид хэрхэн харуулдаг вэ?

Бид хаана байхаас үл хамааран хүндэтгэлийн мэдрэмжтэй байхын чухлыг тайлбарла, гэвч бид сүм дээр хүндэтгэлтэй байхыг тусгайлан санах ёстой. Цуглааны байр бол Тэнгэрлэг Эцэгийн өргөө бөгөөд бид Тэнгэрлэг Эцэгийн өргөөнд хүндэтгэлтэй байвал, өөрийг нь бид хайрладгийг Тэнгэрлэг Эцэг мэддэг.

Дуу

“Би Хүндэтгэлтэй Байхыг Хичээнэ” дууг хүүхдүүдийн хамт дуулах буюу үгийг нь хэл.

Тэнгэрлэг Эцэгтээ би хайртай,
Тэгээд түүний өргөөнд байхдаа би
Хүндэтгэлтэй байхыг хичээнэ би
Тэгвэл тэр надад ойр байх болно.

Үйл ажиллагаа

Хайчилбаруудыг дотор нь хийсэн цүнх буюу савыг үзүүл. Хүүхэд бүрийг нэг нэгээр нь цүнхнээс нэг хайчилбарыг авахуулж, бусад хүүхдүүдэд харуулан, “Тэнгэрлэг Эцэгийн өргөөнд хүндэтгэлийг харуулахын тулд (хайчилбар дээр харуулсан зүйлээрээ) та нар яах ёстой вэ?”

Байж болох хариултууд:

Ам—Аяархан ярь, инээмсэглэ, дуу дуул, залбир, өөр хүн ярьж байхад дуугүй бай.

Нүд—Багш буюу үг хэлэгчийг хар, залбирлын үед нүдээ ань.

Гар—Хөдөлгөөнгүй байлга, асуултад хариулахын тулд өргө, залбирлын үед гараа зөрүүлэн хумхи.

Хөл—Чимээгүй яв, хөдөлгөөнгүй байлга.

Чих—Хэлж байгаа зүйлийг сонс.

Үйл ажиллагаа

Дараах амралтын үйл ажиллагааны үгсийг хэлэх буюу үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Би тэргүүнээсээ (*гараа толгой дээрээ тавина*) эхлээд
Хөлийнхөө хуруу (*хөлийнхөө хуруунд хүрнэ*) хүртэл
Үргэлж хүндэтгэлтэй байдаг.

Явахдаа (*байран дээрээ чимээгүй алхана*) би тэгээд

Ямагт чимээгүй алхдаг.

Ярихдаа би

Үгээ зөөлхөн хэлдэг (*хуруугаа уруулдаа хүргэнэ*).

Огцом чанга биш (*толгойгоо хажуу тийш эргүүлнэ*).

Сонсохдоо би (*гараа чихэндээ хөмрөнө харуулна*)

Уруулаа хамхидаг (*уруулаа жимийсэн байна*)

Гараа би хумьдаг (*гараа хумьсан байна*).

Залбирахдаа би,

Толгойгоо бөхийлгөдөг (*толгойгоо бөхийлгөнө*)

Нүдээ мөн аньдаг (*нүдээ анина*).

Би тэргүүнээсээ (*гараа толгой дээрээ тавина*) эхлээд

Хөлийнхөө хуруу (*хөлийнхөө хуруунд хүрнэ*) хүртэл

Үргэлж хүндэтгэлтэй байдаг.

(Diana Eckersell Janson, “I’m Always Reverent”-аас авав, *Friend*, 1993 оны

Есдүгээр сар, х. 32.)

Хүндэтгэлтэй Байхад нь Бид Бусдад Тусалж Чадна

Багшийн
танилцуулга

Тэдний үйлдлүүд эргэн тойрон дахь хүмүүст нөлөөлдгийг хүүхдүүдэд сануул. Энэ бол Сүм дээр хүндэтгэлтэй байхын өөр нэгэн сайн шалтгаан мөн.

- Хүүхдийн Хэсэгт чиний ойрхон хэн нэгэн дуу шуугиан гаргавал чамд ямар санагдах вэ?

Хэрэв бидний дэргэд байгаа хэн нэгэн дуу шуугиан гаргаад байх юм бол Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн тухай бодох нь бидний хувьд хүнд байх болно. Үүнчлэн бид дуу шуугиан гаргах эсвэл өөр ямар нэгэн хүндэтгэлгүй юм хийх юм бол, өөр хүмүүс бидний хувьд хүндэтгэлтэй байх нь хүнд зүйл болно. Өөрсдөө ч бусдын хувьд ч хүндэтгэлтэй байдлаар үйлдэхэд хүүхдүүдийг урамшуул.

Түүх	<p>Илүү хүндэтгэлтэй байхад нь найздаа тусалсан өөрийн таньдаг хүүхдийн тухай түүхийг ярь, эсвэл дараах түүхийг ярь:</p> <p>Патти их аз жаргалтай охин байв. Тэр инээмсэглэх, инээх, бас дуулах дуртай байжээ. Гэвч тэр хамгаас илүүгээр ярих дуртай байв. Түүнд ярих юм үргэлж бэлэн зэлэн байдаг бөгөөд түүнийг сонсож болох хэнтэй ч гэсэн ярьдаг байлаа. Паттигийн хамгийн сайн найз нь бараг л Паттигийн нэгэн адил их ярих дуртай Мэри Жөү байв.</p> <p>Нэг Ням гарагт Патти Мэри Жөүгийн Хүүхдийн Хэсгийн хичээлд иржээ. Нээлтийн үйл ажиллагааны үед Патти шинэ гутлынхаа тухай Мари Жөүд ярьж эхэлтэл, Мэри Жөү толгой сэгсэрч чимээгүй байхыг Паттид хөдөлгөөнөөр дохин үзүүлэв.</p> <p>Түүнийг сонсох хүн нэгэнт үгүй учраас Патти ярихаа больж, төдөлгүй багшийн ярьж байсан түүхийг сонирхох болжээ. Тэр Аврагчийн тухай мэдэж, Хүүхдийн Хэсэг түүнд таалагдсан аж.</p> <p>Охидыг явахад хичээл дээр хүндэтгэлтэй байсны төлөө багш нь тэдэнд талархал илэрхийлжээ. Хичээлийн дараа Мэри Жөү Хүүхдийн Хэсгийн үеэр тэр яагаад түүнтэй яриагүйг Мэри Жөү тайлбарлажээ. Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрт тэр хайртай учраас тэр сүмд үргэлж идэвхтэй байхыг хичээдэг гэж Мэри Жөү хэлжээ.</p>
Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Мэри Жөү яагаад Хүүхдийн Хэсэг дээр хүндэтгэлтэй байхыг хүссэн бэ? • Хүндэтгэлтэй байхад нь Паттид Мэри Жөү хэрхэн тусалсан бэ? • Хүндэтгэлтэй байхад нь чи бусдад хэрхэн тусалж болох вэ?
Гэрчлэл	<p>Дүгнэлт</p> <p>Хүндэтгэлтэй байх нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай тэрчлэн тэднийг нь хайрлах хайрыг мэдрэхэд нь тэдэнд туслах болно гэдгийг хүүхдүүдэд гэрчил. Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг хүндэтгэх онцгой мэдрэмж төрсөн хувийнхаа туршлагыг та хуваалцаж болно.</p> <p>Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг хайрлан хүндэтгэх өөрсдийн мэдрэмжийг илэрхийлэх боломжийг хүүхдүүдэд олго.</p> <p>Хүүхдийн Хэсгийн дараа цуглааны байрыг орхиж бусад цуглаануудад явахдаа хүндэтгэлтэй байхад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.</p> <p>Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.</p>

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хуруугаар тоглох дараах тоглоомыг тоглоход нь хүүхдүүдэд тусал:

Цасны ширхэг унах шиг чив чимээгүй (*Хоёр гараа өндөрт өргөж дараа нь доош буулган, хуруунуудаараа дэвнэ*),

Цэцэг ургах шиг чив чимээгүй (*эхлээд нударга зангидаж, дараа нь цэцэг гөлөглөх адил хуруунуудаа тэнийлгэнэ*)

Эрвээхэй мэт чив чимээгүй (*эрхий хуруугаа нийлүүлж, бусад хуруунуудаараа далавч адил дэвнэ*)

Намуухан, намуухнаар хажуугаар өнгөрнөм.

Хүүхдийн Хэсэгт ирэхдээ би *(хоёр гараа зөрүүлнэ)*
Ийм л чимээгүй байх болно *(өрөөсөн гараа зүрхэн дээрээ тавина)*

2. Даавуун бөмбөг буюу өөр ямар нэг зөөлөн зүйлийг хүүхэд рүү шидэж өгөөд, хүндэтгэлээ харуулах аль нэг арга замын тухай хэлэхийг тэр хүүхдээс хүс *(Хариултууд нь: цэх шулуун суух, сонсох, Есүсийн тухай бодох, гараа өргөх, чимээгүй явах, бусдад хүндэтгэл үзүүлэх, цээжиндээ хоёр гараа зөрүүлэх байж болно.)* Тэгээд нөгөө хүүхэд бөмбөгийг тань уруу эргүүлэн шиднэ. Хүүхэд бүр хэд хэдэн удаа хариулах хүртэл тоглоомыг үргэлжлүүл. Хүндэтгэл үзүүлэх олон арга замын талаар бодоход нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

3. Хүндэтгэлийг оруулсан хэд хэдэн нөхцөл байдалд дүрээр тоглоход нь хүүхдүүдэд тусал. Дараах санаануудыг буюу эсвэл өөрийнхөө санаануудыг ашигла:

- Хичээлийн үед Хүүхдийн Хэсгийнхээ багшид ямар нэг зүйл хэлмээр чамд санагджээ. Үүнийг чи яаж хүндэтгэлтэйгээр хийж болох вэ?
- Ангийнхаа дуулж буй дууг чи мэдэхгүй байж. Хүндэтгэлийг харуулахын тулд чи яах вэ?
- Жаахан дүү чинь ариун ёслолын үед чамтай ярьжээ. Хүндэтгэлтэй байхад нь түүнд туслахын тулд чи юу хийж болох вэ?
- Хүмүүсийг залбирч байхад чи өрөөнд орж иржээ. Чи хэрхэн хүндэтгэл үзүүлж болох вэ?

4. Хуруугаар тоглох дараах тоглоомыг тоглоход нь хүүхдүүдэд тусал:

Сүм энэ байна *(хуруунуудаа атгаж, хуруугаа дотогш харуулан гараа нийлүүлнэ).*

Шовх орой энэ байна *(заагуур хуруугаараа шовх орой хийж үзүүлнэ).*

Хаалга онгойлгоорой *(гараа дэлгэн, хуруугаа атгасан байна),*

Хараарай тэгээд бүх хүмүүсийг *(хуруугаараа дохино).*

Хаалга хаагаарай *(хуруугаа дотогш харуулан гараа дахин атгана)*

Хараач тэдний залбирахыг.

Хаалгаа нээгээрэй *(гараа дэлгэж, хуруугаа атгана),*

Тэд бүгдээрээ гадагш явлаа *(гараа салгана).*

Хурууны энэ тоглоомыг тоглосны дараа энэ тоглоомыг ариун ёслолын цуглааны үеэр ашигласан хүүхдийн тухай болсон явдлыг ярьж өг. Тэр хүүхэд эргэн тойрноо хараад бүх хүмүүс нам гүм суухыг ажигласнаа, хуруун хүмүүсийг мөн л хүндэтгэлтэй болгохыг хүсч, тэднийг өвөртөө хийжээ.

5. “Хүнгдэтгэл Бол Хайр” *(Children’s Songbook, х. 31)* эсвэл “Эцэг Минь, Би Хүндэтгэлтэй Байна” *(Children’s Songbook, х. 29)* дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл.

Хүндэтгэл Бол Хайр

Хүндэтгэл бол чимээгүй суухаас илүү зүйл:

Энэ бол дээрх Эцэгийн тухай бодох юм,

Адислалуудын тухай бодоход надад ирдэг мэдрэмж юм.

Хүндэтгэлтэй байна би, учир нь хүндэтгэл бол хайр юм.

Хүндэтгэлтэй байх үед энэ нь миний үг, үйл хэрэгт харагддаг.

Дагах зам тодорхой байна.

Хүндэтгэлтэй байх үедээ би зүрх сэтгэлдээ

Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр ойр байгааг мэддэг.

(© 1987 by Maggie Olauson. Зөвшөөрлөөр ашиглана.)

Эцэг Минь, Би Хүндэтгэлтэй Байна
Эцэг минь, хүндэтгэлтэй байх болно би
Таны өргөөнд анир чимээгүй алхална би,
Гараа цээжиндээ зөрүүлэн толгойгоо бөхийлгөн
Залбирал хэлэх үед нүдээ анина;
Сонсож байгаа үгсийг анхаарна,
Учир нь таны өргөөнд би таныг ойрхон байгааг мэдэрнэ.
Би илүү хүндэтгэлтэйгээр ярихын тулд,
Миний олон бодол илүү төгс байж болно.
Эцэг минь, хүндэтгэлтэй байх болно би
Таны өргөөнд анир чимээгүй алхална би.




Амар Амгаланг Бий Болгогчид Адислагддаг

Зорилго

Хүүхэд бүр гэр орондоо амар амгаланг бий болгогч байхыг нь урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Матай 5:1–12 (эсвэл 3 Нифай 12:1–12), 7:1–5 (эсвэл 3 Нифай 14:1–5, 12)-ыг залбиралтайгаар судал.
2. Дараах зураг чимэглэлийн томруулсан хувийг ангийн хүүхэд бүрийн тоогоор болон өөртөө хий (хичээл 26-д ашиглахын тулд өөрийнхөө хувийг хадгал).



3. Хэрэв боломжтой бол, дуртай зүйлээ хамтран хийж байгаа хэдэн гэр бүлийн зураг ол.
4. Ангийн хүүхэд бүрт зориулан цаасны дээд хэсэгт *Амар амгаланг бий болгогчид адислагддаг* гэж бич.
5. “Инээмсэглэл” (*Children’s Songbook*, х. 267) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
6. Шаардлагатай материалууд:
 - а. Библи буюу Мормоны Ном.
 - б. Харандаа буюу будгийн харандаанууд.
 - в. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - г. Зураг 2-37, Уулан Дээрх Номлол, (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 212: 62166); зураг 2-42, Гэр Бүлийн Хөгжилдөөн.
7. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бидний Гэр Орон Дахь Санаа Сэтгэлийн Байдал Баяртай эсвэл Гунигтай Байж Болно

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хүүхэд бүрт цаасан нүүр өг. “Инээмсэглэл” дууг үгэнд нь тохируулан хөмсөг зангидсан буюу инээмсэглэсэн нүүрийг ээлжлэн харуулж өөртэйгөө хамт хүүхдүүдээр дуулуулах буюу үгийг нь хэлүүл.

Ярилцлага

Гэр Бүлийн Хөгжилдөөн, зураг 2-42-ыг түүнчлэн өөрийнхөө олсон, дуртай зүйлээ хамтран хийж байгаа гэр бүлийн гишүүдийн бусад зургуудыг үзүүл.

Зураг дээрх хүмүүсийн санаа сэтгэл ямар байгааг цаасан нүүрийг эргүүлж харуулахыг хүүхдүүдээс хүс.

- Эдгээр хүмүүс яагаад бүгдээрээ баяртай байна гэж та нар бодож байна?

Хэрэв гэр бүлийн гишүүд маргалдаж, зодолдох юм бол тэд ямар байдалтай байна гэж бодож байгаагаа нүүрний төрхөөр нь үзүүлэхийг хүүхдүүдээс хүс.

- Хэрэлдэж, зодолдох нь яагаад гэр бүлийн гишүүдийг уйтгар гунигтай болгодог вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр тэдний цаасан нүүрүүдийг уйтгар гунигтай нүүрний тал руу эргүүлүүлж гэр бүлийг уйтгар гунигтай болгодог ямар нэг зүйлийг хүн бүрээр хэлүүл. Дараа нь хүүхдүүдээр тэдний цаасан нүүрийг баяртай нүүр рүү эргүүлүүлж, тэдний гэр бүлүүдийг баяртай болгодог зүйлүүдийг хэлүүл.

- Танай гэр бүл баяртай байхад дуртай юу эсвэл уйтгар гунигтай байх нь нь дээр үү?

Хүүхдүүдийн анхаарал сарниулахгүйн тулд нүүрнүүдийг хурааж ав. Хүүхдүүд тэдгээрийг гэр лүүгээ авч явахын тулд хичээлийн эцэст эргүүлж өг.

Амар Амгаланг Бий Болгогч Байхыг Есүс Бидэнд Заасан Билээ

Ярилцлага

Уулан Дээрх Номлол, зураг 2-37-г үзүүлж, энэ зургийн талаар юу мэддэгийг нь хүүхдүүдээр яриул. Есүс Христ өндөр дээр гарч, олон чухал зүйлүүдийг, түүний дотор бид өөрсдийн гэр орныг аз жаргалтай болгох зарим арга замыг хүмүүст заасныг тайлбарла.

Матай 5:9 (эсвэл 3 Нифай 12:9)-ийг чанга унш. Амар амгаланг бий болгогчид байхыг Есүс хүмүүст заадаг байжээ. *Амар амгаланг бий болгогч* гэдэг үгийг өөртэйгөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл.

- Амар амгаланг бий болгогч гэж юу вэ?

Амар амгаланг бий болгогч гэдэг нь ууртай байхын оронд баяртай байхад нь бусдад тусалдаг хүн гэдгийг тайлбарла. *Амар амгалан* гэдэг нь тайван байдал ба аз жаргал гэсэн утгатай, иймээс амар амгаланг бий болгогч нь гэр орныг амар тайван, аз жаргалтай газар болгодог.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр амар амгаланг бий болгогчид бөгөөд бидний хүн нэг бүр бас амар амгаланг бий болгогч байж чадна. Яаж гэдгийг Есүс бидэнд хэлсэн билээ.

Матай 7:12 (эсвэл 3 Нифай 14:12)-ыг чанга унш. Бусад хүмүүс өөрсдөд нь яаж ханддаг тэр байдлаар тэдэнд мөн тэгж хандах ёстойг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэгвэл тэд амар амгаланг бий болгогчид болох бөгөөд гэр орондоо аз жаргалын мэдрэмжийг авчрах болно.

Жүжигчлэн тоглох үйл ажиллагаа

Зарим нөхцөлүүдийг хүүхдүүдэд дүрсэлж, эдгээр нөхцөл бүрт амар амгаланг бий болгогчийн үйлдвэл зохих арга замын талаар бодож, тэгээд жүжигчлэн тоглоход нь тэдэнд тусал. Доорх нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл өөрөө зарим нөхцөлийг зохио:

1. Эгч чинь хүрч ирэн гараас чинь номыг чинь шүүрч авахад чи тайвнаар харж байлаа, учир нь тэр үүнийг уншихыг хүссэн ажээ.

- Энэ тохиолдолд чи яах вэ?
- Хэрэв чи амар амгаланг бий болгогч бол юу хэлэх буюу юу хийх вэ?

2. Чи өөрийнхөө дуртай жигнэмгийг авахаар гал тогооны өрөө лүү оржээ. Эрэгтэй дүү чинь жигнэмгийн сав руу харайж очоод сүүлчийн жигнэмгийг аваад идчихэв. Чи ууртай байлаа.

- Энэ тохиолдолд чи яах вэ?
- Хэрэв чи амар амгаланг бий болгогч бол юу хэлэх буюу юу хийх вэ?

3. Чи найзтайгаа хамт зураг зурж байлаа. Модыг ягаанаар будсаны төлөө тэр чамайг шоолжээ. Чи гомдож тэгээд түүнийг доромжилмоор санагджээ.

- Энэ тохиолдолд чи яах вэ?
- Хэрэв чи амар амгаланг бий болгогч бол юу хэлэх буюу юу хийх вэ?

Судар

Матай 7:12 (эсвэл 3 Нифай 14:12)-ыг ангид зориулан дахин унших буюу ярьж өг.

ЗС уриа

Зөвийг сонгох уриаг үзүүл. Хүүхдүүд бусад хүмүүст яаж хандана, тэр байдлаар тэд тэдэнд хандах учиртай бөгөөд тэд бол Есүс Христийг дагаж, зөвийг сонгогчид байдгийг хүүхдүүдэд хэл. Уриа дээрх үгсийг хүүхдүүдээр өөрийнхөө хамт давтан хэлүүл.

Бид Бүгдээрээ Амар Амгаланг Бий Болгогчид Байж Чадна

Түүх

Амар амгаланг бий болгогчдын тухай дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Бишоп өөртөө туслахыг хэдэн залуу хүмүүсээс гуйжээ. Тэрээр нөгөөх залуу хүмүүсийг нэг сарын турш гэр орондоо амар амгаланг бий болгогчид байхыг тэднээс хүссэн боловч юу хийх учиртайг нь тэдний хэнд нь ч хэлсэнгүй. Эелдэг найрсаг, ухаалаг хэрсүү байж сайн үлгэр жишээ үзүүлэхийг тэр тэдэнд хэлсэн аж. Хэрүүл маргааныг зогсооход тусалж, гэр бүлийн гишүүдийг хайрлах хайрыг харуулах арга замыг олохыг тэр тэднээс хүсчээ. Нэг сарын дараа залуу хүмүүс бишоп дээр буцан ирж юу болсныг ярьжээ.

Сарын дараа тэд бүгдээрээ дахин уулзаж юу хийснээ ярьжээ. Амар амгаланг бий болгогчид байх тэдний хүч чармайлтуудын улмаас гэр орон нь амьдрахад илүү баяр хөөртэй газар болсныг залуу хүмүүс бүгдээрээ хэлжээ. (Franklin D. Richards, in Conference Report, 1974 оны 10-р сар, х. 153; *Ensign*, 1974 оны Арваннэгдүгээр сар, х. 106-г үз.)

Ярилцлага

- Бишоп залуу хүмүүсээс юу хийхийг хүссэн бэ?
- Тэд үүнийг хийхэд юу болсон бэ?
- Чи өөрийнхөө гэрт хэрхэн амар амгаланг бий болгогч байж чадах вэ?

Урлан бүтээх үйл ажиллагаа

Амар Амгаланг Бий Болгогчид Адислагддаг гэж дээр нь бичсэн цаасыг хүүхэд бүрт өг. Цаасны дээд тал дээрх үгсийг чанга уншиж, эдгээр үгсийг хүүхдүүдээр хамтад нь давтан хэлүүл. Хүүхдүүдэд харандаа буюу будгийн харандаанууд өгч, аз жаргалтай гэр бүлүүдийнхээ зургийг тэднээр зуруул.

Хүүхдүүдийн зурсан зургуудыг амар амгаланг бий болгогчдын сануулга болгон гэр орондоо хаа нэгтэй өлгөхөд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Дүгнэлт

Дуу

Цаасан нүүрнүүдийг тараан өгч, “Инээмсэглэл” дууг дахин дуулах буюу үгийг нь хэл. Амар амгаланг бий болгогчид байснаар хүүхдүүд хөмсөг зангидалтыг инээмсэглэл болгон хувиргаж чадна гэдгийг тэдэнд сануул.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр биднийг амар амгаланг бий болгогчид байгаасай гэж хүсдгийг гэрчил. Хүүхдүүд гэр орондоо амар амгаланг бий болгогчид байхыг хичээвэл, тэд өөрсдөө болон гэрийнхэн нь илүү аз жаргалтай байж болно гэдгийг тэдэнд сануул.

Ирэх долоо хоногт гэр орондоо амар амгаланг бий болгогч байхаар хичээхэд нь хүүхэд бүрийг урамшуулан дэмж. Дараагийн долоо хоногийн хичээл өөрсдийнхөө туршлагын талаар ярихаар бэлтгэсэн байхыг хүүхдүүдээс хүс.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Ангийн гишүүд гэр орондоо амар амгаланг бий болгогчид байхад нь туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гүй гэж уг хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Есүс Христ, зураг 2-3, эсвэл Есүсийн өөр аль нэг зургийг үзүүл. Есүс Христ тэдний гэрт айлчлахаар ирэх гэж байна гэж хүүхдүүдээр төсөөлөн бодуул. Есүс тэдэнд дээр айлчлан ирэхэд тэд хичнээн их сэтгэл догдлох талаар бодож үзэхийг тэднээс хүс.

- Бэлэн байхын тулд чи юу хийх вэ?
- Есүсийг ирэхэд чи ямар байдалтай байх вэ?

Хэрэв Есүс тэдэн дээр айлчлан ирвэл тэдний хийх зарим зүйлийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул. Хэрэв Есүс тэдний гэр оронд хүрч ирвэл, тэмцэлдэхээр бус харин хуваалцах замаар, бие биэндээ эелдэг найрсаг байх замаар амар амгаланг бий болгогчид байхыг ихэд хичээх байсан гэдгийг тайлбарла. Тэгвэл тэд гэр оронд нь Есүсийн авчирсан сайн мэдрэмжийг эдэлж чадна.

Хэрхэн амар амгаланг бий болгогч байхыг тэд мэдэж болох нэг арга зам бол, хэрэв Есүс тэдний гэр оронд айлчлан ирэх юм бол тэд ямар байдалтай байх талаараа бодох явдал мөн гэдгийг хүүхдүүдэд хэл.

2. “Аз Жаргалтай Гэр Бүл” (*Children’s Songbook*, х. 198) дууг дуулах буюу үгийг нь хэл. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.

Хүүхдүүд амар амгаланг бий болгогчид байгаа үедээ, тэд гэр бүлээ аз жаргалтай болгоход тусалдгийг тэдэнд сануул.

3. “Хэрэв Чи Аз Жаргалтай Байвал” (*Children’s Songbook*, х. 266), дууг дуулах буюу үгийг нь хэлэхдээ *алгаа таш* гэдэг үгийг үйлдэлээр үзүүлэхийг хүүхдүүдэд санал болго.

Хэрэв чи аз жаргалтай байвал мөн үүнийгээ мэддэг бол, алгаа таш.
Хэрэв чи аз жаргалтай байвал мөн үүнийгээ мэддэг бол, алгаа таш.
Хэрэв чи аз жаргалтай байвал,
Тэгвэл нүүр чинь үүнийг лавтайяа харуулна.
Хэрэв чи аз жаргалтай байвал мөн үүнийгээ мэддэг бол, алгаа таш.

4. Бусдын үйлдэлд өөрсдийн үзүүлэх хариу үйлдлийг хүүхдүүд хянаж чадна гэдгийг тэдэнд харуулахын тулд хоёр хүүхдийг өөд өөдөөс нь харуулан зогсоо. Нэг хүүхэд нүүрийн ямар ч хөдөлгөөн харуулахгүй (нүүрний ямар ч илэрхийлэл харуулахгүй) харин нөгөө хүүхэд нь түүнийг инээмсэглэх, инээх гэхчлэн нүүрний өөр ямар нэг илэрхийлэл хийлгэх гэж оролдоно. Энэ үйлдлийг ээлжээр хийхэд оролцох гэсэн бүх хүүхдүүдийг оролцуул.

Гэр орон дахь амар амгалангаас өөр газарт хэн нэгэн хүн ямар нэг зүйлийг хийхэд үзүүлэх өөрсдийн хувийн хариу үйлдлүүдийг хянахыг хичээх ёстой гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Жишээ нь, аль нэг ах юм уу эгч тэдэнд зандран хашгирахад, хүүхдүүд эхлээд мөн л хариуд нь зандран хашгирмаар санагдаж болно, гэвч тэд амар амгаланг бий болгогчид байхыг хүсдэг бол, хариу үйлдэл үзүүлэх өөр илүү сайн аргыг олж чадна.

Зорилго Хүн болгон Есүс Христэд чухал гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

- Бэлтгэл**
1. Лук 15:1–7, Иохан 10:1–18-ыг залбиралтайгаар судал.
 2. Алдагдсан Хонь, зураг 2-44-ийг хатуу цаасан дээр наа. Тэгээд үүнийг эвлүүлж зүйх хэсгүүд болгон хайчилж, эргүүлэн эвлүүлэхэд бүтэн хонь болсон байхад анхаар. (Эдгээр эвлүүлэх хэсгүүдийг цаашид хичээлүүдэд ашиглахын тулд хадгал.) Хичээлийн өмнө эвлүүлэх хэсгүүдийг хонины хамт амархан олдохооргүй газарт ангид хадгал.
 3. Хичээлийн эцэс дэх загварыг ашиглан анги дахь хүүхэд бүрт, мөн өөртөө зориулан хурганы зургийн нэг хувь буюу хуулбарыг бэлтгэ. Хурганы зурган дээр хүн бүрийн нэрийг бич.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Зураг 2-43, Хоньчин.
 5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Гэр орондоо амар амгаланг бий болгогчид байхаар хичээж байгаа туршлагыг нь хүүхдүүдээр илтгүүлж болно.

Хоньчид Хониныхоо Төлөө Анхаарал Халамж Тавьдаг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хоньчин, зураг 2-43-ыг үзүүл.

- Энэ хүн хэн бэ?

Зураг дээрх хүн бол, Есүс Христийг дэлхий дээр байх үед амьдарч байсан хоньчидтой адил хоньчин юм гэдгийг тайлбарла.

- Тэр юу өмссөн байна вэ?

Хоньчны хувцсыг онцлон тэмдэглэ. Хонины арьс буюу ноосоор хийсэн энэ хувцас халуун цөлийн нар болон хүйтэн шөнөөс хамгаалдаг байсныг тайлбарла. Толгой дээрх алчуур нь түүнийг нарнаас хамгаална. Хоньчин усны сав, таяг гэж нэрлэгддэг тулах саваа авч явдаг байжээ.

- Хоньчин юу хийдэг вэ?

Хоньчин хониндоо халамж тавьдгийг тайлбарла. Хонь хоньчныхоо дууг таньдаг, түүний дагуулсан зүгт хонь дагаж явдгийг тайлбарла. Хоньчин хониныхоо араас дагаж явдаггүйг тэмдэглэн хэл. Хонь хаашаа явахыг нь тэдэнд заахын тулд хоньчин хониныхоо өмнө нь явдаг. Хоньчин хонио идээшлэх сайхан ногоон өвстэй бэлчээр лүү дагуулан явдаг. Хоньчин бас

хонио ус руу дагуулан аваачдаг. Шөнө болоход тэр хонио хана буюу хашаагаар хүрээлэгдсэн хороонд нь хаших, эсвэл зэрлэг араатан болон хулгайч нараас хамгаалан аюулгүй агуйд оруулахаар буцаан дагуулж явдаг. Нэг ч хонь алдагдсан байхгүйн тулд хоньчин хонио тоолдог.

Хурга Бүр Хоньчиндоо Чухал

Түүх

Есүсийн үед, эсвэл өнөөдөр, бүх хоньчид хониндоо анхаарал халамж тавьж, тэдгээрийг хамгаалдгийг тайлбарла. Дараах түүхийг өөрийн үгээр тайлбарла:

Карри, Жимми хоёр нэг ферм дээр амьдардаг байжээ. Тэдний гэрийнхэн хонь өсгөдөг байж, Карри, Жимми хоёр ч бас өөрсдийн хөөрхөн бяцхан хургануудтай байж. Тэр хоёр хурганууддаа сайн анхаарал халамж тавьдаг байлаа. Тэд сайн хоньчид байв.

Нэг шөнө хүчтэй шуурга болжээ. Карри, Жимми хоёрын хурга байсан хонины хашааны нэг хэсгийг салхи нураажээ. Аянгын цахилгаанаас айж, бүх хурганууд хашаанаас гарч явжээ.

Өглөө болоход Карри, Жимми хоёр хургануудаа харахаар гадагш гарав. Гэвч хурганууд хаана ч байсангүй. Карри, Жимми хоёр түгшиж эхлэв. Тэд чийгтэй газраар хурганы мөрөөр даган явлаа. Удалгүй Карри, Жимми хоёр бүгдийг нь олсон боловч нэг л хурга байсангүй.

- Карри, Жимми хоёр яасан гэж та нар бодож байна?

Карри, Жимми хоёр хургануудаа хашаанд нь буцааж оруулаад, алга болсон хургыг эрэхээр явжээ. Нэг хурганы мөр бусад хургануудын мөрнөөс өөр зүгт явсныг тэд ажиглав. Тэд энэ мөрийг даган явлаа.

Карри, Жимми хоёр тэгсээр хургыг олов. Хурганы хөл нүхэнд орж эргээд гарч болохгүй болсон байв, тэгээд хурга ядарч туйлдсан байв. Тэд хургыг гэр рүүгээ болгоомжтойгоор авч явжээ. Карри хурганы хөлөн дээрх шалбархайнуудыг цэвэрлэж байх хооронд Жимми хургыг барьж байлаа. Карри, Жимми хоёр бүх хургануудаа олсондоо маш их баяртай байлаа.

- Карри, Жимми хоёр яагаад бусад хургануудаа олсны дараа сүүлчийн хургыг эрэхээр явсан бэ?

Эвлүүлэх үйл ажиллагаа

Өөрийн хийсэн эвлүүлэх хэсгүүдийг шалан дээр юм уу эсвэл ширээн дээр байрлуулж, эвлүүлгийг хамтад нь тавихад хүүхдүүдэд тусал.

Эвлүүлэгт нэг хэсэг дутаж байгааг хүүхдүүд мэдсэн үед, дутаж байгаа хэсэг нь хонины зураг болохыг хэлж өг.

- Хонь алга болоход сайн хоньчин яадаг вэ?

Судрын түүх

Библийг өргөж үзүүлээд, хонь алга болоход сайн хоньчин юу хийдгийг Есүс Христ Библид бидэнд зориулан өгүүлсэн байдгийг хүүхдүүдэд хэл. Есүс дэлхий дээр байх үедээ түүхүүдийг ярих замаар хүмүүст олонтаа заадаг байсныг тайлбарла. Түүхүүдийн нэг нь хоньчин болон алга болсон хонины тухай байлаа. Лук 15:4-ийг унш.

- Сайн хоньчин юу хийх ёстой гэж Библид өгүүлдэг вэ?

Жүжигчлэн тоглох үйл ажиллагаа

Хүүхдүүдээр өөрсдийгөө хоньчид хэмээн төсөөлөн бодуул. Тэднээр хоньчны хувцас өмсүүлж, таяг бариулан дараа нь хонины зурган дээрх алга байгаа эвлүүлэх хэсгийг хайлга. Эвлүүлэх хэсэг олдоход бүх хоньчдыг магтаж, эвлүүлгийг дуусгахын тулд тэднийг цуглуул.

Эвлүүлэх хэсэг олдоход тэдэнд ямар санагдсаныг нь хүүхдүүдээс асуу.

Судар

Лук 15:5–6-д гардаг сургаалт зүйрлэл дэх хоньчин хонио олоход сэтгэл санаа нь ямар байсан тухай ярь. Сайн хоньчин юу хийх ёстой тухай Есүсийн хэлсэн зүйл болон мэдрэмжтэй хүүхдүүдийн туршлагыг харьцуул.

Есүс Христ Сайн Хоньчин, Харин Бид Түүний Хурганууд

Судрын
ярилцлага

Иохан 10:14-ийг чанга унш.

- Энэ судар дахь сайн хоньчин хэн бэ?

Судрууд дахь үгс бол Есүс Христийн үгс. Тэр бол Сайн Хоньчин гэдгийг тайлбарла.

- Есүсийн сүргийн хонинууд хэн бэ? (Сүрэг гэдэг нь олон хониноос бүрдсэн хэсэг хонь гэдгийг тайлбарла.)

Хүүхдүүд бол Есүсийн сүргийн нэг хэсэг гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал. Хоньчин хониныхоо төлөө анхаарал халамж тавьдаг шиг Аврагч биднийг хайрлаж, бидний төлөө анхаарал халамж тавьдаг учраас тэр өөрийгөө хоньчинтой зүйрлэжээ. Тэрээр бид бүгдийг аюулгүй, аз жаргалтай байхыг хүсдэг. Хоньчин хонь болгоноо мэддэг шиг Есүс биднийг нэг бүрчлэн мэддэг. Түүнд бид бүгдээрээ чухал байдаг.

Үйл ажиллагаа

Дээр нь хүүхдүүдийн нэрсийг бичсэн цаасан хургануудыг үзүүл. Нэг хургыг өргөн харуулж, (Хүүхдийн нэрийг хэлээд) бол Есүсийн сүрэг дэх хургануудын нэг мөн гэж хэл. Хургыг ширээн дээр буюу шалан дээр тавь. Өөрийгөө оролцуулан хүн бүгдийг нэрлэх хүртэл энэ үйл ажиллагааг үргэлжлүүл. Байхгүй байгаа хүүхдийн нэр дээр хүрээд, “тэр хүүхдийн нэрийг хэлээд”, бол Есүсийн сүрэг дэх хургануудын нэг мөн, тиймээс тэр өнөөдөр Хүүхдийн Хэсэгт байгаагүйг Есүс мэдсэн байгаа. Өөрийн бүх хүүхдийг энд ирэхийг Тэр хүсдэг” гэхчлэн тэдэнд хэл.

Энэ үйл ажиллагааны дараа бүх хургануудыг цуглуулж аван тэдгээрийг нийтэд нь хүүхдүүдээр тоолуул. Үүний учир бол ангид хичнээн хүүхэд байх ёстойг эсвэл сүрэгт хичнээн хурга байгааг онцлон заахад оршино. Энэ тоог өнөөдрийн хичээлд ирсэн хүүхдийн тоотой харьцуул. Та хүүхдүүдийн төлөө анхаарал халамж тавихад тусалж, тэдэнд заахыг хүсдэг учраас хэрэв тэд өвчлөөгүй буюу хотоос гадагш яваагүй л бол долоо хоног бүр бүгдээрээ ирж байх болно гэдэгт найдаж байгаагаа хүүхдүүдэд хэл. Түүний бүх хурганууд Хүүхдийн Хэсэгт ирдэг байх нь Есүст хичнээн чухал болохыг онцлон тэмдэглэ.

Хүүхдүүд хоньчид байж, алдагдсан хургануудыг олно гэдэг нь—Хүүхдийн Хэсэгт өнөөдөр ирээгүй хүүхдүүдийг Хүүхдийн Хэсэгт буцаж ирэхэд нь тэдэнд туслах явдал мөн гэдгийг хүүхдүүдэд хэл.

Дүгнэлт

Гэрчлэл

Хүүхэд бүр Есүс Христийн хувьд чухал байдаг тухай, Есүс тэднийг нэг бүрчлэн хайрлаж, анхаарал халамж тавьдаг тухай гэрчлэлээ хэл.

Хүүхэд бүрийн нэрийг дээр нь бичсэн цаасан хургыг хүүхэд бүрт өг. Өөрсдийнхөө хургануудыг гэртээ авч очин, хоньчид болон Сайн Хоньчны тухай мэдсэн зүйлээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдийн Хэсэгт өнөөдөр ирээгүй хүүхдэд өгөхийн тулд хүүхдүүдээр зурвас бичүүлэх буюу зураг зуруул. Энэ нь, “Хүүхдийн Хэсэгт бид чамайг саналаа” гэх юм уу эсвэл “Хүүхдийн Хэсэгт ирж бидэнтэй нэгдээч” гэх зэрэг зүйл байж болно.
2. Хүүхдүүдээр өөрсдийнхөө хургануудыг будаж тэднийг ноостой болгохын тулд хөвөн бөөрөнхийлж цавуугаар наалга.
3. “Есүс Бүх Хүүхдүүдэд Хайртай” шүлгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд нь хүүхдүүдэд тусал:

Есүс бүх хүүхдэд хайртай (*гараа алдлан өргөнө*)

Бяцхан хүүхдүүд балчир хэвээрээ байна (*хүүхдийн өндрийг гараараа өвдөгт хүргэн харуулна*)



Өлгийдөө байгаа нялхад ч тэр (*гараараа өлгий дүрслэн харуулна*)

Өндөр болж, том болсон тэдэнд ч бас (*Гараа толгойноос дээш өргөж харуулна*)

(*Finger Fun for Little Folk* by Thea Cannon-аас авав. © 1949 by the Standard Publishing Company, Cincinnati, Ohio. Зөвшөөрлөөр ашиглана.)

4. “Есүс Бяцхан Хүүхдүүдэд Хайртай” (*Children’s Songbook*, х. 59) эсвэл “Би Аврагчийнхаа Хайрыг Мэдэрдэг” (*Children’s Songbook*, х. 74) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа болно.
5. “Хоньчны Зүрх Сэтгэлд Эрхэм Дотно” (*Hymns*, no.221) дууллын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэл.

Хоньчны зүрх сэтгэлд эрхэм дотно,
Түүний сүргийн хонинд эрхэм дотно;
Тэдэнд түүний өгдөг хайр эрхэм дотно,
Алт, мөнгөнөөс ч илүү эрхэм дотно.
Хоньчны зүрх сэтгэлд эрхэм дотно,
Түүний “бусад” алдагдсан хонь эрхэм дотно;
Түүний дагадаг уулсын орой дээгүүр,
Гүнзгий усан дээгүүр.
Тэдний явдаг цөлийн гадна,
Өлссөн, цөхөрсөн, даарсныг
Аврахаар, сүрэгт нь эргүүлж
Авчрахаар тэр яарна.



Зорилго

Тэнгэрлэг Эцэгт талархалтай байж Түүнд талархлаа илэрхийлэхэд нь хүүхэд бүрийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Лук 17:11–19, 1 Тесалоник 5:18-ыг залбиралтайгаар судал.
2. “Дэлхий Даяарх Бүх Хүүхдүүдэд” (*Children’s Songbook*, х. 16) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Жижиг аяга, том халбага, устай сав, аяга, усны савыг багтаахаар хэмжээтэй хайруулын таваг буюу том таваг.
 - в. Хүүхэд бүрт будгийн харандаанууд буюу цаас.
 - г. Самбар, шохой, арилгагч.
 - д. Зураг 2-45, Уяман Өвчтэй Арван Хүн (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 221; 62150).
4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бидэнд Олон Адислал Өгөгдсөн

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хоосон аяга, халбага, устай савыг үзүүл. Тэнгэрлэг Эцэг өөрсдөд нь өгсөн олон адислалуудын талаар бодож үзэхийг хүүхдүүдээс хүс, тэгээд тэд адислалуудыг нэрлэх бүрт устай савнаас нэг халбага ус авч аяга уруу хийхийг тайлбарла.

Дуссан усыг тосч авахын тулд аяга, устай савыг хайруулын таваг буюу том тавган дээр, харин хайруулын таваг буюу том тавгийг ширээ буюу шал зэрэг тэгш гадаргуутай зүйл дээр тавь.

Адислалуудынхаа талаар бодоход нь хүүхдүүдэд туслахын тулд та дараах асуултуудыг ашиглаж болно:

- Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгсөн үзэсгэлэнтэй сайхан бүтээлүүдээс заримыг нэрлэнэ үү?
- Тэрээр биднийг ямар зарим онцгой хүмүүсээр адисалсан бэ?
- Бидний гайхамшигт биес ямар зүйлүүдийг хийж чаддаг вэ?

Хүүхдүүдээр адислалуудыг ээлжээр нэрлүүлж, аягыг бялхаж дүүртэл ус хийлгэ. Тэнгэрлэг Эцэг биднийг хайрладаг бөгөөд бидэнд олон адислал өгснийг тайлбарла. Бид эдгээр адислалуудыг санахдаа, бид Тэнгэрлэг Эцэгт талархаж, Түүнийг хайрлах хайраар дүүрдэг билээ. Энэ аяга усаар

бялхтал дүүрсэн шиг бид хайраар бялхтал дүүрэхийн тулд Тэнгэрлэг Эцэг бидэнд өдий төдий адислал өгсөн юм.

Бид Талархлыг Мэдэрч Бас Харуулах Ёстой

Түүх ба
ярилцлага

Дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Лорагийн төрсөн өдөр дөхөж байв, тэгээд Лорагийн эмээ түүнд тусгай бэлэг өгөхийг хүсчээ. Эмээгийнх нь нүдний хараа муудаж, гараар юм оёх нь түүнд хэцүү болсон ч гэсэн, тэр Лорад хүүхэлдэй хийхээр шийдсэн гэнэ. Сүлжсэн үстэй, хатгамал нүүртэй, гоёмсог цацагт хувцастай хүүхэлдэй хийхийн тулд тэр олон цаг зарцуулсан ажээ. Лорагийн төрсөн өдөр Эмээ нь хүүхэлдэйг боож үүнийг Лора уруу авч явжээ.

Та уг түүхийн хоёр өөр төгсгөлийн тухай ярих гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Анхааралтай сонсож, аль төсгөл нь дээр болохыг шийдэхийг хүүхдүүдээс хүс.

Төгсгөл 1

Лора өөрийн төрсөн өдөр болон бэлэгнүүдэд сэтгэл ихэд догдолжээ. Тэр бүгдийг хурдан задлав. Тэр эмээгийнхээ өгсөн бэлгэнд хүрч ирэн, боодлыг задлан, хүүхэлдэйг хоромхон зуур харснаа, хажуу тийш нь шидчихээд, дараачийн бэлэгт хүрэв.

- Хүүхэлдэй Лорад таалагдсан гэж та нар бодож байна уу?
- Лорагийн эмээд ямар санагдсан гэж та нар бодож байна?

Төгсгөл 2

Лора өөрийн төрсөн өдөр болон бэлэгнүүдэд сэтгэл нь ихэд догдолжээ, тэгээд тэр бэлэг бүрийг анхааралтайгаар задлав. Эмээгийнхээ боодолтой бэлгийг нээж үзэхэд, аятай сайхан мэдрэмж түүнд төржээ. Нямбайлан сүлжсэн үс, хатгамал нүүртэй, гоёмсог цацагт хувцастай хүүхэлдэйд тэрээр ялдамхнаар хүрэв. Тэгээд тэр эмээ рүүгээ гүйж очин түүнийг чанга тэврэв. “Өө, Эмээ танд баярлалаа” гэж шивнэв.

- Хүүхэлдэй Лорад таалагдсан гэж та нар бодож байна уу?
- Лорагийн эмээд ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Аль төгсгөлд Лора эмээгээ хайрлах хайр болон хүүхэлдэйг хийхийн тулд эмээ нь олон цаг зарцуулсныг өндрөөр үнэлснээ харуулсан бэ?

Ярилцлага

Талархал гэдэг үгийг самбар дээр бичиж, хүүхдүүдтэй хамт үүнийг хэл. Талархал гэдэг бол талархах мэдрэмж гэдгийг тайлбарла. Хэн нэгэн хүн бидний төлөө ямар нэг зүйл хийсэн буюу бидэнд ямар нэг зүйл өгсөнд бид талархалтай байгаа бол бид талархлаа харуулах ёстой.

- Түүхийн хоёр дахь төгсгөлд Лора хүүхэлдэйн төлөө талархлаа хэрхэн илэрхийлсэн бэ?

Бидэнд талархлын мэдрэмж төрж талархалаа илэрхийлэх үед бид баяртай байдаг, мөн бидний талархалаа илэрхийлж байгаа хүн ч гэсэн бас баяртай байдгийг тайлбарла. Лора талархалыг мэдэрч, илэрхийлсэн учраас Лора болон түүний эмээгийн хуваалцсан хайрын хийгээд аз жаргалын мэдрэмжүүдийн тухай ярилц.

Судрын түүх ба
ярилцлага

Уяман Өвчтэй Арван Хүн, зураг 2-45-ыг үзүүлж, Лук 17:11–19 дэх түүхийг ярь.

Уяман өвчин бол биеийн эрхтнүүдийг сүйтгэдэг арьсны өвчин гэдгийг тайлбарла. Уяман өвчнийг авчих вий гэж хүмүүс боддог байснаас тэд

уяман өвчтэй хүмүүсээс айдаг байжээ, тиймээс уяман өвчтэй хүмүүс гэр бүл, найз нөхдөөсөө хол хөндий байх ёстой байв.

Есүс Христийн хий гэснийг тэд хийхэд уяман өвчтэй хүмүүс уяман өвчнөөсөө эдгэрч байсныг онцлон тэмдэглэ. Тэд гэр бүл, найз нөхөдтэйгөө дахин хамт амьдрах боломжтой болж байлаа.

- Хэрэв Есүс Христ энэхүү агуу гайхамшгийг та нарын төлөө үйлдсэн бол та нарт ямар санагдах байсан бэ?

Уяман өвчтэй хүмүүс талархлаа хэрхэн илэрхийлснийг мэдэхийн тулд өөрийг тань Лук 15–17-г унших үед хүүхдүүдийг анхааралтай сонсго.

- Уяман өвчтэй хичнээн хүн эдгэрсэн бэ?

Хүүхдүүдээр арван хурууг нь өргүүл.

- Уяман өвчтэй хичнээн хүн Есүст талархахаар эргэж ирсэн бэ?

Хүүхдүүдээр есөн хурууг нь буулгуул. Арван хүнээс зөвхөн ганцхан нь Есүсийн үйлдсэн гайхамшгийн төлөө түүнд талархал илэрхийлснийг онцлон тэмдэглэ.

- Яагаад тэр хүмүүсээс зөвхөн ганцхан нь Есүст талархахаар эргэж ирсэн гэж та нар бодож байна?

Бид Залбирлууддаа Тэнгэрлэг Эцэгт Талархаж Болно

1 Тесалоник 5:18-ыг хүүхдүүдэд чанга уншиж өг.

- Биднийг юу хийх ёстой гэж энэ судар өгүүлдэг вэ?

Тэнгэрлэг Эцэг бидний хүн болгонд олон адислал өгснийг хүүхдүүдэд сануул. Адислалуудынхаа төлөө бид түүнд талархахад Тэрээр баяртай байдаг.

- Бидэнд түүний өгсөн олон адислалын төлөө бид Тэнгэрлэг Эцэгт хэрхэн талархаж болох вэ?

Дуу

“Дэлхий Даяарх Бүх Хүүхдүүд” дууг дуулах буюу үгийг нь хэл.

Өдрийн төгсгөлд дэлхий даяар,
Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд өвдөг сөгдөн залбирна,
Энэ тусгай арга замаар хүн бүр танд талархал өргөнө,
Баярлалаа гэж хэлэн энэ тусгай арга замаар танд талархал өргөнө.

“Грациас,” “Мал-о,” “Вөр данкен дир.”

Дэлхий даяар эелдэг ялдамхан дуу хоолой сонсогдоно

Зарим нь “так,” бусад нь “мөрсц,”

“Канша шимасу” хэмээн бид танд талархана.

Тэнгэрлэг Эцэг маань тэднийг сонсоно;

Тэрээр хэл болгоныг ойлгоно.

Тэнгэрлэг Эцэг маань тэднийг танина;

Тэр тэднийг хайрладаг, тэднийг, хүн болгоныг хайрладаг.

Ярилцлага

- Бид хэзээ залбирдаг вэ?

Өөрсдийн залбирдаг янз бүрийн цаг хугацааны тухай түүнчлэн залбирал бүрт бид Тэнгэрлэг Эцэгтээ талархал илэрхийлж болох зүйлүүдийн тухай ярилц. Жишээ нь, бид хоолны өмнө залбирахдаа, бидэнд идэх хоол өгдөггөйг нь төлөө Тэнгэрлэг Эцэгт талархаж болно. Бид залбирлууддаа Тэнгэрлэг Эцэгт талархахыг санахын ач холбогдолд онцгойлон анхаар.

Бид Ажил Үйлсээрээ Дамжуулан Талархлаа Илэрхийлж Болно

Ярилцах үйл
ажиллагаа

Бид бас ажил үйлсээрээ дамжуулан талархлаа илэрхийлж болдгийг тайлбарла. Бид зарлигуудыг дуулгавартай сахиж, Тэнгэрлэг Эцэг биднээс хийхийг хүсдэг зүйлүүдийг хийх юм бол, бид Тэнгэрлэг Эцэгийг хайрладгаа, тэрчлэн бидэнд түүний өгсөн зүйлүүдийг өндрөөр үнэлдгээ харуулдаг.

Хүн өөрийн ажил үйлсээр талархлаа илэрхийлж болох зарим нөхцөлүүдийг дүрсэл. Тэнгэрлэг Эцэгт дуулгавартай байснаар хүн бүхэн талархлаа хэрхэн илэрхийлж болох тухай ярихыг хүүхдүүдээс асуу. Дараах нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл өөрөө зарим нөхцөлүүдийг зохио:

1. Мэри бол гэрийнхээ ууган хүүхэд нь. Тэр хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй дүүтэй. Тэр гэр бүлдээ талархалтай байдаг.
 - Мэри гэр бүлдээ талархалтай байдгаа Тэнгэрлэг Эцэгт яаж харуулж болох вэ? (Гэр бүлийнхээ гишүүн бүрт хайр, эелдэг ялдам байдлыг харуулснаар.)
2. Жон нэмэлт мөнгө олохын тулд хөршийнхөө зараалаар юманд явжээ. Тэнгэрлэг Эцэг ажил олоход түүнд тусалсанд тэр талархалтай байна.
 - Жон Тэнгэрлэг Эцэгт талархлаа яаж харуулж болох вэ? (Олсон мөнгөнөөсөө аравны нэг төлснөөр.)
3. Ким хөл бөмбөг тоглох дуртай. Тэнгэрлэг Эцэг түүнд хүчтэй, эрүүл бие махбод өгсөнд тэр талархалтай байдаг.
 - Бие бялдрынхаа төлөө Ким Тэнгэрлэг Эцэгт талархлаа илэрхийлэхийн тулд юу хийж болох вэ? (Мэргэн Ухааны Үгийг сахиж; сайн хоол хүнс идэж, бие бялдартаа анхаарал халамж тавих.)
4. Лигийн гэр бүлд номлогчид сайн мэдээг зааж байв, тэгээд эдний гэр бүл баптисм хүртжээ. Ли номлогч нарт нэн их талархалтай байдаг.
 - Тэнгэрлэг Эцэгт талархлаа илэрхийлэхийн тулд Ли юу хийж болох вэ? (Тэр насанд хүрсэн үедээ номлолд үйлчлэхээр бэлтгэх.)
5. Анна Ням гараг бүрийг хүсэн хүлээдэг. Тэр Хүүхдийн Хэсэгт явах дуртай. Тэр Сүмд талархалтай байдаг.
 - Тэр Тэнгэрлэг Эцэгт хичнээн их талархалтай байдгаа харуулдахын тулд юу хийж болох вэ? (Бүх цуглаануудад оролцох; сүм дээр хүндэтгэлтэй байх.)

Дүгнэлт

Урлан бүтээх үйл
ажиллагаа

Хүүхдүүдэд цаас будгийн харандаанууд өгч, өөрсдийн талархалтай байдаг зүйлүүдийн зургийг тэднээр зуруул. Зургуудынхаа талаар ангийн бусад гишүүдэд ярихыг хүүхдүүдээс хүс.

Гэрчлэл

Хүүхдүүдийн багш байгаадаа та хичнээн их талархалтай байдгаа тэдэнд хэл. Та адислалуудынхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт талархлаа хэрхэн илэрхийлдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг бидэнд олон адислал өгснийг, мөн бид талархалтай байж, адислалуудынхаа төлөө түүнд талархахад тэрээр баяртай байдгийг гэрчил.

Залбирлуудаараа болон ирэх долоо хоногийн ажил үйлсээрээ дамжуулан адислалуудынхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт талархлаа санахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хүүхдүүдийг хаалтын залбиралд бэлтгэж байх үед, ангиараа хийх залбиралд Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлж болох зүйлүүдийн талаар тэднээс асуу.

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Өөрсдийн дуртай амьтад, хүнсний ногоо, жимс юу болохыг ярихыг хүүхдүүдээс асуу. Биднийг баясгахын тулд Тэнгэрлэг Эцэг бүх зүйлийг төлөвлөн, Есүс Христ бүтээснийг онцлон тэмдэглэ. Эдгээр зүйлүүдийн төлөө талархлаа илэрхийлэхийг бид санах ёстой.
2. Зарим амьтдын зураг үзүүл. Ус, тэжээл, арчилгаа, хайр зэрэг мал амьтдад шаардлагатай халамжуудын талаар ярилц. Амьтад болон бусад бүтээлүүдэд анхаарал халамж тавих нь бид тэдгээрийн төлөө талархалтай байдгийг Тэнгэрлэг Эцэгт харуулдгийг тайлбарла.
3. Хэрэв олдвол, “Reverence for God and Creation”, *Family Home Evening Video Supplement 2* (53277)-ыг үзүүл. Биднийг амьдарч, аз жаргалтай байхад хэрэгтэй бүхнийг Тэнгэрлэг Эцэг төлөвлөж, Есүс Христ бүтээснийг онцлон тэмдэглэ. Үй олон адислалуудынхаа төлөө бид хичнээн их талархалтай байдгийг тэдэнд харуулах ёстой.
4. “Эцэг Тандаа Талархъя” (*Children’s Songbook*, х. 20), “Над Шиг Бяцхан Хүүхэд Чадах уу?” (*Children’s Songbook*, х. 9), эсвэл “Хайрт Эцэг Тандаа Талархъя Би” (*Children’s Songbook*, х. 7) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. “Хайрт Эцэг Тандаа Талархъя Би” дууны үг гарын авлагын ар талд байгаа.

Бид бас дуугаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгт талархаж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэнгэрлэг Эцэгт зориулсан магтаалын дуунууд залбиралтай адил юм гэдгийг тайлбарла (С ба Г 25:12).

Эцэг Тандаа Талархъя

Эцэгтээ бид талархал өргөө,
Учир нь тэр бүхнийг бидэнд өгсөн билээ.

Нүд, чих, гар, хөл
Өмсөх хувцас, идэх хоол;

Аав, ээж, бяцхан жаал,
Тэнгэрлэг Эцэг бидэнд бүгдийг өгсөн.

Эцэгтээ бид талархал өргөө,
Учир нь тэр бүхнийг бидэнд өгсөн билээ.

Над Шиг Бяцхан Хүүхэд Чадах уу?

Над шиг бяцхан хүүхэд,
Эцэгт зохих ёсоор талархаж чадах уу?
Тийм ээ! Өө тийм! Сайн болоод үнэнч,
Тэвчээртэй, хийдэг бүхэндээ эелдэг бай!
Их Эзэнийг хайрлаж, өөрийхөөнийг хий;
Бүх зүрх сэтгэлээсээ хэлж сур:
Аав аа, бид танд талархъя!
Аав аа, бид танд талархъя!
Тэнгэр дэх Эцэг минь, бид Танд талархъя!

“Баярлалаа” Гэж Хэлэхээ Санагтун

Хичээл
25

Зорилго

Эелдэг байдал хийгээд хайрын үйлсийнх нь төлөө бусдад талархаж байхыг санахад нь хүүхэд бүрийг урамшуулах.

Бэлтгэл

1. Лук 17:11–19, Сургаал ба Гэрээ 78:19-ийг залбиралтайгаар судал.

2. Баярлалаа зурвасыг доор харуулснаар бэлтгэ:

Баярлалаа. Таныг өөрийнхөө багш байгаад би баяртай байдаг. Хайрын мэндчилгээ дэвшүүлсэн, Ребекка

3. Шаардлагатай материалууд:

а. Библи, Сургаал ба Гэрээ.

б. Харандаа буюу будгийн харандаанууд, хүүхэд бүрийн тоогоор цаас.

в. Самбар, шохой, арилгагч.

д. Зураг 2-45, Уяман Өвчтэй Арван Хүн, (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 221; 62150).

4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Анхааруулга: Энэ хичээлийн үеэр зохих үед нь хүүхдүүдэд “баярлалаа” гэж хэлэхэд тусгайлан анхаар.

Хичээл Заах

Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Тусгай Нэгэн Үгийг Бид Ашиглаж Болно

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Бүх хүмүүстэй таны хуваалцахыг хүсдэг тусгай нэгэн үг байдгийг хүүхдүүдэд хэлж өг. Хүн бүр энэ тусгай үгийг ашиглаж болох хэдий ч энэ үг хангалтгүй ашиглагдах нь олонтаа тохиолддог. “Баярлалаа” гэж нэг хүүхэд шивнэн хэл, тэр хүүхэд хажуу дахь хүүхэддээ “баярлалаа” гэж хэлнэ. Энэ үгийг хүүхэд болгон сонсох хүртэл үргэлжлүүл. Сүүлчийн хүүхдийг босгож, энэ үгийг чангаар хэлүүл.

• Хэзээ бид “баярлалаа” гэж хэлдэг вэ?

Бусад хүмүүс бидний төлөө сайн зүйлс хийхэд бид бүгд дуртай байдаг ч гэсэн, тэдэнд талархахаа бид заримдаа мартдагийг тайлбарла.

Судрын түүх Уяман Өвчтэй Арван Хүн, зураг 2-45-ыг үзүүлж, өмнөх хичээлийн зургийн тухай юу санаж байгаагаа өөртөө ярьж өгөхийг хүүхдүүдээс хүс. Уяман өвчтэй арван хүний тухай түүхийг та хүүхдүүдээр биечлэн тоглуулж болно (Лук 17:11–19-ийг үз).

Энэ зургийн тухай ярилцахдаа Христэд талархсан уяман өвчтэй хүнийг онцлон заа.

- Энэ хүн яагаад Есүс рүү эргэж ирсэн бэ?
- Бусад хүмүүс яасан бэ?

Есүс Христ уяман өвчтэй арван хүнийг эдгээсэн боловч зөвхөн ганцхан нь түүнд талархахаа санасан байна гэдгийг хүүхдүүдэд сануул. Нэг хүн талархахаа санасанд Есүс баяртай байсан хэдий ч бусад нь тэгээгүйд гунигтай байсан нь лавтай.

Ярилцлага

- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт бид юуны төлөө талархах ёстой вэ?
- Өөр хэнд бид талархах ёстой вэ? (Өөрсдийн гэрийнхэн, багш нар, найзууд, бидний төлөө сайн зүйл хийдэг хэнд ч гэсэн.)

Бид Бусдад Талархаж Чадна

Түүх ба
Ярилцлага

Самбар дээр зурсан энгийн зураг (жишээ нь загасны уурга, загас, кекс) ашиглан дараах түүхийг өөрийн үгээр ярь.

Аялал болон загасчлах нь Карлост таалагддаг бөгөөд бараг Бямба гараг болгоныг ойролцоох гол дээр загасчилж өнгөрөөдөг байв. Гэвч дараа нь аав нь нас барж, тэгээд Карлосын хувьд олон зүйл өөрчлөгдөв. Түүнийг загасчлахад дагуулж явах хүн байхгүй болов.

Карлос ганцаардаж, уйтгартай байх болов. Түүний Хүүхдийн Хэсгийн багш Тейлор Ах түүнийг уйтгартай байхыг ажиглаад баяртай болгохыг хүсчээ. Тейлор Ах түүнийг загасчлахаар явахыг урив.

Карлос дахин загасчлахаар явахдаа нэн баяртай байв. Тэр бэлэн болж, Тейлор Ахыг ирж авахыг нь хүлээж байлаа. Карлос Тейлор Ах хоёр гол дээр гайхамшигтай сайхан өдрийг өнгөрөөв. Тэр хоёр нилээд хэдэн загас барьж, үдэш нь Карлосын ээж, эгч, дүүсийн хамт хоолондоо загас идсэн аж.

Карлос өөрийг нь загасчлахад авч явсны төлөө Тейлор Ахад талархал илэрхийлэхийг хүсчээ.

- Тейлор Ахад талархахын тулд Карлос юу хийж болох вэ?

Хүүхдүүд хариулсны дараа, тэдний саналд талархал илэрхийлж, Карлос юу хийхээр шийдсэнийг тэдэнд ярь:

Карлос Тейлор Ахад талархал илэрхийлэхээр шийдэж, түүний төлөө тэр ямар нэг сайхан зүйл хийе гэж боджээ. Карлос ээждээ бялуу хийхэд нь тусалж, маргааш нь үтэр үүнийг Тейлор Ахын гэрт аваачиж өгчээ. Карлос бялууг Тейлор Ахад өгч, “Намайг загасанд авч явсанд баярлалаа” гэжээ.

- Карлос түүнд бялуу аваачиж өгөхөд Тейлор Ахад ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Карлост ямар санагдсан гэж та нар бодож байна?

Судар

Сургаал ба Гэрээ 78:19-ийг чанга унш. Хэрэв бид талархалтай байх юм бол бид аз жаргалтай байх болно гэж энэ судар өгүүлдгийг тайлбарла.

Хүүхдийн оролцоо	<ul style="list-style-type: none"> • Хүнд “баярлалаа” гэж хэлэхэд та нарт ямар санагддаг вэ? • Хүн та нарт “баярлалаа” гэж хэлэхэд та нарт ямар санагддаг вэ? <p>Хэн нэгэн өөрсдийнх нь хийсэн сайн зүйлийн төлөө талархсан тохиолдлуудын тухай тэрчлэн тэдэнд талархал илэрхийлэхэд ямар санагдаж байсныг ярихыг хүүхдүүдээс хүс. Та өөрийнхөө хувийн туршлагаас ярьж болно.</p>
Түүх	<p>“Баярлалаа” Гэдгийг Бид Олон Янзаар Хэлж Болно</p> <p>Дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:</p> <p>Вэлс Эгч Хүүхдийн Хэсгийн багш байв. Заах нь түүнд таалагддаг байв, бас ангийнхаа хүүхдүүдийг хайрладаг байлаа. Ням гараг бүрийн хичээлийг тэр сайн бэлтгэж заахыг хичээдэг байв. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг тэр хайрладаг байсан бөгөөд өөрийнхөө гэрчлэлийг мөн Есүс Христ хүүхэд бүрийг хичнээн их хайрладаг тухай тэдэнд ярьдаг байлаа. Тэр ангийнхаа хүүхдүүдэд хайр, анхаарал халамж үзүүлдэг байв. Тэр тэдний төрсөн өдөр болон тусгай үйл явдлуудыг үргэлж санадаг байв.</p> <p>Нэг Ням гарагт сүмийн дараа нэг хүн Вэлс Эгчийн хаалгыг тогшив. Энэ бол түүний ангийн охидын нэг Ребекка байв. Ребекка Вэлс Эгчид гоё ягаан дугтуйтай юм өгөв.</p> <ul style="list-style-type: none"> • Дугтуйнд юу байсныг та нар таана уу?
Ярилцлага	<p>Өөрийн бэлтгэсэн баярлалаа зурвасыг гаргаж үүнийг ангийханд уншиж өг.</p> <ul style="list-style-type: none"> • Вэлс Эгч энэ зурвасыг унших үед түүнд ямар санагдсан гэж та нар бодож байна? • Ребекка багшдаа “баярлалаа” гэдгийг яаж хэлсэн бэ? • Бид талархлаа илэрхийлж болох зарим арга зам юу вэ? • Хэн та нарт сайн зүйлүүд хийдэг вэ? <p>Сүүлчийн асуултуудын хариуг самбар дээр хүүхдүүдээр жагсаан бичүүл. Бүх хүүхдэд хариулах боломж олдсоны дараа, самбар дээрх жагсаалт руу тэдний анхаарлыг хандуулж, хүн бүрт тэд юуны төлөө талархаж болохыг хүүхдүүдээс асуу. Жишээ нь, хүүхдүүдээс дараахыг асуу:</p> <ul style="list-style-type: none"> • Бишопын зөвлөлийн гишүүдэд та нар юуны төлөө талархаж болох вэ? • Хүүхдийн Хэсгийн хөгжмийн удирдаач буюу төгөлдөр хуурчид та нар юуны төлөө талархаж болох вэ?
Урлан бүтээх үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдэд харандаа буюу будгийн харандаанууд, цаас өгч баярлалаа зурвас хийлгэ. Зурвасууд дээрээ <i>Баярлалаа</i> гэж бичих буюу бичихэд нь тэдэнд тусал, тэгээд дараа нь харандаа буюу будгийн харандаагаар зурвасуудыг тэднээр чимэглүүл.</p> <p>Тэд энэ зурвасыг талархал илэрхийлэх гэсэн хэн нэгэнд өгч болно гэдгийг тайлбарла. Зурвасуудаа өгөх хүний тухай хүүхдүүдээр яриул. Бусдад талархал илэрхийлэх нь бидний талархлаа илэрхийлдэг хүмүүсийг төдийгүй, бас биднийг өөрсдийг маань баяртай болгодгийг хүүхдүүдэд сануул.</p>
Багшийн танилцуулга	<p>Дүгнэлт</p> <p>Хичээл дуусахын өмнөхөн, Хүүхдийн Хэсгийн үед сайн зүйл хийснийх нь төлөө хүүхэд бүрт талархал илэрхийл. Чин сэтгэлээсээ мөн тухайн байдалд</p>

тохируулан ханд. Та дараах зүйлүүдийн төлөө хүүхдүүдэд талархал илэрхийлж болно—

- Хичээлийн үед чимээгүй суусны төлөө.
- Хичээлийг анхааралтай сонссоны төлөө.
- Нээлтийн залбирал хэлсний төлөө.
- Бусдад эелдэг хандсаны төлөө.
- Нээлтийн үйл ажиллагаанд дуулсаны төлөө.
- Үг хэлэхийн өмнө гараа өргөсний төлөө.
- Асуултанд хариулсны төлөө.
- Хичээлийн үед баяртай байсны төлөө.

Гэрчлэл

Хичээлд чинь бүх хүүхэд ирсний төлөө талархлаа илэрхийл. Энгийн “баярлалаа” гэдэг үг хүнийг хэрхэн баяртай болгодгийг хүүхдүүдэд сануул.

Долоо хоногийн туршид гэрийнхэн болон найз нартаа “баярлалаа” үгийг хичнээн удаа хэрэглэдгийг тоолж үзэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдийг босч, сандлуудаа тойрон явах зай гарган, сандлуудаа ойртуулан тавихыг хүс.

Доор харуулсан үйлдлүүдийг ашиглан “Бид Хоёр Чихтэй” (*Children's Songbook*, х. 269) дууны эхний бадаг болон дахилтыг дуулах буюу үгийг нь хэлэхэд хүүхдүүдэд тусал.

Үнэнийг сонсохын тулд надад хоёр чих байдаг (*чих рүүгээ заана*)
Сайныг харахын тулд хоёр нүд байдаг (*нүд рүүгээ заана*)
Хаашаа хэрэгтэй газар намайг
Авч явахын тулд надад хоёр хөл байдаг (*сандлуудыг тойрон явна*)

Дахилт:

Ажилдаа болон тоглоомонд (*бөмбөг цохиж хөөргөх дүр үзүүлнэ*)
Тэдгээрийг ухаалгаар ашиглахыг хичээнэ би.
Тэнгэрлэг Эцэгтээ талархана би
Үүнийг надаар хийлгэсний төлөө (*сууж, гараа энгэртээ зөрүүлэн, толгойгоо бөхийлгөнө*).

2. Бүх хүүхдүүд барьж хүрэхээр урт ээрмэл утас буюу оосорт товч буюу бөгж сүвлээд оосрын хоёр үзүүрийг холбож уя. Хүүхдүүдийг тойрог болгон суулгахдаа гарыг нь оосрын дээгүүр ойрхон байлга. Бөгж буюу товчийг “Зогс” гэж хэлэх хүртэл нэг хүүхдээс нөгөө хүүхдэд шилжүүл. Зогс гэж хэлэхэд бөгж буюу товч түүнд байгаа хүүхэд “Би (хүний нэр хэлэх)-нд (ямар нэг зүйл хэлэх)-ний төлөө талархаж байна” гэж хэлнэ. Хүүхэд бүр наад тал нь нэг удаа хариулах хүртэл тоглоомыг үргэлжлүүл.

3. “Талархалтай Байхад Хүргэдэг Намайг” (*Children’s Songbook*, х. 11) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Шөнө орон дотор ганцаараа
 Би нүдээ аниад
 Бурхан надад өгсөн
 Олон зүйлийн төлөө талархдаг.
 Би найз нар бас багш нараа,
 Бас намайг хайрладаг бусдыг хардаг.
 Эдгээр адислалууд ихэд
 Талархалтай байхад хүргэдэг намайг.

4. Өөрсдийн талархалтай байдаг ямар нэг зүйлийг хийх хүүхдүүдэд зориулж давстай зуурсан гурил бэлтгэ (давстай зуурсан гурилын жорыг 43 дугаар хуудаснаас үзэж болно.) Өөрсдийн бүтээлүүдийг гэртээ аваачиж залбирал хэлдэг газартаа тэдгээрийг ойрхон тавихыг хүүхдүүдээс хүс. Тэгвэл тэд өөрсдийн залбиралд Тэнгэрлэг Эцэгт талархахыг санах болно.
5. Ифэр 2:16–18, 6:4–11-д гардаг хөлөг онгоцууд дахь Жарэдчуудын тухай түүхийг ярьж өг. Хөлөг онгоцуудыг дүрслэхийн тулд та хоёр аягыг ирмэгээр нь нийлүүлэн тавьж болно.

Жарэдчуудынх шиг хөлөг онгоц хийхийг тэдэнд болон тэдний гэрийнхэнд Их Эзэн хэлжээ гэж төсөөлөн бодохыг хүүхдүүдээс хүс. Эдгээр жижиг онгоцууд дээр тэд далайд бараг нэг жил болж байгаа гэж төсөөлөн бодохыг тэднээс хүс. Тэд далай дээр давалгаанд шидэгдэн заримдаа бүр живэх шахаж байлаа. Хөлөг онгоцууд дээр бас олон мал амьтад байгаа.

- Иймэрхүү аялалд явбал та нарт ямар санагдах вэ?

Жарэдчуудад аялал ямар санагдаж байсныг харахын тулд Ифэр 6:9-ийг чанга унш. Хэцүү цаг үеийг туулахад ч гэсэн, талархах олон зүйл бидэнд тохиолддогийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Жишээ нь, хэрэв бид өвчилбөл, бидний төлөө анхаарал халамж тавьж байгаа түмүүст бид талархаж болно. Хэрэв бид үргэлж талархал хүлээх зүйлүүдийг эрж хайх юм бол, бид өөрсдийн олон адислалтай учрах болно.

6. Энэ долоо хоногийн турш, хүүхэд бүр танай ангид байгааг та хичнээн өндрөөр үнэлдэг тухай өгүүлж, баярлалаа зурвасыг хүүхдүүдэд илгээ. Хүүхэд бүр ангид тусалсан ямар нэг зүйл хийснийг тусгайлан тэмдэглэ.

Зөвийг Сонгох нь Надад Баяртай Мэдрэмж Төрүүлдэг

Зорилго

Зөвийг үйлдэх нь биднийг баяртай болгодог бол бурууг үйлдэх нь биднийг баяр хөөргүй болгодгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Лук 15:11–24-ийг залбиралтайгаар судал.
2. “Инээмсэглэл” (*Children’s Songbook*, х. 267) мөн “Зөв Замыг Сонго” (*Children’s Songbook*, х. 160) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хүүхэд бүрийн тоогоор жижиг чулуу буюу шош.
 - в. Хичээл 22-т хэрэглэсэн хөмсөг зангидсан буюу инээмсэглэж байгаа нүүр.
 - г. Хүүхдийн тоогоор харандаа буюу будгийн харандаа.
 - д. Хүүхэд бүрийн тоогоор том дугуй цаас.
 - е. Зураг 2-46, Үрэлгэн Хүү (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 220; 62155).
4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Анхааруулга: Найман наснаас доош хүүхдүүд хариуцлага хүлээдэггүй бөгөөд нүглээ наманчлах шаардлагагүйг хүүхдүүдэд сануул. Зөв зүйлийг хийхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж, гэхдээ тэднийг хийсэн зүйлийнх нь төлөө гэм буруутай гэж бодоход бүү хүргэ.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бурууг Үйлдэх нь Биднийг Тавгүй Болгодог

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Нэг хүүхдийн өрөөсөн гутлыг тайлуулж дотор нь жижиг чулуу юм уу эсвэл вандуй хий. Хүүхдэд гутлыг нь өмсүүлж, тасалгаан дотуур хэд алхуул. Хөлд нь ямар байгааг бусад хүүхдүүдэд ярьж өгөхийг тэр хүүхдээс хүс.

Юмс зөв биш байхад бид ая тухгүй буюу баяр хөөргүй байдаг, иймээс бид буруу зүйлийн талаар олон талаас нь боддог.

Гутал доторх юм аа авахыг нөгөө хүүхдээс хүсч, өрөөн дотуур дахин явахыг хүс. Одоо түүний хөлд хичнээн эвтэйхэн байгааг ангийнхандаа хэлэхийг уг хүүхдээс хүс.

Чулуу буюу вандуйг хүүхэд бүрт өгч, гутал дотроо хийж явах хүсэлтэй хүүхдүүдээр үүнийг туршин үзүүл. Тэднийг босгож, хэд алхуулан, гутал доторх зүйл явахад нь хичнээн эвгүй болохыг мэдрүүл. Чулуу буюу вандуйнуудыг буцааж аваад, хүүхдүүдийг дахин босгож, юмыг гутал дотроос авсан нь явахад хичнээн аятайхан байгааг мэдрүүл.

Чулуу буюу вандуйг буруу зүйлтэй харьцуул. Бид ямар нэгэн буруу юм хийхэд, бидэнд ая тухгүй, баяр хөөргүй байдаг. Гэвч бид буруу зүйлийнхээ төлөө харамсаж, буруу сонголтоо залруулахыг хичээх юм бол, энэ нь бид гутал дотроосоо чулуу буюу вандуйг зайлуулахтай адил юм: ая тухгүй мэд-рэмж үгүй болж, бид дахин баяртай байж чадна.

Өнөөдрийн хичээл нь ая тухгүй мэдрэмжийг баяртай мэдрэмжээр солих тухай юм гэдгийг тайлбарла.

Бид Тавгүй Мэдрэмжийг Баяртай Мэдрэмжээр Сольж Болно

- Ямар нэг буруу зүйл хийсэн үед та нарт ямар санагддаг вэ?

Түүх ба
ярилцлага

Буруу зүйл хийж тэгээд баяргүй байсан охины тухай дараах түүхийг өөрийн үгээр ярь. Анхааралтай сонсож, энэ охин баяр хөөргүй мэдрэмжээ баяртай мэдрэмжээр солихын тулд юу хийснийг хүүхдүүдээр олуул.

Анжелагийн найз Мария жижигхэн жимснүүд болон хүнсний ногоонуудтай гоё иж бүрдэл тоглоомон хүнстэй байжээ. Анжела энэ тоглоомон хүнсээр тоглоход дуртай байлаа, бас үүнийг өөрийнх нь байгаасай гэж хүсчээ. Нэг өдөр Мариаг хараагүй үед нь Анжела жижигхэн жимснүүд болон хүнсний ногоонуудаас дүүрэн халбагыг авч халаасандаа хийв. Анжела энэ тухай юу ч хэлэлгүйгээр тоглоомон хүнсийг гэр лүүгээ авч явжээ.

- Анжела авч явсан тоглоомон хүнсээрээ тоглох нь түүнд хөгжилтэй байсан гэж та нар бодож байна уу?

Анжела тоглоомон хүнсээр ил тоглож болохгүй байв, учир нь үүнийг тэр авчирсныг ээж нь мэдэхийг тэр хүсэхгүй байв. Жимснүүд болон хүнсний ногоонуудыг тэр орон дороо хийж, түүгээр тоглохыг хүссэн үедээ орон доогуур мөлхөж орох хэрэгтэй байв. Хэдийгээр Анжелад одоо хүсч байсан тоглоом нь байгаа ч гэсэн, дотроо баяр хөөргүй байлаа.

- Баяр хөөргүй мэдрэмжээ өөрчлөхийн тулд Анжела юу хийж болох вэ?

Тохирох санал гаргасных нь төлөө хүүхдүүдийг магт, мөн Анжелагийн хийсэн зүйлийг тайлбарла:

Түүнийг орон доороо тоглож байхыг Анжелагийн ээж ажиглаад, юу болсныг түүнээс асуужээ. Анжела ээждээ тоглоомон хүнсийг үзүүлээд түүнд хичнээн эвгүй байгааг тайлбарласан ажээ. Тэрээр дахин баяртай байхын тулд юу хийх ёстойг ойлгоход нь Анжелагийн ээж түүнд тусалжээ. Анжела тоглоомон хүнсийг Мариад буцааж өгөөд үүнийг авч явсандаа их харамсаж байгаагаа Мариад ярьжээ. Тоглоомон хүнсийг буцааж өгсний дараа Анжела баяртай болж, сэтгэл нь хөнгөрчээ. Буруу сонголтоо залруулж чадсандаа тэр баяртай байв.

- Анжела ямар буруу зүйл хийсэн бэ?

Ярилцлага

Инээмсэглэж байгаа/хөмсөг зангидсан нүүрний зургийг үзүүл. Эхлээд баяр хөөргүй нүүрийг дараа нь баяртай нүүрийг үзүүл.

- Тоглоомон хүнсийг авч явсны дараах Анжелагийн сэтгэл санааны байдлыг аль нүүрний зураг харуулж байна вэ? (Зургийг баяр хөөргүй тал руу эргүүлэхийг нэг хүүхдээс хүс.)
- Буруу сонголтоо залруулахын тулд Анжела юу хийсэн бэ?
- Тоглоомон хүнсийг буцааж өгсний дараах Анжелагийн сэтгэл санааны байдал ямар байсныг аль нүүр харуулж байна вэ? (Зургийг баяртай нүүрний тал руу эргүүлэхийг нэг хүүхдээс хүс.)

Зарим үед бид бүгдээрээ буруу зүйл хийдгийг хүүхдүүдэд хэл. Буруу зүйл хийх нь биднийг баяр хөөргүй болгодог. Гэвч бид харамсч байгаагаа хэлж, буруу сонголтуудаа залруулах юм бол, бид дахин баяртай болж болно.

Есүс Христ Биднийг Баяртай Байхыг Хүсдэг

Багшийн
танилцуулга

Бид харамслаа илэрхийлж, буруу сонголтуудаа залруулахыг хичээх нь наманчлалын хоёр алхам мөн гэдгийг тайлбарла.

Наманчлал гэдэг үгийг хүүхдүүдээр хэдэн удаа давтан хэлүүл.

Биднийг зөвийг сонгохыг Есүс Христ хүсдэг хэдий ч, бид зарим үед буруу зүйл хийдгийг тэр мэддэг гэдгийг тайлбарла. Бид буруу зүйлүүд хийсэн үед тэр наманчлахыг бидний хувьд боломжтой болгосон юм. Хэрэв бид наманчлах юм бол, бид алдаанууддаа уучлагдаж, дахин баяртай байх болно гэдгийг тэр бидэнд амласан билээ. Наманчлал бол Есүсийн сүмийн гишүүн байхын нэг чухал тал мөн.

Ямар нэгэн буруу зүйл хийх нь бидний гутал дотор чулуу байхтай адил болохыг хүүхдүүдэд сануул. Бидэнд эвгүй байдаг. Наманчлал бол гутал дотроос чулууг авч хаяхтай адил юм. Асуудал шийдэгдэхэд аятай сайхан болдог.

Судрын түүх

Библийг үзүүлж, буруу зүйлийг сонгож, дараа нь наманчлан, зөв зүйл хийсэн нэг хүүгийн тухай судрыг энэ номонд Аврагч өгүүлдгийг тайлбарла. Энэ хүү юу хийсэн болон аав нь түүнд хэрхэн тусалсныг анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс.

Лук 15:11–14 дэх түүхийг өөрийн үгээр ярь. Үрэлгэн Хүү, зураг 2-46-г тохирох цагт нь үзүүл.

Заримдаа энэ түүхийг “Үрэлгэн Хүү” гэж нэрлэгддэгийг тайлбарла. *Үрэлгэн* гэдэг арвич хямгач бус гэсэн утгатайг хүүхдүүдэд хэлж өг. Бага хүү нь шаргуу ажиллахыг хүсээгүй учраас түүний мөнгийг авахыг хүссэнийг тайлбарла. Тэр хүссэнээ л хийхийг хүсдэг байв. Тэр мөнгө олохоороо үрчихдэг байлаа. Сайн биш зүйлүүдэд тэр мөнгөө зарцуулдаг байжээ.

Тэр хүү мөнгөө дууссан үед тэнэг загнаж байснаа, мөн буруу зүйл хийснээ ухаарчээ. Тэр аавдаа эргэж очин, түүнд харамслаа илэрхийлэхээр шийдсэн аж. Тэр эцгийнхээ хүү нь гэж цаашид дуудагдах нь байж боломгүй мэт санагдаж байсан хэдий ч, гэртээ эргэж очоод аавынхаа зарц нарын нэг нь больё гэж түүнээс гуйхаар шийдсэн байлаа.

- Хүү буруу зүйл хийснээ мэдсэн үед түүнд ямар санагдаж байсан гэж та нар бодож байна?

Лук 15:20–24-ийг чанга унш.

- Хүү нь гэртээ эргэж ирэхэд аав нь яасан бэ?
- Аав нь түүнийг мэндлэн угтахад хүүд нь ямар санагдсан гэж та нар бодож байна?

Энэ залуу буруу зүйл хийж байснаа өөрчилж зөв зүйл хийхэд түүний аав баяртай байсан шиг, биднийг буруу сонголтуудаа залруулах гэж хичээх үед бидний эцэг эхчүүд болон Тэнгэрлэг Эцэг бас баяртай байдаг. Бас бид зөв зүйлийг хийхээр сонгох үедээ баяртай байдаг.

Бид Буруу Сонголтуудаа Залруулах Үед Баяртай Мэдрэмжүүд Бидэнд Төрдөг

Үйл ажиллагаа

Хүүхэд бүрт дугуй цаас, харандаа буюу будгийн харандаа өг. Хүүхдүүдээр өөрсдийнх нь инээмсэглэж байгаа/хөмсөг зангидсан нүүрийг зуруул. Зурж дууссан нүүрийг хүүхдүүдэд үзүүлж, хуулбарлахад нь шаардлагатай бол тусал.

Хүн буруу сонголт хийсэн зарим нөхцөлүүдийг дүрсэл. Буруу сонголт хийсний дараа хүн болгоны сэтгэл санаа ямар байхыг харуулахын тулд цаасан нүүрийг нь хүүхдүүдээр өргөж харуул. Дараа нь буруу сонголтоо хүн яаж залруулахыг асууж, үүнийг хийсний дараа хүн тус бүрт ямар санагдахыг харуулахын тулд цаасан нүүрийг хүүхдүүдээр ашиглуул. Дараах жишээ-нүүдийг ашиглах буюу эсвэл зарим жишээг өөрөө зохио:

1. Томас сургуулиас гэр лүүгээ явах замдаа хашаан дээгүүр давж байгаад, хамгийн сайн өмдөө урчихжээ. Ээж нь уурлана гэдгийг тэр мэдэж байв, учир нь сургуулийнхаа хувцастай хашаа битгий давж бай гэж ээж нь түүнд олон удаа хэлдэг байжээ.
 - Томас яах ёстой вэ?
2. Карины ээж түүнд хоёр чихэр, нэгийг нь түүнд өөрт нь, нөгөөг нь эмэгтэй дүүд нь өгчээ. Дүүгээ байхгүй байхаар нь Карин хоёр чихрийг хоёуланг нь идчихэв.
 - Карин яах ёстой вэ?
3. Бен тоглохоор найзынхаа гэрт очжээ, гэтэл найз нь гэртээ байсангүй. Бен буцах гэж байтал найзынх нь нэг тоглоом хашаан дотор байхыг харав. Бен тоглоомыг гэртээ аваачиж түүгээр тоглов.
 - Бен яах ёстой байсан бэ?
4. Рачел сургууль уруу явах замдаа нэг түрийвч олжээ. Дараахан нь нэг охин түрийвч үзээгүй биз гэж түүнээс асуухад, “Үгүй” гэж Рачел хэлжээ.
 - Рачел яах ёстой байсан бэ?
5. Филип дүүтэйгээ арын хашаандаа тоглож байв. Түүний дургуйцдэг нэг зүйлийг дүү нь хийхэд Филип түүнийг цохьж, уйлуулав.
 - Одоо Филип яах ёстой вэ?

Дуу

Инээмсэглэж байгаа/хөмсөг зангидсан нүүрийг хүүхдүүдээр өргүүлж, зохих үед нь цаасан нүүрийг эргүүлж, “Инээмсэглэл” дууг дуулах буюу үгийг нь хэлүүл.

Дүгнэлт

Гэрчлэл

Зөвийг сонгосон үед баяртай мэдрэмж бидэнд байдаг тухай гэрчлэлээ хүүхдүүдэд хэл. Түүнчлэн бид буруу сонголтуудаа залруулсан үед бид бас баяртай байдаг. Есүс Христийн заадаг зүйлүүдийг бид илүү ойр дотно дагаж сурсан үед, бидний хийдэг буруу сонголтууд цөөрөх болно.

Цаасан нүүрүүдийг гэртээ аваачиж, баяртай болон баяр хөөргүй мэдрэмжүүдийн талаар мэдсэн зүйлээ гэрийхэндээ ярихыг хүүхдүүдэд санал болго.

Дуу

“Зөв Замыг Сонго” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Өөрсдийн буруу сонголтуудыг мэдэж залруулахад туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг хүүхдүүдэд сануул.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохи-
рохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт
буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг
“Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Бид Буруу Сонголтуудаа Залруулах Үед Баяртай Мэдрэмжүүд Бидэнд
Байж Болдог” хэсэгт өөрийн дүрсэлсэн нөхцөлүүдийг ашиглан, буруу
сонголтуудаас хэрхэн сэрэмжлэх хийгээд зайлсхийх талаар бодоход нь
хүүхдүүдэд тусал. Өөрсдийнх нь шийдлүүдийг хүүхдүүдээр жүжигчлэн
тоглуул.
2. Шинэ бадгууд зохиож, баяртай сонголтын тухай үйлдлүүдийг хийхэд нь
хүүхдүүдэд тусал, “Хэрэв Чи Баяртай Байвал” (*Children’s Songbook*,
х. 266) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Жишээ нь:

Хэрэв чи баяртай байгаад үүнийгээ мэддэг бол, найз нартаа тусал
(*алгаа таш*)!

Хэрэв чи баяртай байгаад үүнийгээ мэддэг бол, найз нартаа тусал
(*алгаа таш*)!

Хэрэв чи баяртай байгаад үүнийгээ мэддэг бол, зөвийг сонгож үүнийгээ
харуул.

Хэрэв чи баяртай байгаад үүнийгээ мэддэг бол, найз нартаа тусал
(*алгаа таш*)!

Өөр боломжит хувилбарууд:

үнэнийг хэл (*амандаа хоёр удаа хүр*)

тоглоомуудаа хуваалц (*эхлээд нэг гараа, дараа нь нөгөө гараа урагш сунга*)
залбирлуудаа хэл (*гараа өмнөө зөрүүлж, толгойгоо бөхийлгө*)

Бүх санаанууд нэгдсэн сүүлчийн бадгийг дуулснаар та төгсгөж болно:

Хэрэв чи баяртай байгаад үүнийгээ мэддэг бол, найз нартаа тусал
(*алгаа таш*), үнэнийг хэл (*амандаа хоёр удаа хүр*), тоглоомуудаа хуваалц
(*эхлээд нэг гараа, дараа нь нөгөө гараа урагш сунга*), залбирлуудаа
хэл (*гараа өмнөө зөрүүлж, толгойгоо бөхийлгө*)!

3. Хүүхдүүдийг тойрог болгон суулга. Нэгтгэн дүгнэх асуулт асууж, даавуун
бөмбөг буюу өөр зөөлөн зүйлийг асуултад хариулуулахыг өөрийн хүссэн
хүүхэд рүү шидэж өг. Уг хүүхэд хариулсны дараа, тэр давуун бөмбөгийг
тан уруу шиднэ. Хүүхэд бүр дор хаяж нэг асуултад хариулах хүртэл
үргэлжлүүл.

Тавьж болох асуултууд:

- Гутал дотор чинь чулуу юм уу вандуй байвал хөлөнд чинь ямар байх вэ?
- Бид ямар нэг буруу зүйл хийвэл бидний санаа сэтгэл ямар байх вэ?
- Хулгайлагдсан тоглоомоор тоглох нь Анжелад яагаад таалагдаагүй вэ?
- Баяр хөөргүй бодлоо өөрчлөхийн тулд Анжела юу хийсэн бэ?
- Бид буруу сонголтоо залруулахыг хичээх үед бидэнд ямар санагддаг вэ?

Би Хуваалцсанаараа Бусдыг Баяртай Байхад нь Тусалж Чадна

Хичээл
27

Зорилго Бусадтай хуваалцах замаар тэднийг баяртай болоход нь туслахад хүүхдүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Марк 6:30–44, Иохан 6:1–13-ыг залбиралтайгаар судал.
2. Хүүхэд бүрт болон өөртөө ямар нэг бяцхан хөгжилтэй зүйл бэлтгэ. Хэрэв мацгийн Ням гараг бол энэ нь хоол хүнснээс өөр зүйлийг сонгож, хичээлд зохих зохицуулалт хий.
3. “Өгөөч, Гэж Бяцхан Горхи Хэлжээ” (*Children’s Songbook*, х. 236) дууны гуравдугаар бадаг хүртэл дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Бөмбөг, ном, жүрж зэрэг хуваалцаж болох нилээд хэдэн зүйл. Эдгээр юмсыг цаасан буюу даавуун цүнхэнд хий.
 - в. Зураг 2-47, Таван Мянган Хүнийг Хооллосон нь (62143); зураг 2-48, Үсрэгч Дээс (62523); зураг 2-49, Жигнэмэг Хуваалцаж Байгаа Хөвгүүд; зураг 2-50, Блок Хуваалцаж Байгаа Хүүхдүүд.
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Хуваалцаж Чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Цаасан буюу даавуун цүнхэн дотор авчирсан зүйлүүдээ хүүхэд бүрт нэг нэгээр нь үзүүлж, дараах асуултуудыг ашиглан үүнийг ярилц:

- Хэрэв би (юмны нэрийг хэл) өөрөө ашиглавал, үүнийг хичнээн хүн эдэлж болох вэ?
- Хэрэв би үүнийг хуваалцвал хичнээн хүн эдэлж болох вэ?
- Үүнийг би хуваалцаж болох арга замууд юу вэ?

Ярилцлага

Та бүх юмсын тухай хүүхдүүдтэй ярилцсаны дараа асуу:

- Өөр хүнтэй хуваалцаж болох юу юу та нарт байдаг вэ? Та нар үүнийг яаж хуваалцаж болох вэ?

Хуваалцаж болох юмсыг нэрлэн, тэдгээрийг хэнтэй, мөн яаж хуваалцах тухай ярихад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Хэрэв хүүхдүүд эдгээр зүйлүүдийг дурдаагүй бол, бид бас өөрсдийн цаг зав, авьяас чадвар, тэрчлэн сайн мэдээг хуваалцаж болно гэдгийг хэл.

- Бид цаг заваа хэрхэн хуваалцаж болох вэ?
- Бид авьяас чадвараа хэрхэн хуваалцаж болох вэ?
- Бид сайн мэдээг хэрхэн хуваалцаж болох вэ?

Есүс Христ Бидэнд Хуваалцахыг Заасан Юм

Судрын түүх ба ярилцлага

Библийг үзүүлж, хуваалцах замаар Есүс Христ болон өөр олон хүнд тусалсан нэг хөвгүүний тухай түүхийг Библи агуулдгийг тайлбарла. Иохан 6:1–13 (мөн Марк 6:30–44-ийг үз)-т байдаг түүхийг ярь. Таван Мянган Хүнийг Хооллосон нь, зураг 2-47-г холбогдох үед нь үзүүл.

- Тэр хөвгүүнд хичнээн талх, загас байсан бэ? (Иохан 6:9-ийг үз.)
- Таван талх, хоёр загасаар хичнээн хүнийг хооллож болно гэж та нар бодож байна?
- Есүс хичнээн хүнийг хооллосон бэ? (Иохан 6:10-ыг үз.)

Энэ бол үй олон хүн юм гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах ямар нэг хэсэг бүлэгтэй харьцуул (жишээ нь, “Есүс манай хотхоны бүх хүнтэй адил тооны хүмүүсийг хооллосон юм” гэх буюу эсвэл “Манай эндхийн цэнгэлдэх хүрээлэнд багтахаар олон хүнийг Есүс хоолложээ”).

Тэр хөвгүүн хүнсний зүйлийг өөрөө идэж болох байсныг тайлбарла. Гэвч тэр хуваалцах хүсэлтэй байсан учир Аврагч олон мянган хүнд тусалсан гайхамшгийг үйлдсэн билээ.

- Тэр хөвгүүнийг хуваалцахад хүмүүст ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Хуваалцсан хөвгүүнд ямар санагдсан гэж та нар бодож байна?

Дуу

“Өгөөч, Гэж Бяцхан Горхи Хэлжээ” дууны гуравдугаар бадгийг хүртэл дуулах буюу үгийг нь хэл.

Есүс Христ олон зүйлийг бидэнтэй хуваалцсан бөгөөд бусад хүмүүстэй хуваалцахыг биднээс хүсдэгийг хүүхдүүдэд сануул.

Хуваалцсанаар Бид Өөрсдийгөө болон Бусдыг Баяртай Болгож Чадна

Зурган дээрх ярилцлага

Есүсийн үе дэх тэр хөвгүүн хуваалцах арга замыг олсонтой адил бид бас хуваалцах олон арга замыг олж, бусдыг баяртай болгож чадна гэдгийг хүүхдүүдэд хэл. Хуваалцаж байгаа хүүхдүүдийн зургуудыг (2-48, 2-49, 2-50) нэг нэгээр нь үзүүлж, зураг тус бүрт дараах асуултуудыг асуу:

- Энэ зураг дээрх хүүхдүүд юу хийж байна?
- Тэд юу хуваалцаж байна вэ?
- Хуваалцах талаар тэд ямар сэтгэгдэлтэй байдаг гэж та нар бодож байна? Яагаад?

Хүүхдийн оролцоо

Хэзээ тэд хуваалцсан болон хуваалцсан үедээ ямар сэтгэгдэлтэй байсан талаараа ярих боломжийг хүүхдүүдэд олго.

Бид хуваалцах үед зөвхөн бид бусдыг баяртай болоход нь тусалдаг төдийгүй, харин бид өөрсдөө бас баяртай болдгийг заан тэмдэглэ.

Түүх	<p>Хэрэв хүүхдүүд хуваалцах хүслээ харуулсан бол тэднийг магт; дараа нь хуваалцах нь хүн бүрт авчирдаг аятай сайхан мэдрэмжийн талаар тэдэнтэй ярилц. Хуваалцах нь бидэнд баяртай мэдрэмж төрүүлдгийг онцлон тэмдэглэ.</p> <p>Хуваалцсаны улмаас өөрөө баяртай байж, бусдыг баярлуулсан нэг хүүхдийн тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:</p> <p>Ээж нь жаахан эмэгтэй дүүг нь өрөөнд оруулж ирэхэд Давид будгийн харандааны шинэ хайрцгаа гаргаж, нэг гоё зураг будаж байлаа. Аллисонтай будгийн харандаануудаа хуваалцаж, будахад нь дүүдээ туслахыг ээж нь Давидаас хүсчээ. Давид хуваалцахыг хүссэнгүй. Аллисон сайн будсангүй, түүний будгийн харандаануудын нэгийг дүү нь хугалчих магадгүй гэж тэр айжээ. Тэр өөрийнхөө дургүй нэг өнгийн харандаагаа л өгөв.</p> <p>Аллисонд өгсөн харандаа нь удалгүй Давидад хэрэгтэй болов, тэгээд тэр үүнийг буцааж авах гэж оролдов. Аллисон уйлж эхлэх нь тэр. Дүүгээ уйлуулсандаа Давид эвгүйцэж, хэдийгээр дүү нь төдийлөн сайн будаагүй ч гэсэн, мөн л будах дуртай байсныг нь мэдэв. Давид будгийн харандаануудаа хараад, хоёуланд нь хэрэглэж болох олон харандаа байгааг мэджээ. Тэр Аллисонд ямраар л бол будахыг зөвшөөрч, тэгээд дүү нь өөрийнхөө цаасан дээр баяр хөөртэйгөөр будаж байлаа. Давид ч бас баяртай байв. (Marjorie A. Parker, "Inside the Lines,"-аас хялбаршуулан авав, <i>Friend</i>, 1993 оны Хоёрдугаар сар, х. 28–29.)</p> <ul style="list-style-type: none"> • Аллисон яагаад баяртай байсан бэ? • Давид яагаад баяртай байсан бэ?
Үйл ажиллагаа	<p>Дүгнэлт</p> <p>Өөрийн авчирсан зугаатай зүйлүүдийг үзүүл.</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэв эдгээр зугаатай зүйлүүдийг би зөвхөн өөртөө зориулж хадгалдаг бол та нарт ямар санагдах вэ? • Эдгээр зугаатай зүйлүүдийг Есүс намайг яа гэх байсан бол? <p>Зугаатай зүйлүүдийг хоёр хүүхдэд хувааж өгөөд тэднээс асуу:</p> <ul style="list-style-type: none"> • Эдгээр зугаатай зүйлүүдийг Есүс чамайг яа гэх байсан бол? <p>Хоёр хүүхдэд байгаа юмыг нь анги дахь хүн болгоны дунд хуваалгуул. Хуваалцах талаарх өөрийн бодлыг, түүнчлэн хэрэв бүх зугаатай зүйлийг та зөвхөн өөртөө байлгадаг байсан бол танд ямар санагдахыг ангид ярьж өг.</p> <p>Зугаатай зүйлүүдийг хоёр хувааж өгсөн хоёр хүүхдээс эдгээр зүйлүүдийг хуваалцсан тухай дахь сэтгэгдлийг нь асууж дараа нь, тэдэнтэй хуваалцсан сэтгэгдлээ ярихыг үлдсэн хүүхдүүдээс хүс.</p>
Гэрчлэл	<p>Хуваалцах нь баяр хөөр авчирдгийг хүүхдүүдэд гэрчил. Хуваалцсан нь таныг баяр хөөртэй болгосон тохиолдлынхоо тухай та ярьж болно.</p> <p>Энэ долоо хоногт хэн нэгэнтэй ямар нэг юмаа хуваалцахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.</p> <p>Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Хуваалцах хүсэлтэй байхад хүүхдүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг тэр хүүхдэд сануул.</p>

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Бид сүмийн хувьд, ач тустай байхад бид итгэдэг хэмээн өгүүлсэн итгэлийн тунхаг бидэнд байдгийг хүүхдүүдэд хэл. Ач тустай байна гэдэг нь бид бусад хүмүүстэй хуваалцахын хамт тэднийг хайрлах өөрсдийн хайрыг харуулах бусад сайн үйлсийг хийнэ гэсэн утгатай юм. “Ач тустай . . . байхад бид итгэдэг” гэсэн итгэлийн есдүгээр тунхагийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.
2. “Залбирал” (*Children’s Songbook*, х. 22) дууг дуулах буюу үгийг нь хэл. Тэнгэрлэг Эцэг бидэнд олон гайхамшигт адислал өгсөн бөгөөд бид адислалуудаа бусадтай хуваалцахад тэр баяртай байдгийг хүүхдүүдэд сануул.

Тэнгэр дэх Эцэг энэ сайхан өдөр
Баяртай, найрсаг байхад минь надад туслаач
Үргэлж үнэнч шударга байхад минь туслаач.
Адислалуудаа бусадтай хуваалцахад минь туслаач.
3. Найз нар болон гэрийнхэнтэйгээ тэдний хуваалцах дуртай зүйлийг хүүхэд бүрээр хийлгэхийн тулд хүүхдүүдэд зориулан давстай зуурсан гурил авчир (давстай зуурсан гурилын жорыг 43 дугаар хуудаснаас үзэж болно.)
4. Харандаа, будгийн харандаатай сав үзүүл. Өөрт чинь харандаа, будгийн харандаануудтай зөвхөн ганцхан сав байгааг, харин та бүх хүүхэд зураг зурахыг хүсч байгааг тайлбарла. Харандаануудтай савыг нэг хүүхдэд өг.
 - Хүн бүгд харандаа эсвэл будгийн харандаагаар зурахын тулд (тэр хүүхдийн нэрийг хэлээд) яаж болох вэ?

Хүүхэд бүрт цаас өгч, будгийн харандаанууд болон харандаануудыг хүүхдүүдэд хуваан өгч, өөрсдийнхөө хуваалцаж буй зургуудыг зуруул.
5. Номлогч нар болж байгааг (хаалга тогших, судрууд унших, зааж байгаа болон номлогчийн бусад үйл ажиллагаанууд) хүүхдүүдээр үггүйгээр дүрслүүл.
 - Номлогч нар юу хуваалцдаг вэ?
 - Сайн мэдээг бусадтай хуваалцах үед номлогч нарт ямар сэтгэгдэл төрдөг гэж та нар боддог вэ?

Зорилго

Бусдад эелдэг байхад нь хүүхэд бүрийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Лук 10:25–37, Иохан 13:34–35, 15:12-ыг залбиралтайгаар судал. Мөн Матай 22:36–40 болон *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 30-ийг үз.
2. “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” (*Children’s Songbook*, х. 61)-ийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хайчилбар 2-1, шархадсан хүн; хайчилбар 2-2, санваартан; хайчилбар 2-3, Леви хүн; хайчилбар 2-4, Самари хүн.
4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Хүн Бүхэнд Эелдэг Байхыг Есүс Христ Бидэнд Заасан

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хичээлийн төгсгөл дэх Ариун Нутгийн газрын зургийг хүүхдүүдэд үзүүл.

- Энэ юу вэ? (Газрын зураг.)

Хэрэв хүүхдүүд газрын зургийг мэдэхгүй байвал, газрын зураг гэдэг бол улс орон буюу хот зэрэг хэсэг газар нутгийн зураг юм гэдгийг тайлбарла. Нэг газраас нөгөө газарт яаж хүрэхийг мэдэхийн тулд хүмүүс газрын зургуудыг ашигладаг. Хуурай газар, далай тэнгис, гол мөрөн зэрэг газрын зургийн зарим онцлогуудыг тэмдэглэн хэл.

Энэ газрын зураг Есүс Христ дэлхий дээр байх үедээ амьдарч байсан Ариун Нутгийг харуулдгийг тайлбарла.

Иудейг заа. Ариун Нутгийн энэ хэсэгт амьдарч байсан хүмүүсийг Иудейчүүд гэдэг байсныг тайлбарла.

Самарийг заа. Самарид амьдарч байсан хүмүүсийг Самаричууд гэдэг байсныг тайлбарла.

Есүсийн үед Иудейчүүд болон Самаричууд бие биенээ ойлгодоггүй, бие биендээ дургүй байсныг тайлбарла. Иудейчүүд өөрсдийгөө Самаричуудаас илүү сайн гэж боддог байв. Иудейчүүд Самари хүний гэрт хоол иддэггүй эсвэл Самаричуудын бэлтгэсэн хоолыг иддэггүй байв. Иудейчүүд Галил руу (Галилыг заа) явах хэрэгтэй болбол хэдийгээр Самарийг дамжиж явах нь хамаагүй дөт байсан хэдий ч, тэд Самарийг тойрон холуур явдаг байх хүртлээ тийм ихээр Самаричуудад дургүй байжээ. Самариар дамжиж Галилд хүрэхээс түүнийг тойрч тэнд хүрэх нь хичнээн хол болохыг үзүүл.

Судрын түүх ба хайчилбарууд

Есүс Христ дэлхий дээр байхдаа, өөрийнх нь заадаг зүйлүүдийг ойлгоход нь хүмүүст туслахын тулд түүхүүдийг олонтаа ярьдаг байсныг тайлбарла. Түүний ярьсан түүхүүдийн нэг нь Самари хүний тухай байв.

Лук 10:30–37-д байдаг Сайн Самари хүний тухай түүхийг ярьж өг. Зохих үед нь хайчилбаруудыг өргөж харуулан өөртөө туслахыг хэдэн хүүхдээс хүс.

Уг түүхийг ярихдаа дараах зүйлүүдэд онцлон анхаар:

1. Шархадсан хүн Иерусалимаас Иерихо руу явж байжээ (хоёр хотыг газрын зураг дээр заа).
2. Туслахаар зогсолгүй хажуугаар нь өнгөрсөн эхний хүн Иудейн санваартан байв. Санваартнууд ариун сүмд ажилладаг байсан бөгөөд зөв шударга, ариун хүмүүс хэмээн тооцогддог байв.
3. Туслахаар зогсолгүй хажуугаар нь өнгөрсөн хоёр дахь хүн Леви хүн байв. Левичүүд бас ариун сүмд ажилладаг байсан бөгөөд Иудейн шашны хувьд чухал хүмүүс байжээ.
4. Гурав дахь нь Самари хүн байв. Шархадсан хүнд туслахаар тэр зогссон аж.

Энэ Самари хүн тийм эелдэг найрсаг байсан учир Сайн Самари хүн гэж нэрлэгдсэнийг тайлбарла.

Хайчилбаруудыг хүүхдүүдээр буцааж өгүүл.

Жүжигчлэн тоглох үйл ажиллагаа

Хэдэн хүүхдээр Сайн Самари хүний тухай түүхийг жүжигчлэн тоглуулах буюу эсвэл дараах зүйлүүдийг хийж, “Иерихо уруу намайг дагаж яв” тоглоомыг бүх хүүхдүүдээр тоглуул:

Нэг хүүхдийг бэртсэн байдалтайгаар шалан дээр хэвтүүлэх буюу сандал дээр суулга. Та болон бусад хүүхдүүд Иерихо уруу аялж яваа дүр үзүүл. Өөрийгөө дагаж яваа хүүхдүүдээр өөрийнхөө хийж байгааг хийлгэ.

Эхлээд замын даган алхаж яваа санваартныг дүрсэл. Өрөөн дотуур алх. Та нар замын хажууд хэвтэж байгаа хүнийг гэнэт харна. Тэр сүрхий бэртсэн ажээ.

- Санваартан яасан бэ?

Шархадсан хүнд та туслахгүй нь гэдгийг харуулахын тулд замын нөгөө талд гар.

Дараа нь та Леви хүн болно. Өрөөн дотуур алх. Замын хажууд хэвтэж байгаа хүнийг та харна. Түүний хувцсыг хулгайлжээ, бас тэр сүрхий бэртсэн байлаа.

- Леви хүн яасан бэ?

Зогсож, шархадсан хүнийг харна. Тэгээд түүнд туслалгүйгээр аяныхаа замыг хөөнө.

Одоо та Самари хүн болно. Өрөөн дотуур алх. Сүрхий бэртэж, замын хажуу талд хэвтэж байгаа хүнийг та харна.

- Самари хүн яасан бэ?

Самари хүний сайн үйлдлүүдийг жүжигчлэн тогло. (Хэрэв танай анги олон хүүхэдтэй бол үйлчлэлийн өөр өөр үйлдлүүдийг үггүй дүрслэлээр харуулахын тулд хүүхдүүдийг томилж болно.) Тэр хүний шархыг цэвэрлэж, илжгэн дээрээ дүүрэн, түүнийг дэн буудалд аваачиж, тэр хүнд хэрэгтэй бусад зүйлүүдийн төлөө дэн буудлын эзэнд төлөхөөр амлаж байгааг харуул.

Тэд бэртсэн хүнд анхаарал халамж тавилаа, тэд байрандаа буцан сууж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэгээд тэд байрандаа сууж, гараа өвөр дээрээ аяархан тавина.

Ярилцлага

- Аль хүн эелдэг тусч байсан бэ?
- Аль хүн Аврагч түүнээс хийхийг хүсдэг тэр зүйлийг хийсэн бэ?

Есүс энэ түүхийг ярьсны дараа, бид Сайн Самари хүний хийснийг хийж, хүн бүрт түүн шиг эелдэг тусч байх ёстой гэж тэр хэлжээ.

Бид Бусдад Эелдэг Хандаж Чадна

Хүн бүрт эелдэг байх нь, ялангуяа хэн нэгэн бидэнд аятайхан санагддаггүй буюу бидэнд эелдэг бус ханддаг бол, үргэлж амаргүй байдгийг тайлбарла.

Түүх

Өөр хүүхэд түүнд эелдэг бусаар хандахад түүнээс их сургамж авсан нэг охины тухай дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь. Тэр охин хэрхэн шийдэл гаргасныг анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс.

Люиза Тодд хоёр найз нар байсан бөгөөд хамт тоглох дуртай байв. Гэвч нэг үдээс хойш тэр хоёр маргалджээ. Люиза Тоддыг доромжилж, мөн Тодд Люизаг түлхэж унагав. Люизаг уйлж эхлэхэд, тэр нүүрээ муухай болгон түүнийг шоолж.

- Хэрэв чи Люиза байсан бол яах байсан бэ?

Люиза аавыгаа олохоор явжээ. Аав нь түүнд тусална гэж тэр мэдэж байв. Тодд хэрхэн түүнийг түлхэж унагасан хийгээд түүнийг шоолсныг Люиза аавдаа хэлэв. Аавыгаа гадагшаа гарч, Тоддыг шийтгэхийг тэр хүссэн аж.

Тоддыг шийтгэх нь сайн зүйл биш байх болно гэж Люизагийн аав түүнд хэлжээ. Ингэхийн оронд галынхаа өрөө рүү орж, хоёр зүсэм талхан дээр жимсний чанамал түрх гэж аав нь Люизад хэлжээ. Тэгээд нэг зүсэм талхыг Тоддод аваачиж өг гэж тэр Люизад хэлсэн аж. Хэрэв ингэвэл, тэр дайсантай болохын оронд найзтай байх болно гэж аав нь хэлжээ.

Люиза аавынхаа хэлснээр болжээ. Тэр дахин гадагшаа гарч ирээд жимсний чанамалтай талх өгөхөд нь Тодд хэсэгхэн харснаа бэлгийг авлаа. Тодд, Люиза хоёр бие биенээ харж инээмсэглэсэнээ суугаад жимсний чанамалтай талхаа амтархан идэв. Тэр хоёр дахиад найз нөхөд болжээ. (Lucile C. Reading, "A Piece of Bread and Jam"-аас хялбаршуулан авав, *Children's Friend*, 1967 оны 4-р сар, х. 13.)

Ярилцлага

- Тодд түүнийг түлхсэний дараа Люиза яая гэж бодсон бэ?
- Хүн бидэнд эелдэг бусаар хандсан эхний үед бидний хариу үйлдэл ямар байдаг вэ?
- Люиза Тоддод эелдэг хандсан үед юу болсон бэ?
- Люиза Тоддод эелдэг хандаагүй бол юу болох байсан бэ?

Бусад хүмүүс бидэнд эелдэг хандаагүй тохиолдолд ч гэсэн эелдэг байхыг Есүс биднээс хүсдэгийг хүүхдүүдэд сануул.

Судар

Библийг үзүүлж Иохан 15:12-ыг чанга унш. Эдгээр үгс бол Есүсийн үгс болохыг тайлбарла. Бие биенээ хайрлахыг Тэр бидэнд зарлигласан юм. Бид бие биендээ эелдэг байвал, бид хайраа харуулж байгаа нь тэр.

- Дуу “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл. Энэ дууг бие биендээ эелдэг байхыг болон биднээр Есүсийн хийлгэхийг хүсдэг зүйлийг хийхийг бидэнд сануулдгийг тайлбарла.
- Ярилцлага Эелдэг байхын тулд хүүхдүүдийн сонголт хийдэг зарим нөхцөлүүдийг дүрсэлж, нөхцөл бүрт хүүхдүүд юу хийхийг тэднээс асуу. Хэрэв тэдэнд тусламж хэрэгтэй бол хэрхэн үйлдэхийг шийдэх талаарх дууны үгийг бодож үзэхийг хүүхдүүдэд сануул. Дараах нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл өөрөө зарим нөхцөлийг зохио:
1. Чи гудамжаар явж байгаад, нэг хүн унадаг дугуйн осолд орсныг харжээ. Чамайг бүр ойртож очиход энэ нь үргэлж шоолдог нэг хөвгүүн байв. Түүний өмдний шуумаг дугуйн гинжинд орооцолдсон байжээ. Тэр туслалцаагүйгээр хөдөлж чадахгүй байв.
 - Тэр хүүхдэд эелдэг байхын тулд чи яаж болох байсан бэ?
 2. Дараагийн долоо хоногт болох төрсөн өдөртөө зориулж чи тусгай үдэшлэг төлөвлөсөн байж, мөн нэг л хүүхдээс бусад тэр хавийнхаа бүх хүүхдийг урихыг хүсч байв. Тэр эмэгтэй хүүхэд тэнд шинээр ирсэн байв. Тэр огт инээмсэглэдэггүй, түүнтэй тоглоход хөгжилтэй биш байжээ.
 - Энэ охинд эелдэг байхын тулд чи юу хийж болох вэ?
 3. Чи найз нартайгаа тоглож байгаад уначихжээ. Найз нарын чинь нэг нь чамайг болхи гэж нэрлэн, шоолж инээв. Гэтэл одоо нөгөө найз чинь уначихаад уйлж байна.
 - Найздаа эелдэг байхын тулд чи юу хийж болох вэ?
 4. Сургуулийн чинь ангийн хөвгүүн явган явахдаа тусгай тулгуур ашигладаг байв. Бүх хүүхэд тоглохоор гүйж гарах үед тэр удаан явдаг учраас ард нь хоцордог байлаа. Тэр бусад бүх хүүхдүүд тоглохыг харан, ганцаараа суух нь олонтаа байдаг байв.
 - Энэ хүүхдэд эелдэг байхын тулд чи юу хийж болох вэ?

Дүгнэлт

- Нэгтгэн дүгнэлт Дараах асуултуудад хариулах аргаар хичээлийг хүүхдүүдээр нэгтгэн дүгнүүл:
- Өнөөдрийн хичээлээр бид юу сурсан бэ?
 - Эелдэг байх нь яагаад чухал вэ?
 - Бид нинжин сэтгэл гаргахдаа хэний үлгэр жишээг дагадаг вэ?
- Судар Иохан 13:34–35-ыг чанга унш. Бид бусдыг хайрлаж, тэдэнд эелдэг байснаараа бид бол Есүс Христийн шавь нар (дагалдагчид) болохоо харуулдгийг тайлбарла.
- Гэрчлэл Эелдэг байснаар бусдыг хайрлах хайраа харуулахыг Есүс биднээс хүсдэгийг хүүхдүүдэд гэрчил. Бид хүн болгонд, тэр ч байтугай бидэнд үргэлж эелдэг ханддаггүй хүмүүст ч гэсэн эелдэг найрсаг байх ёстойг хүүхдүүдэд сануул. Эелдэг байхыг сонгосноор Есүсийг дагахын ач холбогдлын тухай гэрчлэлээ хэл.
- Ирэх долоо хоногийн турш бусдад эелдэг байхын тулд тусгайлан хүч чармайлт гаргахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж. Хэн нэгэнд хэрхэн хандахыг санах хэрэг гарсан үед “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” дууны

үгсийг санахыг хүүхдүүдэд сануул. Зөвийг сонгосон үед юу тохиолддогийг ажиглахыг тэднээс хүс. Өөрсдийнхөө туршлагын талаар дараагийн долоо хоногт ярихад бэлэн болж ирэхийг тэдэнд санал болго.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдэд цаас, харандаа эсвэл будгийн харандаанууд өгч, эелдэг байснаар бусдыг хайрлах хайраа харуулах арга замуудын тухай тэднээр зураг зуруул. Хүүхдүүдийн зураг болгон дээр *Би бусдад эелдэг байж чадна* гэсэн үгс бич.
2. “Нинжин Сэтгэл Байдал Надаас Эхэлдэг” (*Children’s Songbook*, х. 145) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд хүүхдүүдэд тусал.

Хүн бүрт эелдэг байхыг хүснэ би,
Учир нь энэ нь зөвийг та нар мэднэ.
“Нинжин сэтгэл надаас эхэлдэг:
Үүнийг сана” гэж би өөртөө хэлнэ.


Тэдэнд эелдэг байж болох хүмүүсийн (жишээ нь, гэр бүлийн гишүүд, найз нар эсвэл нэг ангийнхан гэх зэрэг) тухай, түүнчлэн эдгээр хүмүүст нинжин сэтгэлээ харуулж болох арга замуудын талаар санахад нь хүүхдүүдэд тусал. Бидэнд эелдэг бус ханддаг буюу биднээс ялгаатай мэт санагддаг хүмүүст эелдэг байхын ач холбогдлыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

3. “Нинжин Сэтгэл Бол Онцгой Бэлэг” (*Children’s Songbook*, х. 145) дууг хүүхдүүдийн хамт дуулах буюу эсвэл үгийг нь хэл.

Нинжин Сэтгэл Бол Онцгой Бэлэг
Ийм аз жаргалыг энэ нь авчирна;
Бусдад би эелдэг байвал
Зүрх сэтгэл минь дуулна.

Энэ дууг дуулах буюу үгийг нь хэлсний дараа хүүхэд бүрийн хуруу буюу бугуйнаас хэсэг ээрмэл утас буюу оосор уя. Утас буюу оосор нь хүн бүрт эелдэг байхыг тэдэнд сануулах болно гэдгийг хүүхдүүдэд тайлбарлаад, тэд ийм утсыг Хүүхдийн Хэсгийн үлдсэнд уяж өгөхийг тэдэнд санал болго.

Ариун Нутаг



Би Сайн Үлгэр Жишээ Байж Чадна

Хичээл
29

Зорилго

Тэдний гэрэл Есүс Христийн дагалдагчдынх лугаа адил гэрэлтэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Матай 5:14–16-г залбиралтайгаар судал.
2. Хичээлийн төгсгөл дэх загваруудыг ашиглан, дөрвөн лаа, дөрвөн сагсыг цаасаар хайчилж хувил. Цаасан лаанууд дээр дараах нэрсийг бич:
Сюзан
Жосе
Эрик ба Петр
?
Хичээл эхлэхийн өмнө, нэр бичсэн гурван лааг үзүүлж, лаа бүрийг цаасан сагсаар бүтээ. Дараа нь хэрэглэхийн тулд дөрөв дэх лаа (“?”) болон сагсыг хадгал.
3. Хүүхэд бүрт цаасан лаа хийхийн тулд лааг загвар болгон ашигла.
4. “Зөв Замыг Сонго” (*Children’s Songbook*, х. 160), “Есүс Намаг Нарны Цацраг Байхыг Хүсдэг” (*Children’s Songbook*, х. 60) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Нэг лаа, лааны тавиур буюу лаа тогтоогуур.
 - в. Сагс буюу лааг бүрэн бүтээж болох хайрцаг.
 - г. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - д. Харандаанууд буюу будгийн харандаанууд.
6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Анхааруулга: Хичээлийн үеэр ашиглах лааг бүү асаа. Энэ нь цуглааны байруудад лаа асаахгүй байх Сүмийн бодлогод харш юм.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Нинжин сэтгэлээ харуулах тэдний туршлагыг та хүүхдүүдээр хуваалцуулж болно. Хүүхдүүдтэй ярилцах үеэрээ та тэдэнд шивнэ.

“Гэрэл Чинь Гэрэлтэг” Гэж Есүс Христ Заажээ

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хүүхдүүдтэй шивнэж ярихаа үргэлжлүүлэн, энэ долоо хоногт тэд юу хийсэн болон Хүүхдийн Хэсгийн юу нь тэдэнд таалагддаг тухай хүүхдүүдийн зарим нь хариу шивнэх хүртэл асуу. Хэдэн минутын дараа, хүмүүс хэрхэн өөрсдийнхөө эргэн тойрны бусад хүмүүсийн хийдэг зүйлийг олонтаа хийдгийг харуулах туршилтын нэг хэсэг болон та шивнэж байснаа тайлбарла. Та хүүхдүүдэд шивнэн ярьсан учраас тэд хариу шивнэж эхэлсэн. Тэд өөрийн чинь үлгэр жишээг дагасан гэдгийг тэмдэглэн хэл.

Тэд өөрийн чинь үлгэр жишээг дагасны нэгэн адил найз нар нь тэдний үлгэр жишээг дагах нь олонтаа байдгийг хүүхдүүдэд хэл. Сайн үлгэр жишээ байхыг Есүс Христ биднээс хүсдэг.

- Сайн үлгэр жишээ байна гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бидний найз нар бидний юу хийж байгааг хараад дуурайн хийх нь олонтаа байдгийг тайлбарла. Хэрэв тэд бид сайн зүйлүүд хийж, зөвийг соногж байгааг харах юм бол, зөвийг сонгох нь тэдний хувьд бас илүү хялбар байх болно.

Онъсого

Дараах онъсогыг таахыг хүүхдүүдээс хүс:

Намайг лаваар хийсэн.

Миний дотор зулын гол байдаг.

Миний зорилго бол гэрэл өгөх.

Нэг шүдэнз намайг асааж чадна.

Би юу вэ?

Хүүхдүүд онъсогыг таасны дараа, өөрийнхөө авчирсан лааг үзүүлж, лааг юунд ашигладаг тухай ярилц.

Судрын түүх

Есүс Христийг дэлхий дээр амьдарч байх үед цахилгаан гэрэл байгаагүйг тайлбарла. Нар жаргасны дараа харанхуй болоход, хүмүүс харах гэрэлтэй байхын тулд заримдаа лаа асаадаг байжээ.

Нэг өдөр Есүс бусдад сайн үлгэр жишээ байх тухай хичээлийг шавь нартаа зааж байжээ (Матай 5:14–16-г үз). Тэдний үйл ажиллагаа бусдад хэрхэн тусалж чадахыг ойлгоход нь шавь нартаа туслахын тулд Есүс үйл ажиллагааг лааны гэрэлтэй зүйрлэсэн байдгийг хүүхдүүдэд хэл. Матай 5:15-д Есүс шавь нартаа юу гэж хэлснийг чанга унш.

Үзүүлэнт хичээл

Лааг сагс буюу хайрцган дор тавь.

- Хэрэв харанхуй болоход бид лаа асаасан хэдий ч үүнийг сагсаар (хайрцгаар) бүтээвэл юу болох вэ? (Хэн ч гэрлийг харж чадахгүй.)

Сагс буюу хайрцгийг авч лааг тавиур дээр тавь.

- Хэрэв харанхуй болоход лааг лааны тавиур дээр тавьж, тэгээд лааг асаавал юу болох вэ? (Лаа өрөөнд гэрэл өгч, хүн болгон харах боломжтой болно.)

Есүс өөрийн шавь нарыг лаа шиг байж, бусдад гэрэл өгч байхыг хүсдэг байсныг тайлбарла. Хэрэв шавь нар нь Есүсийн заадаг зүйлүүдийг дагаж, сайн үлгэр жишээ байх юм бол, бусад хүмүүс юу хийх ёстойгоо харах болно.

Ярилцлага

Матай 5:16-гаас Есүс шавь нартаа юу гэж хэлснийг чанга унш. Энэ зааврыг дагахыг Есүс бас биднээс хүсдэгийг тайлбарла.

- Энэ сударт та нарын гэрэл гэрэлтэг гэсэн нь ямар утгатай вэ? (Сайн үлгэр жишээ үзүүлэх.)
- Бид найз нөхөд болон эргэн тойрныхоо хүмүүст сайн үлгэр жишээ үзүүлбэл юу тохиолдож болох вэ?

Хүүхдүүд Сайн Үлгэр Жишээ Үзүүлж Чадна

Бусдын хувьд сайн үлгэр жишээ байснаар бид бүгд Есүс Христийн зааврыг даган өөрсдийнхөө гэрлийг гэрэлтүүлж чадна гэдгийг хүүхдүүдэд хэл. Бид Есүсийг дагахаар сонгосон үед бусад хүмүүс биднийг харж, түүний тухай мэдэж болно.

Цаасан лааг бүтээсэн цаасан сагсыг нэг хүүхдээр авахуулж түүнийг ил гаргахыг хүс. Лаан дээрх нэр буюу нэрүүдийг унш. Тэгээд тэр лаатай холбоотой түүхийг ярь. Өөр хоёр сагс болон лаан дээр үүнийг давтаж, өөр хоёр түүхийг ярь.

Сюзаны тухай түүх

Сюзан найз Каролиныхаа төрсөн өдрийн үдэшлэгт уригджээ. Тэр үдэшлэгт явахдаа сэтгэл ихэд хөдөлж, цагийг сайхан өнгөрөөх болно гэдэгт итгэж байлаа. Гэвч, тэр гэртээ ирэхдээ, явсан шигээ тийм сэтгэл догдолсон байдалтай харагдсангүй. Үдэшлэг ямар болов гэж Сюзаны ээж түүнээс асуув.

Үдэшлэг дээр мөстэй цайгаар үйлчиллээ гэж Сюзан тайлбарлав. Каролинын ээж энэ бол яг л насанд хүрэгчдэд зориулсан үдэшлэгтэй адилхан гэж хэлсэн аж.

- Сюзанд цай уухыг санал болгосон үед тэр яасан гэж та нар бодож байна?

Сюзан цай уудаггүйгээ Каролины ээжид хэлж, түүний эцэг эхчүүд болон Хүүхдийн Хэсгийн багш нар нь цай түүний биед сайн биш гэж заадгийг тайлбарлажээ.

Сюзаны ээж Сюзаныг цай уугаагүйнх нь төлөө түүгээр бахархаж байлаа. Каролин болон түүний ээж Сүмийн гишүүд биш байсан бөгөөд Сюзаны гэр бүлийн хийдэг байсан тэр зүйлүүдэд итгэдэггүй байсныг тэр тайлбарлав.

Хэдэн сарын дараа Сюзан, түүний ээж хоёр Каролины ээжээс захидал хүлээн авчээ. Үдэшлэг дээр Сюзан итгэдэг зүйлийнхээ төлөө хатуу зогссоны дараа Каролины гэр бүл Сүмийн тухай илүү ихийг олж мэдэхээр шийдсэнээ Каролины ээж тайлбарласан байв. Номлогч нар тэдэнд заасан ажээ. Сюзан түүнд нөлөөлсөн шиг тэрээр өөр хэн нэгэнд сайн үлгэр жишээ болж чадна гэдэгт найдаж байгаагаа Каролины ээж хэлсэн байв.

- Сюзан өөрийнхөө гэрлийг хэрхэн гэрэлтүүлсэн бэ?

Жосегийн тухай түүх

Жосе болон түүний гэр бүл саяхан шинэ газар нүүж иржээ. Жосегийн анхны шинэ найз нь Паоло гэдэг, Сүмийн гишүүн биш хөвгүүн байв. Жосе, Паоло хоёр хоёул хөл бөмбөгөнд дуртай байв. Нэг өдөр Паоло Жосег дараагийн Ням гарагт хөл бөмбөгийн тоглолтод явъя гэж урьжээ. Ням гарагт хөл бөмбөгийн тоглолтод явах ёсгүйгээ Жосе мэдэж байсан боловч, хэрэв тэр явахгүй бол Паоло гомдох байх гэж тэр зовсон ажээ.

- Хэрэв чи Жозе байсан бол яах байсан бэ?

Жозе хөл бөмбөгийн тоглолтод явахын оронд сүм рүү явахаар шийдэж, тэр Паолог сүм рүү хамт очъё гэж урьжээ. Паоло Жосетой хамт сүм рүү очихыг зөвшөөрөв.

- Жозе хэрхэн сайн үлгэр жишээ үзүүлсэн бэ?

Эрик, Петр
хоёрын тухай түүх

Нэг өдөр нэг эмэгтэй Голланд дахь зарим номлогч нартай уулзахаар иржээ. Яаж залбирдгийг өөртөө зааж өгөн үү гэж эгч нараас тэр хүсчээ. Түүний хүү Эрик, Петр хоёр Хүүхдийн Хэсэгт явж байгаа, мөн энэ нь тэдэнд их таалагдаж байгааг тэр эмэгтэй тайлбарлажээ. Хүүхдийн Хэсэгт тэд яаж залбирдгийг сурчээ.

Хэдэн өдрийн өмнө түүний нялх охин сүрхий өвдсөн байлаа гэж тэр эмэгтэй тайлбарласан аж. Тэр өрөөнөөс гарч хэдэн минут болоод эргэж ирэхэд Эрик, Петр хоёр нялх хүүхдийн орны дэргэд өвдөг сөгдсөн байлаа. Нялх хүүхдийг адисалж, түүнийг эдгээхийг Петр Тэнгэрлэг Эцэгээс хүссэн ажээ. Хөвгүүд нь Хүүхдийн Хэсэгт хэрхэн залбирахыг сурсанд тэр эмэгтэй баяртай байв, тэгээд тэр яаж залбирахыг өөртөө зааж өгнө үү гэж номлогч нараас хүссэн ажээ. Яаж залбирахыг номлогч нар тэр эмэгтэйд заав. Эрик Петр хоёр ээждээ сайн үлгэр жишээ үзүүлсэнд тэд баяртай байлаа.

- Эрик, Петр хоёр өөрсдийнхөө гэрлийг хэрхэн гэрэлтүүлсэн бэ?

Хүүхдийн
оролцоо

Та бүх түүхийг ярьсныхаа дараа, цаасан сагсаар бүтээсэн, “?”-тэй лааг үзүүл. Нэг хүүхдээр сагсыг авахуул. Лаан дээрх “?” нь сайн үлгэр жишээ үзүүлдэг аль ч хүүхдүүдийг төлөөлж байгааг тайлбарла. Сайн үлгэр дуурайл үзүүлсэн тохиолдлуудынхаа тухай ярихыг хүүхдүүдээс хүс.

Бид Өөрсдийнхөө Гэрлийг Гэрэлтүүлж Чадна

Судар

Матай 5:16-г дахин чанга унш. Есүс бидэнд өөрсдийнхөө гэрлийг гэрэлтүүл гэж хэлснийг хүүхдүүдэд сануул. Сайн үлгэр жишээ үзүүлснээр бид гэрлээ гэрэлтүүлэхийн ач холбогдлыг онцлон заа. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд бид Есүс Христийн заадаг зүйлүүдийг дагахын хамт Есүсийн заадаг зүйлүүдийг дагахад нь бас бусдад туслах ёстойг онцлон тэмдэглэ.

Дуу

“Есүс Намайг Нарны Цацраг Байхыг Хүсдэг” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл. Есүсийн төлөө “нарны цацраг” байх гэдэг нь сударт өгүүлснээр, бид гэрлээ гэрэлтүүлэх гэсэн утгатайг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Үйл ажиллагаа

Та зарим нөхцөлүүдийг дүрсэлж, нөхцөл бүрт тэд сонголт хийх хоёр сонголтыг тэдэнд өгөх гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Сонголт бүрийг анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Хэрэв сонголт сайн байвал, хүүхдүүд лааны суурин дээрх өөрсдийнхөө лааг төлөөлүүлэн хүүхэд бүр нэг хуруугаа дээш нь өргөж харуулах ёстой. Хэрэв сонголт сайн биш байвал, тэдний гэрэл саван дор байгааг төлөөлүүлэн, хүүхэд бүр хуруугаа нөгөө гараараа таглана. Нөхцөл бүрийн дараа, аль сонголт нь илүү сайн болох хийгээд энэ нь яагаад гэрлээ гэрэлтүүлэх боломжийг бидэнд олгож байгаа тухай ярилц.

Дараах нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл зарим нөхцөлийг өөрөө зохио:

1. Чи өглөөжингөө тэр хавийнхаа зарим найз нартайгаа тоглож, нэн их хөгжилтэй байжээ. Үдийн хоолны дараа, гудамжны нөгөө талаас тэднийд нэг охин ирж, гаднаас нь харвал тэр тэдэнтэй тоглохыг хүссэн бололтой харагдсан аж. Чи яах вэ?
 - а. Чи болон найз нар чинь тэр охиныг нэгэнт л танихгүй учраас, мөн та нар юу тоглож байгааг тэр мэдэхгүй учраас чи түүнийг өөрсөдтэйгөө хамт тоглоё гэж урих хэрэггүй.
 - в. Чи найз нартаа, “Тэр охиныг ирж бидэнтэй хамт тоглохыг урьцгаая. Тэр тоглохыг хүсч байгаа бололтой” гэж хэлнэ.

2. Чи найз нартайгаа бөмбөг тоглож байжээ. Чи бөмбөгийг хүчтэй цохиж, ингээд бөмбөг хөршийнхөө цонхыг цохьж хагалчихаж. Чи яах вэ?
- Та нар бөмбөг тоглож байгаад чи бөмбөгийг хүчтэй цохьж, тэгээд цонхыг чинь хагалчихлаа гэж чи хөршдөө хэлжээ. Чи уучлал гуйж, хагарсан цонхыг төлж өгье гэв.
 - Чи хагарсан цонхыг харахаар явав. Цонх яйран болтол хагарсан учраас хэн ч үүнийг огт хараагүй юм шиг байцгаая гэж чи найз нартаа хэлжээ. Та нар бөмбөг тоглохоо үргэлжлүүлж, илүү анхааралтай байхыг хичээж байв.
3. Чи сургууль дээрээ үдийн хоолонд (эсвэл Хүүхдийнхээ Хэсэгт явахаар хүлээж) дугаарлан хүлээж байлаа. Дугаарлан хүлээж байсан хүүхдүүдийн зарим нь дэггүйтэж, тоглож эхлэв. Ар дахь хүүхэд чинь чамайг түлхчихэв. Чи яах вэ?
- Хэнийг ч түлхэлгүйгээр дугаартаа зогсоно.
 - Өөрийгөө түлхсэн хүүхдийг түлхэнэ.

Зөвийг сонгосноор сайн үлгэр жишээ үзүүлэх нь хичнээн чухал болохыг хүүхдүүдэд сануул.

Дүгнэлт

ЗС уриа

ЗС уриаг зааж, хэрэв бид Аврагчийн заадаг зүйлүүдийг дагах юм бол бид зөвийг сонгох болно гэдгийг хүүхдүүдэд сануул.

Сюзан, Жозе, Эрик, Петр нар шиг бусдад сайн үлгэр жишээ үзүүлэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Лаатай үйл ажиллагаа

Хүүхэд бүрт цаасан лаа өг. Лаанууд дээр хүүхдүүдийн нэрийг бичих буюу тэднээр бичүүл.

Гэртээ, сургууль дээрээ тэрчлэн сүм дээр сайн үлгэр жишээ үзүүлэх замаар өөрсдийнхөө гэрлийг гэрэлтүүлэх арга замуудын талаар бодоход нь хүүхдүүдэд тусал.

Энэ долоо хоногт сайн үлгэр жишээ үзүүлэх нэг арга замыг хүүхэд бүрээр хэлүүл.

Сайн үлгэр жишээ үзүүлснээр өөрсдийн гэрлийг гэрэлтүүлэхийг нь тэдэнд сануулахын тулд лаануудыг хүүхдүүдэд гэрт өгч явуул.

Гэрчлэл

Сайн үлгэр жишээ үзүүлэхийн ач холбогдлын тухай хүүхдүүдэд гэрчил. Та өөрөө сайн үлгэр жишээ үзүүлсэн буюу Есүс Христийн тухай мэдэхэд чинь тусалсан өөр хэн нэгний туршлагын талаар хуваалцаж болно.

Дуу

“Зөв Замыг Сонго” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урьж, бусдад сайн үлгэр жишээ үзүүлэхэд нь хүүхдүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйлга.

Хүүхдүүдийг ангиас гарах үед, цаасан лаануудаа өмнөө барьж чимээгүй гарч явахыг тэднээс хүс. (Хэрэв хүүхдүүдийг ангиас нь хүн тосч авахаар ирэх хүнийг хүлээх ёстой бол, тосч авах хүнд лаануудаа үзүүлэхийг хүүхдүүдээс хүс.)

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Бид өөрсдийнхөө гэрлийг гэрэлтүүлж чадна” хэсэгт ярилцсан нөхцөлүүдийн илүү сайн шийдлүүдийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул. Түүнчлэн Сюзан, Жосе, Эрик, Петр нарын тухай түүхүүдийг хүүхдүүдээр биечлэн тоглуул.

2. “Миний Хийсний Адилаар Хий” (*Children’s Songbook*, х. 276) дууг дуулах буюу үгийг нь хэл. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа. Бусад хүүхдүүд даган дуурайхын тулд үйлдлүүдийг харуулах замаар хүүхдүүдийг ээлжээр дууг удирдуул.

Эсвэл хүүхэд бүрийг ээлжээр удирдагч болгон, “Удирдагчийг Дага” тоглоомыг хүүхдүүдээр тоглуул.

Энэ дуунд буюу тоглоомонд, хүн бүр удирдагчийн жишээг дагадгийг онцлон хэл. Хүүхдүүд зөвийг сонгосон үед эргэн тойрныхоо хүмүүст сайн үлгэр жишээ үзүүлдэг гэдгийг тэдэнд сануул.

3. “Гэрэлт” (*Children’s Songbook*, х. 144) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Миний гэрэл багахан ч гэсэн,
Энэ нь итгэлийнх бас залбирлынх;
Гэвч хар! Бурханы агуу нар шиг гялалзаж байгааг нь,
Учир нь энэ тэнд гэрэлтэж байсан юм.


Дахилт:

Гэрэлт, гэрэлт, хурц тодоор гэрэлт;
Гэрэлт, гэрэлт, энд өдөр байхад гэрэлт.

Багахан гэрлээ би нуух нь үгүй;
Ингэхийг Их Эзэн надад хэлсэн.
Энэ нь надад харахыг өгсөн.
Үүний гэрэлтэхийг бүгд харж болно.

Дахилт:

4. Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаанд ингэсний адил шивнэн, хүүхэд бүрээс нэгтгэн дүгнэх асуултыг асуу. Хүүхдүүдээр мөн шивнэж хариулуул. Анхааралтай сонсож, бодсоных нь төлөө тэднийг магт.



Зорилго

Дуулгавартай байснаар Есүс Христийн жишээг дагахад хүүхэд бүрийг урамшуулан дэмжих.

Бэлтгэл

1. Египетээс Гарсан нь 20:12, Матай 26:36-46, Иохан 8:28–29, Колосайчууд 3:20-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 35-ыг үз.

2. Дараах үгсийг бичсэн цаасан тууз бэлтгэ;

Дуулгавартай

3. *Би Дуулгавартай Дагаж Чадна* гэсэн үгсийг цаасан дээр хүүхэд бүрт зориулан бичиж бэлтгэ. Хүүхэд бүрийн цамц буюу палаажин дээр энгэрийн тэмдэг хадах тууз буюу сүлбээр зүү авчир, эсвэл тэмдгүүдийг хүүхдийн хүзүүнд оосорлон зүүх утас авчир.

4. “Би Хурдан Дагана” (*Children’s Songbook*, х. 197) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.

5. Шаардлагатай материалууд:

а. Библи.

б. Зураг 2-51, Галуунууд Дэгдээхийнүүдтэйгээ; зураг 2-52, Есүс Гетсеманид Залбирч Байгаа нь (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 227; 62175).

6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Ахлах насны хүүхдүүдийн багш нарт анхааруулах нь: Та нар баяжуулах үйл ажиллагааг анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа болгон ашиглаж болно.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Долоо хоногийн турш тэд сайн үлгэр жишээ үзүүлэх арга замуудын талаар та хүүхдүүдээр яриулж болно.

Дуулгавартай Байдал Аз Жаргал Авчирдаг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Дэгдээхийнүүдтэйгээ Байгаа Галуунууд зураг 2-51-ийг үзүүл. Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтэн байсан Ахлагч Теодор М.Бөртөний тухай дараах түүхийг та өөрийн үгээр ярих хооронд зургийг нэг хүүхдээр өргөн харуулахыг хүс:

Теодор М.Бөртөн дөнгөж таван настай байхдаа ферм дээр эмээгээ эргэж очжээ. Теодор фермийн гадаа тоглох дуртай байв. Түүний энэ ирэлтээр Теодорын эмээ түүнийг дэгдээхийнүүдтэй эм тахиа руу их ойртохгүй байхыг

сэрэмжлүүлэв, учир нь эм галуу түүнийг дэгдээхийнүүдээ хорлох гэж байна гэж бодож магадгүй байв. Теодор тэдэнд хэт ойртохгүй гэж амлажээ.

Гэвч Теодор бүрзийсэн шар дэгдээхийнүүдийг хараад, нэгэнд нь гар хүрээд авчээ. Дэгдээхий цааш гүйхэд, эм галуу Теодор уруу гүйж очин, хатуу хошуугаараа гар дээр нь тоншив. Теодор эмээ рүүгээ уйлсаар гүйв.

Теодорын эмээ түүнийг уйлахаа больтол нь тэвэрч, Теодор дэгдээхийнүүдийг нь хорлох гэж байна гэж эм галуу бодсоныг тайлбарлав. Эм галуу дэгдээхийнүүдээ хамгаалахын тулд түүнийг тоншсон ажээ.

Эм галуунаас хол байхыг түүнд сануулан эмээ нь Теодорыг дахин гадагш гаргажээ. Түүнийг нөгөө эм тахианд хэтэрхий ойрхон очиж болохгүйг түүнд эмээ нь сануулав, учир нь тэр эм галуу бас дэгдээхийнүүдтэй ажээ. Энэ эм галуу нөгөө галуунаас том учир дэгдээхийнүүддээ хүрсэн хүнд үнэхээр гэмтэл учруулж болох байв. Дэгдээхийнүүдэд гар хүрэхгүй гэж Теодор амлажээ.

Теодор эм галуунаас хол байв. Гэвч түүнийг эх галуу болон түүний дэгдээхийнүүд хараад тэдний ойрхноос сайн харахын тулд дөхөж очтол эм галуу далавчаа өргөн, хүзүүгээ сунгаж, түүн рүү чангаар гийнан дуугарав. Теодор айж, гэр лүүгээ буцаж гүйлээ. (Theodore M. Burton, "Friend to Friend: Grandmother's Lesson," *Friend*, 1973 оны 10-р сар, х. 18–19-ийг үз.)

Ярилцлага

- Эм тахиа буюу галуунуудад ойрхон явж болохгүй гэж Теодорын ээж яагаад түүнд хэлсэн бэ?
- Эмээгийнхээ үгэнд ороогүй нь Теодорт ямар санагдсан бэ?
- Түүнд яагаад ингэж санагдсан бэ?
- Энэ сургамжаас Теодор юу мэдэж авсан гэж та нар бодож байна?

Теодорт түүнийг хамгаалах хүмүүс байдгийн адилаар эм тахиа болон галуу дэгдээхийнүүдээ хамгаалдаг гэж эмээ нь түүнд хэлснийг хүүхдүүдэд ярьж өг. Бидний эцэг эх, гэр бүл түүнчлэн Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ дээрээс биднийг харан, хамгаалж байдгийг тайлбарла. Юуг хийх нь аюулгүй болон баяр хөөртэй байдгийг тэд бидэнд заах болно. Бид тэднийг дуулгавартай дагах нь ач холбогдолтой юм.

Цаасан туузан дээр бичсэн үг

“Дуулгавартай” гэж бичсэн цаасан туузыг үзүүл. Энэ үгийг өөртэйгөө хамт хүүхдүүдээр хэд хэдэн удаа хэлүүл. Тэнгэрлэг Эцэг, бидний эцэг эх, түүнчлэн бидний удирдагчид биднээс хийхийг хүсдэг тэр зүйлийг хийснээрээ бид дуулгавартай байдгийг тайлбарла.

Дуулгавартай дагах гэдэг үгийг хэлж, үүнийг ангиар давтан хэлүүл. Дуулгавартай дагах нь дуулгавартай байх гэдэгтэй утга адилаар тайлбарла.

Бид Есүсийн Нэгэн Адил Тэнгэрлэг Эцэгийг Дуулгавартай Дагаж Чадна

Судар

Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагах нь чухал ач холбогдолтойг Есүс Христ Библид заасныг тайлбарла. “Би өөрийн санаагаар юуг ч хийдэггүй, харин Эцэгийн надад зааснаар хийдэг. . . . Учир нь би үргэлж түүний таалалд нийцдэг зүйлүүдийг хийдэг” гэсэн Иохан 8:28–29-ийн хэсгийг чанга унш.

Эдгээр нь Есүс Христийн үгс бөгөөд, Тэнгэрлэг Эцэг түүнээс хүсдэг байсан зүйлийг Есүс үргэлж хийдэг байсан гэсэн утгатайг тайлбарла. Тэр зөвхөн Тэнгэрлэг Эцэгийг баярлуулах болно гэдгийг өөрөө мэддэг зүйлүүдийг л хийдэг байжээ.

	<p>Гетсеманид Залбирч Байгаа Есүс, зураг 2-52-ыг үзүүлж, Матай 26:36–39-д байдаг түүхийг товч ярь.</p> <p>“Эцэг минь, хэрэв боломжтой бол энэ аягыг надаас өнгөрүүлээч” гэж Есүс Христ өөрийн залбиралд хэлснийг чанга унш (Матай 26:39). Хэрэв Тэнгэрлэг Эцэгт эргэж очиход бидэнд туслах өөр арга зам байсан бол Есүс зовж, үхэхийг хүсээгүй юм гэдгийг тайлбарла.</p> <p>Есүс үүний дараа: “Гэвч миний хүслээр биш, Таны хүслээр болог” гэж хэлснийг чанга унш (Матай 26:39). Энэ бол хэдийгээр амаргүй байсан ч гэсэн, Эцэг юу хийхийг түүнээс хүссэнийг Есүс хийх хүсэлтэй байсан гэсэн утгатайг тайлбарла. Есүсийн хийсэн шиг тийм хэцүү ямар нэг зүйл хийхийг биднээс хүсэхгүйг; гэвч Тэнгэрлэг Эцэг биднээс юуг ч хийхийг хүслээ гэсэн бид түүнийг дуулгавартай дагах ёстойг тайлбарла.</p> <ul style="list-style-type: none"> • Тэнгэрлэг Эцэг биднээс хийхийг хүсдэг зарим зүйл юу вэ? (Хариултууд нь залбирах, бие биенээ хайрлах, баптисм хүртэж, гишүүнээр батлагдах тэрчлэн үнэнч шударга байх явдал байж болно.)
<p>Судрын ярилцлага</p>	<p>Бид Эцэг Эхээ Дуулгавартай Дагаж Чадна</p> <p>Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагах юм бол, бас эцэг эхээ ч дуулгавартай дагах болно гэдгийг тайлбарлана. (Хэрэв танай ангийн хүүхдүүдийн зарим нь эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй бол, энэ ярилцлагыг шаардагдах байдлаар зохицуул. Жишээ нь, хүүхдүүд өвөө эмээ нараа ч бас дуулгавартай дагах ёстой.) Арван Зарлигийн нэг нь бид эцэг эхээ дуулгавартай дагах ёстой гэж өгүүлдэг. Египетээс Гарсан нь 20:12-ын “Эцэг эхээ хүндэл” гэсэн эхний хэсгийг чанга унш. Эцэг эхээ дуулгавартай дагах нь тэднийг хүндлэх нэг арга зам болохыг тайлбарла.</p> <ul style="list-style-type: none"> • Бид яагаад эцэг эхээ дуулгавартай дагах ёстой вэ? <p>Колосай 3:20-ийг чанга унш (<i>Их Эзэн</i> гэдэг бол Есүс Христийн өөр нэг нэр гэдгийг хүүхдүүдэд сануул). “Хүүхдүүд ээ, бүх талаар эцэг эхдээ дуулгавартай байгтун” гэсэн энэ шүлгийн эхний хэсгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.</p> <ul style="list-style-type: none"> • Та нар эцэг эхээ дуулгавартай дагах үед та нарт ямар санагддаг вэ? • Та нар эцэг эхээ дуулгавартай дагахад тэдэнд ямар санагддаг вэ?
<p>Дуу</p>	<p>“Би Хурдан Дагана” дууны бүх бадгийг хүүхдүүдийг босгож дуулуулах буюу үгийг нь хэлүүл.</p> <p>Тэнгэрлэг Эцэг болон эцэг эхээ одооноос дуулгавартай дагах болно гэж шийдэхэд нь хүүхдүүдийг урамшуул.</p>
<p>Түүх</p>	<p>Эцэг эхдээ дуулгавартай байсны улмаас баяртай байсан хүүхдийн тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:</p> <p>Катрин найз Априлынхаа гэрт тоглох дуртай байжээ. Катрины ээж Катриныг нэг л цаг тоглож болно гэж хэлжээ. Априлын ээж цаг дууслаа гэж хэлэхэд Катринд явахад их хэцүү байв. Априлын хамт тоглож байсан тоглоомоо дуусгамаар түүнд санагджээ. Катрин түр зуур бодсоноо ээжийнхээ хэлсэн ёсоор гэр лүүгээ явъя гэж шийдэв. Тэд Априлд тэр дорхноо баяртай гэж хэлээд гэр лүүгээ яаран гүйв.</p> <p>Катриныг гэртээ ирэхэд эмээ нь түүнийг хүлээж байлаа. Эмээ нь Катриныг өөртэйгөө хамт гэрт нь очиж хонохыг хүсэв, гэвч тэр гэр лүүгээ яарч байв. Хэрэв Катрин ээжийнхээ хэлсэн цагт харихгүй бол тэр эмээгийнхээ очих боломжийг алдах байв.</p>

- Катринд ямар санагдсан гэж та нар бодож байна?

Бид дуулгавартай байхад сэтгэл догдлом шагнал авахгүй ч гэсэн бид баяртай, амар амгалан мэдрэмжтэй байдгийг онцлон тэмдэглэ. Энэхүү мэдрэмж нь бид зөвийг сонгохыг мэдэхээс ирдэг.

Дүгнэлт

Хүүхдийн
оролцоо

Дуулгавартай байсан үеийнхээ тухай, мөн тэр үед ямар санагдаж байсан буюу эсвэл ирээдүйд (Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудын нэгийг сахих, гадаа тоглохоор гарахаасаа өмнө эцэг эхээсээ зөвшөөрөл авах, гэрээ цэвэрлэхэд туслах буюу эцэг эх нь дуудсан үед тэр даруйд ирэх гэх зэрэг) тэд дуулгавартай байх арга замын талаар нэг нэгээрээ ярихыг хүүхдүүдээс хүс.

Хүүхэд бүр ээлжээр ярьсны дараа түүнд “Би Дуулгавартай Байж Чадна” энгэрийн тэмдэг өг. Тэмдэг нь дуулгавартай байхыг санахад нь тэдэнд туслах учраас тэмдгүүдийг харагдах газарт тавихад нь хүүхдүүдийг урамшуул. Тэмдгүүдээ гэрийнхэндээ тайлбарлаж, өнөөдрийн хичээлээс юу сурснаа хуваалцахыг хүүхдүүдэд санал болго.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг болон эцэг эхдээ дуулгавартай байсан нь амьдралыг чинь хэрхэн адисалсан тухай гэрчлэлээ хуваалц. Дуулгавартай байдал танд аз жаргалтай болгосон үеийнхээ тухай та ярьж болно.


Ирэх долоо хоногийн туршид эцэг эхдээ дуулгавартай байхад нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Дотроо хоёр жижиг дугуйтай нэг том дугуйг самбар дээр зур (зураг чимэглэлийг үз).



Энэ үйл ажиллагаанд хэрэглэгдэх зүйл нь оролцогчийн нүдийг боож байх хооронд хамгийн бага дугуй дотор Х-ийг байрлуулах явдал мөн. Сайн дураараа оролцогчийн нүдийг боож, шохой өг. Нүдийг нь боосон хүүхдийг хоёр, гурван удаа эргүүлж, дараа нь самбарын өмнө зогсоо. Тэр хүүхдээр самбар дээр Х тавиул. Тэгээд түүнд өөр нэг Х-ийг хаана

байрлуулах тухай заавар өгсний дараа үүнийг байрлуул. Нүдийг нь боосон хүүхдэд өөр нэг хүүхдээр “арай дээшээ”, “арай доошоо”, “зүүн тийшээ”, “баруун тийшээ” гэхчлэн заавар өгүүл.

Хоёр тэмдэглээсийг харж нүдээ боолгосон хүүхэд өөр хүүхдийн зааврыг дуулгавартай дагаснаар хэр зэрэг сайн хийснийг ярилц.

- (Нүдээ боолгосон хүүхдийн нэрийг хэлж) зааврыг дуулгавартай дагаснаар яагаад Х-ийг илүү сайн байрлуулсан бэ?

Нүдээ боолгож үйл ажиллагаанд оролцон, өөр хүүхдийн зааврын дагуу Х-ийг дугуй дотор байрлуулахыг хүссэн хүүхэд бүрт оролцохыг нь зөвшөөр.

Дугуйнуудыг илүү сайн харж байсан хүний зааварт дуулгавартай байснаар дугуй дотор тэмдэглээс хийхэд нүдээ боолгосон хүүхдүүд амжилттай байсныг онцлон тэмдэглэ. Зарим үед Тэнгэрлэг Эцэг, бидний эцэг эхчүүд бидний амьдрал дахь зүйлүүдийг бидний хардгаас илүү сайн хардгийг тайлбарла. Тэд бидэнд туслахын тулд заавруудыг өгдөг. Бид Тэнгэрлэг Эцэг болон эцэг эхчүүдээ дуулгавартай дагасан тохиолдолд бид аз жаргалтай байх болно.

2. Дараах түүхийг өөрийн үгээр ярь:

Матью шүдэнзэнд дуртай байв. Асаах лаа буюу гал асаах хэрэг гарвал, тэр туслахыг үргэлж хүсдэг байлаа. Заримдаа түүний эцэг эх шүдэнз зурахыг түүнд зөвшөөрдөг байсан боловч, тэд түүнийг анхааралтай байхыг нь харахын тулд үргэлж дэргэд нь байдаг байв.

Нэг өдөр эцэг эхийгээ өрөөнд байхгүй үеэр ширээн дээр хайрцаг шүдэнз байхыг Матью харжээ. Шүдэнзээр юм бүхнийг өөрөө асааж үзвэл яасан хөгжилтэй байх бол гэж тэр бодов. Анхааралтай байх ёстой гэдгийг тэр мэдэж байлаа.

Шүдэнз бол тоглоом биш, шүдэнзийг тэр зөвшөөрөлгүйгээр хэрэглэж огт болохгүй гэж ээж нь түүнд олон удаа хэлдэг байсныг Матью тэр үед саналаа. Матью чимээгүйхэн шүдэнзнээс холдож, гадаа тоглохоор гарчээ.

Хэрэв Матью шүдэнзийг авсан бол гарч болзошгүй үр дагавруудын тухай хүүхдүүдтэй ярилц. Хэдийгээр энэ тухай нэг ч хүн мэдээгүй боловч, Матьюгийн дуулгавартай байдал гэр бүлд нь ашиг тустай болсныг онцлон тэмдэглэ.

Та дараах асуултуудыг асуух замаар ярилцлагыг үргэлжлүүлж болно:

- Хэрэв тэд шүдэнзээр хамтдаа тоглохын тулд шүдэнзийг унтлагын өрөөнд авчрахыг ах нь түүнд хэлсэн бол Матью яах ёстой байсан бэ?

Буруу гэдгийг нь бидний мэдэх ямар нэг зүйлийг хий гэж хэн нэгэн хүн бидэнд хэлсэн үед бид дагахгүй байх ёстойг тайлбарла. Ямар нэг буруу юм хийхийг бидэнд хэлсэн үед бид дуулгавартай дагахыг Тэнгэрлэг Эцэг хүсэн хүлээдэггүй билээ.

3. Дараахтай адил энгийн зааврууд бүхий цаасуудыг бэлтгэ:

- Самбар арч.
- Ангийн гишүүн бүртэй гар барь.
- “Миний Хийсний Адилаар Хий” дууг дуулах буюу үгийг нь хэл.

- Ангийн гишүүн бүрийн талаар найрсаг зүйлийг хэл.
- Өөрийнхөө талархалтай байдаг таван зүйлийг нэрлэ.
- Долоо хоногийн туршид гэр бүлдээ зориулж өөрийн хийх ямар нэг зүйлийг жүжигчлэн тогло.

Цааснуудыг саванд хий. Савнаас цааснуудыг хүүхдүүдээр ээлжээр сонгуулж, түүн дээрх заавруудыг даган биелүүл.

4. Хичээлийн өмнө ангид нэг жижиг үнэт зүйлийг нууж түлхүүрийг (таавар) бэлтгэ. Түлхүүр бүр нь хүүхдүүдийг дараагийн түлхүүр лүү хөтөлж, сүүлчийн түлхүүр нь үнэт зүйл рүү хөтлөх ёстой. Тааврын төгсгөлд та нэг жижиг зугаатай зүйл буюу бэлгийг хүүхэд бүрт өгч болно.


Үнэт зүйлийг олохын тулд түлхүүр бүр дээрх заавруудыг хүүхдүүд хэрхэн дагах ёстойг тэдэнтэй хамт хэлэлц.

Үнэт зүйлийг хүүхдүүд олсны дараа, хэрэв бид Тэнгэрлэг Эцэгтээ дуулгавартай байх юм бол тэр бүхнээс хамгийн агуу үнэт зүйлсийг бидэнд өгөх болно гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал.

5. Эхлэл 6–8-д байдаг Ноа болон хөвөгч авдрын тухай түүхийг нэгтгэн дүгнэ. Ноа дуулгавартай байсны улмаас, тэр болон түүний гэр бүл үерээс аврагдсаныг тайлбарла. Ноагийн нэгэн адил Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн зарлигуудыг дуулгавартай дагахад нь хүүхдүүдийг урамшуул.

Хичээлийн төгсгөл дэх тарааж өгөх материалыг хүүхэд бүрт өг. Хөвөгч авдрын зургийг хүүхдүүдээр будуулж, дараа нь тэд хэрхэн дуулгавартай байж болохыг харуулсан зураг зуруул.

Ноа Дуулгавартай Байв



Би Дуулгавартай Байж
Чадна

Би Хуулийг Дуулгавартай Сахих Болно

Хичээл
31

Зорилго

Улс орныхоо хуулиудыг хүндэтгэн, дуулгавартай дагахын ач холбогдлыг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 22:15–22, Итгэлийн Тунхаг 1:12-ыг залбиралтайгаар судал.
2. Хүүхэд бүрт хэсэг давстай гурилын зуурмаг бэлтгэ. Давстай гурилын зуурмагийн жорыг хуудас 43-аас үзэж болно. (Давстай зуурсан гурил олдохгүй бол, хүүхдүүдэд ашиглуулах будгийн харандаа, цаас авчир.)
3. Хүүхдүүдийн мэдэх хууль, дүрмүүдийг оруулан зарим нөхцөлүүдийг хуудас цаасан дээр жагсаа. Ангийн хүүхэд бүрт наад зах нь нэг нөхцөлийг дүрсэлж, нөхцөлүүдийг дугаарла. Доорх нөхцөлүүдийг ашиглах буюу эсвэл ангийнхаа хүүхдүүдэд илүү тохирох бусад нөхцөлүүдийг зохио.
 - Чи хичээлдээ бараг хождох шахжээ. Чи явган хүний гарцаар гарахын оронд орон сууцны барилгын дундах гудамжаар хөндлөн гарсан бол сургуульдаа хурдан хүрэх байв. Хэрэв чи хуулинд дуулгавартай байвал яах вэ?
 - Чи аавтайгаа хамт дэлгүүрээр явж байгаад чихэр авч өгөхийг гуйжээ. Аав чинь үгүй гэж, гэхдээ аав чинь авсан хүнсний зүйлүүдийнхээ үнийг төлөө завгүй байв, халаас уруугаа огт ажиглагдалгүйгээр нэг чихэр гулсуулж болмоор байгааг чи харжээ. Хэрэв чи хуулийг дагавал яах вэ?
 - Чи нохойгоо гадаалуулахаар уяанаас нь хөтөлж явжээ. Чи цэцэрлэгт хүрээлэн рүү хүрч ирээд, зогсож тогломоор санагдав, гэтэл “Нохой Оруулж Болохгүй” гэсэн тэмдэг байлаа. Эргэн тойрондоо насанд хүрсэн ямар ч хүн байхгүйг хараад нохойгоо модноос уяж, тэр хооронд чи тоглож болох байв. Хэрэв чи хуулийг дагавал яах вэ?
 - Гэрлэн дохиотой булан дээр чи гудамж хөндлөн гарах байв. Ирж байгаа машин алга, ойр орчинд нэг ч хүн байхгүй байлаа. Гэрлэн дохио хүлээхийг шаардаж байв. Хэрэв чи хуулийг дагавал яах вэ?
 - Чи номын санд байлаа, авсан номоо буцаах гэтэл гэр уншлагын картаа гэртээ орхисон байв. Номын санч хүлээн авах ширээний дэргэд байхгүй байсан учир номтойгоо гараад явчихаж болохоор санагдлаа. Хэрэв чи хуулийг дагавал яах вэ?
4. Нөхцөлүүдийн тоогоор жижиг цааснууд бэлтгэ. Цааснуудыг тоолж аяга буюу сагсанд хий.
5. Хүүхэд бүрт цаасан энгэрийн тэмдэг хий:

Хуулинд
дуулгавартай
байхад бид
итгэдэг.

6. Дараах цаасан туузыг хий:

Хуулинд дуулгавартай байхад бид итгэдэг.

7. Шаардлагатай материалууд:

а. Библи.

б. Зоос (хэрэв боломжтой бол дээрээ улсын удирдагчийн зурагтай).

в. Сүлбээр зүүнүүд, тууз буюу тэмдгүүдийг хүүхдийн хувцсанд хадах утас.

г. Зураг 2-53, Цезарьт Өг.

8. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Хууль, Дүрмүүд Бидэнд Тусалж Чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хүүхдүүдэд давстай зуурсан гурил өгч, хүүхэд бүрээр гэрийн амьтны дүрс хийлгэ. (Хэрэв давстай зуурсан гурил байхгүй буюу танай ангийн хүүхдүүдийн хувьд энэ үйл ажиллагаа хэтэрхий хүнд байвал, тэдэнд будгийн харандаа, цаас өгч хүүхэд бүрээр гэрийн амьтан зуруул. Үүнтэй уялдуулан ярилцлагыг зохицуул.)

Бүх амьтдыг ширээн дээр буюу шалан дээр тавь. Малчин хүмүүс мал, гэрийн амьтандаа тэжээл, ус өгч, тэдгээрийг хамгаалдаг байх ёстойг тайлбарла. Хэрэв мал, гэрийн амьтад эзэнгүй тэнэж явах юм бол, алдагдах буюу гэмтэж бэртэж болно.

- Мал, амьтдыг тэнээд явчихаас сэргийлэхийн тулд бид юу хийж болох вэ? (Хашаа барь.)

Хэсэг давстай зуурсан гурилыг хоёр алганыхаа хооронд бөөрөнхийлж урт нарийхан болго. Гэрийн амьтдыг үүгээрээ тойруулан хашаа болго. Мал, гэрийн амьтдыг аюулгүй байлгахад тусалдаг учир хашаа сайн юм гэдгийг тайлбарла. (Хичээлийн үлдсэн хугацаанд амьтдыг ийм байдалтай үлдээ. Хичээл дуусахад амьтдыг хүүхдүүд гэртээ аваачиг.)

Биднийг мөн аюулгүй байлгах зүйлүүд бидэнд байдгийг тайлбарла. Эдгээр зүйлүүдийг хууль, дүрмүүд гэдэг. Хууль дүрмүүд нь хашаатай адил юм, учир нь тэдгээр нь биднийг аюултай зүйлүүд хийхээс буюу бусад хүмүүсийг золгүй болгохоос сэргийлдэг. Бид хууль, дүрмүүдэд дуулгавартай байх юм бол тэдгээр нь биднийг аюулгүй, аз жаргалтай байхад тусалдаг.

Ярилцлага

Өлмий дээрээ явах мэтийн, ангийн чинь хүүхэд бүрт танил энгийн тоглоом сонго. Тоглоомын дүрмийг хүүхдүүдээр өөртөө яриулж, хэрэв тэд тоглоомын дүрмийг дагахгүйгээр тоглох гэж оролдвол юу болохыг ярилц. Тоглоомын дүрэм нь амжилттай тоглох хийгээд тоглоомыг хөгжилтэй болгоход зайлшгүй чухлыг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

- Тоглоомын дүрмүүдээс гадна ямар төрлийн дүрмүүд байдаг вэ?
- Танай гэрт ямар дүрмүүд байдаг вэ?

“Тоглож дуусахаараа тоглоомоо хурааж бай” гэх мэтийн ямар дүрмийг гэр оронд нь баримталдгийг хүүхэд бүрээр яриул. Хүүхэд бүр ямар нэг дүрмийн тухай дурдахад асуу:

- Энэ дүрэм та нарт хэрхэн тусалдаг вэ?

Хүүхэд бүр гэр бүлийн дүрмээ ярьсны дараа гэр орноосоо өөр газруудад дагадаг дүрмүүд байдгийг онцлон тэмдэглэ.

- Сургууль дээр, Хүүхдийн Хэсэгт баримталдаг зарим дүрмүүд юу вэ?
- Эдгээр дүрмүүд та нарт хэрхэн тусалдаг вэ?

Манай Улс Бидэнд Хуулиудыг Өгдөг

Түүх ба
ярилцлага

Гэр орондоо, сургууль дээрээ болон Хүүхдийн Хэсэгт бидэнд дүрмүүд байдагтай яг адилхан хот болон улс орондоо дагах дүрмүүд бидэнд байдаг. Эдгээр дүрмүүдийг хуулиуд гэж нэрлэдэг. Хуулиуд нь биднийг гэр орон, сургууль, Хүүхдийн Хэсэг дэх дүрмүүдийн нэгэн адил бидэнд тусалж, биднийг хамгаалж байдаг. Бид хуулиудад дуулгавартай байх үед тэдгээр нь биднийг хэрхэн хамгаалдаг буюу бидэнд тусалдаг тухай мэдсэн хүүхдийн тухай түүхийг ярь. Доорх түүхийг ашиглах буюу эсвэл иймэрхүү түүхийг өөрөө зохио:

Жерри өөрийн нохойтой болохыг үргэлж хүсдэг байв, тиймээс төрсөн өдрөөр нь түүнд хөөрхөн гөлөг өгөхөд сэтгэл их догдолжээ. Тэр нохойгоо Пал гэж нэрлэв. Жерри, Пал хоёр хамтдаа тун хөгжилтэй байдаг байлаа.

Бүх нохой хашаагүй талбайд байхдаа уяатай байх ёстой гэсэн хууль Жеррийн хотод байлаа. Нэг өдөр Жерри найзынхаа гэр лүү Палыг авч явахаар шийджээ. Тэр Палын уяаг олсонгүй, тэгээд ч найз нь хэдхэн байшингийн цаана амьдардаг болохоор Жерри Палыг уяагүйгээр авч явахаар шийдэв.

Тэд гудамжаар уруудтал, замын нөгөө талд нэг муур сууж байхыг Пал харжээ. Жерри юу болсныг ухаарахаас өмнө Пал зам руу харайн орж, машинд шүргүүлэв.

Жерри уйлан нохойгоо өргөж аваад гэртээ авчрав. Жерригийн ээж тэр хоёрыг малын эмчид аваачихад тэр Палын хугарсан хөлийг эмчилжээ.

Тэднийг гэртээ ирэхэд Пал алагдаж ч болох байсныг Жерригийн ээж түүнд хэлжээ. Хэрэв тэр хуулийг дагасан бол нохойгоо уяагаар нь тогтоож чадах байсныг, Пал бэртэхгүй байсныг Жерри ойлгов. Түүнийг болон нохойг нь хамгаалах хууль байсныг Жерри ухаарч, дахиад хуулийг хэзээ ч зөрчихгүй байхаар шийджээ.

- Жерригийн хот яагаад нохойг уяагаар нь хөтөлж явах тухай хуультай байсан гэж та нар бодож байна?
- Палын осол хэрхэн сэрэмжлэгдэж болох байсан бэ?
- Дагаж баримтлах ёстой хууль дүрмүүд яагаад бидэнд байдаг вэ?

Ярилцлага

Бидэнд туслах, бас биднийг хамгаалахын тулд хуулиуд гаргадгийг тайлбарла. Өөрийн орон дахь зарим гол хуулиудыг нэрлэхийг хүүхдүүдээс хүс. Хууль бүрийг ярилцаж, яагаад уг хуулийг гаргасныг ярилц. Хууль тус бүр ямар ашиг тустайг мэдэхэд нь хүүхдүүдэд тусал.

Хэрэв танай бүсэд тохиромжтой бол дараах санаануудаас заримыг нь ашиглаж болно:

Замын Хөдөлгөөний Хууль

- Зогс гэсэн бүх тэмдгэн дээр зогс. Энэ нь та нарыг ослоос урьдчилан сэргийлнэ.
- Хурдны хязгаарлалтыг сахь. Хүмүүс ихэд анхаарал болгоомжтой жолоодож, онцгой тохиолдолд хурдан зогсохын тулд хурдны хязгаарлалт заагдсан байдаг.

Гэрийн Амьтны Тухай Хууль

- Хашаанаас гадагш гарсан үед гэрийн амьтныг уяанаас нь барьж яв. Уяа буюу оосор нь гэрийн амьтдыг бэртэхээс (Жерригийн нохой Палын адил), мөн хүмүүсийн өмчийг амьтад гэмтээхээс хамгаалж чадна.
- Амьтдыг зодож болохгүй. Энэ төрлийн хууль нь амьтдыг бэртэж гэмтэхээс хамгаалдаг.

Хувийн Өмчтэй Холбоотой Хуулиуд

- Хулгай бүү хий. Хэрэв бид өөр бусдын юмсыг авбал, хүн бүр баяр хөөргүй байх болно.
- Хог бүү тарь. Хэрэв хүн бүхэн хог тарих юм бол, манай хот муухай, эмх замбараагүй байх болно. Хогийг цэвэрлэхийн тулд бидний эцэг эхчүүд мөнгө төлөхөд (татвараар дамжуулан) хүрч болно.

Хуулинд Дуулгавартай Байхыг Есүс Христ Биднээс Хүсдэг

Ярилцлага

- Татвар гэж юу вэ?

Цагдаагийн ажилтнууд, гал сөнөөгчид, зам, сургууль зэрэг хүн бүрт ашиг тустай зүйлүүдийн төлөө мөнгө төлөхөд нь төрд буюу улс орондоо бидний өгдөг мөнгө бол татвар юм гэдгийг тайлбарла. Хэрэв эдгээр зүйлүүд байхгүй байсан бол ямар байх тухай ярилц. Эдгээр зүйлүүдийн төлөө төлөхөд хүн бүр тусалдаг байхын тулд бидэнд татварын хуулиуд байдгийг тайлбарла.

Судрын түүх

Есүс Христийн үед хүмүүс бас татварын хуулиудтай байсныг тайлбарла. Цезарьт Өг, зураг 2-53-ыг үзүүлж, Матай 22:15–22-т байдаг түүхийг ярь.

Хүмүүс улс орондоо алба гувчуурын мөнгө төлөх ёстой юу гэж Есүсээс асуусныг тайлбарла. Алба гувчуурын мөнгө гэдэг нь татварын мөнгөтэй адил юм.

Өөрийн авчирсан зоосыг үзүүл. Өөртөө зоосыг үзүүлэхийг Есүс хүмүүсээс хүссэнийг тайлбарла. Зоосон дээр улс орны удирдагч, Цезарийн зураг байсныг онцлон тэмдэглэ. (Хэрэв өөрийн чинь авчирсан зоос дээрээ улс орны удирдагчийн зурагтай бол, түүнийг үзүүл.) Матай 22:21-д (*Тэгвэл гэдгээс эхлэн*) Есүс хүмүүст хэлсэн зүйлийг чанга унш. Хүмүүс улс орныхоо хуулиудад ч мөн Тэнгэрлэг Эцэгийн хуулиудад ч дуулгавартай байх ёстой гэж Есүс тэдэнд хэлснийг тайлбарла. Улс орныхоо хуулиудад дуулгавартай байх нь чухал ач холбогдолтой гэж Есүс хүмүүст заадаг байлаа.

Хуулийг Дуулгавартай Дагахад Бид Итгэдэг

Цаасан туузан дээр бичсэн үг

Цаасан туузан дээрх өгүүлбэрийг чанга унш. Энэ бол итгэлийн тухай Сүмийн тунхгуудын нэг итгэлийн арван хоёрдугаар тунхгийн хэсэг гэдгийг тайлбарла.

Өгүүлбэрийг ангиар хамтад нь хэдэн удаа давтан хэлүүл.

Тоглоом

Нөхцөлүүдийн жагсаалт болон аяга буюу дугаартай сагсыг ширээн дээр буюу шалан дээр тавь. Одоо тэд “Хуулийг Дуулгавартай Дагах нь” тоглоомыг тоглож болно гэдгийг ангид хэл. Тэгээд буцаж суун нэг, хоёр хором хүлээ. Хэрэв хэн ч хариулахгүй бол, асуу:

- Яагаад хэн ч тоглоомыг тоглохгүй байгаа билээ? (Дүрмийг хэн ч мэдэхгүй байгаа учраас.)

Хэрэв хүүхдүүд нөхцөлийг ойлгохыг хичээх юм бол, дугаарласан цаасуудыг дэс дарааллаар тавих замаар, тэдний хичээл зүтгэлийг магтаж, дараа нь асуу:

- Та нар “Хуулийг Дуулгавартай Дагах нь” тоглоомыг тоглох уу?
- Яагаад үгүй гэж?

Хууль, дүрмүүд нь биднийг удирдан, чиглүүлэхэд тусалдгийг онцлон тэмдэглэ. Тоглоомын дүрмийг тайлбарла:

1. Аяганаас (эсвэл сагснаас) дугаарыг ав.
2. Нэг гэсэн дугаарыг авсан хүнээс эхлэн өөрийн ээлжийн дэс дарааг тогтоо.
3. Өөрийнхөө ээлж болоход босч зогс.
4. Өөрийнхөө дугаарыг багшид өг, багшийн асуултад бусад хүүхдүүдийн тусламжгүйгээр хариул.
5. Өөрийнхөө ээлжийн өмнө буюу дараа сандалдаа чимээгүй суу.

Аяга буюу сагснаас дугаарыг хүүхэд бүрээр авахуулж тоглоомыг тогло.

Хүүхэд бүрийн дугаарт тохирох нөхцөлийг түүнд уншиж өг.

Хүүхэд бүр асуултыг хариулахад тэмдгүүдийг тэдэнд өг. Сайн санаанууд болон хариултуудын төлөө хүүхдүүдийг магт.

Дүгнэлт

Хүүхдийн оролцоо

Тэмдгүүдийн талаар гэрийнхэн нь асуухад тэд юу гэж хэлэхийг хүүхдүүдээс асуу. Тэд хариултуудаа хуваалцахад бид хамтдаа аз жаргалтай амьдрахын тулд хуулиудыг дуулгавартай дагахын ач холбогдлыг онцлон тэмдэглэ.

Гэрчлэл

Бидний сайн сайхны төлөө хуулиуд зохиогддогийг гэрчил. Хуулийг дуулгавартай дагасныхаа төлөө талархалтай байсан тохиолдлынхоо талаарх хувийн туршлагаа хуваалцаж болно. Тэнгэрлэг Эцэгийн хуулиуд мөн улс орныхоо хуулиудыг дуулгавартай дагахыг хүүхдүүдэд сануул.

Энэ долоо хоногт дуулгавартай дагах нэг хуулийг сонгоход нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Хуулиудыг санаж, дуулгавартай дагахад нь хүүхдүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс хүсэхийг тэр хүүхдэд санал болго.

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Хаад, ерөнхийлөгчид, удирдагчид мөн шүүгчдэд захирагдаж, хуулийг дуулгавартай дагаж, хүндлэн дээдэлж мөн дэмжих ёстой гэдэгт бид итгэдэг” гэсэн итгэлийн арван хоёрдугаар тунхагийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал.

Бага насны хүүхдүүд энгэрийнхээ тэмдгэн дээр бичсэн: “Хуулийг дуулгавартай дагахад бид итгэдэг” гэсэн итгэлийн тунхгийн хэсгийг цээжилж болно.

“Итгэлийн Арванхоёрдугаар Тунхаг” (*Children’s Songbook*, х. 131) дууны үгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд та энэ дууг дуулж болно.

2. Гэр бүлийн гишүүдийг аюулгүй, аз жаргалтай байлгахад туслах гэр бүлийн таван дүрмийн тухай бодохыг ангиас хүс. Дүрэм бүрийг нэрлэх үед хүүхэд бүр нэг хуруугаа гозойлгон харуулна. Таван дүрэм нэрлэгдэхэд хүүхэд бүр таван хуруугаа тэнийлгэн харуулж, хүүхэд бүрийн гарыг самбар дээр тойруулан зур. Гарын зураг бүрийг хүүхдийн нэрээр нэрлэ. Гараараа тусалсанд хүүхдүүдэд талархал илэрхийлж, өөрсдийн гэр бүлийн дүрмүүдээ санаж, дуулгавартай дагахад нь тэднийг урамшуул.

3. Дараах хурууны тоглоомыг хүүхдүүдээр тоглуул:

Би зогсож байна (*Алгаа тэнийлгэн хоёр гараа дээш өргөн ямар нэг юмыг зогсоох мэт*)

Би харж байна (*Нүдээ гараараа таглах мэт тавина*).

Би сонсож байна (*Чихнийхээ ард гараа аяга мэт хөмөрнө*).

Ингээд би зөвийг хийж буйгаа (*өөрийгөө заана*).

Итгэлтэйгээр мэднэ би (*Хуруугаа урагш хойш хөдөлгөнө*).

Хаашаа би явсан нь хамаагүй (*Зайг харуулахын тулд гараа сунгана*).

Зөвхөн уулзвараар гарна (*гараа цээжин дээрээ зөрүүлэн харуулна*).

Гудамжны тал дундуур биш (*Толгойгоо сэгсэрнэ*).

Би урагшаа харж байна (*Нүдээ гараараа таглах мэт тавина*).

Би цааш бодож байна (*толгойныхоо хажууд гараа хүргэнэ*).

Би тэгээд дараа нь хөлөө ашиглана (*дороо алхална*).

Замын хөдөлгөөний дүрмийг сахихын ач холбогдлыг хүүхдүүдэд сануул.

Зорилго Хүүхдүүд Есүс Христийн үлгэр жишээг дагаж, бие биенээ хайрлаж чадна гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах.

- Бэлтгэл**
1. Марк 6:34–44; Лук 17:11–19; Иохан 13:15, 34–35; түүнчлэн 3 Нифай 17-г залбиралтайгаар судал.
 2. Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаанд зориулж том зүрх цаасаар хайчил.
 3. “Би чамайг хайрлахдаа” тарааж өгөх материалын хувь буюу хуулбар түүнчлэн хичээлийн төгсгөл дэх зүрхэн хэлбэрт тааврыг хүүхэд бүрт бэлтгэ. Хэрэв боломжтой бол, тааврыг өнгийн цаасаар хувилах буюу хуулбарлан хий. Тааврыг цэгтэй шугамын дагуу хэсгүүд болгон хайчил.
 4. “Бие Биенээ Хайрла” (*Children’s Songbook*, х. 136), “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” (*Children’s Songbook*, х. 61) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. “Бие Биенээ Хайрла” дууны үг гарын авлагын ар талд хавсаргагдсан байгаа.
 5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи, Мормоны Ном.
 - б. Цавуу буюу зуурмаг.
 - в. Зураг 2-36, Нифайчуудын Хүүхдүүдийг Есүс Адисалж Байгаа нь; зураг 2-45, Уяман Өвчтэй Арван Хүн (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 221; 62150); зураг 2-47, Таван Мянган Хүнийг Хооллосон нь (62143); зураг 2-54, Сүүлчийн Оройн Зоог (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 225; 62174).
 6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бусдаар Хайрлуулах нь Чухал

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Том цаасан зүрхийг хүүхдүүдэд үзүүл.

- Зүрхийг хараад та нар юу гэж бодож байна? (Хайр.)
- Хүн та нарыг хайрладаг гэдгийг та нар хэрхэн хэлдэг вэ?

Өөрсдийг нь хайрладаг хүмүүсийн талаар (гэр бүлийн гишүүд, найз нөхөд, Хүүхдийн Хэсгийн багш нар), тэрчлэн эдгээр хүмүүс хайраа хэрхэн харуулдаг тухай хүүхдүүдээр яриул.

- Өөрийг чинь хайрлах хайраа хүмүүс харуулсан үед та нарт ямар санагддаг вэ?

- Та нар бусад хүмүүсийг хайрлах хайраа тэдэнд харуулсан үед тэдэнд ямар санагддаг гэж та нар боддог вэ?

Биднийг бусад хүмүүс хайрладгийг бид бүгд мэдэх хэрэгтэйг онцлон тэмдэглэ.

Бие Биенээ Хайрлахыг Есүс Христ Бидэнд Заасан

Багшийн танилцуулга

Есүс Христ дэлхий дээр ирж амьдрахаас өмнө хүмүүс “бие биенээ харах” дүрмээр амьдардаг байсныг тайлбарла. Энэ нь хэрэв хүмүүс чамд муугаар буюу нөхөрсөг бишээр хандах юм бол, чи тэдэнд мөн муугаар буюу нөхөрсөг бишээр хандаж болно гэсэн үг юм. Есүс дэлхийд ирсэн үедээ амьдрах өөр арга замыг хүмүүст зааж байсныг тайлбарла.

Судрын түүх

Сүүлчийн Зоог, зураг 2-54-ийг үзүүл. Есүс цовдлогдохынхоо өмнөхөн тэр шавь нартайгаа уулзаж, тэд сүүлчийн хоолыг хамтдаа идсэнийг тайлбарла. Энэ хоол Сүүлчийн Зоог гэж нэрлэгддэг болжээ. Энэ хоолны үед тэр удахгүй тэднийг орхин явна гэдгийг Аврагч шавь нартаа ярьж, тэдэнд зарим заавар өгчээ.

Библийг үзүүлж, Иохан 13:34–35-ыг чанга унш. Эдгээр нь Есүсийн үгс гэдгийг тайлбарла. Шүлэг 34-ийн эхний хэсгийг дахин унш (*Эхний бие биенээ хайрлагтун* гэснийг дуустал).

- Ямар зарлиг вэ?

Энэ сударт бид зөвхөн бие биенээ хайрлахыг төдийгүй, бас бусад хүн болгоныг хайрлах зарлигийг бидэнд Есүс өгснийг онцлон тэмдэглэ. Хэрэв бид Есүсийг дагах юм бол, бид бусдыг хайрлах болно.

Дуу

Өгсөн үйлдлүүдийг ашиглан, “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” дууг дуулах буюу үгийг хэл:

Есүс бүгдийг хайрла гэж хэлсэн (*гараа сунган харуулна*)

Бас тэдэнд найрсаг ханд (*хажуу дахь хүн рүүгээ эргэж, гарыг нь атга*)

Зүрх сэтгэл чинь хайраар дүүрэхэд (*гараа зүрхэн тушаагаа байрлуулна*)

Бусад хүмүүс чамайг хайрлана (*өөрийгөө тэвэрч харуулна*).

Есүс Христ Бусдад Тусалснаар Тэднийг Хайрлах Хайраа Харуулдаг Байв

Судар

Иохан 13:15-ыг чанга унш.

- Үлгэр жишээ үзүүлэх гэж юу гэсэн үг вэ?
- Хэн бидэнд сайн үлгэр жишээ үзүүлсэн бэ?

Өөрийн чинь дөнгөж сая уншсан судар дахь үгсийг Есүс Христ хэлснийг хүүхдүүдэд хэл. Есүс бидэнд үлгэр жишээ үзүүлсэн нэг арга зам бол бусад хүмүүсийг хайрлаж, тэдний төлөө сайн зүйлсийг хийх явдал байсныг тайлбарла.

Судрын түүхүүд ба ярилцлага

Уяман Өвчтэй Арван Хүн, зураг 2-45-ыг үзүүл. Энэ зургаар өгүүлсэн түүхийг ярихыг хүүхдүүдээр хүс (Лук 17:11–19-ийг үз).

- Уяман өвчтэй арван хүнд туслахын тулд Есүс юу хийсэн бэ?
- Яагаад тэр тэднийг эмчилсэн бэ?

Таван Мянган Хүнийг Хооллосон нь, зураг 2-47-г үзүүлж, зургаар өгүүлэгдсэн түүхийг (Марк 6:34–44-ийг үз) ярихыг хүүхдүүдээс хүс. Шаардлага гарвал тэдэнд тусал.

- Хүмүүст туслахын тулд Есүс юу хийсэн бэ?
- Тэр яагаад тэдэнд тусалсан бэ?

Нифайчуудын Хүүхдүүдийг Есүс Эдгээж Байгаа нь, зураг 2-36-г үзүүлж, 3 Нифай 17 дахь түүхийг ярь. Есүс Америк тив дэх Нифайчуудыг орхиж, Тэнгэрлэг Эцэг рүү буцахад бэлэн болсон хэдий ч, Нифайчууд түүнийг явахыг хүсэхгүй байв (3 Нифай 17:4–5-ыг үз). Есүс дахиад багахан хугацаагаар үлдэж бүх өвчтэй хүмүүсийг эдгээж, бүх хүүхдийг адисалжээ.

- Есүс яагаад Нифайчуудтай хамт байсан бэ?
- Есүс яагаад өвчтөнүүдийг эдгээж, хүүхдүүдийг адисалсан бэ?

Эдгээр түүх нэг бүр нь Есүс хүмүүст хайртай учраас тэдэнд тусалж байсныг онцлон тэмдэглэ. Бид хүмүүст тусалснаараа тэднийг хайрладгаа хүмүүст харуулж чадна.

Бид Бусад Хүмүүст Тусалснаар Есүс Христийн Үлгэр Жишээг Дагаж Чадна

Судар

Иохан 13:35-ыг дахин унш. Бид бусад хүмүүсийг хайрлах хайраа харуулахад бид Есүс Христийн үлгэр жишээг дагадгийг тэд мэдэх болно.

Дуу

“Бие Биенээ Хайрла” дууг дуулах буюу үгийг нь хэл.

Түүх

Бид Есүс Христийн жишээг дагаж, бусдад тусалснаар тэднийг хайрлах хайраа харуулж чадна гэдгийг тайлбарла. Хэн нэг хүнийг хайрлах хайраа харуулахын тулд ямар нэг сайн зүйл хийсэн хүүхдийн тухай түүхийг ярьж өг. Та дараах түүхийг ашиглаж болно:

Томас хүндээр өвчилж, удаан хугацаагаар хэвтжээ. Тэр өөрөө болон найз нар нь хийх дуртай хөгжилтэй бүх зүйлийг хиймээр санагдаж байлаа. Түүнийг өвчтэй байх үед түүний зарим найз нар түүнийг эргэж нэг юм уу хоёр удаа иржээ. Гэвч түүний найз Жуан түүнтэй уулзахаар олон удаа иржээ. Бусад хүүхдүүд олон удаа гадаа тоглож байсан тэр үед Жуан Томасын орны дэргэд сууж, Томастай ярьж, инээн бие нь сайжрахад түүнд тусалж байв.

- Томасыг хайрладгаа харуулахын тулд Жуан юу хийсэн бэ?
- Жуаны талаар Томас ямар бодолтой байсан гэж та нар бодож байна? Томасын талаар Жуан ямар бодолтой байсан гэж та нар бодож байна?

Бусдад туслах замаар бид тэднийг хайрлах хайраа харуулах олон арга зам байдгийг тайлбарла. Бид гэр бүл, найз нөхөд, хөршүүд, настай хүмүүс, өвчтөнүүд эсвэл бидний тусламж хэрэгтэй байгаа хэнд ч гэсэн бид сайн зүйлүүдийг хийж чадна.

Үйл ажиллагаа

Тэдэнд тохиолдож болох нөхцөлийн эхний хэсгийг өөрөө тэдэнд ярьж өгч хүүхдүүдээр сонсуул. Хайраа харуулахын тулд тэд юу хийхийг нь яриулах замаар нөхцөл бүрийг төгсгөхийг хүүхдүүдээс хүс. Нөхцөлүүдээс нэг буюу хоёрыг нь та хүүхдүүдээр биечлэн тоглуулж болно. Дараах нөхцөлүүдийг ашиглах буюу зарим нөхцөлийг өөрөө зохио:

1. Чи аавтайгаа хамт автобус ирэхийг хүлээн гудамжны буланд сууж байлаа. Автобусанд суухаар яарч байгаа ахмад насны нэг хүнийг чи харжээ. Тэр хүн таягтай, тиймээс хурдан явж чадахгүй байв. Автобус хүрч ирэн хаалгаа онгойлгов. Чи автобусны довжоонд гишгэх үед, нөгөөх хүн автобусад ирж амжихгүй нь гэж хэлж чадахаар байв.
 - Энэ хүнд хайраа харуулахын тулд чи юу хийж болох вэ?
2. Ням гарагийн өглөө чи сүм рүү явж байлаа. Нэг гартаа нялх хүүхдээ, нөгөө гартаа хэдэн ном барьсан нэг залуу ээжийг чи харжээ.
 - Аврагчийн үлгэр жишээг дагаж, энэ эмэгтэйд хайрлах хайраа харуулахын тулд чи юу хийж болох вэ?

3. Чамайг сургуулиасаа ирэхэд ээж чинь юм оёх гэж байв. Жаахан дүү чинь дургүйцэж уйлж байв, учир нь тэр түүх уншиж өгөхийг ээжээсээ хүссэн ажээ.
 - Ээжийгээ болон жаахан дүүгээ хайрлах хайраа харуулахын тулд чи юу хийж болох вэ?
4. Хүүхдийн Хэсэгт нэг Ням гарагт өөр орноос нэг шинэ охин иржээ. Тэр их ичимхий, бас олон үггүй байв. Дараа нь тэр цуглааны байрны орох хаалганы дэргэд уйлан зогсож байхыг чи харав.
 - Тэр шинэ охиныг хайрлах хайраа харуулж, туслахын тулд чи юу хийж болох вэ?

Дүгнэлт

Эвлүүлэх үйл ажиллагаа

Зүрх зурсан эвлүүлэх материал болон эвлүүлэх үйл ажилагааны бүрэн материалыг хүүхэд бүрт өг. Эвлүүлэх материалыг эвлүүлж, зүрх хэлбэртэй тараах материал болгон наахад нь хүүхэд бүрт тусал. Хүүхдүүдийн хамт эвлүүлсэн материал болон тарааж өгөх материал дээрх үгсийг унш.

Тарааж өгөх материалыг хүүхдүүдээр гэрт нь өгч явуул. Бусдыг хайрлах хайраа харуулах талаар өнөөдөр юу сурснаа гэрийнхэндээ ярихад нь хүүхдүүдийг урамшуул.

Хэрэв цаг гарвал өөрийн хайрладаг хүний нэрийг хэлэхийг мөн тэр хүнийг хайрлах хайраа харуулж болох арга замын тухай ярихыг хүүхэд бүрээс хүс. Бусдад туслах замаар тэднийг хайрлах хайраа харуулахад нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр, бие биенээ хайрлахыг биднээс хүсдэгийг гэрчил. Бусдыг хайрлах хайраа харуулсан үед өөрт чинь ямар санагддагийг хүүхдүүдэд ярь.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Аврагчийн нэгэн адилаар бусдыг хайрлах хайраа харуулахад нь туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг уг хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхэд бүрээр өөрсдийнх нь хайрладаг нэг хүний талаар, тэд уг хүнд ямар байдлаар анхаарал халамж тавьдаг тухай бичүүл. Бага насны хүүхдүүд өөрсдийн хайрладаг хүмүүсийн зургийг зурж болно. Хүмүүст зориулсан захидлууд болон зургуудыг эзэдтэй нь хуваалцахад хүүхдүүдийг урамшуул.
2. Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч болсон Жон Тейлор өөрийн хайрыг харуулсан цаг үеийн тухай түүхийг ярь:

Жон Тейлорыг бага байхад, түүний найз Роберт Вэст хүнд өвчнөөр нас баржээ. Хожим нь энэ хөвгүүний аав Аллее Вэст тосгоноос шилжиж хоньчин болжээ. Аллее зарим үед ганцаарддаг байсныг Жон мэдэж байв, иймээс тэр Аллеетай очиж уулзаж болох уу гэж эцэг эхээсээ асуудаг байжээ. Жоны эцэг эх түүнд зөвшөөрөл өгч бас сагс дүүрэн хүнсний зүйлийг авч яв гэж Жонд өгчээ.

Аллеегийн гэрт очоод буцаж ирэхийн тулд Жон өдөржингөө явган явах хэрэгтэй байсан болохоор тэр өглөө эрт гарсан аж. Нэг удаа амарч байтал, сагсан доторх хүнснээсээ идмээр санагдаж Жон уруу таталттай учирчээ. Гэвч тэр босч замын үлдсэн хэсгийг аль болохоор түргэн алхжээ.

Жонтой уулсандаа Аллее баяртай байв. Тэр хоёр хүнсийг хамтдаа идэж, өнгөрсөн үеийн тухай ярилцжээ. (Deta Petersen Neeley and Nathan Glen Neeley, *A Child's Story of the Prophet John Taylor* [Salt Lake City: Deseret News Press, 1960], х. 12–18-ыг үз.)

- Найзынхаа аавыг хайрлах хайрыг харуулахын тулд Жон Тейлор юу хийсэн бэ?
- Жон Тейлорын хийсэн зүйлийн талаар Аллее Вэст ямар бодолтой байсан гэж та нар бодож байна?
- Жон Тейлорт ямар санагдаж байсан гэж та нар бодож байна?

Бид бусдыг хайрлах хайраа харуулахад бидний тусалсан хүмүүс, бас бид аль аль нь баяртай байдгийг хүүхдүүдэд сануул.

3. Дараах үйл ажиллагааны шүлгийн үгсийг хэлж, үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Есүс Христ Бүх Хүүхдүүдэд Хайртай

Есүс Христ бүх хүүхдүүдэд хайртай (*гараа алдална*)

Бяцхан тэд балчирхан хэвээр байна (*өвдгийн чинээ өндөр хүүхдийг харуулахын тулд гараараа заана*)

Өлгийдөө байгаа жаахан хүүхдийг ч (*гараараа өлгий дүрслэн харуулна*).

Өдий том, өндөр болсныг ч тэр (*гараа толгойн дээгүүр өргөж харуулна*).

(*Finger Fun for Little Folk* by Thea Cannon-аас авав. © 1949 by the Standard Publishing Company, Cincinnati, Ohio. Зөвшөөрлөөр ашиглана.)

Хүүхдүүдийн хүссэн тоогоор давтан хий.

4. Ангийн өмнө хоёр хүүхдийг босгож зогсоо. Ангийнхан бүгдээрээ энэ хоёр хүүхэдтэй адилхан, жишээ нь хоёр нүд, хоёр чихтэй, мөн нэг адил зүйлүүдийг хийх дуртай, эсвэл Сүмийн гишүүд байгаа зэрэг олон зүйлээр адил төстэй тухай ярилц. Дараа нь тэдний ялгаатай талуудыг, жишээ нь, үсний өнгө өөр, сонирхдог зүйлүүд өөр, дадал хэвшил өөр, гэр бүлийн гишүүдийн тоо өөр болох тухай ярилц. Яг адилхан хоёр хүн байдаггүйг тэмдэглэн хэл. Бид бүгдээрээ өөр хэн нэгнээс олон талаар ялгаатай байдаг.

Зарим үед хүмүүс биднээс зарим талаар ялгаатай байдаг тэдэнд хэрхэн хандахыг бид мэдэхгүй байхад хүргэдгийг тайлбарла. Тэд биднээс өөр хэлээр ярьдаг, тахир дутуу, эсвэл аль нэг талаараа биднээс өөр байж болно. Есүс Христ хүн болгонд хайртай байсан, тэрчлэн тэр өөр бусад хүн бүрийг хайрлахыг биднээс хүсдэг байсныг тайлбарла. Бид өөрсдөөсөө өөр хүмүүст ч мөн өөрсөдтэйгөө адилхан хүмүүст ч мөн адил туслах ёстой.

“Би Тантай Хамт Алхана” (*Children's Songbook*, х. 140) эсвэл “Бид Өөр Өөр” (*Children's Songbook*, х. 263) дуунуудыг та хүүхдүүдээр дуулуулах буюу үгийг нь хэлүүлж болно.

Би Тантай Хамт Алхална

Хэрэв та ихэнх хүмүүсийн адилаар эс алхлах аваас,
Зарим хүмүүс чамаас холдоно,
Харин би тэгэхгүй! Би тэгэхгүй!
Хэрэв та ихэнх хүмүүсийн адилаар эс алхлах аваас,
Зарим хүмүүс чиний тухай ярьж шоолно
Харин би тэгэхгүй! Би тэгэхгүй!
Би тантай хамт алхална. Би тантай хамт алхална.
Тийнхүү би таныг хэрхэн хайрладгаа харуулна.


Хэнээс ч Есүс нүүр буруулдаггүй байсан.
Хүн болгонд тэр хайраа өгсөн юм.
Би ч бас тэгэх болно! Би ч бас тэгэх болно!
Есүс уулзсан болгоноо адисалсан,
Тэгээд эргэж, “Над уруу ирж, намайг дага” гэж хэлсэн.
Би ч бас тэгэх болно! Би ч бас тэгэх болно!
Би тэгэх болно! Би тэгэх болно!
Би тантай хамт алхлах болно. Би тантай ярих болно.
Тийнхүү би таныг хэрхэн хайрладгаа харуулна.

Бид Өөр Өөр

Таныг би танина, чи намайг танина.
Нар лугаа, далай лугаа бид өөр өөр.
Таныг би танина, та намайг танина,
Тийм байхаас өөр зам үгүй.

Би чамд тусалдаг, чи надад тусалдаг.
Бэрхшээлээс бид сурдаг, үүнийг бид ойлгож эхэлж байна.
Би чамд тусалдаг, чи надад тусалдаг,
Тийм байхаас өөр зам үгүй.

Би чамайг хайрладаг, чи намайг хайрладаг.
Бид хамтдаа хамгийн сайханд хүрч чадна.
Би чамайг хайрладаг, чи намайг хайрладаг.
Тийм байхаас өөр зам үгүй.



Би Чамайг
Хайрладаг
Шиг

Бие Биенээ

Хайрла

Энэ эвлүүлдэг тоглоомыг ахлах насны
хүүхдүүдэд зориулж ашигла.

Энэ эвлүүлдэг тоглоомыг бага насны
хүүхдүүдэд зориулж ашигла.

Хайрла

Бие Биенээ

Би Аравны Нэгээ Төлж Чадна


Хичээл
33

Зорилго

Бид аравны нэгээ төлснөөр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайраа харуулдаг гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл


1. Марк 12:41–44-ийг залбиралтайгаар судал. Түүнчлэн *Gospel Principles* (31110), бүлэг 32, мөн Е.Талмейжийн *Есүс Бол Христ* номны 3 дахь хэвлэлийн хуудас 561–62-ыг үз, [Солт Лейк Сити: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, 1916].
2. Доор харуулсны дагуу, нугалсан цаас ашиглан хоёр тэмдэг бэлтгэ:




3. Маркийн тухай түүхийг харуулахын тулд мөнгөний хайрцаг хий. Тагтай, хоёр тасалгаа бүхий ямар ч жижиг хайрцгийг та ашиглаж болно. Хэрэв шаардлагатай бол, тасалгаа хийхийн тулд дараах заавар болон зургийг үз.

Картон цаасаар хайрцагны өндөртэй ижил нэг инч (эсвэл гурван сантиметр), хайрцагнаас арай өргөн зурвас хайчил бэлтгэ. Тал бүр дээр нь бүтэн хагас инч (нэг аравны таван см) зайтай тэмдэглэж, тасалгаа гаргахын тулд талуудыг нугал. Нугалсан хэсгийг цавуудан нааж, хайрцаг дотор нэг нь нөгөөгөөсөө том хоёр тасалгаа гаргахын тулд картонон зурвасыг хайрцган дотор хийнэ.

Хайрцагны нүүрэн тал дээр буюу таган дээр, бага тасалгааны тушаа “Аравны Нэг,” том тасалгаан дээр “Зарцуулах буюу Хэмнэх” гэж бич.



4. Зурагт харуулсны дагуу бор цаасаар жижиг зоосны хэмжээтэй хоёр дугуй хайчилж бэлтгэ:



5. Хүүхэд бүрт Аравны Нэг болон Бусад Өргөлүүдийн тасалбар, аравны нэгийн дугтуй олж бэлтгэ.
6. “Би Их Эзэндээ Аравны Нэгээ Өгөхийг Хүсч Байна” (*Children’s Songbook*, х. 150) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
7. Шаардлагатай материалууд:
- Библи.
 - Адил үнэ бүхий арван зоос (эсвэл тасалбар).
 - Зураг 2-55, Бэлэвсэн Эмэгтэйн Сохор Зоос.
8. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Аравны Нэг Бол Бидний Орлогын Аравны Нэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Арван ширхэг зоосыг гартаа өргөн хүүхдүүдэд үзүүл.

- Хэрэв чи эдгээр зоосуудыг ажил хийж олсон бол яах вэ?

Хүүхэд бүрээр хариулуулж, хариулт бүрийн хувьд нааштай тайлбар хий. Зөв ба буруу хариулт гэж үгүй. Хүүхэд бүрийг хариулсны дараа ярилцлагыг үргэлжлүүл.

Хэрэв хүүхэд аравны нэгийг төлөх тухай дурдсан бол, бид мөнгө олсон үедээ хийх ёстой нэн чухал зүйл дурдлаа гэдгийг тайлбарла. Хэрэв хэн нэг нь аравны нэгийг төлөх тухай дурдаагүй бол, хүүхдүүд мөнгө олсон үедээ хийх ёстой нэг маш чухал зүйлийн тухай мэдэхэд нь тэдэнд туслах гэсэн юм гэдгийг хүүхдүүдэд хэл.

Олсон мөнгөнийхөө аравны нэгийг төлж байхыг Тэнгэрлэг Эцэг бидэнд зарлигласныг тайлбарла. Бид аравны нэгийг төлнө гэдэг нь хүмүүс Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай, тэрчлэн ариун сүмүүд, сүмийн барилгууд, хичээлийн гарын авлагууд болон бусад материалууд зэрэг зүйлүүдийн тухай мэдэхэд нь хүмүүст туслахын тулд бид олсон мөнгөнөөсөө заримыг нь Сүмд өгдөгийг тайлбарла.

Үйл ажиллагаа

Та зооснуудыг ширээн дээр эгнүүлэн тавих үедээ өөртэйгөө хамт хүүхдүүдээр арван зоосыг тоолуул. Ширээ буюу шалан дээр “Аравны Нэг” гэсэн тэмдэг тавь. Тэмдгэн дээрх үгийг унших буюу хүүхдүүдээр уншуул. Бидний олдог мөнгөний аравны нэг хэсэг бол аравны нэг болгон бидний төлдөг мөнгөний дүн юм гэдгийг хүүхдүүдэд хэл. Ширээн дээрх буюу шалан дээрх арван зоосноос нэгийг ялган тавьсан нь аравны нэг болно. Аравны нэг гэсэн тэмдгийн өмнө нэг зоосыг нэг хүүхдээр тавиул.

“Зарцуулах буюу Хэмнэх” гэж бичсэн тэмдгийг “Аравны Нэг” гэсэн тэмдгийн хажууд тавь. Тэмдэг дээрх үгийг унших буюу хүүхдүүдээр уншуул.

- Хэрэв энэ нь та нарын олсон мөнгө байсан бол, аравны нэгийг төлсний дараа та нарт хичнээн зоос үлдэх вэ?

Ангиараа нэг зэрэг есөн зоосыг тоолох үед “Зарцуулах буюу Хэмнэх” гэсэн тэмдгийн өмнө есөн зоосыг нэг хүүхдээр тавиул.

“Зарцуулах буюу Хэмнэх” гэсэн тэмдгийн өмнөх зооснуудыг зааж, аравны нэг болгон бидний төлдөг мөнгө бол бидний олдог мөнгөний өчүүхэн бага хэсэг юм гэдгийг тайлбарла.

Бид олдог бүх мөнгөнөөсөө аравны нэгийг төлөх ёстойг тайлбарла. Хүүхдүүд олсон мөнгөнөөсөө аравны нэг болгон төлөх тухай санааг хүүхдүүд цаашид ойлгоход нь туслахын тулд янз бүрийн зоос буюу тооцооны хуудсуудыг та ашиглаж болно.

Бид Аравны Нэгийг Төлснөөрөө Зөвийг Сонгодог

Түүх

Мөнгөний хайрцгийн хажуу дээрх “Зарцуулах буюу Хэмнэх” гэсэн тэмдгэн дээр есөн зоосыг тавьж, Маркийн тухай болон тэрээр аравны нэгээ төлөхөөр сонголт хийсэн тухай түүхийг өөрийн үгээр ярьж өг. Та уг түүхийг ярихдаа зоос гэдэг үгийг өөрийн авчирсан зоосон мөнгөний нэрээр орлуулж болно.

Маркийг дэлгүүрт сүүлчийн удаа очиход тэрээр худалдаж авахыг хүссэн тоглоом харжээ. Марк ээждээ ажил хийж, тэр тоглоомыг худалдаж авахын тулд мөнгө хадгалж байлаа. Тэр есөн зоостой болов. Өнөөх тоглоомыг худалдаж авахын тулд дахиад ердөө ганцхан зоос хэрэгтэй байв. Хэрэв түүнд нэг ажил хийж өгвөл түүнд мөнгө төлж болно гэж ээж нь хэлсэн аж.

Марк Бямба гарагийн өглөө эрт босч өглөөний хоолоо идээд, ээжийнхээ хийж өгөхийг хүссэн ажлыг хийчихэв. Түүнийг ажлаа дуусгахад, хийсэн ажлынх нь төлөө ээж нь маш баяртай байгаагаа түүнд хэлжээ. Тэр Маркад гялалзсан шинэхэн зоос өгөв. Өнөөх тоглоомыг худалдаж авахад хүрэхээр мөнгөтэй болсондоо Марк ихэд баяртай байлаа.

Марк мөнгөнийхөө хайрцгийг авахаар гүйж очоод, зоосыг түүнд хийв. (Өөр нэг зоосыг хайрцагны “Зарцуулах ба Хэмнэх” гэсэн талд тавь.) Тэгээд Марк ээжтэйгээ хамт дэлгүүр лүү явав.

Тэр хоёр дэлгүүрт очиж, Марк нөгөө тоглоомыг олж харав. Тоглоом зарагдаагүй байсанд тэр баяртай байлаа. Тэр тоглоомыг анхааралтай үзэв. Энэ тоглоомоор тоглохсон гэж тэр тэсч ядан хүлээж байжээ.

Марк тоглоомын үнийг төлөхөөр очтол, дэлгүүрийн ажилтан инээмсэглэж, тоглоом арван зоосны үнэтэй гэв. Марк мөнгөний хайрцагнаахыа тагийг нээж, зооснуудаа тоолж эхлэв. (Мөнгөний хайрцагны тагийг авч, “Зарцуулах ба Хэмнэх” гэсэн тал дахь зооснуудыг тоол.) Арван зоосыг авснаа тэрээр: арван зоосны нэг нь аравны нэг байх ёстойг саналаа.

Марк яахаа мэдэхгүй байв. Тэр тоглоомыг авахыг үнэнээсээ хүсч байлаа. Гэвч аравны нэгийнхээ мөнгийг дэлгүүрийн ажилтанд төлсөн тохиолдолд л зөвхөн тэр үүнийг авч чадах байв. Марк дэлгүүрийн ажилтныг, нөгөөх тоглоомыг, тэгээд бас аравны нэгийн зоосоо харав.

- Хэрэв чи Марк байсан бол яах вэ?

Марк аравны нэгийн зоосоо хайрцагны аравны нэг гэсэн тал руу хийв. (Хайрцагны “Аравны Нэг” гэсэн талд зоосыг хий.) Тэр есөн зоосыг “Зарцуулах ба Хэмнэх” тал руу буцааж хийгээд тоглоомыг тавиур дээр нь буцааж тавихын тулд лангууны дэргэдүүр алхлав.

Маркийн ээж юу ч хэлсэнгүй, гэвч тэр Маркийг чанга гэгч нь тэврэв. Зөв зүйл хийснээ Марк мэдэж байлаа.

Марк маргааш нь сүм дээр аравны нэгийн дугтуйгаа бишопт өгөв. Бишоп Маркийн гарыг барьж, Тэнгэрлэг Эцэг түүнийг аравны нэгээ төлсөнд баяртай байгааг хэлжээ. Марк ч бас баяртай байв. Тэр зөв сонголт хийснээ мэдэж байлаа. (Marshall T. Burton, “The Little Red Car,”-аас хялбаршуулан авав, *Instructor*, 1966 оны Дөрөвдүгээр сар, х. 158–59.)

Ярилцлага

- Марк ямар сонголт хийх шаардлагатай байсан бэ?
- Энэ нь яагаад түүний хувьд хүнд сонголт байсан бэ?
- Өөрийнхөө хийсэн сонголтын хувьд Марк ямар сэтгэгдэлтэй байсан бэ? Яагаад?
- Маркийн сонголтын талаар өөр хэн бас баяртай байсан бэ?

Аравны Нэгээ Төлөх нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ Хоёрт Хайртайг Харуулдаг

Ярилцлага

Бид аравны нэгээ төлснөөр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайраа харуулдгийг тайлбарла.

- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд ямар адислалууд өгсөн бэ?

Арван зоосноос нэгийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт бидэнд тэдний өгсөн олон адислалуудын хариуд өгөх нь их биш юм гэдгийг онцлон тэмдэглэ.

Судрын түүх

Бор цаасан дугуйнуудыг хүүхдүүдэд үзүүлж, эдгээр дугуйнууд хичнээн жижигхэн болохыг тэмдэглэ. Эдгээр дугуйнууд Есүс Христийн үед дэлхий дээр хэрэглэгддэг байсан майт хэмээн нэрлэгддэг зооснуудтай хэмжээгээрээ адилханыг тайлбарла. Энэ зоос маш бага үнэтэй байжээ.

Бэлэвсэн Эмэгтэйн Зоос, зураг 2-55-ыг үзүүлж, хэдийгээр майт хэмээгддэг байсан зоос маш жижигхэн, бас маш бага үнэтэй байсан хэдий ч, энэ зооснуудын эзэн эмэгтэй Тэнгэрлэг Эцэгийг хайрладгаа харуулахын тулд тэдгээрийг ашиглажээ. Марк 12:41–44 дэх түүхийг ярь.

Есүсийн үед аравны нэг болон өргөлүүдийг дээд талдаа задгай том савнуудад ариун сүмд хураадаг байсныг тайлбарла. (Зураг дээрх савыг зааж үзүүл.) Нэг өдөр хүмүүс ирж саванд мөнгөө хийхийг нь Есүс харж байв. Бэлэвсэн эмэгтэй мөнгөө хийхийг хараад Есүс шавь нараа дууджээ. Тэр эмэгтэй өөрт нь юу ч байхгүй байхад, Тэнгэрлэг Эцэгт хайртай учраас хангалттай ихийг өгч гавьяат үйл бүтээлээ гэж Тэр шавь нартаа хэлжээ.

Багшийн танилцуулга

Марк 12:43-т Есүс шавь нартаа юу гэж хэлснийг чанга унш. Бэлэвсэн эмэгтэй Тэнгэрлэг Эцэгт хайртай учраас зарим баян хүмүүсийн төлсөнтэй харьцуулахад өөртөө байгаа бүхнээ өгснийг Есүс мэдэж байсныг тайлбарла. Бид ч бас аравны нэгээ төлснөөр, бүр энэ нь маш бага хэмжээтэй байсан ч гэсэн, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайраа харуулж чадна.

Тоглоом худалдаж авахын оронд аравны нэгээ төлөхөөр сонгосноор Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайраа Марк хэрхэн харуулсныг хүүхдүүдэд сануул. Маркийн хувьд энэ нь хэцүү байсан боловч, тэр зөв сонголт хийсэндээ баяртай байлаа.

Дуу “Би Их Эзэндээ Аравны Нэгээ Өгөхийг Хүсч Байна” дууг хүүхдүүдээр дуулуулах буюу үгийг нь хэлүүл. Хүүхдүүд дууны үгийг сурахын тулд дууг хэдэн удаа давт.

Аравны нэгээ Их Эзэнд өргөхийг хүснэ би,
 Үүнийг төлөх бүртээ би
 Надад бас чамд түүний өгсөн
 Бүх тэр бэлгүүдийн талаар бодоход намайг хүргэдэг.

Тэр бидэнд амьдрал, энэ сайхан дэлхийг өгсөн.
 Миний аравны нэг өчүүхэн бага ч гэсэн,
 Бүхний Их Эзэн түүнд
 Миний итгэл талархлыг харуулдаг.

Бид аравны нэгээ төлснөөр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт хичнээн хайртайгаа харуулдаг гэдгийг хүүхдүүдэд сануул.

Бид Аравны Нэгээ Хэрхэн Төлдөг Вэ

Үйл ажиллагаа Есүсийг дэлхий дээр байх үед хүмүүс аравны нэг болон өргөлийн бусад мөнгөө ариун сүм доторх том савнуудад хийдэг байсныг хүүхдүүдэд сануул. Өнөөдөр бид аравны нэгээ бишопдоо (эсвэл салбарын ерөнхийлөгчид) юм уу түүний зөвлөхүүдийн нэгэнд төлдгийг тайлбарла.

Хүүхэд бүрт Аравны Нэгийн болон Бусад Өргөлүүдийн хуудас, аравны нэгийн дугтуй өг. Бид аравны нэгээ төлөх үед эдгээр хуудсууд, дугтуйнуудыг ашигладгийг тайлбарла. Энэ хуудсыг яаж бөглөдгийг хүүхдүүдэд харуул. Хэрэв хүүхдүүд сонирхвол хуудсан дээрх өргөлийн бусад төрлүүдийг товч тайлбарла. Бид мөнгө болон хуудсыг дугтуйнд хийж бишоптоо (эсвэл салбарын ерөнхийлөгчид) эсвэл түүний зөвлөхүүдийн нэгэнд өгдөгийг тайлбарла.

Дүгнэлт

Нэгтгэн дүгнэлт Арван зоосыг дахин үзүүл.

- Хэрэв та нар энэ арван зоосыг ажил хийж олсон бол, аравны нэгт хэдийг нь дугтуйнд хийх вэ?

Зохих тооны мөнгийг нэг хүүхдээр авахуулж, хуудсын хамт дугтуйнд хийлгэ.

- Аравны нэгийн дугтуйг бид яадаг вэ?

Гэрчлэл Бид аравны нэгээ төлснөөр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлах хайраа хэрхэн харуулдаг тухай гэрчлэлээ хэл.

Өөрсдийн олсон ямар ч мөнгөнөөс, хичнээн бага ч байсан хамаагүй аравны нэгийг төлж байхад хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Ариун сүмүүд болон цуглааны байрууд барих, номлолын ажил хийх болон хичээлийн гарын авлагууд хэвлэх зэрэг аравны нэгийн мөнгийг ашигладаг зарим зүйлийн талаар хүүхдүүдтэй ярилц. Эдгээр зүйлүүд бидний хувьд мөн бусад хүмүүст ямар ашиг тустайг ярилц.

Хүүхдүүдэд харандаа, цаас, будгийн харандаанууд өгч, өөрсдийнхөө ярилцсан зүйлүүдийн нэгнийх нь зургийг хүүхэд бүрээр зуруул.

2. “Би Аравны Нэгийг Төлөхдөө Баяртай Байна” (*Children’s Songbook*, х. 150) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Тэнгэрлэг Эцэг минь надад бүх сайн сайхан зүйлийг өгдөг:
Гэрэлтүүлэгч нарыг, ордог бороог, жиргэдэг болжморыг.

Бүх олсныхоо аравны нэгийг төлөхдөө баяртай байдаг би;
Бурхан надад өгсөн бүхний хариуд энэ нь өчүүхэн санагддаг.

Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгсөн аливаа бусад зарлигуудыг сахихад зөв хандлагатай байхын ач холбогдлын талаар ярилц.

3. Аравны нэгийн хайрцаг, лааз буюу дугтуйг хүүхэд бүрээр чимэглүүл.
Савуудыг өөрөө авчрах буюу өөрсдийнхөө савуудыг авчрахыг энэ хичээлээс долоо хоногийн өмнө хүүхдүүдээс хүсч тэдэнтэй холбоо барь.

Зорилго Бүр хэцүү байлаа ч гэсэн үнэнийг ярих хүүхэд бүрийн хүслийг хүчтэй болгох.

- Бэлтгэл**
1. Марк 14:53–65, Итгэлийн Тунхаг 1:13-ыг залбиралтайгаар судал. Түүнчлэн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 31-ийг үз.
 2. “Зөвийг Сонгодгоо Харуулахын Тулд” (“Хэрэв Чи Аз Жаргалтай,” дууны аяар дуулна, *Children’s Songbook*, х. 266) дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
 3. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Зөөлөн ундааны сав мэт хүүхдүүд эргүүлж болох лонх.
 - в. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - г. Зураг 2-56, Есүсийг Шүүсэн нь.
 4. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид үнэнийг ярьж чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Дараах түүхийг өөрийнхөө үгээр ярь:

Нэг өдөр Анн-Мари өвөөтэйгөө хамт загасанд явжээ. Анн-Мари цагийг сайхан өнгөрүүлсэн бөгөөд тэр загас барьсан үедээ бүр ч баяртай байлаа.

Анн-Мари гэртээ ирээд найз Даннитайгаа уулзахаар явлаа. Тэр түүнийг дотогш орохыг урьж, түүнийг галын өрөөнд оруулаад өөрийнхөө барьсан загасыг түүнд үзүүлэв. Даннигийн загас Анн-Марийн барьсан загаснаас илүү том байв.

Даннигийн төлөө Анн-Мари баяртай байсан боловч, түүнд бас гунигтай санагджээ. Даннигийн загастай харьцуулахад түүний загас тун жижигхэн байлаа. Түүнд ямар бодол төрснийг тэрээр Даннид мэдэгдэхийг хүссэнгүй, тиймээс тэр өвөөтэйгөө хамт загасанд явж, нэг маш том загас барьж, тэгээд түүнийг татаж гаргаж ирэхийн тулд загасны тор ашиглахаас аргагүй байсан тухай Даннид ярьжээ. Түүний загас Даннигийн загаснаас бүр ч том байсан гэж Анн-Мари Даннид ярьжээ.

Ярилцлага

- Анн-Мари ямар буруу юм хийсэн бэ?
- Анн-Мари яах ёстой байсан бэ?
- Үнэнийг хэлэх нь ямар утга учиртай вэ?

Үнэнийг ярина гэдэг нь шударга байхын нэг хэсэг гэдгийг тайлбарла. Бид юмсыг яг болсноор нь ярьж байвал бид үнэнийг ярьж байгаа нь тэр.

- Үнэнийг ярихын ач холбогдол юу вэ?

Үнэнийг ярьсан тохиолдлуудынх нь тухай та хүүхдүүдээр яриулж болно.

Итгэлийн Тунхаг

Итгэлийн Тунхаг нь сүмийн гишүүд юунд итгэдэг тухай нотолгоо юм гэдгийг хүүхдүүдэд сануул. “Шударга [бас] үнэнч байхад бид итгэдэг” гэсэн итгэлийн арван гуравдугаар тунхгийн хэсгийг хүүхдүүдэд хэлж өг. Энэ өгүүлбэрийг хүүхдүүдээр хэдэн удаа давтан хэлүүл.

Есүс Христ Үнэнийг Ярьдаг Байв

Судрын түүх

Есүсийг Шүүсэн нь, зураг 2-56-г үзүүл. Хичээлийн үлдсэн хэсэгт зургийг өлгөөтэй байлга. Есүс Христ үргэлж үнэнийг ярьдаг байсныг хүүхдүүдэд хэлж, Марк 14:53–65 дахь түүхийг ярь.

Иудейчүүдийн дээд санваартны гэрт Есүсийг цэргүүд аваачихад, Иудейчүүдийн удирдагчид түүнээс олон асуулт асуусан байдаг. Тэдгээр асуултуудын нэг “Чи Христ юм уу?” гэсэн асуултыг Марк 14:61-ээс чанга унш.

Хэрэв тэрээр Христ, Тэнгэрлэг Эцэгийн тусгай Хүү гэж хэлбэл, удирдагчид түүнийг явуулахгүй гэдгийг Есүс мэдэж байсныг тайлбарла. Марк 14:62-оос “Тэгээд Есүс, би мөн гэж хэлэв” гэж тэрээр дээд санваартанд хариулсныг чанга унш. Тэр ч байтугай, түүний амь нас аюулд ороод байсан үед ч Есүс үргэлж үнэнийг ярьдаг байсныг онцлон тэмдэглэ.

Үнэнийг хэлэх нь хэцүү байлаа ч гэсэн үргэлж үнэнийг хэлэхийг Есүс биднээс хүсдэгийг тайлбарла.

ЗС уриа

ЗС уриаг зааж, түүн дээрх үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Тэгээд дараа нь “Би Есүс Христийг дагаж, үнэнийг ярих болно” гэж өөрийнхөө араас хүүхдүүдээр давтан хэлүүл.

Дуу

“Зөвийг Сонгодгоо Харуулахын Тулд” дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд хүүхдүүдэд тусал.

Зөвийг сонгодгоо харуулахын тулд, үнэнийг ярьдаг би.

Зөвийг сонгодгоо харуулахын тулд, үнэнийг ярьдаг би.

Аврагчийн замыг мэднэ би.

Энэ нь юу хэлэхийг харуулдаг.

Зөвийг сонгодгоо харуулахын тулд, үнэнийг ярьдаг би.

Дууны үгийг сурахад нь хүүхдүүдэд туслахын тулд үгийг хэдэн удаа дуулах буюу хэл.

Энэ нь Бүр Амаргүй Байлаа ч Гэсэн Бид Үнэнийг Ярьж Чадна

Ярилцлага

Үнэнийг хэлэх нь үргэлж амар байдаггүйг онцлон тэмдэглэ. Зарим үед ямар нэг үнэн биш зүйлийг хэлэх буюу эсвэл юу ч хэлэхгүй байх нь бидний хувьд амар байдаг.

- Яагаад зарим үед үнэнийг хэлэхэд хэцүү байдаг вэ? (Хариултууд нь бид хүнийг уурлуулахыг хүсдэггүй, эсвэл бид шийтгэгдэж болох учраас гэхчлэн байж болно.)

Түүх

Үнэнийг хэлээгүйгээс болж харамссан хүүхдийн тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:

Жөү Анн санамсаргүйгээр ээжийнхээ үйлийн хайчийг эвдчихжээ. Тэр хайчийг шургуулганд нуусан учир хэн түүнийг эвдсэнийг ээж нь мэдсэнгүй. Жөү Аннын ээж хайчаа хайж, хайчийг харсан хүн байна уу гэж асуужээ. Жөү Анн хайчийг хараагүй гэж ээждээ хэлжээ.

Ингэж хэлсний дараа Жөү Аннд эвгүй санагджээ. Тэр гэртээ байх ёсгүй байсан үеэр хайчаар тоглож буруу юм хийснээ мэдэж байв, тэгээд одоо тэр энэ тухай худал хэлж хоёр дахь буруу зүйл хийсэн аж. Жөү Аннын бие муудав.

Жөү Анн гэр бүлийн залбиралд ирэхдээ нүдээ түргэн анив. Тэр ээжийгээ хармааргүй байлаа. Жөү Аннын аав залбиралдаа, “Бид оюун ухаандаа амар амгалан, үүрд баяр баясгалантай байж болохын тулд зөвийг хийх зоригийг бидэнд хайрлана уу” гэж хэлэхийг Жөү Анн сонсжээ. Тэр дахиад баяртай байхын тулд хайчны тухай үнэнийг ээждээ хэлэх хэрэгтэйг тэр мэдэж байв.

Жөү Анн эвдэрхий хайчийг ээждээ авчирч өгөөд үнэнээ түүнд хэлэв. Тэр хайчийг эвдэж, бас худал хэлсэндээ харамсаж, зөв зүйл хийхийг хүсч байлаа. (Margery Cannon, “A Miss and a Mistake,”-ээс хялбаршуулан авав, *Children's Friend*, 1962 оны Гуравдугаар сар, х.14.)

Ярилцлага

- Ээж нь эхний удаад хайчны тухай асуухад Жөү Анн үнэн хэлсэн үү?
- Үнэнийг хэлээгүй үед Жөү Аннд ямар санагдсан бэ?
- Ээждээ үнэнийг хэлсэн үед Жөү Аннд ямар санагдсан бэ?
- Үнэнийг хэлэх нь Жөү Аннад амархан байсан уу?

Хайч эвдсэний төлөө шийтгүүлж болно гэж айсан учир үнэнийг хэлэх нь Жөү Аннад хэцүү байсан хэдий ч, тэр үнэнийг хэлсэн үедээ илүү баяртай байсныг тайлбарла.

Тоглоом

“Үнэнийг Хэл” тоглоомыг хүүхдүүдтэй хамт тогло. Хүүхдүүдийг тойрог болгон суулгаж, тойргийн төвд шалан дээр лонх тавь. Та лонхыг эргүүлэхэд лонхны ам чиглэн зогссон хүүхэд үнэнийг хэлэх тухай асуултад хариулна. Хариулсны дараа тэр хүүхэд шилийг эргүүлж дараагийн хүнийг сонгоно (Хэрэв лонхны ам аль хэдийн хариулчихсан хүүхэд рүү харж зогсвол, тэр хүүхэд лонхыг дахин эргүүлнэ.)

Дараах нөхцөлүүд болон тоглоомын асуултуудыг ашиглах буюу эсвэл танай ангийн хүүхдүүдэд илүү тохирох зарим нөхцөлүүдийг зохио (хэрэв танай анги олон хүүхэдтэй бол илүү олон нөхцөлийг та нэмж болно):

1. Чи гэртээ тоглож байгаад санамсаргүйгээр чийдэнгийн шил хагалчихжээ.
 - Чи яах ёстой вэ?
2. Аав чинь чамайг дэлгүүр лүү хурдхан явж, түүнд хэрэгтэй нэг юм худалдаж авчрахыг хүсчээ. Замдаа зогсож, тоглож болохгүй гэж аав чинь чамаас хүсчээ. Хөршийнхөө байшингийн дэргэдүүр өнгөрч явтал, тэр шууданд хийгээрэй гэж хэдэн захидал өгөв. Дэлгүүрээс гэр лүүгээ ирж явах замдаа чи найзынхаа шинэ дугуйг харахаар зогсчээ. Аав чинь цухалдаж, тэгээд чи хөршийнхөө захидлуудыг шууданд хүргэж өгөөд хожимдлоо гэж аавдаа хэлье гэж боджээ.
 - Чи юу гэж хэлэх ёстой вэ?

3. Ширээн дээр жигнэмэгтэй таваг байхыг чи харжээ. Жигнэмэг тун сайхан харагдаж байсан учир чи нэгийг өөртөө, нэгийг жаахан дүүдээ авчээ. Ээж чинь жигнэмгүүдийг найз руугаа авч явахаар ирээд дүүг чинь жигнэмэг идэж байгааг хараад түүнийг загнаж эхлэв.
 - Чи яах ёстой вэ?
4. Чи жаахан эмэгтэй дүү нарынхаа тоглоомуудаас нэгийг нь аваад явтал тэр уйлж эхлэв. Чи эмээгээ ирж явахыг сонсоод, тоглоомыг хурдан буцааж өгсөн хэдий ч, жаахан дүү чинь уйлахаа болихгүй байв. Дүү чинь яагаад уйлсныг эмээ чинь чамаас асуув.
 - Чи юу гэж хэлэх ёстой вэ?
5. Хөршийнхөө байшингийн өмнө чи найз нартайгаа бөмбөг тоглож байв. Чи бөмбөгийг өшиглөтөл, бөмбөг хөршийн чинь байшингийн хаалганы дэргэдэх цэцгийн савыг онож хагалчихав.
 - Чи яах ёстой вэ?

Дүгнэлт

Гэрчлэл

Үнэнч байх нь хэцүү тохиолдолд ч гэсэн, үүний ач холбогдлын талаар гэрчлэлээ хуваалц. Есүс Христ үргэлж үнэнийг ярьдаг байсныг, бас тэрээр үргэлж үнэнийг ярихыг биднээс хүсдэгийг хүүхдүүдэд сануул. Хэдийгээр энэ нь таны хувьд нилээд хэцүү байсан ч гэсэн, үнэнийг хэлсэндээ баяртай байсан үеийнхээ тухай та ярьж болно.

Тэд ямагт зөвийг сонгохоор хичээх ёстой гэдгийг хүүхдүүдэд сануул. Тэд үнэнийг ярьж байгаа нь тэд зөвийг сонгож байгаа хэрэг юм.

Хүүхдийн Хэсэгт өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар гэрийнхэндээ ярихад нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Энэ нь амархан биш байлаа ч гэсэн, үнэнийг ярихад нь ангийн гишүүн бүрт туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг тэр хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Зөвийг Хийхэд Зоригтой Бай” (*Children’s Songbook*, х. 158), “Зөв Замыг Сонго” (*Children’s Songbook*, х. 160), эсвэл “Шударга Байхад Би Итгэдэг” (*Children’s Songbook*, х. 149) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэл. “Зөвийг Хийхэд Зоригтой Бай,” “Зөв Замыг Сонго” дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.

Шударга Байхад Би Итгэдэг

Шударга байхад итгэдэг би;

Үнэнч байхад итгэдэг би,

Хэлдэг бүхэндээ, хийдэг бүхэндээ би

Шударга байхыг өөрөөсөө эхэлдэг би

Үгэндээ хүрдэг, үнэнийг хэлдэг
 Сайн дадлуудыг багадаа хэвшүүлнэ би,
 Зөвийг хамгаалахад үгээ хэлэхийн тулд
 Нэрээ бодож, гэрэл гэгээтэйг эрхэмлэнэ.

Шударга байхад итгэдэг би;
 Үнэнч байхад итгэдэг би,
 Хэлдэг бүхэндээ, хийдэг бүхэндээ би
 Шударга байхыг өөрөөсөө эхэлдэг би

2. Ангийн өмнө гарч ирэн хоёр гараа өргөхийг нэг хүүхдээс хүс. Тэр хүүхдийн шуунаас хэсэг утас сулхан уяж, түүнээс сайн барь. Утас нь бяцхан худал хэлэхтэй адил юм гэдгийг тайлбарла. Үүнээс чөлөөлөгдөхийг тэр хүүхдээс хүс (хүүхэд тайлагдаж болохоор утсыг сулхан өргө).

Дараа нь тэр хүүхдийн бугуйг арваад удаа ороож, бид худал хэлснээ нууцыг хичээхийн хэрээр нэг худал зүйл улам олон өөр худал зүйл уруу хөтөлдгийг та тайлбарла. Бид худал хэлсэн тохиолдолд худал хэлснийг нь хүмүүс мэдэхээс болгоомжилж дахиад олон худал хэлэхэд хүрэх нь олон-таа тохиолддог. Бид олон удаа худал хэлсэн тохиолдолд өөрсдийгөө худал хуурмагаас чөлөөлөхөд нэн бэрхтэй болдог. Одоо нөгөө хүүхдээс чөлөөлөгдөхийг хүс. Хэрэв тэр хүүхэд олон давхар утаснаас чөлөөлөгдөж чадвал та улам олон давхар утсаар түүнийг хэр. Бид хичнээн их худал хэлнэ, зөвийг сонгох болон үнэнийг хэлэх нь улам хэцүү болно.



- Эдгээр худал хуурмаг зүйлүүдээс чи хэрхэн чөлөөлөгдөж чадах вэ?

Хүүхдийн гарыг хэрсэн утаснаас чөлөөлөхийн тулд утсыг хайчаар хайчил. Худал хуурмагаас чөлөөлөгдөхийн тулд бид үргэлж үнэнийг ярих ёстойг тайлбарла. Хэрэв бид нэгэнт худал хэлчихсэн бол, худал хэлсэн тэр хүндээ үнэнийг хэлэх замаар наманчлах ёстой. Бид үнэнийг хэлсэн үед баяртай байж чадна.



3. Хичээлийн төгсгөл дэх “нууц зурвасыг” хүүхэд бүрт хувилан бэлтгэ. Хүүхэд бүрт зурвасын нэг хувийг, харандааны хамт өг. Есүс Христийн заадаг зүйлүүдийн нэг нь энэ нууц зурваст байгааг тайлбарла. Бэлэгдэл бүрийн дагуух үсгийг олж, бэлэгдлийн доорх хайрцганд бичих замаар нууц зурвасыг хүүхдүүд нууц зурвасыг тайлж чадна гэдгийг тэдэнд хэл. Жишээ болгон нэг үсгэнд бичиж, шаардлагатай бол хүүхдүүдэд тусал.

Нууц зурвас юу болохыг мэдсэн үедээ гараа хумхиж, инээмсэглэхийг хүүхдүүдээс хүс. Бүх хүүхэд зурвасыг мэдэхэд, нууц зурвас дээрх “Үнэнийг хэл” үгсийг өөрийнхөө хамт хүүхдүүдээр уншуул.

4. Нөхцөл бүр дэх зөв сонголтыг харуулан, хичээл дэх “ҮНЭНИЙГ ХЭЛ” тоглоомын нөхцөлүүдийн заримыг нь хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул.



† → й N → э ñ → ү ★ → х
♥ → г / → и O → н ◉ → л



† → й N → э ñ → ү ★ → х
♥ → г / → и O → н ◉ → л

Зорилго

Тэнгэрлэг Эцэг бидний хүн болгонд авьяас өгсөн гэдгийг танин мэдэхэд нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 25:14–29-ийг залбиралтайгаар судал. Түүнчлэн *Gospel Principles* (31110), бүлэг 34-ийг үз.
2. Долоо хоногийн турш хүүхэд бүрийн эцэг эхтэй холбоо барьж, хүүхдүүдэд нь ямар авьяас илэрснийг тэднээс асуу. Хэрэв шаардлагатай бол, эелдэг, хөгжилтэй, дуулгавартай, тусч, уучламтгай, нөхөрсөг буюу залбирамтгай байх зэрэг нэн бага ажиглагддаг зарим авьяасын талаар саналаа хэлж болно. Хүүхэд бүрийн авьяасын жагсаалт хий. Уг жагсаалт дээр өөрийн ажигласан авьяасуудыг нэм.
3. Өөрийн жагсаалтыг ашиглан хүүхэд болгонд дараахтай төстэй цаас бэлтгэ. Хүүхдийн нэрийг цаасан дээр бич. Цаасыг дундуур нь нугал. Хүүхдийн авьяасны жагсаалтын нэг талыг хичээлийн үеэр та нар хэлэлцэх болно. Цаасны нөгөө талыг үлдээ.

<p>(Хүүхдийн нэр) Миний авьяасын талаар надаас асуу:</p> <ol style="list-style-type: none">1.2.3.4.5.	
---	--

Хүүхэд бүрийн цаас авьяасын адил тоотой жагсаалттай байхад анхаарах түүнчлэн дуулах, дээс тоглох буюу унших зэрэг хамгийн наад тал нь нэг авьяас хүүхэд бүрийн жагсаалтад байхад анхаар.

4. Өөрийнхөө авьяасуудын нэгийг үзүүлэхэд бэлтгэх буюу эсвэл өөрийн чинь авьяасуудын нэгийг төлөөлөх нэг зүйлийг авчир.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Будгийн харандаанууд эсвэл харандаанууд.
 - в. Зураг 2-57, Хибер Ж.Грант.
6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Авьяас Бол Тэнгэрлэг Эцэгийн Бэлэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Өөрийн нэг авьяасыг үзүүл эсвэл өөрийн авчирсан зүйлийг үзүүлж, энэ зүйл таны нэг авьяасыг төлөөлж байгааг тайлбарла.

- Авьяас гэж юу вэ?

Хэрэв та ямар нэг зүйл авчирсан бол, түүнийхээ тухай ярьж, яагаад энэ нь авьяасыг чинь төлөөлж байгааг болон яагаад танд чухал болохыг тайлбарла. Хэрэв та авьяасаа үзүүлсэн бол, энэ авьяасаа ашиглах нь яагаад танд таалагддагийг тайлбарла.

Тэнгэрлэг Эцэг өөрийн хүүхэд болгонд авьяасууд өгснийг тайлбарла. Дуулах, хөгжмийн зэмсэг тоглох буюу бусдыг баяртай байхад нь тусалдаг зэрэг хүүхдүүдийн мэдэх авьяастай өөрийн хэсэг буюу салбар дахь зарим хүмүүсийг дурд.

Хүүхэд бүр Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд, иймээс тэднээс хүн нэг бүр нь мөн авьяасуудтай байдгийг хүүхдүүдэд сануул. Хүн бүр өөр өөр авьяастай байдгийг тайлбарла.

Бидний Хүн Бүр Олон Янзын Авьяастай Байдаг

Түүх ба
ярилцлага

Өөртөө авьяас байгааг илрүүлсэн нэг хүүхдийн тухай дараах түүхийг өөрийн үгээр ярь:

Эгч Шелли нь гэрийнхээ ар дахь уулсын зургийг сайхан зурж байхыг Венди харжээ. Шелли шиг сайхан зурж чаддаггүйдээ Вендигийн урам хугарчээ. Шелли бас төгөлдөр хуур тоглодог, хичээлдээ онцгой сайн байлаа. Шеллигийн сайн хийж чаддаг бүх зүйлийн талаар Венди бодож үзлээ. Тэр өөрөө эдгээр зүйлүүдийг яагаад сайн хийж чаддаггүйдээ гайхжээ.

- Шеллийн бүх авьяасын талаар бодоход Вендид ямар санагдсан гэж та нар бодож байна?

Нэг өдөр Вендигийн багш түүнийг Хүүхдийн Хэсэгт үг хэлэхийг хүсчээ. Тэр үгэн дээрээ шаргуу ажилласнаар сайн үг хэлжээ. Бишоп Вендигийн үгийг сонсож, түүний үг их таалагдсан тухай түүнд ярьжээ. Венди маш их авьяастай юм байна гэж тэр түүнд хэлэв.

Вендид сайхан дулаан мэдрэмж төрсөн аж. Өөрийнхөө тухай ямар нэг чухал зүйл нээж мэдэхэд нь бишопын үгс Вендид тусалсан аж.

- Юуг мэдэхэд нь бишоп Вендид тусалсан бэ? (Сайн үг хэлэх авьяас түүнд байжээ.)

Вендид өөр бусад авьяасууд байгааг тэр удалгүй мэджээ. Тэр амархан найз нөхөд болдог байв, иймээс бусад хүүхдүүд түүнтэй хамт байхыг үргэлж хүсдэг байлаа. Тэр унших, бичих дуртай байв. Тэр сүмд ирсэн үедээ хүндэтгэлтэй байж, багшийнхаа үгийг сонсдог байлаа. Венди эдгээр зүйлүүдийг авьяас гэж хэзээ ч боддоггүй байв, учир нь эдгээр нь Шеллийн авьяасуудтай адилгүй байв. Одоо өөрт нь авьяасууд байгааг Венди олж мэдсэн хэдий ч, түүний авьяасууд эгчийнхээс нь өөр байлаа.

- Вендид ямар авьяасууд байсан бэ?

Хүн бүр өөр авьяастай байдаг, гэвч бүх авьяас адилхан чухал гэдгийг хүүхдүүдэд онцгойлон заа.

Үйл ажиллагаа

Хүүхдийн Хэсэг дэх хүмүүсийн олон өөр авьяасын тухай тэд мэдэж авах болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Авьяасын жагсаалт бүрийг өөрөө унших үеэр анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Хэнийг дүрсэлж байгааг хүүхдүүд мэдсэн үедээ тэд ямар нэг юмыг чангаар хэлэхгүй, харин гараа өргөх ёстойг хүүхдүүдэд хэл.

“Эдгээр авьяасууд байдаг хүний тухай би бодож байна” гэж эхлээд та хүүхэд бүрийн хувьд бэлтгэсэн авьяасын жагсаалтыг унш.

Та жагсаалт бүрийг уншиж дууссаны дараа, хэнийг дүрсэлснийг хүүхдүүдээр таалга. Хэрэв хүүхдүүд зөв тааж чадаагүй бол, тэр хүүхдийн өмссөн хувцас буюу тэр хүүхэд хөвгүүн үү, охин уу гэхчлэн зарим тодорхой түлхүүрүүдийг өг.

Авьяасаа үзүүлэх нь

Эдгээр авьяасуудыг Тэнгэрлэг Эцэг тэдэнд өгснийг хүүхдүүдэд сануул. Өөрийнхөө жагсаалтаас тус бүр нэг авьяасыг үзүүлэхийг хүүхэд бүрээс хүс. (Хүүхэд бүрийн авьяаснаас ангид хялбархан үзүүлж болох, дуртай дуугаа дуулах, унших, дээс тоглох, үсрэх зэрэг аль авьяасыг хялбархан үзүүлж болохыг урьдаас тогтоосон бай.)

Авьяасуудаа Ашиглахыг Есүс Христ Бидэнд Заадаг Байв

Судрын түүх

Бид авьяасуудаа ашиглах ёстой гэж Есүс Христ заасныг хүүхдүүдэд хэл. Матай 25:14–29-д байдаг түүхийг товч ярь. Энэ амьдралын дараа түүнтэй болон Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахын тулд юу хийх ёстойг ойлгоход нь шавь нартаа туслахын тулд Есүс Христ энэ түүхийг тэдэнд ярьсныг тайлбарла.

Та түүхийг ярихдаа дараах зүйлүүд дээр онцгойлон анхаар:

1. Есүсийн үед талант буюу авьяас гэдэг мөнгөний нэгж байв.
2. Таван талант авсан зарц мөнгийг ухаалгаар ашиглаж, удалгүй дахиад таван талант олов.
3. Хоёр талант авсан зарц мөнгийг ухаалгаар ашиглаж, удалгүй дахиад хоёр талант олов.
4. Нэг талант авсан зарц мөнгийг нууж, үүнийг огт ашигласангүй.
5. Зарц нарын эзэн эргэж ирээд, өөрсдөд нь өгсөн талантаар юу хийснийг тэднээс асуужээ.

Таван талант авч, дахиад таван талант олсон зарцад эзэн нь юу гэж хэлснийг Матай 25:21-ээс чанга унш.

Хоёр талант авч дахиад хоёрыг олсон зарцад эзэн нь мөн адил зүйл хэлснийг тайлбарла. Өөрсдийн авьяасыг ухаалгаар ашигласан энэ хоёр зарцад эзэн нь баяртай байв.

Гурав дахь зарц өөрийн авьяасыг ашиглаагүй учир талантыг түүнээс буцаан авч авьяас нь түүнд огт байхгүй байх болно гэж эзэн нь түүнд хэлснийг тайлбарла (Матай 25:26–29-ийг үз).

Бид сургаалт зүйрлэл дэх эхний хоёр зарц шиг байх ёстой гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Хэдийгээр бид *авьяас* гэдэг үгийг энэ тохиолдолд мөнгөнд холбогдох зүйлүүдэд хэрэглэсэн ч гэсэн бид авьяасаа ухаалгаар ашиглах ёстой.

Бид бүгд Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдийн хувьд энэ дэлхий дээр ашиглаж, хөгжүүлэхийн тулд тусгай авьяас буюу бэлгийг хүлээж авсан байдаг. Бид авьяасаа хөгжүүлэхэд өөрсдийгөө болоод бусдыг баяртай болгодог. Дээрх түүхэн дэх эзэн шиг Тэнгэрлэг Эцэг мөн адил өөрсдийн авьяасыг нууж, улмаар түүнийг алдахыг биднээс хүсдэггүй. Бидний авьяас өсч хөгжиж байхын тулд тэдгээрийг ашиглаж байхыг Тэрээр биднээс хүсдэг. Ингэсэн тохиолдолд бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой дахин хамт амьдрахаар бэлтгэгдэж чадна.

Дадлага Хийж Бид Авьяасаа Хөгжүүлдэг

Хибер Ж.Грант, зураг 2-57-г үзүүл. Хожим нь Сүмийн бошиглогч бөгөөд Ерөнхийлөгч болсон Хибер Ж.Грантын тухай, түүнчлэн авьяасаа хөгжүүлэхийн тулд тэр юу хийдэг байсан тухай түүхийг ярих гэж байгаагаа тайлбарла.

Хибер Ж.Грант хөвгүүн байхдаа бөмбөг тоглохыг хүсдэг байжээ. Гэвч тэр бөмбөгийг их хол шидэж чаддаггүй байв. Түүнийг бөмбөг шидэх гэж оролдоход бусад хөвгүүд түүнийг шоолдог байжээ.

Аварга шалгаруулах тэмцээнд тоглуулахаар түүнийг сонгож авахаар бөмбөгийг тийм сайн тоглож сурахаар тэр шийдсэн аж. Амбаарын нэг талаас бөмбөг шидэх дадлагыг тэр өдөр бүр хийдэг байв. Зарим үед түүний гар шөнө унтаж чадахгүй болтол өвддөг байлаа. Гэвч тэр дадлага хийсээр л байлаа. Хэдхэн жилийн дараа, Хибер аваргын тэмцээнд ялсан багт тогложээ.

- Хибер ямар авьяастай болохыг хүсдэг байсан бэ?
- Энэ авьяасаа хөгжүүлэхийн тулд Хибер юу хийсэн бэ?
- Хибер бөмбөг тоглох дасгал хийснээр юу тохиолдсон бэ?

Амьдралынхаа хожуу үед Хибер банкинд данс хөтлөгчөөр ажиллахыг хүсчээ. Гэвч данс хөтлөгчийн бичгийн хэв цэвэрхэн, гаргац сайтай байх ёстой байлаа. “Чиний бичгийн хэв шувууны мөр шиг юм” гэж Хиберийн найз нарынх нь нэг нь хэлэхэд, нөгөөх нь “Бэхний саван дээр аянга ниргэсэн юм шиг” гэжээ.

Бичгийнхээ хэвийг сайжруулах дадлагыг тэр олон цагаар хийдэг байлаа. Хэдэн жилийн дараа тэр муж улсдаа хамгийн сайхан бичгийн хэвэнд олгодог шагнал хүлээн авсан ажээ. Тэрээр бас бичгийн хэв болон данс хөтлөлтийг их сургуульд заадаг байв.

- Хибер ямар авьяастай болохыг хүсдэг байсан бэ?
- Энэ авьяасаа хөгжүүлэхийн тулд Хибер юу хийсэн бэ?
- Бичгийн хэвээ сайжруулах дадлага хийснээр юу тохиолдсон бэ?

Хиберыг бага байхад ээж нь түүнийг дуулж сураасай гэж хүсдэг байж. Тэр аравтай байхдаа дууны ангид оров. Багш нь Хиберийг дуулж сургах гэж оролдсон боловч эцэст нь орхиж, тэр дахиад сурах гэсний хэрэггүй гэж Хиберт хэлсэн аж. Хэдэн жилийн дараа Хибер дуу заадаг байсан найзтайгаа ярилцжээ. Хибер хэдэн дуулал дуулж чаддаг болох хүсэлтэйгээ найздаа дурджээ. Энэ нь их цаг хугацаа хүч чармайлт шаардах хэдий ч, тэр үүнийг хийж чадна гэж найз нь түүнд ярьсан аж. Хибер маш их дадлага

хийх хүсэлтэй байсан бөгөөд сүмийн дуоллуудыг дуулж сурчээ. (Bryant S. Hinckley, *Heber J. Grant: Highlights in the Life of a Great Leader* [Salt Lake City: Deseret Book Co., 1951], pp. 37–42, 45–49-ийг үз.)

- Хибер ямар авьяастай болохыг хүссэн бэ?
- Бөмбөг тоглож сурах, бичгийнхээ хэвийг сайжруулах болон дуулж сурахын тулд Хибер юу хийсэн бэ?

Хиберийн нэгэн адилаар дадлага хийх юм бол бид авьяасаа хөгжүүлнэ гэдгийг хүүхдүүдэд тайлбарлаж өг. Бид ямар нэг зүйлийг хичнээн ихээр хийнэв, үүнд төдийчинээ сайжирдаг. Хибер авьяасаа ашиглах дадлагыг дахин дахин хийдэг байв, ингэснээр тэд эдгээр зүйлүүдэд илүү сайжирсан юм. Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгсөн авьяасуудыг ашиглахын тулд бид дадлага хийхэд Тэрээр баярладаг билээ.

Дүгнэлт

Үйл ажиллагаа

Хичээлийн эхэн үеэр ярилцсан хүүхэд бүрийн өвөрмөц авьяасуудыг нэгтгэн дүгнэ. Хүүхдүүдэд тэдний авьяасын жагсаалтыг харандаа буюу будгийн харандаануудтай хамт өг. Цаасны хажуу тал дээр өөрсдийнх нь авьяасууд буюу ямар авьяастай болохыг хүсдэг тухай зургуудыг хүүхдүүдээр зуруул.

Зургуудынх нь талаар хүүхдүүдээр бие биенд нь яриулж, авьяас өсч хөгждөгийг дүрслэхэд хэрхэн тэд тусалж болох тухай ярилц.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг бид бүгдэд өөр өөр авьяас өгсөн тухай гэрчлэлээ хэл. Есүс Христ, Тэнгэрлэг Эцэг хоёр авьяасаа ашиглахыг биднээс хүсдэгийг хүүхдүүдэд сануул. Бид авьяасаа ашигласнаар өөрсдийгөө болон бусад хүмүүсийг баяртай болгож чадахын хамт авьяас чадвараа өсч хөгжихөд нь тусалдаг.

Хүүхэд бүрийн жагсаалтын дээд хэсэг дэх: “Миний авьяасын талаар надаас асуу” гэсэн үгсийг чанга унших буюу хүүхдүүдээр уншуул. Өөрсдийн жагсаалтыг гэрийнхэндээ үзүүлж, авьяасынхаа талаар юу мэдсэнээ гэрийнхэндээ ярихад нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Ангийн гишүүн бүрийн авьяасын төлөө Тэнгэрлэг Эцэгт талархаж, авьяасуудаа сайн ашиглахад нь хүүхдүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг тэр хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хүүхдүүдийг тойрог болгон суулга. Тойргоор суусан хүүхдүүдэд даавуун бөмбөг буюу өөр зөөлөн зүйлийг шидэж дамжуулах үед ямар нэг хөгжмийн бичлэгийн аяар аялах буюу дуулж, эсвэл тогло. Хөгжим зогсоход, даавуун бөмбөгийг барьж авсан хүүхэд тойргийн голд зогсож, нэг авьяасаа үзүүлнэ. Авьяасууд нь яруу найргаас цээжээр унших, дуу дуулах, судраас иш татах, өрөөсөн хөл дээрээ үсрэх, эсвэл самбар дээр энгийн зураг зурах зэрэг байж болно. Эелдэг найрсаг байх болон бөмбөг өшиглөх зэрэг ангид хийж үзүүлэх боломжгүй авьяасуудыг хүүхдүүд нүүр буюу биеийн хөдөлгөөнөөр харуулж болно. Хүүхэд бүр авьяасаа үзүүлсний дараа зөөлхөн алга ташихыг хүүхдүүдээс хүс.

Хүүхэд бүр наад тал нь нэг авьяас үзүүлэх хүртэл тоглоомыг үргэлжлүүл.


2. Хүүхэд бүрт будгийн харандаанууд, та өөрөө дээр нь од зурсан цаасыг өг. (Одны загварыг хичээлийн төгсөлөөс үзэж болно). Өөрсдийнхөө одыг ер бусын байдалтайгаар будахыг хүүхдүүдээс хүс. Бүх хүүхдүүдийг будаж дуусахад однуудаа үзүүлж, “Од Бүр Өөр” (*Children’s Songbook*, х. 142) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлүүл.

Од бүр өөр,
Хүүхэд бүр ч бас адил.
Зарим нь гэрэлтэй, аз жаргалтай
Зарим нь номхон, дөлгөөн.
Хийж чадах зүйлээ
Хүн бүр хийх хэрэгтэй.
Чи бол зөвхөн ийм л байж чадах
Тэрхүү хүн мөн билээ.

(© 1980 by K. Newell Dayley. Зөвшөөрлөөр ашиглана.).

Яг өөрсдийнхөө оддын адил хүүхдүүд бас бүгд өөр өөр юм, учир нь тэд өөр өөр авьяас чадвартай байдгийг ойлгоход нь тэдэнд тусал. Авьяасууд бол Тэнгэрлэг Эцэгийн адислалууд гэдгийг хүүхдүүдэд сануул.

3. Дуу удирдах буюу гар урлалын зүйл хийх зэрэг авьяас болон хувирч болох энгийн ур чадварыг хүүхдүүдэд зааж өг.




Би Зөвийг Сонгосон Үедээ Ухаалаг Байдаг

Зорилго

Бид Есүс Христийн заадаг зүйлүүдийг дуулгавартай дагасан үед ухаалаг болдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 7:24–27-г залбиралтайгаар судал.
2. Доор харуулсны дагуу нугалсан цаас ашиглан хоёр тэмдэг бэлтгэ:



3. “Ухаалаг Хүн ба Тэнэг Хүн” (*Children’s Songbook*, х. 281), “Зөв Замыг Сонго” (*Children’s Songbook*, х. 160) дуунуудыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. “Зөв Замыг Сонго” дууны үг гарын авлагын ар талд байгаа.
4. Жижигхэн цаасан дээр зарим ухаалаг үйл ажиллагаа, мөн зарим тэнэг үйл ажиллагаа бич. Доорх үйлдлүүдийг ашигла, мөн өөрийнхөө ангид тохирох өөр зарим үйлдлийг нэм. Цааснуудыг жижиг хайрцаг, аяга буюу цүнхэнд хий.

Залбирлуудаа хэл.
Эцэг эхийнхээ үгэнд ор.
Хүүхдийн Хэсэгт хүндэтгэлтэй бай.
Бусдад эелдэг ханд.
Үнэнийг ярь.
Хуваалц.

Хэрэлд.
Хараалын үг хэл.
Амин хувиа хичээ.
Худал хэл.
Найрсаг бус бай.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Малгай, хос бээлий, хос гутал (эсвэл танай ангийн хүүхдүүдийн өмсч болох гурван төрлийн өөр хувцас).
 - в. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Ухаалаг Шийдвэр Гаргаж Чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Бээлий, малгай, гутлыг үзүүл (хэрэв та бусад хувцас ашиглаж байгаа бол шаардлагатай байдлаар энэ үйл ажиллагааг тохируул). Бээлийг толгой дээрээ тавь.

- Бээлийг бид юундаа өмсөх ёстой вэ? Яагаад?
- Бээлийг бид юунд ашиглах ёстой вэ?

Бээлийг толгой дээрээ өмсвөл тэнэг явдал болно, учир нь бээлий чиний гарыг хамгаалж чадахгүйг онцлон тэмдэглэ.

Бээлийг өмсөх зөв арга замыг харуулахаар нэг хүүхдийг урь.

Малгайг нэг хөл дээрээ тавь.

- Малгайг бид юундаа өмсөх ёстой вэ? Яагаад?
- Малгайг бид юунд ашиглах ёстой вэ?

Малгайг хөл дээрээ өмсвөл тэнэг явдал болно, учир нь малгай чиний толгойг хамгаалж чадахгүйг онцлон тэмдэглэ.

Малгайг зөв өмсөх зөв арга замыг харуулахаар нэг хүүхдийг урь.

Гутлыг гартаа өмс.

- Гутлыг бид юундаа өмсөх ёстой вэ? Яагаад?
- Гутлыг бид юунд ашиглах ёстой вэ?

Гутлыг гар дээрээ өмсвөл тэнэг явдал болно, учир нь гутал чиний хөлийг хамгаалж чадахгүйг онцлон тэмдэглэ.

Гутлыг өмсөх зөв арга замыг харуулахаар өөр нэг хүүхдийг урь.

Бээлий, малгай, буюу гутлыг биеийнхээ буруу эрхтэнд өмсөх хүн ганц нэг хэн байж мэдэх юм гэдгийг тэмдэглэн хэл. Гэвч юу өмсөх вэ гэдэг сонголт мөн ухаалаг буюу эсвэл тэнэг байж болно. Янз бүрийн хувцсыг хэзээ ухаалгаар буюу тэнэг байдлаар өмсөж болохыг хүүхдүүдтэй хамт ярилц (жишээ нь, цаг агаар хүйтэн байхад гадаа бээлий өмсөх нь ухаалаг байхад усанд орохдоо гуталтай байвал тэнэг хэрэг болно).

Бид өдөр бүр олон сонголт хийдгийг тайлбарла. Тэнэг сонголтууд бидэнд хор хөнөөлтэй бөгөөд биднийг баяр хөөргүй болгодог. Ухаалаг сонголтууд биднийг аюулгүй, баяр хөөртэй байлгадаг.

Ухаалаг Байж, Түүний Заадаг Зүйлүүдийг Дуулгавартай Дагахыг Есүс Христ Биднээс Хүсдэг

Судрын түүх

Есүс Христ хүмүүст заахын тулд сургаалт зүйрлэл гэж нэрлэгддэг түүхүүдийг олонтаа ашигладаг байсныг тайлбарла. Тэнэг шийдвэр гаргасан нэг хүний тухай мөн ухаалаг шийдвэр гаргасан нэг хүний тухай нэг сургаалт зүйрлэлийг Тэр ярьдаг байжээ. Та энэ сургаалт зүйрлэлийг Библиэс уншиж өгөх гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Матай 7:24–27-г чанга унш.

Ярилцлага

- Элсэн дээр байшингаа барьсан хүн шуурга түүний байшинг нураахад ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Хадан дээр байшингаа барьсан хүн шуурга түүний байшинг гэмтээлгүй өнгөрөхөд ямар санагдсан гэж та нар бодож байна?

Есүс биднийг энэ сургаалт зүйрлэл дэх хүмүүстэй харьцуулсныг тайлбарла. Хэрэв бид Есүсийн заадаг зүйлүүдийг дагах юм бол бид байшингаа хадан дээр барьсан ухаалаг хүнтэй адилхан юм. Хэрэв бид Есүсийн заадаг зүйлүүдийг дагахгүй бол бид байшингаа элсэн дээр барьсан хүнтэй адил юм. Ингэвэл бид аз жаргалгүй байх болно.

Дуу

Доор харуулсан үйлдлүүдийг ашиглан, “The Wise Man and the Foolish Man” дууг дуулах буюу үгийг хэлэхэд нь ангид тусал.

Ухаалаг хүн байшингаа хадан дээр барив (*Баруун гарынхаа нударгыг зүүн гарынхаа алган дээр бөх батаар суулга*)

Ухаалаг хүн байшингаа хадан дээр барив (*Баруун гарынхаа нударгыг зүүн гарынхаа алган дээр бөх батаар суулга*)

Ухаалаг хүн байшингаа хадан дээр барив (*Баруун гарынхаа нударгыг зүүн гарынхаа алган дээр бөх батаар суулга*)

Тэгтэл аянга нижигнэн бороо цутгав (*хоёр гараа дээш өргөнө; дараа нь хуруунуудаа дэвэн доош буулгана*)

Бороо цутган орж, үер буув (*гараа дахин доошлуулна; дараа нь алгаа дээш нь харуулан хоёр гараа дээш нь өргөнө*)

Бороо цутган орж, үер буув (*гараа дахин доошлуулна; дараа нь алгаа дээш нь харуулан хоёр гараа дээш нь өргөнө*)

Бороо цутган орж, үер буув (*гараа дахин доошлуулна; дараа нь алгаа дээш нь харуулан хоёр гараа дээш нь өргөнө*)

Хадан дээрх байшин байсаар байв (*Баруун гарынхаа нударгыг зүүн гарынхаа алган дээр бөх батаар суулга*)

Тэнэг хүн байшингаа элсэн дээр барив (*хуруунуудаа хөдөлгөн, биеийнхээ өвөр талд гараа хойш урагш хөдөлгөнө*)

Тэнэг хүн байшингаа элсэн дээр барив (*хуруунуудаа хөдөлгөн, биеийнхээ өвөр талд гараа хойш урагш хөдөлгөнө*)

Тэнэг хүн байшингаа элсэн дээр барив (*хуруунуудаа хөдөлгөн, биеийнхээ өвөр талд гараа хойш урагш хөдөлгөнө*)

Тэгтэл аянга нижигнэн бороо цутгав (*хоёр гараа дээш өргөнө; дараа нь хуруунуудаа дэвэн доош буулгана*)

Бороо цутган орж, үер буув (*гараа дахин доошлуулна; дараа нь алгаа дээш нь харуулан хоёр гараа дээш нь өргөнө*)

Бороо цутган орж, үер буув (*гараа дахин доошлуулна; дараа нь алгаа дээш нь харуулан хоёр гараа дээш нь өргөнө*)

Бороо цутган орж, үер буув (*гараа дахин доошлуулна; дараа нь алгаа дээш нь харуулан хоёр гараа дээш нь өргөнө*)

Элсэн дээрх байшин урсан одов (*хуруунуудаа хөдөлгөн, хоёр гараа биеэсээ гадагш хөдөлгөнө*)

Бид Зөвийг Сонгосон Үедээ Ухаалаг Байдаг

Түүх ба ярилцлага

Хүн болгон өдөр бүр сонголтууд хийдгийг тайлбарла. Бид ухаалаг сонготууд хийж болно, бас тэнэг сонголтууд хийж болно. Том болсон хойноо Ерөнхий

Эрх Мэдэлтэн болсон Б.Х. (Харри) Робертсын тухай дараах түүхийг өөрийн үгээр ярь. Уг түүхэн дэх Харригийн сонголтууд ухаалаг уу эсвэл тэнэг үү гэдгийг хүүхдүүдээр шийдүүл.

Харри эрт дээр үед Англид төржээ. Түүний гэр бүл нэн ядуу байв, тиймээс сургуульд явах боломж Харрид байсангүй. Тэр уншиж, бичиж сурахыг туйлын их хүсдэг байв. Хэрэв сурах боломж түүнд олддог юм бол зөвхөн ном унших төдийгүй, бас номнууд бичих болно гэж боддог байжээ.

Харри арван настай байхдаа Америкт ирж, өөрийн эгч Полли болон бусад анхдагчуудын хамт хээр талыг туулжээ.

Харрид олон адал явдал тохиолджээ. Нэг өдөр түүний хэсэг маргааш нь том гол гатлах болсныг тэр сонссон аж. Энэ явдал сэтгэл хөдөлгөм сонсогдсон болохоор тэр маргааш өглөө нь эрт нөгөөх голыг харах гэж буудлаас сэмхэн гарч явжээ. Энэ нь буудлын дүрмийг зөрчсөн хэрэг байлаа.

- Харригийн Буудлаас сэмхэн гарч явах нь ухаалаг шийдвэр байсан уу, эсвэл тэнэг шийдвэр байсан уу, та нар юу гэж бодож байна?

Тэр гол Харрийн бодож байснаас хавьгүй бол байсан болохоор тэр тэнд хүрэхдээ ядарсан байлаа. Тэр хэвтээд хэсэг бургасан дунд бөх гэгч унтчихав.

Харрийг сэрэхэд бүх мухлаг тэрэгнүүд гол гаталчихсан байлаа. Тэр голын эргээр гүйж, хэн нэгний анхаарлыг татахын тулд хашгирав. Голыг сэлж гатал гэж түүнд хэлж, тэгээд тэр хүрэм, гутлаа тайлж гол руу үсрэн оров. Тэр голыг бараг гаталж явтал хэт ядарч, тэгээд хамтлагийн ахмад замын үлдсэн хэсэгт түүнийг морин дээрээ авч гарчээ. Эсэн мэнд гарсандаа Харри баяртай байсан боловч, хүрэм, гутлаа буцаж авах арга байсангүй. Тэр шөнө болгон хүрмээ, өдөр болгон гутлаа үгүйлэн хүсдэг байлаа.

Харри есөн зуун миль газрыг хөл нүцгэн туулах хэрэгтэй болсон аж. Үүний улмаас хөл нь их өвджээ. Замын хажуугаар өргөст кактус ургадаг байсан бөгөөд Харри их өлсдөг байсан учраас үүнийг хүнсэнд зориулж олонтаа түүдэг байв. Хурц өргөс түүний өвдсөн хөлд хатгана. Полли өргөсийг сугалж авах үед хоёул уйлдаг байлаа. Харри хөл нь өвдсөндөө уйлдаг байсан бол Полли Харрийг өрөвдсөндөө уйлдаг байжээ.

- Буудлаас сэмхэн гарч явах Харригийн сонголт яагаад тэнэг байсан бэ?
- Өөрийнх нь сонголт хожим нь Харрид ямар санагдсан бэ?

Солт Лейк Ситид ирсний дараа л сая Харри сургуульд явах боломжтой болжээ. Түүнийг арван нэгэн настай байхад нэг багш түүнийг сургуульд авчирч түүнд цагаан толгой заажээ. Харрид байсан цорын ганц ном нь Библи байв, тэгээд тэр үүнийг дахин дахин уншдаг байв. Тэр сургуульд шаргуу суралцаж маш сайн сурагч болжээ.

- Харри ямар сонголтууд хийсэн бэ? (Тэр уншиж сурахаар сонгосон, бас судруудыг судлахаар сонгосон.)
- Сонголтууд нь ухаалаг байсан уу? эсвэл тэнэг байсан уу?

Харри том болохдоо ухаалаг, бас Сүмд чухал хүн болсон юм. Тэр унших дуртай, судрууд унших нь түүнд таалагддаг байв. Бас тэр Сүмийн тухай олон ном бичжээ. Түүний номнуудыг олон хүмүүс уншиж, Сүмийн тухай илүү ихийг мэддэг байлаа. (*Church News*, 1980 оны Долдугаар сарын 19, х. 8–9; and Truman G. Madsen, *Defender of the Faith: The B. H. Roberts Story* [Salt Lake City: Bookcraft, 1980], х. 19–21, 37–40, 56–57-г үз.)

ЗС уриа ЗС уриаг үзүүлж: “Би зөвийг сонгох болно” гэсэн үгсийг өөрийнхөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл. Бид зөвийг сонгосон үед ухаалаг шийдвэрүүд гаргадгийг хүүхдүүдэд тайлбарла.

Дүгнэлт

Үйл ажиллагаа “Ухаалаг,” “Тэнэг” гэсэн хоёр тэмдгийг шалан дээр буюу ширээн дээр тавь. Тэмдэг тус бүр дээрх үгийг өөртэйгөө хамт хүүхдүүдээр хэлүүл. “Ухаалаг” гэсэн тэмдэг дээрээ биднийг аз жаргалтай болгодог баяр баясгалантай нүүрний зурагтай байгааг онцлон заа.

Жижиг цааснуудтай савыг үзүүлж, савнаас ээлжээр нэг нэг цаас сонгохыг хүүхдүүдээс хүс. Хүүхэд бүрийн сонгож авсан цаасан дээр бичигдсэн үйлдлийг уншиж өгөх буюу тэр хүүхдээр уншуул. Үйлдэл нь ухаалаг уу эсвэл ухаалаг бус уу гэдгийг хүүхдээр хэлүүлж цаасыг холбогдох тэмдгийн дэргэд тавиул.

Ухаалаг сонголт гэж тэдний нэрлэсэн үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдийг урамшуул.

Нэгтгэн дүгнэх
ярилцлага

- Ямар сонголтууд биднийг баяртай болгодог вэ?
- Ухаалаг, баяр баясгалантай байхын тулд хэний заадаг зүйлүүдийг бид дагах ёстой вэ?
- Есүс Христийг дуулгавартай дагахгүй байж, бурууг үйлдэх нь яагаад ухаалаг бус вэ?

Гэрчлэл

Бид ухаалаг шийдвэр гаргасан үедээ баяр баясгалантай байх болно гэдгийг хүүхдүүдэд гэрчил. Есүс Христэд мөн биднийг аз жаргалтай байхад туслахын тулд түүний заадаг зүйлүүдэд талархлаа илэрхийл.

Өөрсдийн шийдвэрүүдийн талаар энэ долоо хоногт онцгойлон анхаарч, ухаалаг шийдвэрүүд гаргахад нь хүүхдүүдийг урамшуул.

Дуу

“Зөв Замыг Сонго” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Ангийн гишүүн бүр ухаалаг байж, зөв шийдвэр гаргадаг байхын төлөө залбирахыг тэр хүүхдээс хүс.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.


1. Мэргэн Хүмүүс, зураг 2-7-г үзүүлж, зургийн тухай хүүхдүүдээр өөртөө яриул. Есүсийг төрсний дараа мэргэн хүмүүс түүнийг эрж олохоор ирснийг хүүхдүүдэд сануул (Матай 2:1–12-ыг үз). Мэргэн хүмүүс зөвхөн агуу их мэдлэгтэй байсан төдийгүй, бас Есүс Христийг хайж, түүнийг шүтэн биширдэг байсны улмаас мэргэн байсныг тайлбарла. Тэд Есүсийг дагахаар мэргэн шийдвэр гаргасан ажээ.

Есүсийг эрж байсан мэргэн хүмүүсийн тухай түүхийг та хүүхдүүдээр жүжигчлэн тоглуулж болно.

2. Саявтархан гаргасан ухаалаг шийдвэрийнхээ талаар ярихыг хүүхэд бүрээс хүс (шаардлагатай бол зөвлөмж өг). Тусгай цаасан дээр хүүхдүүдийн өгсөн хариулт бүрийг бичиж, эдгээр цааснууд дээр хүүхэд бүрээр өөрсдийнх нь зургийг зуруул. Ухаалаг шийдвэр гаргах нь биднийг аз жаргалтай байхад тусалдаг учраас зургийнхаа нүүрүүд дээр инээмсэглэл тавихыг хүүхдүүдээс хүс.
3. Дараах үзүүлэнт хичээлийг үзүүл (үүнийг ангид хийхээс өмнө дадлага хийж үз).

Шаардлагатай материалууд:

- а. Доор харуулсны дагуу энгийн хоёр байшин барих хүүхдийн тоглоомын найм буюу арван гулдмай.



- б. Адил хэмжээний хоёр гүнзгий таваг.
в. Хоёр тавагны нэгэнд хийх том хавтгай чулуу.
г. Нөгөө тавганд хийх хэв оруулж овоолсон элс.
д. Ваар буюу усны лаазанд хийсэн ус.

Нэг тавганд элсийг хэв оруулан хийж, дараа нь хэвээ хавтгайл. Нөгөө тавганд хавтгай чулууг хий.

Гулдмайнуудыг үзүүлж, та нар энэ гулдмайнуудыг хоёр байшин барихад ашиглах болно. Нэг байшинг элсэн дээр, нөгөөг нь хадан дээр барих болно гэдгийг тайлбарла.

Хадан дээрх байшинг барихад туслахыг та хүүхдүүдээс гуйж болно. Энэ байшин элсэн дээр таны барих байшинтай адил байх ёстой.

Хоёр байшинг барьж дууссаны дараа шуурга болж байшингуудыг нүдэж байгааг хүүхдүүдээр төсөөлүүл. Аадар бороо орж, салхи ширүүслээ.

- Шуурга энэ хоёр байшинг яана гэж та нар бодож байна?

Хүүхдүүд өөрсдийн санаануудыг хэлсний дараа, тайлбар хийх хэрэггүй. Ус элсийг урсгаж, түүн дээр барьсан байшин нуртал усыг болгоомжтойгоор түүн рүү хий. Хадан дээр барьсан байшин руу мөн адил хэмжээний ус цутга, тэгээд байшин нурахгүй байгааг хүүхдүүдээр ажиглуул.

Элсэн дээр байшин барих нь тэнэг, харин хадан дээр байшин барих нь ухаалаг хэрэг гэдгийг тогтооход нь хүүхдүүдэд тусал.

Хиламан 5:12-ын эхний хэсгийг (суурийг дуустал) чанга унш. Энэ судар Есүс Христийг хадтай зүйрлэснийг онцлон тэмдэглэ. Есүсийн дараах заасан зүйлүүд хадан дээр байшин барихтай адил юм гэдгийг хүүхдүүдэд сануул. Энэ бол ухаалаг юм.

Би Хүндэтгэлийн Өдрийг Ариунаар Сахиж Чадна

Зорилго

Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих хүүхэд бүрийн хүслийг хүчтэй болгох.

Бэлтгэл

1. Египетээс Гарсан нь 20:8–11, Матай 12:10–13-ыг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 24-ийг үз.
2. Хичээлийн төгсгөл дэх хуанлийг хувилах буюу хэлэн зур. Хүндэтгэлийн өдрүүдийг улаанаар буд. Тухайн сарын өдрүүдийг та тоолж болно.
3. Дараах үгсийг бичсэн цаасан туузыг бэлтгэ:

“Хүндэтгэлийн өдрийг санаж, үүнийг ариунаар нь сахь.”

4. Хүндэтгэлийн өдрийн үйл ажиллагааны хуудсыг (хичээлийн төгсгөл дэх) хүүхэд бүрт хувиран бэлтгэ. Бага насны хүүхдүүдэд хуудсыг цэгтэй шугамын дагуу салган хайчил. Ахлах насны хүүхдүүд хуудсыг өөрсдөө салгаж хайчлахын тулд хэдэн хайч авчир.
5. “Бямба Гараг” (*Children’s Songbook*, х. 196) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
6. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Будгийн харандаанууд.
 - в. Үйл ажиллагааны хуудсуудыг нийлүүлж үдэх үдээсний машин буюу бусад хэрэгсэл.
 - г. Зураг 2-58, Есүс Хатингар Гартай Хүнийг Эдгээсэн нь.
7. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Хүндэтгэлийн Өдөр Бол Онцгой Өдөр

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хуанлийг хүүхдүүдэд үзүүлж, энэ нь сарын бүх өдрийг үзүүлдгийг тайлбарла. Хуанлийг юунд ашигладгийг товч ярилц.

- Энэ хуанлийд ердийн биш юу байна вэ?
- Ямар өдрийг улаанаар будсан байна вэ?
- Яагаад энэ өдөр тусгай өдөр байдаг вэ? (Энэ бол Хүндэтгэлийн Өдөр)

Багшийн
танилцуулга

Дэлхийн эхлэлээс хойш долоо хоног бүрийн нэг өдөр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нарын тухай сурч, санах болон бусдад сайн зүйл хийх өдөр болгон тогтсоныг хүүхдүүдэд хэл. Энэ өдрийг Хүндэтгэлийн Өдөр гэж нэрлэгддэг.

- Долоо хоногийн ямар өдөр Хүндэтгэлийн өдөр вэ?

Судар ба цаасан туузан дээрх үг Египетээс Гарсан нь 20:8-ыг чанга уншиж, цаасан туузан дээрх үгийг үзүүл. Энэ судрыг нэгэн зэрэг давтан хэлэхэд нь хүүхдүүдэд тусал. Энэ бол зарлиг гэдгийг тэдэнд хэл.

Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахина гэдэг нь сүмд явах, судрууд унших болон бусад хүндэтгэлтэй зүйлүүдийг хийх зэрэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нараас бидэнд сануулсан зүйлүүдийг бид хийх ёстойг тайлбарла.

Хүндэтгэлийн Өдрийг Бид Ариунаар нь Сахиж Чадна

Ярилцлага

Хүндэтгэлийн Өдөрт тохирох үйл ажиллагааны төрлүүдийн талаар хүүхдүүдтэй ярилц. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих талаар ямар зүйлүүд хийснийг нь хүүхдүүдээс асуу. Сүмд явах, залбирах, дуулах сүмийн цуглаануудад үг хэлэх, Есүсийн заадаг зүйлүүдийн тухай мэдэж авах, түүнчлэн ариун ёслолоос хүртэх нь Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихад бидний хийж болох зүйлүүд юм гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал.

Хэрэв боломжтой бол бид Ням гарагт ажиллах ёсгүй, мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай бодохоос хол хөндий байлгах зүйлүүдийг хийхгүй байх ёстой.

Үйл ажиллагаа

Хүүхдүүд оролцож болох зарим үйл ажиллагааны тухай ярилц. Хэрэв үйл ажиллагаа нь Хүндэтгэлийн Өдөр бидний хийх ёстой зүйл байвал инээмсэглэх, харин Хүндэтгэлийн Өдөр хийх ёсгүй зүйл байх юм бол хөмсөг зангидахыг хүүхдүүдээс хүс. Доорх жишээнүүдийг буюу эсвэл өөрийнхөө ангийн хүүхдүүдийн хувьд тохирох өөр жишээнүүдийг ашигла.

- Сүмд явах.
- Гэр орноо цэвэрлэх.
- Төрөл төрөгсөддөө зочлон очих.
- Дэлгүүрээс юм авахаар явах.
- Кинонд явах.
- Судрууд буюу бусад сайн номнуудыг унших.
- Залбирах.
- Спорт тоглоом үзэх буюу оролцох.
- Захидал бичих.
- Зугаалахаар явах.
- Судрын тоглоомууд тоглох.
- Өвчтэй хүнийг эргэж очих.

Есүс Христ Хүндэтгэлийн Өдрийг Ариунаар нь Сахидаг Байв

Аль нэг үйл ажиллагаа нь Хүндэтгэлийн Өдөр бидний хийх ёстой зүйл мөн үү гэдгийг мэдэх нь үргэлж амархан байдаггүйг хүүхдүүдэд хэл. Юу хийхийгээ мэдэх хамгийн сайн арга бол Есүс Христийн үлгэр жишээг дагах явдал мөн.

Судрын түүх

Есүс Хатингар Гартай Хүнийг Эдгээсэн нь, зураг 2-58-ыг үзүүлж, Матай 12:10–13 дахь судрыг ярь.

Фарисайчууд бол Есүс Христ болон түүний хийдэг зүйлүүдэд дургүй хүмүүс байсныг тайлбарла. Буруу буюу хуулийн эсрэг хэлсэн зүйлүүд дээр нь тэд Есүсийг унаган барьж авахыг хичээж байв. Хүндэтгэлийг өдөр хүн эдгээх нь буруу гэж тэд түүнд хэлжээ. Тэд үүнийг тийм ээ гэж хэлэхийг түүнээс хүсч байжээ.

Хэрэв Фарисайчууд Хүндэтгэлийн Өдөр хонь нүхэнд унасан бол тэд хонийг нүхнээс гарахад нь туслах байсан гэж Есүс хэлснийг хүүхдүүдэд ярь. Хүмүүс хониноос илүү чухал учраас хүмүүст туслах нь Хүндэтгэлийн Өдөр хийх сайн зүйл юм. Матай 12:12-ын хоёр дахь хэсгийг чанга унш (*Иймээс гэдгээс эхлэн*).

Хэрэв аль нэг үйл ажиллагаа нь бусдад туслах буюу эелдэг найрсаг байх гэх мэтийн, Есүсийн хийх зүйл байвал энэ нь Хүндэтгэлийн өдөр хийж болох сайн зүйл мөн гэдгийг хүүхдүүдэд сануул.

Хүндэтгэлийн Өдрийг Ариунаар Сахих нь Бэлтгэл Шаарддаг

Ярилцлага

Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихын тулд, Хүндэтгэлийн Өдрөөс өмнө зарим тодорхой зүйлүүдэд бэлтгэсэн байх хэрэгтэй.

- Хүндэтгэлийн өдөрт бэлэн байхын тулд та нар болон гэр бүл чинь ямар зүйлүүд хийх хэрэгтэй вэ? (Хариултууд нь сүмд өмсөх хувцсаа угаах буюу индүүдэх, гэр орноо цэвэрлэх, хүндэтгэлийн өдөр идэх хоол хүнсээ бэлтгэх, судруудаа олох болон сүмд шаардлагатай бусад зүйлүүдийг олох зэрэг нь байж болно.)
- Та нар эдгээр зүйлүүдийг хэзээ хийх ёстой вэ?

Дуу

“Бямба Гараг” дууг дуулах буюу үгийг нь хэл. Дуунд дурдсан үйлдлүүдийг үггүй хөдөлгөөнөөр хийж үзүүлэхэд нь хүүхдүүдэд тусал. (Хэрэв танай бүсэд Хүндэтгэлийн Өдөр нь Ням гарагаас өөр өдөр байдаг бол *Бямба, Ням, Даваа* гэхчлэн холбогдох өдрөөр соль.)

Бямба гараг тусгай өдөр.

Энэ бол Ням гарагт бэлтгэдэг өдөр:

Бид гэрээ цэвэрлэж, дэлгүүрт худалдаа хийдэг

Тэгэхээр бид Даваа хүртэл ажилладаггүй.

Бид хувцсаа цэвэрлэж, гутлаа сойзоддог,

Бид үүнийг бэлтгэлээ хийж дуусдаг өдөр гэж нэрлэдэг.

Дараа нь хумсаа авч, үсээ савандан угаадаг,

Тиймээс бид Ням гарагт бэлэн байж чаддаг!

Хүүхдүүд Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихад бэлэн байхын тулд дараагийн долоо хоногт бэлтгэхэд нь хүүхдүүдийг урамшуулан дэмж.

Дүгнэлт

Үйл ажиллагаа

Хүндэтгэлийн өдрийн үйл ажиллагааны хуудсыг хүүхэд бүрт хувилан өг. “Миний Хүндэтгэлийн Өдрийн Ном” хуудсын гарчгийг өөртэйгөө хамт уншихад нь хүүхдүүдэд тусал. Хэрэв та хуудсуудыг салгаж хайчлаагүй бол тэдгээрийг салгаж хайчлахад хүүхдүүдээр туслуул.

Хүндэтгэлийн өдрийн зохих үйл ажиллагаануудыг дүрсэлсэн дараах өгүүлбэрүүдийг уншиж, үйл ажиллагаа бүрийг харуулж байгаа зургуудыг сонгоход нь хүүхдүүдэд тусал.

- Хүндэтгэлийн Өдөр бид Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрыг хүндэтгэж, тэдний тухай мэдэхийн тулд сүмд явдаг.
- Хүндэтгэлийн өдөр бол гэр бүлийнхээ хамт сайн мэдээг судлахад сайн өдөр юм. Бид судруудыг болон өөр сайн номнуудыг уншиж болно.
- Хүндэтгэлийн өдөр бол залбирлын өдөр юм. Бид сүм дээр, гэр бүлтэйгээ хамт түүнчлэн өөрсдөө залбирдаг.
- Хүндэтгэлийн өдөр бид сүмийн дууллууд дуулж, сайн хөгжим сонсож болно.
- Хүндэтгэлийн өдөр бид тэмдэглэлээ хөтөлж, захидал бичих буюу төрөл төрөгсөд, найз нөхөд, номлогч нарт зориулан зураг зурж болно.
- Хүндэтгэлийн өдөр бол гэр бүлийн гишүүд буюу өвчтэй эсвэл ганцаардсан хүмүүсийг эргэж очиход сайн өдөр юм.

Хүүхдүүдэд будгийн харандаанууд өгч зургуудыг будуул. Нугалсан хуудсан дээр хүүхдүүд Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихын тулд хийх гэж байгаа ямар нэг зүйлийнхээ тухай зурахыг тэднээс хүс.

Номныхоо хуудсуудыг нэгтгэн үдэхэд нь хүүхдүүдэд тусал.

Гэрчлэл

Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихын ач холбогдлын тухай гэрчлэлээ хуваалц. Хүндэтгэлийн Өдөр өөрийн хийх дуртай нэг буюу хоёр зүйлийг та дурдаж, эдгээр зүйлүүдийг хийх үед ямар санагддаг тухайгаа ярьж болно. Хүндэтгэлийн Өдөр бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай бид санаж, мэддэг баяр баясгалантай өдөр байх ёстойг онцгой анхаар.

Номнуудаа гэрийнхэндээ үзүүлж, өнөөдөр сурсан зүйлүүдээ тэдэнтэй хуваалцахад нь хүүхдүүдийг урамшуул. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихыг хүүхдүүдэд сануулж байх газарт номнуудаа хадгалахыг хүүхдүүдэд санал болго.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихад ангийн гишүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг тэр хүүхдээс хүс.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Сүмд Явахдаа Би” (*Children’s Songbook*, х. 157) дууг дуулах буюу үгийг нь хэл. Хүүхдүүдийг босгож, дуулах үедээ дор харуулсан үйлдлүүдийг хийлгэ:

Сүмд явахдаа би

Үргэлж баяртай байдаг (*зүрхнийхээ тушаа гараа байрлуулж, инээмсэглэ*).

Хөгжим намуухан, уянгалаг эгшиглэнэ (*гараа чихнийхээ ард хөмөр*);

Өлмий дээрээ би намуухан гишгэлэн суудалдаа хүрнэ (*байрандаа өлмий дээрээ гишгэлж, хуруугаа уруулдаа хүргэ*)

Сүмд намайг ирэхэд (*сандад дээр суу*)

Багш нар, найз нар маань надтай мэндэлнэ (*хажуугийнхаа хүнтэй зөөлхөн гар барь*).

2. Самбар дээр хоёр чих, хоёр нүд, нэг ам, хоёр гар зур. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихад бидний биеийн эдгээр эрхтэн тус бүр юу хийж чадахыг өөртөө ярихыг хүүхдүүдээс хүс.

Жишээ нь:

Нүд—судрууд унших, үг хэлэгчдийг болон сүм дэх багш нарыг харах.

Чих—Сэтгэл санаа өргөсөн хөгжим буюу түүхүүдийг сонсох, Хүүхдийн Хэсгийн хичээл сонсох.

Ам—сүмийн дууллууд буюу Хүүхдийн Хэсгийн дуунууд дуулах, гэр бүлийн гишүүд болон найз нартаа зөлдөг зүйлүүдийг хэлэх.

Гар—Хол газар амьдарч байгаа гэр бүлийн гишүүддээ зориулж зураг зурах, тэмдэглэл хөтлөх.

3. Египетээс Гарсан нь 20:8-ыг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал:

“Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихыг санагтун.”

4. “Хүндэтгэлийн Өдрийг Сана” (*Children’s Songbook*, х. 155) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Хүндэтгэлийн өдрийг үргэлж

Ариунаар хадгалахыг сана.

Их Эзэнийг шүтэн бишрэхийн тулд

Энэ өдрийг адисалж ариусгасан юм.

Хүндэтгэлийн Өдөр Бол Ариун Өдөр

Ням гараг

Даваа гараг

Мягмар гараг


Лхагва гараг

Пүрэв гараг

Баасан гараг

Бямба гараг

Миний Хүндэтгэлийн Өдрийн Ном





Би Ариун Ёслолын Үеэр Есүс Христийг Дурсан Санах Болно

Зорилго

Ариун ёслолын үед хүүхэд бүр Есүс Христийг дурсан санаж байхад нь сүнслэгээр нөлөөлөх.

Бэлтгэл

1. Лук 22:7–20 болон Сургаал ба Гэрээ 20:75–79-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 23-ыг үз.
2. “Би Тэр Сайхан Түүхийг Уншиж Байхдаа Боддог” (*Children’s Songbook*, р. 56), “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” (*Children’s Songbook*, х. 61) мэт Есүс Христийн тухай нэг буюу хоёр дууг хүүхдүүд дуулахад нь туслахад бэлтгэ. Есүсийн тухай эдгээр болон бусад дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа болно.
3. Хэрэв олдох бол зураг ашиглан Есүс Христийн тухай өөрийн дуртай нэг түүхийг ярихад бэлтгэ.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи болон Сургаал ба Гэрээ.
 - б. Ариун ёслолын талх болон усны тосгуур.
 - в. Зураг 2-29, Ариун Ёслол Түгээж Байгаа нь; зураг 2:54, Сүүлчийн Зоог (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 225; 62174); зураг 2-59, *Христийнх*.
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христ Ариун Ёслолыг Бидэнд Өгсөн

Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа

Ариун ёслолын тосгуурыг хүүхдүүдэд үзүүл

- Эдгээр тосгууруудыг юунд ашигладаг вэ?

Ариун ёслолын тосгуурууд болон ариун ёслолын талаар юу мэддэгийг нь хүүхдүүдээр яриул. Өнөөдрийн хичээл ариун ёслолын тухай болохыг тэдэнд хэл.

Судрын түүх ба ярилцлага

Сүүлчийн Зоог, зураг 2-54-ийг үзүүл. Хэрэв хүүхдүүд үүнийг мэдэж байвал, зураг дээр юу болж байгааг тэднээр яриул. Хэрэв тэд зургийг мэдэхгүй байвал, энэ бол Есүс Христ болон түүний Төлөөлөгчдийн зураг гэдгийг хэлж өг. Есүс Христийг заахыг хүүхдүүдээс хүс.

Лук 22:7–20-д байдаг Сүүлчийн Зоогийн тухай түүхийг ярь.

Есүс Христ болон түүний шавь нар Иудейчүүдийн тусгай ариун өдөр Дээгүүр Өнгөрсний Баярыг тэмдэглэж байсныг тайлбарла. Энэ баяр Төлөөгчидтэйгөө хамт идсэн түүний сүүлчийн зоог болох болно гэдгийг

Есүс мэдэж байжээ. Энэ хоолыг Сүүлчийн Зоог гэж олонтаа нэрлэдгийг хүүхдүүдэд хэлж өг.

Есүс өөрийн Төлөөлөгчдөд хайртай байсныг тайлбарла. Есүс явсныхаа дараа өөрийн сүмийн гишүүдийг удирдуулахын тулд эдгээр эрчүүдийг сонгосон ажээ. Тэр тэдэнд олон зүйл зааж, өөрийг нь болон өөрийнх нь заадаг зүйлүүдийг дурсан санахыг тэднээс хүсчээ.

- Есүсийг дурсан санах нь Төлөөлөгчдийн хувьд яагаад чухал вэ?
- Түүнийг дурсан санахад нь тэдэнд туслахын тулд Есүс Төлөөлөгчдөд юу өгсөн бэ?

Лук 22:19-ийг чанга унш. Аврагч хэсэг талхыг жижиглэн үйрүүлж, үүнийг адислаад, ид гэж Төлөөлөгчдөд өгсөн тухай энэ судар бидэнд өгүүлдгийг онцлон тэмдэглэ. Талх түүний биеийг төлөөлөн тэдэнд дурсагдах бөгөөд тэд үүнийг идэх үед түүний биеийг тэдэнд санагдуулах болно гэж тэр тэдэнд хэлжээ.

Төлөөлөгч бүр үйрмэг талхыг идсэний дараа Есүс усан үзмээр хийсэн ундааг адислаад, үүнийг Төлөөлөгчдөд өгснийг хүүхдүүдэд хэл. Энэ ундаа тэдэнд түүний цусыг санагдуулах болно гэж Тэр тэдэнд хэлжээ. Тэд үүнийг уухдаа Тэнгэрлэг Эцэгтэй тэд дахин хамт амьдарч болохын тулд Есүс үхсэн юм гэдгийг санах ёстой.

Хэрэв Төлөөлөгчид түүнийг болон түүний заадаг зүйлүүдийг санаж байх юм бол энэ зөвийг сонгоход тэдэнд туслах болно гэдгийг Есүс мэдэж байсныг тайлбарла.

- Сүүлчийн Зоог дээр Есүс шавь нартаа өгсөн талх, ундааг бид юу гэж нэрлэдэг вэ? (Ариун ёслол)
- Яагаад Есүс ариун ёслолыг Төлөөлөгчдөд өгсөн бэ?

Есүс Христийг Дурсахын Тулд Бид Ариун Ёслолыг Гүйцэтгэдэг

Ярилцлага

Ариун Ёслол Түгээж Байгаа нь, зураг 2-29-ийг үзүүлж, бид ариун ёслолоос яг Есүсийн Төлөөлөгчдийн нэгэн адил хүртдэгийг хүүхдүүдэд сануул. (Есүс өөрийн Төлөөлөгчиддөө өгсөн дарсны оронд бид ус хэрэглэдгийг та тайлбарлаж болно.)

- Хэзээ бид ариун ёслолыг гүйцэтгэдэг вэ?

Бидний ариун ёслол гүйцэтгэдэг цуглааныг ариун ёслолын цуглаан гэж нэрлэдэг, учир нь ариун ёслол уг цуглааны хамгийн чухал байдгийг онцлон тэмдэглэ.

- Бид яагаад ариун ёслол гүйцэтгэдэг вэ?
- Зөвийг сонгохыг санахад ариун ёслол бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

Судар

Ариун ёслолыг түгээхээс өмнө тусгай залбирал хэлэгддэгийг хүүхдүүдэд сануул. Залбирлууд нь бидний хийхээр амласан зарим зүйлийг Тэнгэрлэг Эцэгт хэлдэг. Талхны залбирлыг өөрөө унших үед бид ариун ёслолыг гүйцэтгэх үед Тэнгэрлэг Эцэгт бидний хийдэг хоёр амлалтыг хүүхдүүд мэдэж авахын тулд анхааралтай сонсохыг тэднээс хүс.

“Тэд таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж үүнийг идэж болохын тулд, мөн үргэлж түүнийг санаж, мөн тэдэнд түүний өгсөн зарлигуудыг дагана гэдгээ танд гэрчилж болохын тулд” гэсэн өгүүлбэрүүдийг онцлон, Сургаал ба Гэрээ 20:77-г чанга унш.

“Танд гэрчлэх” гэдэг нь бид Тэнгэрлэг Эцэгт амлаж байгаа гэсэн утгатайг хүүхдүүдэд хэлж өг.

- Бид ямар хоёр зүйлийг хийхээр амладаг вэ?

Бид ариун ёслолыг гүйцэтгэх бүрт Есүсийг санаж, түүний зарлигуудыг сахихаар амладгийг тайлбарла.

Бид Ариун Ёслолын Цуглааны Үед Биднийг Хайрладаг Есүс Христийн Хайрын Тухай Бодож Болно

Багшийн танилцуулга

Христийнхэн, зураг 2-59-ийг үзүүл. Энэ зураг Есүс Христийн нэг хөшөөг харуулдгийг тайлбарла. Ар талд нь зарим гараг болон однуудын зураг байна. Зургийн тухай хүүхдүүдээр хэсэг хугацаанд яриул.

Ариун ёслолын үед бид Аврагч болон биднийг хайрладаг түүний хайрын тухай бодож байх ёстойг тайлбарла. Бидэнд өмнө нь үзүүлсэн зураг гэхчлэн, өөрсдийн үзсэн Есүсийн зургуудыг бид санаж чадна, түүнчлэн бид бас Есүсийн тухай түүхүүдийг санаж чадна.

Түүх

Хэрэв олдох бол нэг зураг ашиглан, Есүсийн тухай өөрийн дуртай түүхүүдийн нэгийг ярь. Уг түүх хүмүүсийг хайрлах Есүсийн хайрыг хэрхэн харуулж байгааг тайлбарла.

Хүүхдийн оролцоо

Есүс Христийн тухай түүхийг хүүхэд бүрээр яриулах буюу эсвэл Есүсийн тухай ямар нэг санаж байгаа зүйлийг нь хүүхдүүдээр яриул. Хүүхдүүдийг ярих үед Есүс биднийг хэрхэн хайрладгийг түүхүүдэд харуулсан болон Есүсийн тухай хүүхдүүдийн санаж байгаа зүйлүүдийг онцлон анхаар.

Есүсийн тухай түүхүүдийг санасан хүүхдүүдийг магт. Ариун ёслолын үед бидний санаж болох олон түүх байдгийг тэдэнд хэл. Ариун ёслолын үед Есүсийн тухай болон тэр биднийг хичнээн их хайрладаг тухай бид бодсоноор, бид түүнийг дурсан санах болно.

Дуу

Бид бас Есүс Христийн тухай олон дуу мэддэг гэдгийг тайлбарла. Ариун ёслолыг түгээж байхад бид чанга дуулдаггүй ч гэсэн, бид дуунуудын үгийг санах нь Есүсийг санахад бидэнд тусалдаг.

“Би Тэр Сайхан Түүхийг Уншиж Байхдаа Боддог”, “Есүс Бүгдийг Хайрла Гэж Хэлсэн” гэх мэт Есүсийн тухай нэг буюу хоёр мэддэг дуугаа хүүхдүүдтэй хамт дуул.

Ариун Ёслолын Үед Хүндэтгэлтэй Байх нь Есүс Христийг Санахад Бидэнд Тусална

Ярилцлага

Бид ариун ёслолын үед хүндэтгэлтэй байвал, Есүсийн тухай бодоход амар байдгийг тайлбарла.

- Ариун ёслолын үед бид яаж хүндэтгэлтэй байж болох вэ?

Дараах санаанууд дурдагдахыг анхаар:

- Ариун ёслолын залбирлуудыг сонсож, төгсгөлд нь “амен” гэж хэл.
- Эцэг эхчүүдээ буюу бусад хүмүүст бүү саад бол. Тэд ч бас Есүсийн тухай бодох хэрэгтэй шүү дээ.
- Ариун ёслолын өмнө харандаа, ном буюу бусад зүйлүүдийг хураасан бай.
- Чимээгүй, өөр өөрийнхөө суудалд бай.

Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Есүсийн тухай түүхүүд буюу дуунуудыг санах замаар Есүс Христийн тухай, биднийг хайрладаг түүний хайр болон түүний заадаг зүйлүүдийн тухай бод. • Хэсэг талх, аягатай усыг бидэнд хамгийн ойрхон байлга. • Ариун ёслолын хундагуудыг тэдгээрээр тоглолгүйгээр хураа. <p>Тэд ариун ёслолын цагаар ариун ёслолын цуглаанд сууж байгаагаар хүүхдүүд төсөөлөхийг тэднээс хүс. Хоорондоо ярилгүйгээр дараах асуултуудын хариуг олохыг хүүхдүүдээс хүс:</p> <ul style="list-style-type: none"> • Та нар Есүсийн тухай бодож байгаагаа харуулахын тулд амаараа юу хийж болох вэ? • Та нар хүндэтгэлтэй байгаагаа харуулахын тулд толгойгоо яах вэ? • Та нар Есүсийн тухай бодож байгаагаа харуулахын тулд гараа яах вэ? • Та нар хүндэтгэлтэй байгаагаа харуулахын тулд хөлөө яах вэ? <p>Ариун ёслолыг түгээж байхад яаж суудаг шиг Есүс Христийн тухай бодож хүүхдүүдийг нэг хоёр минут чимээгүй суулга. Дараа нь Есүсийн тухай юу гэж бодож байгаа нь тэднээр хуваалцуул.</p>
Үйл ажиллагаа	<p>Дүгнэлт</p> <p>Ариун ёслолын цуглааны үед хүүхдүүдийн хийж болох буюу бодож болох зүйлүүдийн талаар өөрөө хэдэн нотолгоог унших үеэр анхааралтай сонсохыг тэднээс хүс. Хэрэв нотолгоо нь ариун ёслолын цуглааны үед тэдний хийх буюу сонсох ёстой зүйлийг дүрсэлбэл хүүхдүүд босох ёстой. Хэрэв нотолгоо нь ариун ёслолын цуглааны үед тэдний хийх буюу сонсох ёсгүй зүйлийг дүрсэлбэл хүүхдүүд суух ёстой.</p> <p>Дараах нотолгоонуудыг ашиглах буюу өөрөө зарим нотолгоог зохио:</p> <ul style="list-style-type: none"> • Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бидэнд хайртайг сана. • Тоглохоор гадагшаа явах тухай бод. • Өвчтэй хүмүүсийг Есүс эдгээсэн тухай бод. • Хөршдөө шивнэх буюу түүнтэй ярь. • Суудал дээрээ хөдөл. • Ариун ёслолын дуу буюу Есүсийн тухай өөр дууны тухай бод. • Тэнгэрлэг Эцэгт хандан залбирал хэл. • Зураг зурах буюу тоглоомоор тогло. • Есүсийн тухай түүхүүдийг сана.
Гэрчлэл	<p>Есүс Христийн тухай гэрчлэлээ хуваалц. Ариун ёслол хүртэхэд бэлэн байгаагаа мэдэрдэг тухай хүүхдүүдэд ярьж өг.</p> <p>Ариун ёслолын үед Есүс Христийг санаж, хүндэтгэлтэй байхад нь хүүхдүүдийг урамшуул.</p> <p>Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.</p>

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Есүсийн Тухай Бодох нь” (*Children’s Songbook*, х. 71) дууг дуулах буюу үгийг нь хэл.

Таг чимээгүй суух нь хэцүү биш,
Есүсийн тухай, толгой дээрх түүний загалмайн тухай бод,
Мөн тэр миний төлөө зовж, миний төлөө хийснийг нь сана;
Таг чимээгүй суух нь хэцүү биш.
Би бүр бага ч гэсэн, энэ нь хэцүү биш,
Есүсийн тухай бодох нь ерөөсөө хэцүү биш.

Тоосон дунд алхсан түүний замуудыг бодно би,
Түүний хайрлаж, итгэж байсан хүүхдүүдийг бас;
Найрсгаар сонсон хөлөөрөө чимээ эс гарган,
Суудалдаа чимээгүй суух нь надад хэцүү биш,
Би бүр бага ч гэсэн, энэ нь хэцүү биш,
Есүсийн тухай бодох нь ерөөсөө хэцүү биш.

2. Хүүхдийн Хэсгийнхээ ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр, нэг санваартан буюу диконьг ангидаа ирүүлж, ариун ёслолын талаарх өөрийнх нь үүргийн талаар товч тайлбарлуул.
3. Хүндэтгэлтэйгээр сууж байгаа хүүхдүүдийн зургийн (хичээлийн төгсгөлд байгаа) хувийг бэлтгэж, будан, эвлүүлэх таван хэсэг болгон хайчил. Хэсэг тус бүрийн ар дээр дараах асуултуудын нэгийг бич:

- Ариун ёслол дээр бидний үйлддэг хамгийн чухал зүйл юу вэ?
- Ариун ёслолын цаг болоход санваартан юу хийдэг вэ?
- Ариун ёслолын үед диконууд юу хийдэг вэ?
- Ариун ёслолын үед бид ямар байдалтай суух ёстой вэ?
- Ариун ёслолын үед бид юуны тухай бодох ёстой вэ?

Эвлүүлэх хэсгүүдийг ширээн дээр буюу шалан дээр дэлгэн тавь. Нэг хүүхдээр эвлүүлэх хэсгийг сонгуул. Эвлүүлэх хэсгийн ар дээрх асуултыг хүүхдүүдээс асууж, үүнд хариулахад нь тэдэнд тусал. Бүх асуултууд хариулагдсан үед эвлүүлэх хэсгүүдийг эвлүүлэхэд нь хүүхдүүдэд тусал.

4. Дараах шүлгийг хэлэхэд нь хүүхдүүдэд тусал:

Ариун Ёслол


Би гараа хумина, би толгойгоо бөхийлгөнө,
Чимээгүй бай, чимээгүй бай;
Ариун ёслол адислагдахад,
Би Таныг дурсана.

(DeVota M. Peterson)

Энэ шүлгийг тогтооход нь хүүхдүүдэд туслахын тулд хэдэн удаа давтан хэлүүл.

Шүлгийг давтан хэлэхийн өмнө та дараах асуултуудыг асууж болох юм:

- Бид юугаа хумих ёстой вэ?
- Бид юугаа бөхийлгөх ёстой вэ?
- Ариун ёслолын үед бид чимээ шуугиан гаргах ёстой юу эсвэл чимээгүй байх ёстой юу?
- Ариун ёслолын үед бид юуны тухай бодох ёстой вэ?



Би Бусдад Үйлчилснээр Есүс Христийг Дагаж Чадна

Хичээл
39

Зорилго Бусдад үйлчилснээр Есүс Христийг дагах хүүхэд бүрийн хүслийг хүчтэй болгох.

Бэлтгэл

1. Иохан 13:1–17, Итгэлийн Тунхаг 1:13-ыг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 28-ыг үз.
2. “Өгөөч, Гэж Бяцхан Горхи Хэлэв”, (*Children’s Songbook*, х. 236), “Би Аврагчийнхаа Хайрыг Мэдэрдэг” (*Children’s Songbook*, х. 74) дууны дөрөвдүгээр бадгийг дуулах буюу үгийг хэлэхэд нь бэлтгэ. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.
3. Хэн нэгэн хүнд үйлчилсний улмаас өөрийнхөө адислагдсан үеийн тухай ярихад бэлтгэ.
4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хүүхэд бүрт цаас, харандаа буюу будгийн харандаанууд.
 - в. Зураг 2-60, Төлөөлөгчдийн Хөлийг Есүс Угааж Байгаа нь (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 226: 62550).
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бусдад Үйлчлэхийг Есүс Христ Биднээс Хүсдэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Та хичээлийг эхлэхдээ будгийн харандаа, цаас буюу бусад зүйлүүдийг ангийн шалан дээр “санамсаргүй” унагаа. Эдгээр зүйлүүдийг авахаасаа өмнө өөртөө туслах боломжийг хүүхдүүдэд олго. (Хэрэв сайн дураараа туслах хүүхэд байхгүй байвал, туслахыг хүүхдүүдээс хүс.)

Өөртөө тусалсанд нь хүүхдүүдэд талархал илэрхийлж, үйлчлэх боломжийг ашигласанд нь тэднийг магт. Хариуд нь ямар нэг зүйл харалгүйгээр бид бусдад туслахыг үйлчлэл гэж нэрлэдгийг тайлбарла. *Үйлчлэл* гэдэг үгийг өөртэйгөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл.

Дуу

“Өгөөч, Гэж Бяцхан Горхи Хэлэв” дууны бүх бадгийг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Есүс өгдөгийн адил бид өгөх ёстойг сүүлчийн шүлэг өгүүлдгийг онцлон заа. Есүс дэлхий дээр байхдаа бусад хүмүүст олонтаа тусалдаг байсныг хүүхдүүдэд ярь.

Судрын түүх

Төлөөлөгчдийн Хөлийг Есүс Угааж Байгаа нь, зураг 2-60-ыг үзүүлж, Иохан 13:1–17 дахь түүхийг ярь. Зураг дээр харуулсан Төлөөлөгчдийг

Есүс өөрийн сүмийг удирдахад туслуулахын тулд дуудсан юм гэдгийг хүүхдүүдэд сануул.

Сүүлчийн Зоогийн тухай өмнөх хичээл дээр сурсан зүйлийг нь хүүхдүүдэд сануул. Христ ариун ёслолын тухай өөрийн Төлөөлөгчдөд заасны дараа тэрээр бусдад үйлчлэх нь хичнээн чухал болохыг тэдэнд заасныг тайлбарла.

Хөлөө угаалгах нь хүмүүсийн хувьд ерийн бусын зүйл биш байсныг тайлбарла, учир нь ихэнх хүмүүс сандаал өмсдөг байснаас хөл нь шороо тоостой, бохир байдаг байжээ. Гэвч үүнийг хийх нь үйлчлэгчийн ажил байв. Петр Есүсээр хөлөө угаалгахыг хүсээгүй ажээ, учир нь Есүс зарц буюу үйлчлэгчийн хувиар ажиллах нь зөв биш гэж тэр бодож байжээ.

Хэдийгээр тэр Аврагч байсан хэдий ч, тэр тэдэнд үйлчилсээр байсныг Есүс Төлөөлөгчдөд тайлбарласныг хүүхдүүдэд ярь. Тэд бие биендээ үйлчлэх ёстойг тэд ойлгоосой гэж Тэр хүссэн ажээ. Иохан 13:15-ыг чанга уншиж, өөрийнхөө жишээг дагаж, бусдад үйлчлэхийг Есүс биднээс хүсдэгийг тайлбарла.

Ярилцлага

- Есүс яагаад Төлөөлөгчдийн хөлийг угаасан бэ?
- Юу хийхийг Есүс Төлөөлөгчдөөс хүссэн бэ?
- Юу хийхийг Есүс биднээс хүсдэг вэ?

Бүр туслуулахаар асуулгагүй байсан ч, тусалсныхаа төлөө шан харамж авахгүй байсан ч боломжтой л байгаа үедээ бусдад туслахыг Есүс биднээс хүсдэгийг тайлбарла. Бид бусдад үйлчилснээр Есүсийг дагаж байгааг онцлон тайлбарла.

Бид Олон Арга Замаар Бусдад Үйлчилж Болно

Түүх

Гэр бүлдээ үйлчлэх арга замыг бодож олсон хөвгүүний тухай дараах түүхийг та өөрийн үгээр ярихдаа анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс:

“Долоон настай нойрмог хөвгүүн саравчинд хүрэх замаа олоход хэцүү тийм харанхуй байлаа. Тэр орноосоо хэрхэн босч, хувцаслан, довжоо руу хэрхэн чимээгүй мөлхөж очин, зоорины тавиур дээрээс сүүний хувин авч хэнийг ч сэрээлгүйгээр гэрээсээ гарч явахаа төлөвлөсөн байлаа.

“. . . [Иосеф] эгч Маригаа үнээ сааж байхыг нь олон удаа харсан аж. Үнээ саах нь түүний бодож байсан шиг тийм ч амархан бишийг тэр мэдлээ. . . . Удалгүй хуруу, бугуй өвдөж эхлэв. Хуруу, гараа амрахын тулд тэр олонтаа зогсож байлаа. . . .

“Хөвгүүн үнээ саахыг ихэд сонирхсон байсан болохоор ийм удаан хугацаа өнгөрснийг мэдсэнгүй, эцэстээ саравчийг орхиж гэрийнхээ зүг чиглэхэд . . . аль хэдийн гэгээ орчихсон байсанд гайхав. Түүнийг галын өрөөнд орж ирэхэд, Ээж нь өглөөний хоол бэлтгэж байсан пийшингийнхээ дэргэдээс түүнийг хараад, ‘Иосеф чи яагаад өглөө ийм эрт босч юу хийдэг билээ?’ гэж асуув.

“Хариуд нь тэр хувин дүүрэн сүүгээ өргөж харуулахад ээжийнх нь сайшаасан инээмсэглэл дээр баяр хөөрийн дулаан мэдрэмж нэмэгдэв. ‘Сайн байна, одоо чи том болсон болохоор өглөө бүр үнээ саах нь чиний ажил байх болно’ тэр хэлэв. Тэгээр ээж нь ярихаа зогсож, ‘Гэвч чи яагаад тэр үнээг саахын төлөө ийм их анхаарах болов?’ гэж асуужээ.

“Иосеф чин үнэнээсээ ээждээ хандан, ‘Аавыг номлолд байх хугацаанд нь би туслахыг л хүссэн хэрэг. [Марид] хийх өөр ажил зөндөө байгааг та

мэднэ шүү дээ. Хэрэв би өглөө үнээгээ саачих юм бол, тэр энэ талаар санаа зовох хэрэггүй болно!” гэж хариулав.

“Ээж нь түүнийг тэвэрч, ‘Намайг аавд чинь захиа бичиж, түүнийг эзгүйд үнээгээ саадаг залуу эр хүнтэй болсныг түүнд хэлэхэд аав чинь хичнээн их баяртай байх бол!’ гэж хэлжээ” (Lucile C. Reading, “The Morning Chore,” *Children’s Friend*, 1970 оны Дөрөвдүгээр сар, х. 23).

Энэ хөвгүүний нэр Иосеф Фийлдинг Смит байсныг, мөн тэр том болсон хойноо Сүмийн арав дахь ерөнхийлөгч болсныг хүүхдүүдэд ярь.

- Иосеф Фийлдинг Смит хэрхэн үйлчилсэн бэ?
- Иосеф Фийлдинг Смит хэнд үйлчилсэн бэ?

Итгэлийн Тунхаг

Бусдад үйлчлэхэд бид итгэдэг гэж итгэлийн арвангуравдугаар тунхагт өгүүлдгийг хүүхдүүдэд ярь. Хүүхдүүдийг босгож, “Бүх хүмүүст . . . сайныг үйлдэхэд бид итгэдэг” гэж хэлэхэд нь тэдэнд тусал.

Үйл ажиллагаа

Есүс Христийн шавь (дагалдагч) байхыг хүсдэг хүүхэд бүрийг босч зогсохыг хүс. Бусдад үйлчлэхийг Есүс өөрийн бүх шавь нараас хүсдэгийг хүүхдүүдэд сануул.

- Бид бусдад хэрхэн үйлчилж болох вэ?

Бусдад үйлчлэх нэг аргыг хэлсэн үед нь хүүхэд бүрийг буцаан суулга.

Хэрэв аль нэг хүүхэд үйлчлэх аргын тухай бодож олох нь хэцүү байвал та дараах санаануудаас нэгийг нь буюу эсвэл ангийн чинь хүүхдүүдэд тохирох өөр санааг санал болгож болно:

- Өөрөөс дүү хэн нэгэнд түүх ярих буюу уншиж өг.
- Эцэг эх, эмээ өвөө нартаа зориулж зураг зур.
- Дүүгийнхээ орхисон тоглоомуудыг хураа.
- Хэлүүлэлгүйгээр хоолны ширээ зас.

Бид Үйлчлэхдээ Баяртай Байдаг

Ярилцлага

- Биднийг үйлчлэх үед хэн баяртай байдаг вэ? (Хариултууд нь бидний үйлчилдэг хүмүүс, бид өөрсдөө, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ байж болно.)

Биднийг бусдад үйлчлэх үед бидний тусалсан хүмүүс баяртай байдаг төдийгүй, бид бас өөрсдөө баяртай байдгийг онцлон тэмдэглэ.

- Бусдад үйлчлэх нь яагаад таныг баяртай болгодог вэ?

Дуу

“Би Аврагчийнхаа Хайрыг Мэдэрдэг” дууны дөрөвдүгээр бадгийг дуулах буюу үгийг нь хэл. (Хэрэв хүүхдүүд дөрөвдүгээр бадгийг мэдэхгүй байвал, та өөрөө уг бадгийг дуулах буюу үгийг нь хэлээд дараа нь хүүхдүүдийг өөртэйгөө хамт дуулуулах буюу үгийг давтан хэлүүл.)

Дүгнэлт

Урлан бүтээх үйл ажиллагаа

Сүм дээр эсвэл гэр орондоо өнөөдөр тэдний гүйцэтгэж болох үйлчлэлийн энгийн үйлдлүүдийн тухай бодож олоход нь хүүхдүүдэд тусал. Хүүхдүүдэд цаас, будгийн харандаанууд буюу харандаанууд өгч өнөөдөр өөрсдийн хийх үйлчлэлийн зургийг хүүхэд бүрээр зуруул. Зурсан зургуудыг нь хүүхдүүдээр бие биенд нь үзүүл.

Хэн нэгэн хүнд үйлчилснээрээ адислагдсан тохиолдлынхоо тухай хүүхдүүдэд ярь. Жинхэнэ баяр баясгалан бусдад үйлчлэхээс ирдгийг гэрчил.

Энэ долоо хоногт тэд бусдад үйлчилж болох арга замуудыг эрж хайхад нь хүүхдүүдийг урамшуул. Тэдний үйлчлэлийн туршлагынх нь талаар дараагийн удаа ангид нь та яриулахыг хүсч болно.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хичээлийн үед хүүхдүүдийн үзүүлж болох үйлчлэлийн үйлдлийн талаар жүжигчлэн тоглоход урьдчилан бэлтгэ (Энэхүү үйлчлэлийн үйл ажиллагаа Хүндэтгэлийн өдөрт тохирсон байхыг анхаар).

Жишээ нь:

- Хүүхэд асрахын багштай хамтран асрахын хүүхдүүдэд Хүүхдийн Хэсгийн дуртай дууг дуулж өгөх ажлыг зохион байгуул.
- Хүүхдийн хэсгийн хөгжимчин, удирдаач нарт талархлын хуудас хийх материалуудыг авчир.
- Самбар арилгах болон сандлуудыг хураах зэрэг дараагийн хичээлд анги танхимыг бэлтгэхэд шаардлагатай зүйлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал.

Үйлчлэлийн үйлдлийг хүүхдүүд хийж дууссаны дараа үйлчлэлийн талаар ямар сэтгэгдэл төрснийг нь тэдэнтэй ярилц. Үйлчлэл биднийг баяртай болгодгийг тэдэнд сануул.

2. Хүүхэд бүрт зориулан гурван жижиг цаасан зүрх хий. “Үйлчлэлийн Нууц Клуб” эхлүүлэх гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Эдгээр зүрхүүдийг гэртээ хийж, үйлчлэлийн нууц үйлдлүүдийг гэр бүлийнхээ гишүүдэд зориулан хийж, үйлчлэл хийсэн газар бүртээ зүрх үлдээхэд нь хүүхдүүдийг урамшуул. Жишээ нь, ах, эгч, дүүгийнхээ орыг засах буюу хурааж дэрэн дээр нь зүрх үлдээж болно. Бусдад нууцаар үйлчилсэн үед төрсөн сэтгэгдлийнх нь тухай дараагийн долоо хоногт ярихыг хүүхдүүдээс хүс.
3. “Би Христтэй Адил Болохыг Хичээнэ” (*Children’s Songbook*, х. 78) дууны хоёрдугаар бадгийг дуулах буюу үгийг нь хэлүүл. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
4. Хүүхдүүдийг шалан дээр тойрог болгон суулга. Зөөлөн даавуун бөмбөг буюу өөр зөөлөн зүйлийг хүүхэд рүү зөөлөн шидэж, хэн нэгэнд үйлчлэх арга замын талаар түүнээс асуу. Хүүхэд хариулаад давуун бөмбөгийг тойрог дахь аль нэг хүүхэдэд шидэж өг. Хүн бүр наад тал нь үйлчлэлийн нэг үйлдэл нэрлэх хүртэл үргэлжлүүл.
5. Хэрэв танай бүсэд байдаг бол *The Worth of Souls* (53147) видео хуурцагны “The Gift” (16 мин.)-ийг Иосеф Фийлдинг Смитийн тухай түүхийг ярихын оронд үзүүл.

6. Хэрэв тэд бусдад үйлчлэхийг хичээвэл дараах нөхцөл тус бүрт хүүхдүүд юу хийхийг ярилцах буюу дүрслэн үзүүл (шаардлагатай бол ангийнхаа хүүхдүүдэд тохируулан нөхцөлүүдийг хялбаршуул)
- Чи хөл бөмбөг тоглохоор замдаа явж байлаа. Чи яарч явлаа, гэвч тоглоомын талбай руу очих замдаа нэгэн настай эмэгтэй хүнсний зүйл хийсэн цүнхээ унагахыг харжээ.
 - Чи найзынхаа гэрт тоглож байлаа. Чи их ядарчээ. Хашаа руугаа хүрч иртэл аав чинь цэцэрлэгт ажиллаж байхыг харав.
 - Юм уухаар галын өрөө рүү орж иртэл, дүүгээ сав суулга угааж байхыг чи харжээ.
 - Чи зарим найз нарынхаа хамт гэр лүүгээ явж байлаа. Хөршийн чинь хашаанд нэг нохой хогийн сав ухаж, эргэн тойронд хог тарааж байгааг харжээ. Хөрш чинь эзгүй байгаа бөгөөд хэд хоногийн дараа ирэх байлаа.
 - Чи сургууль дээр нэг шинэ охиныг хараад өөрийгөө танилцуулжээ. Шинэ охин чамайг үдийн хоолоо хаана иддэг вэ гэж асуув. Чи үдийн хоолоо найз нартайгаа хамт идэхээр төлөвлөсөн байв.
 - Танай гэр бүл сүмд явахаар бэлэн болжээ. Аав чинь хуралд оролцох байсан учир аль хэдийн явчихсан байв. Сүмд явахад нь бэлтгэхэд туслах хэрэгтэй хэд хэдэн эрэгтэй эмэгтэй дүү чамд байдаг.

Зорилго

Бид Есүс Христийн нэгэн адил бусдыг уучилсан үед аз жаргал ирдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Лук 23:13–34, Иохан 18:12–14, 19–24; 19:1–5-ыг залбиралтайгаар судал.
2. “Эцэг Минь, Надад Туслаач” (*Children’s Songbook*, х. 99) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
3. Дараах үгстэй цаасан туузыг бэлтгэ:

“Аав аа, тэднийг уучлаач;
учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна.”

4. Тө өөрөө уучилсан тохиолдлынхоо тухай тэрчлэн уучилсан нь танд ямар сэтгэгдэл төрүүлсэн тухайгаа ярихад бэлтгэ.
5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. ЗС уриа (хичээл 1-ийг үз).
 - в. Шохой, самбар болон арилгагч.
 - г. Зураг 2-56, Есүсийг Шүүсэн нь; зураг 2-61, Цовдлолт (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 230; 62505).
6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга. Үйлчлэлийнхээ туршлагын талаар ярихыг нь та хүүхдүүдээс хүсч болох юм.

Бид Бусдыг Уучилж Чадна

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Өөрийгөө дараах нөхцөлийг дүрсэлж байх үед анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс (ангийнхаа хүүхдүүдэд тохируулан энэ нөхцөлийг шаардлагатай бол хялбаршуулан ашигла):

Чи гартаа хүнд номнууд, цаас (бусад зүйлүүд) барьж явган явж байлаа. Гэнэт нэг хүн чамайг түлхчихэв. Чи газар унаад, авч явсан зүйлүүдээ ч газарт унагачихлаа. Чиний ном, цааснууд газраар нэг таржээ.

- Иймэрхүү зүйл чамд тохиолдож байсан уу?
- Чамд ямар санагдсан бэ?

Энэ нөхцөлийн хоёр өөр төгсгөлийг та дүрслэх гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Аль төгсгөл нь дээр болохыг тэднээс асуу.

Төгсгөл 1

Унаж, хамаг юмаа унагасандаа чи уурлана. Нөгөөх хүн чам руу гүйж ирэн уучлал гуйж, ном цааснуудаа газраас авахад чинь тусалъя гэхэд чи, “Үгүй!” гэж ууртай дуугаар хэлээд түүнийг цааш нь түлхэнэ. Маргааш түүнийг олон юм авч явахтай таарвал чи түүнийг түлхэн унагана гэдэгт найдна.

Төгсгөл 2

Унаж, хамаг юмаа унагасандаа чи уурлана. Нөгөөх хүн чам руу гүйж ирэн уучлал гуйж, ном цааснуудаа газраас авахад чинь тусалъя гэхэд чи, “Баярлалаа танд” гэж хэлнэ. Та хоёр ном, цааснуудыг хурдан цуглуулж авна. Тэр хүн чамайг санаатай түлхэж унагаагүй гэдгийг мэдэж байна гэж чи тэр хүнд хэлээд, та хоёр хоёул баяртайгаар салж явна.

- Энэ түүхийн аль төгсгөл илүү дээр вэ?
- Яагаад хоёр дахь төгсгөл нэгдэхээс илүү сайн бэ?
- Хэн нэгэн хүн бидний дургүй юмыг буюу биднийг гомдоох, уурлуулах зүйл хийсэн үед бид яах ёстой вэ? (Бид тэднийг уучлах ёстой.)

Багшийн
танилцуулга

Хүнийг уучилна гэдэг нь хэдийгээр тэр хүн биднийг гомдоосон эсвэл уурлуулсан ямар нэг зүйл хийсэн байлаа ч гэсэн хайр, эелдэг найрсаг мэдэрэмж төрөх явдал мөнийг тайлбарла. Зарим үед уучлах нь бид тэр хүнд уурласан мэдрэмжээ эелдэг найрсаг мэдрэмж болгон солих явдал байдаг. Бид бусдыг уучилсан үед, тэднийг гомдоох буюу тэднээс хариу авах хүсэл бидэнд төрдөггүй. Хэдийгээр тэд бидэнд найрсаг биш байлаа ч гэсэн бид тэдэнд эелдэг найрсаг байдаг.

Есүс Христ Бусдыг Уучилсан

Сударын түүх

Библийг үзүүлж, Есүс Христ өөрийг нь гомдоосон хүмүүсийг хэрхэн уучилсан тухай нэг түүхийг та Библиэс ярих гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. Христийг шүүсэн болон цовдолсон тухай Лук 23:13–34 болон Иохан 18:12–14, 19–24; 19:1–5 дахь түүхийг ярь.

Есүс болон түүний төлөөлөгчид сүүлчийн үдшийн зоогийг хамт идсэний дараа Есүс Гетсеманийн Цэцэрлэгт очиж, Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахаар явжээ. Есүсийг залбирч дууссаны дараа хэсэг цэрэг ирж, түүнийг олсоор хүлэн ахлах санваартны ордонд аваачиж түүнийг шүүх хуралд оруулжээ.

Есүсийг Шүүсэн нь, зураг 2-56-г үзүүл.

Шүүх хурлын үеэр цэргүүд Есүсийн талаар олон найрсаг бус зүйлийг хийжээ. Тэд түүнийг цохиж, ташуурдан, нулимж, тэргүүн дээр нь өргөст титэм өмсгөн доромжилжээ. Гэвч Есүс уурлаагүйг онцлон тэмдэглэ.

Цовдлолт, зураг 2-61-ийг үзүүл.

Шүүх хурлын дараа цэргүүд Есүсийг Калвари гэдэг газарт аваачиж, түүнийг загалмайд хадсаныг хүүхдүүдэд ярь. Цэргүүдийн түүний талаар хийсэн зүйлүүдэд Есүс уурлаагүйг тайлбарла. Үүний оронд цэргүүдийг уучлахыг тэрээр Тэнгэрлэг Эцэгээс гуйжээ.

Судар ба цаасан
туузан дээрх үгс

Үхэхийнхээ өмнөхөн Есүсийн хэлснийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Лук 23:34-ийн эхний өгүүлбэрийг чанга унш.

Цаасан туузан дээрх үгсийг үзүүлж, үүнийг хичээлийн үлдсэн хугацаанд харагдах газарт тавь. Есүсийн үгсийг өөртэйгөө хамт хүүхдүүдээр давтан хэлүүл.

Хэдийгээр цэргүүд Есүст найрсаг бус байсан ч гэсэн тэр тэднийг уучилж, бас тэднийг уучлахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйсныг онцлон тэмдэглэ.

Бид Бусдыг Уучлахад Баяр Хөөр Ирдэг

Багшийн
танилцуулга

Түүний хийснийг бид хийхээр хичээсэн үед бид Есүс Христийн дагалдагчид болдгийг хүүхдүүдэд сануул. Өөрт нь найрсаг бус байсан хүмүүсийг Есүс үргэлж уучилдаг байв. Бид ч бас бидэнд найрсаг бус байдаг хүмүүсийг уучлах ёстой.

Дуу

“Эцэг Минь, Надад Туслаач” дууллын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэл. Дууллын үгийг анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Бусдыг уучлах нь хичнээн чухал болохыг ойлгоход бидэнд туслахын тулд энэ дууллын үгс залбиралтай адилхан бичигдсэнийг онцлон тэмдэглэ.

Надад найрсаг бус мэт санагдах бүх хүнийг
Чөлөөтэйгөөр уучлахад надад туслаач, хүндэт Эцэг минь
Өдөр бүр надад туслаач, Аав минь, би залбиръя;
Танд ойрхон, ойрхон амьдрахад надад туслаач.

Хүүхдүүдийг босгож, өөртэйгөө хамт дууг дуулах буюу үгийг нь хэлүүл.
Тэд дуулах үедээ үгсийн утгын тухай бодохыг нь урамшуул.

Түүх ба
ярилцлага

Хэрхэн уучлахыг мэддэг байсан хүүгийн тухай дараах түүхийг ярь:

Кентийн ээж хашаагаа цэвэрлэхийг түүнээс гуйжээ. Хашаан дотор моднуудаас унасан навч, жижиг мөчрүүд, ургамлуудыг тэр хаман цуглуулж байв. Кент шаргуу ажиллаж, тэгээд эцэст нь бүх навч мөчрүүдийг хамж том гэгч нь овоолжээ. Тэгтэл Жэд гудамж уруудан ирж, овоолсон навч мөчир лүү гүйж ирээд, навч мөчрүүдийг тал тал тийш нь өшиглөжээ. Кентийн хийсэн бүх ажил хэдхэн агшны дотор юу ч үгүй болох нь тэр.

- Жэдийг ингэхэд Кентэд ямар санагдсан гэж та нар бодож байна?

Жэдийн юу хийснийг Кентийн ах харжээ. Кент Жэдийг хөөж барьж аваад овоолсон навч мөчрийг тараасны төлөө зодох байх гэж тэр бодож байлаа.

- Кент яаж болох вэ?

Хэд хэдэн хувилбараар саналаа хэлэхэд нь хүүхдүүдэд тусал. Дараа нь түүхийг төгсгө:

Кент Жэдийн хойноос гүйлээ. Гэвч Жэдийг цохиод авахын оронд тэр өдөр хийх ажил түүнд үлдсэн эсэхийг Кент түүнээс асуужээ. Жэд толгой дохив.

Хэрэв Жэд навчуудыг хамж, дахин овоолоход тусалвал, Жэдийн ажилд тусалъя гэж Кент санал болгов. Жэд зөвшөөрч, тэгээр тэр хоёр хамтдаа ажиллаж цагийг сайхан өнгөрүүлжээ.

Ярилцлага

Хэрэв бид бусдыг уучилж, тэдэнд найрсаг хандах юм бол, бид дотоод сэтгэлдээ баяртай байх болно гэдгийг тайлбарла. Хэрэв бид уучлахгүй бол бид гомдсон буюу уурласан хэвээр байх бөгөөд бид баяртай байж чадахгүй. Бид баяртай байхын тулд бусдыг уучлах хэрэгтэй.

Зарим нөхцөлүүдийг хүүхдүүдэд дүрсэлж, тухайн нөхцөлд хүүхэд уучлал үзүүлж үү үгүй юу гэдгийг ярилц. Хэрэв дүрслэгдсэн хүүхэд уучлал үзүүлээгүй бол, тэр хүүхэд уучилж, дотроо баяртай байхын тулд юу хийх ёстойг хүүхдүүдээс асуу.

Доорх нөхцөлүүдийг ашиглах буюу зарим нөхцөлийг өөрөө зохио:

1. Жан гоё сайхан зураг зурж дуусгаад байтал жаахан эрэгтэй дүү нь орж ирээд зургийг нь будгийн харандаагаар сараачаад хаячихжээ. Жан ихэд уурлаж, уйлан дүүгийнхээ гар луу нь алгадаад авчээ.
 - Жан дүүгээ уучилсан уу?
 - Жан санаа дотроо ямар байсан гэж та нар бодож байна?
 - Дүүгээ уучлахын тулд Жан яах ёстой байсан бэ?
2. Тоглоомын талбай дээр Донна Кали руу хүрч ирээд түүнийг түлхэж унагаажээ. Донна инээсээр гүйгээд явчихав. Маргааш нь Донна дүүжин даажингаас унаж, өвдгөө бэртээчихэж. Кали яаран гүйж ирээд босоход нь түүнд туслав.
 - Кали Доннаг уучилсан уу?
 - Кали дотроо ямар сэтгэгдэлтэй байсан гэж та нар бодож байна?
3. Чад усан оргилуураас ус уух гэж хүлээж байтал түүний өмнөх хүүхэд эргэж түүн рүү ус цацжээ. Чадын нүүр нэлдээ нойтон болсон ч гэсэн тэр эргэж ганц ч үг хэлэлгүй яваад өгөв. Маргааш нь Чадыг ус ууж байтал нөгөөх хүүхэд хажуугаар нь өнгөрөв. Чад тэр хүүхэд рүү ус цацаж болох байсан хэдий ч, тэр тэгсэнгүй.
 - Чад тэр хүүхдийг уучилсан уу?
 - Чад дотроо ямар сэтгэгдэлтэй байсан гэж та нар бодож байна?

Дүгнэлт

Үйл ажиллагааг нэгтгэн дүгнэ

1-ээс 8-ын тоог самбар дээр жагсаан бич. Тоо тус бүрт тохирох асуултыг хариулж, тоог хүүхдүүдээр ээлжлэн арилгуул. Хэрэв танай анги олон хүүхэдтэй бол, та илүү олон асуулт зохиох хэрэгтэй.

1. Бусдыг уучлах гэдэг нь юу гэсэн үг вэ?
2. Есүс Христ өөрийг нь загалмай дээр дүүжилсэн цэргүүдтэй хэрхэн харьцаж байсан бэ?
3. Цэргүүдийг яахыг Есүс Христ Тэнгэрлэг Эцэгээс гуйсан бэ?
4. Овоолсон навчуудыг өшиглөж тараахад Кентэд ямар санагдсан гэж та нар бодож байна?
5. Кент Жэдийг хэрхэн уучилсан бэ?
6. Жэдийг уучилсан үед Кентэд ямар санагдсан гэж та нар бодож байна?
7. Кент хариугаа авахын оронд түүнд найрсаг хандахад Жэдэд ямар санагдсан гэж та нар бодож байна?
8. Бидэнд найрсаг бус байдаг хүмүүсийг бид уучлахад бидэнд ямар санагдах вэ?

ЗС уриа ба бөгж

ЗС уриаг үзүүл. Уриан дээрх үгсийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Бид Есүсийн нэгэн адил бусдыг уучилснаар бид зөвийг үйлддэг гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

Хүүхдүүд ЗС бөгжөө зүүсэн эсэхийг нь хүүхдүүдээр харуул. Бусдыг уучилснаар зөвийг сонгохыг тэдэнд сануулахад бөгж нь тусалж чадна гэдгийг хүүхдүүдэд хэл.

Бусдыг уучилж, тэдэнд найрсаг хандахад бид баяртай байж чаддагийг гэрчил. Та зөвийг сонгож, бусдыг уучилсан үеийнхээ тухай ярь. Та уучлах хүсэлтэй байсан учир тэр хүний талаар ямар бодолтой байснаа тайлбарла.

Хэрэв цаг гарвал, тэд хэн нэгнийг уучилсан үеийнх нь талаар хүүхдүүдээр яриул.

Энэ долоо хоногт бусдыг уучлах тусгай хүч чармайлт гаргахад хүүхдүүдийг урамшуул. Уучлалын талаар гэрийнхэнтэйгээ ярилцахыг хүүхдүүдэд санал болго.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Бусдыг уучлахад нь хүүхдүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг уг хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Том цүнх, хэдэн чулуу авчир. Хүмүүс бидэнд найрсаг бус байхад бид хэрхэн уурлаж, хариугаа авахыг эрэлхийлдэг тухай хүүхдүүдтэй ярилц. Энэ ярилцлагын үед чулуунуудыг нэг нэгээр нь цүнхэнд хий.

Цүнхэнд нилээд хэдэн чулуу орсон үед хүүхдүүдээр ээлжээр цүнхийг авч явуул. Цүнхийг авч яваа үед алга таших буюу хэн нэгнийг тэврэхийг хүүхдүүдээс хүс. Тэдний үйлдсэн найрсаг бус зүйлүүдийн улмаас бусдад уурлах нь цүнхтэй чулуу авч явахтай адил юм гэдгийг тайлбарла. Энэ бол бидний хувьд хүнд дарамт байдаг.


Таныг цүнхнээс чулуу гаргаж авахад “Би уучлах болно” гэдэг үгийг хүүхдүүдээр нилээд хэдэн удаа давтан хэлүүл. Тэгээд цүнхийг хүүхдүүдээр дахин авч явуул. Бид бусдыг уучилснаараа хүнд ачаа дарамтыг дахин авч явахгүй байх болно гэдгийг тайлбарла. Бид уучилсан үедээ их баяртай байдаг.

2. “Миний Хийсний Адилаар Хий” (*Children’s Songbook*, х. 276) дууг дуулах буюу үгийг нь хэл. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.

Хийх үйлдлүүдийг хүүхдүүдээр ээлжээр сонгуулан дууг хэдэн удаа давт. Бид хэн нэгнийг дагах юм бол тэдний хийдгийг хийдэг гэдгийг хүүхдүүдэд сануул. Хэрэв бид Есүс Христийн дагалдагчид байхыг хүсвэл, бидэнд найрсаг бус байдаг хүмүүсийг бид уучлах түүний хийдгийг бид хийх ёстой.

3. Эхлэл 37, 41–45 дахь Иосеф болон түүний ах нарын тухай түүхийг ярь. Та уг түүхийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуулж болно. Иосеф ах нараа хэрхэн уучилсныг хүүхдүүдтэй ярилц (Эхлэл 45:1–15-ыг үз).
4. Хичээлийн төгсгөл дэх зургийн хувийг хүүхэд болгонд бэлтгэ. Хүүхдүүдэд будгийн харандаа буюу харандаа өгч зураг дээрх хүүхдүүдэд баясгалантай нүүр зуруул. Дараа нь зургуудыг тэднээр будуул. Зургуудыг гэртээ аваачиж, бусдыг уучлахыг тэдэнд сануулж байх газарт тавихыг хүүхдүүдээс хүс.
5. Кентийн тухай түүх болон хичээлийн 219–20 дугаар хуудсан дахь гурван нөхцөлийг (эхний нөхцөлд Жан дүүгээ хэрхэн уучилсан тухай хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул) хүүхдүүдээр биечлэн тоглуул. Эсвэл ангийнхаа хүүхдүүдийн хувьд тохирох адил төстэй зарим нөхцөлүүдийг зохиож, хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул.

Уучлах нь Биднийг Баяртай Болгодог



Зорилго

Есүс Христ амилсан учраас хүн бүгд амилуулагдах болно гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 27:45–66, 28:1–8, Лук 24:13–46, түүнчлэн Иохан 19:30, 20:11–18-ыг залбиралтайгаар судал. Мөн *Gospel Principles* (31110), бүлэг 11, 12-ыг үз.
2. Зураг 2-65, Амилсан Есүс Христ (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 239; 62187)-тай адил хэмжээтэй хуудас цаасыг найман хэсэг болгон хайчил. Хэсгүүдийг 1-8 хүртэл дугаарла. Зураг 2-65-ыг зурагт харуулсны адилаар хэсгүүдийг зурагт бичгийн хавчаар буюу жижиг туузуудаар бэхэлж бүр.

1	2
3	4
5	6
7	8

3. “Тэр Боссон!” дууллын (*Hymns*, no. 199) эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэх буюу энэ дууны бичлэгийг авчир.
4. Шаардлагатай матераилууд:
 - а. Библи.
 - б. Хайчилбар 2-5, Цовдлолтын байдал; хайчилбар 2-6, Есүсийн биеийг ороосон нь, хайчилбар 2-7, булш; хайчилбар 2-8, том чулуу; хайчилбар 2-9, харуулууд; хайчилбар 2-10, тэнгэр элч; хайчилбар 2-11, тостой эмэгтэйчүүд; хайчилбар 2-12; Есүс амилав. Эдгээр хайчилбаруудыг хичээлд ашиглахын тулд дэс дарааллаар нь байрлуул.
 - в. Зураг 2-2, Нялх Хүүхэдтэй Гэр бүл (62307); зураг 2-35, Христ ба Хүүхдүүд (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 216; 62467), зураг 2-62, Мари ба Амилсан Их Эзэн (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 233; 62186), зураг 2-63, Эммау Хүрэх Зам Дээр; зураг 2-64, Есүс Шархаа Үзүүлж Байгаа нь (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 234; 62502).
5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христ Бидний Төлөө Бидний Хийж Чадаагүй Зүйлийг Хийсэн

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Нялх Хүүхэдтэй Гэр Бүл, зураг 2-2-ыг үзүүл. Тэд нялх хүүхэд болж дэлхийд анх удаа ирсэн үеийнх нь тухай хүүхдүүдээр бодуул.

- Чамайг өөрөө юу ч хийж чадахгүй байхад эцэг эхчүүд чинь (эсвэл гэр бүлийн бусад гишүүд) чиний төлөө юу хийдэг байсан бэ?

Тэдний төлөө эцэг эхийнх нь (эсвэл гэр бүлийн бусад гишүүд) хийдэг байсан зүйлүүдийн тухай бодоход нь хүүхдүүдэд тусал. Хүүхэд бүр наад тал нь нэг зүйл нэрлэхэд анхаар.

- Одоо чиний өөрийнхөө төлөө хийж чаддаггүй ямар зүйлүүдийг эцэг эхчүүд чинь (эсвэл гэр бүлийн бусад гишүүд) чиний төлөө хийдэг вэ?
- Яагаад тэд эдгээр зүйлүүдийг чиний төлөө хийдэг вэ?

Бидний эцэг эхчүүд болон гэр бүлийн бусад гишүүд бидний төлөө хийж чадахгүй зүйлүүдийг маань хийхдээ баяртай байдаг, учир нь тэд бидэнд хайртай бас бидэнд туслахыг хүсдэг.

Ярилцлага

Өөр хэн нэгэн бидэнд маш хайртай бөгөөд бидний өөрсдийнхөө төлөө хийж чадахгүй нэг зүйлийг хийх хүсэлтэй байдгийг тайлбарла.

Христ ба Хүүхдүүд, зураг 2-35-ыг үзүүл.

- Бидэнд хайртай энэ хүн хэн бэ?

Биднийг энэ дэлхийд ирэхээс өмнө Есүс Христ бидний Аврагч байхаар санал гаргасныг тайлбарла. Энэ нь бид тэнгэр дэх Эцэгтээ эргэж очин түүнтэй хамт амьдарч чадахын тулд тэр хүн үхэж, дахин амилахад бэлэн байсан гэсэн үг юм. Есүс бол бидний төлөө үүнийг хийх хүчтэй цорын ганц хүн байлаа. Үүнийг бид өөрсдийнхөө төлөө хийж чадахгүй билээ.

- Амилуулагдах гэж юу гэсэн үг вэ?

Бид нас барахад бидний сүнс биеэс маань салдгийг тайлбарла. Есүсийг үхсэний дараа түүний сүнс, бие хоёр амилуулагдсан бие болон нэгдсэн бөгөөд үүрд амьдрах болно. Есүс үхэж, дахин амилсан болохоор, бид бас амилуулагдах болно.

Есүс Христ Амилсан Билээ

Багшийн
танилцуулга

Бидний Аврагч Есүс Христийн амилалт бол юу тохиолдсоныг санахад бидэнд тусалдаг, жил бүр тусгай өдөр болгон бидний тэмдэглэдэг нэн чухал үйл явдал мөн гэдгийг тайлбарла.

- Энэ онцгой өдрийг бид юу гэж нэрлэдэг вэ? (Улаан Өндөгний Баяр)

Улаан Өндөгний Баяраар бид Есүс Христийн амилалтын талаар мэдэж авдгийг хүүхдүүдэд сануул.

Судрын түүх ба
хайчилбарууд

Есүс Христийн цовдлолт, оршуулга болон амилалтын тухай түүхийг ярь (Матай 27:45, 57–66; 28:1–6; Иохан 19:30-ийг үз). Холбогдох үед нь хайчилбаруудыг хүүхдүүдээр дээш нь өргүүл.

Цовдлолтын байдал, хайчилбар 2-5-ыг нэг хүүхдээр өргөж харуул.

Үд дунд болохоос өмнө Есүсийг загалмайд байрлуулсныг тайлбарла. Үд дунд нар харагдахгүй болж, газар дээр гурван цагийн турш харанхуй болжээ (Матай 27:45-ыг үз). Христийн өвдөлт бидний тэсвэрлэж чадахаас хэт

их байлаа. Христ зовохгүй, бас үхэхгүй байхаар сонгож болох байв, гэвч тэр дэлхийд ирж, бидний төлөө зовж, үхэхээр Тэнгэрлэг Эцэгт амласан байв.

Газар доргин чичирснийг хүүхдүүдэд ярь. Харанхуйд харж байсан хүмүүс “Энэ нь төгслөө” гэж Есүс чангаар хашгирахыг сонсчээ (Иохан 19:30-ийг үз). Түүний зовлон төгсөв. Тэр тэргүүнээ унжуулан, наснаас халив. Түүний сүнс биеийг нь орхижээ.

- Есүсийг цовдлогдсоны дараа түүний найз нар, шавь нарт хэрхэн санагдаж байсан гэж та нар боддог вэ?

Цовдлолтын байдлын хайчилбарыг нэг хүүхдээр доош нь тавиул.

Есүсийн цогцсыг ороосон нь, хайчилбар 2-6-г нэг хүүхдээр өргөж харуул.

Есүсийн найз нар болон шавь нар түүний цогцсыг загалмайнаас бол-гоомжтойгоор буулгаж авсныг тайлбарла. Тэд тэр үеийн заншлаар түүний цогцсыг халуун ногоотой нарийн зотон даавуугаар ороов.

Булш, хайчилбар 2-7-г нэг хүүхдээр өргөж харуул.

Аврагчийн найз нар, шавь нар түүний цогцсыг булшинд тавьсныг тайлбарла. Булш нь ихэвчлэн том хаднаас гаргасан, дотор нь хүн оршуулдаг, жижигхэн өрөө мэт агуй байв.

Есүсийн цогцсыг ороосон нь, хайчилбарыг нэг хүүхдээр доош тавиул.

Том чулуу, хайчилбар 2-8 болон харуулууд, хайчилбар 2-9-ийг хүүхдүүдээр өргүүл.

Булшны аман дээр том чулуу тавьж, чулууны хажууд харуулууд зогсож байсныг хүүхдүүдэд ярь.

- Яагаад булшны хаалган дээр чулуу тавьж, харуулууд байрлуулсан бэ? (Матай 27:62–66-г үз)

Есүсийн цогцос булшинд гурван өдөр байсныг тайлбарла. Гурав дахь өдөр нь бас Ням гарагт эрт газар дахин доргиж, чичирхийлжээ (Матай 28:1–2-ыг үз).

Тэнгэр элч, хайчилбар 2-10-ыг нэг хүүхдээр өргүүл.

Тэнгэр элч тэнгэрээс бууж ирэн, булшны хаалган дээрх чулууг гэдрэг нь өнхөрүүлснийг тайлбарла.

Том чулууны хайчилбарыг нөгөөх хүүхдээр доош буулгуул.

- Булшийг манаж байсан хүмүүст юу тохиолдсон бэ? (Матай 28:4-ийг үз.)

Харуулуудын хайчилбарыг нэг хүүхдээр буулгуул.

Тостой эмэгтэйчүүд, хайчилбар 2-11-ийг нэг хүүхдээр өргүүл.

Тэр Ням гарагийн өглөө Есүсийн дагалдагч, Магдалын Мари өөр нэг эмэгтэйн хамт булшин дээр хүрч иржээ (Матай 28:1-ийг үз). Тэд Есүсийн цогцос дээр тос түрхэж халуун ногоо тавихыг хүссэн аж (энэ бол тэр үеийн заншил байв). Тэд булшинд ойртож ирээд, чулуу хажуу тийшээ өнхөрснийг харав. Булш хоосон байв. Есүсийн цогцос тэнд байхгүй байв.

Айх хэрэггүй гэж тэдэнд хэлсэн тэнгэр элчийг тэр хоёр эмэгтэй харсныг тайлбарла. Тэнгэр элч эмэгтэйчүүдэд юу гэж хэлснийг Матай 28:5–6-гаас чанга унш.

Бүх хүүхдүүдээр хайчилбаруудыг нь доош буулгуул. Есүс Амилсан нь, хайчилбар 2-12-ыг нэг хүүхдээр өргүүл.

“Тэр боссон” гэж тэнгэр элч эмэгтэйчүүдэд хэлсэн нь Есүс Христ амилсан гэснийг тайлбарла. Түүний сүнс биенд нь эргэн ирж, тэр дахин амьд болжээ.

Есүсийн найз нар, шавь нар нь түүнийг дахин амьд болсныг сонсоод маш их баяртай байсныг хүүхдүүдэд хэл.

Дуу

“Тэр Амилсан” дууллын эхний бадгийг та дуулах буюу хөгжимд тоглох үед нөгөө хүүхэд амилсан Есүсийн хайчилбарыг өргөсөн хэвээр байна. Дараа нь уг хайчилбарыг тэр хүүхдээр буулгуул.

Тэр амилсан! Тэр амилсан!
Баяртай дуугаар үүнийг зарла.
Гурван өдрийн шоронгоосоо тэр босон;
Бүх газар дэлхий өргөнөөр баясаг.
Үхлийг байлдан дагуулж, хүмүүн чөлөөтэй болов.
Христ тийн ялалт байгуулав.

Магдалын Мари болон Өөрийн Шавь Нар Дээр Есүс Христ Хүрч Ирэв

Ярилцлага

Мари ба Амилсан Их Эзэн, зураг 2-62-ыг үзүүл.

Есүс Христ амилсныхаа дараа өөрийн зарим дагалдагчид дээр хүрч ирснийг тайлбарла. Магдалын Мари бол түүнийг анх харсан хүн юм (Иохан 20:11–18-ыг үз). Есүс түүн рүү хүрч ирэхэд Мари булшны дэргэд уйлж байжээ.

- Есүсийг хараад, тэр дахин амьд болсныг мэдсэн Марид ямар санагдсан гэж та нар бодож байна?

Судрын түүх

Эммау Хүрэх Зам Дээр, зураг 2-63-ыг үзүүлж, Лук 24:13–46 дахь түүхийг ярь.

Есүсийг тэдэнтэй ярьж эхлэхэд хоёр шавь нь түүнийг таниагүйг тайлбарла. Шавь нар нь тэр өдөр булшны дэргэд болсон явдлын талаар Есүст бүгдийг ярьжээ. Есүс тэдэнтэй хамт оройн хоол идэхээр саатаж, хэсэг талх авч үйрүүлээд, үүнийг адисалж, шавь нартаа өгчээ. Тэгэхэд тэд түүнийг хэн болохыг таньсан аж. Тэгээд Есүс тэдний хараанаас алга болжээ.

- Есүсийг харсны дараа шавь нарт нь ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Хэрэв чи түүний шавь нарын нэг байсан бол, мөн Есүсийг харсан бол чи яах байсан бэ?

Тэр хоёр шавь Есүсийг харснаа бусад шавь нарт хэлэхээр Иерусалим уруу яаран гарсныг тайлбарла. Тэр хоёр болсон явдлын тухай бусаддаа ярьж байтал Есүс хүрч иржээ.

Лук 24:36–37-г чанга унш. Шавь нар нь Есүсийг хараад айсан аж, учир нь тэр бол сүнс байх гэж тэд бодсоныг тайлбарла.

Есүс Шархнуудаа Үзүүлсэн нь, зураг 2-64-ийг үзүүл.

Тэр амилсныг тэд мэдэхийн тулд Есүс өөрийн биед хүрэхийг шавь нараасаа хүссэнийг тайлбарла. Лук 24:39–40-ийг чанга унш.

Есүс бас идэх хоол гуйсныг хүүхдүүдэд хэл. Түүний мах яснаас бүтсэн бие сүнстэйгээ дахин нэгдэж амилсан бие болсныг шавь нартаа харуулахын тулд Тэрээр хоолыг иджээ (Лук 24:41–43-ыг үз).

Есүс Христ Амилсан Учраас Бид Амилуулагдах Болно

Багшийн
танилцуулга

Бүх хүмүүс нас барсныхаа дараа дахин амьдарч болно гэдгийг бидний Аврагч Есүс Христ амласныг хүүхдүүдэд хэл. Бид бүгд Есүс Христийн нэгэн адил амилуулагдаж, түүнийхтэй адил амилуулагдсан гайхамшигт биетэй болно. Есүс бидэнд хайртай учраас тэр үүнийг боломжтой болгосон юм.

Үйл ажиллагаа

Найман хэсэг цаасаар бүтээсэн зургийг үзүүл. Цааснуудын цаана нэгэн тусгай зураг байгааг тайлбарла. 1-ээс 8 хүртэлх дугаарыг хүүхдүүдээр ээлжээр сонгуул. Холбогдох асуултыг асууж, ангиар нь хариулуул (шаардлага гарвал хүүхдүүдэд тусал). Анги асуулт бүрт хариулсны дараа, холбогдох цаасыг нэг хүүхдээр авахуулж, зургийн тэр хэсгийг ил гарга.

Үйл ажиллагаанд дараах асуултуудыг ашигла (эсвэл зарим асуултуудыг өөрөө зохио):

1. Хэн амилуулагдах вэ? (Хүн бүгд.)
2. Амилуулагдах гэж юу гэсэн үг вэ? (Дахин амьдрах; үхлийн дараа бидний бие, сүнс хоёр дахин нэгдэх.)
3. “Тэр амилсан” гэж тэнгэр элч хэлсэн нь ямар учиртай байсан бэ? (Есүс Христ амилсан.)
4. Амилсныхаа дараа Есүсийн хийсэн зарим зүйл юу вэ? (Тэр явж, ярьж, хоол идэж, Магдалын Мари болон шавь нартаа үзэгдсэн, шавь нараараа өөрийн гар, хөлийг бариулж үзсэн.)
5. Бидний Аврагч хэн бэ? (Есүс Христ.)
6. Амилсныхаа дараа Есүс Христ хэн хэнд үзэгдсэн бэ? (Магдалын Мари болон өөр олон шавь нартаа.)
7. Одоо Есүс Христ амьд байгаа юу? (Тийм ээ, Тэнгэрлэг Эцэгтэй хамт тэнгэрт.)
8. Яагаад бидний төлөө үхэж, мөн амилах хүсэлтэй байсан бэ? (Тэр бидэнд хайртай бөгөөд биднийг өөртэйгөө болон Тэнгэрлэг Эцэгтэй хамт дахин амьдрах боломжтой байгаасай гэж хүсдэг учраас.)

Зургийг ил гарахад, энэ бол амилсан Есүс Христийн зураг гэдгийг тайлбарла. Бид энэ зургийг хараад, Есүс амилсан учраас хүн бүгд амилуулагдах болно гэдгийг санаж болно.

Дүгнэлт

Гэрчлэл

Есүс Христийг хайрлах хайрынхаа мэдрэмжийг хуваалцаж, түүний тухай түүний амилалтын тухай гэрчлэлээ хэл. “Тэр боссон” гэсэн мэдээ нь хүн бүхний хувьд сайн мэдээ юм гэдгийг хүүхдүүдэд сануул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Үхлийн дараа дахин амьдрахыг бидний хувьд боломжтой болгосон Өөрийн Хүү, Есүс Христийг илгээсний төлөө Тэнгэрлэг Эцэгт талархахыг уг хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт

буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Гар ба бээлийний тухай үзүүлэнт хичээлийг хичээл 3, (хуудас 13-ыг үз) нэгтгэн дүгнэ. Үхэх нь бээлийнээс гараа гаргахтай төстэй юм гэдгийг тайлбарлах замаар адил төстэй байдлыг үргэлжлүүл. Бие (бээлийтэй адил) хөдөлж чадахгүй, харин сүнс (гартай адил) амьд хэвээр байдаг. Амилуулалтад сүнс бие хоёр дахин нэгдэж, хоёул дахин амьд болдог.
2. Хүүхдүүдийг босгож, итгэлийн гуравдугаар тунхгийг өөртэйгөө хамт давтан хэлүүл. Есүс Христ үхэж, дараа нь амилсан учраас, хэрэв бид зарлигуудыг сахих юм бол, бид ч бас амилуулагдах болно, хэзээ нэгэн цагт бид Есүс болон Тэнэгрэлэг Эцэгтэй хамт дахин амьдрах болно гэдгийг тайлбарла. Итгэлийн энэ тунхгийг цээжлэхэд нь та хүүхдүүдэд тусалж болно.
3. “Есүс Үнэхээр Дахин Амилсан уу?” (*Children’s Songbook*, х. 64) дууг дуулах буюу үгийг нь хэл. Дор харуулсан үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Есүс үнэхээр дахин амьдарсан уу? (*Алгаа дээш нь харуулан гараа дэлгэ?*)
Тийм ээ, гурав дахь өдөр ирэхэд (*гурван хуруугаа дээш өргө*),
Тэр сэрж, булшийг орхисон (*байран дээрээ алхал*);
Марийг тэр нэрээр нь дуудсан (*хоёр гараа амаа тойруулан дугуйлж харуул*).

Есүс хайртай хүмүүс дээрээ ирсэн үү (*хоёр гараа зүрхэн тушаагаа тавина*)?
Тийм ээ, хүмүүс түүний хөлөнд хүрсэн (*бөхийж, хөлөндөө гараа хүргэнэ*),
Тэгээд загас, зөгийн бал
Тэр үнэхээр идсэн (*идэж байгааг үггүй хөдлөлөөр харуул*).

Түүний гарт хадаасны ором байлаа (*гар луугаа заана*)
Түүний хажуу талд шархны ором байлаа (*хажуу тал руугаа заана*)
Үхсэнийхээ дараа тэгээд
Есүс үнэхээр дахин амьдарсан уу? (*гараа дэлгэж, алгаа дээш нь харуулна*)
Өө тийм ээ! Би ч бас тэгнэ (*толгой дохино*)!
4. Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр хэсгийн буюу салбарын нэг гишүүнийг ангид ирж, Аврагчийг хайрлах өөрийнхөө хайр болон Амилуулалтын тухай гэрчлэлээ хуваалцахыг урь.
5. Хүүхдүүд нүдээ аньж, өөрсдийгөө хараагүй гэж бодохыг тэднээс хүс. Бид амилуулагдах тэр үед хараагүй буюу эсвэл аливаа тахир дутуу түүнээс хойш байхгүй болно гэдгийг тайлбарла. Бидний бие төгс болох болно. Хүн бүхэн харах, сонсох, гүйх боломжтой байх болно; хэнд ч бие бялдрын аливаа асуудал байхгүй болно. Хэн ч өвчлөхгүй. Хүүхдүүдийг нүдээ нээж, эрүүл, төгс төгөлдөр биетэй байх нь ямар гайхамшигтай байх талаар ярихыг тэднээс хүс.


Есүс Христийн Сүм Дэлхий Дээр Байдаг

Зорилго

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Христ дэлхий дээр байхдаа зохион байгуулсан тэр сүм мөн болохыг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 115:4-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 16, 17-г үз.
2. “Есүсийн Тухай Түүхүүдийг Надад Яриач” (*Children’s Songbook*, х. 57), “Есүс Христийн Сүм” (*Children’s Songbook*, х. 77) дуунуудын эхний бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
3. Хичээлийн төгсгөл дэх дэлхийн газрын зургийг үзэж, хүүхдүүдийн мэдэх зарим газар, түүний дотор өөрийн орныг ол.
4. Хичээлийн үед самбар, хана буюу шалан дээр дэлгэж харуулсан газрын зураг нь дараах байдлаар төгсөх хэрэгтэй:



5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи, Сургаал ба Гэрээ.
 - б. Наалддаг тууз буюу бусад наагч материал (сонголтоор).
 - в. Зураг 2-3, Есүс Христ (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 240; 62572); зураг 2-19, Иохан Баптист Есүст Баптисм Хүртээж Байгаа нь; (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 208; 62133); зураг 2-20, Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн (62018); зураг 2-37, Уулан Дээрх Номлол (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 212; 62166); зураг 2-38, Анхны Үзэгдэл (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 403; 62470); зураг 2-66, Христ Төлөөлөгчдийг Томилж Байгаа нь (*Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга* 211; 62557); зураг 2-67, Анхны Ариун

Ёслолыг Есүс Адисалж Байгаа нь; зураг 2-68 Мелкизедек Санваарын Сэргээлт (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 408; 62371); зураг 2-69; Ариун Ёслолоос Хүртэж Байгаа Хүүхэд; зураг 2-70, Дэлхий Дахины Хүүхдүүд.

6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христ Өөрийн Сүмийг Ариун Нутагт Байгуулсан нь

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Хичээлийн төгсгөл дэх дэлхийн газрын зургийг хүүхдүүдэд үзүүл.

- Энэ юу вэ? (Газрын зураг.)

Газрын зургийн тухай мөн тэдгээрийг юунд ашигладаг тухай товч ярилц. Газрын зураг дээр хүүхдүүд хаана амьдардгийг тэдэнд үзүүл. Хүүхдүүдийн мэддэг байж болох өөр зарим газрыг, тухайлбал номлогч нар энд хаанаас ирдэг буюу хаана үйлчилж байгаа, эсвэл хэсэг буюу салбар дахь шинэ гэр бүл хаанаас шилжиж ирсэн зэргийг зураг дээр заа.

Энэ зураг дээр Ариун Нутаг хэмээн олонтаа нэрлэгддэг нэг бүс нутаг байдгийг тайлбарла. Энэ бүс нутгийг зааж үзүүл. Энэ бол Есүс Христийн өссөн, сайн мэдээг хүмүүст зааж байсан, мөн өөрийн сүмийг зохион байгуулсан газар гэдгийг тайлбарла. Хүүхдийн хэсэгт энэ жил тэд Есүсийн тухай, түүнчлэн Ариун нутгийн хүмүүст түүний зааж байсан зүйлүүдийн талаар олон зүйлийг мэдэж авсныг хүүхдүүдэд сануул.

Багшийн
танилцуулга

Библийг үзүүлж, үүнийг Шинэ Гэрээн дээр нээж харуул. Судрын энэ ном Есүс Христийн тухай болон Ариун Нутгийн хүмүүсийн тухай түүхүүдийг агуулдгийг хүүхдүүдэд сануул. Ариун Нутагт Есүс өөрийн сүмийг хэрхэн зохион байгуулсан тухай бид Шинэ Гэрээнд уншиж болно.

Зураг дээрх үйл
ажиллагаа

Есүс Христ дэлхий дээр байхдаа Ариун Нутагт зохион байгуулсан түүний сүмийн зарим хэсгийн тухай та ярих гэж байгаагаа хүүхдүүдэд хэл. (Цовдлуулсныхаа дараа Есүс Америк тивд Нифайчууд дээр очих үедээ тэдний дунд өөрийн сүмийг мөн ийм байдлаар зохион байгуулсныг та цохон тэмдэглэж болно.)

Уулан Дээрх Номлол, зураг 2-37-г үзүүлж, үүнийг нэг хүүхдээр самбарын зүүн өнцөгт буюу ангийн өмнөх шалан дээр тавиул.

- Энэ зураг юу харуулдаг вэ? (Хүмүүст зааж байгаа Есүс Христийг.)
- Та нарын санаж байгаа Есүсийн заадаг зарим зүйл юу вэ?

Есүс өөрийн заадаг хүмүүст хайртай байсан бөгөөд тэд сайн мэдээг, Тэнгэрлэг Эцэг тэднийг мэдээсэй гэж хүсдэг зүйлүүдийг тэд мэдээсэй гэж хүсдэг байсныг тайлбарла. Есүс өөрийн сүмийг байгуулсан нэг шалтгаан нь сайн мэдээг мэдэхэд нь хүмүүст туслах явдал байв. *Зохион байгуулах* гэдэг нь юмыг зохих журамд нь оруулна гэсэн утгатайг тайлбарла.

- Яагаад Есүс хүмүүсийг сайн мэдээтэй байхыг хүсдэг байсан бэ? (Тэр тэдэнд хайртай байсан бөгөөд Тэнгэрлэг Эцэгтэй хэрхэн дахин хамт амьдарч болохыг хүмүүс мэдээсэй гэж хүсдэг байв.)

Иохан Баптист Есүст Баптизм Хүртээж Байгаа нь, зураг 2-19-ийг үзүүлж, үүнийг Уулан Дээрх Номлол зургийн дор нэг хүүхдээр байрлуул.

Зургийн талаар юу мэддэгээ өөртөө ярьж өгөхийг хүүхдүүдээс хүс. Бид хэрхэн баптизм хүртэх ёстой талаар Есүс үлгэр жишээ үзүүлснийг тайлбарла. Санваар атгагч хэн нэгнээр усанд умбуулалтаар хийх баптизм нь Есүсийн сүмийн нэг чухал хэсэг мөн.

Христ Төлөөлөгчдийг Томилж Байгаа нь, зураг 2-66-г үзүүлж, үүнийг баптисмын зургийн дор нэг хүүхдээр байрлуул.

Өөрийнхөө сүмийг удирдахад туслах арван хоёр эрэгтэй хүнийг Есүс сонгосныг тайлбарла (зураг дээр тэднийг бүгдийг нь харуулаагүй болно). Эдгээр эрчүүдийг Төлөөлөгчид гэдэг байв. Өөрийн сүмийг удирдах болон хүмүүст үйлчлэхэд нь туслахын тулд Есүс тэдэнд санваар олгожээ.

Анхны Ариун Ёслолыг Есүс Адисалж Байгаа нь, зураг 2-67-г үзүүлж, үүнийг Төлөөлөгчдийн зургийн дор нэг хүүхдээр байрлуул.

Энэ зургийн талаар юу мэддэгийг нь хүүхдүүдээр яриул. Өөрийг нь санахад тэдэнд туслахын тулд Есүс Христ хүмүүст ариун ёслолыг өгснийг хүүхдүүдэд сануул.

Есүс Бол Христ, зураг 2-3-ыг үзүүлж, үүнийг анхны ариун ёслолын зургийн дор нэг хүүхдээр байрлуул.

Үнэн сүм бол Есүс Христийн Сүм гэдгийг хүн бүгд мэдээсэй гэж Есүс хүсч байсныг хүүхдүүдэд хэл.

Дуу

Хүүхдүүдийг босгож, “Есүсийн Тухай Түүхүүдийг Надад Яриач” дууг өөрийнхөө хамт хүүхдүүдээр дуулуулах буюу үгийг нь хэлүүл.

Сонсох дуртай Есүсийн тухай түүхүүдийг надад яриач
Хэрэв би тэнд байсан бол асуух байсан тэр зүйлүүдийг.
Замын хажуу дахь байдлыг, тэнгисийн тухай өгүүллийг,
Есүсийн тухай түүхүүдийг, тэдгээрийг надад яриач

Есүс Христ Өөрийн Сүмийг Бидэнд Зориулж Байгуулжээ

Багшийн
танилцуулга

Христийг үхсэний дараа Төлөөлөгчид Сүмийг удирдаж байсныг тайлбарла. Гэвч Төлөөлөгчдийг үхсэний дараа хүмүүс Есүсийг болон Төлөөлөгчдийг мартаж эхэлжээ. Тэд зарлигуудыг дагах буюу Есүсийн заадаг зүйлүүдийг дагахаа болив. Удалгүй Есүс Христийн Сүм дэлхий дээр байхаа болив. Хэдэн зуун жил өнгөрөхөд олон янзын сүм бий болсон хэдий ч, тэдний нэгэнд нь ч үнэн санваар байсангүй.

Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр дэлхий дээрх бүх хүмүүст хайртай хэвээр байгааг хүүхдүүдэд ярь. Хүмүүс сайн мэдээг мэдэж болохын тулд дэлхий дээр Есүс Христийн Сүм дахин бий болохыг тэр хоёр хүсч байлаа.

Газрын зураг

Газрын зургийг дахин үзүүлж, 1820 онд, Нэгдсэн Улсын Нью-Йоркт амьдарч байсан Иосеф Смит дээр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр хүрч ирснийг хүүхдүүдэд ярь. Газрын зураг дээр Нью-Йорк хаана байдгийг хүүхдүүдэд зааж өг.

Зураг дээрх үйл ажиллагаа

Анхны Үзэгдэл, зураг 2-38-ыг үзүүлж, үүнийг нэг хүүхдээр Уулан Дээрх Номлол зургийн дэргэд байрлуул.

Энэ зургийн талаар юу мэддэгийг нь хүүхдүүдээр яриул. Есүс Христ дэлхий дээр байх үедээ өөрөө зохион байгуулсантай яг адилаар Есүс Христийн Сүмийг зохион байгуулахыг Есүс Иосеф Смитэд зарлигласныг тайлбарла.

Сургаал ба Гэрээг үзүүл (Гурвал судрын Сургаал ба Гэрээний оршил хуудсыг үзүүл). Шинэ Гэрээ түүнийг дэлхий дээр байх үед Есүсийн заадаг байсан зүйлүүдийг агуулдгийн нэгэн адил Сургаал ба Гэрээ Иосеф Смит болон манай өнөөгийн бусад бошиглогчдод өгсөн Есүсийн заадаг зүйлүүдийг агуулдгийг онцлон тэмдэглэ.

Баптисм Хүртэж Байгаа Хөвгүүн, зураг 2-20-ийг үзүүлж, үүнийг Есүс баптисм хүртэж байгаа зургийн дэргэд нэг хүүхдээр байрлуул.

Энэ зургийн тухай хүүхдүүдээр яриул. Энэ хүүхэд Есүс Христ баптисм хүртсэнтэй яг адилаар, санваарыг атгадаг хэн нэгнээр, усанд умбуулалтаар (усанд бүрэн гүйцэд дүрэгдэх) баптисм хүртэж байгааг онцлон тэмдэглэ.

Мелкизедек Санваарын Сэргээлт, зураг 2-68-ыг үзүүлж, үүнийг Есүс Төлөөлөгчдийг томилж байгаа зургийн дэргэд нэг хүүхдээр байрлуул.

Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нарыг Мелкизедек Санваарын сэргээлтийн зураг дээр заа. Есүс Христ тэдэнд санваарыг хүртээсэн анхны гурван Төлөөлөгч болох Петр, Иаков, Иахон нар болохыг тайлбарла. Иосеф Смит, Оливер Каудери хоёрт санваар хүртээхийн тулд Петр, Иаков Иохан нарыг Есүс дэлхий дээр эргүүлж ирүүлснийг хүүхдүүдэд хэл. Түүний сүмийн анхны гишүүдэд хэрэгтэй байсны нэгэн адил бидэнд санваар хэрэгтэй болно гэдгийг Есүс мэдэж байжээ.

Ариун Ёслолоос Хүртэж Байгаа Хүүхэд, зураг 2-69-ийг үзүүлж, үүнийг анхны ариун ёслолыг Есүс адисалж байгаа зургийн дэргэд нэг хүүхдээр байрлуул.

- Энэ зурагт юу болж байна вэ?
- Бид яагаад ариун ёслолыг хүртдэг вэ?

Ариун Нутагт Төлөөлөгчдөд тэрээр үүнийг өгсөнтэй адил шалтгаанаар: түүнийг санахад бидэнд туслахын тулд Есүс Христ бидэнд ариун ёслолыг өгснийг онцлон тэмдэглэ.

Есүс Бол Христ, зураг 2-3-ыг шилжүүлэн, хоёр эгнээ зургийн хооронд байрлуул.

Ариун Нутаг дахь түүний дагалдагчдын нэгэн адил, бид Есүс Христийн сүмийн гишүүд гэдгийг тайлбарла.

Судар

- Өнөөдөр Есүс Христийн сүмийн нэр юу вэ?

Сургаал ба Гэрээ 115:4-ийг чанга унш. *Хожмын Үеийн* гэдэг нь одоо бидний амьдарч байгаа үе, *Гэгээнтнүүд* гэдэг нь Есүсийн заадаг зүйлүүдийг дуулгавартай дагадаг хүмүүс гэсэн утгатайг тайлбарла.

Хүүхдүүдийг босгож, “Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг” гэж өөртэйгөө хамт хүүхдүүдээр хэдэн удаа хэлүүл.

Багшийн танилцуулга

Хоёр эгнээ зургуудыг товчхон харьцуулахдаа Есүсийн сүм өнөөдөр Ариун Нутагт байсан сүмтэй яг адилхан юм гэдгийг онцлон тэмдэглэ. Есүс

Ариун Нутаг дахь хүмүүст өгсөнтэй яг адилаар өөрийн заадаг зүйлүүдийг бидэнд өгснийг онцлон тэмдэглэ.

Газрын зураг

Дэлхийн газрын зургийг дахин үзүүл. Ариун Нутгийг дахин зааж үзүүлээд Есүс дэлхий дээр байх үед сүмийн ихэнх гишүүд Ариун Нутагт амьдарч байсныг тайлбарла.

- Өнөөдөр Есүс Христийн Сүмийн гишүүд хаана амьдардаг вэ?

Багшийн танилцуулга

Дэлхий Дахины Хүүхдүүд, зураг 2-70-ыг үзүүлж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бүх дэлхий даяар амьдардгийг тайлбарла. Зураг дээрх хүүхдүүд янз бүрийн орных гэдгийг онцлон тэмдэглэ. Есүс ердөө ганц хоёрхон орны хүмүүсийг биш харин бүх хүмүүсийг түүний заадаг зүйлүүдийг мэдэж, түүний сүмд харъяалагдаасай гэж хүсдэгийг тайлбарла.

Дуу

“Есүс Христийн Сүм” дууг дуулах буюу үгийг нь хэл.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харъяалагддаг би Би хэн гэдгээ мэднэ. Бурханы төлөвлөгөөг мэднэ би.

Итгэлд түүнийг дагана би.

Аврагч Есүс Христэд итгэдэг би.

Түүний нэрийг хүндэтгэнэ би.

Зөвийг хийнэ би; Түүний гэрлийг дагана би.

Түүний үнэнийг тунхаглана би.

Дүгнэлт

Тааруулах тоглоом

Есүс Христ, зураг 2-3-аас бусад бүх зургуудыг самбар дээрх эгнээнүүд, ширээ буюу шалан дээрээс ав. Зургуудыг хольж, нүүрийг нь доош харуулан, шалан дээр хоёр багана болгон тавь (бага насны хүүхдүүдийн хувьд зургийн нүүрийг дээш нь харуул).

Энэ тоглоомын зорилго бол зургуудыг хооронд нь тохируулах явдал мөн гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхэд бүрээр нэгэн зэрэг хоёр зургийг өөд нь харуулуул. Хэрэв зургууд тохирч байвал (Жишээ нь, Есүс баптисм хүртэж байгаа зураг, баптисм хүртэж байгаа хүүхдийн зурагтай тохирно) зургууд Есүс Христийн сүмийн ямар хэсгүүдийг төлөөлж байгааг тэр хүүхдээр хэлүүл. Хэрэв зургууд хоорондоо тохирохгүй байвал, зургуудыг байсан байранд нь буцаан доош харуулж уг хүүхдээр тавиул. (Ар талаар тавьсан зургуудыг тохируулах үед хүүхдүүдийн анхаарал сарнина гэж та үзвэл, ар талд байгаа зургуудын дээр цулгүй цагаан цаас тавьж болно)

Нийт дөрвөн зураг тохиртол үргэлжлүүл. Хэрэв танай анги олон хүүхэдтэй бол зургуудыг дахин хольж, хүн болгонд зургийг тохируулах боломж олгон, тоглоомыг давт.

Гэрчлэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Есүс дэлхий дээр байх үедээ зохион байгуулсан тэр сүм юм гэдгийг гэрчил. Өнөөдрийн хичээл дээр ярилцсан сайн мэдээний сэдвийн (баптисм, санваар, эсвэл ариун ёслол) талаарх өөрийн бодлыг хүүхдүүдэд ярь.

Өнөөдөр сурсан зүйлийнхээ талаар гэрийнхэндээ ярихад нь хүүхдүүдийг урамшуул. Хичээл дээр заагдсан санаануудыг хурдан нэгтгэн дүгнэхэд нь хүүхдүүдэд туслахын тулд та хэдэн асуулт асууж болно.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн төлөө Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлэхийг уг хүүхдэд санал болго.

**Баяжуулах Үйл
Ажиллагаанууд**

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Итгэлийн зургадугаар тунхгийн эхний хэсгийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал: “Анхны Сүмд байсан тэрхүү зохион байгуулалтад бид итгэдэг.” *Анхны Сүм* гэдэг нь Есүсийг дэлхий дээр байх үе дэх Ариун Нутаг дахь Сүм гэсэн утгатайг тайлбарла.
2. Хүүхдүүдэд цаас, будгийн харандаа буюу харандаанууд өгч, тэд өөрсдөө сүм дээр буюу сүмд өөрсдийнхөө цугладаг барилгын тухай зургуудыг тэднээр зуруул. Сүм гэдэг бол зүгээр л нэг барилгаас илүү зүйл гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Энэ бол хэзээ нэгэн цагт бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой хамт байхаар эргэж очихын тулд хэрхэн амьдарвал зохихыг бидэнд заахад тусалдаг байгууллага юм.



Зорилго Есүсийн заадаг зүйлүүдийг дагаснаар Есүс Христийн хоёр дахь ирэлтэд бэлтгэхийг хүсдэг хүүхэд бүрт туслах.

- Бэлтгэл**
1. Матай 24:36, Лук 24:50–53, Үйлс 1:3, 9–11-ийг залбиралтайгаар судал. Мөн *Сайн Мэдээний Зарчмууд* (31110), бүлэг 43-ыг үз.
 2. Гарын авлагын сүүлчийн хуудсан дээрх “Есүсийг Ирэхэд Бэлтгэх нь” тоглоомын хөлгийн хувийг хий (хувийг хийх боломжгүй бол гарын авлагын хуудсыг болгоомжтойгоор салгаж ав). Тоглоомын хөлгийг картон буюу хатуу цаасан дээр наа. Ирээдүйн хичээлүүдэд хэрэглэхийн тулд тоглоомын энэ хөлгийг хадгал.

Хэрэв танай анги олон хүүхэдтэй бол, хоёр бүлэг зэрэг тоглохын тулд та тоглоомын хоёр дахь хувийг хийж болно. Хүүхдийн Хэсгийн удирдагч буюу хүүхдүүдийн эцэг эхийн нэгийг хоёр дахь тоглоомыг хянахаар ирэхийг хүс.
 3. Тоглоомд зориулж арван хоёр жижиг цаас зүсч бэлтгэ. Цаас бүр дээр 1-ээс 6-г дуусталх дугаарын нэгийг бич. Цаасыг эвхэж, тэдгээрийг саванд хий.
 4. Таны ойр дотнын хэн нэгэн хэсэг хугацаагаар эзгүй байсан үеийн тухай ярихаар бэлтгэ. Тэр хүнийг хэрхэн санасан тухайгаа бас түүнийг эргэж ирэхэд хэрхэн бэлтгэсэн тухайгаа ярихаар бэлтгэ.
 5. “Түүнийг Дахин Ирэхэд” (*Children’s Songbook*, х. 82) дууны хоёрдугаар бадгийг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
 6. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хүүхэд бүрт товч буюу чулуу зэрэг жижиг зүйл. Тоглоомонд эдгээр зүйлүүдийг ялгагч болгон ашиглах болно; хүүхдүүд өөрийн ялгагчийг танихын тулд эдгээр зүйл бүр хоорондоо адилгүй (өнгө, хэлбэр буюу хэмжээгээрээ) байх ёстой.
 - в. Зураг 2-62, Мари болон Амилсан Их Эзэн (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 233; 62186); зураг 2-64, Есүс Шархаа Үзүүлж Байгаа нь; зураг 2-65, Амилсан Есүс Христ (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 239; 62187); зураг 2-71, Есүс Дээшлэн Одсон нь (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 236; 62497).
 7. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Бид Өөрсдийн Хайртай Хүмүүсийг Эргэж Ирэхийн Төлөө Бэлтгэдэг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Өөрийн чинь дотнын хэн нэгэн хүн хэсэг хугацаанд эзгүй байсан тохиолдлынхоо тухай ярь. Энэ хүнийг явсан хойгуур өөрт чинь ямар санагддаг байсан хийгээд түүнийг эргэж ирэхийг та хэрхэн тэсэн ядан хүлээж байснаа тайлбарла. Хайртай хүмүүсээ гэртээ ирэхэд хэрхэн бэлтгэсэн хийгээд энэ хүнтэй дахин уулзах үед ямар санагдсан тухайгаа ярь.

Тэдний хайртай хэн нэгэн түр хугацаагаар юманд явсан тохиолдлыг бодоход нь хүүхдүүдэд тусал. Байж болох жишээнүүд гэвэл, эцэг эх нь ажлаар явсан, ээж нь хүүхэд гаргахаар эмнэлэгт хэвтсэн, ах дүү төрөл төрөгсдөөс хэн нэг нь номлолд явсан байж болно. Эдгээр хүмүүсийг явахад, мөн буцаж ирэхэд ямар санагдсаныг хүүхдүүдтэй ярилц. Бид хайртай хүмүүсээ эзгүй байхад нь тэднийг санадаг, харин буцаж ирэхэд нь баяртай байдгийг онцлон тэмдэглэ. Эдгээр хүмүүсийг гэртээ эргэж ирэхэд бэлтгэн тэд болон эцэг эхчүүдийнх нь хийдэг аливаа бэлтгэлүүд, тухайлбал, гэр орноо цэвэрлэж, сайхан болгох, тусгай хоол бэлтгэх буюу гоёлын хувцсаа өмсдөг зэргийг хүүхдүүдээр яриул.

Есүс Христ Эргэж Ирнэ

Багшийн
танилцуулга

Есүс Христ дэлхий дээр амьдарч байх үед түүнд их хайртай олон найз байв. Эдгээр найз нар нь түүнийг дагаж, түүний заадаг зүйлүүдийг сонсдог байв. Юу хийхийг тэр тэдэнд заадаг байсан тэр зүйлийг тэд хийдэг байсан учраас тэднийг түүний шавь нар хэмээн нэрлэдэг байлаа.

Есүс шавь нартаа хайртай байсныг тайлбарла. Өөртэйгөө болон Тэнгэрлэг Эцэгтэй дахин хамт амьдрахын тулд тэдэнд юу хэрэгтэйг мэдэхэд нь тэр тэдэнд тусалдаг байв. Тэд зөвийг сонгохын тулд зөв, буруугийн ялгааг ойлгоход нь тэр тэдэнд тусалдаг байв.

Зураг дээр
ярилцах нь

Мари ба Амилсан Их Эзэн, зураг 2-64, Есүс Шархаа Үзүүлж Байгаа нь, зураг 2-64-ийг үзүүл. Хэдэн долоо хоногийн өмнө (хичээл 41) Есүс амилсныхаа дараа өөрийн шавь нар дээр хүрч ирсэн тухай тэд мэдсэнийг хүүхдүүдэд сануул. Эдгээр зургуудын талаар хүүхдүүдээр хэсэг зуур яриул.

Есүс амилсныхаа дараа шавь нар дээрээ ирж, тэдэнд зааж дөчин хоног байсныг тайлбарла (Үйлс 1:3-ыг үз). Тэр дахин амьд болсныг мөн түүний заадаг зүйлүүдийг тэд мэдэж байсан гэдэгт тэрээр итгэлтэй байхыг хүсч байжээ. Тэр тэдэнтэй дахиад хамт байхгүй ч гэсэн, түүний заадаг зүйлүүдийг шавь нар нь дуулгавартай дагахыг Есүс шавь нараасаа хүсч байлаа.

Судрын түүх

Есүс Дээшлэн Одсон нь, зураг 2-71-ийг үзүүл. Лук 24:50–53, Үйлс 1:9–11 дэх Христ тэнгэрт дээшлэн одсон түүхийг өөрийн үгээр ярь. Дараах зүйлүүдийг онцлон анхаар:

1. Есүс шавь нартаа адислал өгсөн нь.
2. Есүс шавь нараа орхин, тэнгэр дэх Тэнгэрлэг Эцэгтээ очихоор үүлэн дунд дээшлэн одсон нь.
3. Шавь нар нь зогсон Есүсийг алга болтол харж байв.

Шавь нар нь тэнгэр лүү харан зогсож байхад цагаан хувцастай хоёр тэнгэр элч тэдний дэргэд харагджээ.

Үйлс 1:11-д юу гэж өгүүлснийг чанга унш (*Та нар юунд зогсоно вэ* гэдгээс эхлэн).

Нэгэн цагт Есүс Христ явсантайгаа адил арга замаар эргэж ирэх болно гэдгийг тэнгэр элчүүд шавь нарт хэлснийг тайлбарла. Үүнийг бид хоёр дахь Ирэлт гэдгийг хүүхдүүдэд хэл.

Есүс хэзээ эргэж ирэхийг бид яг тодорхой мэддэггүйг тэмдэглэн хэл. Яг тодорхой цагийг зөвхөн Тэнгэрлэг Эцэг л мэддэг (Матай 24:36-г үз). Гэвч бид нэгэн өдөр Есүс дэлхий дээр амьдрахаар эргэж ирэх болно гэдгийг мэддэг.

Ярилцлага

Амилсан Есүс Христ, зураг 2-65-ыг үз.

Есүс дахин ирэхдээ дэлхийн хүмүүсийн дунд байх болно гэдгийг тайлбарла. Тэр бол Есүс Христ, бидний Аврагч гэдгийг хүн бүгд мэдэж, түүнийг шүтэн бишрэх болно.

- Есүсийг дахин ирэхэд чи энд байхыг хүсэх үү? Яагаад?

Есүсийг дахин ирэхэд дэлхий дээр байх нь хичнээн сайхан байхыг хүүхдүүдтэй ярилц. Есүсийг харж, түүнтэй хамт алхлан, ярилцаж, түүний хайрын гараар мөрөөрөө тэврүүлэх нь хүмүүст боломжтой байх болно. Есүсийг ирсний дараа хүн бүгд найз нар байх болно гэдгийг онцол. Хилэнцэт санаа бодолтой хүмүүс байхгүй байх болно. Бүх зүйл хийгээд бүх хүмүүс аюулгүй найдвартай байх учраас бид хаалгаа цоожилж түгжих шаардлагагүй байх болно. Биднийг өвчин эмгэгт хүргэдэг өвчин байхгүй болно, мөн бүх амьтад бидэнтэй болон өөр хоорондоо найз нөхөд байх болно.

Нэгтгэн дүгнэх
үйл ажиллагаа

Хоёр дахь Ирэлтийн тухай дараах асуултуудыг хүүхдүүдээс асуу. Асуултын хариуг мэддэг бол босохыг тэдэнд хэл. Наад тал нь хоёр гурван хүүхэд боссон үед асуултанд хариулуулахаар тэдний нэгийг нь дууд. Хэрэв нэг ч хүн босоогүй бол, эсвэл хүүхдүүд асуултуудыг сайн ойлгоогүй янзтай байвал, мэдээллийг дахин авч үзэх цаг гарга.

- Есүс Христ амилсныхаа дараа хэдэн өдөр шавь нартайгаа хамт байсан бэ? (Дөч.)
- Есүс хэзээ эргэж ирэхийг хэн мэддэг вэ? (Зөвхөн Тэнгэрлэг Эцэг. Дэлхий дээр өөр хэн ч мэдэхгүй.)
- Есүсийг дахин ирсний дараа дайн, тулалдаан байх уу? (Үгүй. Дэлхий дээр хүн бүгд найз нөхөд байх болно.)
- Есүсийг дахин ирэхэд өвчтэй буюу тахир дутуу хүмүүс ямар болох вэ? (Тэд эдгээгдэх болно. Есүсийг дэлхийд эргэж ирэхэд өвчин зовлон байхгүй болно.)
- Есүсийг дахин ирэхэд амьтад ямар болох вэ? (Тэд бидэнтэй болон өөр хоорондоо найрсаг байх болно.)

Бид Есүс Христийн Хоёр Дахь Ирэлтэд Бэлтгэж Чадна

Багшийн
танилцуулга

Хайртай хүмүүс нь гэртээ эргэж ирэхэд тэдний хийсэн бэлтгэлүүдийн талаар хүүхдүүдэд сануул. Мөн түүнчлэн бид Есүс Христийг дэлхийд эргэж ирэхэд бэлтгэх ёстойг тайлбарла. Бид Есүсийн заадаг зүйлүүдийг мэдэж, дагах замаар бэлтгэж болно.

Хэрэв бид бэлтгэгдсэн байх юм бол, бид Аврагчийг хараад баяртай байх болно. Тэрээр хүн бүгдийг өөртэйгөө хамт дахин амьдрахыг хүсдэг, гэвч зөвхөн түүний заадаг зүйлүүдийг дагаж, зөвийг сонгодог хүмүүст л ийм боломж олдох болно. Түүнтэй хамт дахин амьдрахын тулд юу хийх хэрэг-

тэйг мэдэхэд нь Есүс шавь нартаа тусалдаг байв, мөн тэрээр өөрийгөө дахин ирэхэд бэлтгэхэд бидэнд туслахын тулд өөрийн заадаг зүйлүүдийг бидэнд өгсөн билээ.

Дуу

“Түүнийг Дахин Ирэхэд” дууны хоёрдугаар бадгийг дуулах буюу үгийг нь хэл. Өгөгдсөн үйлдлүүдийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Түүнийг хэзээ дахин ирэхийг би гайхна,
Түүний хайраар дүүрсэн нүүрийг харахын тулд
Тэнд би бэлэн байна (*хуруугаа шанаандаа хүргэнэ*)
Түүнтэй хамт залбиралд нэгдэнэ (*залбирч байгаа мэт гараа хумина*)
Түүний хүслийг хэрэгжүүлэхээр өдөр бүр хичээнэ.
Тэгээд гэрлээ би гэрэлтүүлнэ (*хоёр гараа өргөж толгой дэрээ тойрог гаргана*).
Бурханлиг агуу гэрлийг (*Нэг гараараа нүдээ таглана*)
Бусад хүмүүс намайг харж болохын тулд
Тэгээд адислагдсан өдөр ирнэ,
Тэр намайг хайрлаж, бас хэлнэ (*өөрийгөө тэвэрнэ*).
“Чи надад сайн үйлчиллээ, жаал хүү минь;
Миний гарт үлдэхээр ир” (*гараа дэлгэн харуулна*).

(© 1952, 1980 by Mirra Greenwood Thayne. Зөвшөөрлөөр ашиглана.)

Тоглоом

Есүсийн хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь бид ганцхан өдөрт хийчих ямар нэг зүйл биш. Бид Есүсийн заадаг зүйлүүдийг дагах замаар бид бүх амьдралынхаа турш бэлтгэх ёстой.

“Есүсийг Ирэхэд Бэлтгэх нь” тоглоомын хөлгийг хүүхдүүдэд үзүүл. Есүстэй хамт амьдрахад нь бэлтгэхэд тэдний хийж болох зарим зүйлүүдийг энэ тоглоом тэдэнд сануулах болно гэдгийг хэл.

Есүсийг дагахын тулд бидний хийж болох сайн зүйлүүдийг энэ тоглоом хэрхэн дүрсэлдгийг үзүүл. Эдгээр зүйлүүд “Есүсийг Ирэхэд Бэлтгэх нь” гэж хаягласан хэсэг рүү хөтөлнө. Энэ тоглоом бас бидний хийж мэдэх зарим буруу зүйлийг харуулдгийг тэмдэглэн хэл. Эдгээр зүйлүүд “Есүсийг Ирэхэд Эс Бэлтгэх нь” гэж хаяглагдсан хэсэг рүү хөтөлдөг.

Тоглоомонд ялгагч болгон ашиглах жижиг зүйлийг хүүхэд болгонд өг. Тэгээд дараах дүрмийг тайлбарла:

1. Тоглоомын зорилго нь “Гараа” гэж тэмдэглэсэн сумнаас “Есүсийг Ирэхэд Бэлтгэх нь” тэмдэглэсэн хэсэг рүү хүрэх явдал мөн
2. Ээлжээр тоглоно.
3. Өөрийнхөө ээлжинд савнаас нэг цаас сонгон авч өөрийн ялгагчийн цаасан дээрх дугаарын тоогоор нүү. Тэгээд цаасыг эвхэж сав руу эргүүлж хий.
4. Чи тэгш өнцөгт дээр хүрсэн үед чи буюу эсвэл багш чинь тэгш өнцөгт дээр юу гэж бичсэнийг чанга уншина. Энэ заасан зүйлийг дагахын тулд өөрийн хийж болох ямар нэг зүйлийг хэл, эсвэл тэгш өнцөгт дээр дүрсэлсэн зүйлийг хийх нь яагаад чухал болохыг тайлбарла. Хэрэв чи буруу зүйл дүрсэлсэн тэгш өнцөгт дээр буух юм бол, тэгш өнцөгт дээр бичсэн зүйлийн оронд чи юу хийх ёстойг тайлбарла. Хэрэв чамд туслалцаа хэрэгтэй бол, багш чинь чамд зарим зөвлөмжийг өгөх болно.
5. Тэгш өнцөгт бүр дээрх сум нь *дараагийн* ээлжинд хаашаа явах зүгийг заадаг.

“Есүсийг Ирэхэд Бэлтгэх нь” гэсэн бичигтэй хэсгээс хүүхэд тэгш өнцөгт дээр хол буувал, бид буруу зүйл хийсэн тохиолдолд Есүсийн заадаг зүйлүүдийг дагахгүй байгаа явдал юм, гэвч зөвийг хийснээр бид чиглэлээ өөрчилж болно гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

“Есүсийг Ирэхэд Бэлтгэх нь” хэсэгт хүртэл тоглох буюу эсвэл хичээлийг бараг дуусах хүртэл тоглоомыг тоглуул.

Дүгнэлт

Гэрчлэл

Хэдийгээр яг хэзээ гэдгийг бид мэдэхгүй ч гэсэн Есүс Христ дахин ирэх болно гэдгийг гэрчил. Дахин ирэхэд нь түүнийг харах онцгой боломж танд байж болохын тулд та Есүсийн заадаг зүйлүүдийг хэдий хэмжээгээр дагах хүсэлтэй байдгаа хүүхдүүдэд ярь. Та нар бүгдээрээ түүнтэй хамт байхын тулд анги дахь хүүхэд бүр Есүсийн заадаг зүйлүүдийг дагаасай гэсэн хүсэлтэй байдгаа илэрхийл.

ЗС бөгж

Тэд бөгжөө зүүсэн эсэхийг нь хүүхдүүдээр харуул. Бөгж нь зөвийг сонгох болон Есүсийн заадаг зүйлүүдийг дагах явдлыг тэдэнд сануулахад тусалж болно гэдгийг хүүхдүүдэд сануул.

Есүсийн хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд ирэх долоо хоногийн турш хийх ямар нэг зүйлийг ярихыг хүүхэд бүрээс хүс.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь. Есүс Христийн ирэлтэд бэлтгэхэд нь ангийн гишүүдэд туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг уг хүүхдэд санал болго.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Түүнийг Дахин Ирэхэд” (*Children’s Songbook*, х. 82) дууны хоёр бадгийг хоёуланг нь дуулах буюу үгийг нь хэл. Хоёрдугаар бадгийн үг 237–38 дугаар хуудсанд хэвлэгдсэн байгаа.

Түүнийг хэзээ ирэхэд би гайхна,
Тэнгэр элчүүд дуулах нь сонсогдох уу?
Дэлхий цагаан цасаар шуурах уу,
Эсвэл дэлхий хаврыг мэдэх үү?
Бусдаасаа ихэд илүү гэрэлт
Нэгэн од гялалзахад би гайхна.
Өдрийн гэрэл шөнөжингөө үргэлжлэх үү?
Өөрийн багачуулыг тэрээр дуудан
Өвдөгнийхөө дэргэд суулгахад би итгэнэ,
“Тэднийг над уруу ирэхийг зөвшөөр” гэж
Өнгөрсөн үед тэр үүнийг хэлсэн болохоор.

(© 1952, 1980 by Mirla Greenwood Thayne. Зөвшөөрлөөр ашиглана.)

2. Итгэлийн аравдугаар тунхаг Есүс Христийн хоёр дахь ирэлтийн тухай өгүүлдгийг тайлбарла. “Христ дэлхий дээр өөрийн биеэр . . . хаанчлах болно гэдэгт бид итгэдэг” гэсэн өгүүлбэрийг цээжлэхэд нь хүүхдүүдэд тусал. Энэ өгүүлбэрийн утгыг хүүхдүүдэд тайлбарла.

3. Тосоор ажилладаг дэнлүү буюу ийм дэнлүүний зургийг хүүхдүүдэд үзүүл. Арван охины тухай болон тэдний дэнлүүний тухай түүхэнд түүний ирэлтэд бэлтгэхийн ач холбогдлыг Есүс бидэнд заасныг тайлбарла. Матай 25:1–13 дахь арван охины тухай сургаалт зүйрлэлийг ярь. Хэрэв тосгүй бол тосоор ажилладаг дэнлүү гэрэлтдэггүйг тайлбарла. Бэлтгээгүй таван тэнэг охиныг хуриманд очихыг зөвшөөрөөгүйг онцлон тэмдэглэ.

Аврагч хуримыг өөрийн хоёр дахь ирэлттэй харьцуулсныг тайлбарла. Дэнлүүнийхээ тосыг авч байгаа охид Есүстэй хамт байхаар бэлтгэж байгааг зүйрлүүлжээ. Хэрэв түүнийг ирэхэд бид бэлтгээгүй байх юм бол бид түүнтэй хамт амьдрах боломжгүй байх болно.

Есүсийн ирэлтэд тэд бэлтгэж болох арга замуудын талаар ярихыг хүүхдүүдээс хүс. (тоглоомонд ашигласантай адил зарим санал зөвлөгөөг та тэдэнд өгч болно.) Зөвийг сонгосноороо бид Есүс Христийн хоёр дахь ирэлтэд бэлтгэдэг гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал.

4. Хүүхэд бүрт зориулсан тэмдгийн дээд хэсэгт *Би Есүс Христийн Хоёр Дахь Ирэлтэд Бэлтгэж Байна* гэж бич. Хүүхэд бүрт будгийн харандаа буюу балын харандаанууд өгч Есүсийн ирэлтэд бэлтгэж ямар нэг зүйл хийж байгаа өөрийнх нь зургийг тэмдэг дээр хүүхдүүдээр зуруул. Хүүхдүүдэд тэмдгийг зүүж өгөх буюу эсвэл хүзүүний зүүлт болгон тэмдэг бүрийн дээд хэсэгт нүх гарган утсаар оосор хий.

Би Амьтдад Хайраа Илэрхийлж Чадна

Хичээл
44

Зорилго Бүх амьд бүтээлийг хүндэтгэн, найрсаг хандахад нь хүүхэд бүрийг урамшуулан дэмжих.

- Бэлтгэл**
1. Эхлэл 6:11–7:24, Исаиа 11:6–9, Лук 12:6-г залбиралтайгаар судал.
 2. Хичээлийн төгсгөл дэх амьтдын зурагтай дөрвөлжиний хуулбарыг хий (хэрэв хуулбар хийх боломжгүй бол, гарын авлагаас хуудсыг болгоомжтой салгаж ав.) Дөрвөлжинг салгаж ав. Эдгээрийг ирээдүйн хичээлүүдэд ашиглахын тулд хадгал.
 3. “Бүх Зүйл Гэрэл Гэгээтэй, Сайхан” (*Children’s Songbook*, р. 231) дууны дахилтыг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
 4. Та өөрөө мал, амьтанд найрсаг хандсан, эсвэл өөр хэн нэгэн хүн амьтанд найрсаг хандаж байсныг харсан тухайгаа ярихад бэлтгэ.
 5. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Хүүхэд бүрт цаас будгийн харандаанууд.
 - в. Зураг 2-72, Ноа болон Амьтадтай Хөвөгч Авдар (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 103; 62305); зураг 2-73, Бүтээлт—Амьд Бүтээлүүд (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 100; 62483); зураг 2-74, Солт Лейкийн Табернекл (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 503; 62490).
 6. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

**Хичээл Заах
Зөвлөмж**

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Амьтад Чухал

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Амьтдын зурагтай дөрвөлжингүүдийг хольж, шалан дээр буюу ширээн дээр цувруулан доош нь харуулж тавь. Тэд ээлжээр нэг зэрэг хоёр дөрвөлжинг дээш нь харуулж тавихыг хүүхдүүдээс хүс. Хэрэв хоёр амьтан тохирвол, хүүхэд тэднийг дулаан дамжуулах хоолойг налуулан “амьтдын баярын жагсаалд” хамтад нь тавиул. Хэрэв хоёр амьтан тохиороогүй бол, тэр хүүхдээр картыг байсан газарт нь доош харуулж тавь. Бүх амьтад тохирч, амьтдын баярын жагсаалд байрлуулагдах хүртэл үргэлжлүүл.

Жагсаал дахь хос амьтад Библи дэх түүхийн тухай тэдэнд санагдуулж байгаа эсэхийг хүүхдүүдээс асуу. Хэрэв хүүхдүүд Ноа болон түүний авд-рыг санахгүй байвал, дараах байдалтай зарим түлхүүрийг тэдэнд өг:

- Их Эзэн нэг хүнд нэг юм барих тухай хэлжээ.
- Амьтад хосоороо байв.
- Дөчин өдөр, дөчин шөнө бороо орж, дэлхий үерт автав.

Судрын түүх	<p>Ноа болон Амьтадтай Хөвөгч Авдар, зураг 2-72-ыг үзүүлж, Эхлэл 6:11–7:24 дэх түүхийг нэгтгэн дүгнэ. Эдгээр амьтад Үерээс аврагдахыг Есүс Христ хүсч байсныг тайлбарла. Амьтдыг хөвөгч авдарт хий гэж Тэр Ноад хэлж, ийм олон янзын амьтдад хэрхэн халамж тавихыг мэдэхэд нь түүнд тусалжээ.</p>
Зураг дээрх ярилцлага	<p>Амьтдыг Есүс Христ Бүтээсэн Юм</p> <p>Бүтээлт—Амьд Бүтээлүүд, зураг 2-73-ыг үзүүл.</p> <ul style="list-style-type: none"> • Энэ зураг дээр та нар ямар амьтад харж байна вэ? • Та нар эдгээр амьтдад дуртай юу? <p>Хүүхдүүдээр амьтдын тухай хэдэн хором яриул.</p> <ul style="list-style-type: none"> • Эдгээр амьтдыг хэн бүтээсэн бэ? <p>Тэнгэрлэг Эцэгийн удирдлага дор Есүс Христ бүх амьтдыг бүтээснийг хүүхдүүдэд сануул.</p>
Дуу	<p>“Бүх Зүйл Гэрэл Гэгээтэй, Сайхан” дууны дахилтыг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.</p> <p>Бүх зүйл гэрэл гэгээтэй, сайхан, Бүх бүтээл том бас жижиг, Бүх зүйл ухаалаг, гайхамшигтай Бурхан Их Эзэн тэд бүгдийг бүтээсэн.</p>
Судар	<p>Есүс Христийн хоёр дахь ирэлтийн тухай өмнөх хичээл дээр юу сурсныг нь хүүхдүүдэд сануул. Есүсийг дахин ирэхэд амьтад хоорондоо эвтэй, амар амгалан байх болно гэдгийг тайлбарла. Аврагч дэлхий дээр дахин амьдрах үед амьтад ямар байхыг дүрсэлсэн Исаиа 11:6–7-г чанга унш.</p>
Судар	<p>Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ Хоёр Бүх Бүтээлдээ Хайртай</p> <p>Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бүтээл бүрийг, бүр өчүүхэн бага байсан нь ч гэсэн аз жаргалтай байхыг хүсдэгийг тайлбарла. Амьд бүтээл болгон ач холбогдолтой гэж тэд үздэг.</p> <p>Лук 12:6-г чанга унш. Хэдийгээр болжмор маш жижигхэн шувуу ч гэсэн, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр тэдгээрийн төлөө анхаарал халамж тавьдгийг тайлбарла.</p>
Түүх	<p>Солт Лейкийн Табернекл, Зураг 2-74-ийг үзүүл.</p> <ul style="list-style-type: none"> • Та нар ерөнхий чуулганыг телевизээр буюу хиймэл дагуулын шууд нэвтрүүлгээр сүмийн барилгад үзсэн үү? <p>Табернекл хэмээн нэрлэгддэг энэ барилгаас ерөнхий чуулган шууд нэвтрүүлэгддэгийг тайлбарла. Ютагийн Солт Лейк дахь энэ табернеклыг Хожмын Үеийн Гэгээнтэн анхдагчууд барьжээ.</p> <p>Табернеклын өндөр дээвэр, олон хаалгыг зааж, дараах түүхийг өөрийн үгээр ярь:</p> <p>Хаврын нэгэн орой Табернеклын хаалгуудыг барилгыг сэрүүцүүлэхийн тулд онгорхой орхисон байжээ. Нэгэн бяцхан шувуу огт ажиглагдалгүйгээр дотогш нисч орсон аж. Хаалгуудыг хааж цоожлоход нөгөөх бяцхан шувуу дотор үлджээ.</p> <p>Маргааш өглөө нь ажилчид барилгыг концерт тоглоход бэлэн болгож янзлахаар ирээд тэд шувууг олж харан түүнийг гаргах гэж хэдэн цаг оролд-</p>

сон ажээ. Тэд урт иштэй тороор шувууг барихын тулд тусгай бэлтгэгдсэн хүмүүсийг дууджээ.

Менежер Жон Ах ирээд хүмүүс тороор шувуу барих гэж хөөцөлдөж байхыг харав. Хүмүүс тор бариад барилгын нэг тал руу гүйлдэхэд шувуу нөгөө тал руу нь нисдэг байв. Шувууг гаргахын тулд Табернеклын бүх хаалгыг онгойлгосон хэдий ч, энэ нь огт тус болсонгүй.

Тусгай бэлтгэлтэй хүмүүс үрлэн сумтай буу авчирсан байж, тэгээд энэ буугаар шувууг буудъя гэжээ. Жон Ахад энэ санаа таалагдсангүй. Буу барилгыг буюу түүний доторх тоног төхөөрөмжийг гэмтээж мэдэх байв. Үүнээс илүү чухал нь гэвэл тэд шувууг алахыг тэр хүсэхгүй байлаа. Жижигхэн шувуунуудыг буудахгүй байх тухай Сүмийн арванхоёр дахь Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын хэлсэн үгийг тэр санажээ.

Тусгай бэлтгэлтэй хүмүүс бас шувуунд идүүлэхээр хор тавих санал гаргасан аж. Жон ах үүнийг ч бас зөвшөөрсөнгүй. Гэвч шувууг түргэн гаргах ёстойг тэр мэдэж байв, учир нь тэр орой чухал тоглолттой байв.

Жон ах хажуу тийшээ эргэж, товч залбирал хэлэв: “Тэнгэрлэг Эцэг минь, хэрэв болжмор танд чухал бол, түүнийг аюулгүйгээр хэрхэн гаргахыг бидэнд мэдэгдээч?”

Жон Ах залбирлаа дуусгаад, юу хийхийг тэр мэдэж байв. Барилга доторх бүх гэрлийг унтрааж, зөвхөн ганцхан хаалганаас бусад бүх хаалгыг хаалттай үлдээ гэж тэр ажилчдад хэлэв.

Шувуу орган хөгжмийн орой дээр сууж байсан бөгөөд гэрлүүдийг унтрааж, хаалгануудыг хаахад нөгөөх шувуу орган хөгжим дээрээс нээлттэй хаалгыг чиглэн шууд нисчээ. (Ronald D. John, “A Sparrow in the Tabernacle,” *Ensign*, 1989 оны Зургадугаар сар, х. 24–25-ыг үз.)

- Бяцхан шувууны төлөө анхаарал халамж тавьснаа Жон Ах хэрхэн харуулсан бэ (Шувууг буудах буюу хордуулахын оронд тэр энэ тухайд залбирсан.)
- Тэнгэрлэг Эцэг тэр шувуунд анхаарал халамж тавьсныг та нар яаж мэдэв? (Табернеклаас шувууг хэрхэн гаргахыг мэдэхэд нь Жон Ахад тусалсан.)

Бид Амьтад Найрсаг Байж Чадна

Ярилцлага

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр өөрсдийн нэгэн адил амьтад анхаарал халамж тавихыг бид бүгдээс хүсдэгийг тайлбарла.

Өөрсдөд нь буюу гэр бүлд нь байдаг аливаа гэрийн болон бусад амьтдын талаар ярихыг хүүхдүүдээс хүс. (Хэрэв хүүхдүүдэд гэрт нь амьтад байдаггүй бол, гэрийн ямар амьтадтай байхыг хүсдэг тухайг нь яриул.) Эдгээр амьтад анхаарал тавихад хэрхэн туслах талаар ярихыг хүүхдүүдээс хүс. Цэвэр цэнгэг ус, эрүүл ахуйд тохирсон хоол өгөх, амьтдын үсийг цэвэрлэх буюу тэдэнд эелдэг зөөлнөөр хандах зэргээр амьтад анхаарал халамж тавих талаар хийдэг зарим зүйлийг нь хүүхдүүдээр үггүй хөдөлгөөнөөр хийлгүүл.

Түүх

Сүмийн анхны Ерөнхийлөгч, Бошиглогч Иосеф Смит ч бас амьтад эелдэг зөөлөн хандахыг заадаг байв. Дараах түүхийг өөрийн үгээр ярь:

Бошиглогч Иосеф Смит, бас нилээд хэдэн өөр хүмүүс нэг жижигхэн голын эрэг дээр буудаллаад байв. Бошиглогч майхнаа босгож байгаад талын гурван хоржигнуурт могой олж харжээ. Бусад хүмүүс могойнуудыг

алах гэсэн боловч Бошиглогч тэднийг зогсоож, тэдэнд бүү хор хүргэ гэж эрчүүдэд хэлжээ. Могойнуудыг саваанд өлгөсөн эрчүүд тэднийг голын нөгөө талд болгоомжтойгоор гаргаж тавьжээ. Аливаа могой, шувуу эсвэл бусад амьтад тэднийг аялж байх үед хоол хүнсэнд хэрэгтэй л биш бол тэдгээр эрчүүд тэднийг алах ёсгүйг Бошиглогч бусад эрчүүдэд хэлжээ. (*History of the Church*, 2:71–72; мөн Spencer W. Kimball, *Ensign*, 1978 оны Арваннэгдүгээр сар, х. 45-ыг үз.)

Дүгнэлт

Есүс Христ бүх амьтдыг бүтээсэн бөгөөд газар дэлхий дээрх бүх бүтээлүүд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний хэсэг мөн гэдгийг хүүхдүүдэд сануул.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босгож, дараах бадгийн үгсийг хэлж, үйлдлүүдийг хийхэд нь тэдэнд тусал:

Есүс бүх бүтээлд хайртай (*гараа алдлан харуулна*):

Том өндөр заануудад, (*гараа толгой дээгүүрээ өндөрт өргөнө*),

Далайн загаснуудад (*гараа атгаж загас сэлж байгаа юм шиг хөдөлгөнө*),
Өчүүхэн жижиг амьтдад (*доошоо тонгойно*)

Тэр мөлхөгч шавьжнуудад хайртай (*нэг гарынхаа хуруунуудаар нөгөө гар дээрээ “мөлхөж” харуулна*).

Дэндүү жижигхэн хулганад (*доош тонгойно*)

Дээгүүр нисдэг шувуудад (*далавч мэт гараараа дэвнэ*)

Ойн халиун буга (*хоёр эрхий хуруугаа бусад хуруунуудтайгаа нийлүүлэн толгой дээрээ эвэр мэт байрлуулна*),

Бүгд Аврагчийн хайрыг мэдэрдэг (*хоёр гараа зүрхэн тушаагаа байрлуулна*).

Гэрчлэл

Амьтанд хандах эелдэг харьцааг та өөрөө үзүүлсэн буюу эсвэл өөр хэн нэгэн хүн амьтанд эелдэг зөөлөн хандахыг харсан тохиолдлынхоо тухай ярь. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр газар дэлхий дээрх бүх бүтээлүүдэд хайртай, мөн амьтдад эелдэг зөөлөн хандахыг биднээс хүсдэгийг гэрчил.

Энэ долоо хоногт амьтны төлөө ямар нэг сайн зүйл хийхэд нь хүүхэд бүрийг урамшуул.

Урлан бүтээх үйл ажиллагаа

Хүүхдүүдэд цаас, будгийн харандаанууд өгч амьтдад эелдэг зөөлөн хандахын тулд тэд юу хийж болох тухай зургуудыг тэднээр зуруул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын үгийг Жон Ах санасан тухай түүхийг өөрийн үгээр ярь:

“Чанга дуугаар олон удаа жиргэснийг нь санана би:

Зун цагт өдөржингөө,

Бутанд, модонд жиргэдэг

“Бяцхан шувуудыг бүү ал,

Тэдний жиргэх дуу уянгалаг.

Бяцхан шувуудыг бүү бууд!

Дэлхий Бурханы өмч,
Тэр бүгдэд хүнс өгдөг
Томд нь ч жижигхэнд нь ч.
(*Deseret Songs*, 1909, дугаар 163.)

“Надад дүүгүүр байлаа, бас надад сэлүүрт чавх байлаа. Би эдгээрийг өөртөө хийсэн бөгөөд тэд нэн сайн ажилладаг байв. Гэрээсээ миль хол газар үхрээ бэлчээрт гаргах нь миний үүрэг байв. Тэнд замын дагуу эгнэсэн хөвөнгийн том модод байдаг байв, тэгээд бутанд бас модонд жиргэгч бяцхан шувуудыг харвах сан гэсэн сүрхий уруу таталт учирдаг байсныг би санадаг, учир нь би сүрхий сайн харваач байв, би тавин ярд газар дахь шон буюу модны голыг онож чаддаг байв. Гэвч бараг Ням гараг болгонд, “Бяцхан шувуудыг бүү бууд” гэж дуулдаг байсан болохоор магадгүй би биеэ барьдаг байсан биз. . . . Хөөрхөн бяцхан шувуу хөл доор маань унахыг харах нь баяр хөөр биш байлаа” (*Spencer W. Kimball*, Чуулганы Илтгэлд, 1978 оны Дөрөвдүгээр сар, х. 71; мөн *Ensign*, 1978 оны Тавдугаар сар, х. 47–48-ыг үз).

2. Өөрийн дуртай амьтны дүрсийг барихын тулд хүүхэд бүрт давстай зуурсан гурил өг (давстай зуурсан гурилын жорыг 43-р хуудаснаас үзэж болно). Амьтдынхаа дүрсийг гэрийнхэндээ үзүүлэхийн тулд хүүхдүүдээр гэрт нь авч явуул.
3. Өөрийнхөө дуртай амьтны үйлдлүүдийг үггүй хөдөлгөөнөөр хүүхэд бүрээр ээлжлэн хийлгэ. Ямар амьтныг дүрсэлснийг бусад хүүхдүүдээр таалга. Хэрэв бусад хүүхдүүд ямар амьтан дүрслэгдсэнийг таахгүй бол, уг хүүхэд түлхүүрийг үгээр өгч болно.
4. Янз бүрийн амьтдын тухай түлхүүрүүдийг хүүхдүүдэд өг. Дүрсэлж байгаа амьтныг хүүхдүүд мэдсэн бол ямар ч үг хэлэхгүйгээр гараа өргөх ёстойг хүүхдүүдэд хэл. Түлхүүр нь ямар амьтны тухай болохыг гараа өргөсөн хүүхдээс асуу. Дараах түлхүүрүүдийг ашиглах буюу өөрийнхөө нутагт байдаг амьтдын тухай зарим түлхүүрүүд зохио:
 - Би зургаан хөлтэй, миний хүрэм ногоон:
Би бол таны үзсэн хамгийн сайн дэвхрэгч. (Дэвхрэг, царцаа.)
 - Би жижгхэн, олон нугалаатай сэрвэгэр;
Би хоёр талдаа үзүүртэй юм шиг харагддаг. (Чийгийн хорхой.)
 - Миний гэр сайхан сэрүүхэн цөөрөмд байдаг;
Би дэвхэрч, цовхрох тун дуртай. (Мэлхий.)
 - Хавар болоход та намайг хардаг;
Миний цээжин дэх улаан өд модонд өндөрт харагддаг.
(Улаан цээжит (ойн шувуу.)
 - Би дугариг нүүртэй,
Харанхуйд харж чаддаг хоёр том нүдтэй;
Хүмүүс намайг мэргэн гэдэг. (Ууль.)
 - Би хөл гар, нүд, чих, хамартай;
Би сүүлээрээ эсвэл хөлийнхөө хуруугаар модноос дүүжлэгдэж чадна.
(Сармагчин.)

- Хэрэв чи намайг унавал, би чамайг унуулаад явна.

Хазаараас минь барьж явбал намайг залахад амархан. (Морь.)

- Чамайг бодож амжихаас чинь өмнө модонд дүүлэн гарч чадна.

Миний саглагар сүүл баяртай гэх мэт түргэн түргэн далладаг. (Хэрэм.)

- Би ферм дээр амьдардаг, богинохон цагираг сүүлээ

Хоолны хувингаа хараад моодго, моодго хөдөлгөдөг. (Гахай.)

- Би гүйж, харайж, тоглох дуртай;

Миний хэлж чаддаг ганцхан үг бол “Май.” (Хурга.)




















(Таавруудыг “Who Am I?” *Children's Friend*, 1956 оны Тавдугаар сар, х. 208-аас хялбаршуулан авав.)

5. Хичээл хоёроос Варрены тухай түүхийг нэгтгэн дүгнэ (хуудас 7-г үз).

- Варрен эелдэг зөөлөн харьцааг амьтдад яаж үзүүлсэн бэ?

6. Хичээлийн эхэн дэх тохируулах тоглоомыг хүүхдүүдийнхээ хүссэн тоогоор давтан тогло.

7. Шувууны энгийн тэжээлийн тэвш хийж гэртээ аваачин, гаднах хаалгандаа өлгөхөд нь хүүхдүүдэд тусал. Нарсны самрын тос буюу боргоцой, эсвэл сонирхолтой хэлбэр гарган зүссэн зүсэм талхыг тэвшинд тавь. Боргоцой буюу талхыг шувууны үүрэнд тавь. Тэжээлийн тэвхийг мод, бут буюу шонгоос өлгөхийн тулд урт оосор хэрэглэ (Танай нутагт байдаг материалууд ашиглан, шувууны энгийн өөр хэлбэр маягтай тэжээлийн тэвш яаж хийхийг та мэддэг байж болно.)



Бид Есүс Христийн Амилалтыг (Улаан Өндөгний Баяр) Тэмдэглэдэг

Зорилго

Есүс Христ амилсан учраас бид Улаан Өндөгний Баярыг тэмдэглэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

1. Матай 27:57–66; 28:1–8; Марк 15:16–20, 40–47; 16:1–11; Лук 23:44–46; Иохан 20:1–18-ыг залбиралтайгаар судал.
 2. Танай нутагт Улаан Өндөгний Баярыг иргэний журмаар тэмдэглэдэг зүйлүүд, жишээ нь лаа, өндөг, цэцэг буюу гоёлын хувцас зэргийг зурах буюу зургийг нь олж ав. Хичээлийн өмнө эдгээр зүйлүүдийг ширээ, шал буюу самбар дээр дэлгэн үзүүл. Бусад зургуудын дотор Есүс Амилсан нь, хайчилбар 2-12-ыг үзүүл.
 3. “Есүс Үнэхээр Дахин Амилсан уу?” (*Children’s Songbook*, х. 64) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ.
 4. Шаардлагатай материалууд:
 - а. Библи.
 - б. Жижиг хүүдий буюу хайрцаг.
 - в. Хайчилбар 2-5, Цовдлолтын байдал; хайчилбар 2-6, Есүсийн Цогцсыг Ороосон нь; хайчилбар 2-7, булш; хайчилбар 2-8, том чулуу; хайчилбар 2-9, харуулууд; хайчилбар 2-9, тэнгэр элч; хайчилбар 2-11, тостой эмэгтэйчүүд; хайчилбар 2-12, Есүс Амилав. Хайчилбаруудыг анхны Улаан Өндөгний Баярын тухай түүхэнд ашиглагдах дарааллаар тавь.
 - г. Зураг 2-65, Амилсан Есүс Христ (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 239; 62187).
 5. Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.
-

Хичээл Заах

Зөвлөмж

Нээлтийн залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Улаан Өндөгний Баяр Дээр Бид Есүс Христийг Дурсан Санадаг

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Ширээ, шал буюу самбар дээр дэлгэн байрлуулсан зургуудыг үзүүл. Хүүхдүүдээр нэг удаад нэг зургийг таниулж, энд зурагдсан зүйл орон нутаг дахь Улаан Өндөгний Баярыг тэмдэглэдэг иргэний заншилтай яаж холбогдохыг тайлбарла.

Юм бүрийн тухай хүүхдүүд ярилцсаны дараа асуу:

- Энэ юм яагаад бид Улаан Өндөгний Баярыг тэмдэглэдгийн үнэн шалтгаан мөн үү? (Биш.)

Тэгээд нэг хүүхдээр зургийг авахуулж үүнийг жижиг хүүдий буюу хайрцагт хийлгэ.

Ганцхан Есүс Христийн хайчилбар үлдтэл зургуудын тухай ярилцахаа үргэлжлүүл.

- Энэ нь яагаад бид Улаан Өндөгний Баярыг тэмдэглэдгийн үнэн шалтгаан мөн үү? (Мөн.)

Есүс Христ бол бид Улаан Өндөгний Баярыг тэмдэглэдгийн жинхэнэ шалтгаан юм. Анхны Улаан Өндөгний Баяраар Есүс бидний хувьд маш гайхамшигтай нэг зүйлийг хийснийг хүүхдүүдэд сануул.

Анхны Улаан Өндөгний Баяраар Есүс Христ Амилсан Билээ

Хайчилбарууд
бүхий судрын түүх

Анхны Улаан Өндөгний Баярын тухай түүхийг өөрийн үгээр ярь (Матай 27:57–66; 28:1–8; Марк 15:16–20, 40–47; 16:1–11; Лук 23:44–46; Иохан 20:1–18-ыг үз). Таныг түүхийг ярьж байх үед холбогдох хайчилбаруудыг хүүхдүүдээр ээлжлэн өргүүл. Хэрэв хүүхдүүд уг түүхийг мэддэг бол үүнийг ярихад тэднээр өөртөө туслуул.

Цовдлолтын байдал, хайчилбар 2-5-ыг нэг хүүхдээр өргүүл.

Есүст дургүй байсан ёс бус хүмүүс эцэст нь түүнийг үхэлд хүргэх зөвшөөрлийг удирдагчдаасаа олж авсныг тайлбарла. Эдгээр хүмүүс Есүсийг зодож, түүгээр доог тохуу хийж байлаа. Тэд түүнийг хотын гаднах толгой дээр аваачиж загалмайд хаджээ.

Цовдлолтын хайчилбарыг тэр хүүхдээр доош нь буулгуулж, өөр нэг хүүхдээр Есүсийн Цогцсыг Ороосон нь, хайлчилбар 2-6-г өргүүл.

Есүсийг үхсэний дараа найз нар нь түүний цогцост анхаарал халамж тавьснаар түүнийг хайрлах хайраа харуулсныг тайлбарла. Тэд цогцсыг болгоомжтойгоор загалмайгаас буулгаж авав. Тэд цогцсыг цэвэрхэн шинэ даавуунд ороож, агуйн булш буюу толгойн энгэр дэх хаданд ухаж гаргасан нүхэн дотор тавьжээ.

Есүсийн цогцсыг ороосон тухай хайчилбарыг доош нь тавиулж, өөр хүүхдүүдээр булш, хайчилбар 2-7 болон том чулуу, хайчилбар 2-8-ыг дээш нь өргүүл.

Есүсийн найз нар түүний цогцсыг булшин дотор тавьсны дараа том чулууг өнхрүүлэн агуйн амыг тагласныг тайлбарла.

- Тэр орой Есүсийн найз нарт ямар санагдаж байсан гэж та нар бодож байна?

Харуулууд, хайчилбар 2-9-ийг нэг хүүхдээр өргөж харуул.

Дараа нь Аврагчийн зарим дайснууд булшны дэргэд харуул байрлуулсныг хүүхдүүдэд ярь. Гурав хоногийн дараа тэр амилах болно гэж Есүс хүмүүст ярьж байсан учраас тэд ингэсэн ажээ. Түүний амилна гэдэгт дайснууд нь итгэхгүй байжээ. Есүсийн найз нар түүний цогцсыг нуугаад, түүнийг дахин амьд болсон гэж хэлж магадгүй гэж тэд бодсон аж.

Тэнгэр элч, хайчилбар 2-10-ыг нэг хүүхдээр өргүүл.

Гурав дахь өдрийнх нь өглөө тэнгэр элч ирж, булшны аман дээр байсан том чулууг өнхрүүлэн холдуулсан ажээ. Харуулууд маш их айж, үхсэн мэт унацгаажээ.

Харуулуудын хайчилбарыг нэг хүүхдээр доош тавиулж, өөр нэг хүүхдээр тостой эмэгтэйчүүд, хайчилбар 2-11-г өргүүл.

Ням гараг байсан мөн тэр өдөр Есүсийн найз нар байсан зарим эмэгтэйчүүд булш руу очсоныг хүүхдүүдэд хэл. Тэд Есүсийн цогцос дээр тавих халуун ногоо авчирсан аж. Энэ нь нас барсан хүнд хайр хүндэтгэл үзүүлэхийн тулд тэр үед хүмүүс хийдэг байсан зүйл байв.

Хүмүүс тэр том чулууг булшнаас яаж хөдөлгөн холдуулсанд эмэгтэйчүүд гайхсаныг тайлбарла. Гэвч тэд булшинд ороход том чулууг зайлуулж, бас Есүсийн цогцос алга болсон байв. Тэд булшны ойролцоо нэг тэнгэр элчийг харжээ.

- Аврагчийн цогцос алга болсныг харсан эмэгтэйчүүдэд ямар санагдсан гэж та нар бодож байна?
- Тэд тэнгэр элчийг хараад ямар санагдсан гэж та нар бодож байна?

Судар

Матай 28:5–6-д тэнгэр элч эмэгтэйчүүдэд юу гэж хэлснийг чанга унш.

Тэнгэр элч бас түргэн явж, Есүс Христ нас барагсдаас боссоныг шавь нарт нь хэл гэж эмэгтэйчүүдэд хэлснийг тайлбарла (Матай 28:7-г үз).

Бүх хайчилбаруудыг хүүхдүүдээр доош тавиулж, өөр нэг хүүхдээр Есүс Амилсан нь, хайчилбар 2-12-ыг өргүүл.

Эмэгтэйчүүд шавь нарт хэлэхээр явсныг, мөн дараа нь бусад шавь нар Есүсийг харсныг тайлбарла. Тэр дахин амьд болсон байлаа.

- Есүс Христ дахин амьд болсныг мэдэхэд шавь нарт нь ямар санагдсан гэж та нар бодож байна?

Нэгтгэн дүгнэх үйл ажиллагаа

Бүх хайчилбарыг ширээн дээр буюу шалан дээр доош нь харуулан тавь. Хүүхдүүдээр тус бүр нэг хайчилбарыг ээлжлэн сонгуулж, Есүсийн амилалтын тухай түүхийн аль хэсэгт тохирохыг хэлүүл.

Улаан Өндөгний Баяр Дээр Биднийг Амилуулагдах Болно Гэдгийг Бидэнд Сануулдаг

Багшийн танилцуулга

Амилсан Есүс Христ, зураг 2-65-ыг үзүүл.

Есүс Христийг үхсэний дараа түүний сүнс биеийг нь орхиж, тэнгэр өөд явсныг тайлбарла. Гурван өдрийн дараа түүний сүнс биендээ эргэн ирж, тэгээд түүний бие дахин амьд болжээ. Бид үүнийг амилалт гэж нэрлэдэг. *Амилсан* гэдэг үгийг хүүхдүүдээр хэдэн удаа чанга давтан хэлүүл.

Есүс бол Тэнгэрлэг Эцэгийн амилсан хүүхдүүдийн анхных нь байсныг тайлбарла. Тэр амилсан учраас бид бүгдээрээ амилуулагдах болно. Бид үхсэнийхээ дараа Есүс шиг ердөө гуравхан хоноод амилуулагдахгүй байж болно, гэвч хэзээ нэгэн цагт бид амилуулагдах болно.

Түүх

Есүс Христийн тухай болон түүний амилалтын талаар бодсон үедээ баяртай байсан охины тухай түүхийг ярь:

Кармен өөрийн хөрш, Шмидт ахын цэцэрлэгийн ойролцоох хашаандаа тоглох дуртай байв. Шмидт Ахыг цэцэрлэгтээ ажиллаж байх үеэр Кармен түүнтэй олонтаа ярилцдаг байлаа. Тэд сайн найзууд болжээ.

Шмидт Ах их өндөр настай байсан учраас нас барсан гэж нэг өдөр Кармены ээж түүнд хэлжээ. Түүний сүнс биеийг нь орхиж явсан ч гэсэн бие нь дахиад амьд болсонгүй.

Шмидт Ахыг санах болно гэдгээ Кармен мэдэж байсан хэдий ч, ээж нь Улаан Өндөгний Баярын тухай түүхийг түүнд сануулсан аж. Есүсийн амил-

сан тухай түүхийг Карменд сануулжээ. Бид нас барсныхаа дараа бүгдээрээ амилуулагдаж, дахин амьдрах болно гэж Есүс хэлснийг тэр мэдэж байлаа. Шмидт Ах ч бас амилуулагдах болно гэдгийг Кармен мэдэж байв. Есүс биднийг амилуулагдах боломжтой болгосонд тэр баяртай байлаа.

Ярилцлага

Анхны Улаан Өндөгний Баяраар Есүс Христ амилсан тэр үеийн тухай бид өгүүлж байгааг тайлбарла. Есүсийг хайрладаг бүх дэлхийн хүмүүс Улаан Өндөгний Баяраар Есүсийн амилалтыг тэмдэглэдэг.

- Улаан Өндөгний Баяраар бид яагаад баяртай байдаг вэ? (Бид болон бидний хайртай бүх хүмүүс Есүсийн нэгэн адил амилуулагдах болно гэдгийг бид мэддэг.)
- Есүс Христийг дурсан санаж, Улаан Өндөгний Баярын талаарх баяр баясгалангаа харуулахын тулд бидний хийж болох зүйлүүд юу вэ? (Хариултууд нь Есүсийн тухай гэртээ ярилцах, гэрийнхэнтэйгээ хамт Есүсийн тухай дуу дуулах Улаан өндөгний баярын тухай тусгай хичээл, хөтөлбөр болон сүмийн дуунуудтай байх гэхчлэн байж болно.)

Дүгнэлт

Дуу

Хүүхдүүдийг босгож, “Есүс Үнэхээр Дахин Амилсан уу?” дууг дуулах буюу эсвэл үгийг нь хэлүүл. Доорх үйлдлүүдийг хийхэд нь тэдэнд тусал:

Есүс үнэхээр дахин амилсан уу (*алгаа дээш нь харуулан гараа алдал*)
Тийм ээ, гурав дахь өдөр ирэхэд (*гурван хуруугаа дээш нь гозойлго*),
Тэр сэрж, булшийг орхисон (*дороо алхална*);
Тэр Марийг нэрээр нь дуудсан (*хоёр гараараа амандаа дугуй үүсгэ*).

Есүс хайртай хүмүүсийнхээ гэрт ирсэн үү (*хоёр гараа зүрхэн тушаагаа байрлуул*)?

Тийм ээ, хүмүүс түүний хөлийг тэмтэрч үзсэн (*доош бөхийж, хөлдөө хүр*),
Тэгээд загас, зөгийн балнаас
Тэр үнэхээр идсэн (*үггүйгээр идэж байгааг дүрсэл*).

Түүний гар дээр хадаасны ором байв (*гар руугаа заа*)
Хажуу талд нь жадны ором байв (*хажуу тал уруугаа заа*).
Үхсэнийхээ дараа тэгээд
Үнэхээр Есүс дахин амьд болсон уу (*алгаа дээш нь харуулан гараа алдал*)?
Тийм ээ! Би бас тэгэх болно (*толгой дохино*)!

Гэрчлэл

Есүс Христийн амилалтын тухай гэрчлэлээ хэл. Нэгэн цагт та өөрөө болон таны хайртай хүмүүс амилуулагдах болно гэдгийг мэдэх нь ямар санагддагаа хүүхдүүдэд хэл.

Есүс Христийн амилалтын талаар гэрийнхэндээ ярихад нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд

Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. Хичээлийн төгсгөл дэх “Анхны Улаан Өндөгний Баяр” зурагт түүхийг хүүхдүүдтэй хамт унш. Зохих газарт нь зургаар төлөөлүүлсэн үгсийг бөглөхөд нь хүүхдүүдэд тусал. Боломжтой бол түүхийг хүүхэд бүрийн тоогоор хувилан ашиглаж болно.
2. Нас барсан гэр бүлийнхээ нэг гишүүн буюу найзынхаа зургийг авчир. Зургийг хүүхдүүдэд үзүүлж, энэ хүнтэй хамт хийсэн өөрийн хийсэн зарим зүйлийн тухай мөн та яагаад энэ хүнээр бахархдаг буюу түүнийг хайрладаг байснаа ярь. Хэзээ нэгэн цагт энэ хүнтэй дахин уулзах боломжтой байх болно гэдгийг мэдэх нь танд ямар санагддагаа илэрхийл.
3. *Бид Дахин Амьдрах Болно* гэж бичсэн цаасыг хүүхэд бүрт өг. Хүүхдүүдэд будгийн харандаанууд өгч гэрийнхнээсээ буюу эсвэл хайрладаг байсан нас барсан хүмүүсийнхээ зургийг зурахыг тэднээс хүс. Зургуудынхаа талаар ангийн бусад гишүүдэд хүүхдүүдээр яриул.

Есүс Христ амилсан учраас бид нас барсныхаа дараа бүгд амилуулагдах болно гэдгийг хүүхдүүдэд сануул. Бидний хайртай байсан хүмүүс бүгд бас нэгэн цагт амилуулагдах болно.
4. Хүүхдүүдийн таних буюу ажигласан бие бялдрын буюу оюуны гажигтай хүмүүсийн талаар тэдэнтэй ярилц. Бид амилуулагдах үед бидний бие бялдар төгс байх болно гэдгийг ойлгоход нь тусал (Алма 40:23-ыг үз). Тахир дутуу хүн нэг ч байхгүй байх болно. Энэ нь хичнээн гайхамшигтай байх тухай ярилц.
5. “Есүс Боссон” (*Children’s Songbook*, х. 70) дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Есүс бидний найз,
Есүс боссон.
Зүрх сэтгэл минь баяраар дүүрнэ;
Тэр дахин амьд.
Түүнд магтууг дуулна бид,
Энэ бол Улаан Өндөгний Баяр.
Есүс боссон,
Аврагч бурханлиг.
Есүс боссон,
Аврагч бурханлиг!

Анхны Улаан Өндөгний Баяр




найзнар



булш





чулуу




цэргүүд






тэнгэр элч


Есүсийг үхэхэд түүний  гунигтай байв. Тэд түүнийг 



тавьжээ.  өмнө талд том  тавив.  хэн ч өнхрүүлэн




холдуулахгүйг харахын тулд дэргэд нь  зогсож байв.


Есүсийн цогцос **3** өдөр  дотор байжээ. Тэгээд гурав дахь

өдрийн өглөө  хүрч ирэн  өнхрүүлэн холдуулсан аж. 

 хараад айжээ.

Тэр өдөр Есүсийн  найз нар  уруу хүрч ирэв.

 өнхрөн холдсоныг тэд харав.  нэг  байлаа. “Тэр энд

байхгүй: учир нь тэр боссон” гэж  хэлжээ.

Бид бүгд үхсэний дараа дахин амьдарч болохын тулд Есүс үхсэн юм.

Есүс нас барагсдаас босч ирсэн тэрхүү өдрийг хүн бүгдэд сануулахын

тулд бидэнд Улаан Өндөгний Баяр байдаг.

Есүс Христ Бол Хамгийн Агуу Бэлэг (Зул Сарын Баяр)

Зорилго

Бидний Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг дэлхий рүү илгээснээр бидэнд өгсөн агуу бэлгийг үнэлэхэд нь хүүхэд бүрт туслах.

Бэлтгэл

- Матай 2:1–12, Иохан 3:16-г залбиралтайгаар судал.
- Есүсийн Төрөлт, зураг 2-41-ийг (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 200; 62116) хайрцагт байрлуул, хэрэв боломжтой бол, үүнийг бэлэг мэт боо. Шошгон дээр *Иохан 3:16* гэж бичээд үүнийг бэлгэнд бэхэл.
- Хуудас цаасыг дундуур нь нугалан карт болгож, нэг тал дээр нь *Хөгжилтэй Зул Сарын Баяр* гэж бичээд хүүхдийн тоогоор карт хий. Хэрэв боломжтой бол, хүүхдүүдэд картуудаа хийх дугтуйнууд авчир.
- Мэргэн Хүмүүсийн дагаж явсан одыг төлөөлүүлэн цаасан од хайчлах буюу зур (одны загварыг хичээлийн төгсгөлд өгөгдсөн байгаа)
- Мари, Иосеф, Мэргэн Хүмүүсийг биечлэн тоглохын тулд хэрэглэх зарим энгийн хувцсууд (хүзүүний ороолт буюу орхимж гэх мэт) авчир. Хэрэв хувцас олдохгүй бол, дүрүүдийг харуулах нэрийн шошгуудыг авчир. Бас Есүсийг төлөөлөх хүүхэлдэй болон Мэргэн Хүмүүсийн бэлгүүдийг төлөөлөх эд юмс (хайрцаг, жижиг сав болон ваар гэх мэт) авчир.
- “Тэр Хүүгээ Илгээсэн” (*Children’s Songbook*, х. 34) дууг дуулах буюу үгийг нь хэлэхэд бэлтгэ. Энэ дууны үг гарын авлагын ар талд байгаа.
- Шаардлагатай материалууд:
 - Библи.
 - Зул Сарын Баярын сүнслэг хөгжмийн бичлэг (сонголтоор).
 - Харандаа, будгийн харандаанууд.
 - Зураг 2-7, Мэргэн Хүмүүс (Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга 203; 62120).
- Өөрийн ашиглахыг хүссэн аливаа баяжуулах үйл ажиллагаанд шаардлагатай бэлтгэлүүдийг ханга.

Хичээл Заах Зөвлөмж

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Долоо хоногийн хугацаанд хүүхдүүдээр ямар нэг юм хийлгэхээр та тэднийг урамшуулан дэмжсэн бол үүнийгээ шалга.

Есүс Христийн Төрөлт Агуу Бэлэг Байв

Анхаарал
төвлөрүүлэх үйл
ажиллагаа

Боосон бэлгийг хүүхдүүдэд үзүүл. Биднийг нэн их хайрладаг нэг хүнээс ирүүлсэн гайхамшигтай бэлгийг төлөөлсөн нэг зүйл боодол дотор байгааг тэдэнд хэл.

Хүүхэд бүрээр ээлжээр бэлгийг өргүүлж үзүүлэн дотор нь юу байгааг таалга.

Шошго нь түлхүүр болохыг хүүхдүүдэд хэл. Иохан 3:16-г чанга унш. Одоо бэлэг нь юу болох хийгээд хэнээс ирснийг тэд мэдсэн эсэхийг нь хүүхдүүдээс асуу (*Бурхан гэдэг бол Тэнгэрлэг Эцэгийн өөр нэгэн нэр гэдгийг та хүүхдүүдэд сануулах хэрэгтэй байж болно*). Бэлгийг нэг хүүхдээр задлуулж, зургийг хүн бүгд харж болохын тулд дээш нь өргүүл.

Ярилцлага

- Бэлэг нь юу вэ?
- Бэлэг хэнээс ирсэн бэ?
- Яагаад Есүс Христийн төрөлт ийм агуу бэлэг байдаг вэ?

Есүс Христийн төрөлт ийм агуу бэлэг байдгийн нэг шалтгаан нь Есүс амьдрах зөв замыг бидэнд заахаар ирсэн явдал мөн гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд туслах. Бусдыг хайрлаж, тэдэнд туслах нь биднийг аз жаргалтай болгох болно гэдгийг тэр бидэнд заадаг байжээ. Есүсийг дэлхийд илгээснээрээ зөвхөн Зул Сарын Баяраар төдийгүй, харин аз жаргалыг үргэлж олоход бидэнд туслах бэлгийг Тэнгэрлэг Эцэг бидэнд өгсөн юм.

Дуу

“Тэр Хүүгээ Илгээсэн” дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Мэргэн Хүмүүс Нялх Есүст Бэлгүүдийг Өгчээ.

Судрын түүх ба ярилцлага

Бидэнд өгсөн өөрийн бэлгийн тухай Тэнгэрлэг Эцэг хүн бүгдийг мэдээсэй гэж хүсч байсан, иймээс тэр үзэсгэлэнт шинэ одыг тэнгэрт байрлуулсныг онцлон тэмдэглэ.

Мэргэн Хүмүүс, зураг 2-7-г үзүүлж, Есүсийг олохын тулд тэр одыг дагаж явсан Мэргэн Хүмүүсийн тухай түүхийг ярихыг хүүхдүүдээс хүс (Матай 2:1–12-ыг үз). Тэдний мартсан байж болох аливаа тодруулах зүйлд хүүхдүүдэд тусал.

Матай 2:11-ийг чанга унш.

- Мэргэн Хүмүүс Есүст ямар бэлэг авчирсан бэ?

Франкинсенс болон мирр нь шашны ёслолуудад хэрэглэгддэг байсан анхилуун үнэртэн байсныг тайлбарла. Гурван бэлэг бүгд их үнэтэй олоход хэцүү байжээ. Мэргэн Хүмүүс өөрсдийн олж чадах хамгийн сайхан бэлгийг Есүст авч ирэхийг хүсч байжээ.

- Мэргэн Хүмүүс яагаад эдгээр бэлгүүдийг Есүст авчирсан бэ? (Тэд түүнийг хайрлаж, хүндэтгэдгээ харуулахын тулд.)
- Яагаад Мэргэн Хүмүүс Есүсийг хараад тэргүүнээ мэхийлгэн түүнийг бишрэн шүтсэн бэ? (Тэр бол Аврагч, Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдгийг тэд мэдэж байжээ.)

Жүжигчлэн тоглох үйл ажиллагаа

Мэргэн Хүмүүсийн тухай түүхийг хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул. Оролцохыг хүссэн хүүхэд бүрт аль нэг дүрийг өг. Хүүхдүүд Мари, Иосеф, Мэргэн Хүмүүс болж болно (хүн бүрийг оролцуулахын тулд Мэргэн Хүмүүс хэд ч байж болно). Та бас нэг хүүхдээр цаасан одыг өргүүлж болно. Хувцсаа өмсөх буюу нэрийн шошгоо хадахад нь хүүхдүүдэд тусал.

Тоглолтод нэмэхийн тулд, Зул Сарын Баярын сүнслэг хөгжмийг ар талд аяархан тоглуулж болно.

Матай 2:1–12-оос сонгож авсан шүлгүүд, ялангуяа шүлэг 2 болон 9–11-ийг унших замаар хүүрнэн өгүүл. Матай 2:2-ыг Мэргэн Хүмүүсээр өөртэйгөө хамт давтан хэлүүлж болно. (Хэрэв шаардлагатай бол, *Иудейчүүдийн Хаан* гэдэг нь Есүс Христийн өөр нэг нэр болохыг тайлбарла.)

Хайрын Бэлэг Өгөх нь Бидэнд Баяр Хөөр Авчирдаг

Түүх

Есүст өгсөн бэлгээр дамжуулан Мэргэн Хүмүүс түүнийг хайрлах өөрсдийн хайрыг харуулсны адилаар бид бусдыг хайрлах хайраа харуулахын тулд тэдэнд бэлэг өгч болно гэдгийг тайлбарла.

Хожим нь Ерөнхий Эрх Мэдэлтэн болсон С.Дилвөрт Янг гэдэг хөвгүүний тухай дараах түүхийг ярь.

С.Дилвөрт Янгийг таван настай байхад болсон Зул Сарын Баярын үеэр нэг дэлгүүрийн цонхон дээр эвлүүлдэг зураг тавьсан байхыг тэр харжээ. Эвлүүлдэг зурагт галт тэрэг чирсэн хөгшин морины зураг байв. Зул Сарын Баярт зориулсан тэр эвлүүлдэг зургийг Дилвөрт бусад юунаас ч илүүгээр хүсч байжээ.

Зул Сарын Баярт зориулсан тэр эвлүүлдэг зурагт юу тохиолдсоныг Ахлагч Янг хожим нь тайлбарлахдаа:

“Тэгсээр Зул Сарын Баярын өглөө болоход, миний сандал дээр оймс дүүрэн сайхан зүйлүүд өлгөсөн байхыг би олж харлаа. Гэтэл бас баруунтаа нь миний нөгөөх үгийн сүлжээ бас харагдаж байв. Энэ нь тод өнгийн цаасан боодолтой байсан хэдий ч, хэлбэрээр нь юу болохыг би хэлж чадах байлаа. Би хайрцгийг түргэн онгойлгож, тэгээд удалгүй эвлүүлдэг зургийг хамтдаа бөглөхөд хамаг ухаанаа тавьсан байв.

“Удсан ч үгүй аав маань өрөөнд орж ирээд манай гудамжинд Женсений гэр бүл саяхан Даниас ирснийг миний эрэгтэй дүү, эгч бид гуравт хэлэв. Тэдний аав нь ажилгүй, мөнгөгүй байгааг тэр хэлээд бид Зул Сарын Баярын хоолоо тэдэнд аваачиж өгөхийг бидэнд санал болгов. Тэрчлэн аав хамгийн дуртай тоглоомоо сонгон авч Женсений хүүхдэд өгөхийг бид гурваас хүсч билээ. . . .

“Бид Женсенгийнхэн уруу явахаасаа өмнө би эвлүүлдэг зургаараа гурван цагийн турш тоглон цагийг сайхан өнгөрөөж билээ. Би өөр нэг юм өгөсөн гэж бодсон боловч бэлгэнд өгөх ганцхан л зүйл байсныг яах аргагүй мэдлээ.

“Арван нэг дөчин тавд бид гарлаа. Аав цацагт хяруулын махыг тэвшин дээр тавьж авч явав. Ээж, миний эгч Эмили төмс, сүмс, амтлагч, цангис жимс, амттан авч явлаа. Харин би нямбайлан боосон нөгөөх өөрийнхөө дуртай галт моторын эвлүүлдэг зургаа барьж явав.

“Бид Женсенгийн гэрт орж, буланд байсан жижигхэн ширээн дээр Аав цацагт хяруулаа тавихад, бусад нь дагалдав.

“Бид бүгдээрээ ээлжлэн бэлгийг түүнд өглөө. Эмили охинд нь гоё хүүхэлдэй өгөв. Би урагш алхаж, миний насны хөвгүүнийг харлаа. Би май гэж хэлээд эвлүүлдэг зургийг түүнд өглөө. Тэр үүнийг надаас аваад инээмсэглэв. Миний удаах эрэгтэй дүү өөрийнхөө хандивыг хамгийн бага хүүхдэд нь өгөв. Тэгээд бид гэртээ эргэж ирж билээ.

“Манай гэр Женсенгийнхний гэр хоёрын хооронд нэг л хороололд явган явах зуур хөл минь бараг л газарт хүрэхгүй шахам байсан нь хачирхалтай байлаа. Би чухам л сайн сайхан мэдрэмжийн үүлэн дунд хөвж явах шиг санагдаж байв, учир нь би өөр хүнийг баяртай болгосноо мэдэж байв.

“Манай Зул Сарын Баярын зоог лаазалсан вандуй, талх, цөцгийн тос, савласан жимс байсан боловч Зул Сарын тусгай Баярын хувьд мартагдашгүй утга учиртай байлаа!” гэжээ (S. Dilworth Young, “Friend to Friend: A Special Christmas,” *Friend*, 1972 оны 12-р сар, х. 20–21).

Ярилцлага	<ul style="list-style-type: none"> • Өөрийг нь баяртай болгосон ямар зүйлийг Дилвөрт хийсэн бэ? • Өөрийнхөө дуртай тоглоомыг аваачиж өгсний дараа яагаад тэр баяртай байсан бэ? • Хүнийг баяртай болгосон ямар нэг зүйлийг та нар түүнд өгч байсан уу? <p>Бусдад бэлэг өгөх замаар тэднийг баярлуулж байсан тохиолдлуудынх нь талаар хүүхдүүдээр яриул.</p>
Багшийн танилцуулга	<p>Бид бусдад бэлэг өгснөөр тэднийг хайрладаг гэдгээ харуулдгийг тайлбарла. Бэлэг хүлээж авах нь биднийг баяртай болгодог бол бас бэлэг өгөх нь биднийг баяртай болгодог. Их хайрладгаа харуулах гэж хэтэрхий үнэтэй бэлэг авах ёсгүйг онцлон тэмдэглэ. Хамгийн сайн бэлэг бол үйлчлэлийн бэлэг юм.</p>
Түүх	<p>Үйлчлэлийн бэлэг өгсөн хөвгүүний тухай түүхийг ярь. Та дараах түүхийг ашиглаж болно:</p> <p>Зул Сарын Баяр удахгүй болох гэж байв, тиймээс Бет гэрийнхэндээ хичнээн их хайртайгаа харуулахын тулд тэдэнд Зул Сарын Баярын бэлэг өгөхийг хүссэн ажээ. Гэвч Бетэд ямар ч мөнгө байсангүй. Тэр ямар ч бэлэг өгч чадахгүй юм байна гэж бодоод, их гунигтай байлаа. Тэгтэл Хүүхдийн Хэсгийн багш нь хамгийн сайн бэлэг бол мөнгөөр худалдаж авч болдоггүй зарим бэлэг юм гэж ангийнханд нь ярьж байсныг Бет санажээ. Бет үйлчлэлийн бэлэг өгөхөөр шийдсэн аж.</p> <p>Бет гэр бүлийнхээ гишүүн бүрт карт хийж, карт бүр дээрээ гэр бүлийнхээ гишүүн бүрт зориулан хийж болох ямар нэг зүйлийг бичжээ. Эмэгтэй дүүгийнхээ картан дээр тэр түүний дуртай тоглоомыг түүнтэй тоглоно гэж бичив. Ахынхаа картан дээр нэг орой түүний ээлжинд аяга тавгаа угаана гэж тэр бичив. Ээжийгээ зүүрмэглэх хооронд нялх хүүхдийг харахаар түүнд амласан аж, мөн аавдаа тэр цэцэрлэгт ажиллахад нь туслахаар амлав. Түүний дуртай бэлэг эмээд нь амлагдсан байв: тэр нэг сарын турш өглөө болгон хамгийн түрүүнд эмээгээ чанга тэвэрч байхаар түүнд амласан аж.</p> <p>Зул Сарын Баярын өглөө Бет бэлгүүдээ гэрийнхэндээ өгөв. Бетийн үйлчлэлийн бэлэг хүн бүгдэд таалагдлаа. Бет тэдэнд ийм гайхамшигтай сайхан бэлэг өгсөн учраас тэр өөрсдийг нь хайрладгийг тэд мэдэв.</p>
Картан дээрх үйл ажиллагаа	<p>Хүүхэд бүрт карт, харандаа буюу будгийн харандаанууд өг. Тэд бүгдээрээ эдгээр картуудаар Бетийн хийсэн шиг үйлчлэлийн бэлэг өгч болно гэдгийг хүүхдүүдэд хэл.</p> <p>Ах эгч дүү нарынхаа орыг засах, хоолны ширээ засах жаахан дүү нартайгаа тоглох эсвэл эцэг эхийнхээ зараалаар юманд явах зэрэг хүүхдүүдийн өгч болох зарим бэлгийн тухай ярилц. Үйлчлэлийн бэлэг болон үүнийг өгөх хүнийг сонгоход нь хүүхэд бүрт тусал.</p> <p>Картны дотор талын хуудасны дээд талд <i>Би үйлчлэх болно</i>, доод талд нь <i>Таны төлөө</i> гэж бичихэд нь хүүхэд бүрт тусал.</p> <p>Үйлчлэлийн бэлэг болгож өөр хэн нэгэн хүнд зориулан юу хийх гэж байгааг нь хүүхэд бүрээр хуудасны дунд талд нэг зураг зуруул</p> <p>Хэрэв та дугтуйнууд авчирсан бол, картыг дотор нь хийлгэхийн тулд хүүхэд бүрт нэг дугтуй өг. Бэлгийг хүлээн авагчийн нэрийг дугтуйн дээр буюу эсвэл картан дээр бичихэд нь хүүхдүүдэд тусал.</p> <p>Гэрийнхэн нь бэлэг солилцох үед картуудаа тэдэнд өгөхийг хүүхдүүдэд сануул.</p>

Хүүхдүүд иймэрхүү бэлгийг гэр бүлийнхээ бусад гишүүд буюу найз нартаа зориулан бэлтгэхийг та тэдэнд санал болгож болно.

Дүгнэлт

Багшийн
танилцуулга

Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгсөн хамгийн чухал бэлэг гэдгийг хүүхдүүдэд сануул. Яагаад гэвэл бид хэзээ нэгэн цагт түүнтэй болон Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар эргэж очиход Есүс бидэнд туслах болно. Тэнгэрлэг Эцэг Есүсийг дэлхийд илгээх замаар биднийг хайрладаг хайраа харуулсан шиг, бид бусдад тусгай бэлэг өгснөөр тэднийг хайрлах хайраа харуулж чадна.

Гэрчлэл

Есүс Христ бол бидний Аврагч болох тухай гэрчлэлээ хэл. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бүгд бүгдэд хичнээн хайртайг бодох үед өөрт чинь ямар санагддаг тухай хүүхдүүдэд хэл. Мөн түүнчлэн та бусдад бэлэг өгөх үед ямар санагддагаа хүүхдүүдэд ярь.

Зул Сарын Баярыг тэмдэглэх үеэрээ Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дурсан санахад нь хүүхдүүдийг урамшуул.

Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

Баяжуулах Үйл Ажиллагаанууд



Дараах үйл ажиллагаануудаас ангийнхаа хүүхдүүдэд хамгийн сайн тохирохыг нь сонгож ав. Та тэдгээрийг хичээл дээр ашиглах, эсвэл дүгнэлт буюу нэгтгэн дүгнэлт болгон ашиглаж болно. Нэмэлт удирдамжийг “Багшид зориулсан тусламжууд”-ын “Хичээлийн цаг” хэсгээс үз.

1. “Амгалан Шөнө” (Дуулал, х.53) дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг нь хэл.

Амгалан шөнө! Ариун шөнө!
Эх хүү хоёрыг тойроод
Эргэх орчлон тайван саруул.
Энхрий хонгор үр минь ээ
Амар тайван нойрс доо
Амар тайван нойрс доо

2. “Малын Тэвшинд” (*Children’s Songbook*, х. 42), “Марийн Бүүвэйн Дуу” (*Children’s Songbook*, х.44), эсвэл “Өө, Чимээгүй Бай, Миний Хүү” (*Children’s Songbook*, х. 48) дуунуудыг дууулан буюу үгийг нь хэл. Эдгээр дуунуудын үг гарын авлагын ар талд байгаа.

3. Матай 2:1–2, 9–11-ийг чанга унш. Мэргэн Хүмүүст харагдсан одны ач холбогдлын тухай ярилц. Цаасаар хоёр гурвалжин хайчилж, нийлүүлэн одыг чимэхэд нь хүүхэд бүрт тусал (доорх загварыг хар). Одуудыг хүүхдүүдээр гэрт нь авч хариул.



Дуунуудын Үгс

Аз Жаргалтай Гэр Бүл

Би ээждээ хайртай: тэр надад хайртай.
Бид аавдаа хайртай, тийм ээ тийм
Тэр бидэнд хайртай, бид аз жаргалтай

Гэр бүл болохыг та харж байна шүү дээ.
Би эгчдээ хайртай; тэр надад хайртай.
Бид ахдаа хайртай, тийм ээ тийм;
Тэр бидэнд хайртай, бид аз жаргалтай
Гэр бүл болохыг та харж байна шүү дээ
(© 1948, 1975 by Pioneer Music Press, Inc.
Жэкман Хөгжмийн Корпорацийн зөвшөөрлөөр
ашиглана.)

Малын Тэвшинд

Малын тэвшнээс өөр, унтах газаргүй
Бяцхан Их Эзэн Есүс орон дээр хэвтэж байна;
Тэнгэрийн одод түүний дэрээс доош харжээ,
Бяцхан Их Эзэн Есүс өвсөн дээр нойрсоно.

Үхэр доош тонгойход, хөөрхий хүү сэрэв;
Гэвч Их Эзэн Есүс уйлсан ч үгүй.
Их Эзэн Есүс танд би хайртай, тэнгэрээс доош
хараач
Өглөө болох ойрттол миний өлгийн дэргэд үлдээч.

Надад ойр байгаач, Их Эзэн Есүс; таныг үлдээч
гэж хүснэ би
Надад үүрд ойр байж, намайг хайрлаач, зал-
бирья би
Өөрийнхөө ялдамхан энхрийлэлд бүх хүүхдийг
адислаач,
Өөртэйгөө хамт тэнгэрт амьдрахад биднийг
тохирох болгооч.

Баптисм

Иудейд эрт дээр үед
Есүс Иохан Баптист дээр ирэв.
Иордан голд хөвөн
Умбуулалтаар баптисм хүртэв.

Яагаад баптисм хүртэх болов гэж
Баптистыг асуухад
“Хуулийг биелүүлэхийн тулд”,
“Дээд тэнгэр дэх хаант улсад
Эцэгийн хамт орохын тулд” гэж Есүс
хэлэв.

Есүсийн үгэнд бид итгэх ёстойг
Эдүгээ бид мэддэг,
Дуулгавартайгаа харуулахын тулд
Бидний Их Эзэн Есүс Христийн адил
баптисм хүрт.

Зөв Замыг Сонго

Амьдрах, аз жаргалтай байх зөв зам бий;
Энэ бол өдөр бүр зөвийг сонгох.
Есүсийн заадаг зүйлүүдийг би сурна
Энэ нь надад тусалж замыг надад
үзүүлнэ.

Дахилт:

Зөв замыг сонгож, аз жаргалтай бай.
Зөвийг би үргэлж сонгох ёстой.
Сайн мэдээгээр дамжуулан залбирал-
тай байхыг,
Итгэлтэй байхыг, наманчлахыг, дуулга-
вартай дагахыг сурна би,
Хэрэв би түүний заадаг зүйлүүдээр
амьдрах юм бол,
Өдөр бүр жинхэнэ аз жаргалтай байхаа
мэднэ би.

Дахилт:

Зөвийг Хийх Зоригтой Бай

Зөвийг чи хий! Чи үнэнч бай! Чиний л хийх ёстой
Ажил болохоор, зоригтой, даруу байн;
Чи маш сайн хий. Элч хийснийг чинь үтэр хэлэ-
хээр яарна.
Хий, хий, зөвийг чи хий; Бай бай, чи үнэнч бай,
чи үнэнч бай.

Миний Хийдгийн Адилаар Хий

Миний хийдгийн адилаар хий
Намайг дага, намайг дага!
Миний хийдгийн адилаар хий;
Намайг дага, намайг дага!
Хэрэв би өндрийг эсвэл намыг хийвэл
Хэрэв би хурдан эсвэл удаан хийвэл,
Миний хийдгийн адилаар хий;
Намайг дага, намайг дага!
Миний хийдгийн адилаар хий;
Намайг дага, намайг дага!
(© 1963 by D. C. Heath and Company.
Зөвшөөрлөөр ашиглана.)

Өгөөч, Гэж Бяцхан Горхи Хэлжээ

“Өгөөч” гэж бяцхан горхи хэлжээ.
Өө! “Өгөөч”, Өгөөч, Өгөөч Өө! “Өгөөч”
“Өгөөч” гэж бяцхан горхи хэлж
Толгойг уруудан яарна;
“Би жижигхэн, гэвч хаашаа яваагаа мэднэ
Талбай улам ногоорон харагдсаар.”

Дахилт:

Өдөржингөө дуулна, дуулна
“Өгөөч, Алив! Өгөөч.”
Өдөржингөө дуулна, дуулна
“Өгөөч, Алив! Өгөөч, алив өгөөч.”
“Өгөөч” гэж бяцхан горхи хэлнэ.
Өө! “Өгөөч”, Өгөөч, Өгөөч, Өө! “Өгөөч”
“Өгөөч” гэж бяцхан горхи хэлж
Өнгийн цэцгүүд дээр унана;
“Тэдний гундсан толгойг би өндийлгөнө”
Өнгийн цэцгүүд дээр унана;

Дахилт:

Есүсийн өгсөн шиг өгөөч
“Өгөөч, Алив! Өгөөч, алив өгөөч.”
Есүсийн өгсөн шиг өгөөч
Өгөх зүйл бүгдэд байдаг
Горхи, цэцгийн дэлбээ өгдөг шиг өг:
Учир нь Бурхан, бусад хүмүүс амьдардаг.

Дахилт

Тэр Хүүгээ Илгээсэн

Хайр, эелдэг занг Эцэг дэлхийд хэрхэн
харуулж чадсан бэ?
Тэр Хүүгээ, шинэ төрсөн нялх түүнийг
амар амгалан, ариун байдалтайгаар
илгээсэн.
Бидний явах ёстой замыг Эцэг дэлхийд
хэрхэн харуулж чадсан бэ?
Тэр Хүүгээ дэлхий дээр хүмүүнтэй
хамт алхахаар илгээснийг бид
мэдэж болно.
Золиослолын тухай, үхлийн тухай Эцэг
дэлхийд хэрхэн хэлж чадав аа?
Тэр Хүүгээ бидний төлөө үхэж,
амьдрах амьсгалтайгаар босохын
тулд илгээсэн.
Эцэг биднээс юу хүсдэг вэ? Судрууд юу
хэлдэг вэ?
Итгэлтэй бай, найдвартай бай, түүний
Хүү шиг амьдар, тэдний арга замаар
бусдад тусал.
Тэр юу хүсдэг вэ? Түүний Хүү шиг
амьдар.
(© 1982 by Mabel Jones Gabbott.
Зөвшөөрлөөр ашиглана.)

Би Бурханы Хүүхэд

Би Бурханы хүүхэд тул
Энэ эх дэлхийд намайг
Их энэрэнгүй эх эцгийг
Дэлхийн хамт заяав.

Дахилт:

Надад замаа олоход туслан
Хөтлөн удирдаач.
Түүнтэй амьдрахын тул
Би юу хийх ёстойг заагаач.

Би Бурханы хүүхэд тул
Дэндүү оройтолгүй
Түүний үгсийг сайн ойлгоход
Намайг дэмжин туслаач

Дахилт

Би Бурханы хүүхэд тул
Их адислал хүртэнэ
Сургаалыг хэрэв дагавал би
Ахин түүнтэй амьдарна

Дахилт

Аврагчийнхаа Хайрыг Би Мэдэрдэг

Аврагчийнхаа хайрыг би мэдэрдэг
Эргэн тойрондох бүх дэлхийд.
Миний хардаг бүхнээр дамжин
Сүнс бодгалийг минь дулаацуулдаг.

Дахилт:

Би түүнийг дагахыг,
Бүх амьдралаа түүнд өгөхийг тэр мэддэг.
Аврагчийнхаа хайрыг
Надад түүний үнэгүй өгсөн хайрыг би мэдэрдэг

Дөрөвдүгээр бадаг:

Бусдад үнэгүй үйлчилснээр би
Аврагчийнхаа хайрыг хуваалцана.
Үйлчлэлд адислагдана би
Өгснөөр хүлээн авна би

Дахилт

(© 1978, 1979 by K. Newell Dayley. Бүх эрх хамгаалагдсан. Зөвшөөрлөөр ашиглана.)

Эцэг Минь Амьдыг Би Мэднэ

Ариун Эцэг минь амьд, намайг бас хайрлана.
Ариун Сүнс надад үүнийг үнэн хэмээн шивнэнэ.
Тэр үнэн хэмээнэ.

Би сургаалыг дагахаар алтан дэлхийд
төрлөө. Ариун Сүнс надад үүнийг чи
чадна хэмээн хэлнэ.
Чи чадна хэмээнэ.

Би Төрсөн Өдрүүддээ Дуртай

Би төрсөн өдөртөө, бүгдэд нь хайртай;
Тэд нэг бүрчлэн надад баяр хөөр авчирдаг.
Гэвч найм хүртлээ хүлээж чадашгүй нь би
Учир нь тэр үед би баптисм хүртэнэ шүү дээ.

Үнэн санваар атгагч нэгнээр
Есүс шиг баптисм хүртэж
Бурханы ариун хуулийг дагах нь
Миний хийхийг хүсдэг тэр зүйл билээ.

Толгой дээр минь гар тавих
Тэр үед Ариун Сүнсийг би хүлээн авна.
Хэрэв тэгээд би анхааралтай сонсох юм бол,
Надад хамгаас хэрэгтэй адислал надад ирнэ.

Хайрт Эцэг Тандаа Талархъя

Хайрт Тэнгэрлэг Эцэг минь,
Таныхаа би хайр халамж, ивээл энэрэлд
тань талархъя.
Таны намайг баясгахаар өгсөн бүх
адислал,
Энэрэх эцэг эх, найз нөхөд өгсөнд баяр-
лалаа.

Энд надад өгсөн ивээл бүрт талархъя.
Энэ өдөр би энэрэнгүй сайн хүүхэд
байна.
Эцэг эхийнхээ үгийг сайн сонсон дагая,
Энэрэнгүй Есүс Христийн ариун
нэрээр би Намайг хайрлан адислаач
гэж гуйя, танаас.

Тэр Сайхан Түүхүүдийг Уншихаараа Би

Би Есүс хүмүүсийн дунд амьдарч
байхдаа
Хүүхдүүдийг өөрийн сүргийнх гэх
Тэр эрт үеийн сайхан түүхийг нь
уншихаараа би
Тэр үед л амьдармаар болох юм.
Тэр толгой дээр минь гараа тавин
илбээд
Зөөлхнөөр тэвэрсэн ч болоосой.
Тэр Өөрийн хүүхдүүдийг над уруу
ирүүл хэмээн
Зөөлөн харцаар харахыг хармаар байна.

Би Есүстэй Адилхан Болохыг Хичээнэ

Есүстэй адилхан болохыг хичээнэ би;
Түүний замыг дагана би.
Хийдэг, хэлдэг бүхэндээ түүний ади-
лаар хайрлахыг хичээнэ би.
Буруу сонголт хийхээр үргэлж уруу
татагдана би,
Гэвч намуухан аниргүй дуу хоолой
шивнэхэд сонсохыг хичээнэ би.

Дахилт:

Есүс чамайг хайрладгийн адилаар
бие биенээ хайрла.
Хийдэг бүхэндээ эелдэг дөлгөөнийг
харуулахыг хичээ.
Үйл хэрэг санаа бодолдоо эелдэг
дөлгөөн хайраар дүүрэн бай,
Учир нь эдгээр зүйлүүдийг Есүс
заасан юм.

Хөршөө хайрлахыг хичээнэ би;
 Найз нартаа үйлчлэхийг сурна би.
 Есүс дахин хүрч ирэх баярт өдрийг хүсэн
 хүлээнэ би
 Түүний заасан хичээлүүдийг санахыг хичээнэ би
 Тэгвэл Ариун Сүнс миний бодолд нэвтэрч, хэлнэ.

Дахилт

(© 1980 by Janice Kapp Perry. Зөвшөөрлөөр ашиглана.)

Есүс Бяцхан Хүүхдүүдэд Хайртай Байсан

Есүс бяцхан хүүхдүүдэд хайртай байсан,
 Надад шиг багачуудад.
 Тэр тэднийг адисалж, тэдэнд тусална.
 Тэгээд тэднийг өвөр дээрээ авна.

Олон сайхан зүйлийг тэр тэдэнд заадаг байв,
 Бидний хийх ёстой тэр зүйлүүдийг:
 Бие биенээ хайрлаж, туслахыг,
 Шударга, эелдэг, үнэнч байхыг.

Бүгдийг Хайрла Гэж Есүс Хэлсэн

Бүгдийг хайрла гэж Есүс хэлсэн
 Тэдэнд бас эелдэг ханд.
 Зүрх сэтгэл чинь хайраар дүүрсэн цагт
 Бусад хүмүүс чамайг хайрлах болно.

Есүс Намайг Нарны Цацраг Байхыг Хүсдэг

Есүс намайг нарны цацраг байхыг хүсдэг.
 Түүнд өдөр бүр гэрэлтэж байхын төлөө;
 Гэрт, сургууль дээр, тоглоомонд,
 Юм бүхэнд түүнийг баярлуулахын тулд.

Дахилт:

Нарны туяа, нарны туяа,
 Есүс намайг нарны цацраг байхыг хүсдэг.
 Нарны туяа, нарны туяа,
 Түүний төлөө нарны туяа болно би.

Хайраар дүүрэн байхыг Есүс надаас хүснэ
 Бас намайг бүгдэд найрсаг байхыг харахыг хүснэ,
 Хэрхэн баяртай аз жаргалтай байхыг харуулж
 Түүний балчир нэгэн байж чадна.

Дахилт

Бие Биенээ Хайрла

Миний нэг адилаар,
 Бие биенээ хайрла.
 Энэ шинэ тушаалаар:
 Бие биенээ хайрла.
 Та нар
 Бие биенээ хайрлаж чадвал
 Хүмүүс та нарыг
 Миний шавь нар гэх болно.
 (© 1961, renewed 1989 by Luacine C. Fox.
 Зөвшөөрлөөр ашиглана.)

Марийн Бүүвэйн Дуу

Бүүвэй, бүүвэй, өөдөсхөн үүр минь.
 Бүүвэй хонгорхон үр минь.
 Үнэт амьдрал чинь дөнгөж эхэллээ;
 Ээж чинь чамайг чанга тэвэрнэ.
 Иосеф шөнөжингөө харахад
 Цацарсан гэрэлд чинь од туслаа.
 Бүүвэй, бүүвэй, өөдөсхөн үүр минь.
 Бүүвэй хонгорхон үр минь.

Энхрийхэн толгой чинь титэм өмсөнө.
 Эцэг чинь Хаан билээ учир нь.
 Энхрийхэн гар чинь бяцхан билээ
 Авчрах адислал чинь агуу билээ.
 Бүх бүтээл дуунд минь нэгдэг
 Энх амгалангийн төлөө, хайрын төлөө
 энэ шөнө төрсөн билээ.
 Бүүвэй, бүүвэй, өөдөсхөн үүр минь.
 Бүүвэй хонгорхон үр минь.

Өө, Чимээгүй Бай, Миний Хүү

Өө, чимээгүй бай, миний хүү; түүх ярья би,
Бяцхан Их Эзэн дэлхийд оршихоор хэрхэн
ирснийг;
Алс холын оронд далайн дээгүүр зам болсныг,
Миний хонгорхон үр чам шиг л нялх хүү төрсөн
юм.

Дахилт:

Бүүвэй үр минь, бүүвэй хонгорхон үр минь.
Айх юмгүй нойрсдоо бяцхан үр минь;
Бүүвэй үр минь, бүүвэй хонгорхон үр минь.
Есүс эндэх бяцхан нэгнээ халамжлах болно.

Тэнгэр элчүүд түүхийг яруухнаар ярьсан юм,
Тэдний эргэн тойронд тэнгэрлэг гэрэл гийж байв.
Одод гялалзан гэрэлтэж, харин нэг нь зам зааж
Хонгорхон хүүгийн төрсөн газар дээгүүр манд-
сан юм.

Дахилт

Тэнгэр элчүүдийн хэлснээр хоньчид түүнийг
эндээс олсон юм,
Хөөрхий бяцхан түүнд хүүхдийн ор байсангүй.
Тэжээлийн тэвшинд доош нь түүнийг чимээгүй-
хэн тавьсан юм,
Тэгээд бяцхан хүү Есүс өвсөн дээр унтсан юм.

Дахилт

Би Хурдан Дагана

Ээжийгээ дуудахад би
Хурдан түүнийг дагана.
Өдөр болгон өдөр бүхэн
Хамгийн сайныг хийхийг хүснэ би.

Аавыгаа дуудахад би
Хурдан түүнийг дагана.
Өдөр болгон өдөр бүхэн
Хамгийн сайныг хийхийг хүснэ би.

Тэнгэрлэг Эцэг надад хайртай,
Өдөр бүр намайг адисалдаг
Өдөр болгон өдөр бүхэн
Хамгийн сайныг хийхийг хүснэ би.

Инээмсэглэл


Хэрэв чи хөмсөг зангидалттай учирвал
Үүнийг хэвээр нь бүү байлга.
Үүнийг дээш доош нь түргэн эргүүл,
Хөмсөг зангидалтыг хөөн зайлуулж
инээмсэглэ.

Хөмсөг зангидсан нүүрэнд хэн ч дургүй.
Инээмсэглэлээр үүнийг өөрчил.
Үргэлжийн инээмсэглэлээр тэгээд
Дэлхийг илүү сайхан газар болго.

Ариун Сүнс

Христ дэлхий дээр байхдаа
Бидний үнэнч, мөнхийн анд
Биднийг тайтгаруулах Ариун Сүнсийг
Илгээх болно гэж тэр амласан.
Намуухан чимээгүй дуу хоолойгоор
Ариун Сүнс шивнэдэг.
Бурхан, Есүс хоёрын тухай тэр гэрчилж
Бидний зүрх сэтгэлийг баярлуулдаг.

Ариун санваарын хүчээр
Биднийг гишүүнээр батлагдахад
Бидэнд өгөгдсөн Ариун Сүнс
Биднийг цаг тутамд удирддаг.
Намуухан чимээгүй дуу хоолойг
Би ямагт сонсох болно,
Тэгээд түүний гэрлээр зөвийг хийнэ би
Тэгэх бүртээ сонголт хийнэ би.



Ямар нэг зүйлийг хуваалц

Сүмд яв

до тнэл үсэлт
есхнийх эстэ

Амьтдад эел-
нөөөө дэг зөөлөн
ханд

Хүн нэгн нэг
дэвэст тийнх
хүнийг тавар

Найрсаг
байсны төлөө
"Баярлалаа танд"
гэж хэл

Гишүүн бус
хүнийг
сүмд авчир

Сүм дээр
хүндэтгэлтэй
бай

Найрсаг
бус байсан
хүнийг уучил

Ах, эгч, дүү
нартайгаа
бүү хэрэлд

Залбирлын
үед дүү
чимээ
гаргах

Хөрш зэргэлдээ
хэн нэгэнд
тусал

Есүсийг
Ирэхэд
Бэлтгэх нь

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

